

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
УЛС ТӨР СУДЛАЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА,
НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ
УЛС ТӨР СУДЛАЛЫН ТЭНХИМ – АРДЧИЛАЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ
ПОЛИТОЛОГИ
№ XXII

2024 он

ПОЛИТОЛОГИ XXII ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22 (593)
XXII

ISSN 2227-6904

Key title: Политологи

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч: проф. Ж.Төртогтох, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
Орлогч эрхлэгч: проф. С.Мөнхбат, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
Нарийн бичиг: Д.Уртнасан, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
Сэтгүүлийн туслах ажилтан: Г.Баярчимэг, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим

Гишүүд:

проф. С.Базарпүрэв, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
проф. Н.Бурмаа, МУИС, УТСОУХНУС, Нийтийн удирдлагын тэнхим
др. Д.Ундрах, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
др. Б.Эрдэнэдалай, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
др. Г.Туяагэрэл, МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим
др. Я.Төгөлдөр, ШУТИС, Нийгмийн ухааны тэнхим
др. Н.Мягмарцоож, МУБИС
др. О.Хатанболд, ШУА, ФХ, Улс төр, эрх зүйн салбар
др. Б.Одгэрэл, Отгонтэнгэр Их Сургууль
др. М.Мөнхзул, ХААИС
др. Ж.Жаргал, Удирдлагын Академи

Хаяг:

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө, МУИС-ийн хичээлийн V байр, Улс төр судлал, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль, Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв

Утас: 976 - 75754400 (5102)

POLITOLOGY XXII SCIENTIFIC JOURNAL

№22 (593)
XXII

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor-in-Chief:	Prof. Turtogtokh Janar, SPSIRPA, National University of Mongolia
Co-editor	Prof. Munkhbat Sonomdarjaa, SPSIRPA, National University of Mongolia
Secretary:	Urtnasan Dagiidamba, SPSIRPA, National University of Mongolia
Assistant:	Bayarchimeg Ganbaatar, SPSIRPA, National University of Mongolia
Board members:	Prof. Bazarpurev Sambuu, SPSIRPA, National University of Mongolia
	Prof. Burmaa Natsag, SPSIRPA, National University of Mongolia
	Dr. Undrakh Davaadorj, SPSIRPA, National University of Mongolia
	Dr. Erdenedalai Bat-Ulzii, SPSIRPA, National University of Mongolia
	Dr. Tuyagerel Ganbat, SPSIRPA, National University of Mongolia
	Dr. Tuguldur Yanjiv, Mongolian University of Science and Technology
	Dr. Myagmartsooj Natsag, Mongolian State University of Education
	Dr. Khatanbold Oidov, Mongolian Academy of Sciences
	Dr. Odgerel Batsaikhan, Olgontenger University
	Dr. Munkhzul Myagmarsuren, Mongolian University of Life Science
	Dr. Jargal Jambal, National Academy of Governance

Address:

Department of Political Science & Center for Democracy Studies, School of Political Science, International Relations and Public Administration, National University of Mongolia, Zaluuchuud avenue, Ulaanbaatar, Mongolia

Phone: 976 – 75754400 (5102)

ПОЛИТОЛОГИ XXII
Эрдэм шинжилгээний бичиг
№22 (593)

АГУУЛГА

Өмнөх үг

ПАРЛАМЕНТЫН ИНСТИТУТ

Монгол Улсын Их Хурлын төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэх нь
Ж.Төртогтох, Г.Туяагэрэл.....9

Парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох асуудалд
Д.Сүхболд18

Парламентын хянан шалгах бүрэн эрхийн хэрэгжилт (УИХ-ын нээлттэй сонголын асуудалд)
Ж.Төртогтох, Б.Уянга.....33

Парламентын сонгуулийн сурталчилгааны хугацааны асуудалд
Г.Золзаяа42

УИХ-ын эмэгтэй гишүүдийн нийгмийн сүлжээнд оруулсан постуудад хийсэн шинжилгээ
Б.Эрдэнэдалай, Ю.Ариунзаяа51

УЛС ТӨРИЙН НАМ, СОНГУУЛЬ

Монголын улс төрийн намын үзэл баримтлал, түүний хэрэгжилтийн зарим асуудал
С.Мөнхбат, Б.Эрдэнэдалай70

Монголын улс төрийн намуудын төлөөлөх үүрэг, түүний биелэлт
Д.Ундрах, Б.Анхзаяа82

Нам, намын системийн төлөвшилд сонгуулийн тогтолцооны эрх зүйн орчин нөлөөлөх нь
Ж.Төртогтох, Б.Болор-Эрдэнэ93

УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй хүндрэл, бэрхшээл
У.Батцэрэн, Д.Алтанхуяг101

Монголын сонгогчдын ирц, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс (Залуучуудын жишээн дээр)
Н.Мягмарцоож111

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГО

Монгол, Хятад, Оросын геополитикийн үндэс суурь, цаашдын чиг хандлага
Д.Түмэнжаргал, А.Отгонням, Sebule119

Үндэсний аюулгүй байдал: Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хянах нь
Ш.Эвсанаа.....132

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн чадавхийг сайжруулах асуудалд <i>Т.Заяа</i>	139
--	-----

Монгол улсын гадаад бодлогын хэрэгжилтэд спортын дипломат ажиллагааны хувь нэмэр <i>Т.Есүхэй, Ц.Төрболд</i>	148
--	-----

УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад олгодог санхүүжилтэд хийсэн шинжилгээ <i>Г.Туяагэрэл, Э.Эрдэнэцэцэг</i>	154
--	-----

2019 оны Монгол Улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: төрийн санхүүжилтийн зохицуулалт, онол <i>Б.Баярбаатар, Д.Бумдарь</i>	164
---	-----

2020 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн санхүүгийн зарцуулалтад хийсэн шинжилгээ <i>Д.Ундрах, О.Ариунбилэг</i>	176
--	-----

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨРИЙН СУДАЛГАА

Ардчиллыг залруулахуй <i>С.Базарпүрэв, О.Мөнхжаргал</i>	192
--	-----

Монгол дахь улс төрийн соёлын хэтийн төлөв хандлага <i>О.Хатанболд, Д.Уртнасан</i>	200
---	-----

Улс төрийн мөргөлдөөн судлалын онол, арга зүйн асуудал, мөргөлдөөнийг зохицуулах шийдвэрлэх арга <i>Х.Батхүү</i>	211
---	-----

Үндэсний адилсал <i>М.Мөнхзул, Г.Уянга</i>	222
---	-----

Улс төрийн патронажийн тухай ойлголт, институционал хандлага <i>Н.Отгонбаяр, Л.Билгүүнтөгс</i>	227
---	-----

Албан бус улс төр: клиентелизм, төр болон намыг барьцаалах тухай ойлголтыг тайлбарлах нь <i>Д.Бадамдаш, Б.Сарантуяа, Д.Бумдарь</i>	235
---	-----

Зохиогчдын тухай товч	248
-----------------------------	-----

POLITOLOGY XXII

Scientific journal

№22 (593)

CONTENTS

Foreword

PARLIAMENTARY INSTITUTION

Representative Functions of the State Great Khural of Mongolia and its Implementations
Turtogtokh J., Tuyagerel G.9

Some Methods for Properly Determining the Number of Members of Parliament
Sukhbold D.18

The Implementation of the Parliamentary Oversight Power and Public Hearings (In Case of the Public Hearings Organized by the State Great Khural of Mongolia 2020-2023)
Turtogtokh J., Uyanga B.33

The Issues of the Election Campaign Length
Zolzaya G.42

An Analysis the Social Media Posts of the Female Members of Mongolian Parliament
Erdenedalai B., Ariunzaya Yu.51

POLITICAL PARTY AND ELECTION

Mongolian Political Party Ideology and Some Issues of Its Implementation
Munkhbat S., Erdenedalai B.70

Representative Duties of Mongolia Political Parties and Its Implementation
Undrakh D., Ankhzaya B.82

Legal Regulations of Election System and Its Influence on Party and Party System
Turtogtokh J., Bolor-Erdene B.93

POLITICAL PARTICIPATION

Legal, Social and Economic Factors and Challenges
Battseren U., Altankhuyag D.101

Voter Turnout in Mongolia and Its Influencing Factors (On the Example of Young Citizens)
Myagmartsooj N.111

NATIONAL SECURITY AND FOREIGN POLICY

Foundations and Trends of Geopolitics of Russia, China and Mongolia
Tumenjargal D., Otgonnyam A., Sebule.119

National Security: Monitoring the Foreign Direct Investment
Evsanaa Sh.132

Issues of Strengthening the Capacity of the National Security <i>Zaya T.</i>	139
The Contribution of Sports Diplomacy to the Foreign Policy of Mongolia <i>Yesukhei T., Turbold Ts.</i>	148
POLITICAL FINANCING	
Analysis of Government Funding for Media Organizations <i>Tuyagerel G., Erdenetsetseg E.</i>	154
Amendment of the 2019 Constitution of Mongolia: Regulation and Theory of Public Funding of Political Parties <i>Bayarbaatar B., Bumdari D.</i>	164
Financial expence analysis of candidates for the 2020 Parliamentary election of Mongolia <i>Undrakh B., Ariunbileg O.</i>	176
COMPARATIVE POLITICAL STUDIES	
Rectyfing Democracy <i>Bazarpurev S., Munkhjargal O.</i>	192
Perspectives and Attitudes of Political Culture in Mongolia <i>Khatanbold O., Urtnasan D.</i>	200
Theoretical and Methodological Issues of Political Conflicts and Methods of Managing and Resolving the Conflicts <i>Batkhuu Kh.</i>	211
National identity <i>Munkhzul M., Uyanga G.</i>	222
Political Patronage and Its Institutional Approach <i>Otgonbayar N., Bilguuntugs L.</i>	227
Informal Politics: Explaining the Concepts of Clientelism, State and Party Capture <i>Badamdash D., Sarantuya B., Bumdari D.</i>	235
List of Contributors	248

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс Төр Судлал, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургуулийн Улс төр судлалын тэнхимийн “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж буйг хүлээн авна уу.

МУИС-ийн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу шинээр зохион байгуулагдсан Улс Төр Судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулийн бүтцэд Улс төр судлалын тэнхим түүхийн шинэ хуудсаа эхлүүлж буй энэ цаг үед тус сэтгүүлийн шинэ дугаар уншигчдад хүрч буйг тэмдэглэе. Улс төр судлалын тэнхим нь нийгмийн шинжлэх ухааны олон янзын салбаруудыг манлайлан түүчээлж ирсний нэгэн бодит байдал нь ийнхүү улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгаанд манлайлагч байх үүрэг хүлээсэн Улс Төр Судлалын тэнхим нь сургууль болон өсөн дэвшиж, өргөжин дэвшиж буй хэрэг болно.

Улс төр, төр засаг, тогтолцоо, институтын тулгуур зангилаа асуудлуудыг судлан танин мэдэх, таниулан мэдүүлэх, улс төрийн үйл явц, харилцааны мөн чанарт нэвтрэх, шинжлэх ухаан, судалгаанд суурилсан үнэлэлт дүгнэлт, тийм учир холбогдол бүхий мэдлэгийг бий болгоход улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна.

Сэтгүүлийн энэхүү дугаарт парламент, улс төрийн нам, намын систем, сонгууль, улс төрийн оролцоо, коммуникаци, улс төрийн санхүүжилт, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого болон харьцуулсан улс төрийн зарим чухал асуудлыг хөндсөн сэдвийн хүрээнд нийт 36 эрдэмтэн судлаачдын дангаар болон хамтран бичсэн 23 өгүүлэл нийтлэгдэж байна.

Энэхүү дугаарт нийтлэгдсэн өгүүллэг тус бүр нь тухайн зохиогчийн үзэл санаа, байр суурь, судалгааны өгөгдөхүүнд тулгуурлаж байгаа бөгөөд МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв, Политологи сэтгүүлийн редакцын байр суурь биш болохыг анхаарч хүлээн авна уу.

**МУИС-ийн Улс Төр Судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын
Сургуулийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв
Политологи эрдэм шинжилгээний сэтгүүл**

Ерөнхий редактор, профессор Ж.Төртогтох

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 9-17 дахь тал

**“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ НЬ”¹**

Ж.Төртогтох

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор

Ардчилал судлалын төвийн захирал

Г.Туяагэрэл

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Хураангуй:

Төлөөллийн ардчиллын онолын үүднээс авч үзвэл хууль тогтоох институци болох Улсын Их Хурал нь үндэсний нийтлэг эрх ашгийг илэрхийлж байдгаараа бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны байх шинжээ бүрдүүлж байдаг төлөөллийн институци юм. Монгол Улс парламентын тогтолцоонд шилжээд 30 жил болсон хэдий ч хууль тогтоох институцийн ард түмнийг төлөөлөх чиг үүрэг багасах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн үндсэн үүрэг нь бүдгэрэх улмаар институцид итгэх олон түмний итгэл буурах байдал ажиглагдаж байна. Иймд бид энэхүү судалгаагаараа парламентын төлөөллийн чиг үүрэг гэж юу болох, түүнийг хэрхэн үнэлэх боломжтой болохыг харуулахын зэрэгцээгээр төлөөллийн чиг үүргийн талаарх судлаачдын үзэл баримтлалд тулгуурлан 2020 оны сонгуулиар байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг гишүүдийн ирц, сонгогчидтой тогтоосон холбоо, хууль тогтоох үйл явцад иргэд, сонгогчдын оролцоог хангаж ажиллаж байгаа байдал гэсэн үндсэн гурван үзүүлэлтээр үнэлж үзлээ.

Түлхүүр үгс: Хууль тогтоох институци, төлөөллийн чиг үүрэг, төлөөллийн ардчилал

Хууль тогтоох институцийн төлөөллийн чиг үүргийн талаарх онолын үзэл баримтлал

Төлөөлөх, төлөөлөгч (representation) гэх нэр томьёо нь латин гаралтай бөгөөд латин хэл дээрх анхны утга нь одоогийн бидний өдөр тутмын амьдрал, судалгаа шинжилгээнд хэрэглэж буй хэн нэгнийг улмаар сонгогчдыг төлөөлсөн агентлаг, хууль тогтоох институци, засгийн газар гэх мэт төлөөллийн байгууллагатай ямар ч холбоогүй байсан. Латин *repraesentare* нь "бий болгох, харуулах, дахин харуулах" гэсэн утгатай бөгөөд сонгодог латин хэлэнд түүний хэрэглээ нь бараг бүхэлдээ бусад хүн эсвэл байгууллагатай холбоотой ойлголт байгаагүй².

Дундад зууны үед энэ үгийг Христ шүтлэгтнүүдийн дунд хамтын хариуцлагыг илэрхийлсэн нэр томьёогоор хэрэглэгдэж байсан³. Энэхүү нэр томьёоны хэрэглээ нь XIII зууны сүүл XIV зууны эхэн үеэс нэмэгдсэн байдаг.

Дундад зууны үеийн хуульчид төлөөлөгч нь хамтаар, амьдарч хамтын хариуцлага хүлээх нийгмийн зохион байгуулалтыг илэрхийлэх нэр томьёог гэж үзэн хэрэглэж байсан байдаг. Эзэн хаан ард түмний төлөө засаглаж, тэдний өмнө хариуцлага хүлээж, тэдний сайн

¹Энэхүү өгүүллийг МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимд хэрэгжиж буй «Монгол дахь улс төрийн хөгжил 1990 оноос хойш: улс төрийн институци, харилцаа, үйл явц» (ШУТИБХЗГ-2021/456) сэдэвт хавсарга судалгааны төслийн хүрээнд бэлтгэсэн болно.

² (Lagarde, 1937)

³ (Tierney, 1955)

сайхны төлөөлж санаа тавьдаг гэсэн Ромын хуулиас энэхүү үзэл санаа үүдэлтэй гэж судлаачид үзсэн байдаг.

Жорж де Лагард XIII зууны сүүлээр төлөөлөл гэдэг бол олон нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх ойлголт бөгөөд энэ нь хууль хүчний байгууллагын үйл ажиллагаатай шууд холбоотой гэж үзсэн байдаг. Хуульч Альберт де Гаудино иргэд өмгөөлөгчөөр дамжуулан нэхэмжлэл гаргадаг бөгөөд энэ нь хүн бүр өөрийн биеэр шүүхэд өргөдөл гаргах боломжгүй байдаг тэр байдлаас иргэнийг төлөөлсөн өмгөөлөгч гэх дүрийг бий болгодог гэж өөрийн бүтээлдээ дурдсан байдаг.

Философич Э.Бёркийн бүтээлүүдэд улс төрийн төлөөлөл гэх ойлголтыг өргөн агуулгаар авч үзсэн байдаг. Тэрээр тэгш бус байдал нь аливаа нийгэмд жам ёсны зүйл бөгөөд түүнээс зайлсхийх боломжгүй ба ард түмний зарим нэг хэсэг нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чадвартай нийгмийн дээд хэсэг байх ёстой гэж үздэг. Харин эмх цэгцтэй зөв зохион байгуулалттай нийгэмд энэ эрх баригч бүлэг нь жинхэнэ элитүүд байдаг бөгөөд тэднийг "төрөлхийн язгууртнууд"⁴ гэж нэрлэсэн байдаг. Ийм элит бол "зөв зохион байгуулалтаар бүрдсэн аливаа томоохон бүтцийн салшгүй салшгүй хэсэг" бөгөөд ард түмнийг удирддаг. Олон түмэн өөрсдийгөө удирдах чадваргүй. Учир нь эрх мэдэл олон түмний гарт байвал ямар ч хяналт зохицуулалтгүй болдог бөгөөд энэ байдал нь засаглалын тогтворгүй болгодог. Ямар ч бүтцийн хувьд удирдлага бол тодорхой удирдамж, зааврын тусламжтайгаар хийгддэг⁵. Тиймээс сайн төр гэдэг нь нэг талаас жинхэнэ төрөлхийн язгууртнуудыг олон түмнээс ялгаатайгаар өсгөж, сургаж, энэ үүргээ хамгийн сайн гүйцэтгэж чадна гэдгээ ухамсарлан засаглалыг хэрэгжүүлж ард түмнийг захирч нөгөө талаас ард түмэн захирахыг зөвшөөрдөг улс юм⁶. Харин тэрхүү ард түмний төлөөлөгчид нь дундаж, жирийн иргэн биш харин мэргэн ухаан, чадвартай амжилттай яваа нийгмийн элит хэсэг байх ёстой. Төлөөлөгч хүний хамгийн чухал чадвар нь практик дүгнэлт хийх чадвар юм гэж үзсэн байдаг. Учир нь Э.Бёрк төлөөлөх гэдэг нь зөвхөн оюун санааны асуудал биш, харин ёс суртахуун нягт холбоотой байдаг гэж үзсэн. Тиймээс төрөлхийн элитийн давуу тал буюу төлөөлөгчдөд байх эрхэм чанарууд нь өөрийн туршлагаас олж оюун дүгнэлт, ариун журам, мэргэн ухаан оршдог. Энэ бүх чанарууд нь ард түмэнд зөвөөр ойлгогдоход тустай юм. Улс төрд аливаа асуудалд ёс суртахууны хувьд зөв хариултууд байдаг харин түүнийг зөв гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрөхөд оюун ухаан, практик ур чадвар хэрэгтэй болно.

Төлөөлөгч нь ард түмэнд дуулгавартай үйлчлэх зарц бус харин өөрийн давуу чадвараа бүрэн ашиглаж ажиллах өртэй. Гэтэл төлөөлөгч өөрийгөө олонхын зарц мэтээр төлөөллийн үүргээ гүйцэтгэх гэж оролдох нь зарим талаараа өөрийн үзэл бодлыг "золиослох" шаардлага үүсдэг. Иймд төлөөлөх нь ард түмний хүслийг дагахтай ямар ч холбоогүй, харин сонгогдсон элитээр үндэсний сайн сайхныг бүтээлгэх, батлан харуулах тухай үзэл санаа юм⁷.

И.Бентамын бүтээлд ард түмний төлөөлөх боломжтой хууль тогтоогчийн хувийн шинж чанарт өгөөмөр сэтгэл, бусдыг аз жаргалтай байдлаас таашаал авдаг байх гэж дурдсан байдаг ч ийм шинж чанартай хууль тогтоогчид маш цөөхөн байдаг гэж үзжээ. Учир нь хувь хүнд байх дээрх чанарууд нь институцилагдсан(хүлээн зөвшөөрөгдсөн) хууль тогтоогч болсноор сонгогчийн хувьд байсан дээрх итгэл үнэмшил нь хүчтэй аргумент байхаа больж, улмаар түүнийг институцийн хамгаалалтын тусламжтайгаар өөрийн шинэ үнэт зүйлийг бий болгож эхэлдэг. Нөгөө талаас нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхийн тулд засгийн газрын, намын ашиг сонирхолд нийцүүлэхээс өөр боломжгүй юм гэж үзсэн байдаг.

Судалгааны үр дүн

2020 оны сонгуулиар байгуулагдсан УИХ-ын төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг УИХ-ын гишүүдийн парламентын дотоодод ажил хэрэг буюу буюу хуралдааны ирц, байнгын

⁴ (P.Canavan, 1960, хууд. 397)

⁵ (P.Canavan, 1960, хууд. 328)

⁶ (Beer, 1957, хууд. 616)

⁷ (P.Canavan, 1960, хууд. 156)

хороодод ажилласан байдал, парламентын гадаад ажил буюу сонгогдсон тойрогтоо ажилласан байдалд дүн шинжилгээ хийхээр төлөвлөсөн.

Иймд УИХ-ын чуулганы ирцийг тооцохдоо 2021.04.01-2023.03.01 хооронд УИХ-ын албан ёсны цахим эх сурвалж болох www.parliament.mn ирцийн мэдээллийг судалгааны энэ хэсэгтээ хэрэглэсэн. Судалгааны энэхүү хугацаанд Монгол Улсын Их Хурал нийтдээ 108 удаа чуулсан байдаг. Доорх хүснэгтээс харвал УИХ-ын гишүүдийн 42.1 хувь нь нийт 80-89 хүртэлх, 30.3 хувь нь 90-99 хүртэлх, 17,1 70-79 хүртэлх 6.6 хувь 100-106 хүртэлх, 2.6 хувь нь 59-өөс цөөн, 1.3 хувь нь 60-69 удаагийн хуралдаанд оролцсон байна.

Хүснэгт 1. УИХ-ын хуралдааны ирцийн мэдээлэл

Хуралдааны тоо	УИХ-ын гишүүдийн тоо	Эзлэх хувь
80-89	32	42.1
90-99	23	30.3
70-79	13	17.1
100-106	5	6.6
59-аас бага	2	2.6
60-69	1	1.3

Эх сурвалж: Судлаачид www.parliament.mn албан ёсны мэдээллийг нэгтгэж боловсруулав.

УИХ-ын хуралдаанд оролцоогүй шалтгааныг дараах байдлаар тайлбарлан ирцийн тэмдэглэгээнд хийсэн байна. Үүнд:

1. Гадаадад
2. Орон нутагт
3. Чөлөөтэй
4. Эмнэлгийн чөлөөтэй
5. Тасалсан
6. Хоцорсон

УИХ-ын чуулганы хуралдаанд дээрх шалтгаануудын эзлэх хувийн жинг тодруулан авч үзвэл “гадаадад” гэдэг шалтгаан 14.7 хувь, “орон нутагт” гэдэг шалтгаан нь 13,8 хувь, “чөлөөтэй” гэдэг шалтгаан нь 20.2 хувь, “эмнэлгийн чөлөө” гэдэг шалтгаан нь 9.8 хувь, “тасалсан” гэсэн шалтгаан 9.8 хувь, “хоцорсон” гэх шалтгаан 31.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс “гадаадад” гэдэг шалтгаантай УИХ-ын гишүүдийн хувьд 2-50 хүртэлх удаагийн хуралдаанд, орон нутагт ажилласан гишүүдийн хувьд 0-32 удаа, “эмнэлгийн чөлөөтэй” гэдэг гишүүдийн хувьд 19 хүртэлх, “хоцорсон” гэдэг шалтгаантай гишүүдийн хувьд 42 хүртэлх удаагийн чуулганд тус тус оролцоогүй байна. УИХ-ын гишүүд 14 хүртэлх 22.4 хувь нь л судалгааны энэхүү хугацаанд “орон нутагт” гэсэн шалтгаанаар хуралдаанд оролцоогүй тохиолдол байсангүй. УИХ-ын гишүүдийн 6.6 хувь нь л огт чөлөө авахгүйгээр, 23.7 хувь нь “эмнэлгийн чөлөө” авалгүйгээр чуулганы хуралдаандаа оролцсон байна. Харин УИХ-ын гишүүдийн 5.3 хувь нь хоцролгүйгээр хуралдаандаа оролцож байсан болох нь баримт бичгийн судалгаанаас харагдаж байна.

Зураг 1. УИХ-ын гишүүдийн хуралдаанд суугаагүй шалтгаан

	Гадаадад		Орон нутагт		чөлөөтэй		Эмнэлгийн чөлөөтэй		тасалсан		Хоцорсон	
Нийт хэмжээ	21		6		7		4		4		11	
Дундаж хэмжээ	2-50 удаа		0-32 удаа		0-43 удаа		0-19 удаа		0-13 удаа		0-42 удаа	
Нийт шалтгаанд эзлэх хувь	14.7		13.8		20.2		9.8		9.8		31.7	
Тухайн тохиолдлын эзлэх хувь	45-50 удаа	2.6	22-32 удаа	2.6	43 удаа	1.3	13-19 удаа	2.6	10-13 удаа	2.6	32-42 Удаа	2.6
	30-38 удаа	9.2	10-15 Удаа	7.9	17-25 удаа	3.9	13-15 удаа	2.6	5-9 удаа	23.7	22-29 удаа	6.6
	20-29 удаа	40.8	5-10 удаа	25.0	10-15 удаа	15.8	5-10 удаа	15.8	1-6 удаа	53.9	10-19 удаа	32.9
	10-19 удаа	38.2	1-5 удаа	42.1	5-9 удаа	28.9	1-5 удаа	55.3	Огт таслаагүй	19.7	5-9 удаа	30.3
	2-8 удаа	9.2	Огт яваагүй	22.4	1-5 удаа	43.4	Огт эмнэлгийн чөлөө аваагүй	23.7			1-4 удаа	22.4
					Огт чөлөө аваагүй	6.6					Огт хоцроогүй	5.3

Эх сурвалж: Судлаачид [ЦАХИМ ПАРЛАМЕНТ \(parliament.mn\)](http://parliament.mn) албан ёсны эх сурвалжаас нэгтгэж боловсруулав.

Хууль тогтоох институцийн төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийн үнэлэхийн тулд иргэд сонгогчидтой хэрхэн холбоотой ажиллаж байгааг судлах шаардлагатай юм. Иймд бид Монгол Улсын Их Хурлын хувьд төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэхдээ УИХ-ын гишүүдийн орон нутаг, сонгогдсон тойрогтоо ажилласан талаарх мэдээлэлд баримт бичгийн шинжилгээг хийсэн. Ингэхэд судалгааны хугацаанд УИХ-ын гишүүд 453 ажлыг орон нутаг, сонгогдсон тойрогтоо хийсэн гэдгээ судалгааны анхдагч эх сурвалж болгон авч үзсэн цахим эх сурвалжид тэмдэглэсэн байна. Иймд эдгээр орон нутагт ажилласан байдлыг агуулгын төстэй байдлаар доорх арван дөрвөн бүлэгт хуваан авч үзэхэд 13.9 хувь нь “төрийн бодлого шийдвэр, өөрчлөлтийн талаар иргэдэд танилцуулах, санаа бодлыг нь сонсох”, 10.81 хувь нь “шаардлагатай байгаа эд хогшил, тоног төхөөрөмжийг гадуулан өгөх”, 10.37 хувь нь “аймаг, сум орон нутагт хийгдэж байгаа үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцах”, 9.93 хувь нь “төрийн шагнал одон медаль гардуулах”, 8.6 хувь “аймаг сум орон нутгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзах, дурсгалын зураг авхуулах” гэх мэт ажлууд тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд хууль тогтоох төлөөллийн институцийн гишүүний хувьд УИХ-ын гишүүн төлөөлөгчийн чиг үүргээ парламент доторх буюу хууль тогтоох, хууль санаачлах; ажлын хэсгийг ахлах, гишүүнээр ажиллах; байнгын, түр, дэд хороодыг ахлах, гишүүнээр ажиллах байдлаар хэрэгжүүлж байдаг. Харин УИХ-ын төлөөллийн чиг үүргийг парламентын гадна хэрэгжүүлэхдээ УИХ-ын гишүүд сонгогдсон тойрог буюу орон нутагт ажиллах ажилладаг. Төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийн энэ хэлбэрийн хувьд иргэд сонгогчдын санаа бодлыг сонсон төрийн бодлого шийдвэрт тусгуулах, хууль эрх зүйн зохицуулалтын эрэлт хэрэгцээ шаардлагыг олон нийтийн санаа бодолд тулгуурлан томъёолох ажлууд багтах ёстой. Гэтэл бидний судалсан анхдагч болон хоёрдогч эх сурвалжид тусгагдсан орон нутаг, сонгогдсон тойрогт хийсэн ажлуудыг харахад бодлого шийдвэрийн өөрчлөлтийг танилцуулж иргэдийн санаа бодлыг сонссон гэх боловч тэрхүү санаа бодол, иргэдээс гарсан өргөдөл гомдлын тоон үзүүлэлт, хэрхэн шийдвэрлэгдэж төрийн ямар бодлого шийдвэрт яаж тусгагдсан талаарх мэдээлэл огт байгаагүй. Үүнээс гадна аймаг сумдын эмнэлэг, сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг гардуулан өгсөн гэх боловч улсын төсвөөр авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ юм уу эсвэл өөрийн санаачилга санхүүжилтээр хийж байгаа ажил эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл УИХ-ын гишүүдийн орон нутагт хийгдсэн ажлууд нь хууль тогтоох институцийн төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг хэлбэрийн хувьд хангаж байгаа боловч агуулгын хувьд бүрэн дүүрэн хангаж байна гэж үзэж болохооргүй байна.

Хүснэгт 2. Орон нутагт ажилласан ажлын төрөл

№	Орон нутагт ажилласан ажлын төрөл	Давталтын тоо	Эзлэх хувь
---	-----------------------------------	---------------	------------

1	Төрийн бодлого шийдвэр, өөрчлөлтийн талаар иргэдэд танилцуулах санаа бодлыг нь сонсох	63	13.9
2	Шаардлагатай байгаа эд хогшил, тоног төхөөрөмжийг гардуулан өгөх	49	10.81
3	Аймаг, сум орон нутагт хийгдэж байгаа үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцах	47	10.37
4	Төрийн, шагнал, одон медаль гардуулах	45	9.93
5	Аймаг сум орон нутгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзах, дурсгалын зураг татуулах	39	8.6
6	Тайлант уулзалт	35	7.72
7	Эмэгтэйчүүд, ахмад настан, ЕБС, нэгдсэн эмнэлгүүдээр зочлох	30	6.62
8	Аймаг, сум, дүүрэг, хороонд ажиллах ажиллагаа	30	6.62
9	Аймаг, сум, орон нутагт амжилттай хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй танилцах	27	5.96
10	Иргэдийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах	26	5.73
11	Төрийн санхүүжилтээр хийсэн ажлын нээлтэд оролцох	19	4.19
12	Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж өгөх	17	3.75
13	Тэтгэлэг, хандив, мөнгөн тусламж, санхүүжилт	16	3.53
14	Бусад	10	2.2

Эх сурвалж: Судлаачид (Vip76.mn | Very Important Person, ЦАХИМ ПАРЛАМЕНТ (parliament.mn) цахим эх сурвалжаас нэгтгэж боловсруулав

Орон нутагт хийгдсэн ажлуудыг судлах судалгааны энэ хэсэгт УИХ-ын 61 гишүүний цахим эх сурвалж дах мэдээлэл, тоон баримтыг ашигласан. Ингэхдээ 1992 оноос өнөөдрийг хүртэлх хугацаан дах 76 гишүүнтэй найман парламентын бүтэц хэрхэн шинэчлэгдэж байсан болохыг судлан дараах бүтцийн шинэчлэлийн матрицыг гаргасан.

2020-2024 онд сонгогдсон УИХ-ын гишүүдийн хувьд орон нутагт хийсэн ажлын үзүүлэлтэд парламентад сонгогдсон давтамжийг хамааруулан судалгаа хийж үзсэн. Судалгааны энэ хэсэгт УИХ-д хоёр дахь удаагаа сонгогдсон гишүүдийн 80.8 хувь, анхны удаагаа сонгогдсон гишүүдийн 88.2 хувь, дөрөв дэх удаагаа сонгогдсон гишүүдийн 83.3 хувь, тав удаагаа сонгогдсон гишүүдийн 66.7 хувь, гурав дах удаагаа сонгогдсон гишүүдийн 50 хувийн төлөөллийг хамруулан авч үзсэн. Ингэхэд орон нутагт хийж гүйцэтгэсэн ажлын 29.1 хувь нь парламентад хоёр дах удаагаа сонгогдсон гишүүд, 22.3 хувь нь анхны удаагаа сонгогдсон гишүүд, 8.2 хувь нь тав дах удаагаа сонгогдсон, 7 хувь нь тав дах удаагаа сонгогдсон, 4 хувь нь гурав дах удаагаа сонгогдсон гишүүд тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл парламентын гадна төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг хангахад анхны болон хоёр дах удаагаа сонгогдсон гишүүд илүүтэй оролцсон болох нь харагдаж байна.

Хүснэгт 3. УИХ-ын гишүүдийн орон нутагт хийсэн ажилд хийсэн шинжилгээ

Судалсан УИХ-ын гишүүдийн тоо	УИХ-д сонгогдсон тоо	Төлөөлөх хувь	Гүйцэтгэсэн ажлын тоо
21	2	80.8	29.1
30	1	88.2	22.3

5	4	83.3	8.2
2	5	66.7	7
3	3	50	4

Эх сурвалж: Судлаачид www.parliament.mn албан ёсны эх сурвалжаас нэгтгэж боловсруулав.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 3-р зүйлийн 1-р хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн зааж Монгол Улсын Их Хурал бол төлөөллийн институци бөгөөд төрийн үйл хэрэгт иргэд шууд оролцох эрхтэй болохыг хуульчлан баталгаажуулсан баталгаажуулсан байна.

Ард түмэн сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан төрийн үйл хэрэгт шууд оролцон тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт асуух, санал өгөх эрхээ УИХ-ын цахим хуудас буюу [ЦАХИМ ПАРЛАМЕНТ \(parliament.mn\)](http://ЦАХИМ ПАРЛАМЕНТ (parliament.mn)) сайт, түүний гар утас хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан программ хангамжаар дамжуулан хэрэгжүүлэхээр заасан байгаа нь судлаач бидний хувьд хууль тогтоох институцийн төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхдээ дээрх цахим эх сурвалжийг албан ёсны эх сурвалж болгох боломжтой болох нь харагдаж байгаа юм. Иймд www.parliament.mn сайт, D-parliament аппликейшн дээр байгаа зарим мэдээлэлд дараах зарим дүн шинжилгээ хийн иргэдийн санаа бодлыг төрийн шийдвэрт хэрхэн тусган ажиллаж байгааг судалсан. Энэхүү цахим платформ дээр хуулийн төслийн талаар иргэдийн санаа бодлыг тусгахын тулд хуулийн төслийн заалтуудаар санал авдаг. Мөн D-parliament цахим платформыг ашигласнаар нь хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, нийтийн цахим хэлэлцүүлэг өрнүүлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод байдал хангагдах, нийтийн цахим хэлэлцүүлэг өрнүүлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод байдал хангагдана хэмээн эрх зүйн чадамжийг нь тодорхойлсон байдаг.(Эх сурвалж: [ХЭРХЭН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ САНАЛ ӨГӨХ ВЭ? \(parliament.mn\)](http://ХЭРХЭН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ САНАЛ ӨГӨХ ВЭ? (parliament.mn)))

Хууль тогтоох институцид, төрийг удирдах үйл хэрэгт Иргэдийн төлөөлөл хангагдах нэг үндэслэл бол хууль, тогтоомжид саналаа тусгах бөгөөд энэ талаар Үндсэн хууль, заалт, УИХ-ын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн дээр дурдсан заалтуудад тусгаж өгсөн байна. Дээрх хуулиудад хуулийн төсөл өргөн мэдүүлэхээс өмнө хууль санаачлагч нь хуульд өөрөөр заагаагүй бол олон нийт болон төрийн байгууллагаас санал авч болохоор заасан байна. Олон нийтийн хэлэлцүүлгийг бичгээр санал авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга явуулах; олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах; бусад хэлбэр зэргээр явуулдаг байна. Гэхдээ иргэд хуулийн хүрээнд саналаа өгөхөд цаг хугацааны хязгаар тавигдаж байна.

Зураг 2. Хуулийн төслүүд дээр иргэдийн саналыг хүлээж авах хугацааны ялгаатай байдал

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ГАНБААТАРЫН
ГАРГАСАН "НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС
ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ" ХУУЛИЙН
ТӨСЛИЙН 5.1 ДЭХ ХЭСГИЙГ ХАСАХ САНАЛ

ХАРАХ

Санал авч дууссан: 2023.05.04 - 06.30

ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ҮЕИЙН ХООЛЛОЛТ

ХАРАХ

Санал авч дууссан: 2023.09.12 - 10.06

АРД ИРГЭДИЙГ ТӨЛӨӨЛӨН АЖИЛЛАДАГ
ТӨРИЙН ХЯНАН ШАЛГАХ БИЕ ДААСАН
ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ АСУУДЛААР САНАЛ
АВЧ БАЙНА.

ХАРАХ

Санал авч дууссан: 2023.04.03 - 04.09

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ТАЙЛАН, САНАЛ, ДҮГНЭЛТЭД ТАНЫ
САНАЛЫГ НЭЭЛТТЭЙ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА

ХАРАХ

Санал авч дууссан: 2023.03.17 - 03.23

Эх сурвалж: [ЦАХИМ ПАРЛАМЕНТ \(parliament.mn\)](http://parliament.mn)

Дээрх зургаас харахад УИХ-ын гишүүн С.Ганбаатарын гаргасан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай” хуулийн төслийн 5.1(Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг даатгалын сангаас тус тус олгоно) дэх хэсгийг хасах дээр иргэдийн саналыг авах хугацаа 56 хоног; эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдлыг дэмжих үйл ажиллагаатай холбоотой жирэмсэн болон хөхүүл үеийн хооллолтын талаарх санал хүлээн авах хугацаа 42 хоног; ард иргэдийг төлөөлөн ажилладаг төрийн хянан шалгах бие даасан тогтолцоог бий болгох асуудлаарх саналыг хүлээж авах хугацаа 7 хоног; хөгжлийн банкны хянан шалгах түр хорооны тайлан, санал дүгнэлтэд санал хүлээн авах хугацаа 7 хоног байна. “D-parliament” цахим платформын хувьд санал авах хэсгээр хуулийн төсөлд санал өгөх хэсгийн хугацаа харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Мөн санал авахгүй гэх үндэслэл бүхий хуулийн заалтуудаар иргэдийн санал өгөх эрхийг нь хязгаарлах тохиолдол байна. Мөн иргэдийн авсан саналыг хэрхэн хууль, тогтоомж, шийдвэрт тусгагдсан, хэдэн хүн саналаа өгсөн, иргэдээс гарсан өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэж нэхэмжлэгч талд ямар хугацаанд эргэж мэдэгдсэн гэх төрийн үйл ажиллагааны ил тод байдал, төрийг удирдах үйл хэрэгт ард түмэн оролцох боломжийг цахимаар болон бусад хэлбэрээр хэрхэн хангаж ажиллаж байгаа талаарх бодит баримт, статистик тоон үзүүлэлт огт байхгүй байгаа нь төрийн институцийн үйл ажиллагаа, төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх хэмжих шалгуургүй болгож улмаар бодлогын залгамж чанар, ахиц дэвшлийг бодитоор тодорхойлох боломжгүй болгосоор байна.

Дүгнэлт

2020 оны сонгуулиар байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд:

1. Ингэхэд УИХ-ын хуралдаан ирцийн мэдээллийн бүрэн бүтэн байдал хангагдаагүй, хуралдааны ирц тухай бүр тавигддаггүй
2. Хуралдаанд тодорхой шалтгааны улмаар суухгүй, таслах, чөлөөтэй байх, хуралдааны хугацаанд орон нутагт ажиллах гэх мэт сонгогчдын төлөөллийн хэрэгжилтийг үнэлэх хамгийн эхний үзүүлэлт болох ирцийн асуудал хангалттай гэж үзэх хэмжээнд байхгүй байна.
3. Байнгын, түр, дэд хороодын хуралдааны тэмдэглэлээс харахад тухай бүрийн хуралдаанд оролцвол зохих УИХ-ын гишүүдийн 52-70 хүртэлх хувийн ирцтэйгээр хуралдсан байгаа нь ажиглагдсан.
4. УИХ-ын гишүүдийн орон нутагт сонгогчидтойгоо уулзах ажлын жагсаалтад төрийн дээд шагнал, одон медаль гардуулах, төсвийн бүтээн байгуулалтаар хийгдсэн ажлыг хүлээн авах, хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд оролцох, аймаг орон нутаг дах төрийн байгууллагуудаар зочлох гэх мэт уламжлалт ажлууд хэвээр хадгалагдсаар байна.
5. Хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны цахим эх сурвалжаар дамжуулан иргэдээс санал авч байгаа D-parliament апплкейшний хувьд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эрхээ ард түмэн эдлэх үйл явцад тухайн хуулийн төслийн ач холбогдол(УИХ-ын гишүүдийн хувьд эрх ашгийн зөрчилтэй байж болох боломжтой)-оор нь ялгаатай цаг хугацааны хязгаар тавьж байна.
6. Санал авахгүй гэх үндэслэл бүхий хуулийн заалтуудаар зарим чухал улс орны хөгжилтэй холбоотой асуудлаарх төсөлд иргэдийн санал өгч чадахгүй төрийн удирдах үйл хэрэгт оролцох эрхээ шууд ба шууд бусаар хязгаарлуулсаар байна.
7. Олон нийтийн санаа бодлыг авах цахим платформ, албан ёсны цахим эх сурвалжийн хувьд хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, нийтийн цахим хэлэлцүүлэг өрнүүлсэн, Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан, нийтийн цахим хэлэлцүүлэг өрнүүлсэн, Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод байдал хангасныг үнэлж дүгнэх үзүүлэлт бодит статистик хэмжүүр огт байхгүй байна.

Abstract:

In the theory of democracy, Parliament, is an institution of representation that creates a universally recognized legal entity that expresses national interests. Mongolia has been transitioning to a parliamentary system for 30 years, but the fundamental role of representing the people of the legislative constitution and strengthening representative democracy has been blurred, resulting in a decline in public trust in the institution. Therefore, in this study, we evaluated the representation functions of the Mongolian Great Ikh Khural, established in the 2020 elections, based on the views of researchers on the role of representation, as well as the participation of citizens and voters in the legislative process.

Keywords: Legislative institution, representatation, representative democracy

Ашигласан ном, материал

1. Buisseret, P., Folke, O., Prato, C., & Rickne, J. (2022). Party Nomination Strategies in List Proportional Representation Systems. *American Journal of Political Science*, 535-790.
2. Beer, S. H. (1957). The representation of interests in British government : Historical Background . *American Political science Review* , 616.
3. Cassinelli, C. W. (1950). *The concept representative government* .
4. Dahl, R. A. (1963). *Modern political analysis*. Prentice-Hall, Englewood Cliffs, N.J.

5. Fairlie, J. A. (1940). The Nature of Political representation. *American political science review* XXXIV, 244.
6. Ford, H. J. (New York). *Representative government*. 1924.
7. Азийн сан. (2023). *Монгол Улсын Сонгууль /1992-2021/*. Улаанбаатар.
8. Амаржаргал, П. (2015). Парламентын төлөөллийн мөн чанар, хөгжил, онол үзэл баримтлалын улс төр-эрх зүйн асуудал. П. Амаржаргал-Д, *Парламентын онол үзэл баримтлалын асуудал (Эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэл)* (хуудсд. 164-183). Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
9. НээлттэйНийгэмФорум. (2012). *Улсын Их Хурлын сонгууль 2012 "Шударга сонгуулийн төлөө иргэдийн хяналт" сүлжээнээс хийсэн мониторинг*. Улаанбаатар: НээлттэйНийгэмФорум.
10. Парламентын судалгааны хүрээлэн. (2020). Улсын Их Хурлын гишүүдийн чуулганы нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанд оролцсон байдлын талаарх судалгаа. *Парламент судалгааны эмхэтгэл*, 176-201.
11. Парламентын судлалын хүрээлэн. (2020). 1992 оноос хойш байгуулагдсан Улсын Их Хурлын Байнгын хорооны бүтэц, бүрэлдэхүүн. *Парламент судалгааны эмхэтгэл*, 202-267.

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООГ ЗОХИСТОЙ ТОГТООХ АСУУДАЛД

Д.Сүхболд

Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн профессор, доктор

Хураангуй:

Ард түмний олонхын хүсэл зоригийг илэрхийлж байдаг парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох зарим аргачлалын талаар өгүүлж, эцэст нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2023 оны нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлж 126 болгосон үндэслэлд онол-арга зүйн болон математик шинжилгээ хийх зорилгоор энэхүү өгүүллэгийг бичсэн.

Тодруулбал Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэх үндэслэл болсон куб язгуурын аргын үндэслэл, эерэг, сөрөг талуудыг харьцуулан судалж, онол-арга зүйн болон математик шинжилгээ хийсэн гэдгээрээ энэхүү өгүүллэг шинэлэг бөгөөд ач холбогдолтой байж болох юм.

Түлхүүр үгс: Үндсэн хууль, парламент, парламентын гишүүн, хүн амын тоо гишүүдийн тоо, куб язгуур

Оршил

Парламент хэдэн гишүүнтэй байх ёстой вэ, парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох шинжлэх ухааны аргачлал бий юу гэдэг нь орчин цагийн улс төрийн болон Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны анхаарал татсан, маргаантай асуудлын нэг. Учир нь парламентын гишүүдийн тоо хэд байх нь төлөөллийн чанар болон хууль тогтоох үйл ажиллагаа, цаашилбал улсын тусгаар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд шууд нөлөөлдөг. Иймээс энэхүү өгүүллэгээр парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох онол-арга зүйн хандлагууд болох газар нутаг, хүн амын тооноос хамааруулж тогтоох, 30 мянган сонгогч тутмаас нэг төлөөлөгч гэх Англи-Америкийн загвар, Эстонийн судлаач Рейн Таагеперагийн боловсруулсан куб язгуурын аргачлал зэрэгт харьцуулсан шинжилгээ хийхийг зорив. Эцэст нь Үндсэн хуулийн 2023 оны нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгож нэмэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж чадсан уу гэх асуултад математик шинжилгээний аргаар хариулахыг оролдсон.

Хүн амын тооноос куб язгуур авч парламентын гишүүдийн тоог тогтоох тухай Р.Таагеперагийн үндэслэл нь өөрөө учир дутагдалтай. Тодруулбал куб язгуурын арга нь гагцхүү 4 сая хүртэлх хүн амтай улсуудын хувьд тохирч болох агаад хэрэв хүн амын тоо 4 саяас дээш бол алдаа заах аргачлал юм. Үүнийг батлах зорилгоор парламентын гишүүдийн тоог нийт хүн амаас куб язгуур авч гаргасан тоотой харьцуулсан судалгааг парламентын нэг танхимтай 114 улсын жишээн дээр харуулав.

Парламентын гишүүдийн тоог газар нутаг, хүн амын тооноос хамааруулж тогтоох аргачлал

Ард түмний хүсэл зоригийг шууд илэрхийлдэг парламентын гишүүдийн тоог зохистой тогтооход газар нутгийн хэмжээ болон хүн амын тоо чухал нөлөөтэй. Тухайлбал хүн ам цөөхөн, жижиг улс орнуудын хувьд парламент дахь төлөөллийн тоо нь хэт цөөн байгаа тохиолдолд тэдгээр хэдхэн хүний дарангуйллал үүсэж болзошгүй тул үүнийг хязгаарлахын тулд тодорхой хэмжээгээр парламентын гишүүдийн тоог нь их болгох шаардлагатай.

Эсрэгээрээ хүн ам олонтой, газар нутгийн хэмжээ их улсуудын хувьд улс төрийн олон янзын хуваагдал, төөрөгдөл үүсгэхгүйн тулд парламент дахь төлөөллийн тоог тодорхой хэмжээгээр хязгаарлах нь зүйн хэрэг юм.¹

Түүнчлэн ихэнх судлаачид үзэхдээ парламентын гишүүдийн тоо нь тухайн улсын хүн амын тооноос хамаарах ёстой хэмээн үздэг. Энэ шалгуураар авч үзвэл 1 тэрбум 300 сая хүн амтай БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал 3000 гишүүнтэй байхад, 37 мянган хүн амтай Монакогийн Үндэсний зөвлөл 18 гишүүнтэй, 4 сая гаруй хүн амтай Либерийн Хууль тогтоох ассамблей 35 гишүүнтэй, 82 сая хүн амтай Туркийн Үндэсний дээд ассамблей 550 гишүүнтэй байх жишээтэй.

Эндээс харвал олон хүн амтай бол олон гишүүнтэй, цөөн хүн амтай бол цөөхөн гишүүн бүхий парламенттай байдаг гэх таамаглал үнэн мэт санагдана. Гэтэл энэ нь харьцангуй ойлголт. Тодруулбал БНХАУ-ын хувьд социалист улс төрийн дэглэмтэй учраас парламент нь засаг захиргааны нэгж бүрээс сонгогдсон маш олон депутат буюу 3000 гишүүнтэй байна. БНХАУ төдийгүй хуучин социалист системийн улсуудын парламент ихэнх нь олон гишүүнтэй байсан. Жишээлбэл социализмын үеийн БНМАУ засаг захиргааны нэгж бүрээс сонгогдсон 450 депутаттай байсан.

Монако, Либери улсуудын хүн амын тооны зөрүү бараг 3.700.000 атал парламентын гишүүдийн тооны зөрүү нь дөнгөж 17 байна.

Коста-Рика улс 4.800.000 мянган хүн амтай атлаа Хууль тогтоох ассамблей нь дөнгөж 57 гишүүнтэй. Ийнхүү парламентын гишүүдийн тоог хүн амын тооноос хамааруулан тогтоодог шалгуур нь харьцангуй шинжтэй.

Харин зарим судлаачид парламентын гишүүний тоо нь хүн амын тооноос хамаарах ёсгүй, гол нь парламент ард түмнийг төлөөлөх болон Засгийн газрын үйл ажиллагааг хянах үүргээ гүйцэтгэхийн тулд аль болох олон гишүүнтэй байх ёстой гэж үздэг. Эдүгээ парламентын гишүүдийн тооны дэлхийн дундаж бол 245-250 байдаг ба жижиг улсууд буюу 10 сая доторх хүн амтай улсуудын парламентын гишүүдийн дундаж тоо 100-120 байдаг.²

Гучин мянган сонгогч тутмаас нэг төлөөлөгч гэх Англи-Америкийн загвар

Нэг танхимтай парламент болон хоёр танхимтай парламентатын доод танхимын гишүүдийн тоог авч үзвэл ихэнхдээ 30 мянган сонгогч тутмаас нэг төлөөлөгч сонгох байдлаар бүрдүүлсэн байдаг. Тухайлбал АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хоёрдугаар хэсэгт доод буюу Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн тоог тогтоохдоо “...гучин мянган сонгогчийг төлөөлөх төлөөлөгчийн тоо нэгээс хэтрэхгүй байна”³, “...хүн амын тооны өсөлтөөс шалтгаалж 10 жил тутам хүн амын тооллого явуулж, Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн тоог өсгөх ёстой”⁴ талаар заажээ. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийг 30 мянган сонгогчоос нэг төлөөлөгч сонгож бүрдүүлэх тус аргачлалыг АНУ-ын Үндсэн хуулийн тайлбар гэж хэлж болох Холбооны баримт бичгийн 55 дугаар нийтлэлд ч өгүүлсэн байдаг.⁵

Гэтэл түүхийг сөхөн үзвэл АНУ 1776 онд Үндсэн хуулиа батлахдаа, Их Британи улсын Нийтийн танхимаа бүрдүүлэхэд ашигладаг 30 мянган сонгогч тутмаас нэг төлөөлөгч сонгодог загвараас санаа авсан гэдгийг мэдэж болно. Тухайн үед Англи, Шотланд улсууд 8 сая хүнтэй байсан бөгөөд эдгээр 8 сая хүнийг Нийтийн танхимын 585 хүн төлөөлдөг байв.⁶

¹ The Federalist papers 10 - The Same Subject Continued. The Union as a Safeguard Against Domestic Faction and Insurrection. (James Madison)

² Д.Сүхболд, Р.Ууганбаатар, Д.Лхагвасүрэн нар “БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи” 127 дахь тал. УБ., 2020

³ Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль” Нэгдүгээр зүйл: Хоёрдугаар хэсэг. 21 дахь тал. УБ., 2000. Орч. Д.Цолмон, Ч.Лхагважав.

⁴ Мөн тэнд

⁵ “Full text of The Federalist papers-55” The Same Subject Continued: The Total Number of the House of Representatives. (James Madison) <https://guides.loc.gov/federalist-papers/full-text>

⁶ “Full text of The Federalist papers-56” The Same Subject Continued: The Total Number of the House of Representatives. (James Madison) <https://guides.loc.gov/federalist-papers/full-text>

Харин 1776 оны АНУ-ын Үндсэн хуулийг зохиогчид Английн 8 сая хүний эрх ашгийг жинхэнээсээ төлөөлж буй хүмүүс нь яг үнэндээ сонгогдсон тойрогтоо оршин суудаг 279 төлөөлөгч бөгөөд нэг хүн 28670 хүний эрх ашгийг хамгаалж байна гэж үзээд, Англитай харьцуулан харваас 30 мянган сонгогчийг нэг гишүүнээр төлөөлүүлэх нь олонхын эрх ашгийг хамгаалах хангалттай боломжтой загвар хэмээн үндсэн хуульчилжээ. Энэ үүднээс тус аргачлалыг парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох “Англи-Америкийн загвар” гэж нэрлэж болохоор.

Англи-Америкийн гэгдэх загвар дахь нэг танхимтай болон хоёр танхимтай парламентын доод танхимын гишүүдийн тоог тогтоохдоо 30 мянган сонгогчоос нэг гишүүн сонгоно гэдэг бол зүгээр нэг сэтгэлийн хөөрлөөр гаргаад ирсэн тоо биш агаад энэ нь парламент дахь төлөөллийн зохистой харьцааг тогтооход хамгийн тохиромжтой харьцаа гэж үзэж болно. Тухайлбал ОХУ 150 сая хүнтэй атлаа 618 гишүүнээс бүрдсэн парламенттай, бол АНУ 370 сая хүнтэй мөртлөө 535 гишүүнээс бүрдсэн парламенттай байна.

Хэрвээ эдгээр улсуудын парламентын гишүүдийг 30 мянган сонгогчоос нэг төлөөлөгч гэсэн зарчмаар тооцвол ОХУ таван мянга, АНУ арван хоёр мянган гишүүнээс бүрдсэн парламенттай байх ажээ. Гэтэл эдгээр улсуудын Үндсэн хуулийн түүхээс харвал ард иргэдийн цөөхөн төлөөлөл нь тоогоо аажмаар нэмэгдүүлж, энэ хэрээр ач холбогдолтой болж ирсний дараагаар дахин тоогоо бууруулсан нь эрх мэдлийн хуваарилалт, тэдгээрт оногдох хяналтыг зохистойгоор тавих шаардлагаас үүдсэн байна. Өөрөөр хэлбэл өмнө өгүүлсэнчлэн хүн ам олонтой, газар нутгийн хэмжээ их улсуудын хувьд улс төрийн олон янзын хуваагдал, төөрөгдөл үүсгэхгүйн тулд парламент дахь төлөөллийн тоог тодорхой хэмжээгээр хязгаарлах нь зүйн ёсны хэрэг болж байна.

Хоёр танхимтай парламентын дээд танхимын гишүүдийн тоог зохистой тогтоох аргачлал

Хууль тогтоох байгууллага нь хоёр танхимтай бол дээд танхимын гишүүдийн тоо доод танхимын гишүүдээс ямагт бага байдаг, бага байхаас өөр аргагүй байдаг нь олон улсын жишиг юм. Энэ нь дээд танхимын өөрийнх нь онцлог шинжүүдтэй холбоотой. Үүнд *нэгдүгээрт*, дээд танхимын хувьд тухайн улсын нэрийн өмнөөс гадаад улстай гэрээ байгуулах, хэлэлцээр хийх асуудлаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөх, Ерөнхийлөгчийн гадаад улстай байгуулах гэрээ хэлэлцээрийг чуулганаар хэлэлцэж батлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах, шүүх эрх мэдлийг байгуулахад оролцох, төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар эцсийн шийдвэрийг гаргах (импичмент) доод танхимаас баталсан хуулийн төслийг хянан хэлэлцэх, онц болон дайны байдал тогтоох зэрэг улсын болон олон улсын түвшний, бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд голлон оролцдог улсын түвшний эрх бүхий хууль тогтоох байгууллага юм.

Засгийн эрхийг олны дундаас шилэгдсэн тогтвортой удирдагч нар эс барих аваас гадаад улс орнууд тухайн улсын ул суурьгүй, холбирсон гадаад бодлогыг өөрсдөдөө давуутайгаар ашиглаж болзошгүй. Энэхүү аюулын эсрэг доод танхимын эрх мэдэл хангалтгүй. Учир нь доод буюу ард түмнийг төлөөлдөг танхимын гишүүд улсын хэргийг гадаад улсад төлөөлөх асуудалд тэр бүр ач холбогдол өгдөггүй бөгөөд зөвхөн өөрийн сонгогдсон тойргийн итгэл, хүндлэлийг олж авахад илүү анхаардаг. Үнэхээр урт хугацааны стратеги, олон улсын харилцаатай холбогдсон бодлогыг хэрэгжүүлэхэд бүрэлдэхүүн нь байнга солигдож байдгийн зэрэгцээ олон хүнээс бүрдсэн доод танхим нь хангалтгүй юм.

Харин эсрэгээрээ цөөн тоотой бөгөөд гишүүн бүр нь нийтийн өмнө хариуцлага хүлээх байдлаар зохион байгуулагдсан, урт хугацааны бүрэн эрхийг хэрэгжүүлэгч дээд танхим л энэхүү улсын түвшний чиг үүргийг гүйцэтгэх боломжтой.

Хоёрдугаарт, хууль тогтоох байгууллагын гишүүдийн тоо нь олон байх тусам шийдвэр гаргахад нөлөөлж буй хүмүүсийн тоо нь цөөн болдог зүй тогтлыг бид ойлгох хэрэгтэй. Анхаарал татахуйц энэ асуудлын цаад шалтгаан нь хүний тоо олон болох тусам шийдлийг баримтад тулгуурлах бус сэтгэлийн хөөрлөөр гаргах магадлал өндөртэй болдогт

оршиж байгаа юм. Хууль тогтоох байгууллагын гишүүдийн тоо олон байх тусам тэдгээрийн дотор мэдлэг, мэдээлэл хомс хүмүүсийн эзлэх хувь мөн л их болж ирдэг.

Ер нь цөөн тооны бусдыг ятгах чадвартай хүмүүс л олны гаргаж буй шийдвэрт нөлөөлөх боломжтой байдгийг түүхээс харж болно. Тухайлбал Эртний Грек, Ром зэрэг улсуудад шийдвэр гаргахаар бүх хүнийг цуглууллаа ч гэсэн уран цэцэн үгтэй ганцхан хүн бусдынхаа бодлыг өөрчилж, хүссэн шийдвэрээ гаргуулж чаддаг байсан тул эцэстээ шийдвэр олных бус нэг хүнийх болон хувирдаг байжээ. Үүнээс харвал гишүүдийн тоо олон байснаар шийдвэр зөв гардаг гэвэл худлаа юм. Өөрөөр хэлбэл гишүүдийн тоо олон байлаа ч шийдвэр гаргагч нарын тоо бага хэвээрээ байх юм.

Хууль тогтоох байгууллагыг бүрдүүлэх мэдлэг боловсролтой гишүүдийн тоо нэмэгдэх тусам алдаа мадаггүй хууль, шийдвэрүүдийн тоо багасдаг энэхүү онцлог дээд танхимд илүү их хамааралтай. Тиймээс дээд танхимын гишүүдийн тоог нэмэх гэж мунхагаар хандахын оронд гишүүдийн ур чадвар, ухаан билигт илүү ач холбогдол өгвөл зохилтой юм. Засаглал харагдах байдлаараа ардчилсан мэт боловч мөн чанараараа олигархи хэв шинжтэй болохоос урьдчилан сэргийлэх нь хүн төрөлхтний анхаарах ёстой асуудлын нэг гарцаагүй мөн. Иймээс дээд танхимын гишүүдийн тоог ямагт багаар тогтоодог зүй тогтолтой.¹

Рейн Таагеперагийн боловсруулсан куб язгуурын аргачлал

Парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох шалгуурын талаар Эстони гаралтай улс төр судлаач, физикч Рейн Таагепера 1972 онд “Үндэсний хурлын гишүүдийн тоо” сэдэвт судалгааны өгүүлэл бичсэн нь анхаарал татдаг. Түүний өгүүллэгт парламентын гишүүдийн тоог тогтоох шалгуурыг дараах байдлаар нэрлэжээ. Үүнд (1) Хүн амын тоо (2) Эдийн засгийн хөгжлийн түвшин (3) Нийгмийн дэмжлэгийн түвшин, (4) Тухайн үндэстний даасан байдал, тусгаар тогтнолын баталгаа, (5) Сонгуулийн системийн онцлог буюу тухайн парламентын гишүүд сонгогддог эсвэл томилогддог эсэх, (6) Парламентын чиг үүрэг нь шийдвэр гаргах, зөвшилцөл, хэлэлцүүлэг дээр тулгуурладаг эсэх (7) Парламентын гишүүдийн тоог эрт үеэс хэрхэн тогтоож ирсэн туршлага, жишээ (8) Тухайн үндэстний өвөрмөц байдал буюу менталитет гэсэн найман шалгуурыг нэрлэжээ.²

Судлаач Р.Таагеперагийн хувьд эдгээр шалгуураас хүн амын тоо, болон нийгмийн дэмжлэгийг авах гэсэн хоёр шалгуурыг үндэслэл болгон парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох куб язгуурын аргачлалыг боловсруулсан агаад хоёр танхимтай улсуудын хувьд зөвхөн доод танхимыг судалгаандаа хамруулжээ.

Тодруулбал парламентын гишүүдийн тоог хүн амын тоотой харьцуулж үзээд парламентын гишүүдийн тоо нь хүн амын тооны гуравны нэг зэрэгт буюу куб язгуур гаргасантай ойролцоо байвал зохимжтой гэж үзсэн. Тэрээр тус дүгнэлтдээ тулгуурлаад куб язгуур гэдэг математик аргачлал байна, харин цаана нь ямар агуулга байж болох вэ гэдгийг загварчилж харуулсан.

Судлаачийн санаа бол парламентын гишүүдэд бусад гишүүдтэйгээ харилцах болон тойргийн сонгогчидтойгоо харилцах харилцаа холбоо маш чухал. Тойргийн сонгогчидтой харилцах харилцаа нь хүн амын юу хүсч байгааг илэрхийлэх бол бусад гишүүдтэй харилцах харилцаа нь парламент болон Засгийн газарт сонгогчдын хүсэлтийг хууль тогтоомж болгон өөрчлөх боломжийг олгоно.³ Хэрэв парламент хэт цөөн тооны гишүүдтэй бол гишүүн бүрийн тойргын сонгогчид болон бусад гишүүдтэй харилцах харилцаанд хүндрэл үүснэ. Өөрөөр хэлбэл парламентын гишүүн сонгогчид болон бусад гишүүдтэй харилцахын тулд өөрт байгаа цаг хугацаа, хүч энергээ дэмий барах эрсдэлтэй.

¹ Д.Сүхболд, Р.Ууганбаатар, Д.Лхагвасүрэн нар “БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи” 187 дахь тал. УБ., 2020

² Social science research 1, 385-401 (1972) “The Size of National Assemblies” Rein Taagepera

³ Math Could Help Set Right the Sizes of National Legislatures. <https://www.insidescience.org/news/math-could-help-set-right-sizes-national-legislatures>

Тухайлбал тойргийн сонгогчидтой харилцах харилцаа бол нэг цэгийг олон цэгтэй холбох амаргүй явдал байдаг. Тэгэхээр парламентын гишүүн өөрт байгаа цаг хугацаа, хүч, энергээ 50, 50 хувиар хувааж энэ хоёр харилцаандаа зөв хуваарилах хэмжээний байх ёстой, үүнийг куб язгуурын аргаар тогтоох ёстой гэсэн санаа юм. Улмаар түүний төрөлх Эстони улс 1991 онд ЗХУ-аас салж, тусгаар тогтнох үедээ парламент буюу Рийгикогугийн гишүүдийн тоог түүний зөвлөснөөр нэг сая хүн амын тооноос куб язгуур авч 101 гишүүнтэй болсон түүхтэй.

Орчин үед түүний дэвшүүлсэн куб язгуурын аргыг хэрэглэхэд төвөгтэй. Учир нь нэгдүгээрт, Р.Таагеперагийн хувьд нэг танхимтай парламент бүхий улсууд, эсвэл хоёр танхимтай бол зөвхөн доод танхимын гишүүдийн тоог энэ аргачлалаар авч үзсэнээрээ учир дутагдалтай. Парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох аргачлал нь нэг танхимтай парламент төдийгүй, хоёр танхимтай парламентын танхим бүрийн гишүүдийн тоог ч зохистой тогтоох боломжтой байх ёстой.

Хоёрдугаарт, тус аргачлал зөвхөн 4 сая доторх хүн амтай улсуудад тохирох талтай. Хүн амын тоо 4 саяас дээш болбол тус аргачлал буруу тийшээ хазайна. Энэ нь хүн амын тоо өсөх тусам парламентын гишүүдийн тоо хэмжээ хязгааргүй ихсэх хандлагаар илэрнэ. Тухайлбал Монгол Улс 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр парламентын гишүүдийн тоогоо нэмэх үндэслэлээ хоёр сая сонгуулийн насны иргэдээс куб язгуур авч 126 болгосон. Гэтэл Монгол Улсын хүн ам цаашдаа 10 саяас дээш болж нэмэгдвэл яах вэ гэсэн асуултад бид хариулах ёстой. Тодруулбал АНУ-ын 322 сая хүн амаас куб язгуур авбал Төлөөлөгчдийн танхим нь 435 биш, 685 гишүүнтэй, Австралийн 23 сая хүн амаас куб язгуур авбал Төлөөлөгчдийн танхим нь 148 биш 284 гишүүнтэй байх тооцоо гарч байна.

Гуравдугаарт, куб язгуурыг нийт хүн амын тооноос авах уу, эсвэл сонгуулийн насны иргэдийн тооноос авах уу гэдэг нь маргаантай. Р.Таагеперагийн хувьд насанд хүрсэн иргэдийн бичиг үсэг тайлагдсан хэсгээс куб язгуур авах санааг дэвшүүлсэн байдаг. Тэгвэл насанд хүрсэн иргэдийн бичиг үсэг тайлагдсан хэсэг гэдгийг орчин үе дахь сонгуулийн насны иргэд гэдэгтэй дүйцүүлж болох уу гэдэг нь эргэлзээтэй.

Энэ мэтээр парламентын гишүүдийн тоог тогтоох арга, аргачлалууд их байдаг авч зарчмын хувьд бид нэг зүйлийг ойлгох ёстой. Энэ нь улс хэдий жижиг ч засаг барих төлөөллийн тоо нь хэт цөөн байгаа тохиолдолд тэдгээр хүний дарангуйлал үүсч болзошгүй тул үүнийг хязгаарлахын тулд тодорхой хэмжээгээр тоог нь их болгох шаардлагатай байдаг бол улс хэдий том байвч төөрөгдөл үүсгэхгүйн тулд засагт буй төлөөллийн тоог тодорхой хэмжээгээр хязгаарлах нь зүйн хэрэг юм. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд сонгуулиар гаргах төлөөлөгчдийн тоог тогтоохдоо иргэдийнх нь тоонд бус засаглалын үр дүнтэй байдалд илүү анхаарах нь чухал юм.

Түүнчлэн томоохон улсын хувьд парламентын гишүүнээр сонгогдож буй хүмүүс нь сонгуулийг будилуулах замаар сонгогдох магадлал бага байдаг бөгөөд иргэд хамгийн зөв хүнээ чөлөөтэйгээр сонгох альтернатив боломжтой байдаг. Харин жижиг улсын хувьд энэ байдал эсрэгээр буюу сонгуульд нэр дэвшигчид сонгуулийг будлиантуулах боломжтойгоос гадна мэдлэг боловсролтой, зөв хүнээ сонгох альтернатив боломж багатай. Энэ нь нийт хүн амын тоо цөөхөн байдагтай холбоотой.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгож нэмэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж чадсан эсэх

Монгол Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байх” Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, гишүүдийн 86 хувийн саналаар эцэслэн баталсан. Миний бие парламент судлаачийн хувьд Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмсэн энэхүү явдалд зарим улс төрийн шинжилгээг хийсэн. Ингэхдээ хараат бус, хөндлөнгийн судлаачдын зөвлөмж, саналыг тусгасан эсэх, хамгийн гол нь судалгаа, шинжилгээнд үндэслэж чадсан эсэхэд анхаарал хандуулж, энэ талаарх зарим шинжилгээг хийснээ өгүүллэгийн энэхүү хэсэгт толилуулья.

Эрх баригчдын хувьд парламентын гишүүдийн тоог нэмэх шинжлэх ухааны үндэслэлийг Эстони гаралтай улс төр судлаач, физикч Р.Таагеперагийн 1972 онд боловсруулсан хүн амын тооноос куб язгуур авах аргаар тогтоох явдал хэмээн сурталчилсан. Гэтэл Рейн Таагеперагийн 1972 онд бичсэн “Үндэсний хурлын гишүүдийн тоо” сэдэвт судалгааны өгүүллийг уншиж үзвэл парламентын гишүүдийн тоог тогтоохдоо хүн амын тооноос куб язгуур авах ганцхан аргаар биш буюу (1) хүн амын тоо, (2) эдийн засгийн хөгжлийн түвшин, (3) Нийгмийн дэмжлэгийн түвшин, (4) Тухайн үндэстний даасан байдал, тусгаар тогтнолын баталгаа, (5) Сонгуулийн системийн онцлог буюу тухайн парламентын гишүүд сонгогддог эсвэл томилогддог эсэх, (6) Парламентын чиг үүрэг нь шийдвэр гаргах, зөвшилцөл, хэлэлцүүлэг дээр тулгуурладаг эсэх, (7) Парламентын гишүүдийн тоог эрт үеэс хэрхэн тогтоож ирсэн туршлага, жишээ, (8) Тухайн үндэстний өвөрмөц байдал буюу менталитет гэсэн найман шалгуурыг нэрлэсэн тухай өмнө өгүүлсэн билээ.

Гэтэл эрх баригчдын хувьд эдгээр найман шалгуураас зөвхөн хүн амын тоо гэх ганцхан шалгуурыг Монгол Улсын парламентын гишүүдийн тоог нэмэх шинжлэх ухааны үндэслэл болгосон нь харамсалтай. Эрх баригчдын дурдаагүй зарим шалгуурыг авч үзвэл тухайлбал парламентын гишүүдийн тоо нь нийгмийн дэмжлэгийн түвшинтэй шууд холбоотой. Өөрөөр хэлбэл нийгмийн дэмжлэгийг авч чадахгүй бол гишүүдийн тоог нэмж болохгүй. Түүнчлэн эдийн засгийн хөгжлийн түвшин нь гишүүдийн тоог тодорхойлох гол хүчин зүйл. Өөрөөр хэлбэл тухайн улсын эдийн засгийн хөгжил сул, эсвэл сайн байх нь парламентын гишүүдийн тоог тогтооход харгалзан үзэх гол шалгуур юм.

Тэрчлэн парламентын гишүүдийн тоог эрт үеэс тогтоож ирсэн туршлага нь засаг захиргааны нэгж бүрээс сонгогдсон, маш олон гишүүдтэй байнгын бус ажиллагаатай Ардын Их Хурлаар хязгаарлагдах агаад, тодруулбал манай улсын хувьд парламентын гишүүдийн тоог тогтоож ирсэн хангалттай туршлага байхгүй. Тэгэхээр гадны улсууд дахь парламентын гишүүдийн тоог зохистой тогтоож ирсэн туршлагаас санаа авах ёстой болно.

Ийнхүү эрх баригчид парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох тухай Р.Таагеперагийн санааг мушгин гуйвуулж зөвхөн хүн амын тооноос куб язгуур авах аргыг нь Монгол Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэх гол үндэслэл болгожээ.

Гэтэл хүн амын тооноос куб язгуур авч парламентын гишүүдийн тоог тогтоох тухай Р.Таагеперагийн үндэслэл нь өөрөө учир дутагдалтай. Тодруулбал куб язгуурын арга нь гагцхүү 4 сая хүртэлх хүн амтай улсуудын хувьд тохирч болох агаад хэрэв хүн амын тоо 4 саяас дээш бол алдаа заах аргачлал юм. Үүнийг нэг танхимтай парламент бүхий 114 улсын жишээн дээр харьцуулсан судалгаа хийж харуулав.

Хүснэгт 1. Парламентын гишүүдийн тоог нийт хүн амаас куб язгуур авч гаргасан тоотой харьцуулсан судалгаа (парламентын нэг танхимтай улсуудын жишээн дээр)

Д/д	Улсын нэр	Хүн амын тоо	Парламентын нэр	Гишүүдийн тоо	Куб язгуураар гаргасан тоо	4 саяас бага хүн ам	Гишүүдийн тоо куб язгуур хоёр зөрүү
1	Австри	8,458,023.00	Холбооны Ассамблей	64	203.746248		
2	Азербайджан	9,235,100.00	Милли Межлис	125	209.80405		

3	Албани	3,063,320.00	Ассамблей	140	145.23260 3	тийм	- 5.2326032 8
4	Ангол	19,088,106.0 0	Үндэсний Ассамблей	220	267.25198 9		
5	Андорра	76,246.00	Дээд Ерөнхий Зөвлөл	42	42.403888 9	тийм	- 0.4038889 3
6	Сири	21,895,150.0 0	Ард түмний Зөвлөл	250	279.75808 2		
7	Армен	3,060,631.00	Армений Дээд Зөвлөл буюу Үндэсний Хурал	190	145.19009 6	тийм	44.809904 5
8	Беларус	9,463,300.00	Үндэсний Ассамблей	260	211.5181		
9	Бенин	10,160,556.0 0	Үндэсний Ассамблей	83	216.59037 7		
10	Болгар	7,284,552.00	Үндэсний Ассамблей	240	193.85080 8		
11	Ботсван	2,155,784.00	Үндэсний Ассамблей	47	129.18192 4	тийм	- 82.181923 9
12	Бурунди	9,420,248.00	Үндэсний Ассамблей	81	211.19685 4		
13	Бутан	733,643.00	Парламент	150	90.190665 7	тийм	59.809334 25
14	Вануату	266,937.00	Парламент	50	64.387702	тийм	- 14.387702
15	Вьетнам	93,421,835.0 0	Үндэсний Ассамблей	395	453.74947		
16	Гайна	735,554.00	Ардын Үндэсний Конгресс	65	90.268907 7	тийм	- 25.268907 7
17	Гана	27,043,093.0 0	Парламент	200	300.15951 9		
18	Гватемал	14,647,083.0 0	Конгресс	80	244.67168 6		
19	Гвиней	11,474,383.0 0	Үндэсний Ассамблей	144	225.55014 7		
20	Гвиней- Биссау	1,693,398.00	Үндэсний Ардын Их Хурал	100	119.19362 1	тийм	- 19.193621 2
20	Гондурас	8,893,259.00	Үндэсний Конгресс	128	207.18277 6		
21	Грек	9,903,268.00	Депутатууд ын танхим	300	214.74654 1		
22	Гүрж	4,490,500.00	Парламент	235	164.98010 2		

23	Дани	5,707,622.00	Фолькетинг	179	178.71118 5		
24	Доминик	10,349,741.0 0	Ассамблей	32	217.92639 1		
25	Жибути	810,179.00	Үндэсний Ассамблей	65	93.223841 3	тийм	- 28.223841 3
26	Зайр	77,433,744.0 0	Парламент	738	426.22941 6		
27	Замби	14,638,505.0 0	Үндэсний Ассамблей	155	244.62391 3		
28	Зимбабве	13,771,721.0 0	Парламент	150	239.69707 7		
29	Израиль	8,120,300.00	Кнессет	120	200.99751 7		
30	Индонез	253,609,643. 00	Төлөөлөгчди йн танхим	500	632.97795 9		
31	Ирак	32,585,692.0 0	Үндэсний Ассамблей	250	319.40544 5		
32	Иран	80,840,713.0 0	Исламын Зөвлөх Ассамблей	248	432.39106 6		
33	Исланд	321,857.00	Альтинг	63	68.531092 1	тийм	- 5.5310921 4
34	Йемен	24,527,000.0 0	Төлөөлөгчди йн танхим	301	290.54593 9		
35	Кабо Верде	538,535.00	Үндэсний Ассамблей	72	81.358820 7	тийм	- 9.3588206 6
36	Камерун	20,386,799.0 0	Үндэсний Ассамблей	180	273.18049		
37	Кени	45,010,056.0 0	Үндэсний Ассамблей	202	355.71582 3		
38	Кипр	1,122,544.00	Төлөөлөгчди йн танхим	56	103.92845 2	тийм	- 47.928451 8
39	Кирибати	104,488.00	Ассамблей	41	47.100133 6	тийм	- 6.1001335 8
40	Коморын арал	766,865.00	Парламент	43	91.532004 3	тийм	- 48.532004 3
41	Коста Рика	4,713,168.00	Хууль тогтоох Ассамблей	57	167.66315 7		
42	Кот-дивуар	22,671,331.0 0	Үндэсний Ассамблей	168	283.02556 9		
43	Куба	11,047,251.0 0	Үндэсний Ассамблей	601	222.71599 4		

44	Кувейт	2,742,711.00	Үндэсний Ассамблей	50	139.97807 5	тийм	- 89.978074 8
45	Лаос	6,803,699.00	Үндэсний Ассамблей	85	189.48799 4		
46	Латви	2,027,000.00	Сейм	100	126.55653 7	тийм	- 26.556537 1
47	Либерии	4,092,310.00	Хууль тогтоох шилжилтийн Ассамблей	35	159.95193 9		
48	Ливан	5,882,562.00	Үндэсний Ассамблей	128	180.51868 9		
49	Ливи	6,244,174.00	Бүх ард түмний Конгресс	750	184.14432 2		
50	Литва	2,939,431.00	Сейм	137	143.24773 3	тийм	- 6.2477326 8
51	Лихтенштейн	36,842.00	Диет	25	33.274719 2	тийм	- 8.2747192 1
52	Люксембург	563.00	Депутатууд ын танхим	60	8.2572632 7	тийм	51.742736 73
53	Маврикий	1,331,155.00	Үндэсний Ассамблей	71	110.00427	тийм	- 39.004269 8
54	Мадагаскар	21,842,167.0 0	Үндэсний Ассамблей	134	279.53224 2		
55	Македон	2,058,539.00	Бүгд Найрамдах Улсын Ассамблей	130	127.20954 5	тийм	2.7904548 45
56	Малави	15,805,239.0 0	Парламент	194	250.95760 2		
57	Мали	16,455,903.0 0	Үндэсний Ассамблей	129	254.35517 2		
58	Мальдив	393,595.00	Иргэдийн Мажлис	48	73.285241 7	тийм	- 25.285241 7
59	Мальт	446,547.00	Төлөөлөгчдийн танхим	69	76.434434 8	тийм	- 7.4344348 3
60	Марокко	33,542,001.0 0	Мажлис Наваб	333	322.49995 3		
61	Маршаллын арлууд	70,983.00	Парламент	33	41.404872 4	тийм	- 8.4048723 5
62	Микронезийн Холбооны улс	105,681.00	Конгресс	14	47.278712 1	тийм	- 33.278712 1

63	Мозамбик	23,700,715.0 0	Бүгд найрамдах улсын Ассамблей	250	287.24588 5		
64	Молдав	3,555,200.00	Парламент	104	152.62347 8	тийм	- 48.623477 9
65	Монако	36,950.00	Үндэсний Зөвлөл	18	33.307201 7	тийм	- 15.307201 7
66	Монгол	3,238,479.00	Улсын Их Хурал	76	147.94956 6	тийм	- 71.949565 8
67	Монтонегро	650,036.00	Скупстина	75	86.625509 7	тийм	- 11.625509 7
68	Науру	9,488.00	Парламент	18	21.170196 6	тийм	- 3.1701966 4
69	Нигер	177,155,754. 00	Ассамблей	83	561.63188 3		
70	Никарагуа	6,167,237.00	Үндэсний Ассамблей	93	183.38488 9		
71	Панам	3,608,431.00	Хууль тогтоох Ассамблей	72	153.38143 7	тийм	- 81.381436 8
72	Папуашинэ Гвиней	6,552,730.00	Үндэсний Парламент	109	187.12885 4		
73	Перу	30,147,935.0 0	Конгресс	120	311.23315 6		
74	Португали	10,427,301.0 0	Бүгд найрамдах улсын Ассамблей	230	218.46941		
75	Руанда	12,337,138.0 0	Шилжилтий н Үндэсний Ассамблей	70	231.06711 4		
76	Сальвадор	6,125,512.00	Хууль тогтоох Ассамблей	84	182.97038 3		
77	Самоа	196,628.00	Хууль тогтоох Ассамблей	49	58.149830 6	тийм	- 9.1498306 1
78	Сан Марино	3,248.00	Ерөнхий Дээд Зөвлөл	60	14.809441 3	тийм	45.190558 74
79	Сао Томе ба Принсипи	190,428.00	Үндэсний Ассамблей	55	57.532105 6	тийм	- 2.5321055 7
80	Саудын Араб	30,770,375.0 0	Мажлис Аль Шура	120	313.36050 8		
81	Сейшелийн арлууд	9,165.00	Үндэсний Ассамблей	33	20.927185 5	тийм	12.072814 54

82	Сенегал	13,567,338.0 0	Үндэсний Ассамблей	120	238.50539 9		
83	Сент Винсент ба Гренада	102,918.00	Ассамблей	21	46.863038 7	тийм	- 25.863038 7
84	Сент Китс ба Невиз	51,538.00	Үндэсний Ассамблей	15	37.214242 8	тийм	- 22.214242 8
85	Серб	7,209,764.00	Бүгд найрамдах улсын Ассамблей	250	193.18512 5		
86	Сингапур	5,312,400.00	Парламент	84	174.48720 6		
87	Соломоны арлууд	609,883.00	Үндэсний Парламент	47	84.803838 3	тийм	- 37.803838 3
88	Солонгос /БНАСАУ/	24,851,627.0 0	Ардын Их Хурал	687	291.82216 5		
89	Солонгос /БНСУ/	49,039,986.0 0	Үндэсний Ассамблей	299	366.03008 2		
90	Судан	35,482,233.0 0	Мажлис Ватани	400	328.60208 5		
91	Суринам	573,311.00	Үндэсний Ассамблей	51	83.073675 3	тийм	- 32.073675 3
92	Сьерра Леоне	5,743,725.00	Парламент	80	179.0872		
93	Тажикстан	8,161,000.00	Дээд Зөвлөл	181	201.33276 6		
94	Танзани	49,639,138.0 0	Үндэсний Ассамблей	275	367.51472 4		
95	Того	7,351,374.00	Үндэсний Ассамблей	81	194.44174 3		
96	Тонга	10,644.00	Хууль тогтоох Ассамблей	30	21.997244 8	тийм	8.0027551 66
97	Төв Африкийн БНУ	5,277,959.00	Парламент	85	174.10931 4		
98	Тувалу	10,782.00	Парламент	13	22.091902 1	тийм	- 9.0919020 6
99	Тунис	10,886,500.0 0	Депутатууд ын танхим	163	221.63044 9		
100	Турк	81,619,392.0 0	Үндэсний Дээд Ассамблей	550	433.77493 3		
101	Уганда	35,918,915.0 0	Парламент	276	329.94463 4		
102	Узбекстан	29,559,100.0 0	Олий Мажлис	250	309.19353 3		

103	Украйн	44,291,413.0 0	Дээд Рада	450	353.81250 5		
104	Унгар	9,957,731.00	Үндэсний Ассамблей	386	215.13948 8		
105	Финлянд	5,422,950.00	Эдускунта	200	175.68925 5		
106	Хятад	1,373,505,51 1.00	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчди йн Их Хурал	2978	1111.5870 2		
107	Чад	11,412,107.0 0	Үндэсний Ассамблей	52	225.14135 6		
108	Швед	9,551,781.00	Риксдаг	349	212.17528 1		
109	Шинэ Зеланд	4,198,260.00	Төлөөлөгчди йн танхим	120	161.32058 1		
110	Шри Ланка	20,675,000.0 0	Үндэсний Ассамблей	225	274.46175 7		
111	Эквадор	15,445,691.0 0	Үндэсний Конгресс	82	249.04000 4		
112	Экваторын Гвиней	722,254.00	Ардын төлөөлөгчди йн танхим	80	89.721526 1	тийм	- 9.7215260 8
113	Эритрея	6,380,803.00	Үндэсний Ассамблей	105	185.47773 3		
114	Эстон	1,312,252.00	Рийгикогу	101	109.48108 2	тийм	- 8.4810820 6

Судалгаанд хамрагдсан 114 улсаас 4 сая хүртэлх хүн амтай 44 улс буюу 38.5 хувьд нийт хүн амын тооноос куб язгуур авч парламентын гишүүдийн тоог тогтоох аргачлал тохирч байна. Харин 4 саяас дээш хүн амтай 70 улс буюу 61.5 хувьд одоо байгаа парламентын гишүүдийн тоо нь хүн амаас куб язгуур авч гаргасан гишүүдийн тоотой тохирохгүй байна. Тэгэхээр хүн амын тооноос куб язгуур авч парламентын гишүүдийн тоог гаргадаг тус аргачлал 4 саяас дээш хүн амтай улсуудын 61.5 хувьд нь огт таарахгүй буюу улс төрийн практикт туршигдаагүй байгаа нь их тооны хууль¹ талаасаа үнэний утгад ойртоогүй байна гэсэн үг. Түүнчлэн хүн амын тооноос куб язгуур авч парламентын гишүүдийн тогтоох Р.Таагеперагийн аргачлал нь онолын хувьд учир дутагдалтай талаар өмнө өгүүлсэн билээ.

Түүнчлэн эрх баригчдын хувьд Улсын Их хурлын гишүүдийн тоог анх 152 болгох тухай санал, санаачилгыг дэвшүүлсэн боловч нийгмийн дэмжлэгийг аваагүй учир 126 болгож бууруулсан. Гэтэл 152 гэдэг тоо нь нийт хүн амаасаа куб язгуур авах аргачлал дээр суурилсан байсан. Харин 126 гэх тоо нь сонгуулийн насны 2 сая гаруй иргэдээс куб язгуур авсан тоо юм. Эндээс харвал нийт хүн амаас куб язгуур авах, сонгуулийн насны хүн амаас куб язгуур авах хоёр нь эрс тэс ялгаатай. 152 гэдэг тоог нийгмийн дэмжлэгийг аваагүй

¹ Их тооны хуулийг анх Италийн математикч Жероламо Кардано (1501-1576, болон Швейцарын математикч Якоб Бернулли (1655-1705) нар нээжээ. Их тооны хууль нь адилхан туршилтыг маш олон удаа давтаж хийсний үр дүнг дүрсэлдэг теорем. Энэ хуулийн дагуу, олон туршилтаас гарсан үр дүнгийн дундаж нь математик дундажтай ойролцоо байх бөгөөд туршилтын тоо нэмэгдэх тусам статистик нарийвчлал улам сайжирдаг буюу үнэн утга уруу улам их ойртох хандлагатай байдаг.

учраас бууруулж 126 болгож байгаа нь эрх баригчид парламентын гишүүдийн тоог нэмэх талаарх шинжлэх ухааны тогтсон үзэл онол, зарчимгүй байсныг гэрчилнэ.

Цаашилбал 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр парламентын гишүүдийн тоог нэмэх бусад үндэслэлүүд болох (1) хүн амын тоо нэмэгдсэн учраас парламент дахь иргэдийн төлөөллийг нэмэгдүүлэх, (2) Хууль батлах үйл явц сайжрах, (3) Төр улсын бүрэн эрхт байдал баталгаажих, (4) Нэг гишүүний кнопны хүч буурах, (5) Эрх мэдлийн хуваарилалтын хяналт, тэнцлийг хангах, (6) мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт нэмэгдэх зэрэг нь өнгөцхөн бөгөөд манай орны өнөөгийн байдлаас ургуулсан, гагцхүү эрх баригчдын болон тэдэнд үйлчилдэг судлаачдын санаа бодлыг тусгасан мэт байдалтай. Тухайлбал 1992-2023 он хүртэлх хугацаанд Монгол Улсын нийт хүн амын тоо 2.1 саяас 3.4 сая болж 61%-аар өссөн байхад гишүүний тоо 76 хэвээр байгаа нь гишүүдийн иргэдийг төлөөлөх чадвар суларч, Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн заалт хэрэгжих нөхцөлийг бууруулж байна гэх үндэслэл нь агуулгын хувьд алдаатай үндэслэл. Учир нь парламентын гишүүдийн тоог нийт хүн амаас тооцдоггүй, харин сонгуулийн насны гучин мянган хүн тутмаас тооцдог дэлхийн жишиг байдаг.¹ Сонгуулийн насны гэдэг нь насанд хүрсэн, эрх үүрэг хүлээж, нийгмийн харилцаанд бие даан оролцох орох чадвар бүхий бие хүн буюу эрх зүйн чадамжтай субъект юм.

Хэрэв сонгуулийн насны иргэдээс биш нийт хүн амаас нэг төлөөлөгч гэж тооцвол дөнгөж төрсөн болон насанд хүрээгүй хүүхэд тэрчлэн эрх зүйн чадамжгүй хүмүүсээс хүртэл төлөөлөгч сонгогдох ёстой болдог тул сонгуулийн эрхийг ийнхүү насанд хүрсэн, эрх зүйн чадамжтай иргэнээр хязгаарладаг. Тэгэхээр гучин мянган сонгогчоос нэг гишүүн гэж тооцвол манай улс 2023 байдлаар хоёр сая нэг зуун мянган сонгогчтой тул парламентын гишүүдийн 70 болно.

Тэрчлэн Улсын Их Хурлын 76 гишүүнийг 126 болгож нэмсэнээр хууль батлах үйл явц гишүүдийн тоо нэмэгдсэнээр сайжрах, төр улсын бүрэн эрхт байдал баталгаажих, эрх мэдлийн хуваарилалтын хяналт, тэнцлийг хангах зэрэг нь үнэмшилгүй агаад харин парламентыг тэнцүү эрхтэй хоёр танхимд хувааснаар дээр дурдсан давуу талууд бий болно.

Цаашилбал мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт нэмэгдэх, нэг гишүүний кнопны хүч хүч буурах зэрэг үндэслэл нь бүр ч итгэл үнэмшилгүй. Жишээлбэл парламентад олонх болсон улс төрийн нам нь Засгийн газар болон хууль тогтоох эрх мэдлийг сүвлэн зангиддаг манай улсад мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт нь гишүүдийн тооноос бус харин эрх баригч намын хатуу чанд зохион байгуулалт, Засгийн газрын чадамжаас шууд шалтгаална.

Эцэст нь хэлэхэд 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгож нэмсэн явдал нь ирээдүйд дараах сөрөг нөхцлийг бий болгох талтай хэмээн таамаглаж байна. Үүнд:

1. Парламентын гишүүдийн тоо олон болох тусам шийдлийг баримтад тулгуурлах бус сэтгэлийн хөөрлөөр гаргах магадлал өндөр болдог.

2. Парламентын гишүүдийн тоо олон байх тусам тэдгээрийн дотор мэдлэг, мэдээлэл хомс хүмүүсийн эзлэх хувь мөн л их болж ирдэг.

3. Парламентын гишүүдийн тоо олон байхтай холбоотой яригддаг бас нэгэн асуудал нь олонхид суурилсан шийдвэр гаргалт юм. Олонхын саналаар шийдвэр гаргах нь тодорхой хэмжээний давуу талтай. Гэвч шийдвэр гаргагч нарын тоо хэт олон байвал эргээд шийдвэрийн хурд, үйл ажиллагааны үр дүнтэй байдалд сөргөөр нөлөөлдөг.

4. Эртний Грек, Ром зэрэг улсуудын түүхийг харвал цөөн тооны бусдыг ятгах чадвартай хүмүүс л олны гаргаж буй шийдвэрт нөлөөлөх боломжтой байдгийг харж болно. Үүнээс харвал парламентын гишүүдийн тоо олон байснаар шийдвэр зөв гардаг гэвэл худлаа юм. Үлгэрлэвэл парламентын гишүүдийн тоо олон байлаа ч шийдвэр гаргагч нарын тоо бага хэвээрээ байх юм. Тиймээс парламентын гишүүдийн тоог нэмэх гэж мунхагаар хандахын оронд гишүүдийнхээ ур чадвар, ухаан билигт ач холбогдол өгвөл зохилтой.

¹ Тухайлбал АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хоёрдугаар хэсэгт "...Гучин мянган сонгогчийг төлөөлөх төлөөлөгчийн тоо нэгээс хэтрэхгүй байна" хэмээн заажээ. *Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль* "Нэгдүгээр зүйл: Долоодугаар хэсэг. 21 дахь тал. УБ., 2000. Орч. Д. Цолмон, Ч. Лхагважав

5.Тэрчлэн 2008 оноос эхлэн Франц, Итали, Унгар, Япон, Мексик, Нидерланд, Португал, Румын, Их Британи зэрэг олон улсад парламентын гишүүдийн тоог цөөлөх санал санаачилга тасралтгүй яригдаж, олонхын дэмжлэг авч байна. Тухайлбал Италид Депутатуудын танхимын гишүүдийг 630-400 болгох, Сенатын гишүүдийг 315-200, бүр 150 болгох тухай санал санаачилга газар авч, “парламентын гишүүний тоог бууруулна” гэж амлаж буй нэр дэвшигчид сонгуульд ялалт байгуулах магадлал өндөрсөж байна. Хоёр алхаад хана мөргөх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бидэнд хэрэггүй. Таваас арван жилийн дараа парламентын гишүүдийн тоог бууруулж чадна гэж амласан нэр дэвшигчид сонгуульд ялалт байгуулж эхлэх вий.

Дүгнэлт

Парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох зарим аргачлалуудыг хөндөж бичсэн энэхүү өгүүлэгийн үр дүнг дараах байдлаар танилцуулья. Үүнд нэгдүгээрт, парламентын гишүүдийн тоог газар нутаг, хүн амын тооноос хамааруулж тогтоодог аргачлал өөрийн гэх уян хатан онцлогтой байна. Энэ нь хүн ам олонтой, газар нутгийн хэмжээ их улсуудын хувьд улс төрийн олон янзын хуваагдал, төөрөгдөл үүсгэхгүйн тулд парламент дахь төлөөллийн тоог тодорхой хэмжээгээр хязгаарлаж, эсрэгээрээ хүн ам цөөхөн, жижиг улс орнуудын хувьд парламентын гишүүдийн тоо хэт цөөн байгаа тохиолдолд тэдгээр цөөн хүний дарангуйлал үүсэж болзошгүй тул үүнийг хязгаарлахын тулд тодорхой хэмжээгээр парламентын гишүүдийн тоог нь их болгодог хандлагаар ажиглагдаж байна.

Хоёрдугаарт, 30 мянган сонгогч тутмаас нэг төлөөлөгч гэх Англи-Америкийн загварыг парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох нийтлэг бөгөөд сонгодог аргачлал гэж судлаачийн хувьд үзэж байна. Анх Англид үүсэж, АНУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан тус аргачлал дэлхийд ихэд тархсан хэлбэр байна. Тухайлбал гучин мянган сонгогчоос нэг гишүүн гэж тооцвол манай улс 2023 байдлаар хоёр сая нэг зуун мянган сонгогчтой тул парламентын гишүүдийн 70 болохоор байна.

Гуравдугаарт, парламентын хоёр танхимтай улсуудын хувьд дээд танхимын гишүүдийн тоо доод танхимын гишүүдээс ямагт бага байна. Энэ нь олон улсын жишиг төдийгүй хоёр танхимын бие биенээсээ ялгарах гол онцлог ажээ.

Дөрөвдүгээрт Эстонийн улс төр судлаач, физикч Р.Таагеперагийн боловсруулсан парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох куб язгуурын аргачлал нь зөвхөн 4 сая доторх хүн амтай улсуудад тохирч байна. Хэрэв хүн амын тоо 4 саяас дээш болбол тус аргачлал буруу тийшээ хазайна гэдэг нь математик судалгаагаар батлагдаж байна.

Тавдугаарт, Монгол Улсын хувьд 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгож нэмэхдээ Эстонийн судлаач Р.Таагеперагийн боловсруулсан парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох найман шалгуураас зөвхөн хүн амын тоо гэх ганцхан шалгуурыг Монгол Улсын парламентын гишүүдийн тоог нэмэх шинжлэх ухааны үндэслэл болгосон учир дутагдалтай байна.

Цаашид парламентын гишүүдийн тоог зохистой тогтоох тухай аргачлал, шинжлэх ухааны судалгааг өргөжүүлэх шаардлагатай. Учир нь Монгол Улсын хүн амын тоо 4 саяас дээш болж өсөх тохиолдолд парламентын гишүүдийн тоог нэмэх гол үндэслэл болсон куб язгуурын аргачлал алдаа заах эрсдэлтэй. Тухайлбал судалгаанд хамрагдсан 4 саяас дээш хүн амтай 70 улс буюу 61.5 хувьд одоо байгаа парламентын гишүүдийн тоо нь хүн амаас куб язгуур авч гаргасан гишүүдийн тоотой тохирохгүй байна.

Abstract:

This article describes some methods for determining the appropriate number of members of parliament that reflect the will of the majority of the people and is written with the aim of conducting a theoretical, methodological and mathematical analysis of the reasons for the increase

in the number of members of the State Great Hural to 126 as a result of an amendment to the Constitution of Mongolia in 2023.

In particular, this article can be innovative and significant because it studies the basics of the cube root method, which is the basis for increasing the number of deputies of the State Great Hural, compares its positive and negative aspects, and also makes theoretical-methodological and mathematical analyzes.

Key words: Constitution, parliament, member of parliament, population, number of members, cube root

Ашигласан ном, материал

I.Монгол эх сурвалж

“Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль” Нэгдүгээр зүйл: Хоёрдугаар хэсэг. 21 дахь тал. УБ.,2000. Орч.Д.Цолмон, Ч.Лхагважав.

Д.Сүхболд, Р.Ууганбаатар, Д.Лхагвасүрэн, М.Сайнбаяр, Д.Зоригтбаатар “БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи УБ.,2020

Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” УБ.,2010

II.Гадаад эх сурвалж

Alexander Hamilton, James Madison, and John Jay. “The Federalist papers” Introduction and Notes by Charles R.Kesler. Copyright (1961)

Social science research 1, 385-401 (1972) “The Size of National Assemblies” Rein Taagepera

Math Could Help Set Right the Sizes of National Legislatures.
<https://www.insidescience.org/news/math-could-help-set-right-sizes-national-legislatures>

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 33-41 дэх тал

**ПАРЛАМЕНТЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ
(УИХ-ЫН НЭЭЛТТЭЙ СОНСГОЛЫН АСУУДАЛД)**

Ж.Төртогтох

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор

Ардчилал судлалын төвийн захирал

Б.Уянга

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Нээлттэй сонсголыг дэлхийн улсуудад иргэдийн мэдэх эрхийг хангах, шийдвэр гаргахдаа олон нийтийг оролцуулах, парламентын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх болон орон нутаг, нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд янз бүрийн хэлбэрээр зохион байгуулдаг. Манай улсад УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос анх удаа “7 сарын 1”-ний асуудлаар нээлттэй сонсголыг 2009 оны арванхоёрдугаар сарын 3-нд зохион байгуулж байжээ. Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд парламентын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой өөрчлөлт оруулж, УИХ-ын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг 2021 онд баталсан. Үүний дагуу УИХ-аас хууль, тогтоолын биелэлттэй холбоотой болон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар иргэдийн мэдэх эрх, түүнчлэн томилгоонд олон нийтийн оролцоог хангах, нэр дэвшигчдийг нийтэд танилцуулах зорилгоор нээлттэй сонсголуудыг олноор зохион байгуулж байна. Иймд парламентын нээлттэй сонсголын чиглэлээр судлах, ажиглалт, дүн шинжилгээ хийж, ололт болон дутагдалтай талуудыг танилцуулах, сайжруулах арга замыг тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсэж буй тул энэ чиглэлээр судалсан болно.

Түлхүүр үгс: Нээлттэй сонсгол, парламентын хяналт, иргэдийн оролцоо, мэдэх эрх

Удиртгал:

Францын гүн ухаантан Ш.Л.Монтескьюгийн Эрх мэдэл хуваарилах замаар төрийн дур зоргыг хязгаарлаж болох тухай онолын¹ үүднээс авч үзвэл хууль тогтоох эрх мэдэл бүхий парламент нь гүйцэтгэх засаглалдаа хяналт тавих ёстой. Энэ нь парламентын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх үндсэн зорилгыг нөхцөлдүүлж байгаа бөгөөд хянан шалгах арга хэлбэрийн нэг нь нээлттэй сонсгол юм. Нөгөө талаас төр, засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна, иргэд сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах үйл хэрэгт оролцоно гэсэн ардчиллын үндсэн үзэл санааны үүднээс авч үзвэл хууль тогтоох байгууллага аливаа үйл ажиллагаа, шийдвэрт гаргалтад иргэдийн оролцоо, мэдэх эрхийг хангах зорилгоор нээлттэй сонсгол хийж буй юм.

Гавьяат хуульч Б.Чимид “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх зарим асуудал” сэдэвт илтгэлдээ² парламентын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх тухай саналыг 2010 онд дэвшүүлжээ. Тэрбээр дэлхийн томоохон орнуудын судлаачдын түүвэрлэн гаргаснаар парламентын хяналт шалгалтын 12 хэлбэр байгааг тоочин дурдсаны дотор парламентын ажил хэргийн сонсгол явуулах хэлбэр багтсан бөгөөд эдгээр хэлбэрүүдийг зөв

¹ Барон де Монтескью. (орч. Төмөрхүлэг Т.) Хуулийн амин сүнс. Улаанбаатар. Монсудар. 2009.

² УИХ-ын Тамгын газар. Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил (онол практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл). Улаанбаатар, УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех. 2010. ху 54.

тусган хэрэглэхэд парламентын хяналт шалгалт хүчтэй нөлөөтэй болно гэж үзсэн. МУИС-ийн профессор С.Базарпүрэв, докторант Х.Батхүү нар парламентын хяналтыг сайжруулах арга замууд дэвшүүлсний дотор парламентын хяналтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах тухай санал³ гаргасан байдаг. Судлаачдын дэвшүүлсэн эдгээр санал өдгөө парламентын хяналтын хэрэгжилтэд бодит биеллээ олж эхэлж буй бөгөөд УИХ-аас хяналтын сонсголууд олноор зохион байгуулж байгаа нь ололттой тал юм.

Нийтийн сонсголын онцлог шинж нь шийдвэр гаргадаггүй, аль болох олон хүний, олон талын санал, байр суурийг сонсох зорилготой, гэрч, шинжээч, ажиглагч, оролцогчдод үнэнийг мэдүүлэх үүрэг хүлээлгэдэг, урьдчилан тов тогтоож, иргэдийг бүртгэдэг, тухайн асуудлаар мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулдаг онцлогтой.

Нээлттэй сонсголын талаарх Үндсэн хууль, эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар УИХ-ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал УИХ цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна” хэмээн зохицуулсан бөгөөд үүний дагуу УИХ-ын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг баталсан. Нийтийн сонсголын тухай хуульд⁴ нээлттэй сонсголын есөн төрлийг хуульчилсан байна. Эдгээр хууль, эрх зүйн зохицуулалтаас үзвэл УИХ-аас дараах төрлийн нээлттэй сонсголыг зохион байгуулах боломжтой. Үүнд

- Хууль тогтоомжийн сонсгол
- Ерөнхий хяналтын сонсгол
- Төсвийн хяналтын сонсгол
- Нэр дэвшигчийн сонсгол (нэр дэвшигчийн танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол)
- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол
- Хянан шалгах түр хорооны нотлох баримтын сонсгол

Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, шинжээч, ажиглагчийг сонсголд оролцогч гэж үзнэ. Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа, эсэхэд хяналт тавих талаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагч гэнэ. УИХ-ын холбогдох байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгоно. Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч сонсголд оролцох, тайлбар өгөх үүрэгтэй.

Нийтийн сонсголын тухай хуулийн 15.1.1-д зааснаар сонсголд оролцогч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх эрхтэй бол ажиглагч нь сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа, эсэхэд хяналт тавих бөгөөд сонсголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй. Сонсголд тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг заавал оролцуулахаар хуульчилсан байдаг.

Сонсголд оролцогч хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэхээс гадна сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах, сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах эрхтэй.

Нээлттэй сонсголыг санаачлах

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн байнгын хороо хэлэлцэн хүлээн авсан,

³ Базарпүрэв, С., Батхүү Х. Монгол дахь парламентын хяналтын асуудал. Политологи сэтгүүл, XXI. 2019. ху 160

⁴ Нийтийн сонсголын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11225>

цөөнхийн бүлэг хүсэлт гаргасан, эсхүл УИХ-ын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонголыг зохион байгуулах боломжтой. Харин төсвийн хяналтын сонголыг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо санаачлах бөгөөд хэрэв УИХ-ын есөөс доошгүй гишүүн төсвийн хяналтын сонгол явуулах хүсэлт гаргасан бол зохион байгуулна. Ерөнхий хяналтын сонголын хувьд Ерөнхийлөгч, УИХ-ын есөөс доошгүй гишүүн, түүнчлэн байнгын, дэд хорооны нийт гишүүний олонх, эсхүл цөөнхийн бүлэг хүсэлт гаргасан, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн байнгын, дэд хороо хэлэлцэн хүлээн авсан бол зохион байгуулах боломжтой.

Нэр дэвшигчийн сонголын хувьд УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан УИХ-аас 10 гаруй байгууллагын зохих албан тушаалд нэр дэвшигчтэй нээлттэй сонгол хийхээр хуульчилсан. Мөн УИХ-аас нэр дэвшигчийн сонгол явуулахаар хуульд тусгайлан заасан, эсвэл УИХ танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонгол явуулахаар УИХ-ын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол нэр дэвшигчийн сонгол зохион байгуулахаар заасан юм. Гэвч хуулийн эл зохицуулалтын зарим хэсгийг буюу Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурорын албан тушаалд нэр дэвшигчтэй холбогдуулан УИХ-аас нэр дэвшигчийн сонгол хийх зохицуулалтыг Цэцийн шийдвэрээр⁵ түдгэлзүүлсэн бөгөөд УИХ цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй⁶ гэж үзээд байна.

Нийтийн эрх ашгийг хөндсөн асуудал болох Боловсролын зээлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, Коронавирусийн халдварын эсрэг арга хэмжээнд зарцуулсан төсвийн талаар нээлттэй сонгол хийхийг⁷ иргэд, иргэний нийгмийн байгууллагынхан шаардсан боловч одоогоор хийгээгүй байна. Нийтийн сонголууд зохион байгуулахад оролцогчдын цай, кофены зардлаас гадна шинжээчдийн цалин хөлс багтдаг бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлдэг.

Нээлттэй сонголуудад хийсэн дүн шинжилгээ

УИХ-аас 2020-2023 онд дараах 23 нээлттэй сонголыг зохион байгуулсан байна. Бүх сонголын тов, зарлалыг урьдчилан олон нийтэд нээлттэй зарласан бөгөөд нотлох баримтыг шинжлэн судлах сонсголоос бусад тохиолдолд оролцогчид, ажиглагчдыг нээлттэй бүртгэж авсан. Түүнчлэн нээлттэй сонголуудыг УИХ-ын фэйсбүүк дэх албан ёсны цахим хуудас, МҮОНТ болон бусад мэдээ мэдээллийн сайтууд, телевизийн сувгуудаар дамжуулжээ. Сонголын тов, төрөл, оролцогчдын тоог доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Сонголын сэдэв, тов, төрөл, оролцогчдын тоо

	Сонголын сэдэв	Болсон хугацаа	Сонголын төрөл	Оролцогчдын тоо
1	ХЭҮК-ын гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдын нээлттэй сонгол	2020.06.10, 11	томилгооны	55 оролцогч 31 ажиглагч
2	ХЭҮК-ын дэргэдэх эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний сонгон шалгаруулалтад	2020.06.11	томилгооны	80 оролцогч

⁵ Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 9 сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоол

⁶ Улсын Их Хурлын 2023 оны 10 сарын 5-ны өдрийн 78 дугаар тогтоол

⁷ <https://www.uuh.mn/petition/view/94>

	оролцогчдын нээлттэй сонсгол			
3	Авлигатай тэмцэх газрын дэд даргын томилгооны сонсгол	2021.07.06	томилгооны	1 ажиглагч 5 оролцогч
4	Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах сонсгол	2021.11.15	томилгооны	6 оролцогч, ажиглагч
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах сонсгол	2021.11.16	томилгооны	21 оролцогч, ажиглагч
6	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаарх нийтийн сонсгол	2021.12.30	ерөнхий хяналтын	10 оролцогч 3 ажиглагч
7	ХЭҮК-ын дэргэдэх эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдын нээлттэй сонсгол (Я.Цэлмэн, Б.Өнөрмаа, Ч.Отгончулуун, ажлын хэсгийн сонсгол)	2022.02.17	томилгооны	2 ажиглагч Оролцогчийн тоо тодорхойгүй
8	ХЭҮК-ын хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдын нээлттэй сонсгол (Т.Саруул, С.Дондов, ажлын хэсгийн сонсгол)	2022.02.17	томилгооны	2 ажиглагч Оролцогчийн тоо тодорхойгүй
9	Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих сонсгол	2022.03.29	ерөнхий хяналтын	4 ажиглагч 170 гаруй оролцогч
10	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч болон даатгуулагчийг төлөөлсөн	2022.04.18	томилгооны	3 оролцогч

	гишүүнд нэр дэвшигчийн сонсгол			
11	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүний нэр дэвшигчийн сонсгол	2022.04.18	томилгооны	10 гаруй оролцогч
12	ХЭҮК-ын дэргэдэх эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсгол	2022.05.03	томилгооны	3 оролцогч
13	ХЭҮК-ын хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсгол	2022.05.03	томилгооны	3 оролцогч
14	Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол (Чанарын шаардлага хангадаггүй барилгын материалын асуудлаар)	2022.06.27	хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын	50 гаруй оролцогч
15	Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах сонсгол (ШЕЗ-өөс санал болгосон Д.Батбаатар, Н.Баярмаа нар)	2022.07.04	танилцах	3 оролцогч
16	Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн нээлттэй сонсгол (ШЕЗ-өөс нэр дэвшүүлсэн Н.Батчимэг, Б.Ганболд, М.Пүрэвсүрэн)	2022.11.28	танилцах	6 оролцогч 3 ажиглагч
17	“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах” сонсгол	2022.12.21	ерөнхий хяналтын	108 оролцогч
18	Хөгжлийн банкны асуудлаарх нотлох баримтын сонсгол	2023.01.16-20, 02.13-17 03.13-17	нотлох баримтыг шинжлэн судлах	356 хүн гэрчээр оролцсон. 4 ТББ-ын төлөөлөл, мөн хууль, хяналтын байгууллагын албан тушаалтнууд ажиглагчаар оролцсон.

				Нээлттэй бүртгэл явуулаагүй.
19	ЭМДҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол	2023.04.10	томилгооны	9 оролцогч
20	Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсгол (Н.Монсор, Ж.Золзаяа)	2023.04.24	томилгооны	1 ажиглагч бүртгүүлсэн
21	Хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн асуудлаарх сонсгол	2023.07.05	хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын	50 орчим оролцогч, ажиглагч
22	Хүүхдийн эрхийг хамгаалах, хангах асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол	2023.10.25	хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын	85 оролцогч
23	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг УИХ-д танилцуулах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол	2023.12.04-07 (эхний үе шат) 2023.12.18-22 (хоёр дахь шат)	нотлох баримтыг шинжлэн судлах	Давхардсан тоогоор нийт 419 хүн гэрчээр оролцсон. ТББ-ын 2 төлөөлөл хөндлөнгийн ажиглагчаар оролцсон, Мөн хууль, хяналтын байгууллагын албан тушаалтнууд урилгаар оролцсон. Нээлттэй бүртгэл явуулаагүй.

Жич. Эрхэлсэн ажил, чиг үүрэгтэй холбоотойгоор сонсголд оролцсон төрийн байгууллагын албан тушаалтнуудын тоог сонсголд оролцогчийн тоонд хамруулаагүй болно.

Олон нийтийн анхаарлыг татсан асуудлын нэг болох “Нүүрсний хулгай”, “Хөгжлийн банкны чанаргүй зээлийн асуудал”, “Хүүхдийн эрхийг ноцтойгоор зөрчсөн тохиолдлууд”-ын мөрөөр буюу дараа нь зохион байгуулсан нээлттэй сонсголд иргэд олноор бүртгүүлэн оролцсон бол бусад асуудлаар зохион байгуулсан сонсголд дунджаар 3-10 хүн бүртгүүлэн оролцсон гэж үзэхээр байна. 2020 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд УИХ-аас зохион байгуулсан сонсголуудыг төрөл болон зохион байгуулсан тоогоор доорх хүснэгтэд харууллаа. Нэр дэвшигчийн сонсголыг хамгийн олон буюу 15 удаа зохион байгуулсан байна.

Хүснэгт 2. Сонсголын төрөл, зохион байгуулсан тоо

Сонсголын төрөл	Зохион байгуулсан тоо
Нэр дэвшигчийн сонсгол (томилгооны, танилцах)	15
Ерөнхий хяналтын сонсгол	3
Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол	3
Нотлох баримтын сонсгол	2

Сонсголоор хэлэлцэх асуудал, холбогдох албан тушаалтны хийх мэдээлэл, тайлан, баримтуудыг олон нийтэд урьдчилан танилцуулах шаардлагатай гэж үзэхээр байна. Сонсголын үеэр тайлан, илтгэл танилцуулж, УИХ-ын гишүүд түүнтэй холбоотой асуулт асуухад ихээхэн цаг зарцуулж, иргэд, оролцогчдыг залхаах байдал ажиглагдсан. Тиймээс танилцуулах мэдээллийг олон нийтэд өмнө нь танилцуулчихвал сонсголын үеэр товч танилцуулга хийж, шууд асуулт, хариултад шилжих, гарц, шийдэл түлхүү ярих боломжтой. Нэр дэвшигчийн сонсголын тухайд нэр дэвшигчдийн намтрыг постер болон бусад хэлбэрээр бэлтгэж, иргэдэд танилцуулбал илүү үр дүнтэй. Өнгөрсөн хугацаанд болсон сонсголуудын үеэр нэр дэвшигчдийн танилцуулгыг parliament.mn хуудсанд файл хэлбэрээр байршуулсан.

Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулдаг болсноор тухайн албан тушаалд тавигдах шалгуурыг хангасан хүн томилогдох, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх, асуулт тавих боломж бүрдсэн⁸. Харин ерөнхий хяналтын сонсголын тухайд дэг, зохион байгуулалт, үр дүнгийн хувьд зарим талаар учир дутагдалтай байна. Тухайлбал, сонсголын үеэр УИХ-ын гишүүдээс гадна оролцогчид асуулт асуух эрхтэй, эсэх нь эргэлзээтэй. Зарим сонсголын үеэр зөвхөн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөлд асуулт асуух боломж олгосон зэргээр өөр өөр хэлбэрээр хийсэн байна.

Ерөнхий хяналтын сонсгол нь парламентын хянан шалгах бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа атал шинжээч томилж ажиллуулах, дүгнэлт сонсох, баримт дэлгэж тавих тал дутагдаж байна. Тодруулбал, ерөнхий хяналтын сонсголын үеэр парламентын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг аудитын, хүний эрхийн, мэргэжлийн хяналтын, хууль, хяналтын байгууллагын хараат бус, хөндлөнгийн санал, дүгнэлт дутагдаж байна. Сонсголын дэг, журмыг нарийвчлан тодорхойлох, сонсголын үеэр худал мэдээлэл түгээх, бусдыг гүтгэх, доромжлох асуудал гаргахгүй байхад анхаарах нь сонсголыг үр дүнтэй болгох, иргэдийн итгэлийг дээшлүүлж, цаашид оролцоог нь сайтар хангахад чухал нөлөөтэй.

УИХ-ын гишүүдийн ирц бүрдээгүйгээс сонсголын эхлэх хугацаа хойшлох тохиолдол цөөнгүй байна. Мөн хоёр удаад ирц бүрдээгүйгээс тодорхойгүй хугацаагаар цуцлагдсан тохиолдол гарчээ. Тухайлбал, чанарын шаардлага хангадаггүй барилгын материалын асуудлаарх хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол байнгын хорооны гишүүдийн ирц бүрдээгүй, хуралдаан давхацсан тул хойшилсон. Мөн ХЭҮК-ын эрүү шүүлтийн асуудал хариуцсан болон хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүний нэр дэвшигчийн сонсгол байнгын хорооны гишүүдийн ирц бүрдээгүйгээс маргааш нь зохион байгуулагдсан байна.

УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийн хүрээнд хамаарах сонсголуудаас төсвийн хяналтын сонсголыг одоогоор хийгээгүй байна. Монгол Улсын парламент нээлттэй, ил тод байдлыг хангах, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор нээлттэй сонсголыг олноор зохион байгуулж байгаа нь сайн жишиг юм.

⁸ <https://legaldata.mn/news/181>

Дүгнэлт

Нотлох баримтын сонсголоос бусад сонсголуудын зар, бүртгэлийн хуудсыг урьдчилан нийтэд түгээж, иргэдийг бүртгэсэн. Гэвч нийтэд шуугиан тарьсан асуудлаас бусад тохиолдолд иргэд олноор бүртгүүлж оролцох нь ховор байна. Сонсголд иргэдийн оролцоо хэр байна вэ гэдэг нь маш чухал. Нүүрсний асуудал, Хөгжлийн банкны асуудал, хүүхдийн эрхийн ноцтой зөрчлийн дараа болсон сонсголуудад иргэд олноор бүртгүүлж, оролцжээ.

Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулдаг болсноор тухайн албан тушаалд тавигдах шалгуурыг хангасан хүн томилогдох, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх, асуулт тавих боломж бүрдүүлсэн. Гэвч Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурорыг томилохын өмнө нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах хуулийн зохицуулалтыг Цэцийн дүгнэлтээр түдгэлзүүлээд байна. Уг нь нэр дэвшигчийн сонсгол нээлттэй, ил тод байдал, Үндсэн хуулиар олгосон, иргэдийн оролцоо, мэдэх эрхийг хангахад чухал нөлөөтэй.

УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийн хүрээнд хамаарах сонсголуудаас төсвийн хяналтын сонсголыг одоогоор хийгээгүй байгаа тул цаашид ийм төрлийн сонсголыг хийх, төсөвт тавих хяналтыг сайжруулах чухал ач холбогдолтой.

Нийтийн эрх ашгийг хөндсөн асуудал болох Боловсролын зээлийн сангийн зарцуулалт, Коронавирусийн халдварын эсрэг арга хэмжээнд зарцуулсан төсвийн талаар нээлттэй сонсгол хийхийг иргэд, иргэний нийгмийн байгууллагынхан шаардсан боловч одоогоор хийгээгүй байна. Цаашид ийм төрлийн асуудал, сэдвээр нээлттэй сонсгол хийж, парламентын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх, иргэдийн мэдэх эрхийг хангах нь чухал юм.

Ерөнхий хяналтын сонсголын үеэр парламентын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг аудитын, хүний эрхийн, мэргэжлийн хяналтын, хууль, хяналтын байгууллагын хараат бус, хөндлөнгийн санал, дүгнэлт дутагдаж байна.

Монгол Улсын парламент нээлттэй, ил тод байдлыг хангах, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор нээлттэй сонсголыг олноор зохион байгуулж байгаа нь сайн жишиг бөгөөд цаашид зохион байгуулалтыг нь сайжруулахад анхаарах нь зүйтэй.

Abstract:

Public open hearings are organized in various ways in countries around the world to ensure citizens' right to know, to involve the public in decision-making, to implement parliamentary oversight, and at the level of local government organizations. In our country, the Human Rights Subcommittee of the State Great Khural organized the first public hearings on the issue of "July 1" on December 3, 2009. As part of the amendments to the Constitution in 2019, a specific provision which ensures the implementation of the oversight powers of the State Great Khural, was included in the Constitution, and then the parliamentary oversight law (On monitoring and inspection of the State Great Khural of Mongolia) was enacted in 2021. Accordingly, the Parliament is organizing public hearings in order to ensure the public's right to know about issues related to the implementation of laws and resolutions, as well as to ensure public participation in appointments and to introduce candidates to the public. Therefore, there is a need to study, observe, and analyze the public hearings of the parliament, to present the achievements and shortcomings, and to identify ways to improve them, so we have studied in this area.

Key words: Public hearings, parliament oversight, civic participation, right to know.

Ашигласан ном, материал

1. Амаржаргал, П. (2016). Парламентын бүрэн эрх: Төлөвшил, хөгжлийн чиг хандлага Үндсэн хуулийн эрх зүй, Парламентын эрх зүй: Хууль зүйн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон диссертац.
2. Базарпүрэв, С., Батхүү Х. (2019). Монгол дахь парламентын хяналтын асуудал. Политологи сэтгүүл, XXI
3. Барон де Монтескью. (орч. Төмөрхүлэг Т.) (2019). Хуулийн амин сүнс
4. Норовдондог, Ц нар. (2021). Парламентын хяналт шалгалтын тогтолцоо ба эрх зүйн зохицуулалт: бусад орнуудын туршлага. Парламент боть, 32
5. Мөнхбат, У. нар. (2010). Дэлхийн улс орнуудын парламент: хураангуй лавлах Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан лавлах.
6. Мөнхсайхан, О. (2015). Цэцийн гишүүн, Дээд шүүхийн шүүгч, Ерөнхий прокурорыг нийтийн сонсголоор томилох нь. Шүүх эрх мэдэл боть, II.
7. УИХ-ын Тамгын газар. Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын төлөвшил, хөгжил (онол практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл). Улаанбаатар, УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех. 2010.
8. Hironori Yamamoto. (2007). Tools for parliamentary oversight.
9. UCL The Constitution unit (2010). An Evaluation of Pre-Appointment Scrutiny Hearings.
10. Robert J D Hazell. (2019). Improving parliamentary scrutiny of public appointments.

Хууль, эрх зүйн баримт бичиг, гарын авлага

11. Монгол Улсын Үндсэн хууль
12. УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль
13. Нийтийн сонсголын тухай хууль
14. Нийтийн сонсгол зохион байгуулах журам
15. Монгол улсын их хурлаас албан тушаалтныг томилохтой холбогдуулан томилгооны сонсгол зохион байгуулах журам
16. Нээлттэй сонсгол: Бодлого боловсруулах үйл явцад оролцох иргэдийн гарын авлага, Нээлттэй нийгэм форум (2009)

Нээлттэй сонсголын тайлан, тэмдэглэл

17. ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшигч болон Эрүү шүүлтийн асуудал хариуцсан гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан <https://www.parliament.mn/nn/18161>
18. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой (хүүхдийн эрхийн асуудлаарх) сонсголын тэмдэглэл <https://www.uih.mn/ns/view/101>
19. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахтай холбоотой ерөнхий хяналтын сонсголын тэмдэглэл <https://www.parliament.mn/nn/41255/>
20. Нүүрсний асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тэмдэглэл <https://www.parliament.mn/nn/19271>
21. МҮОНРТ-ийн ҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тэмдэглэл <https://www.parliament.mn/nn/30015>
22. ЭМДҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан <https://www.parliament.mn/nn/29961>
23. Чанарын шаардлага хангадаггүй барилгын материалын асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлан <https://www.parliament.mn/nn/18236>
24. Нийтийн сонсголын сан. <https://www.uih.mn/ns>
25. Хүний эрхийн Үндэсний Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн талаарх томилгооны сонсголын дэг <https://www.uih.mn/sudalga/s/72>
26. Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах үүрэг бүхий хянан шалгах Түр хорооны тайлан <https://www.parliament.mn/nn/29940/>

ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦААНЫ АСУУДАЛД

Г.Золзаяа

Отгонтэнгэр Их Сургууль,
Сэтгүүл зүй, Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч

Хураангуй:

Сонгуулийн сурталчилгааны хугацааны талаар судлаачид өөр өөр байр суурьтай байна. Сонгогчдын мэдэх эрх, сонголтоо хийх, нэр дэвшигчид өөрийгөө сонгогчдод таниулах гэх мэт олон ач холбогдолтой тул сурталчилгааны хугацаа хангалттай урт байх нь зүйтэй гэж барууны эрдэмтэд үздэг. Харин зарим судлаачид хэт урт сурталчилгааны хугацаа нь сонгогчдыг залхаах, нэр дэвшигчдээс илүү санхүүгийн зардал шаардах, төрийн үйл ажиллагаа алдагдах зэрэг сөрөг талтай гэж үздэг байна. Баримт бичгийн судалгаанаас авч үзвэл дэлхийн улс орнууд 20-р зуунд сонгуулийн сурталчилгааны хугацааг янз бүрээр туршиж, хэрэгжүүлж ирсэн бөгөөд харилцан адилгүй хугацаатай байна. Гэсэн ч дийлэнх улс орнуудын сурталчилгааны хугацаа 30-50 хоногийн хооронд байдаг бөгөөд сонгуулийн өдрөөс 24-48 цагийн өмнөөс санал өгөх өдөр хүртэл аливаа сурталчилгааг хуулиар хориглох нь түгээмэл байна.

Түлхүүр үгс: УИХ, сонгуулийн кампанит ажил, нэр дэвшигчид

Оршил хэсэг:

Монгол Улс 1992 оноос хойш УИХ-ын сонгуулийг найман удаа зохион байгуулжээ. Энэ хугацаанд сонгуулийн сурталчилгааны хэв маяг, зохион байгуулалт, хугацаа зэрэгт өөрчлөлт орсоор өнөөг хүрлээ.

Сонгуулийн сурталчилгааны талаар судлаачид өөр өөрсдийн тодорхойлолтыг өгдөг. Сонгуулийг албан ёсоор зарлаж, улс төрийн намууд сонгуульд өрсөлдөхөөр нэр дэвшигчдээ бүртгүүлж, сонгуулийн кампанит ажлын штабаа байгуулж, төсөл, календарчилсан төлөвлөгөө боловсруулж, сурталчилгааны арга хэлбэрээ сонгон хэрэгжүүлэх тодорхой хугацааны үйл явцыг хамааруулж сонгуулийн сурталчилгаа хэмээн нэрлэж байна. Харин сонгогчийг ухуулах ухуулга сурталчилгаа үндсэндээ сонгуулийн өмнөх кампанит ажлуудын үед хийгдэж байдаг бөгөөд сонгуулийн кампанит ажлын үе бол тэр бүхнийг гагцхүү “хайрцаглаж” өгөх л үе юм. Иймээс сонгуулийн кампанит ажил, сонгуулийн өмнөх кампанит ажил нь арга, хэлбэр, агуулгын хувьд эрс ялгаатай төдийгүй түүнийг хүлээн авч буй сонгогчдын сэтгэл зүй ч ихээхэн ялгаатай, улмаар үр нөлөө нь ч өөр өөр байдгийг манай зарим улс төрийн намууд бүрэн тооцож чаддаггүй.¹

Европын холбооны Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан судалгаа болон судлаачид өөрсдийн орны сонгуулийн сурталчилгааны хугацааны талаар хийсэн харьцуулсан судалгаанууд хийгджээ. Манай улсын хувьд 1992 оноос эхлэн УИХ-ын сонгуулийн сурталчилгааны хугацаа буурсаар байна. Энэ талаар судлаачид харилцан адилгүй байр суурь илэрхийлдэг.

Судалгааны зорилго: Парламентын сонгуулийн сурталчилгааны хугацааны чиг хандлагыг судалж, манай улсын парламентын сонгуулийн сурталчилгааны оновчтой хугацааг тодорхойлох нь энэхүү судалгааны зорилго юм.

Судалгааны арга: Тус судалгаанд чанарын судалгааг голчлон ашиглав. Улс төр судлалын эрдэмтэн, судлаачид, нэр дэвшигчид, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэн

¹ Д.Оюунчимэг, (2015) “Сонгуулийн сурталчилгааны арга зүй”, Политологи сэтгүүл №13 (442), х-124.

зэрэг 6 оролцогчоос ганцаарчилсан ярилцлага авсан. Мөн түүнчлэн ардчилсан улс орнуудын сонгуулийн сурталчилгааны хугацааны талаарх судалгааны ажил, хууль, эрх зүйн баримт бичгийн судалгаа хийсэн. Ингэхдээ харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашигласан болно.

Үр дүн: Сонгуулийн сурталчилгаа нь нэр дэвшигчдийн байр суурь, бодит нөхцөл байдлын талаар сонгогчдод хүртээмжтэй мэдээлэл хүргэхэд чиглэдэг.² Сонгуулийн сурталчилгааны хугацаа бага байснаар сонгогчид цөөн тооны, хязгаарлагдмал мэдээлэл дээр үндэслэн сонголт хийхэд нөлөөлдөг гэж судлаачид үздэг. Тухайлбал АНУ-ын эрдэмтэн Стивенсон, Ваврек нар ардчилсан 13 орны 113 сонгуулийн мэдээллийг ашиглан сонгогчид доод тал нь 6 долоо хоног үргэлжилсэн харьцангуй урт кампанит ажилд өөрсдийн дүгнэлтийг хийх боломжтой ба хэт богино сонгуулийн сурталчилгааны үед сонгогчид хангалттай мэдээлэл авч, нухацтай сонголт хийх боломжгүй гэж дүгнэсэн.³

Гэвч хэт урт хугацааны сонгуулийн сурталчилгаа нь их хэмжээний зардал гаргах сул талтай байна.⁴ Энэ талаар ганцаарчилсан ярилцлагын судлаачид “Сүүлийн үед цахим техник, технологи хөгжиж байгаатай холбогдуулан УИХ-ын сонгуулийн хугацааг 2 долоо хоног болгоход асуудалгүй. Хуучин цагт бараг хоёр сар байсан. Тухайн үед цахим орчин одоогийнх шиг хөгжөөгүй, унаа техникийн хувьд ч хүндрэлтэй байсан учраас урт хугацаатай байхад асуудалгүй байсан. Хоёрдугаарт сонгуулийн үед төрийн ажил цалгардах тал байдаг. Ингээд бүх ажил алдагдах мөн урт хугацаанд нэр дэвшигчээс гарах зардал өндөр байдаг” хэмээн тодотгож байсан юм.

Хүснэгт 1. УИХ-ын сонгуулийн сурталчилгааны хугацаа, сонгуулийн систем, саналын тоо

Он	Хуулиар тогтоосон сурталчилгааны хугацаа	Сонгуулийн систем	Нэрсийн жагаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн тоо, (хувь)
1992 он	45 хоног ⁵	Томсгосон мажоритар буюу 1 тойрогт олон мандат	1,085,129	1,037,392 (95.6%)
1996 он	45 хоног	Жижигсгэсэн мажоритар буюу 1 тойрогт нэг мандат	1,147,260	1,057,182 (92.1%)
2000 он	45 хоног	Жижигсгэсэн мажоритар буюу 1 тойрогт нэг мандат	1,247,033	1,027,985 (82.4%)
2004 он	45 хоног	Жижигсгэсэн мажоритар буюу 1 тойрогт нэг мандат	1,279,516	1,051,812 (82.2%)
2008 он	30 хоног	Томсгосон мажоритар буюу 1 тойрогт олон мандат	1,542,617	1,179,448 (76.5%)
2012 он	22 хоног	Холимог тогтолцоо (70:30)	1,840,824	1,238,537 (67.3%)
2016 он	18 хоног	Томсгосон мажоритар буюу 1 тойрогт олон мандат	1,911,047	1,406,123 (73.6%)
2020 он	22 хоног	Томсгосон мажоритар буюу 1 тойрогт олон мандат	2,003,969	1,475,895 (73.6%)

Монгол Улс 1992 онд УИХ-ын сонгуулийн сурталчилгааны хугацаа 45 хоног байсан бөгөөд 2008 оноос 30 хоног, 2012 онд 22 хоног болгон өөрчилж байжээ. Харин 2016 онд

² Gelman A & King G. (1993) Why American Presidential Election Polls So Variable When Votes are So Predictable? British Journal of Political Science 23 (3): 409

³ Stevenson R. & Vavreck L. (2000) Does Campaign Length Matter? Testing for Cross-National Effects. British Journal of Political Science. 30 (2): 217-235

⁴ Costas Panagopoulos (2013), Campaign Duration and Election Outcomes, Politics and Governance, 1(1), p-66-73

⁵ Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, 1992 он, 26-р зүйлийн 1-р заалт

бүх шатны сонгуулийн 18 хоног байхаар хуульд өөрчлөлт оруулсан. “2019 онд баталсан сонгуулийн тухай хуулиар сурталчилгааны хугацаа 18 хоног байсныг 22 хоног болгон өөрчилсөн.”⁶ “Сурталчилгааны хугацааг 30 хоног болгосноор зардал багасна гэж тооцоолсон боловч нэгжийн өртөг нь улам өссөн дүн гарчээ. Харин сурталчилгааны хугацаа богиносон нь сонгогчдыг залхаахгүй байх давуу талтай.”⁷

Ихэнх улс оронд сонгуулийн кампанит ажлын хугацааг тодорхой заасан байдаг бол зарим улс оронд сонгууль товлох, парламент тарах болон бусад хүчин зүйлээс хамаарч хугацааг хуулиар тогтоогоогүй байх нь бий. Жишээ нь АНУ-д сонгуулийн сурталчилгааны тогтсон нэг хугацаа байдаггүй.

Хүснэгт 2. Улс орнуудын сонгуулийн сурталчилгааны хугацаа, парламентын доод танхим эсвэл нэг танхимын сонгуулийн тогтолцоо /2023 оны байдлаар/

УЛС ОРОН	СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦАА	СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО
Бельги	4 сар	Пропорциональ тогтолцоо
Болгар	30 хоног	Пропорциональ тогтолцоо
Хорват	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Кипр	3 сар	Пропорциональ тогтолцоо
Чех	90 хүртэлх хоног	Пропорциональ тогтолцоо
Дани	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Эстони	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Франц	2 долоо хоног	Мажоритари тогтолцоо
Финланд	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Герман	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Грек	30 хоног	Пропорциональ тогтолцоо
Унгар	50 хоног	Холимог тогтолцоо
Ирланд	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Итали	Тогтсон хугацаагүй	Холимог тогтолцоо
Латви	120 хоног	Пропорциональ тогтолцоо
Литва	6 сар	Пропорциональ тогтолцоо
Люксембург	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Мальта	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Нидерланд	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Португаль	12 хоног	Пропорциональ тогтолцоо
Румын	30 хоног	Пропорциональ тогтолцоо
Словаки	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Словени	30 хоногоос ихгүй	Пропорциональ тогтолцоо
Испани	15 хоног	Пропорциональ тогтолцоо
Канад	37 хоногоос доошгүй 51-ээс дээшгүй	Мажоритари тогтолцоо
Австрали	33 хоног	Мажоритари тогтолцоо
Япон	12 хоног	Холимог тогтолцоо
Сингапур	Хамгийн багадаа 9 хоног	Мажоритари тогтолцоо
Израиль	30-150 хоног ⁸	Пропорциональ тогтолцоо

⁶ Д.Түмэнжаргал & Г.Эрдэнэбаяр (2021) “Монгол Улсын сонгуулийн хуулийн өөрчлөлт: Хэрэгжилт, боловсронгуй болгох асуудал”, Политологи XVIII, “Эрдэм шинжилгээний бичиг №18, (534), х-104

⁷ UNDP (2013), Монгол Улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж, Улаанбаатар, х-15

⁸ Израильд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа сонгууль болохоос 150 хоногийн өмнөх хугацааг хамардаг бөгөөд сонгуулийн өмнөх 30 хоногийн хугацаанд кино театр, телевизээр сурталчилгаа явуулахыг хориглодог.

Филиппин	45 хоног	Холимог тогтолцоо
БНСУ	14 хоног	Холимог тогтолцоо
Англи	60 хоног	Мажоритари тогтолцоо
Монгол Улс	22 хоног	Мажоритари (2020 он) тогтолцоо
АНУ	130-141 хоног	Мажоритари тогтолцоо
Албани	30 хоног	Пропорциональ тогтолцоо
Босни ба Херцеговина Улс	30 хоног	Пропорциональ тогтолцоо
Македон Улс	20 хоног	Пропорциональ тогтолцоо
Монтенегро	Тогтсон хугацаагүй	Пропорциональ тогтолцоо
Шинэ Зеланд	30 хоног	

Бельги Улс Сонгуулийн зардлыг хязгаарлах, хянах тухай хуулийн 5-р зүйлд заасны дагуу сонгууль болохоос 4 сарын өмнөөс сурталчилгаа хийхийг зөвшөөрдөг байна. Сонгуулийн санал авах өдөр хүртэл кампанит ажил явуулж, сурталчилгаа хийх боломжтой байдаг. Болгар Улсын сонгуулийн тухай хуулийн 175-р зүйлд “Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 30 хоногийн өмнө эхлүүлнэ” гэж заасан.⁹ Түүнчлэн тус хуулийн 182-р зүйлд сонгуулийн санал авах өдрөөс 24 цагийн өмнө эхэлж, сонгуулийн өдрүүдэд сурталчилгаа хийхийг хориглосон. Хорват Улс доод тал нь 60 хоног байхаар хуульд тусгаж өгсөн. Кипр Улс 2004 оны (10(I)2004) хуулийн VII хэсгийн 2-р зүйлд сонгуулийн сурталчилгааг сонгууль эхлэхээс 3 сарын өмнө эхлүүлэхээр заасан байдаг. Тус хуулийн 63-р хэсэгт зааснаар сонгуулийн сурталчилгааг сонгуулийн өдрөөс 2 хоногийн өмнөөс хориглодог. Чех Улс Сонгуулийн тухай хуулийн (62/2003) 59-р зүйлийн 3-т сонгуулийн сурталчилгааны хугацааг сонгуулийн өдрөөс 90-ээс доошгүй байхаар тусгажээ. Дани Улс сонгуулийн хуульд кампанит ажлын тодорхой хугацаа зааж өгөөгүй. Сонгуулийн санал авах байр болон ойр орчмын газруудаас бусад тохиолдолд сонгуулийн өдөр сурталчилгааг явуулахыг зөвшөөрдөг.¹⁰ Эстони Улсын парламентын сонгуулийн тухай хуульд сонгуулийн сурталчилгааны хугацааг заагаагүй. Гэвч сонгуулийн хуулийн 5-р зүйлд сонгуулийн санал авах байранд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглосон. Франц 1977 оны 7-р сарын 7-ны өдөр баталсан 77-729 дугаарт хуулийн 15-р зүйлд “Сонгуулийн сурталчилгааг сонгууль болохоос өмнөх хоёр дахь даваа гарагаас эхэлж болно”¹¹ хэмээн заасан. Финланд Улсын Сонгуулийн тухай хуульд сонгуулийн кампанит ажлын үргэлжлэх хугацааг заагаагүй. Харин сонгуулийн тухай хуулийн 72-р хэсэгт санал хураах хугацаанд санал авах байр болон ойр орчмын газарт үг хэлэх, хэвлэмэл болон бичгээр ухуулах, сонгогчдын сонгох эрх чөлөөнд нөлөөлөхийг хоригложээ.¹² ХБНГУ-ын хувьд сонгуулийн сурталчилгааны тогтсон хугацааг хуулиар тогтоож өгөөгүй байдаг. Намууд болон нэр дэвшигчдийн кампанит ажил сонгууль болохоос хэдэн сарын өмнө буюу ихэвчлэн Холбооны Ерөнхийлөгч сонгуулийн товыг тогтоосноос (сонгуулийн өдрөөс нэг жилийн өмнө) эхэлдэг. Грек Улс Европын сонгуулийн тухай хуулийн 14-р зүйлийн 1-д зааснаар Санал хураах өдөр, үргэлжлэх хугацааг сонгууль товлосон өдрөөс хойш 30-аас доошгүй хоног байхаар заажээ. Унгар Улсад сонгуулийн тухай хуулийн 139-р зүйлийн 1-д зааснаар сонгуулийн сурталчилгаа нь сонгуулийн өдрөөс 50 хоногийн өмнө эхлэн сонгуульд дуустал үргэлжилнэ. Сонгуулийн өдөр санал авах байр, санал авах байрнаас 150 метрийн зайд сонгогчдын хүсэлд нөлөөлөхүйц байдлаар сурталчилгаа явуулахыг хориглодог.¹³ Ирланд Улс сонгуулийн сурталчилгааны үргэлжлэх хугацааг нарийвчлан хуулиар тогтоогоогүй.

⁹ Bulgaria Election Code, (In force from 2014) Chapter twelve, Article 175

¹⁰ Denmark Folketing (Parliamentary) Election Act, Article 50

¹¹ Law No 77-729, France, (1977), Article 15

¹² Finnish Election Act, (1998), Section 72

¹³ Act XXXVI of 2013 on the Election Procedure, Section 139 (1)

Итали Улс сонгуульд зарласан хугацаанаас эхлэн сурталчилгааг зөвшөөрдөг. Ихэнхдээ сонгуулийн өдрөөс 2 сарын өмнө сонгуулийн тов гаргадаг. Латви Улсад Сонгуулийн өмнөх кампанит ажлын тухай хуулийн 1,2-т зааснаар сонгууль болохоос 120 дахь өдрөөс эхлэн сонгуулийн санал авах өдөр хүртэл үргэлжилнэ¹⁴ хэмээн заасан. Санал авах өдрөөс 1 хоногийн өмнөөс сурталчилгааг зогсоодог. Литва Улс сонгууль зарласан өдрөөс сурталчилгаа эхлэхийг зөвшөөрдөг. Сонгуулийг санал хураалтаас 6 сарын өмнө зарладаг. Люксембург Улс сонгуулийн сурталчилгааны хугацааны талаар тусгайлан хуульд заагаагүй. Мальта Улс Сонгуулийн сурталчилгааны хугацаатай холбоотой үндэсний хэмжээний тодорхой заалт байхгүй. Санал хураалт эхлэхийн өмнөх өдөр болон сонгуулийн өдөр олон нийтийг хамарсан хурал, жагсаал цуглаан хийхийг хориглосон байдаг.¹⁵ Нидерланд Улс Сонгуулийн хуульд сурталчилгааны хугацааны талаар тусгайлан заалт байхгүй. Харин сонгуулийн өдөр санал авах байранд болон ойр орчимд сонгогчдын шийдвэр гаргахад нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулж болохгүй.¹⁶ Польш Улсад Сонгуулийн тухай хуулийн 104-р зүйлд сонгуулийн сурталчилгааны хугацаа эрх бүхий байгууллага сонгууль товлон зарласан өдрөөс эхэлж, сонгуулийн өдрөөс 24 цагийн өмнө дуусна гэж заасан. Хуульд тус улсын Ерөнхийлөгч сонгуулийн санал хураах өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө сонгууль явуулах тухай зарлиг гаргах ёстой гэж заасан.¹⁷ Португал Улсын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар “Бүгд Найрамдах Улсын Ассамблейн гишүүдийн сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаа сахилга баттай холбоотой хуулийн заалтууд хамаарна. Сонгуулийн сурталчилгааны үргэлжлэх хугацаа 12 хоног байна” гэж заажээ.¹⁸ Румын Улс 33/2007 хуулийн 35 дугаар зүйлд зааснаар сонгуулийн сурталчилгааны хугацаа 30 хоног үргэлжилж, сонгуулийн өмнөх бямба гарагийн 7:00 цагт дуусна¹⁹ гэж заажээ. Испани Улсад сонгуулийн сурталчилгааны хугацаа 15 хоног үргэлжилж, сонгуулийн өдрийн өмнөх өдрийн 00 цагт дуусна гэж хуульд тусгасан. Швед Улс сонгуулийн сурталчилгааны хугацааны талаар тодорхой заалт хуульдаа тусгаж өгөөгүй.²⁰ Канад Улс 1926 онд сонгуулийн сурталчилгааны хугацаа 74 хоног байсан бол эдүгээ доод тал нь 36 хоног болгосон.²¹ Улмаар 36-51 хоногт сонгуулийн сурталчилгааны хугацаа байхаар хуульд тусгажээ.²² Австрали Улс 1910 онд сонгуулийн сурталчилгааны хугацаа анх 11 долоо хоног үргэлжилж байсан бол эдүгээ 33 хоног байхаар тогтсон. Израиль Улс хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах сонгуулийн сурталчилгааг 150 хоногийн өмнөөс эхлэхийг зөвшөөрдөг. Харин сонгуулийн өдрөөс өмнөх 30 хоногийн хугацаанд телевизээр сурталчилгаа явуулахыг хориглодог.²³ Филиппин Улсын сонгуулийн тухай хуулийн 3-р хэсэгт парламентын сонгуулийн сурталчилгааны хугацаа 45 хоног байхаар тогтоожээ.²⁴ БНСУ-ын Төрийн удирдах түвшний албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 4-р бүлгийн 33-р зүйлд “Парламентын гишүүд болон орон нутгийн байгууллагын гишүүн болон даргыг сонгохдоо сонгуулийн сурталчилгааг 14 өдрийн турш зохион байгуулна” гэж заасан талаар БНСУ-ын иргэн Жён Кёнжин ярьж байв. Бүгд Найрамдах Албани Улсын Сонгуулийн тухай хуульд сонгуулийн сурталчилгаа нь “сонгууль болохоос 30 хоногийн өмнө эхэлж, сонгуулийн өдрөөс 24 цагийн өмнө дуусна” гэж заасан байдаг. Сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Сонгуулийн өмнөх өдөр болон санал хураах өдөр хүртэл аливаа сурталчилгааг хориглодог. Босни Герцеговин Улсын Сонгуулийн тухай хуулийн 16-

¹⁴ Pre-election Campaign Law, Latvia, Section 1 and 2

¹⁵ General Elections Act, Malta, Article 65

¹⁶ Keiswet, The Netherlands, Section V, Chapter V, Art 1-39

¹⁷ The Polish Electoral Code, (2011), Article 104

¹⁸ The Law on Election to the European Parliament, Portugal, Article 10

¹⁹ The Law No 33/2007, Romania, Article 35

²⁰ Micaela Del Monte, Silvia Kotanidis, Length of the election campaign and the electoral silence period in European Parliament elections, PE 751.463- September 2023, p.4-9

²¹ <https://www.elections.ca/content.aspx?section=vot&dir=bkg&document=ec90795&lang=e>

²² <https://electionsanddemocracy.ca/canadas-elections/canadas-election-process/election-campaigning>

²³ https://aceproject.org/ace-en/topics/me/mea/mec02/mobile_browsing/onePag

²⁴ Omnibus Election Code of The Philippines, 1995, Article 1, Section 3

р бүлэгт "Сонгуулийн сурталчилгаа сонгуулийн өдрөөс 30 хоногийн өмнө эхэлж, сонгуулийн өдрөөс 24 цагийн өмнө дуусна" гэж тусгажээ.

Бүгд Найрамдах Македон Улсын Сонгуулийн тухай хуулийн 69-р зүйлийн 2-т "Сонгуулийн сурталчилгаа нь сонгуулийн санал авах өдрөөс 20 хоногийн өмнө эхэлдэг бөгөөд нэг, хоёр дахь шатны сонгуулийн сурталчилгааг сонгууль болохоос 24 цагийн өмнө болон сонгуулийн өдөр үргэлжлүүлж болохгүй" гэж заасан. Монтенегрод Зөвлөлийн гишүүн, төлөөлөгчийн сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгаа нь "Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг баталгаажуулсан өдрөөс сонгуулийн сурталчилгаа дуусах хүртэл" гэж заасан байдаг.

Зургаадугаар зүйлд "Сонгуулийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, олон нийтийг хамарсан сурталчилгаа хийх ажлыг санал авах өдрөөс 24 /хорин дөрөв/ цагийн өмнө зогсооно" гэж заасан.

Улс төр судлаачид болон улс төрчдөөс ганцаарчилсан ярилцлагын аргаар сонгуулийн сурталчилгааны хугацааны талаарх санал бодлыг судалж үзэхэд өөр өөр байр суурьтай байсан юм. Тухайлбал, сонгуулийн сурталчилгаанд шаардах хугацаа тойргоос хамааран харилцан адилгүй байдаг талаар нэр дэвшигч эмэгтэй онцолж байв.

Ганцаарчилсан ярилцлагаас

УИХ-д аль тойргоос өрсөлдөж буйгаас хамаараад хугацааны хувьд нэр дэвшигчид харилцан өөр бодолтой байдаг болов уу. Жишээ нь нийслэлийн тойрогт буюу төвлөрсөн газруудад цаг хугацаа алдах нь харьцангуй гайгүй байх, харин орон нутагт өрсөлдөж байвал нэг тойргоос нөгөө тойрогт очиход хугацаа шаарддаг тул томоохон газар гутагтай, мөн томсгосон мажоритар тойргуудад хугацаа шаардлагатай. Жижигсгэсэн тойрог, төвлөрсөн газар, дэд бүтэц интернэт хөгжсөн газруудад хугацаа богино байхад төдийлөн асуудалгүй байна гэж бодож байна.

2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч, Эмэгтэй, 42 настай

Сонгуулийн тухай хууль, журам нь олон нийтийн мэдэх эрхийг хангаж чадаж байна уу, үнэн бодит, хүртээмжтэй мэдээллээр иргэдийг хангах боломж бий юу гэдэг нь чухал асуудал юм. Тухайлбал, сонгуулийн сурталчилгааны хугацаа хэт богино байх нь олон нийтэд хангалттай мэдээлэл олж авах, түүнийгээ эргэцүүлэн тунгаах боломж олгодоггүй. Богино хугацаанд олон мэдээлэл дунд төөрөлдөх, шинэ нэр дэвшигчийн талаар мэдээлэл авахгүй байх тохиолдол олон гардаг талаар зарим судалгаанд дурджээ. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа 18 хоног байсан. Сонгуулийн сурталчилгааны хугацаа хэтэрхий богино, мөн хуулиар мөрийн хөтөлбөрүүд урьдчилан батлахыг зааж өгсөн зэрэг нь нэр дэвшигчдийг олон нийтэд үзэл санаагаа илэрхийлэх боломжийг хязгаарласан гэж Олон Улсын Сонгуулийн Ажиглах Хорооны тайланд дурджээ.²⁵ Өөрөөр хэлбэл сонгуулийн сурталчилгааны хугацаа богино байх нь олон сул талтай байгааг судалгааны байгууллагууд мөн дурдаж байв.

Нөгөөтээгүүр сонгуулийн ирцийн үзүүлэлтэд сурталчилгааны хугацаа нөлөөлдөг байна. "Бүх төрлийн сонгуулийн ирц буурахад сонгогчийн боловсрол тааруу, сонгуулийн тогтолцоо, хууль дүрмийн байнгын өөрчлөлт, үүнтэй холбоотой ойлгомжгүй байдал, бухимдал, улс төрийн томоохон намуудын талаарх нийгмийн сөрөг ойлголт, сонгуулийн сурталчилгааны богино хугацаа зэрэг нийтлэг хүчин зүйлс нөлөөлж болно."²⁶

²⁵ Глоб Интернэшнл (2021), "Сонгуулийг мэдээлж, сурвалжлах нь", Улаанбаатар, х-23

²⁶ Азийн Сан (2023), Монгол Улсын Сонгууль (1992-2021), Улаанбаатар, х-11

Ганцаарчилсан ярилцлагаас

УИХ-ын сонгуулийн сурталчилгааны хугацаа хэт урт байх нь мөнгөгүй нэр дэвшигчдэд хүндрэлтэй байдаг. Харин хэт богино болчихвол маневр хийх, сонгогчдод өөрийгөө таниулж чадахгүй асуудалд хүрнэ.

УИХ-ын гишүүн асан, Эмэгтэй, 60 настай

Ганцаарчилсан ярилцлагаас

УИХ-ын сонгуулийн сурталчилгааны хугацаа хэт урт байх нь мөнгөгүй нэр дэвшигчдэд хүндрэлтэй байдаг. Харин хэт богино болчихвол маневр хийх, сонгогчдод өөрийгөө таниулж чадахгүй асуудалд хүрнэ.

УИХ-ын гишүүн асан, Эмэгтэй, 60 настай

Зарим судлаачид болон улс төрчид манай улсын нөхцөлд богино буюу 22 хоног байх нь шударга бус нөхцөл байдал үүсгэнэ гэж үзэж байв. Хэдийгээр техник, технологи хөгжиж байгаа боловч цахим орчинд дийлэнх сурталчилгааг хийх нь өрөөсгөл хэмээн тодотгож байсан юм. 2020 оны байдлаар манай улсын зургаагаас дээш насны хүн амын интернэт хэрэглэдэг хүн амын дундаж хувь 64.7 хувь байсан. Улаанбаатар, Орхон, Дархан-Уул аймгийн хүн амын интернэт хэрэглэгчдийн эзлэх дундаж хувь нь 72.5% байгаа хэдий ч бусад аймгуудын дундаж нь 45-63% байна.

Ганцаарчилсан ярилцлагаас

УИХ-ын сонгуулийн сурталчилгааны хугацааг нэмэгдүүлэх шаардлагатай. Учир нь шинээр нэр дэвшигчид өөрсдийгөө таниулах тодорхой хугацаа хэрэгтэй. Тиймээс 25 хүртэл хоног сурталчилгааг явуулах нь үр дүнтэй гэж бодож байна.

УИХ-ын гишүүн асан, Эрэгтэй, 59 настай

Манай улс сонгуулийн сурталчилгааны хугацааг бууруулах болсон гол үндэслэлүүдийн нэг нь нэр дэвшигчдээс гарах санхүүгийн зардлыг бууруулах зорилготой байдаг. Гэвч богино хугацааны сурталчилгаа нь санхүүгийн зардлыг улам өсгөдөг талаар судлаачид байр сууриа илэрхийлж байсан. Энэ талаар А.Б Зевиринцев “Богино хугацааны кампанит ажил нэлээд урт хугацаагаар үргэлжилсэн кампанит ажлаас илүү их санхүүгийн зардал шаарддаг байна. “Шинжээчдийн үнэлгээгээр бол орон нутагт хийх дөрвөн сарын кампанит ажил ижил үр нөлөөтэй боловч зөвхөн нэг сарын хугацаанд явуулах кампанит ажлаас ойролцоогоор 2 дахин бага санхүүгийн зардал шаарддаг ажээ.”²⁷

Дүгнэлт

Сонгуулийн сурталчилгааны хугацаа нь сонгуулийн үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийн нэг юм. Сурталчилгааны хугацааны талаар судлаачид өөр өөр байр суурьтай байгаа нь гарч буй үр дүнгээс хамааралтай юм. Нэг талаар сурталчилгааны урт хугацаа нь өндөр зардал, сонгогчдыг залхаах гэх мэт сул талтай байдаг бол нөгөө талаар олны танил бус улс төрчид олон нийтэд өөрийн мэдээллийг түгээх, сонгогчид олон талаас дүгнэж сонголтоо хийхэд дөхөм болдог байна.

Улс орнууд өөрсдийн онцлогт тааруулан сонгуулийн сурталчилгааны өөр өөр хугацаатай байхаар хуульдаа тусгаж өгсөн. Зарим улс оронд сонгуулийн сурталчилгааны эхлэл, төгсгөлийг хуулиар тогтоодоггүй. Ерөнхийдөө бэлтгэлийн үе шат, сонгуулийн өмнөх

²⁷ Зевиринцев.А.Б (2003), Мэдээлэл харилцааны менежмент, УБ., х-123

үе, сонгуулийн сурталчилгааны "оргил" үе гэсэн үе шаттайгаар явагддаг байна. Дийлэнх улс орнууд 4-6 долоо хоногт сонгуулийн сурталчилгаа явуулахыг зөвшөөрдөг байна. Иймд уг тоог олон улсын дундаж гэж үзэх боломжтой юм. Сонгуулийн сурталчилгааны хугацаа бага улс орнуудын дийлэнх нь хүн амын дунд интернэт ашиглах хэрэглэгчдийн эзлэх хувь 90 буюу түүнээс дээш байх нь түгээмэл байна.

Иймд манай улсын хувьд өргөн уудам газар нутагт сонгогчдод мэдээлэл хүргэх цаг хугацааны хязгаарлалт, танигдаагүй улс төрчид олон нийтэд өөрийн мэдээллийг хүргэх, цахим хэрэглэгчийн хувь хот, орон нутагт ялгаатай үзүүлэлттэй байдаг зэргийг харгалзан үзэж 30 хоног байх нь зохистой гэж үзэж байна.

Abstract

Researchers have different opinions about the duration of election campaigns. Some scholars believe that the campaign period should be long enough because of the importance of voters' right to know, to make their choice, and for candidates to introduce themselves to voters. However, some researchers believe that too long campaign period has negative aspects such as annoying the voters, demanding more financial expenses from the candidates, and reducing government activities. According to the document research, countries around the world have implemented election campaign periods in different ways in the 20th century. Majority countries have a lead time of 30-50 days. It is common for the law to prohibit any advertising from 24 to 48 hours before election day.

Keywords: Parliament, election campaign, election candidate

Ашигласан ном, материал

Монгол хэл дээр:

1. Азийн Сан (2023), Монгол Улсын Сонгууль (1992-2021), Улаанбаатар
2. Глоб Интернэшнл (2021), “Сонгуулийг мэдээлж, сурвалжлах нь”, Улаанбаатар
3. Зверинцев.А.Б (2003), Мэдээлэл харилцааны менежмент, УБ
4. Д.Оюунчимэг (2016), “Сонгуулийн сурталчилгааны арга зүй”, Политологи сэтгүүл №13 (442)
5. Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, 1992 он, 26-р зүйлийн 1-р заалт
6. НҮБ-ХХ (2013), Монгол Улсад үзүүлсэн сонгуулийн тусалцааны сургамж, Улаанбаатар,
7. Д.Түмэнжаргал, Г.Эрдэнэбаяр (2018), “Монгол Улсын сонгуулийн хуулийн өөрчлөлт: Хэрэгжилт, боловсронгуй болгох асуудалд”, Политологи XVIII, Эрдэм шинжилгээний бичиг №18, (534)

Англи хэл дээр:

1. Act XXXVI of 2013 on the Election Procedure, Section 139 (1)
2. Bulgaria Election Code, (In force from 2014) Chapter twelve, Article 175
3. Costas Panagopoulos, Campaign Duration and Election Outcomes, Politics and Governance, 1(1), 2013, 66-73
4. Denmark Folketing (Parliamentary) Election Act, Article 50
5. Finnish Election Act, (1998), Section 72
6. Gelman A, King G. (1993), Why American Presidential Election Polls So Variable When Votes are So Predictable? British Journal of Political Science; 23 (3): 409
7. General Elections Act, Malta, Article 65
8. Keiswet, The Netherlands, Section V, Chapter V, Art 1-39
9. Law No 77-729, France, (1977), Article 15
10. Micaela Del Monte, Silvia Kotanidis, Length of the election campaign and the electoral silence period in European Parliament elections, PE 751.463- September 2023, p.4-9
11. Omnibus Election Code of The Philippines, 1995, Article 1, Section 3
12. Pre-election Campaign Law, Latvia, Section 1 and 2

13. Stevenson R., Vavreck L. (2000), Does Campaign Length Matter? Testing for Cross-National Effects. *British Journal of Political Science*. 30 (2); 217-235
14. The Polish Electoral Code, (2011), Article 104
15. The Law on Election to the European Parliament, Portugal, Article 10
16. The Law No 33/2007, Romania, Article 35

Цахим эх сурвалж:

<https://www.elections.ca/content.aspx?section=vot&dir=bkg&document=ec90795&lang=e>
<https://electionsanddemocracy.ca/canadas-elections/canadas-election-process/election-campaigning>
https://aceproject.org/ace-en/topics/me/mea/mec02/mobile_browsing/onePag
<https://explodingtopics.com/blog/countries-internet-users>
<https://electionsanddemocracy.ca/canadas-elections/canadas-election-process/election-campaigning>

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 51-69 дэх тал

**УИХ-ЫН ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ОРУУЛСАН
ПОСТУУДАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Б.Эрдэнэдалай

МУИС, УТСОУХНУС

Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Ю.Ариунзаяа

МУИС, УТСОУХНУС

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 2020 онд сонгогдсон УИХ-ын эмэгтэй гишүүдийн нийгмийн сүлжээнд оруулсан постуудад дүн шинжилгээ хийх, ингэхдээ улс төрийн мэдээлэл харилцааны асуудалтай холбон судлаж, сайжруулах боломжтой зарим саналыг дэвшүүлнэ.

Түлхүүр үгс: УИХ-ын эмэгтэй гишүүд, мэдээлэл харилцаа, нийгмийн сүлжээ дэх пост

Оршил:

Сүүлийн жилүүдэд технологи дээр суурилсан мэдээлэл харилцаа эрчимжиж улс төрчид мэдээллийг хэрхэн дамжуулж, цаг үеийн аливаа үйл явдалд ямар байр суурьтай оролцож байгааг түүний нийгмийн сүлжээнд оруулж буй мэдээллүүдээс харах боломжтой болсон. Өөрөөр хэлбэл, улс төрчдийн нийгмийн сүлжээн дэх мэдээлэл, постууд улс төрийн мэдээлэл харилцааны нэгэн сонирхолтой судлагдахуун болсон байна. Гадны улс орнуудад твиттерийг улс төрийн мэдээлэл харилцаандаа ихээр ашиглаж байхад манай улсын хувьд улс төрчид фэйсбүүк, твиттерийг сонгуулийн үед идэвхтэй ашиглаж, тэр хэрээр сонгуулийн кампанит ажлын пост мэдээлэлд хийсэн мониторингууд ч хийгдэх болжээ. Улс төрчид уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглахаас илүүтэй нийгмийн сүлжээнд үзэл бодол, байр сууриа илэрхийлэх нь нэмэгджээ. Улс төрийн нам, улс төрчид дэргэдээ цахим орчин хариуцсан мэргэжилтэнтэй болж олон нийтийн санаа бодолд нөлөөлөхүйц хэмжээнд ашиглах болсон. Монголын улс төрчид иргэд, олон нийт, сонгогч, дэмжигчидтэй харилцахдаа нийгмийн сүлжээний сувгуудыг хэрхэн ашигладаг талаар хангалттай хэмжээнд судлагдаагүй байна. Энэ талаар хийсэн цөөн хэдэн судалгаа нь гол төлөв ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн нэр дэвшигчдийн үйл ажиллагаанд төвлөрсөн. Тиймээс УИХ-ын эмэгтэй гишүүдийн нийгмийн сүлжээний сувгуудад дүн шинжилгээ хийх, ялангуяа монголчуудын хамгийн их хэрэглэж буй фэйсбүүк хуудсыг шинжлэн судлах нь улс төрийн коммуникацийн нэг судлагдахуун болсон байна.

Улс төр ба нийгмийн сүлжээ

Улс төрийн коммуникацийг улс төрийн зорилгын үүднээс бусадтай харилцах, мэдээлэл дамжуулах үйл явц гэж тодорхойлж болно. Улс төрийн коммуникаци хэмээх ойлголтод засгийн газар, улс төрийн намууд сонгуулийн үеэр ч бай, сонгуулийн үеэс бусад үед ч олон нийтийн дэмжлэгийг авахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахыг багтаадаг¹. Сүүлийн жилүүдэд харилцаа холбооны шинэ технологи, интернэтийн өсөлт нь

¹ Riaz, Saqib (2010). Effects of New Media Technologies on Political Communication, Journal of Political Studies, Vol. 1, Issue 2, 161-173

урьд өмнө хэзээ ч байгаагүй мэдээлэл түгээх шинэ дүр төрхийг нээж өгсөн. Энэ нь ялангуяа интернэт хүмүүсийн өдөр тутмын амьдралд өнөөг хүртэл төсөөлшгүй байдлаар нэвтэрч байна. 1980-аад оноос хойш интернэтийн өсөлт бусад харилцаа холбооны хэрэгслийн өсөлтөөс хурдан байсан².

Интернэтийн сүлжээ дэлхий даяар хэрэглэгдэх болсон цагаас хойш хэвлэл мэдээллийн салбарт төдийгүй улс төрийн коммуникацийн судалгааны хүрээнд “шинэ медиа” гэсэн нэр томъёо орж ирсэн. Шинэ медиа нь цахим сүлжээн дээр суурилж хөгжсөн, олон төрлийн сувгууд, платформыг нэгтгэсэн ойлголт юм.

Сошиал медиа нь вэб 2.0 технологи дээр суурилсан төрөл бүрийн программууд бөгөөд хэрэглэгчийн үүсгэсэн контентыг солилцох боломжийг олгодог. Фэйсбүүк, инстаграм, твиттер зэрэг нь өдгөө хамгийн олон хэрэглэгчтэй нийгмийн сүлжээний харилцааны платформууд болсон байна. Тухайлбал, 2004 онд үүссэн хэдий ч 2006 оноос олон нийтэд нээлттэй болсон фэйсбүүк хэрэглэгчдэдээ контент, зураг, видео, нийтлэл оруулах зэргээр олон зүйлийг санал болгодог. Харин твиттер өөрийн үзэл бодлоо 280 тэмдэгтэд (анх гарахдаа 140 тэмдэгт байсан) тааруулан илэрхийлэх боломжийг олгодог. Твиттер дотоод болон олон улсын улс төрийн амьдралд улам бүр хамааралтай хэрэгсэл болоод байна.

Үзэгч, сонсогчид нь идэвх сул хүлээн авагч байдаг уламжлалт мэдээллийн хэрэгслүүдтэй харьцуулахад нийгмийн сүлжээ нийгмийн идэвхтэй оролцоог цогцлоох дэвшилтэт, интерактив платформыг бий болгож, ингэснээр мэдээллийг түгээх, хүлээн авах арга хэлбэрийг өөрчилсөн. Фэйсбүүк, твиттер өөрийн нэрийн профайл үүсгэж, сүлжээндээ хэрэглэгч нэмж, өөрөө контент бүтээж, түгээж, нийтэлж, үзэл бодлоо хуваалцаж, өөрөөр хэлбэл өөрийгөө сурталчлах, бусадтай харилцах харилцаа холбооны нэг хэрэгсэл болж чадсан. Улс төрчид ч фэйсбүүкийг дагагчийнхаа тоог нэмэгдүүлэх, улс төрийн үйл ажиллагааг сурталчлан таниулахад түлхүү ашиглаж байна. Хувь хүний болон улс төрийн байр сууриа бататгаж, өөрийг нь дэмжиж буй хүмүүсийн хүрээллийг бий болгож, нөлөөгөө тогтоох хэрэгсэл нь болжээ.

Улс төрийн коммуникаци мэдээллийн технологиор дамжуулж иргэдийн улс төрийн шийдвэр болон сонгуулийн үр дүнд нөлөөлөх арга хэрэгсэл юм. Нийгмийн сүлжээний мэдээлэл улс төрийн коммуникацийн судалгааны үндсэн салбарын нэг болох улс төртэй иргэдийг холбох хэрэгсэл гэж хэлж тайлбарлаж болно.

Мэдээлэл олж авах, санал бодлоо илэрхийлэх, улс төрийн хэлэлцүүлэг өрнүүлэх нь нийгмийн сүлжээний давуу тал. Нэг үгээр нийгмийн сүлжээ бол олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний элементийг дэмжсэн платформ юм. Иргэд уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйлчлүүлэхээсээ илүүтэйгээр фэйсбүүк, твиттерээр үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлж байгаа бөгөөд улс төрийн оролцооны нэг хэлбэр. Пью цэнтр судалгааны төвийн хийсэн судалгаагаар фэйсбүүкийг байнга ашигладаг хүмүүсийн улс төрд оролцох оролцоо ашигладаггүй хүмүүстэй харьцуулахад өндөр байгааг тогтоосон байна³.

Нийгмийн сүлжээний сувгууд нь харилцаа холбооны чухал хэрэгсэл болоод зогсохгүй улс төрийн коммуникацийн нэг арга хэрэгсэл болсон.

Технологийн дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үсрэнгүй хөгжил нь намуудыг гишүүдээрээ дамжин иргэд, сонгогчдод хүрдэг тогтолцоог халж, телевиз, радио, цахим хуудас, сошиал орон зайг өргөн ашиглах боломжийг нээсэн. Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд улс төрийн нам иргэд сонгогчдын дунд “урт удаан хугацаанд амьдрах” хэрэгцээ улам өсөж байна. Мөн нөгөөтэйгүүр улс төрчид нийгмийн сүлжээг маркетинг, зар сурталчилгааны нэг чухал хэрэгсэл болгохоос гадна ухуулга сурталчилгаандаа ч түлхүү ашиглаж байна.

² Adeyanju, A (2015). Comparative Study of Social Media, Television and Newspapers' News Credibility, International Conference on Communication, Media, Technology & DesignAt: Dubai, United Arab Emirates.

³ Adeyanju, A (2015). Comparative Study of Social Media, Television and Newspapers' News Credibility, International Conference on Communication, Media, Technology & DesignAt: Dubai, United Arab Emirates.

Францын судлаач Ж.Эллюл “Ухуулга сурталчилгаа бол байнгын бөгөөд удаан хугацаанд үргэлжлэх ёстой” гэсэн зарчмыг гаргаж ирсэн бөгөөд реклам сурталчилгаа өдөр шөнөгүй, тасралтгүй явагдаж байж сая амжилт олдог гэж үзжээ⁴. Улс төрчид нийгмийн сүлжээнд мэдээлэл оруулахдаа өөрийгөө тодруулсан байдлаар сурталчлах нь түгээмэл байна.

Шинжлэх ухаанд детерминизм хэмээх ойлголт байдаг бөгөөд түүний дотор технологийн детерменизм гэдэг бол технологийн хөгжил улс төрийн коммуникацийг бий болгож хөгжүүлсэн гэж үздэг хандлага⁵ юм. Телевиз үүссэнээр улс төрийн коммуникацид шинэ хуудас нээж улс төрчид хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцаж мэдээлэл, сурталчилгаа явуулах нь нэмэгдсэн. Харин нийгмийн сүлжээ бий болсноор 24 цагийн турш мэдээллээ нийтлэх боломжтой болж цахим орчныг улс төрийн коммуникацидаа ашиглах болсон.

Улс төрчдийн технологийн хөгжилтэй зэрэгцэн алхах үйл явцыг тайлбарлахад Л.Даунс, С.Мью нарын судлаачдын гаргаж тавьсан “салаалах зарчим”-ын онолыг ашигладаг⁶. Нийгмийн сүлжээг улс төрийн үйл ажиллагаандаа идэвхтэй ашиглах нь тогтмол кампанит ажлын нэг чухал арга суваг юм. Сонгогчид сонгуулийн кампанит ажлын үеийн сурталчилгаанд биш тухайн улс төрчийн талаарх урт хугацааны ажиглалтаа чухалчилдаг. Тиймээс нийгмийн сүлжээг ашиглан тогтмол кампанит ажлыг оновчтой зохион байгуулах нь технологи дээр суурилсан мэдээлэл харилцааны чухал чиглэл болсон байна. Судлаач Ормштэйн болон Р.Манн нарын тогтмол кампани хийгдэх шалтгаан нь 24 цагийн мэдээг хүлээн авах мэдээлэл харилцааны технологийн дэвшилтэй холбоотой гэж үзсэн байдаг⁷.

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн 2008 оны сонгуульд ялалт байгуулахад нөлөөлсөн нэг зүйл нь шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглаж чадсан явдал байв. Үүнээс хойш ихэнх улс төрчид сонгуулийн кампанит ажлын тактикаа боловсруулахдаа нийгмийн сүлжээний сувгуудын гүйцэтгэх үүргийг харгалзан үздэг болж, тэдний хувьд фэйсбүүк, твиттер улс төрийн коммуникацийн чухал хэрэгсэл болов. АНУ-ын нэгэн адилаар, бусад оронд улс төрчид твиттер, фэйсбүүкийг улс төрийн үйл ажиллагаандаа ашиглах нь нэмэгдэж байна⁸.

Нийгмийн сүлжээний хүчийг ашигласан бас нэг жишээ бол 2016 оны АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын үеийн Дональд Трампын үйлдэл гэж судлаачид үздэг. Трамп олон нийттэй харилцахдаа ердийн телевизийн сурталчилгаанаас илүү твиттер хуудсыг ашиглаж, зарим үед эрээ цээргүй бичсэн сэтгэгдлээрээ олон нийтийн хараанд өртөж, тэр хэрээр АНУ-ын ерөнхийлөгч болж чадсан. Мөн 2019 онд Английн Ерөнхий сайдаар Борис Жонсоныг сонгогдоход нөлөөлсөн нэг хүчин зүйл нь түүний дагагч нарын тоо бусад нэр дэвшигчдээс 500.000 “лайк”-аар илүү байсантай холбоотой байсан. Эндээс харахад нийгмийн сүлжээ нь улс төрийн үйл явцад төдийгүй улс төрчийн мэдээлэл харилцааны чухал хэрэгсэл болсон байна.

АНУ-ын сенатч, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч асан Берни Сандерс олон нийтийн сүлжээг хамгийн сайн аргаар өөртөө ашигтайгаар ашигласан. Тэрээр инстаграм, фэйсбүүк, твиттер тэр ч байтугай тиктокийг ашиглан олон нийтэд, ялангуяа улс төрийн асуудалд анхаарлаа хандуулдаггүй залуу сонгогчдын сонирхлыг татсан видео бичлэг, нийтлэл оруулж цаашлаад залуусын хэрэглэдэг “меме”-үүдийг ашигладаг нь залуучуудад төдийгүй улс төрөөс ангид үзэгчдэд хүрч чадсан⁹ байна.

⁴ Мөнхцэцэг, Ц (2002) Улс төрийн манипуляци. Политологи ЭШБ №1 52-57

⁵ M. R. Smith and L. Marx (1994) *Does Technology Drive History? The Dilemma of Technological determinism*. Cambridge, MA: MIT Press

⁶ L. Downs and C. Mui (2001). *Unleashing the Killer App*. Boston, MA: Harvard University Press.

⁷ N.J. Ormshtein and T.E. Mann (2000) *The Permanent Campaign and its Future*. Washington, DC: American Enterprise Institute and The Brookings Institute.

⁸ Aaron Smith, Pew Research Center “The Internet’s Role in Campaign 2008” (April 15, 2009) <https://www.pewresearch.org/internet/2009/04/15/the-internets-role-in-campaign-2008/>

⁹ Irma Jakić. (2021, July 22). Best Political Social Media Accounts. <https://www.determ.com/>

Монгол Улс 2023 оны 11 сарын байдлаар 3.4 сая хүн амтай¹⁰ байна. “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний судалгаа”-наас үзэхэд, 2021 оны байдлаар нийт өрхийн 80 хувь нь интернэт хэрэглэж байна. Интернэт хэрэглэж байгаа иргэдийн 95 хувь нь мэдээлэл авах гэж ашигладаг. 35 хүртэлх насны иргэдийн 92.8 хувь нь интернэт ашигладаг. Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 98 хувь нь үүрэн утас, үүнээс 90.4 хувь нь ухаалаг утас сүүлийн гурван сард хэрэглэсэн¹¹ байна. Дээрх судалгааны дүнгээс харахад монголчуудын интернэтийн хэрэглээ харьцангуй өндөр бөгөөд интернэтийн тусламжтайгаар мэдээлэл олох үйл явц өндөр гэж дүгнэж болохоор байна. Эндээс интернэт хэрэглээ монголчуудын хувьд энгийн хэрэглээ болсон байна.

“We are social” болон “Hootsuite” байгууллагууд нь дэлхийн улс орнуудын дижитал хэрэглээний тайланг жил бүр гаргаж www.datareportal.com сайтад нийтлэдэг бөгөөд тус сайтын мэдээлснээр Монголын фэйсбүүк хэрэглэгчдийн тоо 2017 онд 1.6 сая байсан бол 2023 оны эхэнд хийсэн тайландаа Монголын социал медиа хэрэглэгчдийн тоо 2.5 саяд хүрсний 2.3 сая нь фэйсбүүк хэрэглэдэг гэсэн байна. Мөн инстаграм хэрэглэгчид 774 мянгад хүрч, харин твиттерийг 151 мянган хүн хэрэглэж байгаа¹²-г дурджээ.

Зураг 1. Монголчуудын социал хэрэглээний судалгаа

	2017	2018	2019	2020	2021	2022	2023
 INTERNET USERS	1.6M	2M	2.2M	2.2M	2.01M	2.16M	2.85M
 SOCIAL MEDIA USERS	1.6M	2M	2.2M	2.1M	2.6M	2.85M	2.5M
 FACEBOOK	1.6M	2M	2.2M	2.1M	2.5M	2.5M	2.3M
 INSTAGRAM	-	-	400.000	420.000	670.000	854.900	774.600
 TWITTER	-	-		52.000	73.600	131.500	151.000

Эх сурвалж: www.datareportal.com

Хэвлэл мэдээлэл эрх чөлөөтэй биш нийгэмд шинэ медиа технологи чухал үүрэг гүйцэтгэж байна. Сонин хэвлэл болон радио, телевизийг хориглож болно, гэхдээ интернетийг хориглож болохгүй, блог, фэйсбүүкийг орхиж болохгүй, гар утасны мессежийг засгийн газар зогсоож болохгүй. Улс төрийн харилцааг олон эрдэмтэн, судлаачид янз бүрээр тодорхойлсон байдаг. Жишээлбэл, Роберт Э.Дентон, Гари С.Вудворд нар улс төрийн харилцаа холбоог илгээгчдийн улс төрийн орчинд нөлөөлөх хүсэл эрмэлзэл хэлбэрээр дүрсэлсэн байдаг. Тэдний хэлснээр харилцааг “улс төрийн” болгодог чухал хүчин зүйл бол мессежийн эх сурвалж биш харин түүний агуулга, зорилго¹³ юм.

УИХ-ын эмэгтэй гишүүдийн 2020 оны сонгуульд оролцсон зардлын санхүүжилтээс харахад 137 саяас 651 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Эдгээр зарцуулалтаас 5 орчим хувийг зөвхөн цахим орчин ашиглах зардалд зарцуулжээ¹⁴. Эндээс харахад нэг нэр дэвшигч цахим орчинд 6-32 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн сүлжээнд идэвхтэй байж олон нийтийн хамгийн ихээр ашиглаж буй фэйсбүүк, твиттер зэргийг тогтмол кампанит ажилдаа зүй зохистой ашигласнаар харьцангуй бага зардлаар

¹⁰ Статистикийн үндэсний хорооны сайт. МУ-ын хүн амын тоо. <https://www.1212.mn/mn>

¹¹ Үндэсний статистикийн хороо. (2021). Өрхийн болон хүн амын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний түүвэр судалгаа. Улаанбаатар.

¹² Дижитал хэрэглээний тайлан. <https://datareportal.com/reports/digital-2023-mongolia>

¹³ Riaz, Saqib (2010). Effects of New Media Technologies on Political Communication, Journal of Political Studies, Vol. 1, Issue 2, 161-173

¹⁴ Эрдэнэдалай, Б. (2023). Улс төрийн санхүүжилт: Олон Улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал. Улаанбаатар. 179-181

өөрийн улс төрийн байр сууриа бататгаж, олон нийтэд танигдаж, пи араа өсгөх боломжтой гэдэг нь харагдаж байна.

Нийгмийн сүлжээний сувгууд өртөг багатай, хувийн санаачилга голлох үүрэг гүйцэтгэдэг учраас улс төрийн өрсөлдөөнд сул оролцдог парламентын эмэгтэй гишүүдэд тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг тул улс төрд оролцох эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой. АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Монгол Улсад 2020 оны 5 дугаар сарын 14-нөөс 6 дугаар сарын 15-ны өдөр явуулсан судалгаанаас үзэхэд, монголчуудын улс төрийн талаарх мэдээллийг авахад хамгийн их ашигладаг мэдээллийн хэрэгсэл нэгт телевиз, хоёрт сошиал медиа орж байна¹⁵. Эндээс цаашид улс төрийн мэдээ, мэдээлэл түгээх, хүлээн авахад сошиал медиагийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэнэ хэмээн таамаглахад хүргэж байгаа юм.

“Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ” судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 82.6 хувь нь улс төрийн үйл ажиллагаандаа нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглаж байна. Улс төрч эмэгтэйчүүдийн хувьд өөрийгөө таниулах, улс төрийн байр сууриа бэхжүүлэх, улс төрийн үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх, олон нийтийн санаа бодлыг мэдэх, сонгогч, дэмжигчидтэйгээ шууд харилцахад фэйсбүүк чухал үүрэгтэй байна. Ялангуяа олон нийтийн санаа бодлыг мэдэх, сонгогч, дэмжигчидтэйгээ шууд харилцахад фэйсбүүк нь твиттерээс илүү үр дүнтэй хэмээн судалгаанд оролцогчдын 69.5% дүгнэжээ¹⁶.

УИХ-ын гишүүд чуулганы үеэр болон чуулган завсарласан үеүдэд өөрийн фэйсбүүк хуудастаа ямар төрлийн мэдээллийг хэрхэн нийтлэж байгааг шинжлэн үзэх нь тухайн гишүүний талаар хийсэн ажил, тодорхой үйл явдалд оролцож буй байр суурь, хандлага, цаашдын зорилго гээд илүү их зүйлийг мэдэх боломжийг олгож байна.

УИХ-ын эмэгтэй гишүүдийн нийгмийн сүлжээнд оруулсан постуудад хийсэн шинжилгээ

2020 оны УИХ-ын сонгуулиар парламентад 13 эмэгтэй гишүүн сонгогдсон. Судалгааны хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 03-аас 2023 оны 03 дугаар сарын 15 хүртэл буюу УИХ-ын намрын чуулган эхлэх өдрөөс хаврын чуулган эхлэх хүртэлх хугацаанд эдгээр гишүүдийн фэйсбүүк хуудсанд нийтлэсэн постуудын мэдээллийг шинжлэхийг зорилоо.

УИХ-ын эмэгтэй гишүүдийн нийгмийн сүлжээнд оруулсан пост мэдээлэлд анализ хийхдээ “цэнхэр тэмдэгтэй” албан ёсны пэйж хуудсыг сонгосон бөгөөд хэрэв уг тэмдэглэгээгүй бол өөрийн нэрийн фэйсбүүк хуудсыг сонгон авч, нийтэлсэн мэдээ мэдээлэлд анализ хийв.

Эмэгтэй гишүүд нийгмийн сүлжээг идэвхтэй ашигладаг бөгөөд УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэгээс бусад гишүүдийн фэйсбүүк хуудас албан ёсны хаягт өгдөг баталгаажуулалтын цэнхэр тэмдэгтэй болжээ. Твиттер хуудсыг 7 гишүүн идэвхтэй ашигладаг бөгөөд Ч.Ундрам гишүүн ганцаараа “цэнхэр тэмдэг”-тэй твиттер хаягтай байв. Судалгаанд УИХ-ын гишүүний хувиар ашигладаг албан ёсны фэйсбүүк пэйж хуудсыг сонгон авсан бөгөөд хамгийн олон дагагчтай нь П.Анужин (113.000), хамгийн бага дагагчтай нь Б.Жаргалмаа (6.100) гишүүн байна. Харин твиттерт хамгийн их дагагчтай нь С.Одонтуяа (155.000) гишүүн байв.

¹⁵ БНОУХ “Залуучуудын санаа бодлын судалгаа”

https://www.iri.org/wp-content/uploads/2020/09/mongolia_ned_youth_poll_2020_-_public_0.pdf

¹⁶ Бямбаханд, Л. (2022). Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ. Цахим засаглал: Төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж ба сорилтууд.

Хүснэгт I: УИХ-ын эмэгтэй гишүүдийн ашигладаг фэйсбүүк хуудас

Гишүүдийн нэрс	Өөрийн фэйсбүүк хуудас- Дагагчийн тоо	Албаны ёсны пэйж хуудас/ дагагчийн тоо	Хамааралтай фэйсбүүк хуудсууд
С.Одонтуяа УИХ-ын дэд дарга	Одонтуяа Салдан (14.000)	Saldan Odontuya (102.000)	-
А.Адъяасүрэн	Adiyasuren Amgalan (18.504)	Амгалангийн Адъяасүрэн (88.000)	-
П.Анужин	Anujingua PurevOchir (201.000)	Пүрэв-Очирын Анужин (113.000)	-
Б.Баярсайхан	Bayarsaikhan Baljinnyam	Bayarsaikhan Baljinnyam MP (88.000)	Балжиннямын Баярсайхан сан
Х.Булгантуяа	Булгантуяа Хүрэлбаатар	Bulgantuya Khurelbaatar (92.000)	
Б.Жаргалмаа	Бадарчийн Жаргалмаа (4800)	Б.Жаргалмаа (6.100)	
Г.Мөнхцэцэг	Munkhtsetseg Gompildoo (2018 оноос хойш ашиглаагүй)	Гонпилдоогийн Мөнхцэцэг (14.000)	-
Ц.Мөнхцэцэг	Muki Munkhtsetseg (6374)	Доктор - PhD, дэд профессор Цэрэнжамцын МӨНХЦЭЦЭГ (16.000)	-УИХ-ын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийн ажлын алба -УИХ-ын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийн дэмжигчид
Д.Өнөрболор	Өнөрболор Дамдинсүрэн	Дамдинсүрэнгийн Өнөрболор (34.000)	Дамдинсүрэнгийн Өнөрболорыг дэмжигчид
М.Оюунчимэг	Мөнхөөгийн Оюунчимэг (7220)	М.Оюунчимэг гишүүнийг дэмжигчдийн хуудас (26.000)	М.Оюунчимэг гишүүний ажлын алба
Д.Сарангэрэл	Сарангэрэл Даваажанцан	Сарангэрэл Даваажанцан (37000)	-
Б.Саранчимэг	Batsukh Saranchimeg 11259	Batsukh Saranchimeg Батсүхийн Саранчимэг (32.000)	

Ч.Ундрэм	Чинбатын Ундрэм (49.000)	-Чинбатын Ундрэмыг дэмжигчид
----------	-----------------------------	------------------------------------

Зураг 2. УИХ-ын эмэгтэй гишүүдийн фэйсбүүк дэх дагагчийн тоо



Зураг 3. УИХ-ын эмэгтэй гишүүдийн твиттер дэх дагагчийн тоо




-УИХ-ын эмэгтэй гишүүдийн фэйсбүүк хуудас нь 6200 –аас 113000 хүртэл дагагчтай бөгөөд дунджаар 53000 орчим хүнд хүрч мэдээ, мэдээлэл хүргэдэг байна. Эндээс эмэгтэй гишүүд улс төрийн мэдээлэл түгээхдээ нийгмийн сүлжээг идэвхтэй ашиглаж байна.

-УИХ-ын эмэгтэй гишүүдийн 50 гаруй хувь нь твиттерийг коммуникацидаа ашигладаг бөгөөд энэхүү сувагт идэвхгүй байдал монголчуудын дийлэнх хэрэглэгч твиттерийг хэрэглэдэггүйтэй холбоотой байж болно. Эмэгтэй гишүүдээс твиттерт хамгийн

олон дагагчтай нь С.Одонтуяа (155000) гишүүн, хамгийн бага дагагчтай нь Ц.Мөнхцэцэг (889) гишүүн байна.

Хүснэгт 2. УИХ-ын эмэгтэй гишүүдийн фэйсбүүк хуудсанд нийтэлсэн мэдээллүүдийн ерөнхий тойм



Фэйсбүүкт нийтлэж байгаа мэдээллүүд ихэвчлэн ямар төрлийн мэдээ мэдээлэл байгааг тодорхойлох үүднээс оруулсан постуудын нийтлэг давтагдаж байгаа мэдээлэлд үндэслэн дараах байдлаар ангиллаа.

Хүснэгт 3. УИХ-ын эмэгтэй гишүүдийн фэйсбүүк хуудсандаа оруулдаг мэдээллүүдийн нийтлэг агуулга

Постын сэдэв	Олон нийтэд чиглэсэн мэдээ, мэдээлэл	Байр суурь	Тойрогтоо ажилласан талаарх мэдээ, мэдээлэл	Мэндчилгээ	Хувь хүн, гэр бүлийнхээ талаар
Агуулга	-Цаг үеийн мэдээлэл -Содон шинэ мэдээ -Зөвлөгөө зөвлөмж	Аливаа нэг асуудлаар байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн -ярилцлага, -тодруулга	-Тойргийн иргэдийг хүлээн авч уулзсан талаарх -Тойргийн уулзалтууд	-Тэмдэглэлт баярын өдрүүдэд зориулсан -Өдөр тутмын мэндчилгээ	Өөртэй нь хамааралтай дурсамж -гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл

Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд цаг үеийн мэдээ мэдээллийг түлхүү постолдог. Тухайлбал, УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа нар фэйсбүүк хуудсаа өдөр тутмынхаа үйл ажиллагаанд идэвхтэй ашиглаж, цаг үеийн мэдээллийг оруулдаг бол фэйсбүүкт хамгийн идэвхгүй нь Д.Сарангэрэл гишүүн байлаа.


Судалгааны хугацаанд тойрогтой холбоотой мэдээлэл хамгийн их оруулж байсан нь орон нутгаас сонгогдсон гишүүд байсан бөгөөд тэр дундаа нэг тойрог буюу Сэлэнгэ аймгаас сонгогдсон Ч.Ундрам, Д.Өнөрболор нар тойрогтой холбоотой болон тойргийн гишүүдтэй уулзсан талаарх мэдээллийг хамгийн их нийтэлжээ. Дээрх хоёр гишүүний араас Завхан

аймгаас сонгогдсон Б.Баярсайхан, Баянхонгор аймгаас сонгогдсон А.Адъяасүрэн нар орж байна.


Харин тойрогтой холбоотой мэдээлэл хамгийн бага оруулсан гишүүд Х.Булгантуяа, П.Анужин, Д.Сарангэрэл нар байлаа.

Судалгааны хугацаанд Ц.Мөнхцэцэг, Б.Баярсайхан нарын гишүүд цаг үеийн асуудлаар үзэл бодол, байр сууриа өөрийн фэйсбүүк хуудсаараа түлхүү илэрхийлсэн бол гэр бүл болон хувийн амьдралтай холбоотой пост хамгийн ихээр оруулсан нь Ч.Ундрам гишүүн байсан.

Зураг 4. УИХ-ын эмэгтэй гишүүдийн өдөр тутмын мэндчилгээнүүдээс




Зураг 5. УИХ-ын эмэгтэй гишүүдийн оруулсан мэндчилгээнүүдээс



Д.Өнөрболор, Б.Баярсайхан, М.Оюунчимэг, А.Адъяасүрэн нарын гишүүд фэйсбүүк хуудсаараа өдөр тутмын мэндчилгээг түлхүү оруулсан бол дийлэнх гишүүд нийтээр тэмдэглэдэг болон тэмдэглэлт баярын өдөрт зориулж мэндчилгээ бүхий пост оруулдаг нь ажиглагдсан.

Мөн бусад салбарын болон олон улсын тэмдэглэлт өдрүүдэд ач холбогдол өгч цаг алдалгүй постолдог. Өдөр тутмын мэндчилгээ болон баяр ёслолын холбогдолтой мэдээлэл хамгийн ихээр оруулдаг нь М.Оюунчимэг, Б.Баярсайхан нарын гишүүд байсан.

Зураг 6. УИХ-ын эмэгтэй гишүүдийн тойрог дээрээ ажилласан талаарх мэдээлэл-1




Гишүүд тойрогт ажиллах үеийнхээ мэдээллийг фэйсбүүк хуудастаа нийтлэхдээ ихэвчлэн фото зурагтай мэдээлэл түлхүү оруулж байсан бол Д.Өнөрболор гишүүний тойрогтоо ажилласан мэдээллүүд видео хэлбэрээр орсон байв. Эндээс харахад нэг гишүүний цаана зураг авах, видео бичлэг хийх мэргэжлийн баг ажиллаж байгааг харж болно.

Мөн зарим гишүүд хаштагийг (#) ашиглаж, хаана байгаагаа тодотгосон байсан нь онцлог байв. Хаштагийг нийгмийн сүлжээнд тодорхой нэг үйл явдал асуудлыг тодотгож онцлохдоо хэрэглэдэг бөгөөд түүний тусламжтайгаар тухайн асуудал хэчнээн хүний анхаарлын төвд орсныг тандах боломжийг олгодог юм.

Гишүүдийн оруулсан постын мэдээллээс ирэх сонгуульд хаанаас нэр дэвших талаар таамаглал дэвшүүлэх боломжтой. Тухайлбал Б.Ундрэм, Д.Өнөрболор, Б.Баярсайхан нарын гишүүд тойргийнхоо иргэдтэй уулзсан талаарх мэдээлэл түлхүү оруулж байгаагаас харахад тухайн сонгогдсон тойргоосоо дахин нэр дэвших магадлалтай юм. Харин Б.Саранчимэг УИХ-д Баянзүрх дүүргийн сонгуулийн 22 дугаар тойргоос нэр дэвшиж сонгогдсон ч энэхүү судалгааны хугацаанд сонгогдсон тойрогтой холбоотой 5 мэдээ нийтэлсэн бол Дундговь аймагтай холбоотой 7 мэдээ оруулснаас харахад ирэх сонгуульд өөрийн төрсөн нутаг болох Дундговь аймгаас нэр дэвших магадлалтайг харуулж байна.

Зураг 7. УИХ-ын эмэгтэй гишүүдийн тойрог дээрээ ажилласан талаарх мэдээлэл-2



УИХ-ын гишүүд тойрогтоо ажиллах явцдаа ирэх сонгуульдаа бэлдэн иргэд сонгогчидтой уулзалт зохион байгуулж, өөрийгөө сурталчлах ажлаа хийдэг. Тойрогтоо ажиллах үедээ Д.Өнөрболор гишүүн Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт, Б.Саранчимэг гишүүн тойргийнхоо өрхийн эмнэлэгт тус тус машин бэлэглэж, Г.Мөнхцэцэг гишүүн сургуулийн, харин Б.Жаргалмаа гишүүн цэцэрлэгийн нээлтэд оролцсон талаарх мэдээллээ нийтэлсэн байв. Мөн Д.Өнөрболор гишүүн багш нарыг эрт илрүүлгийн үзлэгт хамруулж байхад С.Одонтуяа гишүүн тойргийнхоо эмнэлэгт хөхний эхоны аппарат авч өгсөн талаар, Ц.Мөнхцэцэг гишүүн Олон улсын шүдний мэргэжилтнүүдийг урьж, П.Анужин гишүүн тойргийнхоо саажилттай иргэдийг нэгэн бариачаар бариулахаар болсон талаарх мэдээллээ нийтлэв. Эндээс харахад тойрогтоо ажиллах нэрээр төрийн байгууллагад хэрэгцээт зүйлийг нь өгөхөөс гадна УИХ-ын гишүүд зарим нэг талаараа эрүүл мэндийн салбарынхны ажил үйлчилгээг давхар гүйцэтгэж байна гэж хэлж болохоор байна.

Зураг 8. УИХ-ын эмэгтэй гишүүдийн тойрог дээрээ ажилласан талаарх мэдээлэл-3




Доктор - PhD, дэд профессор
Цэрэнжамцын МӨНХЦЭЦЭГ
Oct 18, 2022 · 6

Швейцарын нүүр, амны эрүүл ахуйч
Габриэлла Шмидт Корситто тэргүүтэй
"Мишээл хүүхдийн сан"-гийн мэргэжлийн
шүдний эмч нарын баг сургалт, эмчилгээ
хийж байна.

УИХ-ын сонгуулийн 24 дүгээр тойрог,
Сүхбаатар дүүргээс сонгогдсон УИХ-ын
гишүүн Ц.Мөнхцэцэг миний бие Швейцарын
нүүр, амны эрүүл ахуйч Габриэлла Шмидт
Корситто тэргүүтэй "Мишээл хүүхдийн
сан"-гийн мэргэжлийн шүдний эмч нарын
багийг урьж тойргийнхоо 12-20 дугаар
хорооны 03-16 насны хүүхэд багачуудад амны
хөндийн үзлэг оношлогоо, шүдний эмчилгээ,
сургалтыг үнэ төлбөргүй хийж байна.
Энэхүү үзлэг оношлогоо, эмчилгээ 2022 оны
10 сарын 14-19-ний өдрүүдэд болж өндөрлөх
юм.

Сонгогдсон тойрогтой холбоотой мэдээллүүд тойргийн иргэдтэй уулзаж, ямар нэг бүтээн байгуулалт, үйл ажиллагааны нээлт, өдөрлөгт оролцсон талаарх мэдээллүүдээс бүрдэж байв.

Зураг 9. АН-аас сонгогдсон гишүүдийн постуудаас



УИХ-д Ардчилсан намаас нэр дэвшиж сонгогдсон хоёр эмэгтэй гишүүн байдаг нь А.Адьяасүрэн, С.Одонтуйа нар юм. С.Одонтуйа гишүүн эв нэгдлийн хувьд асуудалтай байгаа Ардчилсан намд төвийг сахих байр сууриар хандаж байгаа нь намтай холбоотой мэдээллийг оруулахдаа "Бид нэг л нам" хэмээн тодотгож, оруулснаас харж болно. Тэрээр Ардчилсан намыг хамгаалагч, эрх баригч намын эсрэг аливаа асуудалд шүүмжлэгчийн байр сууринаас хандсан постуудыг түлхүү нийтэлсэн бол А.Адьяасүрэн гишүүн намтай холбоотой пост мэдээлэл энэхүү судалгааны хугацаанд оруулаагүй байв.

Хэлбэрийн хувьд чуулган болон байнгын хороонд хэлсэн үг, байр сууриа бичлэгээр фэйсбүүктэй нийтлэх нь түгээмэл байсан.

УИХ-ын эмэгтэй гишүүд өөрийн байр сууриа илэрхийлэхдээ уламжлалт мэдээллийн хэрэгслээс гадна товч тодруулгыг хэвлэлийн сайтуудад, цаг үеийн мэдээлэл, байр сууриа ярилцлага хэлбэрээр өдөр тутмын сонин, сайтуудад ихэвчлэн өгсөн бөгөөд тэрхүү мэдээллүүдээ фэйсбүүк хуудсандаа давхар оруулсан байлаа. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд


өгсөн ярилцлагуудаас нь гишүүний байр суурийг мэдэхээс гадна ямар хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ойр ажилладаг, мэдээллээ ямар сувгаар түлхүү гаргах сонирхолтой байгааг нь дүгнэх боломжтой.

Зураг 10. УИХ-ын эмэгтэй гишүүдийн байр суурь, ярилцлага-1




УИХ-ын гишүүн С.Одонтуяа тухайн цаг үеийн хамгийн анхаарал татсан сэдвээр байр сууриа илэрхийлж байсан бол судалгааны хугацаанд Д.Өнөрболор гишүүн Өдрийн сонинд сар бүр нэг материал нийтлүүлсэн байв.

Зураг 11. УИХ-ын эмэгтэй гишүүдийн байр суурь, ярилцлага-2




Эмэгтэй гишүүд сонин, сайтад ярилцлага өгөхдөө ажлын хэсэгт орж ажиллаж байгаа хуулийн төсөлтэй холбоотой асуудлаар тодруулга, ярилцлага өгөх нь түгээмэл байсан. Тухайлбал Ч.Ундрэм “Органик бүтээгдэхүүний тухай хууль”, Б.Саранчимэг “Ил тод байдлын тухай хууль”, Г.Мөнхцэцэг, Б.Баярсайхан нар “Боловсролын багц хууль”, Б.Жаргалмаа “Нийгмийн халамжийн багц хууль”-ийн төслийн талаар тодруулга ярилцлага өгч, байр сууриа илэрхийлсэн байв.

Зураг 12. УИХ-ын эмэгтэй гишүүдийн байр суурь, ярилцлага-3




Судалгааны хугацаанд Ц.Мөнхцэцэг гишүүн сонин, сайтад дэлгэрэнгүй ярилцлага хамгийн их өгчээ. Энэ нь өдөр тутмын сонин, сайтын сэтгүүлчидтэй ойр ажиллаж байгааг харуулахын зэрэгцээ анх удаа сонгогдсон гишүүний хувьд хэвлэлтэй ойр байж, үзэл бодлоо цаг тухай бүрд илэрхийлэх боломжийг алддаггүй нь харагдаж байна.

Зураг 13. УИХ-ын эмэгтэй гишүүдийн цахим тайлан




Технологийн нөлөөгөөр гишүүд хийсэн ажлын тайланг цахим хэлбэрээр иргэдэд хүргэдэг болсон байна. Д.Өнөрболор, Ч.Ундрам, М.Оюунчимэг, Ц.Мөнхцэцэг нарын гишүүд фэйсбүүк хуудсандаа нэг жилийн хугацаанд хийсэн тайлангаа цахимаар үзэх боломжтой байдлаар байршуулжээ.

Зураг 14. УИХ-ын эмэгтэй гишүүдийн онцлох постуудаас



Судалгааны явцад цаг үеийн мэдээ мэдээллээс гадна бусад шинэ мэдлэг, мэдээлэл болохуйц постууд ч ажиглагдаж байв. Зарим эмэгтэй гишүүдийн оруулж хэвшсэн мэдээллүүдээс онцолбол, Ц.Мөнхцэцэг гишүүн УИХ-ын чуулган болон байнгын хороонд болох үйл явдлын мэдээллийг цаг алдалгүй нийтэлдэг бол Д.Өнөрболор гишүүн “мэдлэгээ хуваалцаж” агуулгын дор бусад улс орны нийгэм, эдийн засгийн мэдээллийг, С.Одонтуяа гишүүн “Иргэн та энэ мэдээллийг заавал уншаарай” агуулгын дор иргэдэд хэрэгтэй мэдээллийг түлхүү нийтэлж байв.

Зураг 15. УИХ-ын эмэгтэй гишүүдийн хувийн амьдралтай холбоотой пост



Фэйсбүүктээ хувийн амьдралтай холбоотой пост мэдээллүүдийг оруулж олон нийтэд өөрийгөө эерэгээр ойлгуулах гэсэн оролдлогуудыг ч зарим гишүүд хийсэн. Ч.Ундрам гишүүний хувьд хувийн амьдралтай холбоотой мэдээлэл ихээхэн асуудал дагуулсан бөгөөд хувийн амьдралтай холбоотой постыг хамгийн их оруулсан. Б.Баярсайхан, Д.Өнөрболор, Ц.Мөнхцэцэг нар хувь хүний шинжтэй мэдээлэл пост оруулахдаа нөхөр, хүүхдийнхээ зургийг хуваалцаж гэр бүлийн хувьд “асуудалгүй” гэдгээ харуулж байв.

Зураг 16. УИХ-ын эмэгтэй гишүүдийн төсвийн талаар оруулсан пост



Батсүх Саранчимэг Батсүхийн Саранчимэг
November 12, 2022

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСӨВ БАТЛАГДАЛАА

МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ ӨРГӨӨР 2023 ОНЫ БАЙГУУЛЛАХ, ДЭВЭЭГЭЙН САМУУЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХӨМӨЖ, БАЙГАА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГААЛАА

Хүрээний төсөл	Төсөв арга хэмжээний код, үндсэн нэр, байршил	Хүрээний төсөл	Төсөв арга хэмжээний код	Самууламж өрт
Х.1.1.1.1.1	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.2	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.3	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.4	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.5	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.6	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.7	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.8	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.9	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.10	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.11	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.12	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.13	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.14	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.15	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.16	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.17	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.18	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.19	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.20	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.21	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.22	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.23	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.24	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.25	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.26	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.27	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.28	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.29	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.30	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.31	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.32	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.33	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.34	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.35	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.36	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.37	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.38	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.39	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.40	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.41	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.42	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.100	2023	2022	4,000.0
Х.1.1.1.1.43	Улаанбаатар хотын төсвийн төсөл 4.1 т.1			

Аливаа нэг сэдвийг хэрхэн постолсон байгаагаар нь тухайн гишүүний байр суурь, хандлагыг мэдэх боломжтой. Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл багтагдсан талаарх мэдээллийг оруулсан 5 гишүүний дөрөв нь сонгогдсон тойрогтойгоо холбоотой мэдээлэл оруулсан байв. Эндээс харахад УИХ-ын гишүүдийн оруулж буй пост мэдээллүүд зөвхөн сонгогдсон тойргийн иргэдэд чиглэгдэж байгаа нь харагдана.

Зураг 17. УИХ-ын эмэгтэй гишүүд фэйсбүүктээ нийтэлсэн амлалтууд


Гишүүд фэйсбүүктээ олон нийтэд хандсан, амлалт өгсөн мэдэгдлүүдийг ч хийдэг. Сонгогчид энэ амлалтын хүрээнд хэрхэн ажиллаж байгааг нь асуух боломжтой. Тухайлбал, Д.Өнөрболор гишүүн “нүүрсний хэргийг ил тод болгож хариуцлага тооцуулахын төлөө тууштай ажиллана” гэсэн бол П.Анужин гишүүн “Нийгмийн даатгалын багц хуулийг батлуулахын төлөө”, А.Адъяасүрэн гишүүн “хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйг бүрдүүлэхийн тулд санаачлага гаргаж эмэгтэй гишүүдээ уриалан ажиллах болно” гэсэн амлалтууд бичсэн байв.

Зураг 18. УИХ-ын эмэгтэй гишүүдийн фэйсбүүк постоос



Нийгмийн эмзэг асуудлаар эмэгтэй гишүүдийг байр сууриа илэрхийлдэггүй гэж олон нийт ихээхэн шүүмжлэлтэй ханддаг. Машиндаа амаржсан эхийн асуудлаар хоёр гишүүн үзэл бодлоо фэйсбүүк хуудсаараа илэрхийлсэн байв.

Зураг 19. УИХ-ын эмэгтэй гишүүдийн байр суурь, ярилцлагуудаас



УИХ-ын гишүүд зурган постерыг фэйсбүүк хуудастаа түлхүү оруулдаг бөгөөд постер ямар нэг сэдвийн хүрээнд өөрийн байр сууриа илэрхийлсэн утга агуулгатай байлаа.

Дүгнэлт

Нийгмийн сүлжээний нэг платформ болох фэйсбүүк улс төрийн мэдээлэл харилцааны нэг чухал хэрэгсэл болоод зогсохгүй тогтмол кампанит ажлын нэг чухал хэрэгсэл болжээ. УИХ-ын эмэгтэй гишүүд өөрсдийн фэйсбүүк хуудсандаа цаг үеийн мэдээ, мэдээлэл постолж, байр сууриа илэрхийлж, улс төрийн мэдээлэл харилцааны хэрэгсэл болгон ашиглахаас гадна иргэд сонгогчидтойгоо ойр байх нэг талбар болгон ашиглаж байна.

2020 оны сонгуулиар сонгогдсон УИХ-ын 13 эмэгтэй гишүүний (2022 оны 10 дугаар сарын 3-аас 2023 оны 03 дугаар сарын 15 хүртэл) Намрын чуулган эхлэх өдрөөс Хаврын чуулган эхлэх хүртэлх 5 сарын хугацаанд фэйсбүүк хуудастаа нийтэлсэн постуудыг шинжлэхэд хамгийн их мэдээлэл оруулсан нь М.Оюунчимэг гишүүн байсан бөгөөд нийт 172 постыг оруулсан байв. Харин хамгийн бага пост оруулсан нь Д.Сарангэрэл гишүүн байлаа. Тэрээр судалгааны хугацаанд нийт 13 постыг фэйсбүүктээ оруулсан байв.

УИХ-ын эмэгтэй гишүүдийн нийгмийн сүлжээн дэх идэвхтэй байдалтай холбогдуулан ирэх 2024 оны сонгуульд нэр дэвших сонирхлыг дүгнэвэл Д.Сарангэрэл, П.Анужин, Б.Жаргалмаа нарын гишүүд фэйсбүүкийг хамгийн идэвхгүй ашигладаг бөгөөд улс төрийн мэдээ мэдээлэл, байр сууриа хангалттай постолж оруулдаггүй нь дахин нэр дэвших сонирхолгүй байгааг эсвэл УИХ-ын гишүүний хувьд хангалтгүй ажиллаж байгааг харуулж байна гэж дүгнэж болохоор байна. Мөн улс төрийн мэдээлэл харилцаа тэр дундаа сонгуулийн кампанит ажилд нийгмийн сүлжээний нөлөөллийн талаар судалгаа хийж, энэ талаар хамгийн их мэдээлэлтэй байдаг Ц.Мөнхцэцэг гишүүн сошиал орчинд хамгийн бага

дагагчтай. Хэвлэл мэдээллийн салбартай хамгийн ойр ажиллаж байсан Б.Жаргалмаа, Д.Сарангэрэл, Г.Мөнхцэцэг нарын гишүүд фэйсбүүкийг төдийлөн сайн ашигладаггүй, сонгогдсоноосоо хойш хамгийн олон албан тушаалыг хашиж буй Х.Булгантуяа гишүүн судалгааны хугацаанд хамгийн бага мэдээлэл оруулсан байв.

-УИХ-ын эмэгтэй гишүүдийн фэйсбүүк хуудасны пост мэдээллийг шинжлэхэд дийлэнх нь зурагт мэдээлэл байсан бөгөөд УИХ-ын чуулган болон байнгын хорооны хуралдааны үеэр хэлсэн үг, байр сууриа видео хэлбэрээр оруулах байдал түгээмэл байна.

-УИХ-ын эмэгтэй гишүүд цаг үеийн мэдээ мэдээллээ пост хэлбэрээр, аливаа нэг асуудлын талаар үзэл бодол байр сууриа өдөр тутмын сонин, сайтад ярилцлага байдлаар өгч фэйсбүүк хуудастаа байршуулдаг.

-Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг, харин орон нутгаас сонгогдсон эмэгтэй гишүүд тойрогтой холбоотой мэдээллийг хамгийн их оруулдаг.

-УИХ-ын эмэгтэй гишүүдийн тойрогтоо ажилласан талаарх мэдээллүүдийг ангилвал төсвийн байгууллагын нээлт, шаардлагатай машин тоног төхөөрөмж өгсөн, тойргийнхоо иргэд сонгогчдыг хүлээн авч уулзсан талаарх мэдээлэл дийлэнх хувийг эзлэж байна.

-Аливаа баяр ёслолын үеэр зурган пост, видео мэндчилгээ бэлтгэж фэйсбүүктээ оруулдаг зэргээс харахад гишүүдийн ард хэвлэл мэдээлэл, пи арыг нь хариуцсан баг ажилладаг гэж дүгнэж болохоор байна.

Зөвлөмж, санал

Нийгмийн сүлжээ нь олон нийтийн мэдээлэл авах, түгээх, бусадтай харилцах харилцаанд өргөн хүрээний дэвшил авчирсан. Улс төрчдийн хувьд харьцангуй өртөг багатай гэж хэлж болох нийгмийн сүлжээний платформуудыг ашигласнаар улс төрийн коммуникацаа үр дүнтэй зохион байгуулах боломжтойгоос гадна мэдээлэл сурталчилгааны зардлаа ч хэмнэх боломжтой юм. Монголын хэрэглэгчдийн дийлэнх нь фэйсбүүкийг өдөр тутамдаа тогтмол ашиглаж байгаа учраас улс төрчид ч хүссэн хүсээгүй нийгмийн сүлжээний идэвхтэй хэрэглэгч болоход хүргэж байна. Улс төрчид пи арын мэргэжилтнээс гадна мэдээлэл харилцааны мэргэжилтэнтэй болж, цаашлаад энэ чиглэлийн баг ажилласнаар улс төрийн коммуникацийн үйл явцыг илүү дүнтэй болоход нөлөөлөх болно. Цаашид улс төрчид нийгмийн сүлжээний тусламжтайгаар иргэдийн санаа бодлыг хэрхэн өөрчилж байгаа болон энэхүү нийгмийн сүлжээ нь иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгааг онцлон судлах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Abstract:

Within the area of this research work, the social media posts of the female members of Parliament elected in 2020 will be analyzed, and in doing so, some proposals that can be studied and improved by correlating with the problem of political information communication will be put forward.

Keywords: female members of Parliament, political communication, the social media posts

Ашигласан ном, материал

1. Батболд, Ц. (2018). Улс төрийн социологийн онолын үндэс
2. Болд-Эрдэнэ, Б. (2017). Нийгмийн харилцааны онол практик. Улаанбаатар.
3. Бямбаханд, Л. (2022). Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ. Цахим засаглал: Төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж ба сорилтууд.
4. Дижитал хэрэглээний тайлан. <https://datareportal.com/reports/digital-2023-mongolia>
5. Монгол Улсын Их Сургууль. (2021). Улс төрийн мэдээлэл харилцаа. Улаанбаатар.

6. Мөнхбат, С. (2021) Онлайн ардчиллын бэхжилт ба Монголын улс төрийн намын гишүүнчлэлд тулгарч буй сорилтууд. Политологи XXI ЭШБ №21 (579)
7. Мөнхцэцэг, Ц (2002) Улс төрийн манипуляци. Политологи ЭШБ №1
8. Эрдэнэдалай, Б. (2023). Улс төрийн санхүүжилт: Олон Улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал. Улаанбаатар
9. БНОУХ “Залуучуудын санаа бодлын судалгаа” https://www.iri.org/wp-content/uploads/2020/09/mongolia_ned_youth_poll_2020_-_public_0.pdf
10. Үндэсний статистикийн хороо. (2021). Өрхийн болон хүн амын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний түүвэр судалгаа. Улаанбаатар.
11. Үндэсний статистикийн хорооны сайт. <https://www.1212.mn/mn>
12. Aaron Smith, Pew Research Center “The Internet’s Role in Campaign 2008” (April 15, 2009) <https://www.pewresearch.org/internet/2009/04/15/the-internets-role-in-campaign-2008/>
13. Adayanju, A (2015). Comparative Study of Social Media, Television and Newspapers' News Credibility, International Conference on Communication, Media, Technology & DesignAt: Dubai, United Arab Emirates.
14. Irma Jakić. (2021, July 22). Best Political Social Media Accounts. <https://www.determ.com/>
15. L. Downs and C. Mui (2001). Unleashing the Killer App. Boston, MA: Harvard University Press.
16. M. R. Smith and L. Marx (1994) Does Technology Drive History? The Dilemma of Technological determinism. Cambridge, MA: MIT Press
17. N.J. Ormshtein and T.E Mann (2000) The Permanent Campaign and its Future. Washington,DC: American Enterprise Institute and The Brookings Institute.
18. Riaz, Saqib (2010). Effects of New Media Technologies on Political Communication, Journal of Political Studies, Vol. 1, Issue 2.

**МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ТҮҮНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ¹**

С.Мөнхбат

МУИС, УТСОУХНУС-ийн захирал

Б.Эрдэнэдалай

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Хураангуй:

Улс төрийн үзэл баримтлалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, улс төрийн бодлого шийдвэрт тусгах, намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө өөр өөрсдийн бодлогыг тусгах, хэлэлцүүлэх ажил нэн чухал байна. Үүнийг БШУЯ-ын захиалгаар, ШУТСангийн санхүүжилттэй МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төвийн хамтран 2022 онд гүйцэтгэсэн “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн экспертийн судалгааны дараах зураг дахь дүнгээс харж болно. Тухайлбал, нийт 7 оноогоор үнэлэх хариултаас 2.8 оноогоор сонгуульд оролцож буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр өөр өөрийн онцлог бүхий, ялгаатай байдаггүй, 2.58 оноогоор Монголын улс төрийн намууд үзэл баримтлалын хувьд ялгаатай хөгжиж чадаж байгаа байдал хангалтгүй гэсэн нь хамгийн өндөр оноо авсан үзүүлэлт байлаа. 2.23 оноогоор Монголын улс төрийн намуудын үнэт зүйл тодорхой, ойлгомжтой байдаггүй, 2.21 оноогоор улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр үзэл баримтлалтайгаа нийцдэггүй, 2.09 оноогоор сонгогчид улс төрийн намын үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй танилцан сонголтоо хийж чаддаггүй гэж хариулсан нь намууд үзэл баримтлалаа төдийлөн баримтлахгүй, ач холбогдол өгдөггүйг шууд харуулж байлаа.

Түлхүүр үгс: Үзэл баримтлал, улс төрийн бодлого шийдвэр, үзэл баримтлал ба мөрийн хөтөлбөр, намын үзэл баримтлалын талаарх экспертийн дүгнэлт, иргэдийн ойлголт

Орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлалын хандлага үзэл суртлын үнэт зүйлсийг хатуу баримтлахын оронд тухайн нөхцөлд тохируулан үзэл баримтлалаа тодорхойлох болсон байна. Г.Шелдон “Т.Жефферсоны улс төрийн философи” гэдэг номдоо Жефферсон либерал ба бүгд найрамдахчуудын үзлийн алийг нь илүү баримталж байсан бэ гэдэг судалгаа хийжээ. Тухайн номд дурдагдсан түүхэн баримтуудад тулгуурлавал Жефферсон либерал үнэт зүйлст илүү ханддаг байсан нь харагддаг хэдий ч тухайн нөхцөл байдалд консерватив үнэт зүйлсийг илүү баримтлан шийдвэр гаргадаг байжээ. Энэ нь үзэл суртлын үнэт зүйлс ба үзэл баримтлалын хоорондох ялгааг харуулж буй баримт юм. Өөрөөр хэлбэл, тухайн үзэл суртлын үнэт зүйлсийг дэмждэг хэдий ч нөхцөл байдалд тохируулан өөр үнэт зүйлсийг сонгон авч хэрэгжүүлэх явдал бол тодорхой цаг хугацааны хувьд үзэл баримтлал, хандлагаа тодорхойлж буй үйл явц юм.

¹ Энэхүү өгүүллийг БШУЯ-ын захиалгаар, ШУТСангийн санхүүжилттэй МУИС-д хэрэгжиж буй “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: институци, үйл явц, харилцаа” сэдэвт хавсарга судалгааны төслийн хүрээнд бэлтгэж нийтлүүлэв.

Судлаач доктор Ц.Ганболд, доктор Ц.Батболд нарын “Монгол дахь социал демократ үзэл суртлын өнөөгийн байдал, цаашдын хандлага”² өгүүлэлд дурдсанаар, орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлалын хандлага дараах хүчин зүйлстэй илүү холбоотойгоор адилсах шинжтэй хөгжиж байна гэж үзсэн. Үүнд:

1. Дундаж сонгогчдын хүсэл, сонирхлыг харгалзан үзэх.
2. Ардчиллын ерөнхий үнэт зүйлсийг харгалзан үзэх.
3. Үндэсний сэргэн мандлын төлөөх зорилго.
4. Олон улсын харилцааны дэг журам.
5. Дэлхийн эдийн засгийн либералчлал, чөлөөт зах зээл.
6. Үзэл суртлын давхцал болон өөрчлөлтөөс хамаарсан адилсал.
7. Ангийн ялгаа ач холбогдлоо алдсан.

Дээрх ерөнхий долоон гол хүчин зүйлс улс төрийн намуудын үзэл баримтлалыг улс орныг удирдахад илүүтэй чиглэгдэж буйг илэрхийлж байгаа нь улс төрийн намын хөгжлийг “catch all” ба “картель” намуудын хэв маяг руу чиглүүлсэн ажээ. “Catch all” ба “картель” намууд нь нийгмийн хэсэг бүлэг, аль нэг социал давхрагын эрх ашгийг хангахыг эрмэлзэхээс татгалзаж, нийгмийн бүх давхрагын эрх ашгийг зохицуулах “өргөн хүрээтэй бодлого” (catch all намын мөн чанарын нэг)-ыг өөр өөрсдийн үзэл суртлын үнэт зүйлст тулгуурлан боловсруулахад бусад намуудын үзэл бодлыг “харгалзан үзэж зохицуулах” (картель намын мөн чанарын нэг)-ыг илүүд үзэх болжээ. Энэ хандлага нь нэг талаар орчин үеийн улс төрийн намуудын зорилгоо хэрэгжүүлэх байр суурийг илүү прагматик тал руу шилжүүлж, үзэл суртлын чиг баримжаа, хатуу үнэт зүйлс, үйл ажиллагааны хэв маягийг бүдэгрүүлэхэд хүргэжээ. Уг хандлага нь улс төрийн намуудыг үзэл сурталгүй болгоно гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн намууд үзэл суртлын хатуу үнэт зүйлст тулгуурлан туйлшралгүйгээр бусад үнэт зүйлсийг харгалзан үзэж үзэл баримтлалаа боловсруулан хэрэгжүүлэх хандлагад шилжиж байгаа бөгөөд хэрэгжүүлж буй улс төрийн бодлого, хөтөлбөрт үзэл санааны чиг баримжаа, үнэт зүйлс, үйл ажиллагааны хэв маяг нь тод бусаар ч гэсэн хадгалагдсаар байгаа юм.

Энэ утгаар авч үзвэл, улс төрийн үзэл суртлын талаар илүү тодорхой тайлбарлах шаардлага тулгарч байгаа бөгөөд өнөө үед Монголын улс төрийн намуудын гишүүд ямар чиг баримжаа бүхий үзэл суртал, үнэт зүйлсийн систем, үйл ажиллагааны хэв маягийг баримтлаж ажиллахаа ч мэдэхээ байсан тал, гишүүд төдийгүй, лидерүүдэд нь ч ажиглагдаж байна.

Сонгуульд ахиухан суудал авах, иргэд сонгогчдод таалагдахын тулд намууд бүгд зүүний чиглэл бүхий хэт улс төржсөн үйл ажиллагаа явуулахад хүрдэг нь тэдгээрийг аяндаа социалист, коммунист болон популист хэв маягийн массын намууд болгоход хүргэдэг гэхэд хилсдэхгүй. Өөрөөр хэлбэр, манайд эдүгээ орчин үеийн хэв маягийн нам байх нийгэм улс төрийн, хууль эрх зүйн орчин нөхцөл, боломж бүрдээгүй байна. Шинээр ямар ч сайхан санаа, зорилготой үнэнхүү ардчилсан, либерал нам анхлан байгуулагдсан ч хуульд заасан бүтэц зохион байгуулалтын дагуу, намын гишүүд, идэвхтэн дэмжигчдийнхээ хүсэл зоригийн дагуу ард түмний хэрэгцээ сонирхолд тохируулан үйл ажиллагаа явуулахад хэсэг хугацааны дараа хүссэн хүсээгүй массыг хамарсан зүүний эсхүл популист хэв маягийн нам болж хувирдаг. Намын гишүүд нь ч ингэхийг хүсдэг, шаарддаг. Өөр зам байхгүй байна.

Өдгөө дэлхий дахинд улс төрийн намын хямрал нүүрлэжээ. Энэхүү хямралд нэн түрүүнд олон түмний намууд өртөж байгааг Италийн улс төр судлаач Пьеро Игнаци онцлон тэмдэглэсэн³ байдаг. Иймээс орчин үеийн намууд улс төрийн үзэл суртлын хатуу тогтсон хэлбэрийг тууштай хамгаалахаас илүүтэйгээр үзэл санаа, бодлого, үйл ажиллагааны прагматик байна⁴ гэжээ.

² Ц.Ганболд, Ц.Батболд. Монгол дахь социал демократ үзэл суртлын өнөөгийн байдал, цаашдын хандлага. Политологи XI эрдэм шинжилгээний бичиг. УБ. 2014. 24 дэх тал

³ Ignazi, P. The Crisis of Parties and the Rise of New Political Parties / P. Ignazi // Party Politics. -1996.-Vol.2

⁴ Баасансүрэн. Д. Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага. Бүхнийг шүүрэгч өргөн хүрээний намаас картель загварт. Политологи XXI эрдэм шинжилгээний бичиг №15 (476): УБ. 2017. 34 дэх тал

2000 оноос эхлэн улс төрийн намууд үзэл баримтлалын ялгарлаа алдаж, хувийн, бас бүлгийн эрх ашгийг чухалчилж, намууд төрийн албыг зарж, сонгуульд ялалт байгуулахын тулд төрийн нөөц, хөрөнгийг ашиглах сонирхол илт ажиглагдах болсон⁵ байна.

Улс төрийн үзэл баримтлалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, улс төрийн бодлого шийдвэрт тусгах, намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө өөр өөрсдийн бодлогыг тусгах, хэлэлцүүлэх ажил нэн чухал байна. Үүнийг МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төвийн хамтран 2022 онд гүйцэтгэсэн “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгааны дараах зураг дахь дүнгээс харж болно. Тухайлбал, нийт 7 оноогоор үнэлэх хариултаас 2.8 оноогоор сонгуульд оролцож буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр өөр өөрийн онцлог бүхий, ялгаатай байдаггүй, 2.58 оноогоор Монголын улс төрийн намууд үзэл баримтлалын хувьд ялгаатай хөгжиж чадаж байгаа байдал хангалтгүй гэсэн нь хамгийн өндөр оноо авсан үзүүлэлт байлаа. 2.23 оноогоор Монголын улс төрийн намуудын үнэт зүйл тодорхой, ойлгомжтой байдаггүй, 2.21 оноогоор улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр үзэл баримтлалтайгаа нийцдэггүй, 2.09 оноогоор сонгогчид улс төрийн намын үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй танилцан сонголтоо хийж чаддаггүй гэж хариулсан нь намууд үзэл баримтлалаа төдийлөн баримтлахгүй, ач холбогдол өгдөггүйг шууд харуулж байлаа.


Зураг 1. Улс төрийн намын үзэл баримтлал, үнэт зүйлийн өөрчлөлттэй холбоотой асуултад експертүүдийн өгсөн хариулт



(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Зураг 2. Монголын улс төрийн намууд үзэл баримтлалын хувьд ялгаатай байдлаар хөгжиж чадаж байгаа эсэх


⁵ Э.Гэрэлт-Од, “Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь”. МУИС, ХЗҮХ, Улс төр судлаачдын нэгдсэн холбоо. Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ.,2020, 38 дахь тал



(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр ШУТИС-ийн багш, судлаачдын 2021 онд гүйцэтгэсэн “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” судалгаанд намуудын үзэл баримтлалын талаар иргэдээс тодруулсан байна. Энэхүү судалгаанд, иргэдийн хувьд намуудыг үзэл баримтлалаар нь болон баримталж байгаа бодлогын чиглэлээр нь төдийлөн ялгаж ойлгохгүй байна. Учир нь улс төрийн намууд үзэл баримтлалаараа ялгардаг эсэхийг асуухад 45.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Тэгэхээр намуудын үзэл баримтлалын талаарх ойлголт иргэдийн дунд хангалтгүй байгааг илэрхийлж байна. Судалгаанд оролцогчдын 27.7 хувь нь үзэл баримтлалаараа ялгардаг, 24.8 хувь нь ялгардаггүй гэж хариулсныг шалгах асуултаар лавлахад “баруун, зүүн, төвийн” гэсэн үзэл баримтлалыг ялгаж чадахгүй байлаа. Үүнээс үзэхэд төвийн, барууны, зүүний гэх үзэл баримтлалын ялгааг мэдэхгүй, ойлголт байхгүй байгаа нь иргэдэд улс төрийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулсан⁶ нь харагдаж байна.

Зураг 3. Монголын улс төрийн намууд үзэл баримтлалаараа ялгардаг эсэх



Улс төрийн нам улс төрийн үзэл баримтлалынхаа дагуу намын мөрийн хөтөлбөрөө боловсруулж, сонгуулийн кампаниар сурталчилна. Өөрөөр хэлбэл, энэ нь үзэл баримтлалын стратегийн зорилгод хүрэх зорилтууд буюу улс төрийн бодлогоо тодорхойлж буй явдал юм. Улс төрийн намуудын үзэл баримтлал сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хэрхэн тусдаг, улс орны хөгжлийн бодлогыг хэрхэн тодорхойлж байна гэдгийг нарийн судалсан шинжилгээ дүгнэлт төдийлөн алга. Гэхдээ парламентад олонх болж засгийн эрхийг ээлжлэн барьж

⁶ ШУТИС, Нээлттэй нийгэм форум. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал. УБ.,2021. 31 дэх тал

ирсэн зарим намуудын үзэл баримтлал хэдий өөр ч, нийгмийг халамжилсан мөрийн хөтөлбөрийн заалтуудыг зэрэгцээд дэвшүүлж ирсэн жишээг 2004 болон 2008 оны УИХ-ын сонгуулийн үеийн мөрийн хөтөлбөрүүдээс харж болно.

Хүснэгт 1. 2004 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн зарим намын сонгуулийн мөрийн хөтөлбөр⁷ дэх эдийн засгийн шинжтэй амлалтууд

	МАХН (Одоогийн МАН)	Эх орон-Ардчилал эвсэл
Уриа	Таны төлөө тантай хамт	Өнөөдрийн дарамтыг хална, Өрх гэрийг тэтгэнэ
	Шинэ гэр бүлийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. Анх удаа гэрлэж буй шинэ гэр бүлд нэг удаа 500.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно. Хүн амын өсөлтийг төр, засгаас дэмжиж шинээр мэндэлсэн хүүхэд бүрт нэг удаа 100.000 төгрөгийг тэднийг өсгөж бойжуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгоно. Хүн амын өсөлтийг урамшуулж, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийг олон хүүхэдтэйд тооцон өргөтгөж 1 өрхөд жилд 100.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.	18 хүртэл насны бүх хүүхдэд сар бүр 10.000 төгрөгийн “Итгэлийн мөнгө” олгоно. Өрх бүрийг орон сууцтай болгох үүднээс “40.000 орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хүснэгт 2. 2008 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн зарим намын сонгуулийн мөрийн хөтөлбөр⁸ дэх эдийн засгийн шинжтэй амлалтууд

	МАХН (Одоогийн МАН)	Ардчилсан нам
Уриа	Шударга ёс- Хариуцлагатай төр Дэвших хөгжил- Дэвжих амьдрал	Иргэн бүрт – Эрдэнийн хувь Зөв бодлого – Зөв сонголт
	Шинээр гэр бүл бологсод, Шинэ төрсөн хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжүүдийг үргэлжлүүлэх. Шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд нэг удаа 300,000 төгрөг Алдарт эх - II одонтой эхэд 500,000, Алдарт эх - I одонтой эхэд 1 сая төгрөгийн тэтгэмжийг жил бүр олгох. Хөдөөг хөгжүүлэх зорилгоор сум бүрийг 50 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэр бүхий “сумын хөгжлийн сан”-тай болгоно. Ашигт малтмалын томоохон ордуудыг аж ахуйн эргэлтэд оруулж олсон орлогоос “ Эх орны хишиг ” сан байгуулах хууль гаргаж, улс орныхоо хөгжил, иргэн бүрийнхээ амьдралд	Малчин өрхийн орлогын эх үүсвэрийг тогтвортой байлгах үүднээс түүхий ноолуурын доод үнийг 30.000 төгрөгөөс унагахгүй, хонь, тэмээний ноосны үнийг 3000-6000 төгрөгт хүргэх бодлого баримтлана. Зэвсэгт хүчин, хил хамгаалалт, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, дотоодын цэргийн байнгын албан хаагчид тэтгэвэрт гарах, хүндэтгэх шалтгаанаар албанаас чөлөөлөгдөх тохиолдолд 1 удаа 5 сая төгрөгийн, Хэрэв албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алвалд 25 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.


⁷ УИХ-ын 2004 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр
<https://www.gec.gov.mn/m/2004?n=%D0%A3%D0%98%D0%A5>

⁸ УИХ-ын 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр
<https://www.gec.gov.mn/m/2008?n=%D0%A3%D0%98%D0%A5>

	өгөөжтэй хэлбэрээр зарцуулна. Батламж дээр бичсэн үнэлгээ 1.500.000 төгрөг.	Ирэх 5 жилд 140.000 орон сууц барьж ашиглалтад оруулна. Хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгоно. Мөнгөний ханш уналттай уялдуулж хэмжээг нь өсгөнө. Ард түмэн хөрсөн доорх баялгийн үр шим, түүний ашгаас хүртдэг байх ёстой гэдгийг иш үндэс болгон иргэн бүрт олгох “Эрдэнийн хувь” санаачилга дэвшүүлсэн. Үнэлэгдэх хэмжээ нь 1.000.000 төгрөг байна. Жил бүр дотоодын болон гадаадын их дээд сургуулиудад 1000-5000 оюутныг нэн шаардлагатай мэргэжлээр сургах “20 жилийн хөтөлбөр” гаргаж төрөөс санхүүжүүлнэ. Гадаад дотоодын их сургуулийг нэн шаардлагатай мэргэжлээр төрийн бус зардлаар төгсөн иргэнээ 10.000-100.000 хүртэл доллараар 1 удаа урамшуулж тодорхой салбарт гэрээгээр ажиллуулна.
		


2004 болон 2008 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн МАН, АН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн шинжтэй амлалтууд харилцан байгаа нь намууд үзэл баримтлалын хүрээнд бодлогоо дэвшүүлэх бус, тухайн үеийн нийгэм сэтгэл зүйн хандлага, хэрэгцээг харж амлалт өгдөгийг харуулж байгаа. Энэ үр дүн экспертүүдийн судалгааны дараах дүнтэй мөн давхцаж байгааг харж болно.

Зураг 4. Монголын улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр үзэл баримтлалтайгаа нийцдэг эсэх




(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Зураг 5. Сонгуульд оролцож буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр өөр өөрийн онцлог бүхий, ялгаатай байдаг эсэх



(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Зураг 6. Сонгогчид улс төрийн намын үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй танилцан сонголтоо хийдэг эсэх




(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Бодлогын нам нь хатуу гишүүнчлэлтэй бус мэргэжлийн чадварлаг улс төрчдөөс бүрдсэн бодлогын сонголт санал болгох, засгийн эрхийг барих зорилго бүхий улс төрийн хүчин. Бодлогын нам нь боловсон хүчний чадварлаг нөөцтэй, тодорхой тооны цөөн улс төрчдөөс бүрдсэн, бодлого боловсруулах чадамжтай байдаг.

Судалгаанд оролцогчдын 38.5 хувь нь бүх намын бодлого, мөрийн хөтөлбөрийг уншдаг гэсэн бол 22.7 хувь нь огт уншиж байгаагүй гэж хариулсан. Энэ нь иргэдийн дунд намуудын бодлого, мөрийн хөтөлбөрийг сонирхож, уншдаг байдал харилцан адилгүй байгааг харуулж байна. Иргэдийн хувьд нас ахих тусам мөрийн хөтөлбөрийг уншдаг, мөрийн хөтөлбөр, бодлого, үзэл баримтлалыг харж сонголтоо хийх хандлага давамгайлж байна. Харин залуу үе маань улс төрийн намуудын бодлого, мөрийн хөтөлбөртэй хэр зэрэг танилцаж, уншдаг талаар асуухад дараах дүр зураг харагдлаа. Тэд огт уншдаггүй, уг нь уншдаг байсан, бодлого мөрийн хөтөлбөр нь хэрэгждэггүй учраас уншихаа больсон, одоо худал амлалт өгөөд байхаар уншмааргүй болж байна, өөрийнхөө эрх ашигт хамааралтай бодлого, мөрийн хөтөлбөрийг л уншдаг, зөвхөн хоёр том намынхыг уншдаг гэсэн хариултууд өглөө. Мөн телевиз болон аав, ээж бусад хүмүүсийн ярианаас энэ талаарх зарим нэг мэдээллийг авдаг хэмээн ярьж байсан⁹ байна.


Зураг 7. Улс төрийн намуудын бодлого, мөрийн хөтөлбөрийг уншдаг байдал



⁹ ШУТИС, Нээлттэй нийгэм форум. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал. УБ., 2021. 25 дахь тал

Оролцогчдын 65.8 хувь нь ямар нэг байдлаар уншдаг гэж хариулсан бөгөөд “Мөрийн хөтөлбөртөө үлгэрийн юм бичдэг, хоосон амлалт өгдөг, бүгд ялгарахгүй ижил мэт санагддаг, хоёр том намын, мөн нэр хүндтэй, олны танил хүний мөрийн хөтөлбөрийг дийлэнхдээ уншдаг” гэж хариулсан¹⁰ байна.

Зураг 8. Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр иргэдийн амьдралд нөлөөлөх нөлөөлөл




Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр иргэдийн амьдралд нөлөөлдөггүй гэж 39.8 хувь хариулсан бол 39.5 хувь нь аль аль талаараа нөлөөлдөг гэж хариулжээ. Энд мөн сонирхол татсан нэг судалгааны үр дүн нь намын мөрийн хөтөлбөр амьдралд эергээр нөлөөлдөг гэж үзсэн оролцогчоос сөргөөр нөлөөлдөг гэж үзсэн оролцогч хоёр дахин их байна. Эергээр нөлөөлсөн гэж үзэх иргэд оршин суугаа газар нь шинэ бүтээн байгуулалт хийгдэж, орчны тохижилт нь сайжирч, төрийн үйлчилгээний байгууллагууд нэмэгдэж байгаад сэтгэл хангалуун байсан. Жишээлбэл, ХУД-ийн иргэд цалин нэмэгдсэн, утаа багассан, эко дүүрэг, өмнөх жилүүдээс бараа бүтээгдэхүүний үнэ нэг их нэмэгдээгүй, дахин төлөвлөлт хийгдэж байна, манай дүүрэг хөгжиж байгаа нь бидний амьдралд эергээр нөлөөлж байна. Одоо л яг сайхан болох нь гэхээр сонгууль болоод нам, гишүүд нь солигдоод зарим хийж байсан ажил нь царцдаг хэмээн ярьж байв. БГД-ийн оролцогчдын дийлэнх нь эмнэлэг, өндөр настны төв, хүүхэд хөгжлийн төв, номын сан зэрэг шинээр баригдсан, зайлшгүй асаргаа шаардлагатай хүмүүст дэмжлэг үзүүлдэг болсон гэж хариулсан бол орон нутгийн иргэдээс хувийн хэвшилд ажилладаг бидэнд намуудын мөрийн хөтөлбөр нөлөөлөхгүй байна гэж үзжээ. Намын мөрийн хөтөлбөр иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлж байгааг хот, хөдөөгийн оролцогчид ялгаагүй “Хэт их биелэгдэхгүй амлалт өгдөг, халамжийн бодлогыг хавтгайруулдаг, энэ нь иргэдийг бэлэнчлэх сэтгэлгээтэй болгодог, мөрийн хөтөлбөрөө биелүүлдэггүй, тэтгэврийн насыг уртасгасан, намчирхлаас болж ажилгүйдэл, дарамт шахалт ирдэг, иргэдийн дунд талцал бий болгодог” гэж үзэж¹¹ байна.

Бид экспертүүдээс авсан судалгааны хүрээнд иргэд намын үзэл баримтлалыг уншдаг эсэх, үзэл баримтлал нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй хэрхэн холбогдож байгаа зэргийг сонирхон анализ хийсэн ч иргэдэд улс төрийн намын үзэл баримтлалын талаарх ойлголт хэр зэрэг байгаа, үнэхээр энийг мэдэж байна уу гэдэг нь маш эргэлзээтэй байсан юм. Үүнийг баталсан мэт судалгааны хариулт эмэгтэйчүүдээс авсан судалгааны асуултад гарч ирсэн юм. Нийгмийн ардчилал монголын эмэгтэйчүүдийн холбооны Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр хийсэн “Эмэгтэйчүүдийн амьдралын чанар 2021” судалгаанд оролцогч 1110 эмэгтэйчүүдийн 26.4 хувь нь улс төрийн намуудын үзэл баримтлалын ялгааг огт мэддэггүй, 28.1 хувь нь үзэл баримтлалын талаар сайн мэдэхгүй гэж хариулсан бол дөнгөж 4.4 хувь нь энэ талаар сайн ойлголттой гэж хариулсан байна.

¹⁰ Мөн тэнд. 26 дахь тал


¹¹ Мөн тэнд. 27 дахь тал

Зураг 9. Эмэгтэйчүүд улс төрийн үзэл баримтлалын ялгааг мэддэг эсэх




Судалгаанд оролцогчдыг насны үечлэлээр¹² ангилан харвал, GenY болон GenX үеийнхэн хамгийн бага мэдлэгтэй бөгөөд ойролцоогоор 4 хүн тутмын нэг нь улс төрийн намын үзэл баримтлалыг ойлгодог гэж хариулсан бол GenBB үеийн 5 эмэгтэй тутмын 3 нь улс төрийн үзэл баримтлалын ялгааг мэднэ гэж хариулсан байна.

Зураг 10. Эмэгтэйчүүд улс төрийн үзэл баримтлалын ялгааг мэддэг эсэх, насны үечлэлээр



Зураг 11. Монголын улс төрийн намуудын үнэт зүйл тодорхой, ойлгомжтой байдаг эсэх

¹² GenZ - (1997-2010), GenY- (1981-1996), GenX- (1980-1965) GenB – (1946-1964)



(Эх сурвалж: “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт төслийн хүрээнд хийсэн екпертийн судалгаа. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төв. 2022 он)

Улс төрийн намуудын үзэл суртал, үнэт зүйлс, үнэлэмж нь тодорхой бус байх, үйл ажиллагаа нь тогтвортой бус байх, зөвхөн сонгуулийн үед идэвхжих зэрэг нь тухайн намууд сонгуульд амжилт олоход муугаар нөлөөлдөг төдийгүй сонгогчдыг сонголтгүй байдал руу түлхдэг, нөгөөтэйгүүр нийгмийн дунд “улс төрийн нам”-ын нэр хүндийг унагаж байгаа явдалд улс төрийн намууд, ялангуяа жижиг намууд хариуцлагатай хандах ёстой. Олон нийтэд улс төрийн намуудын үзэл суртал, үнэт зүйлс, үнэлэмж нь тодорхой бус, намуудын ялгарал тод бус байгаа нь улс төр судлаач Д.Оюунчимэгийн 2010 онд хийсэн фокус бүлгийн судалгааны үед ажиглагдсан¹³ байна. Уг судалгаанд оролцогчид “Эрэлийн Эрдэнэбатын нам”, “Буянгийн Жагаагийн нам” зэргээр нэрлэн улс төрийн намуудыг ялган таних гэж оролдож байсан нь тэнд оршин байгаа доголдлыг илтгэж байжээ. Эндээс бид улс төрийн намуудын үзэл баримтлалыг онолын хувьд нарийвчлан судлах, үзэл баримтлал тухайн бодлогод хэрхэн нөлөөлөх, цаашлаад намуудын үнэт зүйл, үнэлэмж маш тодорхой байж, мөрийн хөтөлбөртөө ялгаж салгаж тусгах, намын гишүүд болон сонгогчид энэ талаарх ойлголттой, мэдлэгтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

Улс төрийн намууд төрийн бодлогын хувилбаруудыг гаргаж, үүндээ тулгуурлан өрсөлддөг, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэгч, иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төвлөрүүлэгч чөлөөт ардчилсан нийгмийн институт утгаар хөгжиж чадахгүй, харин гагцхүү засгийн эрхийг авах болон сонгуулийн үеэр л идэвхждэг байгууллага болон хувирсан.

Улс төрийн намын үзэл баримтлал, түүний дагуу боловсруулагдсан намын мөрийн хөтөлбөртэй холбоотой онолын болон эмпирик судалгаа манайд ховор байна. Иймээс МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төвийн багш, судлаачдын 2022 онд гүйцэтгэсэн “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” сэдэвт експертийн судалгааг гүйцэтгэсэн юм. Судалгаанд оролцсон експертүүд нийт 7 оноогоор үнэлэх хариултаас 2.8 оноогоор сонгуульд оролцож буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр өөр өөрийн онцлог бүхий, ялгаатай байдаггүй, 2.58 оноогоор Монголын улс төрийн намууд үзэл баримтлалын хувьд ялгаатай хөгжиж чадаж байгаа байдал хангалтгүй гэсэн нь хамгийн өндөр оноо авсан үзүүлэлт байлаа. 2.23 оноогоор Монголын улс төрийн намуудын үнэт зүйл тодорхой, ойлгомжтой байдаггүй, 2.21 оноогоор

¹³ Д.Оюунчимэг. Сонгуулийн кампанийн үе дэх улс төрийн намууд, нэр дэвшигчдийн хариуцлага. Политологи VI эрдэм шинжилгээний бичиг. УБ, 2010. 161 дэх тал

улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр үзэл баримтлалтайгаа нийцдэггүй, 2.09 оноогоор сонгогчид улс төрийн намын үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй танилцан сонголтоо хийж чаддаггүй гэж хариулсан нь намууд үзэл баримтлалаа төдийлөн баримтлахгүй, ач холбогдол өгдөггүйг шууд харуулж байлаа.

Улс төрийн намд иргэд тухайн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч, дэмжсэн хүсэл зоригийн үндсэн дээр бус төрийн албанд орох гэх мэт, хувийн явцуу ашиг сонирхлын үүднээс элсэх, нөгөө талаас гишүүдийн тооны өндөр босгыг хуульчилснаас улс төрийн намууд хэт гишүүнчлэлээр хөөцөлдөх, түүний тулд иргэдийг хуучинсаг аргаар хомрогolon элсүүлэх, гишүүдийн бүртгэлийг бодит бусаар хөтлөх, тэрхүү бүртгэлд нь төрийн болон олон нийтийн зүгээс тавих хяналтын тогтолцоо сул байна гэж дүгнэлээ.

Abstract:

There has not been much theoretical and empirical research on the political party concept and the party program developed according to it. Therefore, in 2022, the professors and researchers of the Department of Political Science and the Center for Democracy Studies of the National University of Mongolia carried out an expert study on the topic "Mongolia's political development since 1990: processes, relations and attitudes". Out of the total 7 points, the experts who participated in the survey said that the platforms of the political parties participating in the elections have their own characteristics and are not different, with 2.8 points. With a score of 2.23, the values of political parties in Mongolia are not clear and understandable, with a score of 2.21, the political party's election platform does not match its ideals, and with a score of 2.09, voters are unable to make a choice after reviewing the election platform developed according to the political party's ideals, which means that the parties do not adhere to their ideals, directly showing that it is not important.

Key words: Ideology, political policy decisions, ideology and programs, expert opinions on party ideology, citizens' understanding

Ашигласан ном, материал

1. Баасансүрэн. Д. Улс төрийн намын хөгжлийн өнөөгийн чиг хандлага. Бүхнийг шүүрэгч өргөн хүрээний намаас картель загварт. Политологи XXI эрдэм шинжилгээний бичиг №15 (476). УБ. 2017.
2. БШУЯ-ын захиалгаар, ШУТСангийн санхүүжилттэй МУИС-д хэрэгжиж буй “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: институци, үйл явц, харилцаа” сэдэвт хавсарга судалгааны тайлан. УБ.,2023
3. Ганболд. Ц, Батболд. Ц. Монгол дахь социал демократ үзэл суртлын өнөөгийн байдал, цаашдын хандлага. Политологи XI эрдэм шинжилгээний бичиг. №11 (402). УБ. 2014
4. Гэрэлт-Од. Э. Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь. МУИС, ХЗҮХ, Улс төр судлаачдын нэгдсэн холбоо. Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ.,2020
5. Оюунчимэг. Д. Сонгуулийн кампанийн үе дэх улс төрийн намууд, нэр дэвшигчдийн хариуцлага. Политологи VI эрдэм шинжилгээний бичиг. №58 (332). УБ.,2010
6. УИХ-ын 2004 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр
<https://www.gec.gov.mn/m/2004?n=%D0%A3%D0%98%D0%A5>
7. УИХ-ын 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр
<https://www.gec.gov.mn/m/2008?n=%D0%A3%D0%98%D0%A5>
8. ШУТИС, Нээлттэй нийгэм форум. Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал. УБ.,2021
9. Ignazi,P. The Crisis of Parties and the Rise of New Political Parties / P. Ignazi// Party Politics.- 1996.-Vol.2

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ТӨЛӨӨЛӨХ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

Д.Ундрах

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Б.Анхзаяа

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Энэхүү судалгааны өгүүллийн хүрээнд улс төрийн намын төлөөлөх үүргийг тодруулан судалж Монголд үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд тэр дундаа УИХ-д суудалтай (МАН, АН, ХҮН) намууд төлөөлөх үүргээ биелүүлэхэд хүчин чармайлт гаргаж байгаа эсэхэд хийсэн ажиглалт, шинжилгээний үр дүнгээс танилцуулах болно.

Түлхүүр үгс: *жендэр, феминизм, амлалт, намын гишүүн, улс төрийн оролцоо, эмэгтэйчүүд*

Удиртгал:

Монгол Улс нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоо руу шилжээд даруй 33 жил өнгөрөөд байгаа ч бодит байдал дээр нэг намын ноёрхол руу аажмаар шилжээд буй гэх шүүмжлэлүүд хөврөх болсон. Энэ бүхэн нь улс төрийн намууд намууд төлөвших хууль эрх зүйн орчин бүрдээгүй, бүгд ижил тэгш гараанаас эхлээгүй гээд олон асуудалтай холбогдоно. Залуучуудын санаа бодлын судалгаагаар улс төрийн нам хамгийн тааламжгүй институцээр тодорсон нь (БНОУХ, 2020) бид өнгөрсөн алдаагаа эргэж харах, намын төлөвшилд анхаарах зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Төлөөллийн ардчиллын замыг сонгосон улсын хувьд иргэдийн төлөөлөх эрхийг хангах үүрэгтэй гол институци болох улс төрийн намын төлөвшил, хөгжилд анхаарлаа хандуулах нь ардчиллаа бэхжүүлэх чухал арга зам юм. Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэдэг олон үүргийн нэг нь нийгмийн бүлгийн бүхий л төлөөллийг хангах үүрэг юм. Манай улс төрийн намууд энэхүү үүргээ хэлбэр төдий ойлгож, агуулгын хүрээнд ухамсарлаж биелүүлэхгүй байгааг нь УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 17¹ хувьтай байгаагаас харж болно. Сүүлийн гурван удаагийн сонгуульд нийт нэр дэвшигчдийн 24.7 хувийг л эмэгтэйчүүд эзэлж байгаа нь дээрх таамаглалыг улам бататгаж байна. Иймд тэгш төлөөллийг хангахад улс төрийн намууд тэргүүлэх үүрэгтэй оролцох гол субъект гэдгийг бүх нийтэд тэр тусмаа улс төрийн намуудад ойлгуулах арга замыг эрэлхийлэх бодит шаардлага бий болж байна. Сэдвийн судлагдсан байдлыг харвал шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог хууль эрх зүйн орчинтой холбон судалсан тохиолдлууд цөөнгүй байгаа бөгөөд харин улс төрийн намын бодлого, үйл ажиллагаатай холбон судалсан тохиолдол бага байна.

Өнгөрсөн хугацаанд улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо төдийлөн нэмэгдээгүй гол шалтгааныг улс төрийн намын төлөөллийг хангах үүрэгтэй

¹ Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага судалгааны тайлан. 2022

холбон тайлбарлахыг зорьсон болно. Ингэхдээ 2023 оны хавар хийгдсэн суурь хуулийн өөрчлөлтүүд (ҮХНӨ, УИХ-ын Сонгуулийн тухай хууль, УТНТХууль)-ийг “амилуулах” гол хүч улс төрийн намуудад төвлөрч буйг нэхэн сануулах, цаашдын нөлөөллийн ажлуудад гол зүг чигээ болгох нь энэхүү судалгааны гол зорилго болно. Энэ хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлээ:

- Улс төрийн системийн онолыг тайлбарлах,
- Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх төлөөллийн үүргийн ойлголтыг тодотгох,
- Монголын улс төрийн намуудын төлөөллийн үүргийн биелэлт, түүний өнөөгийн байдлыг тодорхойлох,
- Улс төрийн намуудын тэгш төлөөллийн төлөөх амлалтад шинжилгээ хийх,
- Дүгнэлт боловсруулах

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд судалгааны шинжилгээний ажлууд багагүй хийгдсэн байна. Тухайлбал, улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудлаарх олон нийтийн санаа бодлын 2010, 2012 оны судалгаа нь энэ чиглэлд олон нийтийн санаа бодлыг тандах зорилгоор хийгдсэн Монгол Улсад анхдагч судалгаа юм. КОЙКА олон улсын байгууллагын санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нь” төслийн хүрээнд “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” 2022 судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгаа нь улс төрийн оролцооны талаарх олон нийтийн төсөөллийг тодорхойлж, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгохыг зорьсон байна.

“Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс 2020 судалгаа” нь олон улсын туршлага, Монгол дахь өнөөгийн нөхцөл байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны нийгэмд үзүүлэх нөлөө зэргийг баримт бичгийн судалгаагаар тодруулж, оролцоог хязгаарлаж буй хүчин зүйлсийг асуулга, ярилцлагын аргаар тодруулж, зөвлөмж боловсруулсан байна. Мөн 2021 онд хийгдсэн “Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл судалгаа” хийгдсэн байна. Энэхүү судалгааны онцлог нь улс төр дэх залуучууд, эмэгтэйчүүдэд нөлөөлж буй улс төрийн институцын, хувь хүний, нийгэм соёлын хүчин зүйлсийг тус бүрд нь судлан дүгнэлт гаргасан явдал юм. Э.Гэрэлт-Од судлаач 2019 онд хэвлүүлсэн “Ардчилсан нийгэмд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг, роль” бүтээлдээ улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүргийг олон улсын нам судлаачдын онолуудыг нэгтгэн, Монголын улс төрийн намуудын өнөөгийн нөхцөл байдал, төлөвшилд үнэлэлт дүгнэлт өгчээ.

“Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2020” судалгаагаар намын дотоод ардчиллыг индекслэх шалгуур үзүүлэлтийг илүү тодруулсан бөгөөд тэр дундаа төлөөлөх үүргийг гол шалгуур үзүүлэлтийн нэг болгосон нь энэхүү судалгаанд хэрэглэгдэх чухал хэрэглэгдэхүүн болсон.

Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх ТӨЛӨӨЛЛИЙН үүрэг

Хүмүүс нэгдэн амьдарч буй ямар ч нийгэм улс төрийн системгүйгээр оршин тогтнох боломжгүйг Д.Истон “системийн онол”-оороо нотолсон байдаг. Уг онол нь улс төрийн системийн оршин тогтнож, хадгалагдан үлдэхэд нөлөөлж, үйлчилж байдаг хүчин зүйлсийг тодорхойлж өгснөөрөө ач холбогдолтой. Түүнчлэн улс төрийн системд аюул учруулж болох сурвалжуудыг судлах нь улс төрийн шинжлэх ухааны нэг гол зорилго гэж тэрээр үзжээ. Нөгөө талаар, улс төрийн системийг тогтворжуулах замаар түүнийг сахин хадгалж болох боломжийн талаар санал дэвшүүлжээ.²

Улс төрийн орчин нь намын үйл ажиллагааны үндсэн хүрээ болдог бөгөөд энэ хүрээн дэх намын төлөвшилтийн үйл явц нь нийгмийн улс төрийн бүхэл үйл явцын салшгүй хэсэг, харин нам, намын тогтолцоо нь улс төрийн нийтлэг системийн нэг үндсэн бүрдэл нь болдог.

² С.Базарпүрэв.2002. Дэвид Истоны улс төрийн системийн онол

Энэхүү харилцан үйлчлэлийн механизмын агуулгыг дараах байдлаар томъёолон тодорхойлж болох байна. Энэ нь нэгд, *бүтэц-бүрдэлжилтийн институционал механизм; хоёрт, үүрэг-үйл ажиллагааны функционал механизм; гуравт, мэдээлэл солилцооны коммуникатив механизм; дөрөвт, эрх зүй-зохицуулалтын регулятив механизм* зэрэг болно.³ Эдгээрээс үүрэг-үйл ажиллагааны функционал механизмын тухайд авч үзье.

Үүрэг – үйл ажиллагааны функционал механизм. Аливаа нийгмийн систем тодорхой чиг үүрэгтэй байдаг. Хэрвээ систем зорилго, чиг үүрэггүй бол уг систем оршин үйлчлэх боломжгүй болж, системлэг шинжээ алдахад хүрдэг. Нам бол улс төрийн системийн бүрдэл элемент мөн. Намын нэг үндсэн онцлог нь улс төрийн системийн хүрээнд тодорхой зорилго, чиг үүрэгтэй байдагт оршдог.

Намууд улс төрийн системтэй чиг үүргийн хоёр үндсэн хэв маягаар холбогддог. Үүнд: улс төрийн систем дэх *төрийн засаглалын харилцаагаар нөхцөлдсөн бүлэг чиг үүрэг*, нөгөөх нь улс төрийн систем дэх *нийгмийн харилцаагаар нөхцөлдсөн бүлэг чиг үүрэг* юм. Тэгвэл хоёр дахь бүлэг чиг үүрэгт нийгмийн төлөөллийг хангах, нийгэмшүүлэх, ашиг сонирхолыг нэгтгэх, улс төрийн соёл, хариуцлагыг хэрэгжүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцахтай холбоотой чиг үүрэг хамаарагддаг. Ингэж намууд улс төрийн системийн бие даасан институцын хувьд өөрт оногдсон жам ёсны чиг үүргээр дамжуулан улс төрийн бүхэл системтэй гүн гүнзгий холбоо харилцаанд оршдог байна⁴.

Улс төрийн намууд ардчилалгүйгээр гарч ирж болох ч, улс төрийн намгүйгээр ардчилал амжилтад хүрч чадахгүй. (ACE Electoral Knowledge Network, 2012)

Английн эрдэмтэн А.Хивүүд улс төрийн намын чиг үүргийг нэлээд нарийн олон талаас нь судалж дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Төлөөллийн үүрэг,
2. Элитийг төлөвшүүлэх дайчлах үүрэг,
3. Зорилгоо томъёолох үүрэг, сонирхлыг нэгтгэх, илэрхийлэх үүрэг,
4. Нийгэмшүүлэх болон засгийн газрыг байгуулах гэж ангилжээ.

Орчин үеийн улс төрийн системд намууд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж судлаач Л.Даймонд, Р. Гюнтер нар “Улс төрийн намууд ба Ардчилал” бүтээлдээ тэмдэглээд улс төрийн намын гүйцэтгэх үүргийг долоо ангилж үзсэн байдаг. Үүнд,

1. Нэр дэвшүүлэх үе буюу элитийг татан оролцуулах, сонгуульд тухайн намыг төлөөлөн өрсөлдөх хүнийг олох, бэлтгэх;
2. Сонгуулийн дайчилгааны үе буюу намууд нэр дэвшигчээ дэмжүүлэхийн тулд сонгогчдынхоо сэдлийг идэвхжүүлж, зарим тохиолдолд тэднийг сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцох бололцоогоор хангах;
3. Асуудлыг бүтэцжүүлэх чиг үүрэг буюу нийгмийн бүлгүүд тодорхой асуудлаар богино эсвэл урт хугацааны турш илэрхийлж буй эсэхээс янз бүрийн асуудлаар сонголт, альтернативыг бүтэцжүүлэхэд намууд үүрэг гүйцэтгэдэг.
4. Нийгмийн төлөөллийн чиг үүрэг нь нийгмийн янз бүрийн бүлгийг төлөөлөх чиг үүрэгтэй байдаг. Энэ үүрэг нь сонгуулийн үед бүлгүүдийн дэмжлэг авахын төлөө өрсөлдөөний явцад илэрнэ. Мөн сонгуулийн дараа хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх үеэр хууль тогтоох явцад илэрдэг.
5. Ашиг сонирхлыг нэгтгэн нягтруулах нь намуудын бас нэг үүрэг. Бүлгүүдийн сонирхлыг түгээмэл биш юмаа гэхэд илүү өргөн хүрээнд нэгтгэн нягтруулахад чиглэх ёстой. Энэ нь олон нам бүхий парламентын системтэй орнуудад ашиг сонирхлыг нэгтгэх, нягтруулах үйл явц сонгуулийн дараа засаг барих, эсвэл байгуулагдах үед явагддаг.
6. Засгийн газрыг ажиллуулах үүрэг нь ажлаа хийж чадаж байгаа эсэхийн чухал хэмжүүр болно.
7. Нийгмийн интеграцчлалыг хангах үүрэг нь намууд улс төрийн үйл явцад үр дүнтэй оролцох боломжийг иргэдэд олгодог ба ийнхүү оролцсон иргэд

³ Д.Болд-Эрдэнэ. 2010. Улс төрийн систем, намын харилцан хамаарах: онол- арга зүй

⁴ Д.Болд-Эрдэнэ. 2010. Улс төрийн систем, намын харилцан хамаарах: онол- арга зүй

тодорхой амжилтад хүрэхдээ системийг цааш нь үргэлжлүүлэн авч явах сонирхолтой болдог⁵.

А.Хивүүдийн тодорхойлолтоор улс төрийн намууд нийгэмд эн тэргүүнд **төлөөллийн** үүргийг гүйцэтгэдгийг дурдсан бол, Л.Даймонд, Р. Гюнтер нарын бүтээлд ч мөн дээрх төлөөллийн үүргийн зарчим давтагдаж байна. Гэвч бодит байдал дээрээ намууд нийгмийн бүлгийн төлөөллийн үүргээ хангалттай биелүүлж ирээгүйг эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх олон хөдөлгөөнүүд харуулж байна.

ХИХ зууны үеэс эрчимжиж эхэлсэн феминист хөдөлгөөн нь эмэгтэйчүүдийг эрчүүдтэй адил тэгш эрхтэй байх улс төр ба эрх зүйн нөхцөл бололцоо олгохыг шаарддаг. Энэ цаг мөчөөс эхлэн феминизмийн гурван давлагаа өрнөсөн гэж үздэг.⁶ Нэгдүгээр давлагаа нь эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргээр нь ялгаварлан гадуурхах үзэлтэй илүү тэмцэж байсан бол хоёр, гуравдугаар давлагаанаас эхлэн эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийн төлөө тэмцэж эхэлсэн. Учир нь дэлхийн хүн амын тал хувийг бүрдүүлдэг нийгмийн хамгийн том бүлэг болохынхоо хувьд нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд ижил тэнцүү оролцох нь эмэгтэйчүүдийн үндсэн эрх гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх, ойлгуулах нь уг хөдөлгөөний гол зорилго юм.

Монгол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдал

Монгол Улс 1924 он буюу яг 100 жилийн тэртээ Анхдугаар Үндсэн хуулиараа эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан бүс нутагтаа анхдагч улс юм. Дэлхий дахинаа өрнөсөн феминист хөдөлгөөний үзэл санаа тусгалаа олсон нь энэ. Ийнхүү эмэгтэйчүүд нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд эрх тэгш оролцож, үр шимийг нь ижил тэнцүү хүртэх боломж бүрдсэн ч бодит байдал дээр хангалтгүй хэвээр байна. Монголын нийт хүн амын 51 хувь⁷, нийт сонгогчдын 52 хувийг⁸ бүрдүүлдэг эмэгтэйчүүдийн төлөөлөл УИХ-д буюу улс төрийн шийдвэр гаргах дээд түвшинд 17.3 хувьтай байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг Жендэрийн ялгаатай байдлын индексээр Монгол Улс 146 орноос 70 дугаарт жагссан байна. Энэхүү индексийг дөрвөн шалгуур үзүүлэлтэд үндэслэн гаргадаг бол Улс төрийн оролцоон дахь жендэрийн тэгш байдлаараа манай улс 146 орноос 113 дугаар байрт эрэмбэлэгдсэн нь хамгийн тааруу дүн юм⁹. 2021 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улс парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувиар нийт 193 орноос 127 дугаарт жагсаж байна.

1990 оны Цагаан морин жилийн хувьсгалаараа Монгол Улс нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоонд тайван замаар шилжсэн. Ийнхүү Монголын ардчиллын тэр тусмаа төлөөллийн ардчиллын хөгжилд улс төрийн нам хамгийн чухал үүрэгтэй субъект болж хувирсан. Энэ үүднээсээ улс төрийн намууд Монголын ардчиллыг бэхжүүлэхэд тодорхой үүргүүдийг хүлээгээд зогсохгүй ардчилалд учирч буй дээрх сорилт бэрхшээлүүдийн өмнө хариуцлага хүлээх учиртай субъект юм.

Улс төрийн нам бол сонгуулийн болон сонгуулийн бус үеэр залуус, эмэгтэйчүүдээс дэмжлэг авах, улмаар улс төрд татан оролцуулж, бүх шатны улс төрийн шийдвэр гаргах байгууллагад сонгогдоход дэмжлэг үзүүлэх үр дүнтэй бүтэц. Өөрөөр хэлбэл, нам үйл ажиллагаа, бодлого, үнэт зүйлээрээ дамжуулж залуус, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөлж чадах цорын ганц улс төрийн байгууллага.¹⁰ Гэвч намууд төлөөллийн үүргээ ухамсарлан эмэгтэйчүүдийн төлөөллийг улс төрийн шийдвэр

⁵ Э.Гэрэлт-Од.2019.“Ардчилсан нийгэмд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг, роль”

⁶ Charlotte Krollokke. Gender communication theories and analyses from: Silence to performance. Sage publication. 2006pp

⁷ Монгол Улсын хүн амын тоо, нэг нас, хүйс, насны бүлгээр. <https://www.1212.mn/>

⁸ 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтад 2 сая 624 иргэн бүртгэгдсэнээс 961 мянга 971 буюу 48 хувь нь эрэгтэй, 1 сая 38 мянга 653 буюу 52 хувь нь эмэгтэй байна. СЕХ-ний мэдээлэл.

⁹ ДЭЗФ- Жендэрийн ялгаатай байдлын индекс.2022. https://www3.weforum.org/docs/WEF_GGGR_2022.pdf

¹⁰ Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс.2020


гаргах үйл явцад оролцуулах улс төрийн хүсэл зориг байхгүй байгаа нь ажиглагдаж байна. Ийнхүү дүгнэхийн учир нь төлөөллийн ардчилалд улс төрийн намууд нь төр болон иргэдийг хооронд нь холбох үүргийг гүйцэтгэдэг тухай дээр дурдсан. Гэтэл намуудын эрэгтэй төлөөллөөс бүрдсэн УИХ өнгөрсөн хугацаанд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлдэг олон улсын жишиг бүхий механизм болох нэр дэвших квотыг хэдэнтээ унагаж байсан түүхтэй. Тэр ч бүү хэл батлалцсан квотоо доод хязгаар бус дээд тааз гэж “андуурч”, эмэгтэйчүүдийг квотод нь хүргэх төдий нэр дэвшүүлсээр ирсэн. Тухайлбал, сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд давхардсан тоогоор нийтдээ 1,814 хүн нэр дэвшсэнээс 430 нь буюу **24.7%**¹¹ нь эмэгтэйчүүд байна. Үүнээс харахад сонгогчид эмэгтэйчүүдийг сонгодоггүй биш улс төрийн намууд эмэгтэйчүүдийг олноор нэр дэвшүүлдэггүй байна.

Зураг 1. Квотын төлөөх тэмцлийн цагалбар,
Зургийн эх сурвалж: Эмэгтэйчүүдийн манлайлын сүлжээ




Үнэн хэрэгтээ улс төрийн намууд эмэгтэйчүүдийн “нуруу”-н дээр өндийдөг

График 1. МАН-ын гишүүнчлэлийн мэдээлэл



¹¹ Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага судалгааны тайлан.2022


График 2. АН-ын гишүүнчлэлийн мэдээлэл



Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд төрийн эрхийг ээлжилж барьсан Монголын хоёр том улс төрийн намын гишүүдийн талаас илүү хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг нь дээрх хоёр графикаас харагдаж байна.

Улс төрийн намууд нийгмийн бүлгийн бүхий л төлөөллийг хангах нь намын дотоод ардчиллын бодит тусгал болдог билээ. Намын дотоод ардчилал буюу “internal democracy within political party”, нам доторх ардчилал буюу “intra-party democracy” хэмээх ойлголт нь намын шийдвэр гаргах бүхий л түвшинд гишүүд, дэмжигчдийг оролцуулах тухай өргөн хүрээний ойлголт юм. Намын дотоод ардчиллыг оролцоо (25%), өрсөлдөөн (24%), төлөөлөл (16%), ил тод байдал (35%) байдал гэх дөрвөн үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлж, индексжүүлж судалгаа хийжээ¹². Төлөөлөл гэх шалгуур үзүүлэлт нь сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах болон намын дотоод бүтцийн байгууллагуудад нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хэрхэн хамруулж буйг харгалзана. Намын гол шийдвэрүүдийг гаргах албан тушаал болон хууль тогтоох дээд байгууллагад нэр дэвшигчдэд эзлэх залуучууд, эмэгтэйчүүдийн хувь хэмжээнд үнэлгээ өгсөн байна. Тухайлбал сонгуульд нэр дэвшигчдэд эзлэх эмэгтэйчүүдийн хувь сонгуулийн хуулийн шаардлагад нийцүүлэх бус сайн дурын хувь хэмжээг тогтоодог эсэхийг шинжилсэн байна. Хэмжигдэхүүн нь нийт 16 хүртэлх оноотой.

Зураг 2. Улс төрийн намын төлөөлөл, 2019-2020



МАН болон АН нь залуучуудын, эмэгтэйчүүдийн, оюутны болон ахмадын холбоо зэрэг дотоод төлөөллийн байгууллагуудтай учир өндөр оноо авсан байна. Гэсэн хэдий ч

¹² Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс.2020

эдгээр байгууллагуудын намын гол чиг үүрэгт эзлэх байр суурь, нөлөөлөл хязгаарлагдмал. Намд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо анхан болон дунд шатандаа харьцангуй их байдаг бөгөөд дээд түвшин дэх оролцоо хангалтгүй байна¹³.

Энэ бүхнээс харахад намууд нийгэм, улс төрд олон үүрэг гүйцэтгэж байдгын нэг нь төлөөллийн үүрэг юм. Монголын улс төрийн намууд энэ үүргийг хэрхэн ухамсарлаж, ямар түвшинд хүчин чармайлт гаргаж ирсэн нь намуудын дотоод ардчиллын индексээс харагдаж байна. Түүнчлэн 2020 онд гүйцэтгэсэн залуучуудын санал бодлын судалгаагаар улс төрийн нам хамгийн тааламжгүй институцээр тодорсон нь (БНОУХ, 2020) намууд нийгэмд гүйцэтгэх үүргийг хэлбэр төдий ойлгож ирсний хор уршиг байх талтай. Улс төрийн нам хамгийн тааламжгүй институц болтлоо нэр хүнд нь унасан энэ цаг үед ардчилсан үндсэн хуульт ёстой төлөөллийн ардчиллын замыг сонгосон бидний хувьд намаас татгалзах, үгүйсгэх гэхээсээ илүүтэй төлөвшүүлэх, бэхжүүлэхэд анхаарлаа хандуулах нь чухал.

Намын дотоод ардчилал, төлөвшил нь улс орны засаглалын хувь заяанд шууд нөлөөлдөг гэдгийг олон нийт ч ойлгож, намууд ч зарим эрх ашиг дээрээ нэгдэж, өөрсдийн хувь заяагаа зөв зүгт залахад зарим нэг хүчин чармайлт гаргаж байна. Үүний нэгэн жишээ бол 2023 оны хавар Монголын улс төрийн намууд тодорхой хэмжээнд зөвшилцөлд хүрч, ҮХНӨ, Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль зэрэг суурь хуулиудад томоохон өөрчлөлтүүдийг хийж чадсан. Цаг хугацааны хувьд энэ үйл явдлаас өмнө улс төрийн намууд нэгдэж “Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөллийг хангах амлалт”-д гарын үсэг зурсан нь мөн түүхэн үйл явдал болсон.

Зураг 3. “Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөллийг хангах амлалт”-д гарын үсэг зурах ёслолын үеэр



Найман зүйл заалт бүхий энэхүү баримт бичиг нь төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх тэр тусмаа засаглалд нийгмийн бүлгийн бүх төлөөллийг хангахад улс төрийн нам чухал үүрэгтэй институц болохыг нэхэн сануулах, олон нийтийн өмнө амлалтад гарын үсэг зурснаар намууд цаашдын үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлд илүү идэвх санаачилгатай ажиллах хөшүүрэг болно гэж үзэж буй аж.

Зураг 4. УИХ-д суудалтай гурван намын амлалтын баримт бичгийн хуулбар



¹³ Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс.2020. 20 дах тал

Үүний дараагаар УИХ-ын 2023 оны хаврын чуулганаар суурь хуулийн өөрчлөлтүүд хийгдэж, үндсэндээ улс төрийн намууд төлөвших, төлөөллийг хангахад чиглэсэн хууль эрх зүйн асуудлууд шийдэгдсэн гэж хэлж болно.

ҮХНӨ-21.1. 1.Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ-30.2. Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ- 7.6. Намын төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна. (шинэчилсэн найруулгын төсөл)

Ийнхүү улс төрийн намууд амлалтад гарын үсэг зураад, хуулийн өөрчлөлтүүд хийгдээд долоон сар гаруйн хугацаа өнгөрч, сонгуулийн жил гарахад сар гаруй хугацаа үлдээд байна. Өнгөрсөн намар зарим намууд ирэх жилийн сонгуульдаа бэлдэж, шинэ бүтэц бүрэлдэхүүнээ зарласан. Тэдний шинэ бүтэц бүрэлдэхүүн нь дээрх хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн чухал үйл ажиллагаа болоод зогсохгүй олон улс, нийт сонгогчдынхоо өмнө өгсөн АМЛАЛТ-аа биелүүлэх хүсэл зоригийн бодит илэрхийлэл юм. УИХ-д суудалтай гурван (МАН, АН, ХҮН) намын жишээн дээр дээрх амлалтын баримт бичгийн биелэлтэд хөндлөнгийн шинжилгээ хийлээ.

1. 2023.08.29-нд АН-ын ҮБХ хуралдаж сонгуульд манлайлж орох удирдлагын багаа томилов.

Зураг 5. АН-ын дэд дарга нар. Зургийн эх сурвалж: news.mn



Хүснэгт 1. АН-ын дотоод бүтцэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Намын байгууллагууд	Үүнээс эмэгтэйчүүдийн эзлэх хувь
ҮБХ- 414 гишүүнтэй	25,12
Дэд дарга- 16 дэд даргатай	18,75

АН-ын ҮБХ нь одоогоор 414 гишүүнтэй байгаа бөгөөд 104 нь буюу 25 хувь нь л эмэгтэйчүүд байна. Мөн шинээр томилогдсон 16 дэд даргын 3 нь буюу 18 хувь нь эмэгтэйчүүд томилогдсон байгаагаас харвал “намын шийдвэр гаргах бүх түвшинд аль нэг

хүйсийн төлөөллийг 40-өөс доошгүй хувьд хүргэх, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хангах” амлалтаа АН биелүүлсэнгүй.

АН нь улсын хэмжээнд 180,00 орчим гишүүнчлэлтэй бөгөөд үүний 54 орчим хувь нь эмэгтэйчүүд гэх албан бус тоо байна.

1. 2023.09.15-ны өдөр ХҮН намын төлөөлөх зөвлөлийн хуралдаан болж Удирдах зөвлөлийн гишүүдээ нэмж сонгон, Төлөөлөх зөвлөлийн бүрэлдэхүүнээ өргөтгөн тэлж, орон тооны бус нарийн бичгийн дарга нараа томилсон.

Зураг 6. ХҮН намын удирдлагын багийн бүтэц



Хүснэгт 2. ХҮН намын дотоод бүтцэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Намын байгууллагууд	Үүнээс эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Удирдах зөвлөл	44.4
Гүйцэтгэх зөвлөл	37.5

ХҮН нам нь нийт 24,981 гишүүнтэй бол 10,667 нь буюу 42.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Удирдах зөвлөл дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь 44, Гүйцэтгэх зөвлөл дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь 37 хувь байгаа нь амлалтдаа хүрэх хүчин чармайлт гэж харагдаж байна. ХҮН намын хувьд ХҮН 50:50 бодлогоо зарласан бөгөөд нэр дэвшүүлэх хүйсийн харьцааг 50:50 байлгахаар зорьж буй.

2. МАН-Одоогоор, их, бага хурлаа хуралдуулж, шинэ бүтэц зохион байгуулалтаа зарлаагүй байна. МАН нь улсын хэмжээнд нийт 286,648 гишүүнтэй бөгөөд 156,582 нь буюу 54,62 хувь нь эмэгтэйчүүд байна.¹⁴

¹⁴ ЖҮХ-д ирүүлсэн Хүйсийн тэнцвэрт байдлын тайлан.2022

Хүснэгт 3. МАН-ын дотоод бүтцэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Намын байгууллагууд	Хувь
XXX Хурал	23.7
Хяналтын Ерөнхий хороо	19.0
Бага хурал	21.1
Удирдах Зөвлөл	27
Удирдах Зөвлөлийн Ажлын албаны удирдлага	32
Удирдах зөвлөлийн ажлын алба	50.9
Нийт	25.4

Эмэгтэйчүүд намын гүйцэтгэх түвшинд харьцангуй оролцоо өндөр байдаг ч шат ахих тусам оролцоо нь багасч байгаа нь ажиглагдаж байна. Намын гишүүдийн дийлэнх болсон (**54,62%**) эмэгтэйчүүдийн төлөөллийг удирдах түвшиндээ хангаж чадаагүй байхад нийт сонгогчдоо төлөөлж чадах эсэх нь мөн л эргэлзээ төрүүлж байна.

Дүгнэлт

УИХ-д суудалтай гурван нам дээрх амлалтад хэрхэн ач холбогдол өгч, хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлаа дотоодоо хэрхэн хангаж байгааг судлах зорилгоор энэ удаагын судалгааны хүрээнд АМЛАЛТ-ын бичиг баримт, түүнтэй уялдуулан авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудад ажиглалт, шинжилгээ хийлээ. Үүнээс дүгнэж үзэхэд:

- Улс төрийн нам нь төлөөллийн ардчилалтай улсын хувьд төрийн байгууллын чухал институцын нэг. Энэ утгаараа улс төрийн намуудын олон нийтэд хандаж хэлсэн мэдэгдэл, амлалтууд хариуцлагатай, үр дүнд хүрдэг байх учиртай. Гэтэл улс төрийн намууд зөвхөн дээрх амлалтын хүрээнд л гэхэд хэлбэр төдий ойлгож байгаа нь амлалтын биелэлтээс харагдаж байна. Үнэн хэрэгтээ нам нь амласан бол биелүүлдэг, үлгэр дуурайлал үзүүлдэг, нийгмийн сэтгэл зүйг чиглүүлдэг хамгийн гол субъект юм. Гэвч энэхүү үүргээ биелүүлж ирээгүй, цаашид ч биелүүлэх хүсэл зориг төдийлөн ажиглагдахгүй байна.
- Өнгөрсөн хугацаанд Монголд үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд үг үйлдэл, төлөөллийн үүргээ биелүүлээгүй алдаа дутагдалдаа төдийлөн хариуцлага хүлээж байгаагүй. Улс төрийн намыг улс төрийн гол институц гэж харахаас илүүтэй эрх мэдэл, ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх хэрэгсэл төдий ойлгож ирсэн нийтлэг ойлголт, дүр зураг хэвшсэн байгаа нь нууц биш. Гэвч өнгөрсөн хаврын чуулганаар шинэчлэн баталсан хуулиуд нь улс төрийн намыг бодлогын институц болон төлөвшихөд чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн хүлээж байна. Харин улс төрийн намууд нь энэхүү боломжийг ажил хэрэгч байдлаар харж, тусган хэрэгжүүлэх нь хамгийн таагүй институц болтлоо унасан нэр хүндээ аврах цаашилбал улс орны ирээдүйд чухал нөлөөтэйг ухамсарлах нь чухал байна.
- Улс төрийн намын тухай шинэ хуулиар улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэх заалт орсон. Үүнийг дагаад намуудын хариуцлага нэмэгдэнэ. Учир нь татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжих тул намын төлөвшилд иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах шаардлага бий болгож байгаа нь харагдаж байна. Энэхүү иргэдийн хяналт, оролцоог бодит ажил хэрэг болгож эс чадваас өдгөө хэвшиж тогтсон намын хуучин соёл хэвээр үргэлжлэх дүр зураг ажиглагдаж байна.

Abstract:

Within the framework of this research article, the representative role of political parties will be investigated and the results of observations and analysis will be presented on whether the

political parties operating in Mongolia, including the parties sitting in the parliament (МАН, АН, ХҮН), are making efforts to fulfill their representative role.

Key words: gender, feminism, commitment, party membership, political participation, women

Ашигласан ном, материал

1. Д.Болд-Эрдэнэ. 2010. Улс төрийн систем, намын харилцан хамаарах: онол- арга зүй
2. С.Базарпүрэв.2002. Дэвид Истоны улс төрийн *системийн онол*
3. Э.Гэрэлт-Од.2019.“Ардчилсан нийгэмд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг, роль”
4. Charlotte Krolokke. Gender communication theories and analyses from: Silence to performance. Sage publication. 2006
5. Монгол Улсын хүн амын тоо, нэг нас, хүйс, насны бүлгээр. <https://www.1212.mn/>
6. 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтад 2 сая 624 иргэн бүртгэгдсэнээс 961 мянга 971 буюу 48 хувь нь эрэгтэй, 1 сая 38 мянга 653 буюу 52 хувь нь эмэгтэй байна. СЕХ-ний мэдээлэл.
7. ДЭЗФ- Жендэрийн ялгаатай байдлын индекс.2022.
https://www3.weforum.org/docs/WEF_GGGR_2022.pdf
8. Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс.2020
9. ЖҮХ-д ирүүлсэн Хүйсийн тэнцвэрт байдлын тайлан.2022
10. Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага судалгааны тайлан. 2022
11. The electoral knowledge network – Civic and voter education guiding,
<https://aceproject.org/ace-en/topics/ve/ved/ved02/ved02f>
12. Улс төрийн намууд ба жендэрийн тэгш байдал- Дотроос гадагш хувьсган өөрчлөхөд зориулсан гарын авлага.2021
13. Улс төрийн намуудад зориулсан жендэрийн бодлого боловсруулах аргачлал.2016
14. Шийдвэр гаргах түвшинд дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл.2022
15. Монгол Улсын улс төрийн намын тухай хуулийн төсөлд шинжээчдийн хамтарсан дүгнэлт, зөвлөмж.2023
16. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.2023.
<https://legalinfo.mn/mn/detail/508>
17. УИХ-ын Сонгуулийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/14869>

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 93-100 дахь тал

**НАМ, НАМЫН СИСТЕМИЙН ТӨЛӨВШИЛД СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ
ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨЛӨӨЛӨХ НЬ**

Ж.Төртогтох

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор

Ардчилал судлалын төвийн захирал

Б.Болор-Эрдэнэ

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

“Нам, намын системийн төлөвшилд сонгуулийн тогтолцооны эрх зүйн орчин нөлөөлөх нь” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд сонгуулийн тогтолцоо гэж чухам юу болох, сонгуулийн тогтолцооны хууль эрх зүйн орчны нөхцөл байдал, сонгуулийн тогтолцоог хэрхэн яаж ангилдаг талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалснаас гадна нам нь улс төрийн хамгийн чухал институцийн хувьд сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүдээс үүдэн хэрхэн хөгжин, төлөвшиж ирснийг онцолсон.

Монгол Улсад болж өнгөрсөн УИХ-ын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 оны нийт 8 удаагийн сонгууль нь зохион байгуулагдсан цаг үеийн өвөрмөц онцлог, эдийн засгийн байдал, улс төрийн намын болон төрийн бодлого шийдвэр, нийгэм цаг үеийн уур амьсгал, сонгуулийн тогтолцооны хууль эрх зүйн өөрчлөлт зэргээс хамаарч өөр өөрийн өвөрмөц онцлогтой, үр дүнтэй байсан. Монгол Улсад сонгуулиудыг олон мандаттай томсгосон тойргоор болон нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явуулж ирсэн нь улс төрийн хоёр хүчин ээлжлэн төрийн эрхийг барих боломжийг бүрдүүлсэн бөгөөд түүн дотроо мажоритар тогтолцоогоор сонгууль зохион байгуулахдаа томсгосон тойргийг сонгон явуулж байгаа нь нэг том намыг дэмжих нөхцөл боломжийг бий болгодог учраас нэг намын олонхи эсхүл хоёр том нам ээлжлэн төрийн эрх барьж байгаа нь сонгуулийн тогтолцоотой холбоотойг онцолсон.

Түлхүүр үгс: Сонгуулийн тогтолцоо, нам, намын системийн төлөвшил, ардчилал, сонгууль, хууль, эрх зүйн орчин

Удиртгал:

Монгол Улсын ардчилал нь 30 гаруй жилийн хугацаанд найман удаагийн ардчилсан сонгуулиар баталгаажсан бөгөөд дээрх сонгуулиуд нь алдаа, дутагдалтай байсан ч улс төрийн олон намын өрсөлдөөнийг хангасан, засгийн эрхийг тайван замаар шилжүүлсэн, чөлөөт, шударга сонгууль болсон гэж ихэнх ажиглагчид үздэг. Монгол Улс нь залуу ардчилалтай боловч өнөөг хүртэл тэсвэр хатуужилтай, хүчирхэг ардчиллыг бэхжүүлсээр ирснийг харуулсаар байна. Монгол Улсын ардчиллын түүх ерөнхий зургаараа эерэг ч улс төр, сонгуулийн хувьд нилээд сорилттой тулгарч иржээ. Гурван шатны сонгууль Улсын Их Хурал, Орон нутгийн сонгууль, Ерөнхийлөгчийн сонгуулиудад сонгогчдын ирц буурч, Засгийн газар болон сонгогдсон албан тушаалтнуудад итгэх иргэдийн итгэл буурч байгааг олон нийтийн санал асуулгын дүнгүүдээс харж болно. Эдгээр асуудал нь дэлхийн олон ардчилсан оронд тулгардаг боловч Монголын сонгуулийн тогтолцооны эрх зүйн орчины онцлогоос үүдэлтэй сорилтууд давамгайлж байна. Монгол Улсын сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдлаас үүдэлтэй урьдчилан таамаглах боломжгүй, тодорхойгүй байдал, улс төрийн намуудын эрх ашгаа тэргүүнд тавьдаг хандлага, улс төрийн байр сууриа бэхжүүлэх

сонирхлын үүднээс сонгуулийн тогтолцоог (жишээ нь багц саналын тогтолцоо) сонгодог, улмаар бага саналын зөрүүтэй ч төрийн эрхийг үргэлжлүүлэн барих улс төрийн зорилго зэрэг үүнд нөлөөлдөг. Сонгуулийн тогтолцооны холбогдох хууль, дүрэм журам байнга өөрчлөгдөж байгаа нь сонгуулийн хамгийн том сорилт юм. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монгол Улс УИХ-ын сонгуулийн тухай хуулиа таван удаа өөрчилж, гурван удаа нэмэлт, өөрчлөлт оруулан, дөрвөн өөр сонгуулийн тогтолцоог ашиглажээ. УИХ-ын сонгуульд ашиглагдаж байгаа тогтолцоог Орон нутгийн сонгуульд мөн шууд ашигладаг. Сонгуулийн тогтолцоог энэ мэтээр байнга өөрчлөх нь сонгогчдын боловсрол, улс төрийн намын институтчилал, стратегид сөргөөр нөлөөлж, тогтолцоонд урьдчилан таамаглах боломжгүй, тодорхойгүй байдлыг бий болгож байна. УИХ-ын сонгууль бүрийн өмнө, заримдаа хэдхэн сарын өмнө сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийг хийж байгаа нь сонгуулийн үр дүнд шууд нөлөөлөхийн хажуугаар улс төрийн намын системийн төлөвшилд сөрөг үр дагаварыг үүсгэж байна. Олонх болсон нам, эвсэл сонгуулийн тогтолцооны талаарх нийтийн ашиг сонирхол, үнэт зүйлсийг чухалчлалгүй өөрсдийн дахин сонгогдох кампанит ажилд зориулан уг өөрчлөлтийг хийж ирсэн нь богино хугацааны, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр юм. Ерөнхийдөө энэ тогтворгүй байдал нь засаг захиргааны байгууллагуудын “легитим” чанар буурахад нөлөөлж буй том хүчин зүйл юм. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тодорхой хэмжээнд хязгаарлаж, зургаан жилийн хугацаатай нэг удаа сонгогдох болгосноор УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн хоорондох хугацаанд ихээхэн өөрчлөлт оруулсан бол Монгол Улсын Үндсэн хуулийн 2023 оны 5 сарын 31-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн тогтолцоог анх удаа Үндсэн хуулиар хуульчилсан юм. Ингэснээр сонгуулийн тухай хуулинд нам, эвсэлүүд дур мэдэн гар хүрэх боломжгүй нөхцөл байдал үүсч байгаа бөгөөд гагцхүү Үндсэн хуулийн өөрчлөлтөөр л Сонгуулийн тухай хуулийг өөрчлөх боломжтой болж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуульд дараах байдлаар сонгуулийн тогтолцооны үндсэн хуулийн эрх зүйн үндсийг тодорхойлсон¹:

4.2. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно².

4.3. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно³.

4.3.1. Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар⁴;

Тухайн төр барьж буй улс төрийн нэг хүчин ямар бодлого барьж ажиллаж байна, ардчиллын үнэт зүйлсийг алдагдуулж байна уу, ард түмний эрх, эрх чөлөө, язгуур ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байгаа зэргээс ихээхэн хамаардаг бөгөөд нэг нам үнэмлэхүй олонхи болж олон жил оршин тогтновол ардчиллын үнэ цэнэ, үнэт зүйлс алдагдах магадлалтай. Иймээс цаашид Монгол Улс төрийн институцийг төлөвшүүлэх, ил тод байдлыг хангах, сонгогчдын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, сонгуулийн санхүүжилтийг бууруулахад нөлөөлөх сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгоход анхаарах хэрэгтэй.

Сонгуулийн тогтолцооны ангилал

Сонгуулийн тогтолцоо гэж сонгогч хэдэн саналтай байх, саналаа хэнд өгөх, саналыг ямар аргаар парламентын суудалд хуваарилах зэргийг багтаасан арга, дүрмийг хэлдэг. Сонгуулийн тогтолцоо нь дараах гурван гол үүргийг гүйцэтгэдэг. Нэгдүгээрт, сонгогчдын өгсөн саналд үндэслэн нам, нэр дэвшигчдийн суудлын тоог тогтоох, хоёрдугаарт, иргэд сонгосон төлөөлөгчидтэйгөө хариуцлага тооцох хэрэгсэл, гуравдугаарт, эрх мэдлийн төлөө

¹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail/14869>

² Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail/14869>

³ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail/14869>

⁴ Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail/14869>

өрсөлдөгчид сонгогчидтойгоо харьцах арга замыг сонгох хөшүүрэг болдог байна. Судлаач Б.Рейллигийн тодорхойлсноор сонгуулийн тогтолцоо нь “Сонгуульд өгсөн аливаа саналыг парламент, эсвэл бусад албанд хэрхэн суудал болгохыг заасан журам, үйл ажиллагаа”⁵ юм. Судлаач Бенжамин Рейлли сонгуулийн тогтолцоог тодорхойлоход дараах нийтлэг зарчмуудыг удирдлага болгодог⁶ хэмээн үзсэн. Үүнд:

- Шударга төлөөллийг хангах
- Сонгуулийн үйл ажиллагаа иргэдэд хялбар, үр дүн нь утга учиртай байх
- Эв нэгдлийг хангах хөшүүрэг болгох
- Тогтвортой, шуурхай ажиллагаатай засгийн газар бүрдүүлэх
- Засгийн газартай хариуцлага тооцох боломжтой
- Сонгогдсон төлөөлөгчтэй хариуцлага тооцох боломжтой
- Улс төрийн намуудыг бэхжүүлэх
- Хууль тогтоох байгууллагад сөрөг хүчин байх, түүний хяналтыг дэмжих
- Сонгуулийн үйл явцыг тогтвортой байлгах
- Олон улсын стандартыг харгалзан үзэх

Гэвч сонгуулийн тогтолцоо нь дээрх асуудлыг бүрэн шийдэх боломжгүй. Өөрөөр хэлбэл сонгуулийн тогтолцоо бүр өөрийн давуу ба сул талуудтай. Иймээс ямар тогтолцоог сонгох нь судалгаанд тулгуурласан улс төрийн шийдэл байх ёстой.

Улс төрийн шинжлэх ухаанд ардчилсан сонгуулийн тогтолцоог үндсэн хоёр гол тогтолцоонд хуваан авч үздэг бөгөөд ялалт байгуулж буй хувь хэмжээний ялгаанаас үл хамааран ялагч нь бүгдийг авдаг олонхын буюу мажоритар, авсан саналын хувь хэмжээгээр улс төрийн намуудад суудал хуваарилдаг пропорциональ буюу хувь тэнцүүлсэн тогтолцоо гэж ангилдаг. Тогтолцоо тус бүртээ олон хувилбартай. Улс орнууд энэ хоёр тогтолцооны аль нэг, эсхүл хоёуланг нь хослуулан өөрт тохирсон хувилбарыг хэрэглэдэг. Сонгуулийн тогтолцоог ангилах хамгийн нийтлэг арга нь сонгогчдын өгсөн саналыг нам, нэр дэвшигчийн хууль тогтоох байгууллагад авах суудлын тоонд хэр хувь тэнцүүлэн хөрвүүлж байгаа үр дүнгээр ангилах явдал юм. Энэхүү өргөн хүрээний ангилал дотроо сонгуулийн тогтолцоонуудыг олон хуваан авч үзэх ба сонгогчдын саналыг хэрхэн хууль тогтоох байгууллага дахь суудал болгож буйгаас нь шалтгаалан олонх, дийлэнхийн тогтолцоо-мажориатар, хувь тэнцүүлэх тогтолцоо- пропорциональ систем, холимог систем болон бусад систем⁷ хэмээн дахин ангилдаг.

1. Дийлэнх/ олонхнийн тогтолцоо (Majoritarian system): Энэ тогтолцоо нь түгээмэл хэрэглэдэг таван хувилбартай. Харьцангуй олонхын тогтолцоонд (first past the post-FPTF) нэг мандаттай тойрогт заавал үнэмлэхүй олонхи санал авах албагүй, харин бусад өрсөлдөгчтэй харьцуулахад хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялалт байгуулна. Саналын төлөөх өрсөлдөөн намуудаас илүү нэр дэвшигчдийн хооронд явагдах ба сонгогч саналын хуудсанд дэмжиж буй нэр дэвшигчийнхээ нэрийг дугуйлдаг. Энэ тогтолцоог Их Британи, АНУ, Энэтхэг, Канад болон Британий колони байсан орнууд хэрэглэдэг

2. Хувь тэнцүүлэх тогтолцоо (Proportional system): Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь намын авсан саналыг хууль тогтоох байгууллагын суудалд зориудаар хувь тэнцүүлэн хөрвүүлэхэд оршдог. Хувь тэнцүүлэх тогтолцооны үндсэн 3 хувилбар байдаг. Нээлттэй жагсаалттай, хаалттай жагсаалттай, шилжих дан саналын тогтолцоо тус тус ордог. Эдгээр бүх хувилбарт олон мандаттай тойргоор сонгуулийг зохион байгуулдаг. Учир нь нэг мандаттай тойрогт нэг л хүн ялагч болох тул суудлыг хувь тэнцүүлэн хуваарилах боломжгүй нь ойлгомжтой. Израйль, Нидерландын Вант Улсад улс нь бүхлээрээ олон мандаттай нэг тойрог болдог. Камбожийн вант улс зэрэг оронд сонгуулийн тойргуудыг

⁵ Рейли, Бенжамин. Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд. НҮБХХ. Улаанбаатар 2010 он.

⁶ Рейли, Бенжамин. Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд. НҮБХХ. Улаанбаатар 2010 он.

⁷ Electoral system (ACE project) <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/esd01/esd01c/default>

засаг захиргааны нэгжид үндэслэн тогтоодог бол Индонезид сонгуулийн тойргийн хэмжээг хуулиар тогтоож, тойргуудыг байгуулах үүргийг сонгуулийн төв байгууллагад үүрэг болгодог ажээ.

3. Холимог тогтолцоо (Mixed system): Дийлэнх/ олонх болон хувь тэнцүүлэх тогтолцооны аль алиных нь шинжүүдийг нэгтгэх оролдлого гэж ойлгож болно. Холимог тогтолцоонд өөр өөр томъёололтой сонгуулийн хоёр тогтолцоог зэрэгцүүлэн ашигладаг. Үүнд санал өгөх сонгогчид ижил байх бөгөөд төлөөлөгчдийг гол төлөв нэг мандаттай тойрог бүхий харьцангуй олонхын болон намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлэх системийг хослуулан сонгодог. 1990-ээд онд сонгуулийн шинэтгэл хийсэн улс орнууд холимог тогтолцоог нийтлэг сонгосон байдаг бөгөөд үүнийг хувь тэнцүүлэх болон орон нутгийн төлөөллийг нэгэн зэрэг хангах сайн үр дагавартай хэмээн үзсэн. Холимог тогтолцоог дотор нь холимог-хувь тэнцүүлэх, холимог-мажоритар гэсэн хоёр өргөн бүлэгт ангилж үздэг. Холимог хувь тэнцүүлэх тогтолцоог (Mixed member proportional-MMP) Герман, Шинэ Зеланд зэрэг оронд хэрэглэдэг бөгөөд парламентын суудлын нэг хэсгийг (ихэвчлэн 50 хувийг) нэг мандаттай тойргоос, үлдсэнийг нь намын жагсаалтаар санал хураан хуваарилдаг. Холимог мажоритар тогтолцоо (Mixed member majoritarian), дээрхээс ялгаатай нь хувь тэнцүүлэх намын жагсаалт, орон нутгийн тойргоор санал зэрэг хурааж, пропорционал бус байдлыг залруулах зохицуулалт хийдэггүй. Парламентын суудлын нэг хэсгийг хувь тэнцүүлэн, үлдсэнийг нь олонхын, эсвэл мажоритар тогтолцооны аль нэг хэлбэрээр хуваарилдаг. Сүүлийн жилүүдэд шилжилтийн ардчилалтай орнууд энэ тогтолцоог сонгох нь түгээмэл байгаа бөгөөд Зүүн Ази, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан олон орон ийм тогтолцоогоор сонгууль явуулж байна

4. Бусад: Сонгуулийн дийлэнх олонхын болон хувь тэнцүүлэх аргуудаас өөр үл шилжих, дан санал, хязгаарлагдмал санал, Борда санал гэсэн аргуудыг багтаадаг.

Сонгуулийн тогтолцооны эрх зүйн орчин ба намын системийн төлөвшил

Монгол Улс 1992 оноос хойш төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-ыг дөрвөн жил тутам бүх нийтийн, шууд, чөлөөт, ардчилсан сонгуулиар байгуулж ирсэн. Өнгөрсөн хугацаанд нийт найман удаа байнгын ажиллагаатай УИХ-ыг сонгон байгуулсан бөгөөд энэ нь иргэд өөрсдийн төрөө өөрсдөө байгуулж байгаа ардчилсан арга юм. Сонгуульд 18-аас дээш насны сонгуулийн эрх бүхий иргэд оролцдог. Учир нь 1948 онд НҮБ-ын баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21.3 дугаар зүйлд “ Ард түмний хүсэл зориг бол засаг төрийн үндэс мөн. Мөн хүсэл зориг нь бүх нийтэд сонгуулийн тэгш эрх эдлүүлэх үндсэн дээр санал хураалтыг нууцаар хураах, эсхүл саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц бусад хэлбэрийг ашиглах замаар тогтмол, хуурамч бус сонгууль явуулахад илэрлээ олно”⁸ гэж заасан нь дэлхий нийтээр сонгох эрхийг хэрэгжүүлэх гол арга болсон юм. 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн 3.1 зүйлд “Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”⁹ гэж хуульчилсан. Хожим УИХ 2003 онд “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.1-д “Сонгуулийн тогтолцоо, үйл явцын журмыг иргэдийн бие даасан оролцоог хангаж, чадварлаг УИХ бүрдүүлэхэд чиглүүлж боловсронгуй болгоно”¹⁰ гэж заасан. Сонгуулийн тогтолцоо нь сонгогчдын саналыг парламент хуваарилах, төрийн институцийг бүрдүүлэх арга зам, дүрэм журам юм. Гэхдээ ихэнх судлаачид сонгуулийн тогтолцоог тойрог ямар байх, сонгогч саналаа яаж өгөх, намуудын кампанит ажлын стратеги, нэр дэвшигч хэн байх, намын бодлого ямар байх, сонгогчдын саналыг хэрхэн татах, авсан саналыг яаж парламентад шилжүүлэх зэрэг олон асуудлыг багтаадаг өргөн

⁸ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он. <https://www.legalinfo.mn/law/details/1271>


⁹ Монгол Улсын Үндсэн Хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>

¹⁰ Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. 2003 он. <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

хүрээтэй ойлголт гэж үздэг. Гэвч сонгуулийн тогтолцоог сайжруулах хууль эрх зүйн орчинд өнөөг хүртэл ахиц дэвшил гараагүй байна.

Тодруулбал, өнгөрсөн хугацаанд Монгол Улс сонгуулийн тогтолцоог 1992, 1996, 2005, 2011, 2015, 2016, 2019 онуудад нийт 7 удаа өөрчилжээ. Үүнээс тавыг нь хуулийг шинэчлэн найруулж, хоёрыг нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулан өөрчилж байсан аж. Сонгуулийн тогтолцооны өөрчлөлт бүр ээлжит сонгууль болохын өмнөхөн болдог байсан бөгөөд сонгуулийн хуулийг сайжруулах нэртэй эрх баригч намын улс төрийн бодлого байсан гэж зарим судлаачид үздэг.

Зураг 1. УИХ-ын сонгуулийн хуулиуд ба тогтолцооны өөрчлөлтүүд¹¹



1. Анхны хууль¹² - ийг УИХ 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан. Хуулийн 8.1 зүйлд Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно гэж заасан. Энэ нь сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцооны (Block voting) хувилбар юм. Хожим 1996 онд ээлжит сонгуулиас 2 сарын өмнө уг хуулийн 8.1 зүйлийг “Сонгуулийг нэг мандат бүхий тойргоор зохион байгуулж явуулна” гэж өөрчилсөн нь сонгуулийг жижигрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP) тогтолцоо юм. Энэ тогтолцоог 1996, 2000, 2004 онуудад хэрэглэсэн байдаг.

2. Хоёр дахь хууль¹³ -ийг УИХ 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан. Хуулийн 4.2 зүйлд Нам, эвсэл нь олон мандаттай тойрогт тухайн тойрогт оногдох мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ гэж заасан. Энэ нь 1992 онд хэрэглэсэнтэй ижил олонх, дийлэнхийн тогтолцооны (Block voting) хувилбар бөгөөд Монгол Улс сонгуулийн тогтолцооны шинэтгэлээс ухарсан үйлдэл байсан.

3. Гурав дахь хууль¹⁴ -ийг УИХ 2011 оны 12 сарын 15 өдөр баталсан. Хуулийн 4.8 зүйлд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд 76 гишүүнийг сонгоно. 4.9 зүйлд Энэ хуулийн заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн намын жагсаалтаас тус тус сонгоно гэж заажээ. Сонгуулийн энэ тогтолцоо нь олонх дийлэнхийн болон хувь тэнцүүлсэн тогтолцоог зэрэгцүүлэн (Paralell system) хэрэглэсэн анхны бөгөөд сүүлчийн тохиолдол байсан.

4. Дөрөв дэх хууль¹⁵ -ийг УИХ 2015 оны 12 сарын 25-ны өдөр баталсан. Энэ хууль нь УИХ, Ерөнхийлөгч болон орон нутгийн сонгуулиудыг нэг хуулиар зохицуулах оролдлого байсан бөгөөд сонгуулийн тогтолцоог өмнөх хуультай ижил 48/28 гэсэн холимог тогтолцоог дахин баталсан. Гэвч Үндсэн хуулийн цэц 2016 оны 4 сарын 22-ны өдрийн 05-р тогтоолоор Сонгуулийн хууль Үндсэн хууль зөрчсөн¹⁶ гэж үзсэн тул УИХ 2016 оны 5 сарын 5-ны өдөр

¹¹ Политологи. Эрдэм шинжилгээний бичиг. 2023 он.

¹² Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 1992 он. <https://www.gec.gov.mn/>

¹³ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2005 он. <https://www.gec.gov.mn/>

¹⁴ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2011 он. <https://www.legalinfo.mn/law/details/351>

¹⁵ Сонгуулийн тухай хууль. 2015 он. <https://www.legalinfo.mn/law/details/1217820>

¹⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 05 дугаар тогтоол.

<https://www.legalinfo.mn/law/details/11847?lawid=1184721>

уг тогтоолыг хэлэлцээд ээлжит сонгуулиас хоёр сарын өмнө хуулийн 7.1 дэх заалтыг Сонгууль нь олонхийн /мажоритар/ тогтолцоотой байна гэж өөрчилсөн.

5. Тав дахь хууль¹⁷-ийг УИХ 2019 оны 12 сарын 20-ны өдөр баталсан. Хуулийн 4.3 зүйлд Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно гэж заасан нь мөн л 1992, 2008 онд хэрэглэсэн Олонх, дийлэнхийн тогтолцооны олон мандатын том тойргийн (Block voting) хувилбарыг дахин хуульчилжээ.

Дээрх сонгуулийн хуулиуд болон тогтолцооны өөрчлөлтүүдээс харахад Монгол Улс 1992 оноос хойш УИХ-ын сонгуулийг найман удаа зохион байгуулахдаа сонгуулийн Олонх, дийлэнхийн тогтолцооны нэг мандаттай жижиг тойргийн (FPTP) хувилбарыг 1996, 2000, 2004, 2016 онд, олон мандаттай томсгосон тойргийн (BV) хувилбарыг 1992, 2008, 2020 оны УИХ-ын сонгуулиудад хэрэглэжээ.

Харин түүхэндээ 2012 онд сонгуулийн холимог тогтолцоог 48/28 хувилбараар хэрэглэсэн. Энэ нь УИХ-ын 76 мандатын 48-г олон мандаттай томсгосон мажоритар 26 тойргоос, 28 мандатыг улс нэг тойргоос намын жагсаалтыг сонгох холимог хувилбар юм. Угтаа энэ холимог хувилбар нь Олонх, дийлэнхийн тогтолцоог 63 хувиар, хувь тэнцүүлсэн тогтолцоог 37 хувиар зэрэгцүүлэн хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тогтолцооны давуу болон сул талуудыг тэнцвэржүүлээгүй юм.

Хүснэгт 1. УИХ-д сонгогдсон нам, бие даагчдын суудлын тоо¹⁸

№	Сонгуулийн жил	МАН	АН	Бусад	Бие даагчид	Нийт
1	1992 он	70	5		1	76
2	1996 он	25	50		1	76
3	2000 он	72	1	1	2	76
4	2004 он	36	36		4	76
5	2008 он	45	28	2	1	76
6	2012 он	26	34	13	3	76
7	2016 он	65	9	2	1	76
8	2020 он	62	11	2	1	76

Дүгнэлт

УИХ-ын сонгуулийн тогтолцооны өөрчлөлтүүдээс харахад мажоритар буюу олонх дийлэнхийн тогтолцооны хувилбаруудыг хэрэглэж ирсний улмаас улс төрийн намын системийн төлөвшилд сөрөг үр дагаварууд гараад байна. Сонгуулийн Олонх дийлэнхийн тогтолцооны нэг онцлог нь зарим үед парламентад нэг нам давамгайлсан “супер мажоритар” олонх бүрдэх боломжийг олгодог. Өнгөрсөн сонгуулиудын дүнг харахад 1992, 2000, 2016, 2020 оны сонгуулиар УИХ-д МАН үнэмлэхүй олонхийн суудлыг авсан байдаг. Монгол Улсад сонгуулийн тогтолцооноос үүдэлтэй давамгайлагч нэг намтай намын систем тогтож байна. Энэ нь МАН бөгөөд өөрийн нүсэр бүтэц, уламжлалт тогтолцоогоо хадгалсаар байгаа, улс төрийн тавцанд хүчтэй хэвээр байгаа шалтгаан нь сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцоо болж байна. Учир нь МАН 1992, 2008, 2020 онд олон мандаттай том тойргоор, 2000, 2016 онуудад нэг тойрог нэг мандаттай жижигрүүлсэн тогтолцоонд тус тус ялалт байгуулжээ.

АН 1996, 2004 онуудад УИХ-ын сонгуулийг нэг тойрог, нэг мандаттай жижигрүүлсэн тогтолцоогоор зохион байгуулахад эвсэж ялалт байгуулсан. Эндээс харахад АН сонгуульд

¹⁷ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он.

<https://www.legalinfo.mn/law/details/14869>

¹⁸ Sumati Luvsandende, (2018) Voters ‘voices II. Ulaanbaatar. 25p

амжилттай өрсөлдөх, олон суудал авах боломж нь МАН-ын эсрэг хүчтэй эвсэл байгуулах бөгөөд энэ нь саналаа хуваахгүй байх боломж болж байна. Өөрөөр хэлбэл, АН сонгуульд эвсэл байгуулж оролцсон үедээ л хүчтэй өрсөлдөгч болдог, бусад үед дандаа ялагддаг зүй тогтол харагдаж байна. Мөн АН нь сонгуулийн тогтолцооноос үүдэлтэй органик бус нэгдлүүдийн түүх байна. Тодруулбал 1990 оны АИХ-ын сонгуулийн дараа МЧХН, БНН-ууд нэгдэж НН (Нэгдсэн Нам), 1992 оны УИХ-ын сонгуулийн дараах МоАН, НН, МСМН, МҮДН-ууд нэгдэж МҮАН (Монголын Үндсэний Ардчилсан Нам), 2000 оны УИХ-ын сонгуулийн дараах МҮАН, МСДН, МШАН, МУСМН, МоАН, МУНН гэх нийт 12 намын нэгдэл юм. Нэгдэл бүр сонгуулийн олонх, дийлэнхийн тогтолцооны шууд үр дагавар байсан байна. Энэ үзэгдлийг улс төрийн ухаанд М.Дювержигийн хуулиар тайлбарладаг. Гэвч институцчиж амжаагүй улс төрийн намуудад олонх дийлэнхийн тогтолцоо хоёр намын системийг биш, харин нэг нам давамгайлсан намын системийг тогтоход нөлөөлж байх талтай. Учир нь сонгуулийн тогтолцоо нь намын институцлалыг дэмжихгүй, хоёр намын систем тогтоход саад болсоор байна.

Abstract:

In the academic article "Influence of the legal framework of the electoral system on the formation of parties and party systems", apart from the scientific study of what the electoral system is, the legal framework of the electoral system, and how the electoral system is classified, the party is the most important part of the political system. As an important institution, it has been emphasized how it has developed and matured due to changes in the electoral system. The 8 parliamentary elections held in Mongolia in 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, and 2020 are characterized by the unique features of the times, economic conditions, political party and state policy decisions, and social times depending on the situation and legal changes in the electoral system, it had its own characteristics and effectiveness. Elections in Mongolia have been conducted by multi-mandate enlarged constituencies and single-mandate majoritarian system, which has created the opportunity for two political forces to hold the power in turn. The fact that the majority or two major parties alternately rule the government is related to the electoral system.

Key words: Electoral system, party, formation of party system, democracy, election, law, legal environment

Ашигласан ном, материал

1. Э.Гэрэлт-Од. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ. (1992-2020), судалгааны тайлан. 2021 он.
2. Б.Рейлли. Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд. Монгол Улс. НҮБХХ. 2010 он.
3. Д.Ноолон. “Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэтгэл” Бодлогын баримт, бичиг. Фрейдрих Эбэрт Сан. 2009 он.
4. Ж.Бямбадорж. Сонгох эрх ба Монгол Улсын сонгуулийн тогтолцоог шинэчлэх асуудал. Шинэ толь сэтгүүл. 1998 он
5. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2020)
6. Монгол Улсад сонгуулийн хувь тэнцүүлсэн системийн аль хувилбар илүү тохиромжтой вэ? Бодлогын зөвлөмж. 2005 он.
7. Монгол Улсын сонгууль. Эмхэтгэл. (1990-2020) Азийн сан. Улаанбаатар. 2023 он.
8. УИХ-ын сонгуулийн олонх дийлэнхийн тогтолцоог боловсронгуй болгох нь. Бодлогын зөвлөмж. 2005 он.
9. Монголын намын системийн институтчлэл. Дефакто институт, КАС. Улаанбаатар 2020. https://defacto.mn/wp-content/uploads/2020/09/instuchlel_tailanB5_ok%D0%9501.pdf
10. Н.Цолмонтаяа. Сонгуулийн тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох асуудалд. Шинэ толь сэтгүүл. №25, 1999 он.
11. Сонгуулийн дараах олон нийтийн санаа бодлын тандалтын судалгаа. 2016 оны 8 сарын 16-26. https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-2016_-_public_desk_mon.pdf
12. ТАНИЛЦ: 1992-2016 он хүртэл УИХ-ын сонгуулийн тойрог хуваалт ба үр дүн. <https://ikon.mn/n/1ra9>
13. Улс төрийн намуудын төлөвшил, өнөөгийн нөхцөл байдал. Судалгааны тайлан. Монголын дипломатын академи. Улаанбаатар. 2019 он. <https://mirim.mn/wp-content/uploads/2020/02/Songiili-Sudalgaanii-tailan-2019.pdf>
14. Политологи Эрдэм шинжилгээний бичиг, №19 (558)
15. Политологи Эрдэм шинжилгээний бичиг, №16 (489)
16. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик /эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл/. Улаанбаатар. 2009 он.
17. Монгол Улсын сонгууль (1992-2021). Судалгааны эмхэтгэл. Азийн сан. Улаанбаатар. 2023 он.
18. Э.Гэрэлт-Од. Д.Бямбажав. Олон мандаттай том тойргоос авах СУРГАМЖ. <https://ikon.mn/opinion/1u27>
19. Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам эвслийн зардлын тайлан. ҮАГ. Монгол Улс. 2020 он. <https://audit.mn/?p=9633>
20. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн зардлын дээд хэмжээг тогтоолоо. <https://ikon.mn/n/1xd5>
21. Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем. Улаанбаатар. 2012 он.

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 101-110 дахь тал

**ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮНДРЭЛ
БЭРХШЭЭЛ**

У.Батцэрэн

Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургууль,
Сургалтын менежер, доктор, дэд профессор

Д.Алтанхуяг

Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургууль,
Докторант

Товч утга:

Хүн төрөлхтний хүлээн зөвшөөрсөн ардчиллын нийтлэг загвар нь шууд ба төлөөллийн ардчилал юм. Ардчиллын энэ хоёр загвар нь харилцан уялдаатай бие биеэ нөхөн сэлбэж байдаг жамтай. Монгол улсын ардчилсан өөрчлөлтийн үйл явцаас үзвэл ардчиллын дээрх хоёр загварыг н харьцаа алдагдаж, шууд ардчилал гэхээсээ төлөөллийн ардчиллыг зохистой загвар хэмээн үзэж ирсэн. Гэвч төлөөллийн ардчиллын боломжийг бүрэн дүүрэн ашиглаагүй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх иргэдийн улс төрийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлж чадаагүй. Үүний нөлөөгөөр шууд болон төлөөллийн ардчиллын аль алиных нь давуу үр өгөөжтэй тал нь бүдгэрэн хумигдаж, тэдгээрийн боломжтой арга, хэлбэрийг ашиглахгүй байх улмаар иргэдийн улс төрийн оролцоо багассаар байна.

Иймээс ШУА-ийн ФХ-ийн Улс төр судлалын салбараас “Монгол улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо” сэдэвт суурь судалгааны төсөл хэрэгжүүлэн шинжээчдийн санал асуулга явуулан уг асуулыг цогц хэлбэрээр нь судалж байна. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй улс төр, эрх зүйн хүчин зүйлс болон улс төр, эрх зүйн бэрхшээлтэй асуудлыг ЭША У.Батцэрэн, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн зарим асуудлыг ЭША Т.Хулан нар товч авч үзэхийг зорив.

Түлхүүр үгс: ардчилал, иргэдийн улс төрийн оролцоо, бэрхшээл, хүчин зүйл, улс төр, эрх зүй, нийгэм, эдийн засаг, улс төрийн лидер, улс төрийн нам, сонгууль, улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн ухамсар, улс төрийн боловсрол, хуулийн үйлчлэлийн чадамж.

Ардчиллын оршихуйн суурь үндэс нь иргэдийн улс төрийн оролцоо байдаг. Иргэд ардчилал, улс төрийн шийдвэр гаргах үйл явцад бодитой оролцохын хэрээр ардчилал улам бүр баталгаажин төлөвшинө гэж үздэг. Монгол улс иргэдийн улс төрийн оролцоог Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн түвшинд эрх зүйн хувьд баталгаажуулж, түүний суурь үндсийг нэгэнт бүрдүүлсэн билээ. Гэвч бодит байдал дээр иргэдийн улс төрийн оролцооны талаарх хүчин зүйл тэр дундаа улс төр, хууль эрх зүй, эдийн засаг, нийгмийн үзэл санааны хүчин зүйлс төдийлөн хангалтай хэрэгжиж чадахгүй байна.

Улс төрийн хүчин зүйл

Монгол Улсад иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд бүх талын оролцооны зүй ёсны хэрэгцээг хангах болон бодит боломжийг өргөтгөх, улмаар уг оролцоонд нөлөөлж буй асуудлуудыг сайтар судлах хэрэгтэй билээ. Тухайлбал, иргэдийн улс төрийн оролцооны чадавхийг бэхжүүлэх, нэмэгдүүлэхийн тулд нэн түрүүнд улс төр,


эрх зүйн хүчин зүйлс болон төлөөллийн ба шууд ардчилалд учирч буй асуудал, бэрхшээл, гажуудал зэргийг шинжлэх ухаан тэр дундаа улс төрийн шинжлэх ухааны үүднээс судлаж үзэх хэрэгтэй билээ. Дээрх сэдвийн хүрээнд дараах хоёр зорилтыг дэвшүүлж байна. Нэгд: иргэдийн улс төрийн оролцооны зохион байгуулалтын хэлбэрийг нарийсгаж, арга замыг шинэтгэн, үр ашгийг дээшлүүлэх. Хоёрт: төлөөллийн ба шууд ардчилалд учирч буй асуудал, бэрхшээл, гажуудал зэргийг судлах явдал юм.

Үүний хүрээнд ШУА-ийн ФХ-ийн УТС-ын хамт олон 2014-2016 онд “Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо” сэдвийг суурь судалгааны хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудын шинжээчдийн дунд санал асуулга явуулж үр дүнг нь нэгтгэн дараах байдлаар тоймлон хүргэж байна. Үүнд:

Судалгаанд нийт 40 шинжээч оролцсон бөгөөд насны бүтцийн хувьд 40 хүртэлх насны 9 хүн буюу 22.5 хувь, 41-50 насны 11 хүн буюу 27.5 хувь, 51-60 насны 12 хүн буюу 30.0 хувь, 61-ээс дээш насны 7 хүн буюу нийт судалгаанд оролцогчдын 17.5 хувь нь байна.

Мөн хүйсийн хувьд 62.5 хувь нь эрэгтэй, 35 хувь нь эмэгтэй хүмүүс байна. Шинжээчдийг харгалзан үзэх голлох үзүүлэл бол тэдний эрхэлж буй ажил алба юм. (График № 1).

График № 1. Эрхэлж буй ажил (хувь, тоо)



Эх сурвалж: Судалгааны тайлан

Дээрх графикаас харахад судалгааны байгууллага болон эрдэмтэн, багш, судлаачид дийлэнх олонх хувьтай оролцсон нь манай судалгааг шинжлэх ухааны талаас нь үнэлж дүгнэсэн өөрөөр хэлбэл, эрдэм шинжилгээний түвшинд бүрэн нийцсэн суурь судалгааны төслийн ажил болсон гэж дүгнэж болно.

Иргэдийн улс төрийн оролцооны талаар судалгаанд оролцогчид төдийлөн хангалтай биш гэж 67.5 хувь нь хариулсан бол хангалтай гэж 12.5 хувь, огт хангалтгүй гэж 20 хувь нь үзсэн байна. Энэхүү үр дүнгээс харахад манай улсад иргэдийн улс төрийн оролцооны асуудал хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Улс төрийн амьдралын өнөөгийн ардчилсан тогтолцоонд иргэдийн оролцоогүйгээр ардчиллын мөн чанарыг илэрхийлж боломгүй билээ. Улс төрийн оролцоо гэдэг бол иргэдээс төрийн байгууллага, төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж буй үйлдлийг хэлнэ. Монголчуудын улс төрийн оролцоо нь иргэд төрд хандах уламжлалт хандлагаас ихээхэн хамаарч байна. Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийг улс төрийн болон эрх зүйн гэсэн ерөнхий хоёр бүлэгт хуваан үзэж, эцэст нь бэрхшээлтэй асуудлыг товч дүгнэхийг хичээв. Үүнд:

- Улс төр: сонгуулийн оролцоо, улс төрийн намын оролцоо имиж, улс төрийн лидерийн оролцоо имиж, улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн ухамсар (График № 2)
- Эрх зүй: эрх зүй, хуулийн үйлчлэлийн чадамж
- Улс төр, эрх зүйн бэрхшээл

График № 2. Улс төрийн хүчин зүйл (хувь)



Эх сурвалж: Судалгааны тайлан

Дээрх графикаас харахад улс төрийн оролцоонд хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйл нь улс төрийн ухамсар болон улс төрийн намын оролцооны асуудлууд байгаа бол улс төрийн лидерийн оролцооны асуудал бусад хүчин зүйлсээ бодвол дундаж үзүүлттэй байна. Харин улс төрийн тогтворгүй байдал, сонгуулийн оролцоо бага хувьтай байгаа боловч бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр хувьтай байна.

Зарим талаараа нөлөөлж буй хүчин зүйлд дээрх улс төрийн хүчин зүйл мөн адил өндөр хувьтай байна. Эндээс дүгнэн өгүүлэхэд иргэдийн улс төрийн оролцоонд бүгд өндөр хувьтай нөлөөлж байгаа бол нөлөөлж байна, зарим талаараа нөлөөлж байна гэсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн дундаж хувийг нь гарган эрэмбэлэн үзвэл дараах үр дүн харагдаж байна. (Хүснэгт № 1).

Хүснэгт № 1. Улс төрийн хүчин зүйл (дундаж хувь, эрэмбэ)

№	Хүчин зүйл	Дундаж хувь	Эрэмбэ
8	Улс төрийн лидерийн оролцоо имиж	46.2	1
7	Улс төрийн намын оролцоо имиж	45.0	2
6	Сонгуулийн оролцоо	42.3	3
9	Улс төрийн тогтворгүй байдал	42.3	4
10	Улс төрийн ухамсар	37.5	5

Эх сурвалж: Судалгааны тайлан

Улс төр дэх иргэн хүний оролцоо бол ардчиллын нэг үнэт зүйл, түүний мөн чанарын илэрхийлэл болдог ба эрх зүй, улс төрийн амьдралд иргэд идэвхтэй, сайн дурын үндсэн дээр, эзэн ёсоор оролцох нь ардчиллын гол асуудал юм. Энэ ч утгаар нь Францын эрдэмтэн Gustave A De Cocq “Иргэдийн оролцоо бол ардчиллын оршин тогтнох, сүүлийн тулах цэг”¹ хэмээн бичсэн байдаг байна.

Дээрх хүснэгтээс харахад манай улсад иргэдийн улс төрийн оролцоонд улс төрийн лидер буюу улс төрчид ихээхэн нөлөөлж байдаг байна. Мөн улс төрийн намуудын нөлөөлөх нөлөөлөл өндөр хувьтай байна. Ардчилсан нийгэмд иргэний улс төрийн оролцоонд хөндлөнгөөс нөлөөлөх нь мэдээж буруу зүйл юм. Энэ нь өнөөдөр бидний хувьд тулгараад

¹ Gustave A De Cocq. Citizen participation: Doomed to extinction or last foothold of democracy? An exploratory study in four west European countries: the Netherlands, ... to North America, (Atlantic series, nr. 7). NY., 1969. p. 59

буй нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих асуудал буюу иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл юм.

Манай орны хувьд иргэдийн улс төрд оролцох оролцоо нь дутмаг байна. Энэ нь нэг талаас иргэдийн өөрийн улс төр дэх оролцооны идэвх сул, нөгөө талаас хөндлөнгийн улс төрийн субьектүүдийн нөлөөлөл их байгаатай холбоотой бөгөөд харин иргэд эсрэгээрээ улс төрийн субьектүүдийн үйл ажиллагаанд оролцох нь өнөөдөр бидэнд тулгамдаад буй хүндрэл, бэрхшээлтэй асуудлын нэг юм.

Нийгмийн хувьд улс төрийн тогтвортой байдал иргэдийн улс төрийн оролцоонд мөн тодорхой хэмжээнд нөлөөлдөг нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Харин иргэдийн өөрийн оролцоо нь маш чухал юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн улс төрийн ухамсар шинжээчдийн үнэлгээгээр бага үзүүлэлттэй гарсан байна. Иймд бид цаашид иргэн бүрийг улс төрийн мэдлэг боловсролтой болгох, улс төрийн амьдралд идэвхтэй оролцуулах, улс төрийн ухамсрыг төлөвшүүлэхэд нь зүйтэй юм.

Өнөөгийн нийгэмд жирийн иргэдийн дунд улс төрийн оролцоог сонгуульд оролцох хэлбэр хэмжээнд буруу ташаа ойлгох явдал нэлээдгүй байна. Өөрөөр хэлбэл, манай улсад иргэдийн оролцоо нь ихэнхдээ сонгууль өгөхөд л илэрдэг. Сонгууль болоход бүх хүн саналаа өгч, идэвхтэй улс төрийн оролцоо болдог.

Манай улс иргэний идэвхтэй улс төрийн оролцооны хэлбэрийг бүрдүүлж, иргэн хүн бүрийг идэвхтэй оролцуулах хэрэгтэй юм. Улс төрийн тогтолцоо нь ардчилсан шинжтэй байхын тулд иргэдийн улс төрийн оролцоо өргөн байх боломжийг нээсэн байх хэрэгтэй. Ардчилсан улс оронд бүх нийтийн чөлөөт сонгуулиар улс төрийн олон өрсөлдөгчийн дотроос төр барих хүчнийг тодруулдаг. Энэ нь ард түмэн төлөөллийн ардчиллын зарчмын дагуу улс төрд оролцож байгаа оролцооны нэгэн хэлбэр нь юм.

Иргэдийн улс төрийн оролцооны олон янзын арга хэлбэр бий. Тэдгээрийг дотор нь нийцтэй ба нийцгүй оролцоо гэж ангилна. Тухайн үед нийгмийн амьдралыг зохицуулж буй эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээ, нийгмийн гишүүдийн дийлэнхийн эрхэмлэдэг үнэт зүйлсэд харшлахгүй зорилго, арга хэлбэртэй оролдлогуудыг нийцтэй оролцоо гэж нэрлэнэ. Дээрх хэм хэмжээ ба үнэлэмжид харш бүх оролдлогыг нийцгүй оролцоо гэж үзнэ. Тухайлбал, нийцтэй оролцоо гэдэгт: сонгуульд оролцох, ард түмний санал асуулга, жагсаал цуглаан зэрэгт оролцох.

Доктор Н.Мягмарцоож өөрийн нэгэн өгүүлэлдээ “...иргэд зөвхөн санал өгөгч байх нь иргэдийн оролцооны доод, идэвхгүй түвшин юм... ..иргэд сонгуульд оролцон саналаа өгөх нь улс төрийн оролцооны нэгэн чухал хэлбэр байдаг хэдий ч өнөөдөр зөвхөн иргэд санал өгөгч, сонгогч байхаас татгалзаж эхэлж байгаа нь тэдний сонгуульд оролцох идэвхээс харагдаж байна” хэмээн өгүүлсэн байдаг.

Иргэдийн улс төрийн оролцоо ганц сонгуулиар хязгаарлагддаггүй нь ойлгомжтой бөгөөд бид оролцооны олон төрлүүдийг ашиглаж сурах нь чухал юм. Монгол улсын иргэд төлөөллийн ардчиллын зарчмын дагуу төрийг удирдах, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаанд оролцох зэрэг эрхүүдийг хууль эрх зүйн тогтоомжуудад тусгаж өгсөн байдаг. Өнөөгийн нийгэмд хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудад иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаа болон учирч буй хүндрэл, бэрхшээл, хуулийн үйлчлэлийн чадамж зэргийг судлах нь энэхүү суурь судалгааны нэгэн зорилт билээ.

Эрх зүйн хүчин зүйл


Иргэдийн улс төрийн оролцоонд дан ганц улс төрийн хүчин зүйлээс гадна эрх зүйн хүчин зүйлс чухал юм. Тухайлбал, 1924 онд батлагдсан анхдугаар Үндсэн хуулийн нэгдүгээр бүлэгт: “...Бүх Монгол улсыг Үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Ард Улс” гээд “...Улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэн улсын аливаа хэргийг Улсын Их Хурал, мөн энэ хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино” гэж тунхаглажээ. Улсын дээд эрхийг хууль эрх зүйн үүднээс жирийн ардад эдлүүлнэ гэсэн хэдий ч амьдрал дээр жирийн иргэдийн улс төрийн оролцоо гэж бараг байсангүй.

Харин 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж хууль эрх зүйн хүрээнд иргэдийн улс төрийн оролцооны талаар тов тодорхой зааж, хэнээс ч хараат бусаар иргэд улс төрд оролцож болохыг зааж өгсөн билээ. Гэвч иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчин хэр зэрэг үйлчилж байгаа нь өнөөдөр судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаад байна.

Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, үр нөлөөг сайжруулах суурь нь эрх зүйн орчинг хэрэн бүрдүүлснээс голлон шалтгаалдаг төдийгүй түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга замуудыг эрх зүйн хүрээнд шийдэж өгдөг.

Судалгаанд оролцсон шинжээчдийн хувьд иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийг дараах байдлаар үнэлсэн байна. (График № 3).

График № 3. Эрх зүйн хүчин зүйл (хувь)




Эх сурвалж: Судалгааны тайлан

Шинжээчдийн үнэлгээрээр дүгнэхэд хэцүү болон огт нөлөөлөхгүй байна гэж 18.4 хувь, хуулийн үйлчлэлийн чадамж гэж 21.1 хувь нь хариулсан байна. Харин нөлөөлж байгаа болон зарим талаараа нөлөөлж байна гэж 81.6 хувь, хуулийн үйлчлэлийн чадамж гэж 78.9 хувь нь хариулсан байна. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр хүчин зүйлийг судалгаанд оролцсон шинжээчдийн дөрвөн хүн тутмын гурав нь нөлөөлдөг гэж хариулжээ. Харин эсрэгээрээ дөрвөн хүн тутмын нэг нь нөлөөлдөггүй гэж дүгнэсэн байна.

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл

Иргэдийн оролцоонд хүн амын боловсрол, соёл, амьжиргааны түвшин, иргэний нийгмийн байгууллага, авлигал, ёс зүй, бизнес санхүү, татвар даатгал, хөрөнгийн зах зээлүүд нөлөөлж байна. Үүнийг дараах олон түмний оролцооны түвшнээс харж болох юм. (График № 4).

График № 4. Олон түмний улс төрийн оролцооны түвшин (хувь)



Эх сурвалж: Судалгааны тайлан

Олон түмний улс төрийн оролцоог үнэлэхдээ шинжээчдийн дийлэнх хэсэг нь буюу 67.5 хувь нь иргэдийн оролцоо хангалттай биш, 20 хувь нь огт хангалтгүй байна гэсэн бол ердөө 12.5 хувь нь л иргэдийн оролцоо хангалттай байна гэж үзсэн юм. Судалгааны дүнгээс харахад иргэд улс төрийн оролцоо зөвхөн сонгууль өгөх хэлбэрээр илэрч байна. Үүнийг дараах хүснэгтээс харж болох юм. (Хүснэгт № 2).

Хүснэгт № 2. Иргэдийн улс төрийн оролцооны хэрэгжилтийн хэлбэр

№	Хүчин зүйл	Хувь
1	Бүх төрлийн сонгуульд оролцон саналаа өгөх	28.1
2	Ард нийтийн санал асуулгад оролцох хэлбэр	2.2
3	Улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох	17.0
4	Орон нутгийн түвшний улс төрийн оролцоо	5.2
5	Төр, засгийн албаны хүмүүстэй янз бүрийн түвшинд харилцах байдал	11.9
6	Иргэний нийгмийн байгууллага, улс төрийн клубын үйл ажиллагаанд оролцох	13.3
7	Үзэл бодол, санал дүгнэлтээ төр, засагт илэрхийлэх	11.1
8	Төр, засгийн шийдвэр гаргах үйл явцад оролцох	-
9	Хууль ёсны жагсаал цуглаанд оролцох	8.9
10	Өөр бусад	2.2

Эх сурвалж: Судалгааны тайлан

Судалгаанд оролцогчдын 28.1 хувь нь бүх төрлийн сонгуульд оролцон саналаа өгдөг. 17 хувь нь улс төрийн намын үйл ажиллагаанд оролцдог. 13.3 хувь нь иргэний нийгмийн байгууллага клубын үйл ажиллагаанд оролцдог гэж тус тус хариулжээ. Иргэдийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшин дэх оролцоонд та хэр сэтгэл хангалуун байдаг вэ гэсэн асуултад төдийлөн хангалттай биш гэж 60 хувь, огт хангалтгүй гэж 37.5 хувь нь хариулсан. Судалгаанаас үзэхэд иргэд зөвхөн сонгуульд оролцох оролцоо нь түлхүү байгаагаас иргэдийн улс төрд оролцох оролцоо сул байна. Харин манай улсад иргэдийн улс төрийн оролцооны нэг хэлбэр буюу бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшин дэх сэтгэл ханамжийн байдал нь судалгаанд оролцсон шинжээчдийн дүгнэлтээр огт хангалтгүй гэсэн үр дүн гарсан байна. (График № 4).

График № 4. Иргэдийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшин дэх оролцооны сэтгэл ханамж



Эх сурвалж: Судалгааны тайлан

Иргэдийн улс төрийн оролцоонд дараах хүчин зүйлүүдээс аль нь илүү нөлөөлж байна гэж Та бодож байна вэ? гэсэн асуултад боловсролын түвшин нөлөөлж байна 60 хувь нь, соёл 44.7 хувь нь, иргэний нийгмийн байгууллага нөлөөлж байна 40 хувь нь, авлигал 59 хувь нь, 47.5 хувь нь зарим талаар нөлөөлж байна хариулсан. Иргэдийн улс төрийн оролцоонд бизнес нөлөөлж байна гэж 43.2 хувь нь, санхүү 26.3 хувь нь, татвар 16.2 хувь нь, хөрөнгийн зах зээл 16.2 хувь нь нөлөөлж байна гэж хариулсан.

Харин иргэдийн улс төрийн оролцоонд нийгэм болон эдийн засгийн зарим асуудлууд хэрхэн нөлөөлж буйг дараах хүснэгтээс харж болох юм. (Хүснэгт № 3).

Хүснэгт 3. Иргэдийн улс төрийн оролцоон дахь нөлөөлөл (хувь)

№	Хариулт	Нөлөөлж байна	Зарим талаар нөлөөлж байна	Огт нөлөөлөхгүй байна	Дүгнэхэд хэцүү
1	Боловсрол	60.0	35.0	5.0	-
2	Соёл	44.7	50.0	2.6	2.6
3	Иргэний нийгмийн байгууллага	40.0	47.5	5.0	7.5
4	Авлигал	59.0	30.8	-	10.3
5	Ёс зүй	43.6	35.9	7.7	12.8
6	Бизнес	43.2	43.2	5.4	8.1
7	Банк, санхүү	26.3	47.4	7.9	18.4
8	Татвар даатгал	16.2	51.4	8.1	24.3
9	Хөрөнгийн зах зээл	16.2	35.1	27.0	21.6

Эх сурвалж: Судалгааны тайлан

Нийгмийн хувьд улс төрийн тогтвортой байдал иргэдийн улс төрийн оролцоонд чухал нөлөө үзүүлдэг. Улс төрийн оролцоонд дараах хүчин зүйлээс аль нь илүү нөлөөлж байна вэ? гэсэн асуултад боловсрол нөлөөлж байна 60.0 хувь нь, зарим талаар боловсрол нөлөөлж байна гэж 35.0 хувь нь хариулсан байна.

Харин нийгэм, эдийн засгийн хувьд иргэдийн улс төрийн оролцооны явцад тохиолдож буй дараах бэрхшээлтэй асуудлууд дотроос дараах асуудлууд илүүтэй үйлчилж байна гэж судалгаанд оролцогчид хариулсан байна. (Хүснэгт № 4).

Хүснэгт № 4. Нийгэм, эдийн засгийн бэрхшээл (хувь)

№	Хариулт	Хувь
1	Улс орны эдийн засгийн нөхцөл байдал	10.7
7	Хэвлэл мэдээллийн тэнцвэргүй нэг талыг барьсан байдал	6.0
8	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боймлох оролдлого	1.3
9	Шүүх, цагдаа, хүчний байгууллагуудын хууль бус үйл ажиллагаа	2.7
10	Иргэдийн улс төрийн боловсрол, соёлын хомсдол	8.1
11	Зах зээлийн эдийн засгийн мэдлэг, боловсролын хомсдол	1.3
12	Иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшөөгүй байдал	4.7
14	Шударга иргэд, байгууллагын дуу хоолойг боомилох, дарамтлах байдал	6.0

Эх сурвалж: Судалгааны тайлан

Судалгааны дүнгээс үзэхэд иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй нийгмийн болон эдийн засгийн хүчин зүйлийн асуудалд **нэгдүгээрт**, улс төрийн боловсролыг сайжруулах, **хоёрдугаарт**, иргэдийг улс төрийн шийдвэр гаргах үйл явцад өргөнөөр татан оролцуулах, **гуравдугаарт**, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, **дөрөвдүгээрт**, эдийн засгийн салбарын талаарх мэдлэг, мэдээллийг зөв ойлгуулах, **тавдугаарт**, иргэдийг ажлын байраар хангах, **зургаадугаарт**, улс төрийн тогтвортой байдал намуудын нийгмийн хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Улс төр, эрх зүйн бэрхшээл

Иргэдийн улс төрийн оролцооны явцад тохиолдож буй бэрхшээлтэй асуудлуудыг судалгаанд оролцсон шинжээчид дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, улс төрийн намын төлөвшөөгүй байдал болон улс төрийн хүрэн дэх эрх мэдлийн төлөөх тэмцэл, хуйвалдаан, улс орны эдийн засгийн нөхцөл байдал, улс төрчдийн авлига хээл хахууль, лобби, ёс зүйгүй байдал зэрэг бэрхшээл нь шинжээчдийн хувьд өндөр хувийг авсан байна. Өөрөөр хэлбэл, дээрх бэрхшээлүүд нь манай улсын хэмжээнд иргэдийн улс төрийн оролцоонд хамгийн ихээр саад учруулдаг гэсэн үг юм. Шинжээчдийн үнэлсэн үнэлгээний дүнг дараах хүснэгт № 5-д авч үзвэл.

Хүснэгт № 5. Иргэдийн улс төрийн оролцооны явцад тохиолдож буй бэрхшээл

№	Хүчин зүйл	Тоо	Хувь	Эрэмбэ
2	Улс төрийн намуудын төлөвшөөгүй байдал	29	19.5	1
3	Улс төрийн хүрэн дэх эрх мэдлийн төлөөх тэмцэл, хуйвалдаан	28	18.8	2
1	Улс орны эдийн засгийн нөхцөл байдал	16	10.7	3
6	Улс төрчдийн авлига хээл хахууль, лобби, ёс зүйгүй байдал	16	10.7	4
10	Иргэдийн улс төрийн боловсрол, соёлын хомсдол	12	8.1	5
7	Хэвлэл мэдээллийн тэнцвэргүй нэг талыг барьсан байдал	9	6.0	6
14	Шударга иргэд, байгууллагын дуу хоолойг боомилох, дарамтлах байдал	9	6.0	7
5	Сонгуулийн тогтолцооны гажуудал	7	4.7	8
12	Иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшөөгүй байдал	7	4.7	9
4	Үндсэн хууль болон эрх зүйн чадамжийн хомсдол	6	4.0	10
9	Шүүх, цагдаа, хүчний байгууллагуудын хууль бус үйл ажиллагаа	4	2.7	11
8	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боймлох оролдлого	2	1.3	12
11	Зах зээлийн эдийн засгийн мэдлэг, боловсролын хомсдол	2	1.3	13
13	Төр ёсны уламжлалаа умартсанаас үүдсэн бэрхшээл	1	0.7	14

Эх сурвалж: Судалгааны тайлан

Дээрх бэрхшээлүүдийг бүлэглэн авч үзвэл судалгаанд оролцсон шинжээчдийн 2 хүн тутмын нэг улс төрийн хүчин зүйлийг онцолсон бол эдийн засаг, иргэний нийгмийн

байгууллагын талаар 4 хүн тутмын нэг нь тус тус хариулсан байна. Үүнийг дараах бүлгүүдээс харж болох юм. (Хүснэгт № 6).

		Хүснэгт № 6. Бүлэг	
№	Хүчин зүйл	Хувь	
	Улс төр		
	Улс төрийн намуудын төлөвшөөгүй байдал		
	Улс төрийн хүрээн дэх эрх мэдлийн төлөөх тэмцэл,		
1	хуйвалдаан		54.4
	Улс төрчдийн авлига хээл хахууль, лобби, ёс зүйгүй байдал		
	Сонгуулийн тогтолцооны гажуудал		
	Төр ёсны уламжлалаа умартсанаас үүдсэн бэрхшээл		
	Эдийн засаг		
2	Улс орны эдийн засгийн нөхцөл байдал		12.0
	Зах зээлийн эдийн засгийн мэдлэг, боловсролын хомсдол		
	Иргэний нийгмийн байгууллага		
3	Шударга иргэд, байгууллагын дуу хоолойг боомилох, дарамтлах байдал		10.7
	Иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшөөгүй байдал		
4	Иргэний боловсрол		8.1
	Хэвлэл мэдээлэл		
5	Хэвлэл мэдээллийн тэнцвэргүй нэг талыг барьсан байдал		7.3
	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боймлох оролдлого		
6	Эрх зүй		4.0
7	Хүчний байгууллага		2.7

Эх сурвалж: Судалгааны тайлан

Манай улсын хувьд иргэдийн улс төрийн оролцооны асуудал их онцлогтой учир нь XX зууны эхэн хүртэл хаант засагтай байж байгаад коммунист тогтолцоонд шилжиж улмаар 1990-ээд оноос иргэдийн улс төрийн оролцоо хэмээх ойлголт бий болж эхэлсэн. Төрийг бурханчлан шүтэж ойлгодог, төрийн минь сүлд өршөө, төрийн минь хишиг хэмээн залбирч ирсэн ард түмэн. Тиймээс ч иргэдийн оролцоо хэмээх ойлголт бараг байхгүй байсан гэж хэлж болох юм. Ардчилсан тогтолцоонд шилжээд иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг тунхаглаад 20 гаруй жил болсон боловч бидэнд уламжлалт сэтгэлгээ тодорхой хэмжээгээр хадгалагдсаар байна. Энэ нь нэг талаараа иргэдийн улс төрийн оролцооны нэгэн бэрхшээлтэй асуудал юм. Нөгөө талаар энэхүү иргэдийн улс төрийн оролцооны бэрхшээлтэй асуудал нь иргэдийн боловсрол, мэдлэг, мэдээллээр дутагдалтай байдал, нийгэм-эдийн засгийн хямрал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм.

Дээрх судалгааны эцсийн дүнгээс үзэхэд манай улсад улс төр, эдийн засаг, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн боловсрол, хэвлэл мэдээлэл, эрх зүйн зэрэг бэрхшээлүүд иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж байна. Иймээс бид дээрх бэрхшээлүүдийг даван гарахын тулд нэн түрүүнд иргэдийн улс төрийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа мөн төрд оролцох оролцоог нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн үнэн бодит, тэнцвэртэй мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэж байх шаардлагатай.

Мөн улс төрийн субъектүүдийн үйл ажиллагаа, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зэрэгт иргэдийг идэвхтэй татан оролцуулах болон төр, засгийн зүгээс иргэдийг зөвхөн сонгогч, сонгуульд оролцох оролцоогоор хангах бус төлөөллийн шат, шатны байгууллагад тэдний санал бодлыг хүргэх, шаардлагатай гэж үзвэл өөрийн санал өгч дэмжсэн төлөөллийн байгууллагын төлөөлөгчид хариуцлага хүлээлгэдэг байх тийм эрх зүйн орчныг бүрдүүлж өгснөөр иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй бэрхшээлийг тодорхой хэмжээнд багасгах боломжтой юм. Хамгийн гол бэрхшээлтэй асуудал бол иргэдийн өөрсдийн нь идэвх зүтгэлтэй байх асуудал юм.

Abstract:

The common type of democracy that was accepted by the humans is a direct and representative model. These two types of the democracy are traditionally related to each other and refreshed each other as well. In view of the democratic changes of Mongolia, the relations of the above mentioned two types were lost at that time and the representative democracy was deemed as proper rather than the direct democracy. However, a possibility for the representative democracy was not fully used and a creation of any conditions for political involvement of citizens to realize such possibility was failed. Consequently, efficient and advantageous sides of either direct or representative democracies were unclear and their potential forms were not used and the political participation of citizens has been reduced.

Therefore, the Department of Political Studies of the Institute of Philosophy of Mongolian Academy of Sciences is implementing the base survey project called as *"Representative Democracy and Citizens Political Participation of Mongolia"* and has been conducting a questionnaire among experts and investigating such questionnaire as integrated. Based on this questionnaire, Battseren U., a research worker intends to study the political and legal issues and related challenges that are impacting on political participation of citizens and Khulan T., a research worker some issues regarding the social and economic factors respectively.

Key words: democracy, political participation of citizens, challenges, factory, politics, law, society, political leaders, political party, election, political instability, political consciousness, political education, capacity of legal effect.

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 111-118 дахь тал

**МОНГОЛЫН СОНГОГЧДЫН ИРЦ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС
(ЗАЛУУЧУУДЫН ЖИШЭЭН ДЭЭР)**

Н.Мягмарцоож

МУБИС

Доктор, дэд профессор

Сонгогчдын ирц гэдэг нь сонгуулийн санал хураах өдөр сонгогчид санал өгөх эрхээ хэрхэн ашиглаж байгааг илэрхийлдэг бөгөөд саналаа өгсөн сонгогчдын саналын хүчинтэй, хүчингүй, санал тэмдэглээгүй зэргийг оруулан тооцдог. Сонгогчдын ирцийг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны бүртгэлтэй сонгогчдоос эсвэл тухайн улсын сонгуулийн насны хүн амын тооноос тооцох гэсэн хоёр аргыг хэрэглэн гаргадаг. (Abdurashid 2016)


Хүн төрөлхтөн сонгуулийн эртний уламжлалтай хэдий ч ард түмэн төр засгаа сонгож байгуулдаг улс орнуудын тоо 1990 оноос хойш эрчимтэй нэмэгдсэн. Тухайлбал 1971-1980 онд 94 улс, 1981-1990 онд 114 улс төр засгаа сонгуулийн зарчмаар байгуулж байсан бол, 1991-2000 онд 176 улс, 2001 оноос 194 улс болж нэмэгджээ. Энэ нь сонгогчдын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн ч, санал өгөх эрхээ эдэлж буй сонгогчдын ирц буурсаар байна. 1940-1980 аад оны хооронд сонгогчдын ирц 78%-аас 76% болж ялимгүй буурсан бол 1990 онд 70%, 2011 он 66%, 2021 оны байдлаар 60% болтлоо буураад байна. (Abdurashid 2016)

Ялангуяа посткоммунист орнуудад сонгогчдын ирц огцом буурч байна. Тухайлбал, 1990 оноос хойш Европын посткоммунист 22 орноос ОХУ, Беларусь гэсэн хоёр улсын сонгогчдын ирц тогтвортой, нэмэгдэх төлөвтэй байгаа бол бусад улс орнуудад сонгогчдын ирц дунджаар 18%-иар, Албани улсад сонгогчдын ирц хамгийн их буюу 46%-аар буурчээ. (Abdurashid 2016) Судлаачид посткоммунист орнуудад сонгогчдын ирц буурч байгаа шалтгааныг улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны шилжилтийн үеийн хүнд хэцүү байдал, түүнд сэтгэл дундуур байгаатай холбон тайлбарладаг (Mason 2003/04; Kobach 2001; Krastev 2002). Монгол улс посткоммунист орны тоонд орох бөгөөд Ерөнхийлөгч, УИХ, Орон нутгийн сонгуульд оролцох сонгогчдын ирц сүүлийн гучин жил буурсаар байна.

Монголын сонгогчдын ирц (1992 - 2021)

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжин улс төр, эдийн засаг, эрх зүйн гээд нийгмийн бүхий л тогтолцоо үндсэндээ өөрчлөгдсөн. Ийнхүү Монголын ард түмэн шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцох боломж бүрдэж, чөлөөт ардчилсан сонгуулиар өөрсдийн төлөөллийг сонгодог болсон. 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсан цагаас хойш манай улсын иргэд төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ – ын 8 удаагийн, Ерөнхийлөгчийн 8 удаагийн, ИТХ -ын 7 удаагийн нийт 23 сонгуульд оролцсон байна.

Зураг 1. УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц (1992 - 2021)



Сонгогчид 1992 оноос УИХ-ын 8 удаагийн сонгуульд оролцохдоо 1992 – 2012 оны хооронд ирц 28,32% - иар буурч 67,28% болсон бол 2016 оноос нэмэгдэн 73.58% болж, 2020 онд тогтворжин 73,64% болсон. 2020 оны сонгуулийг 1992 онтой харьцуулахад 21,96% - иар буурсан байна. Энэ нь Латви, Украин, Молдав зэрэг посткоммунист орнуудтай ижил үзүүлэлт юм. (Abdurashid 2016)

Ерөнхийлөгчийн 8 удаагийн сонгуульд 2017 оны 2% - ийн өсөлтийг эс тооцвол 2021 оны сонгуулийн ирцийг 1993 оны сонгогчдын ирцтэй харьцуулахад 33,38% - иар буурчээ. Энэ нь Словани, Болгар, Румын зэрэг посткоммунист орнуудын сонгогчдын ирцийн бууралттай ижил үзүүлэлт юм. (Abdurashid 2016)

Ийнхүү Монголын сонгогчдын ирц буурч байгаа шалтгааныг социализмаас ардчилалд шилжих үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, сонгуульд оролцох нь иргэний үүрэг биш эрх болсонтой, төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрийн намуудад итгэх итгэл буурч байгаа зэрэг хүчин зүйлтэй холбон тайлбарладаг.

Сонгогчдын ирцийг тоон болон хувьчилсан үзүүлэлтээр гаргахаас гадна нас, хүйс зэрэг үзүүлэлтээр шинжилж, харьцуулах нь танин мэдэхүйн болон шинжлэх ухааны судалгааны чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл энэ нь сонгогчдын ирцтэй холбоотой үндсэн асуудлууд, нөлөөлөгч хүчин зүйлс, бэрхшээл зэргийг илрүүлэх замаар ирцийг тогтвортой байлгах, эсвэл нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоход чухал нөлөөтэй.


- **Нас.** Сонгогчдын насны тухай мэдээллийг ил тод нарийвчлалтай болгох шаардлага үүсдэг тул Монгол Улс 2016, 2020 онуудад сонгогчдын ирцийг 18-25 нас, 26-35 нас, 36-45 нас, 46-55 нас, 55-аас дээш нас гэсэн 5 бүлэгт хувааж байсан. Харин 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар сонгогчдын ирцийн мэдээллийг нийт 12 бүлгээр задлан харуулдаг болсон. (<https://turnout.gec.gov.mn/>) Сонгогчдын нас ахих тусам сонгуулийн ирц өндөр болдог гэж үздэг ба 2021 оны сонгуулийн үр дүнг харахад 20 ба түүнээс дээш насны сонгогчдын нас ахих тусам ирц нь нэмэгдэж байна. Харин 18-19 настай сонгогчдын ирц бусад залуу сонгогчдын ирцээс илүү байна. (Хүснэгт 1)
- **Хүйс.** Сонгогчдын ирц дэх жендэрийн ялгааны тухай асуудлыг судлаачид олон талаас нь судлан эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдээс илүү байдаг талаар хэд хэдэн судалгааны үр дүн гарсан байдаг (CAWP 2015; Abdurashid 2016). Монголд ч дээрхтэй ойролцоо үр дүн гарч байгаа нь сүүлийн үеийн сонгуулиудаас харагдаж байна. Жишээ нь: 2016 оны сонгуульд эрэгтэйчүүдийн 70,6%, эмэгтэйчүүдийн 76,6% оролцсон бол 2021 онд эрэгтэйчүүд 55,6%, эмэгтэйчүүд 62,83% оролцжээ. Энэ нь 2012 оны УИХ-ын сонгогчдын ирцээр нотлогддог. Насны бүлэг ахих тусам эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 17 хувиар илүү оролцож байсан.

Залуу сонгогчдын ирц

2021 оны байдлаар Монгол Улсад сонгуулийн насны 2041985 иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд түүний 44% - ийг 18-34 насны залуучууд эзэлж байна.(1212.mn) Энэ нь залуучуудын үүрэг, байр суурь сонгуульд хэр ач холбогдолтойг харуулж байгаа хэрэг юм.


Гэтэл сонгуулийн насны иргэдээс хамгийн их хувь эзэлдэг залуучуудын ирц хангалтгүй байгааг дараах судалгаанаас харж болно. (Зураг 3)

Зураг 2. 18 – 35 насны залуучуудын сонгуулийн оролцоо (2012 - 2021)



Дэлхийн бусад улс орнуудын хувьд ч залуу сонгогчдын оролцоо санаа зовоосон асуудал байсаар иржээ. Жишээ нь: АНУ гэхэд 1972 оноос хойш 18 настай иргэн санал өгч эхэлсэн бөгөөд 18-35 насны залуучуудын сонгуулийн ирц 1996 онд 39,6% болж хамгийн бага түвшинд хүрсэн бол 1972, 2020 онд 55% болж хамгийн өндөр түвшинд хүрчээ. Их Британи 2001 онд 42,7%, 2005 онд 42,5% байсан бол 2009 оноос бага зэргээр нэмэгдэж байна. Румын, Польш зэрэг посткоммунист орнуудын хувьд ч залуучуудын ирц 50% орчим л байна.

Зураг 3. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль ба залуучуудын ирц



2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн залуу сонгогчдын ирц (18-34 нас) – тэй холбоотой зарим дүгнэлтүүд:

- 18-34 насны сонгогчдын ирц 50,13% байна. Энэ нь 35 ба түүнээс дээш насны сонгогчдын ирцээс 8,3% - иар бага байна. Мөн энэхүү сонгуулийн хамгийн өндөр ирц болох 65-69 насны сонгогчдын ирц (76.99%) – ээс 26,86% - иар бага үзүүлэлт болж байна.
- Залуу сонгогчдын ирцийг насны ангилал тус бүрээр нь авч үзвэл улсын дундаж (59,35%) – аас 5,31% - 15,63% - иар бага байна.
- Залуучуудын насны ангилалаас 18-19 насны сонгогчдын ирц 56,45% бөгөөд энэ нь улсын дундаж (59,35%) – аас 2,9% доогуур үзүүлэлт юм.
- Улсын дундаж (59,35%) - аас дээгүүр үзүүлэлт Улаанбаатар (18-19 нас), Хэнтий (30-34 нас), Сүхбаатар (30-34 нас), Орхон (18-19 нас), Дорноговь (18-19 нас) гэсэн 5 аймагт байна.
- Булган аймгийн 20-24 насны сонгогчдын ирц 29,52%, Сэлэнгэ аймгийн 20-24 насны сонгогчдын ирц 30,25% байгаа нь хамгийн бага үзүүлэлт болсон бол Улаанбаатар хотын 18-19 насны сонгогчдын ирц 63,63%, Орхон аймгийн 18-19 насны сонгогчдын ирц 61,93% байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Залуу сонгогчдын ирцэд нөлөөлөгч хүчин зүйлс

Сонгогчид сонгуулийн өдөр саналаа өгөх шийдвэр гарган оролцоход олон хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд энэ нь нарийн төвөгтэй асуудал учир судлаачид олон талаас нь удаан хугацааны туршид судалсаар ирсэн байдаг (Blais and Dobrzynska 1998; Geys 2006; Abdurashid 2016). Залуу сонгогчдын ирцэд нөлөөлөгч хүчин зүйлийг гаргахдаа сонгогчдын ирцэд нөлөөлдөг ерөнхий хүчин зүйлст тулгуурлан залуучуудын жишээ баримтаар баяжуулан гаргахыг зорьлоо. (International IDEA 2006)

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс

Хүн амын тоо. Цөөн хүн амтай орнуудад санал тус бүрийн нөлөө илүү их байдаг тул сонгуульд олон хүн саналаа өгөхөөр ирдэг гэж үздэг. 2021 оны сонгуульд 100 мянгаас дээш хүн амтай 7-н аймгийн 6 нь залуучуудын дундаж (50,13%) – аас бага үзүүлэлттэй байна. (Хүснэгт 1)

Хүн амын тогтвортой байдал. Нэг газарт удаан хугацаагаар оршин суудаг хүмүүс ихэвчлэн орон нутгийн асуудал, нэр дэвшигчдийн талаар илүү сайн мэдлэгтэй байдаг бөгөөд тэдний өдөр тутмын амьдралд нөлөөлөх улс төрийн шийдвэрт илүү их санаа зовдог. Тиймээс тэд сонгуульд санал өгөх магадлал өндөр байдаг. Нөгөө талаар нэг газраас нөгөөд ойр ойрхон нүүдэллэх нь хүмүүсийн улс төрийн үйл явцад оролцох хүслийг бууруулж болзошгүй юм. 2021 оны сонгуулиар 20-24 насны сонгогчдын ирц хамгийн бага 43,72% байсан ба 15 аймагт тэдний ирц 40% - иас доош байна. (Хүснэгт 1) Монголд байгаа 148,4 мянган оюутны ихэнх нь дээрх насныхан байгаа, хөдөө орон нутагт ажлын байр хомс, төв суурин газар түр хугацаагаар амьдрах, ажиллах сонирхол зэрэг нь тэдгээр насныхан нэг газраа тогтвортой байх боломжийг бууруулж энэ нь саналаа өгөхөд сөргөөр нөлөөлж байж болно.

Эдийн засгийн хөгжил. Өндөр хөгжилтэй орнуудад хүмүүс илүү их мэдээлэлтэй, улс төрийн үйл явцад оролцдог гэсэн нийтлэг ойлголт байдаг бол эдийн засгийн бэрхшээл нь сонгогчдын хайхрамжгүй байдлыг үүсгэж, хүмүүсийг улс төрөөс холдоход хүргэж, үндсэн хэрэгцээгээ хангахад анхаарлаа төвлөрүүлдэг тул эдийн засгийн бэрхшээл нь улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг. Нэг хүнд ногдох ДНБ – ний хэмжээгээр улсын дундаж (11680 төг) – тай ижил буюу илүү байгаа 4-н аймгийн залуу сонгогчдын ирцийг авч үзэхэд улсын дундаж (50,13%) – аас дээгүүр үзүүлэлттэй нь Улаанбаатар хотын залуу сонгогчид байна. 2020 оны өрсөлдөх чадварын үнэлгээгээр эхний 3-т орж байгаа аймгуудаас Дорноговь аймгийн залуучуудын ирц дундажаас илүү, Орхон, Дархан-Уул аймгийн залуучуудын ирц 0,68% - 7,88% бага байна. Энэ нь эдийн засгийн чадавх, сонгогчдын ирцийн хамаарлыг илүү нарийвчилан судлах ёстойг харуулж байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Сонгогчдын ирц ба нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлт

№	Аймгууд	2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль						Хүн ам	1 хүнд ногдох ДНБ 2019	Өрсөлдөх чадвар 2020
		Нийт ирц	18-19 нас	20-24 нас	25-29 нас	30-34 нас	18-34 нас			
1	Архангай	55.80 %	41.41 %	31.62 %	39.95 %	53.02 %	41,50 %	95067	5875	XVI I
2	Баян-Өлгий	58.69 %	50.91 %	45.89 %	45.97 %	56.19 %	49,74 %	105853	3946	XIII

3	Баянхонгор	55.91 %	49.47 %	36.52 %	43.98 %	52.87 %	45,71 %	89329	5636	XIX
4	Булган	56.14 %	43.06 %	29.52 %	35.93 %	45.73 %	38,56 %	61516	5867	XXI
5	Говь-Алтай	57.77 %	50.35 %	34.93 %	40.32 %	55.14 %	45,19 %	88974	5882	XX
6	Говьсүмбэр	61.14 %	55.60 %	42.33 %	48.91 %	58.51 %	51,33 %	18008	6463	V
7	Дархан-Уул	55.95 %	55.69 %	37.47 %	38.61 %	49.25 %	42,25 %	103580	5499	III
8	Дорноговь	60.97 %	60.53 %	46.18 %	49.61 %	57.01 %	53,33 %	71233	5840	II
9	Дорнод	55.69 %	57.56 %	35.03 %	41.12 %	49.24 %	45,73 %	83473	11446	VIII
10	Дундговь	53.29 %	47.15 %	33.18 %	39.58 %	46.94 %	41,71 %	47274	8199	XVI
11	Завхан	61.10 %	55.58 %	38.73 %	44.25 %	56.39 %	48,73 %	73231	5785	XVI II
12	Өвөрхангай	55.80 %	48.66 %	34.43 %	39.72 %	52.20 %	43,75 %	116785	5286	VII
13	Өмнөговь	52.66 %	52.40 %	38.15 %	40.05 %	45.76 %	44,09 %	71248	11870	IV
14	Орхон	58.93 %	61.93 %	39.44 %	44.14 %	52.29 %	49,45 %	105361	20316	I
15	Сүхбаатар	64.75 %	59.20 %	42.91 %	50.13 %	60.65 %	53,22 %	64307	8574	X
16	Сэлэнгэ	51.17 %	47.45 %	30.25 %	33.79 %	43.47 %	38,74 %	108370	7398	IX
17	Төв	54.50 %	48.34 %	33.20 %	36.72 %	47.05 %	41,32 %	93332	7241	XV
18	Увс	58.75 %	51.09 %	39.43 %	43.99 %	58.48 %	48,24 %	84294	5019	VI
19	Ховд	60.65 %	55.68 %	42.86 %	44.92 %	57.75 %	50,30 %	88974	4461	XI
20	Хөвсгөл	55.89 %	48.89 %	35.98 %	41.14 %	50.12 %	44,03 %	136058	5348	XIV
21	Хэнтий	63.75 %	58.44 %	42.33 %	47.15 %	59.45 %	51,84 %	78507	6491	XII
22	Улаанбаатар	61.75 %	63.63 %	54.08 %	51.68 %	55.72 %	56,27 %	1499140	16960	
	Нийт	59.35 %	56.45 %	43.72 %	46.32 %	54.04 %	50,13 %	3357542	11680	

Улс төрийн хүчин зүйлс

Улс төрийн бодлого, зорилт. Сонгуульд оролцож байгаа нам эвсэл, нэр дэвшигчид сонгогчдын тодорхой хэсгийн дэмжлэгийг авахаар, тэдэнд ашигтай, сонгуульд оролцох сэдэл төрүүлсэн бодлого зорилтыг дэвшүүлэх нь сонгогчдын оролцоонд нөлөөлдөг гэж үздэг.

Улс төрийн институцид итгэх итгэл. Ерөнхийлөгч, УИХ, ИТХ зэрэг иргэд өөрсдөө сонгодог улс төрийн институциас гадна бусад төрийн байгууллагад итгэх итгэл сул байх нь

сонгогчдын ирцэд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал: 2016 онд КАС, УА “Залуучуудын улс төрийн оролцоо /18-35 нас/” судалгааны тайланд сонгуульд санал өгч байгаагүй залуучуудын 17,9% нь насанд хүрээгүй байсан бол үлдсэн 80% гаруй нь итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, улс төрд итгэдэггүй, улс төр сонирхдоггүй учир оролцдоггүй гэж ихэнх нь хариулсан байна. 2020 онд БНОУХ, IRIM “Залуучуудын санал бодлын судалгаа” -д “Аливаа улсын хувьд ардчиллыг бий болгоход сонгууль чөлөөтэй, шударга явагдаж бодит сонголтыг өгөх нь чухал” гэдгийг залуучуудын 98% нь зөв гэж үзсэн ч улс төрийн намуудад 60% сөрөг, УИХ-д 56% сөрөг, ИНБ -д 64% эерэг үнэлгээ өгсөн байна.

Сонголт хийх боломж. Сонгуульд өрсөлдөх нам эвсэл, нэр дэвшигчдийн тоо болон сонголт хийх боломж өргөн байх нь сонгогчдын ирцэд эерэгээр, бага байх нь сөргөөр нөлөөлдөг байна.

Тогтолцооны хүчин зүйлс

Сонгуулийн тогтолцоо. Сонгуулийн пропорциональ тогтолцоог ашигладаг сонгуульд сонгогчдын ирц мажоритар системийг ашигладаг сонгуулиудаас илүү өндөр байдаг.

Албадан санал хураалт. Мэдээжийн хэрэг сонгогчид хуулийн дагуу санал өгөх үүрэг хүлээсэн тохиолдолд ирц эрс нэмэгддэг.

Зэрэгцээ сонгууль. Нэг өдөр хэд хэдэн сонгууль болоход сонгогчдын ирц ихэвчлэн өндөр байдаг.

Санал хураалтын зохион байгуулалт. Санал хураалтын янз бүрийн зохион байгуулалтын загвар нь сонгогчдын ирцэд нөлөөлж болно. Үүнд санал өгөх өдөр, амралтын эсвэл ажлын өдрүүдэд явагдах сонгууль, санал өгөх технологийн боломж, санал авах байрны байршил, урьдчилсан санал хураалт, шуудангаар болон цахимаар санал өгөх, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр санал өгөх зэрэг олон асуудлууд нөлөөлж болно. 2021 оны сонгуулийн хувьд улс нэг тойрог гэсэн зарчмаар явагдсан хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 24-р зүйлд зааснаар өөрийн үндсэн харьяаллаас өөр газар сонгууль өгөхөөр бол шилжилт хийх тухай заасан нь олон залуу сонгогчдыг сонгууль өгөх боломжгүй болгоход нөлөөлсөн байж болно.

Хувь хүний хүчин зүйл

Нас. Нас бол сонгогчдын ирцэд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Монголын залуу сонгогчдын ирц тухайн жилийн сонгуулийнхаа дундажаас 2012 онд 26,2%, 2016 онд 22,8%, 2020 онд 9,6%, 2021 онд 8,2% доогуур байсан нь нас ахих тусам сонгогчдын оролцоо нэмэгддэг олон улсын зүй тогтолтой ижил үр дүнг харуулж байна.

Боловсрол. Боловсролын түвшин өндөр байх нь ерөнхийдөө сонгогчдын ирц өндөр байгаатай холбоотой байж ч зарим судалгаагаар энэхүү үр дүн өөр байх тохиолдлууд байна (International IDEA 2006).

Улс төрийн боловсрол. Улс төрийг сонирхох нь сонгуулийн ирцэд нөлөөлөх чухал хүчин зүйл байж болно. Сургууль болон залуучуудын дунд иргэний боловсролыг олгохдоо улс төрийн үйл явцыг сонирхох сонирхлыг хөхиүлэн дэмжиж, нийгэм, улс төрийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн, сургалт, семинар зохион байгуулах зэргээр улс төрийн боловсролыг нэмэгдүүлэх боломжтой.

Иргэний үүрэг. Иргэний үүргийн тухай ойлголт нь сонгуульд санал өгөх хандлагад нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Олон хүмүүс улс төрийн шийдвэр гаргахад хувь нэмэр оруулах нь тэдний үүрэг гэж ойлгодог. Тухайлбал энэ нь анх

сонгуулийн насанд хүрч буй залуучуудад илүү ажиглагддаг. Жишээ нь: 2021 оны сонгуулиар 18-19 насны сонгогчдын ирц 20-24 насны сонгогчдоос 12,73%, 25-29 насны сонгогчдоос 10,13%, 30-34 насны сонгогчдоос 2,41% - иар тус тус их байна.

Дүгнэлт

Л.Даймонд “Сонгогчдын оролцоо бага байгаа нь ардчиллын дархлаа сул байгаагийн шинж” гэсэн нь сонгууль ардчилал, түүний хөгжилд хэр ач холбогдолтойг нотолж буй хэрэг юм гэсэн байдаг.

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон 18-35 насны залуучуудын ирц 2016 оныхоос ялимгүй буюу 0,7% - иар буурсан бол 2020 оны (18-25 нас) ирцээс 11,1%-иар доогуур байгаа нь нэг талаас цар тахлын шууд нөлөө, нөгөө талаас улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, тогтолцооны, хувь хүний гэсэн үндсэн хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Сонгогчдын ирцэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах нь нарийн төвөгтэй, цаг хугацаа шаардсан, тухайн улсын нийгэм улс төрийн тогтолцоо, нийгмийн байдал зэрэг олон зүйлтэй хамааралтай учир цаашид нарийвчилан судлах шаардлагатай.

Монголын сонгуулийн насны иргэдийн 44% - ийг эзэлдэг 18-35 насны залуучуудын сонгуулийн оролцоо хангалтгүй буюу хоёр хүний нэг нь л сонгуульд оролцож байгаа нь энэхүү асуудалд анхаарах хэрэгтэй болсны дохио юм.

Залуу сонгогчдын ирцийг нэмэгдүүлэхийн тулд дараах арга замыг ашиглах хэрэгтэй. Үүнд:

- Эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Сонгуулийн хууль тогтоомжид урьдчилан санал өгөх, шуудангаар санал өгөх гэх мэт хэлбэрүүдийг нэмэх, боловсронгуй болгох, Ерөнхийлөгчийн сонгуулийн үед шилжилт хөдөлгөөн хийхгүйгээр байгаа газраа саналаа өгөх боломжийг сонгогчдод олгох гэх мэт.
- Мэдээллээр хангах. Сонгогчид тэр дундаа залуучуудад зориулсан сонгуулийн ач холбогдол, сонголт хийхийн давуу тал, үр өгөөж, сонгууль өгөх заавар, зөвлөмж зэргийг мэдээллийн төрөл бүрийн сувгийг ашиглан түгээдэг байх
- Залуучуудад улс төрийн боловсрол /иргэний боловсрол/ олгох тогтолцоог бий болгох, боловсронгуй болгох.

Abstract:

In the words of L. Diamond, "Low participation of voters means weak immunity for democracy," underscoring the crucial role of elections in fostering democratic development. This paper explores the dynamics of voter turnout in Mongolia, focusing on the example of the youth demographic.

The 2021 presidential election witnessed a marginal decrease of 0.7% in turnout among 18-35-year-olds compared to the 2016 election, and a more substantial drop of 11.1% from the 2020 turnout (ages 18-25). This decline can be attributed, in part, to the direct social impact of the pandemic, while various other factors, including political, social, economic, systemic, and individual influences, have played a role in shaping voter participation.

Investigating the intricacies of the factors affecting voter turnout requires specialised efforts due to the time-consuming and meticulous nature of the process. Such endeavours involve a comprehensive examination of the country's socio-political system and the prevailing social conditions. Notably, the turnout of young people aged 18-35, who make up 44% of Mongolia's voting-age population, is disheartening. The fact that only half of this demographic engages in the electoral process signals a significant issue that demands attention and resolution. Addressing this challenge is imperative for strengthening the democratic fabric of Mongolia.

Keywords: voter turnout, democracy, youth demographic, election participation, Mongolian politics, socio-economic influences

Ашигласан ном, материал

1. N. Derksen, F. M. Falconi, S. Jayme, C. Worsech. 2018. Increasing Youth Voter Turnout.
2. A. Solijionov. 2016. Voter turnout trends around the world. International IDEA.
3. F. M. Robertson. 2009. A Study of Youth Political Participation in Poland and Romania.
4. Youth Voter Participation. 1999. International IDEA.
5. Mason, David S. 2003/04. "Fairness Matters: Equity and the Transition to Democracy." World Policy Journal 20 (4): 48–56
6. Kobach, Kris. 2001. "Lessons Learned in the Participation Game." In Direct Democracy: The Eastern and Central European Experience, ed. Andreas Auer and Michael Butzer. Burlington, VT: Ashgate Publishing, 292–309.
7. Krastev, Ivan. 2002. "The Balkans: Democracy without Choices." Journal of Democracy 13 (3): 39–53
8. БНУУХ, ИРИМ. 2020. Залуучуудын санал бодлын судалгаа.
9. КАС, УА. 2016. Залуучуудын улс төрийн оролцоо /18-35 нас/.
10. <https://turnout.gec.gov.mn/>
11. www.1212.mn

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 119-131 дэх тал

**МОНГОЛ, ХЯТАД, ОРОСЫН ГЕОПОЛИТИКИЙН ҮНДЭС СУУРЬ, ЦААШДЫН
ЧИГ ХАНДЛАГА**

Д.Түмэнжаргал
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

А.Отгонням
Жилин Их сургуулийн Зүүн хойд Ази судлалын
хүрээлэнгийн докторант

Sebule
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Сүүлийн жилүүдэд ашиг сонирхолдоо хөтлөгдөн дэлхийн улс төр, эдийн засгийн бүтцэд гарсан өөрчлөлт, Сирийн дайн, Хятад-Америкийн худалдааны дайн, Орос-Украины дайн, Япон, Өмнөд Солонгос бие биедээ хориг арга хэмжээ авч, томоохон улс орнууд нэгдэж эхэлсэн. Гадаад орчны өөрчлөлтийн өмнө Монгол Улс өөрийн ашиг сонирхлоо энэ тэргүүнд тавьж, Хятад, Оростой харилцах харилцаагаа газар зүйн байрлалдаа тулгуурлан зохицуулдаг. Энэхүү өгүүлэлд Монгол улсын геополитикийн онцлог, БНХАУ-ын хөгжлийн Монгол дахь нөлөө, ОХУ-ын Монгол дахь нөлөө, Монгол Улсын Орос, Хятадын хоорондын тэнцвэрт байдал, Монгол-Хятад-Оросын эдийн засгийн бүтээн байгуулалт зэрэг таван асуудалд анхаарлаа хандуулсан болно.

Түлхүүр үгс: Геополитикийн доорх коридор. Монгол, Хятад, Оросын геополитикийн шинжилгээ.

Монгол, Орос, Хятад гурван улс нь газар зүйн үүднээс авч үзвэл хил залгаа хөрш орнууд юм. Монгол, Оросын хилийн шугамын урт 3485 км бол Монгол, Хятадын хилийн шугамын урт 4700 км орчим байдаг. Монгол, Хятадын хил дэлхийн бусад улсын хилээс хамгийн урт нь юм. Монгол Улс нь Хятад, Орос хоёр улсын дунд оршноор газар зүйн байршлын хувьд хоёр том зах зээлийн дунд бөгөөд Монголын зам тээврийн салбарт ихээхэн ач холбогдолтой байдаг.

1990-ээд онд ЗХУ задран унасан нь олон улсын хамтын нийгэмлэгт томоохон нөлөө үзүүлж, янз бүрийн улс орон, ялангуяа ЗХУ-ын янз бүрийн улсууд болон хөрш зэргэлдээ орнуудын дипломат харилцаанд гүн гүнзгий өөрчлөлтүүд гарч эхэлсэн. ЗХУ-аас хараат байхаа больж, бие даасан гадаад бодлогоо аажмаар бий болгож, бие даасан дипломат харилцааны замд орж эхэлсэн. ЗХУ задран унасны дараа Монголд томоохон өөрчлөлтүүд гарч, эдийн засгийн хувьд зах зээлийн эдийн засгийн тогтолцоо хэрэгжиж, улс төрийн хувьд ардчилал, хүний эрхийн хөгжлийн гарцыг судалж, олон тулгуурт, нээлттэй, гадаад бодлого хэрэгжүүлж эхэлсэн.

1. Монгол Улсын геополитикийн онцлог

Монгол Улс далайд гарцгүй орны хувьд газар зүйн өвөрмөц онцлогоосоо шалтгаалж эх газрын өвөрмөц уур амьсгалтай буюу 1580 метрийн өндөрт өргөгдсөн бүс нутаг, энэ цаг уурын хамгийн тод онцлог нь температурын зөрүүтэй дөрвөн улиралтай. Монгол Улсын геополитикийн онцлогийг бүхэлд нь дараах гурван зүйлд нэгтгэн дүгнэж болно.

(1) *Монгол улс бол далайд гарцгүй орон.* Монгол орон өргөн уудам газар нутагтай ч далайд гарцгүй. Геополитикийн өргөрөгөөс харахад Монгол Улс Зүүн хойд Ази гэж хуваагддаг. Газарзүйн өвөрмөц онцлог нь Монгол Улсыг эдийн засгийн хувьд харьцангуй таагүй байдалд оруулдаг. Дипломатч Л.Эрдэнчулуун нэгэн үе Монголд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэрээр хэлэхдээ: Газар нутаг том, хүн амын тоо цөөхөн, эдийн засаг нь шилжилтийн шатандаа яваа, дэд бүтцийн бүтээн байгуулалтын үр хөврөлийн хэлбэр бүхий дэлхийн бүх улс орон дөнгөж бүрэлдэн тогтсон. Энэхүү газар зүйн өвөрмөц онцлог нь Монголыг удаан хугацаанд таагүй байдалд оруулдаг¹.

(2) *Монгол улс өргөн уудам газар нутагтай, хүн ам сийрэг суурьшсан.* 2018 онд Монгол Улсын хүн ам 3.12 сая гаруй, улсын дундаж нягтрал нэг ам.км-д 2.00 хүн байгаа нь дэлхийн хамгийн доод түвшин² байна. Хүн амын тоо, хүн амын насны бүтэц нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл юм. Хүн амын тоо нь ажиллах хүчний хөгжлийн үндсэн баталгаа болдог нь эдийн засгийн хөгжлийн аливаа үйл явцыг хөдөлмөрийн баазаар баталгаажуулах шаардлагатай болгодог. Учир нь хүн амын өсөлт нь эдийн засгийн эрч хүчийг хадгалах чухал нөхцөл болдог. Монгол Улсын хүн амын тархалт харьцангуй тархай бутархай, голчлон Улаанбаатар хотод хүн ам нь нягтаршиж, эдийн засгийн бүсүүд төвлөрсөн. Харин алслагдсан бүс нутагт эдийн засгийн хөгжил буурай, хүн амын нягтаршил багатайгаас болж эдийн засгийн хөгжлийг хангалттай хангаж чадахгүй, хүн амын аюулгүй байдал, хөгжлийн хангалттай түүчээлж чаддаггүй. Түүнчлэн хүн амын хомсдол нь Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй бас нэг чухал хүчин зүйл бөгөөд ХХI зууны эхэн үеэс Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт дөнгөж 1.5 орчим хувьтай байгаа нь сүүлийн жилүүдэд ажиллах хүчний хомсдолд орсоор байгааг харуулж байна. Мөн Монгол Улсад хүн амын хөгшрөлтийн асуудал нэлээд хурцаар тавигдаж, нийгэм, эдийн засагт хүнд дарамт учруулж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд нөлөөлж байна.

(3) *Монгол бол шилжилтийн үеийн улс бөгөөд улс төрийн автономит эрхтэй.* Монгол Улс төвийг сахисан орны хувьд Хятад, Орос улстай стратегийн хувьд зохицонгуй хөгжлийн харилцаатай байхаас гадна аль нэг улсын улс төрийн нөхцөл байдалд орохгүй байхыг анхаардаг. өртсөн Монгол Улс улс төрийн автономит эрхтэй, хэн нэгний нөлөөнд автахгүй байх ёстой. Хөрш орнуудын нөлөө, ноёрхол. Монгол Улсын нэрт дипломатч Эрдэнэчулуун “Олон улсын харилцаанд жижиг, сул дорой орнуудын тэмцэл нь тэдний мэдлэг, урсац бүрдээгүй усны урсгалыг жолоодох чадвараас ихээхэн шалтгаалдаг. Жижиг, сул дорой орнууд геополитикт илүү ихээр өртдөг. Иймд жижиг улсын гадаад бодлого нь ажиглалт, дүн шинжилгээ, хураангуй гэсэн хэд хэдэн зорилгод хүрэх ёстой³. ”Зүүн хойд Азийн бүх улс орнуудын дунд Монгол Улс одоогийн байдлаар улсынхаа зөөлөн хүчний хувьд ч, хатуу хүчний хувьд ч харьцангуй хоцрогдсон байдаг. Гэвч Монгол Улс улс төрийн хувьд төвийг сахисан, аль ч улсын эсрэг түрэмгийлэлд оролцдоггүй учраас дэлхийн аль ч улстай найрсаг харилцаатай байгаа нь ардчилсан шинэчлэлийн зангилаа бүрт дэлхийн бүх улс орнууд Монгол Улсад өндөр дэмжлэг үзүүлж байгаа нь дамжиггүй. Энэ нь Монгол Улсын томоохон давуу тал юм.

2. Хятадын хөгжлийн Монголд үзүүлэх нөлөө

Улс төрийн нөлөө. Хятадын эдийн засаг хурдацтай хөгжиж, олон улсын хамтын нийгэмлэгт тасралтгүй дээшилсээр байгаа энэ үед Азийн орнууд Хятадын хөгжилд янз бүрийн хариу үйлдэл үзүүлэх нь Хятадын хөгжлийн явцад тулгарах ёстой асуудал юм. Монгол Улс БНХАУ-тай хиллэдэг хөрш орны хувьд түүхэндээ хоёр орны харилцаанд

¹ 朱金春.地缘安全视野下的跨界民族认同意识研究——以二连浩特出境蒙古族为例[R].中央民族大学, 2009:78.

² Договор о дружественных отношениях и сотрудничестве междуРоссийской Федерацией и Монголией Дипломатический вестник [J]. 2003, 4.

³ Московскаядекларация[J].2018.№03.12.

саарал үе байсан өнөө үед харилцаа нэгэнт сайжирсан. Тухайлбал 2011 онд тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд БНХАУ-д төрийн айлчлал хийж, хоёр улс улс төр, соёл, бусад чиглэлээр олон тооны хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан цагаас хоёр улсын улс төрийн харилцаа анхны харилцан итгэлцлийн харилцаанаас стратегийн түншлэлийн харилцаанд шилжсэн юм. Мөн 2014 онд БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол улсад айлчилж, хоёр орны харилцааг дахин өргөжүүлэн хөгжүүлж, хоёр орны харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хэмээн тодорхойлсон нь ахиц дэвшил, нээлт болсон. БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилга 2018 оноос эхэлснээс хойш Монгол Улс “Нэг бүс нэг зам” стратегид түшиглэн Монгол Улсын “Хөгжлийн зам”-ыг дэвшүүлсэн зэрэг нь Монгол Улсын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх эхлэл болсон.

Монголын төр засгийн удирдагчдын баталсан өөр нэг чухал дипломат стратеги бол хөрш орнуудтай харилцах харилцааг зохицуулах, тэнцвэржүүлэхэд ашигладаг “гуравдагч хөршийн бодлого” боловч үр дүн нь тийм ч таатай биш байна⁴. АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй зарим капиталист орнууд Монгол Улсын эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх гэсэн далбаан дор Монголын дотоод уур амьсгалыг эвдрэлцүүлж, үндэсний аюулгүй байдалд заналхийлэх зорилго агуулдаг. АНУ Монголд орж ирэх боломжийг ашиглан Монголын ардчиллын хөгжлийн үйл явцыг бүх талаар ахиулж, улмаар Монголоор дамжуулан Хятадад хориг тавих, нөлөө үзүүлэх, Хятадын ард түмнийг эсрэг байлгахыг хичээдэг. Япон улс Монголд тусламж үзүүлж улс орныхоо эдийн засгийн хөгжлийг шалтаг болгон Монголын янз бүрийн салбарт нэвтэрч, олноор бааз байгуулж, томоохон хөрөнгө оруулалт хийж, нийгэм, байгалийн баялгаараа Хятадтай өрсөлдөхийг хүсч байдаг. Үүний зэрэгцээ Монгол Улсад, АНУ-ын Зүүн хойд Ази дахь цөм бүсийг байгуулахад АНУ-тай хамтран ажиллаж, Орос, Хятад хоёрыг хоёуланг нь агуулж, улмаар Хятад улстай үүссэн арлын харьцангуй хурцадмал дипломат харилцааг намжаах боломжийг эрэхийлж байдаг.

Өнөөгийн өнцгөөс харвал, Монгол улсын гуравдагч хөршийн стратегийн хөгжил илүү өргөн цар хүрээтэй, гүн гүнзгий болж, Хятадтай харилцах харилцааг тодорхой хэмжээгээр хязгаарлах нөлөөг аажмаар бүрдүүлж байна. Монгол Улсын Хятад улсад нөлөөлж буй гуравдагч хөршийн бодлогын улмаас Хятад улс аажмаар Монгол улсад үл итгэх, эргэлзэх хандлагатай болж байгаа юм. Монгол Улс Хятадыг гуравдагч орныг ашиглан хязгаарлахыг Хятад улс эсэргүүцэж байна. Хятадын түгшүүрийг арилгахын тулд Монгол улс эргэлзээг арилгах хэрэгтэй байна. Тухайлбал хоёр орны улс төрийн итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ авч, харилцан хүндэтгэж, сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэхийг нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Одоогийн байдлаар хоёр орны харилцан солилцоонд тулгараад байгаа хамгийн том саад бэрхшээл бол түүхэн асуудлаарх өөрсдийн үзэл бодол бөгөөд энэ саадыг хэрхэн даван туулах нь хоёр орны удирдагчдын өмнө тулгамдсан чухал асуудал болоод байгаа бөгөөд энэ нь хоёр орны удирдагчдаас ч мөн адил чухал асуудал болоод байна.

Хятадын хувьд сайн хөршийн, энх тайвны гадаад бодлогыг үргэлж баримталж ирсэн бөгөөд хөршүүдийнхээ хувьд түншийн хувьд хөрш байж, хөршүүдтэйгээ найрсаг байж, хөршүүдтэйгээ найрсаг харилцаагаа хөгжүүлж, хөршүүдтэйгээ найрсаг харилцаатай байх ёстой гэдэгт хатуу итгэж байна. Монгол, Хятад хоёр бие биедээ итгэж, харилцан дэмжиж, энх тайвнаар зэрэгцэн орших, хамтдаа хөгжих ёстой. Монголын хувьд түүхийн асуудал ард түмнийг ардчилсан улс төрийн амьдралыг хүсэн тэмүүлж байгаа ч нүүдэлчин амьдралын үзэл санаа нь гүн үндэстэй учраас ардчилсан улс төрд өрөөсгөл ханддаг, улс төрд баригдахыг хүсдэггүй, бүтээн байгуулалтад хүндрэлтэй байдаг. Харилцан итгэлцсэн харилцаа, бие биедээ эргэлзэх, оновчтой, зөв дүгнэлт, таамаглал гаргахад хүндрэлтэй байгаа нь Монгол улсад ч мөн адил эргэлзээ, олон улсын солилцоонд үл итгэх байдалд хүргэсэн. Иймээс Монгол, Хятадын түүхэн харилцаанд харилцан хардах, хардлагаас гарахад хэцүү байсан нь Монгол, Хятадын хөгжилд саад тотгор учруулсаар байгаа юм.

⁴ 蒙中全面战略伙伴关系的进程、挑战及机遇[C], 学术研讨会论文集·乌兰巴托·2015年.

Аюулгүй байдлын нөлөө. 2011 онд Монгол улс, БНХАУ хамтран хоёр орны хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай мэдэгдэл гаргаж, бие биенийхээ эсрэг улс төрийн эвсэлд хэзээ ч оролцохгүй, гуравдагч оронтой хэзээ ч харилцаанд орохгүй гэдгээ амласан⁵. Гэвч энэ байр суурь алдагдснаар нөгөө улсын аюулгүй байдлыг алдагдуулж байна⁶. 2013 оноос хойш таван жилийн хугацаанд Монгол улс, БНХАУ хоёр талт ажил хэргийн зөвлөлдөх уулзалтыг хэд хэдэн удаа зохион байгуулж, хоёр талын улс төрийн байдал, аюулгүй байдал, улс төрийн харилцаа, цэрэг арми зэрэг асуудлаар гүнзгий ярилцсан нь цэргийн хамтын ажиллагааны чухал тулгуур болсон. Хоёр улсын хооронд хоёр орны хамтын ажиллагааны А платформыг боловсронгуй болгосон. Мөн Монгол, Хятад хоёр улс харилцан олон удаагийн хамтарсан сургуулилт хийж, тактикийн уялдаа холбоо тогтоож, хоёр армийн харилцаа, найрамдлыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны төвшин дээшилсэн юм.

Зүүн хойд Азийн чухал орны нэг болохын хувьд Монгол улс нь Хятад улсыг хүчирхэгжүүлэх тодорхой нөхцлийг бүрдүүлж, Хятадын ойр орчмын бүс нутгийн тогтвортой, амар тайван орчныг бүрдүүлэхэд чухал хүчин зүйл болж байна. Монгол улсын ирээдүйн аюулгүй байдлын хөгжлийн чиг хандлага нь Хятадын үндэсний аюулгүй байдлын стратеги болон эдийн засагт нөлөөлж байна. XXI зуунд орсны дараа Монгол улсын үндэсний аюулгүй байдалд гарсан өөрчлөлтүүд Хятадад төдийгүй хоёр орны харилцаанд шууд нөлөөлж байна.

Зүүн хойд Ази дэлхийн бусад улс орнуудын анхаарлыг татаж, дэлхийн эдийн засгийн хэв маягт улам бүр чухал байр суурийг эзэлсээр байна. Томоохон гүрнүүдийн ашиг сонирхлын өрсөлдөөн байнга өрнөж, бүс нутгийн дэг журам, аюулгүй байдал, улс хоорондын газар нутгийн маргаан, угсаатны хуваагдал болон бусад асуудлууд зэрэг олон улсын болон бүс нутгийн зарим асуудлууд байнга ил гарч байдаг.

Улс төрийн эрх мэдлийн өөрчлөлт, өрсөлдөөн нь нийгэмд нөлөөлж байна. Зүүн хойд Азийн хөгжил, ирээдүйн бүс нутгийн аюулгүй байдал нь Монгол, Хятадын харилцаанд ихээхэн нөлөөлнө. Хятад улс Зүүн хойд Азид хурдацтай хөгжиж, дэлхийн өрсөлдөөнд байр сууриа тасралтгүй дээшлүүлж байгаа нь мөн л Зүүн хойд Азид байдаг Монгол улсыг Хятад улс хөөрөхөөс болж үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нь хохирол учруулах вий гэсэн болгоомжлолыг ихээр төрүүлж байна. Тиймээс гуравдагч этгээдийн эрх мэдлийг ашиглан Хятадыг хянаж, тэнцвэржүүлнэ гэж найдаж байна. Нэг талаас Хятад улс хүчирхэгжинэ гэдэг нь Монгол улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлэх вий гэж болгоомжилж байна. Нөгөө талаараа энэ байгууллагыг бий болгох вий гэж санаа зовж байна. АНУ-тай хамтын ажиллагаатай байх нь улс орны хөгжилд нөлөөлнө. Энэ хэцүү байдалд Монгол улс АНУ, Хятад, Орос гэсэн гурван том эдийн засгийн дунд тохирох байр суурийг хайх хэрэгтэй болно. Энэ гурван том эдийн засагтай сайн хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээ, улс төр, эдийн засгийн хувьд хараат бус байх зэрэг нь Монголын төрд асар том сорилт болж байна.

Эдийн засгийн үр нөлөө. Монгол, Хятадын хамтын ажиллагааны хамгийн чухал тал болох эдийн засгийн харилцаа нь хоёр орны дипломат харилцааг шууд хөгжүүлэх хөдөлгөгч хүч мөн. Хятадын эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр Монгол улстай олон улсын худалдаа тогтмолжиж, хоёр талын импорт, экспортын худалдааны хэмжээ жилээс жилд нэмэгдэж, Монгол, Хятад хоёр тал харилцан ашигтай байх зарчмыг баримталсаар ирсэн.

Ашиг тус. Дэд бүтцийн нөхцлийн хувьд Монгол, Хятадын хил дээр гадаад худалдааны 21 боомт, олон мянган бээрийн урттай авто болон төмөр замын тээврийн шугам байдаг нь Монгол, Хятадын худалдааг хөгжүүлэхэд таатай нөхцөл, материаллаг суурийг

⁵ 申林.蒙古“第三邻国”外交析论[J].当代世界, 2013(4).

⁶ 拉·包勒德.蒙古安全环境及国防政策某些问题[J].战略研究·2013.

бүрдүүлсэн⁷. Хоёр орны газарзүйн өвөрмөц давуу тал болон харьцуулсан давуу талуудын ачаар хоёр орон худалдаанд бие биенээ нөхөж, Монгол, Хятадын худалдааны хамтын ажиллагаа улам бүр нэмэгдсээр 2009 оноос хойш Хятад улс Монголын импорт, экспортын худалдааны хамтын ажиллагааны хамгийн том хөрш орон болсон. Монгол улс БНХАУ-ын нийт гадаад худалдаанд эзлэх хувь нэмэгдэж, хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа ахисаар байна. 2011 онд Монгол, Хятадын харилцаа анхны сайн хөршийн найрсаг харилцаанаас стратегийн хамтын ажиллагааны харилцаанд шилжиж, гурван жилийн дараа Монгол, Хятадын харилцаа шинэ амжилт гаргаж, иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг албан ёсоор тогтоосон. Экспортын худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах нь бодлогын чанартай нөхцлийг бүрдүүлж, хоёр талын эдийн засаг, худалдааны салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлж байна.

2011 онд Хятад улсын ДНБ анх удаа Японыг давж, дэлхийн хоёр дахь том эдийн засагтай, дэлхийн хамгийн том гадаад валютын нөөцтэй орон болж, импорт экспортын худалдааны хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж байна. 2014 онд Хятадын импорт, экспортын худалдааны нийт хэмжээ 500 сая юанийг давж, анх удаагаа АНУ-ыг гүйцэж, дэлхийн анхны томоохон худалдааны орон болсон. Хятадын эдийн засаг хурдацтай өсөхийн хэрээр дэлхийн эдийн засгийн бүтцэд нөлөөлж, Хятадын хөрш орнууд ч өөрийн гэсэн эдийн засгаа хөгжүүлж, давуу талтай болж, бүс нутгийн хөгжилд хүчин чармайлт гаргаж, хувь нэмрээ оруулж байна.

Хоёр улс дипломат харилцаагаа сэргээснээс хойш Монгол улс нь Хятадын хөрш чухал орны хувьд худалдааны хамтын ажиллагаагаа тасралтгүй гүнзгийрүүлсээр ирсэн. 2013-2017 он хүртэлх таван жилийн хугацаанд Хятадын засгийн газраас Монгол Улсад үзүүлсэн эдийн засгийн болон санхүүгийн дэмжлэгийн нийт хэмжээ өмнөх 50 жилийн нийт дүнгээс давсан. Монгол, Хятадын импорт, экспортын худалдааны нийт хэмжээ нэмэгдэж, ялангуяа Монгол Улсаас БНХАУ-д хийх экспортын худалдааны хэмжээ жил ирэх тусам өсөх хандлагатай байна. Монгол Улс, БНХАУ-ын эдийн засаг, худалдааны солилцоо, хамтын ажиллагаа нь зарим гэрээ, хэлэлцээр зэрэгт суурилж, хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны явцад асуудал гарсан тохиолдолд холбогдох газруудыг оролцуулан уулзалт, зөвлөлдөх механизмыг бий болгосон.

Хятадын эдийн засаг урагштай хөгжихийн хэрээр Монгол Улсын эдийн засаг эрчимтэй хөгжиж, Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны цар хүрээ тасралтгүй өргөжиж, хамтын ажиллагааны цар хүрээ үргэлжлэн гүнзгийрч, эдийн засгийн үр өгөөжөө нэмэгдүүлсээр байна. Цаашид хоёр орон харилцан хүндэтгэж, харилцан дэмжин, хамтдаа ашиг хүртэх хамтын ажиллагааны зарчим, удирдамжийн үзэл баримтлалыг баримталж, Зүүн Азийн эдийн засгийн хөгжил цэцэглэлт, хөгжлийг хамтдаа ахиулах болно.

Монгол дахь Оросын нөлөө. ОХУ бол Монголын гол холбоотон байсан бол одоо улс орнуудын дунд ширүүн өрсөлдөөнтэй тулгарч, орос хэлийг аажмаар англи хэлээр сольж, Монголчуудын хамгийн өргөн хэрэглэгддэг гадаад хэл болсон. Энэ нь Монголын уул уурхайн салбарын өсөн нэмэгдэж буй хэсгийг барууны компаниуд хянадагтай холбоотой. Уул уурхайн салбар бол Монгол улсын эдийн засгийн хамгийн чухал хэсэг юм. Монгол улсын уул уурхайн салбарт ноёрхож буй хоёр компанийн гуравны хоёр нь Канад, Британи улсын компаниудынх юм. Австралийн компаниуд Монголын уул уурхайн салбарын томоохон тоглогчид. Канадын уул уурхайн аварга Рио Тинто Монголд нөлөөллөө нэмэгдүүлснээр ЗХУ задран унасны дараа Монголын эдийн засаг дахь Оросын оролцоо эрс буурсан⁸.

1990-ээд он гэхэд Хятад улс Монгол улстай дипломат харилцаа тогтоож, Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэхийн хэрээр Монголын Оростой хийх худалдаа 80

⁷ 任雪娇. 中蒙经贸合作中的蒙方因素实证分析[J]. 经济论坛, 2009(4).

⁸ Nikola Mikovic. Russian Influence in Mongolia is Declining[J]. U.S. Library of Congress ISSN. 2019(2).

орчим хувиар буурсан. ЗХУ-ын үед Монголыг ЗХУ-ын 16 дахь албан бус бүгд найрамдах улс гэж үздэг байсан бөгөөд тус улсын ихэнх хүмүүс орос хэлээр ойлгодог байсан. Өнөө цагт Монголчуудын дунд, тэр дундаа залуучуудын дунд орос хэлтэй хүн ховорхон байна. Орос хэл эдийн засгийн төдийгүй соёлын нөлөөгөө ч алдаж, англи хэл орос хэлийг орлож, олон Монгол залуусын ярьдаг хамгийн түгээмэл гадаад хэл нь англи хэл болсон. Шилжин суурьшилт болон дэлхийн эдийн засагт цаашид нэгдэх хүсэл нь энэхүү өөрлөлтөд нөлөөлж байна. Хэдийгээр Монгол улсын олон сургууль, их, дээд сургуулиуд оюутнууддаа орос хэл заасаар байгаа ч тус улсад Оросын соёлын нөлөө улам бүр буурсаар байна.

Гэвч сүүлийн жилүүдэд Орос улс бүс нутгийн гүрний статусаа сайжруулахын тулд Монгол улстай харилцаагаа сэргээхийг эрмэлзэж байна. ОХУ-ын Засгийн газар Монгол улсын өрийн 88 хувийг тэглэж, Монгол-Хятад-Оросын харилцааг хөгжүүлэх зорилгоор ОХУ-аас Хятад руу нефть дамжуулах хоолойг Монголын нутгаар дайруулах гэрээнд гарын үсэг зурсан. Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулга төрийн эрхэнд гарсны дараа Орос руу дөхөж эхэлсэн. Х.Баттулга орос хэлээр чөлөөтэй ярьдаг бөгөөд тангараг өргөснөөс хойш хэдхэн долоо хоногийн дараа Будапешт (жүдо бөхийн 31 дэх удаагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдах хот) руу явж, Путинтэй уулзсан юм. Хэд хоногийн дараа тэрээр Евразийн нөгөө талд (Дорнын эдийн засгийн форум байрладаг) Владивосток руу явж, Путинтэй дахин уулзахад Х.Баттулгад Путиныг дэлхийн хаана ч харж болно гэсэн сэтгэгдэл төрсөн. Дараа нь 2018 оны 6 дугаар сард Чиндао хотод болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын дээд хэмжээний уулзалтад оролцоходоо, 2018 оны 9 дүгээр сард болсон Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад тэрээр Путинтэй дахин уулзаж, Х.Баттулга Путинтэй дахин уулзсан. Тэр ч бүү хэл Х.Баттулга тэр хоёрын олон нийтийн тэврэлт, инээмсэглэл, эрхий хуруугаараа дүүрэн байсан нь Х.Баттулгын Путинтэй харилцах харилцаа Монголын өмнөх Ерөнхийлөгчид хэзээ ч байгаагүй хувийн шинж чанартай болсныг харуулсан. Х.Баттулга ОХУ-д хандсан илт хандлагыг Хятад руу найрсаг зангаар (2018 оны 8 дугаар сард БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И-гийн Монголд хийсэн айлчлалын дохио байсан) хэсэгчлэн нөхөх боломжтой бөгөөд энэ нь Монгол улсын гадаад бодлогын чиг хандлагыг тодорхой харуулж байна. Х.Баттулга ОХУ-тай улс төрийн харилцаагаа бэхжүүлэх замаар Монгол улс Хятадаас эдийн засгийн хараат байдал гүнзгийрч буй асуудлыг шийдвэрлэхийг сонгосон. Энэхүү шинэ арга барил нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа боловч өөр ямар ч шалтгаангүйгээр Ерөнхийлөгч үүнийг дээд цэгээс нь идэвхтэй шахаж байгаа бол Улаанбаатарын бодлого тодорхойлогчдын дунд энэ хандлага нэмэгдэж байсан. Харин У.Хүрэлсүх Монгол улсын Ерөнхийлөгч болсноор хоёр улстай харилцан энэ тэнцүү харилцах чиг шугамыг баримталж байна.

Монгол, Орос, Хятадын тэнцэл. Хүйтэн дайн дууссаны дараа Монгол улс олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, өөрийн ашиг сонирхолд тулгуурлан энхийг эрхэмлэсэн, тогтвортой, олон тулгуурт гадаад бодлогыг хөгжүүлэхийн төлөө идэвхтэй ажиллаж ирсэн. Гэвч Монгол улс далайд гарцгүй, геополитик маш их хязгаарлагдмал учраас Монгол улс “гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлсэн. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалд Монгол улс БНХАУ, ОХУ-тай тэнцвэртэй байж “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогыг бэхжүүлэх ёстой гэж онцолсон. "Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал", "Монгол улсын аюулгүй байдлын бодлогын үзэл баримтлал", "Монгол улсын үндэсний хөгжлийн ерөнхий стратеги", "Монгол улсын гадаад бодлогын эдийн засгийн хөтөлбөр" зэрэг чухал баримт бичгүүдэд "гуравдагч хөрш"-ийн дипломат стратегийг шинэчлэн тусгасан.

Монголын хоёр том хөрш болох Хятад, Орос хэдийгээр геополитикийн хувьд Хятад, Орос хоёр Монголыг голд оруулсан нь Монголд үл үзэгдэх саад, дарамт шахалт үзүүлсэн ч үнэн хэрэгтээ Хятад, Орос хоёр Монголын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцоогүй юм. Монголын эсрэг түрэмгийллийн шинж тэмдэг илэрч байгаагийн хувьд гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлэх сайн үндэс суурийг тавьж байна. Монгол улс "гуравдагч хөрш"-өөс бүрэн хараат биш. Хэрвээ гуравдагч хөрш Орос, Хятадтай антагонист байр суурьтай байвал

Монгол, гуравдагч хөршийн харилцаа өөрчлөгдөнө⁹. Монгол Улс газарзүйн онцлогоосоо шалтгаалан хоёр хөрш БНХАУ, ОХУ-тай үндэсний аюулгүй байдлын хувьд маш чухал харилцаатай, гуравдагч хөрш хоёр хөршийн харилцаа хурцадвал Монгол улс гуравдагч хөршийн бодлогыг сохроор дагаж чадахгүй. Монголд том хөршийн нөлөө гуравдагч хөршөөс илүү шууд бөгөөд чухал. Монгол улсын гадаад бодлогын зорилго нь хоёр том хөршийнхөө тэнцвэрийг хадгалах явдал юм.

Гадаадын хөрөнгө оруулалтын тэнцвэрийг хадгалах нь үндэсний аюулгүй байдлыг хангахад нэн тэргүүнд тавигдах асуудал юм. "Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын бодлогын үзэл баримтлал"-д "Гадаадын аль нэг улсад оруулсан хөрөнгө оруулалт нь нийт гадаадын хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байх. Гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжид оруулах хөрөнгө оруулалтыг хатуу хязгаарлаж, хөрөнгө оруулалтын эзлэх хувь хэмжээг тогтооно" гэсэн байр суурийг дэвшүүлсэн. Аль ч улсад хэтрүүлж болохгүй. Улс бүрийн хөрөнгө оруулалт динамик тэнцвэртэй байлгахыг баримталдаг. Монгол улс далайд гарцгүй учраас газарзүйн хүчин зүйл харьцангуй тааламжгүй байгаа нь гуравдагч хөрш болон Монгол улсын худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Тээврийн янз бүрийн суваг байдаг ч Хятад, ОХУ-аар дамжин өнгөрөх шаардлагагүй тээврийн хэрэгсэл цөөхөн байдаг. Хөрш орнуудаар дамжих шаардлагагүй цорын ганц тээврийн суваг бол агаарын тээвэр юм. Тээврийн сувгууд хязгаарлагдмал учир Монгол улс болон гуравдагч хөрш хоорондын худалдааны тээвэрлэлт, даатгалын зардал харьцангуй өндөр буюу хөгжингүй бүс нутгуудынхаас хоёр дахин их байна. Тиймээс Монгол улс Хятад, ОХУ-тай зөвхөн тээврийн зардлаар хамтын ажиллагаагаа бэхжүүлж чадна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн жилүүдэд Монгол улс гурван хөлийн тэнцвэрт байдлыг тогтооход хэцүү болж эхэлснийг харуулсан. Энэхүү нарийн шилжилтийн эхлэл нь 2013-2014 онд болсон хоёр чухал үйл явдлаас улбаатай. 2013 оны намар БНХАУ-ын дарга Ши Жиньпин "Торгоны зам" төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээ зарласан нь хожим нь дэд бүтцийн төсөл, шууд хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх замаар Хятадын эдийн засгийг хөгжүүлэх "Бүс ба зам" санаачилга болсон юм. Монголын геополитикийн бас нэг харгис үнэн бол Хятадын санал болгож буй эдгээр төслүүдийг ашиглах нь тийм ч тохиромжтой зүйл биш юм. Хятадын дэд бүтцийн хүрээний үйл ажиллагааны гол зорилго нь баруун тийш Төв Ази руу тэлэх бөгөөд эдгээр шинэ холбоосуудын зарим нь буюу газрын тос, байгалийн хийн хоолой, эрчим хүчний шугам, авто зам, төмөр зам ямар нэгэн байдлаар Монголыг дайран өнгөрч, эдийн засгийг нь өсгөх болно. Гэвч "Бүс, зам" санаачилгын өмнө Монгол Улс баруун тийш явах цорын ганц зам болж, энэ том төлөвлөгөөнд саад болж, Монгол Улс Хятадтай өрсөлдөх хүч хараахан болоогүй байгаа тул Монголын бодлого боловсруулагчид өөрсдийнхөө улс орныг баруун тийшээ явах боломжтой гэж төсөөлж байна.

Хоёрдахь үйл явдал бол Орос Украиныг эзлэн түрэмгийлж, Крымыг өөртөө нэгтгэж, улмаар барууны орнуудтай харилцаагаа тасалсан зөрчилдөөн нь Оросыг Хятадын тэвэрт ойртуулах санаанд оромгүй үр дагавартай байсан. АНУ, БНХАУ-ын хоорондын хурцадмал байдал Бээжин, Москвагийн харилцааг улам хурцатгасан. Удаан хугацаанд тасалдсан Хятад-Зөвлөлтийн эвслийн хойд дүр хараахан гарч ирээгүй байгаа ч Хятад, Оросын улс төр, эдийн засаг, сүүлийн үед цэргийн хамтын ажиллагаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч байна. Оросууд Хятадын урт хугацааны хөгжлийн талаар санаа зовж буй хэвээр байгаа ч хоёр орны бүс нутгийн болон дэлхийн нийтлэг ашиг сонирхол нь тэднийг болгоомжтой далдлахыг уриалсан. Монгол Улсын хувьд хоёр хөрш шаардлагатай бол гадаад бодлогоо зохицуулж, нэгдмэл фронт байгуулах санал хүртэл тавьж болно гэсэн үг юм.

Монголын нөхцөл байдалтай тулгарсан Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2015 оны 9 дүгээр сард Швейцарь, Туркменистан улсуудад таалагдсан шиг Монгол Улс "байнгын төвийг сахих" байр сууриа зарлахыг оролдсон. Гэсэн хэдий ч Бээжин ч, Москва ч

⁹ 战略研究所.大国范围内的国家政策:蒙古国第三邻国政策[M].乌兰巴托:Munkhiin useg出版社, 2011:129.

энэ санааг хүлээж аваагүйгээс эцэст нь энэ санааг зогсооход хүрсэн. Ц.Элбэгдорж мөн Хятад, Орос хоёрыг эрх тэгш харилцахыг эрмэлзэж, Ерөнхийлөгч Путин, Ши Жиньпин нартай гурван талт форматаар уулзсан. Гэвч ийм уулзалтууд нь Монгол улс хөрш орнуудтайгаа тэнцвэржүүлэх үүргийг илчилж, Ц.Элбэгдорж ОХУ-ын Украин дахь үйл ажиллагаа, Өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын үйл ажиллагаа зэрэг эмзэг асуудлуудыг харах шахалтад автсан. Товчхондоо, сүүлийн жилүүдэд Монгол улс “гуравдагч хөрш”-ийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь битгий хэл Хятад, Орос хоёрын хооронд тэнцвэртэй байх нь улам хэцүү болгож байна. Х.Баттулга засгийн эрхэнд гарсны дараа Хятад, Орос хоёрыг тэнцвэржүүлэх үйлдлийг хадгалах бараг боломжгүй гэж үзээд аажмаар Орос руу хазайж эхэлсэн. Харин У.Хүрэлсүхийн хувьд хоёр орны Монгол улсын статусын уриалгад Монгол улс эдийн засаг, худалдааны салбарт хөрш зэргэлдээ орнуудаас хэт хамааралтай, томоохон гүрнүүдийн ашиг сонирхлоос үүдэлтэй гадаад дарамт шахалт, “олон тулгуурт” гадаад бодлогоо үр дүнтэй барихыг ихэд хичээж буйгаа илэрхийлж байна.

Монгол Улс хүндэрсэн эдийн засгаа хөгжүүлэхийн тулд гадаад бодлогоо уламжлалт түншүүд болох Орос, Хятад руу чиглүүлж байгаа ч Монголын мэргэжилтнүүд Улаанбаатарт хараат байдал нэмэгдэх аюул нүүрлэж байгааг анхааруулж байна. Монгол улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүх, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нар хоёр орны харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүргэсэн нь Хятад улсын нэгэн адил ОХУ ч Монголын ашигт малтмалын ашиг сонирхлыг баримталж байгааг илтгэнэ. Хоёр талын хөрөнгө оруулалт нэмэгдэж, газрын тос, байгалийн хий барих тухай төсөл эцэстээ хэрэгжихээр болсон. ОХУ нь Монголын гурав дахь том экспортлогч хэдий ч Монголын нийт экспортын дөнгөж 1.4%-ийг эзэлсээр байгаа бол Монголын экспортын 90%, 3.6%-ийг Хятад, Канад улсууд эзэлж байна. Импортын 27.6 хувийг ОХУ, 37.8 хувийг БНХАУ-аас импортолсон байна. Гэсэн хэдий ч Бээжин Улаанбаатарын эдийн засгийн хамгийн том түнш хэвээр байгаа бөгөөд Хятад улс нь Монголын эдийн засгийн импортын эх үүсвэр бөгөөд экспортын дийлэнх хувийг ашигт малтмал, ялангуяа зэс, нүүрс эзэлж, хоёр талын худалдаа 2017 онд 6 тэрбум ам.долларт хүрсэн.

Монголын "гуравдагч хөрш"-ийн бодлого хэзээ ч Орос, Хятадыг орлож байгаагүй. Монгол улс хоёр хөршийнхөө нөлөөг тэнцвэржүүлэхийг ямагт хичээж ирсэн нь АНУ, Япон, Өмнөд Солонгос, Канад гэх мэтийн дэмжлэгээр нотлогддог. Энэхүү бодлогын ерөнхий удирдамжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ¹⁰. Өмнө нь Монголын бодлого боловсруулагчид болон парламентын гишүүд өргөн хүрээний харилцааг хадгалах дипломат зорилгыг дэмжсэний хариуд төслөөс эдийн засгийн өгөөж багатай байхыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байсан бол одоо доод талынхандаа илүү хөтлөгдөж магадгүй байна. Тиймээс эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй таагүй хэвээр байгаа цагт Монгол улс Хятад руу хазайсан ч магадгүй Орос руу чиглэх хандлагатай харагдаж байна. Үүний үр дүнд Бээжин, Москва хоёр Улаанбаатарын хувьд урьд өмнөхөөсөө илүү чухал болж, цаашид хамтран ажиллах хүсэлтэй байна. Үүний зэрэгцээ Монгол, Хятад, Оросын харилцаа улам бүр ойртож байгаа нь эдийн засаг, геополитикийн үр өгөөжтэй нөхцөлд худалдаа, худалдааны хүрээнээс хол давж магадгүй юм. Уг нь Монгол улс Орос, Хятад хоёрыг дундуур нь уулзах боломжийг бүрдүүлэх. Төрийн тэргүүний айлчлал гурван талт хамтын ажиллагааг хэр зэрэг ахиулахаас шалтгаалж Орос, Хятад хоёр улс Монголын эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийг дэмжихэд анхаарч, Монгол, Хятад, Оросын харилцааг бэхжүүлэх боломж юм. Үүний нэг жишээ нь Орос, Хятад хоёрыг Монголоор дамжуулан холбосон хойд-өмнөд төмөр замын сүлжээ, мөн Монголыг дайруулан газрын тос, байгалийн хийн хоолой тавих санал юм. Гэхдээ Монгол улс өөр давуу талтай байж магадгүй бөгөөд БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монголыг АПЕК зэрэг бүс нутаг дамнасан эвсэл, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг бүс нутгийн бүлгүүдэд нэгтгэх сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. АПЕК нь Монгол Улсад бусад оронтой хамтын ажиллагаагаа бэхжүүлэх боломжийг олгох юм.

¹⁰ 达瓦道尔吉 (Davaadorj.Ts).蒙古国安全政策构想反映的保障经济安全理论与方法的一些问题[J].战略研究, 2011:124.

Монгол улс Хятад, Оросын хооронд тэнцвэртэй байгаа нь Монголыг ч эрсдэлд оруулж байна. Монголчууд түүхэндээ улс орныхоо харилцааны талаар хоёрдмол байр суурьтай байсан ч Орос, ялангуяа Хятадтай ойр дотно харилцаатай байх нь Монгол улсыг Хятад, Оросоос хэт хараат болгож, улс төрийн тусгаар тогтнолоос нь хасуулж болзошгүй юм. Хэдий Хятад улс хөршийнхөө тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үргэлж хүндэтгэж, өөрийн шийдвэрээ гаргах боловч Улаанбаатар хот Бээжингээс экспортын чиглэлийн хувьд ихээхэн хамааралтай хэвээр байна гэж Монголын шинжээчид үзэж байна. Түүгээр ч барахгүй Монголын урд хилээр гарч буй ихэнх барааг Хятадаас өөр газар тээвэрлэх нь юу л бол, найдлага нь улс төрийн асуудалд хүртэл хүрч магадгүй юм.

3. Геополитикийн хүрээнд Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор байгуулах нь

Геополитикийн хүчин зүйлд тулгуурлан Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор байгуулах урьдчилсан нөхцлийг бүрдүүлж байна. 2014 оны 9 дүгээр сард Душанбе хотноо Монгол, Хятад, ОХУ-ын дээд хэмжээний анхны уулзалт эдийн засгийн хамтын ажиллагаанд, 2015 оны 7 дугаар сард ОХУ-ын Уфа хотноо хоёр дахь удаагаа болж, ОХУ-ын дээд хэмжээний уулзалтын гол сэдэв нь эдийн засгийн хамтын ажиллагаанд анхаарал хандуулах сэдвийн хүрээнд болсон. Эдийн засгийн коридор байгуулж, Монгол улсын “Хөгжлийн зам” төлөвлөгөө, ОХУ-ын Зүүн Африкийн эдийн засгийн хамтын нийгэмлэг (Зүүн Африкийн эдийн засгийн хамтын нийгэмлэг), БНХАУ-ын “Бүс, зам” санаачилгын талаар хэлэлцэж, 2016 оны 6 дугаар сард Ташкент хотноо гурав дахь удаагийн дээд хэмжээний уулзалт болсон. Хятад-Монгол-Оросын төлөвлөгөөт эдийн засгийн коридорт гурван улс хамтран гарын үсэг зурснаар Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридорын төлөвлөлтийн төлөвлөгөө албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридорын хамтын ажиллагааны тодорхой чиглэлүүдэд: тээврийн дэд бүтэц, аж үйлдвэрийн салбарын хамтын ажиллагаа, хилийн боомтыг хөгжүүлэх, худалдаа, хяналт шалгалтын журмыг дэмжих, эрчим хүчний салбар, байгаль орчин, экологи, боловсрол, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа, хүмүүнлэг, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллахаар болж, улмаар Монгол, Хятад хоёр орны дээд, дээд хэмжээний солилцоо ойр ойрхон болж, хамтын ажиллагааны олон чухал баримт бичиг, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж, Монголын хамтарсан уулзалтад Хятадын Худалдааны сайд ч оролцож, Хятадаас маш их үнэ төлбөргүй тусламж авч, бага хүүтэй зээл авснаар Монгол улсад хөрөнгө мөнгө дутмаг зарим төслүүдийг саадгүй хөгжүүлэхэд тус дөхөм болсон¹¹.

¹¹ 中华人民共和国驻蒙古国大使馆网站: 2017年中蒙经贸合作十大新闻 <http://mn.china-embassy.org/chn/zmgx/sbgx/t1326658.htm>.

Төмөр замын тээвэр



Замын тээвэр



Санхүүгийн эх үүсвэр

Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридорыг эхлүүлж, хэрэгжүүлснээр Монгол, Хятад, ОХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа улам гүнзгийрч, институцлэгдэж байна. Монголын геополитик, Хятадын эдийн засгийн хөгжлийн гацаа, олон улсын орчинд тулгараад байгаа Орос, Монгол, Хятад, Орос гурван улс бол түүхэн хөгжлийн онцгой туршлагатай гурван орон юм. 2005 онд Улаанбаатар хотноо Монгол, Хятад, ОХУ-ын Гадаад хэргийн сайд нарын түвшний албан бус уулзалт болсон нь Монгол, Хятад, Оросын улс төрийн харилцан итгэлцлийг нэмэгдүүлсэн юм. 2008 онд Улаанбаатар хотноо геополитикийн тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол, Хятад, Орос хоёр орны найрсаг, сайн хөршийн харилцааг хөгжүүлэх боломжийн талаар сурталчлах зорилгоор ХХI зуунд Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын хөгжил сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдсан.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцлал. 2012-2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж Монгол улсын эдийн засгийг хөгжүүлэх, санхүүгийн хурц хүндрэлийг даван туулах таатай нөхцөлийг бүрдүүлж, хамтын ажиллагааны хүсэл эрмэлзэл,

хамтын ажиллагааны механизмыг өндөр түвшинд бий болгох, бүтээн байгуулалтын үзэл баримтлалыг бий болгосон.

Монголын нутаг дэвсгэрээр дамжин Хятад-Монгол-Оросын ачаа тээврийн суваг. Монгол Улсыг идэвхтэй сурталчилснаар гурван улсын дээд хэмжээний уулзалтын механизм ч бий болж, Монгол, Хятад, Оросын харилцаа улам сайжирч байна. 2014 онд "Бүс ба зам"-ыг стратегийн тулгуур болгож, Монгол-Хятад-Оросын эдийн засаг, эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт хөгжлийн хурдацтай замд орсон.

Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн айлчлал, бүтээн байгуулалтын хэлэлцээрт Монголын Засгийн газар өндөр ач холбогдол өгч, дэд бүтцийн бүтээн байгуулалт, эрчим хүчний системийн бүтээн байгуулалт, ашигт малтмалын нөөцийн бүтээн байгуулалт зэрэг салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлсээр байна. 2014 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Монгол, Хятад хоёр орон харилцан уялдаа холбоотой харилцааг бэхжүүлэх асуудлаарх уулзалт хийж, уулзалтын үеэр Монгол Улс, БНХАУ-ын санал болгож буй Торгоны зам болон Монгол Улсын дэвшүүлж буй "Хөгжлийн зам"-ын уялдаа холбоог хэрхэн хэрэгжүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар ярилцсан. Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа хоёр орны нийтлэг ухамсарт хүрсэн. Монгол, Хятадын дээд удирдагчид ойр ойрхон харилцан айлчлал хийж байгаа нь Монгол Улс Хятад улсыг хамтын ажиллагааны чухал түнш хэмээн үзэж, Монгол, Хятадын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд Хятадын засгийн газар ихээхэн ач холбогдол өгч байгааг бүрэн харуулж байна.

Хятад улсын хувьд Европын орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийг хүсэж байгаа бол Монгол Улстай харилцаагаа бэхжүүлж, Монголоор дайран өнгөрч, Европын орнуудад хүрч, Европын орнуудтай ойр дотно харилцаатай байж, Монгол улс Хятадын бүтээн байгуулалтад боломж олгох ёстой хэмээн үздэг.

Монгол, Хятад, ОХУ-ын дээд түвшний удирдагчид өндөр давтамжтай харилцан айлчлал хийж, Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридорын стратегийн түншлэлийн харилцааг эрүүл, эрчимтэй хөгжүүлэхэд идэвхтэй тус дөхөм үзүүлж, Монгол, Хятадын харилцааг эдийн засгийн түншлэлийн харилцаанаас өндөр түвшинд ахиулсан. Иж бүрэн стратегийн түншлэл нь Хятад, Оросын хөрш зэргэлдээ дипломат харилцаанд Монгол Улсын улс төрийн байр суурь, эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлсэн. Гурван улсын эдийн засгийн коридорын хамтын ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхийн тулд Монгол, Хятад, ОХУ-ын удирдагчид гурван улсын хооронд тээвэр, ложистикийн бүтээн байгуулалтыг тасралтгүй ахиулснаар Монголын төмөр замын тээврийн бүтээн байгуулалтын төсөл техникийн хувьд илүү боловсронгуй болсон.

Монголын анхны төмөр замын тээврийн байгууламжийн хоцрогдол, жигд бус хөгжил нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ноцтой нөлөөлсөн бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Хятад, Орос улсууд Монголын төмөр замын бүтээн байгуулалтад техникийн дэмжлэг үзүүлэхээр маш олон тооны техникийн мэргэжилтнүүдээ илгээж, Монгол улсын төмөр замын бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын тээвэр, төмөр замын ложистикийн сүлжээг хөгжүүлэх. Монгол улс таван жилийн дотор авто зам, төмөр замын тээврийн сүлжээг бүрэн нээж, газрын тос, байгалийн хий, өнгөт төмөрлөгийн салбарыг өргөн цар хүрээтэй, тогтмол хөгжүүлэх "Бэлчээрийн зам" үндэсний хөгжлийн стратегийг дэвшүүлсэн.

Металл олборлох үйлдвэрүүд. Гурван улсын хилийн тээвэр хоорондоо холбогдож, гурван улсын хоорондох тээврийн замыг нээж байна. Энэхүү стратеги нь БНХАУ-ын "Торгоны зам", ОХУ-ын "Эдийн засгийн коридор" стратегитай төстэй бөгөөд Монгол, Хятад, ОХУ-ын эдийн засгийн хөгжилд тээврийн сайн холбоосыг нээж өгсөн юм.

Монгол улс, БНХАУ, ОХУ-ын тодорхойлсон эдийн засгийн хөгжлийн коридор нь хойд өргөргийн 45-60 градусын хооронд орших газар нутаг юм. Нийт нутгийн 80 гаруй хувь нь тэгш тал, цөөхөн хэсэг нь толгод байдаг. Европын орнууд болон Зүүн Азийн орнуудын хооронд сайн суваг нь эртний Хятадын торго Европ руу тээвэрлэх цорын ганц зам байсан

бөгөөд Монгол цай, сүүн бүтээгдэхүүнээ Европ руу зөөвөрлөх цорын ганц зам байсан түүхэн ач холбогдолтой.

Монголын Засгийн газар дэд бүтцийн бүтээн байгуулалтад 300 сая юанийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд төсөл амжилттай хэрэгжиж чадвал Монголын хил дамнасан асуудалтай нэгэн зэрэг хэрэгжих юм. Хятадын талаас БНХАУ-ын Засгийн газар ӨМӨЗО-ны Манжуурын чөлөөт бүс байгуулах баримт бичгийг албан ёсоор баталсан. Энэ нь ӨМӨЗО-ны анхны чөлөөт бүс юм. Манжуурын худалдааны чөлөөт бүс нь өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарч, хурдны зам, галт тэрэгний буудал, нисэх онгоцны буудлын уулзвар., газар зүйн байршил нь онцгой давуу талтай, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 500 сая юаньд хүрсэн. Монгол улсын төмөр замын тээврийн сүлжээг амжилттай байгуулсны дараа хоёр улсын гадаад худалдааны боомтуудад логистикийн агуулах, бүтээгдэхүүн тээвэрлэх, олон улсын транзит тээвэр, хил дамнасан татвар хураах зэрэг олон төрлийн ая тухтай үйлчилгээг үзүүлж, Монголын боомтыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот нь үйлдвэрлэл, тээвэрлэлтийг дэмжих үйлчилгээ, олон улсын ложистикийн түгээлтийн үйлчилгээ, задгай түүхий эдийн худалдааны үйлчилгээ, түүхий эдийг дахин боловсруулах үйлчилгээ, олон улсын импорт экспортын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг улс орны хэмжээнд чухал ач холбогдолтой ложистикийн түгээлтийн төв болох юм.

2016 оны 6-р сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол улсын Ташкент хотноо ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нартай гурван улсын уулзалт хийсэн¹². УИХ-ын чуулганы хуралдаанаар “Монгол-Хятад-Оросын эдийн засгийн хамтын ажиллагааны бүтээн байгуулалтын төслийн төлөвлөгөө”, “Олон улсын гааль, татварын хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Монгол-Хятад-ОХУ-ын гадаад худалдааны хөнгөлөлт үзүүлэх тухай хэлэлцээр” зэрэг гурван улсын хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсан. ". Мөн 2016 оны 10 дугаар сард Орос, Хятад, Монгол улсын бүх шатны засгийн газар эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны бүтээн байгуулалтыг тодорхойлсон "Монгол-Хятад-Оросын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх төслийн төлөвлөгөө"-г гүнзгийрүүлэн судалж, тайлбар хийсэн. Монгол-Хятад-Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа саадгүй хэрэгжихийн тулд төрөл бүрийн гэрээ, бодлогын байгууллагын баталгаа шаардлагатай. Зөвхөн сайн тодорхой хууль эрх зүйн зохицуулалттай байж Монгол-Хятад-Оросын эдийн засгийн хамтын ажиллагаанд зөрчилдөөн гарахгүй юм. Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор төсөл хэвийн хэрэгжиж, олон салбарын хамтын ажиллагааг эмх цэгцтэй явагдах юм. Түүнчлэн Монгол улс, БНХАУ, ОХУ-ын хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлсэн нь цаашдын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд илүү их, илүү сайн хамтын ажиллагааны боломжийг бий болгоход тустай юм.

¹² Ministry of Foreign Affairs of Mongolia. www.mfa.gov.mn

Дүгнэлт

Монгол улс нь Хятад, Орос гэсэн хоёр том улсын дунд оршдог, газар зүйн байрлал нь маш чухал учраас Монгол улсад тээврийн ач холбогдлыг ч бий болгож байна. Газар зүйн байршлын онцлог нь улс төрийн онцлогийг нь хязгаарлаж байна. Хятад улс хөгжиж, дэлхийн бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол улс газар зүйн байрлалдаа тулгуурлан Хятадтай харилцаагаа идэвхтэй хөгжүүлж, Хятадын “Бүс ба зам”-ын буухиа галт тэргэнд суух ёстой. Үүний зэрэгцээ том гүрнүүдийн хоорондын тэнцвэртэй харилцааг бий болгож, "гуравдагч хөршийн бодлого"-ыг сулруулж байж л Монгол улс үсрэнгүй хөгжилд хүрэх боломжтой.

Монгол улс Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг идэвхтэй ахиулах ёстой. Хоёр тал Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор болон "Бүс, зам" санаачилгын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх шаардлагтай байна. Иймд шинэ эринд Монгол улс геополитикийг бүрэн ашиглаж, энх тайван, тогтвортой хөгжлийг идэвхтэй дэмжиж, эдийн засгийн харилцан хамаарал бүхий нөхцөл байдлыг бүрдүүлж, Монгол-Хятад, Монгол-Оросын хоёр талын хамтын ажиллагааны харилцааг идэвхтэй хөгжүүлж, дэмжих хэрэгтэй байна.

Abstract:

Shifting global power dynamics, exemplified by conflicts like the Syrian War, the United State and China trade war, and the Russia-Ukraine war, are prompting major countries to realign and form new alliances. Recognizing this evolving external environment, Mongolia, guided by its national interests and geographic position, seeks to carefully navigate its relationships with both China and Russia.

Keywords: Mongolia's unique geopolitical positioning, the impact of China's growth on Mongolia, Russia's influence on Mongolia, how Mongolia balances its relations with these two powerful neighbors, and the potential for economic development within the trilateral Mongolia-China-Russia framework.

Ашигласан ном, материал

1. 朱金春.地缘安全视野下的跨界民族认同意识研究——以二连浩特出境蒙古族为例[R].中央民族大学, 2009:78.
2. Договор о дружественных отношениях и сотрудничестве междуРоссийской Федерацией и Монголией Дипломатический вестник [J]. 2003, 4.
3. Московскаядекларация[J].2018.№03.12.
4. 蒙中全面战略伙伴关系的进程、挑战及机遇[C], 学术研讨会论文集, 乌兰巴托, 2015年.
5. 申林.蒙古“第三邻国”外交析论[J].当代世界, 2013(4).
6. 拉·包勒德.蒙古安全环境及国防政策某些问题[J].战略研究, 2013.
7. 任雪娇.中蒙经贸合作中的蒙方因素实证分析[J].经济论坛, 2009(4).
8. Nikola Mikovic. Russian Influence in Mongolia is Declining[J]. U.S. Library of Congress ISSN. 2019(2).
9. 战略研究所.大国范围内的国家政策:蒙古国第三邻国政策[M].乌兰巴托:Munkhiin useg出版社, 2011:129.
10. 达瓦道尔吉(Davaadorj.Ts).蒙古国安全政策构想反映的保障经济安全理论与方法的一些问题[J].战略研究,2011:124.
11. 中华人民共和国驻蒙古国大使馆网站: 2017年中蒙经贸合作十大新闻 <http://mn.china-embassy.org/chn/zmgx/sbgx/t1326658.htm>.
12. Ministry of Foreign Affairs of Mongolia. www.mfa.gov.mn

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЯНАХ НЬ

Ш.Эвсанаа

ДХИС, ЭЗНУС,

Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, ахмад

Хураангуй:

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь үндэсний аюул байдалд хэрхэн нөлөөлөх тухай асуудал нарийн төвөгтэй, олон талт бодлогын асуудлыг авч үздэг. Өнөөдөр “үндэсний аюул байдал”, “аюулгүй байдлын чухал сонирхлууд”, “төрийн бодлого” гэсэн нэр томьёо, ойлголтууд нь өөрчлөгдөж улсын аюулгүй байдал, иргэдийн амар амгалан байдал болон амьдралын хэв маягийн гол асуудлуудыг авч үзэх гэсэн чиглэл рүү парадигмын шилжилт хийж байна. Эрчим хүчний хараат бус байдал, кибер халдлага, онцгой ач холбогдолтой дэд бүтцийг хамгаалахтай холбоотой аюул заналхийлэл нь аюулгүй байдлын асуудлууд нь тэдгээр салбарт хийгдэж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүнийг хянах нь олон асуудлыг дагуулдаг.

Түлхүүр үгс: Үндэсний аюулгүй байдал, хөрөнгө оруулалт, аюулгүй байдлын сонирхол, аюул, заналхийлэл

Удирдгал:

Аюул заналхийлэл ба ижил төстэй ойлголтууд

Хувь хүн, үндэстэн, олон улсын аюулгүй байдал нь хүн төрөлхтний шийдвэрлэвэл зохих нэн чухал асуудлын гэдгийг үгүйсгэх аргагүй. Ялангуяа үндэсний аюулгүй байдал нэн чухал. Учир нь аюулгүй байдлын зохицолдоо тааруу бусад хоёр түвшинг, нөхцөл байдлыг тодорхойлоход төр зонхилох үүрэгтэй.

Түүхийн туршид төрийн оршин тогтнол, нэг нь нөгөөгийнхөө аюулгүй байдалд заналхийлсээр ирсэн. Үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх зорилгоор нэг улс нь цэрэг, эдийн засгаа бэхжүүлж эхлэхэд нөгөө нь эдийн засгийн эмх замбараагүй байдалд орж, дайнд бэлдэх болдог байна. Үндэсний аюулгүй байдлын асуудлын цар хүрээ, шинж чанар түүхэн цаг үеэс шалтгаалан асар их зөрчилдөөн, эсвэл намжмал байдал, өсөн нэмэгдэж буй хамтын ажиллагаагаар тодорхойлогдсоор иржээ. Иймэрхүү хэлбэлзэл байдаг ч, айдас түгшүүр оршсоор байна.¹

Аюулгүй байдал нь зөвхөн үндэстний шинжтэй үзэл баримтлал биш юм. Уламжлал ёсоор уг үзэл баримтлалыг судалж, дүн шинжилгээ хийж, зөвлөмж болгосон ихэнх бүтээлүүдэд хүчин чадал ба энх тайвны үзэл баримтлалд үндэслэдэг байсан нь бий. Өөрсдийн аюулгүй байдлаа хангахын тулд бие биеэсээ үлэмж хэмжээгээр харилцан хамаарах аюулгүй байдлын зөрчил учир шалтгаан нь олон янз болж байна.

“Үндэсний аюулгүй байдал” нь маш өргөн хүрээний ойлголт ба категорийн нэр томьёо² ашиглан шууд томьёолох боломж тааруу байсаар ирсэн.

Энэхүү тодорхойлолтыг томьёолж чадахгүй байгаа нь улс бүр тухайлсан зорилтот хүрэхийн тулд тухайн зорилгоо хэрхэн тодорхойлохоос шалтгаалж ялгаатай ойлголт, ойлголтын зөрүү үргэлжилсээр байна. Иймд энэхүү тодорхой бус нөхцөл байдал нь

¹ Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он, 5 дахь тал

² WJ MOON, ‘Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний аюулгүй байдлын чухал сонирхлууд’ (2012) 15:2 Олон Улсын Эдийн Засгийн Хууль Сэтгүүл 481,500.

үргэлжилсээр аливаа бодлого, арга хэмжээг “үндэсний аюулгүй байдал” гэсэн дээвэрт хамруулах хандлага ажиглагддаг.

Улмаар аюул заналхийллын хамрах хүрээ тэлэх тутам шинэ асуудал нэмэгддэг. Тухайлбал, Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт (ГШХО) нь үндэсний аюулгүй байдлын асуудал болж байна. Хэдий ихэнх улс орны хувьд ГШХО-д нээлттэй ханддаг боловч байгалийн баялаг, аж үйлдвэрлэл, эдийн засаг ба бусад сонирхлоо хамгаалах үүднээс улс орнуудын засгийн газрууд бодлого, зорилтууддаа шинэчлэл хийх зарчим баримталж байна. Ялангуяа ГШХО-ын кейсыг тусад нь авч үздэг. Нөгөө талаас нь авч үзвэл Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Гэрээнд тусгай санал оруулах, зарим заалтыг хасах ажил аажим өрнөсөөр буй.

Харвардын их сургуулийн доктор Карлос Исплугүүс³-ийн судалгааны ажил болох *“An applied approach to national security: Controlling foreign direct investment on “national security” or related grounds”* буюу “Үндэсний аюулгүй байдалд ашиглагддаг аргачлал: үндэсний аюулгүй байдалд холбогдох хүчин зүйлстэй холбоотой гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хянах” (sbornik, 2017) нь аюулгүй байдал, аюул заналхийллын талаарх ялгаатай олон төрлийн ойлголт, ирээдүйн чиг хандлагыг тодорхой тайлбарласан байдаг.

“Үндэсний аюулгүй байдал”, үндэсний “аюулгүй байдлын чухал сонирхлууд”, “төрийн бодлого” нь уламжлалт цэргийн заналхийллээс улс орноо хамгаалах, терроризм, тагнуулын ажиллагаа гэсэн ойлголтоос тэлж, кибер тагнах ажиллагаа, улс төр, санхүү ба эдийн засгийн системтэй холбоотой эрсдэлүүд, нийгэм соёл, томоохон дэд бүтэц, байгаль орчны нөлөө гэх мэт олон талт арга хэмжээ авах шаардлагуудыг бий болгож байна.

Үндэсний аюулгүй байдлын нэгдмэл ойлголт

Өмнө нь “аюулгүй байдал”, “үндэсний аюулгүй байдал” нь уламжлалт ойлголтын хүрээнд цэрэг, армийн хамрах хүрээтэй холбогдсоор ирсэн бөгөөд гадаад аюул заналхийлэл, түрэмгийллээс газар нутгаа хамгаалах тухай байсан бол өнөөдөр олон иргэдийн амь, амьдралд нөлөөлөх онцгой ач холбогдолтой дэд бүтцүүд, тэдгээрийг эзэмшигч хувийн хэвшлүүд, олон улсын худалдаа зэрэг илүү төвөгтэй, олон өнцгөөс авч үзэх асуудал болсон⁴. Түүнчлэн технологийн хувьсгал нь зөвхөн газарзүйн хил хязгаарын ойлголтыг өөрчилсөн. Кибер аюулгүй байдал нь шинэ аюул заналхийллийн парадигм болж байна. Улмаар “аюулгүй байдал”, “үндэсний аюулгүй байдал”-ын ойлголт нь шинэ аюул заналхийлэл, сорилтуудтай тулгарч буй гэдгийг онцлох ёстой.

Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцээс хамаарсан ажлын нэг онцлог, сул тал нь кибер заналхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Кибер халдлагыг армийн мөргөлдөөнөөс гадна гадаад бодлогын хэрэгсэл болгон ашиглах нь одоогийн байдлаар хязгаарлагдмал байгаа. П.Мөнхтогтын (П.Мөнхтогт, 2021) орчуулсан “Rethinking readiness” буюу “Онц Байдал” номд дурдсанаар Орос, Иран болон Хойд Солонгос улсууд хүчтэй кибер халдлагын тестүүд хийж байгаа нь АНУ болон холбоотон улсуудад заналхийлэл болж байна гэжээ. Түүнчлэн 2018 онд арван хоёр тэрбум орчим компьютер халдлагад өртөж файлууд нь хулгайлагдсан гэсэн үзүүлэлт байдаг. Энэ тоо 2023 он гэхэд гучин гурван тэрбум хүрнэ гэсэн тооцоо байхаас үүний талаас илүү хувь нь АНУ-д хулгайлагдана гэсэн байна. Жаран сая гаруй Америкчууд⁵ иргэний үнэмлэхийн хулгайд өртсөн байдаг. 2018 оны тайланд Америк компанийн өгөгдөл алдагдсанаас учирсан дундаж хохирлын хэмжээ \$3.86 сая бол хулгайд алдагдсан файл бүрээс учирсан хохирлын дундаж хэмжээ нь \$148 байгаа нь өмнөх жилтэй харьцуулбал 6.4 болон 4.8 хувиар өссөн байна.

Мөн “Оросын Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги-2020”-д үндэсний аюулгүй байдлыг тодорхойлохдоо “иргэн, нийгэм, улсыг дотоодын ба гадаадын аюул заналхийллээс

³ Prof. Dr. Carlos Esplugues LLM (Harvard), MSc (Edinburgh), Professor of Private International Law, University of Valencia (Spain)

⁴ OECD, Security-Related Terms in International Investment Law and in National Security Strategies, May 2009, Paris, OECD 2009, p 3

⁵ П.Мөнхтогт. Онц байдал. (2021)-XXI Зууны мега гамшгийн гарын авлага. УБ., 2021 он

хамгаалах, үндсэн хууль, эрх чөлөө, иргэдийн чанартай амьдрал, Оросын Холбооны Улсын тогтвортой хөгжил, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Улсын батлан хамгаалах ба аюулгүй байдлыг баталгаажуулах” гэсэн байдаг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын салбарт үндэсний аюулгүй байдлыг авч үзэх

Үндэсний аюулгүй байдлын ойлголт нь улс орон бүрт ялгаатай байдаг. АНУ-ын хувьд онцгой ач холбогдолтой⁶ дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийгдсэн ГШХО-ыг үндэсний аюулгүй байдлын асуудал гэж авч үздэг. Европын Холбоо (ЕХ)-д бусад улсаас хийгдэж буй өндөр технологийн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын давамгайл байдал үүсэх аюул байдаг. Оросын хувьд цэргийн ноу-хау болон байгалийн баялгийн бизнест хийгдэх хөрөнгө оруулалт бөгөөд түүнд тавих хяналтыг чанга хадгалдаг. Түүнчлэн эдгээр улсуудын хувьд терроризмын аюул заналхийлэлд өртөх эрсдэл нь байнгын айдас дагуулдаг тул ГШХО ба үндэсний аюулгүй байдал хоорондын хамаарал нь цэрэг армийн болон стратегийн хамрах хүрээ болдог. ЕХ, Япон болон бусад хөгжингүй орнуудын хувьд үндэсний аюулгүй байдлын ойлголт нь ихэвчлэн эдийн засаг, түүнтэй холбоотой хүрээ, стратегийн аж үйлдвэрлэл ба үндэсний тэргүүлэгч компаниудтай хамааралтай. Францын Засгийн газар “эдийн засгийн эх оронч үзэл”-ийн тухай ярьдаг.

Тухайн нэг салбарт хэрэгжиж буй ГШХО төсөл, түүний учруулж болох хор, хохирлыг авч үзэх нь тухайн улс орны эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүчний хараат бус байдал, эдийн засгийн стратегийн чухал секторуудыг хянах, онцгой ач холбогдолтой дэд бүтцийг хамгаалах шаардлагатай арга хэмжээг авах зэрэгт хөрөнгө оруулагчийг анхаарал хандуулахыг шаарддаг.

Энэхүү санаачлагын хүрээнд олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний үндэсний аюулгүй байдалтай холбоотой заалтуудад нэмэлт өөрчлөлт орж байна. Тухайлбал, 1994 онд хийгдсэн Америкийн Нэгдсэн Улс ба Монгол Улс Хоорондын (Хоёр Тал Хоорондын Хөрөнгө Оруулалтын Хэлэлцээр) Хөрөнгө Оруулалтыг Дэмжих ба Хамгаалах Худалдааны гэрээний Заалт Х(1)-д “чухал аюулгүй байдлын сонирхлууд”-ийг авч үзэхдээ “*дайн ба үндэсний онц байдал*⁷ зарласан үед аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээнүүд авахыг тусгасан; дайн ба үндэсний онц байдлаас үл үүдэлтэй бусад арга хэмжээнүүдийн хувьд Талуудын чухал аюулгүй байдлын сонирхлыг шууд хамаарлыг тодорхой тусгаж өгөх ёстой”.

Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд болж буй аюулгүй байдлын аюул заналхийлэлтэй холбоотой ойлголтын өөрчлөлт нь өсөн нэмэгдэж буй байгаль орчны асуудлууд, байгалийн баялгийн хязгаарлагдмал нөөц, ус ба эрчим хүч ханган нийлүүлэхтэй холбоотой онцгой ач холбогдолтой дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг баталгаажуулах нь орчин үеийн нийгмийн хөгжлийн үндэс болжээ. АНУ-д 09 дүгээр сарын 11-ний болсон үйл явдал нь глобальчлагдсан дэлхийд эдгээр өөрчлөлтүүдийн салхийг хагалсан. ГШХО бол эдгээр секторуудын нэг нь бөгөөд энэ орчинд шинэ ойлголт, хандлагыг бий болгох зайлшгүй шаардлага үүссэн гэдгийг илэрхийлдэг.

ГШХО-тай холбоотой үндэсний аюулгүй байдлын хамрах хүрээ нь улс орон бүрд ялгаатай байдаг. Жишээ нь, “Их Британийн Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги ба Стратегийн Батлан Хамгаалах ба Аюулгүй Байдлын Дүн Шинжилгээ 2015”, Аюулгүй ба Хөгжилтэй Их Британи бодлогын баримт бичигт ГШХО-ийн үндэсний аюулгүй байдлын хамрах хүрээнд шинэ (Hinkley Point C) цөмийн эрчим хүчний станцын бүтээн байгуулалтад оруулсан Хятадын хөрөнгө оруулалтын талаар нухацтай авч үзсэн байдаг. Баримт бичигт дурдсанаар Их Британийн эрчим хүчний дэд бүтцийг орчин үеийн болгох “урт хугацааны эрчим хүчний аюулгүй байдлыг хангах” хөрөнгө оруулалтыг татахдаа “аливаа үндэсний аюулгүй байдлын эрсдэл ба бууруулах боломж”-ийн шаардлагатай үнэлгээг хийх ёстой

⁶ Critical infrastructure-онцгой ач холбогдолтой дэд бүтэц

⁷ National emergency-үндэсний онц байдал

гэжээ. ГШХО төслүүд, ГШХО-ын тухай хуулийн шинэчлэл нь үндэсний аюулгүй байдлын асуудалтай нийцүүлэн хөгждөг. Эдийн засгийн эерэг нөлөөтэй гэсэн үнэлгээ хийгдсэн үндэсний аюулгүй байдлын анализ хийгдэх ёстой. НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Чуулганы бодлогын үндсэн зарчмууд баримт бичигт үндэсний аюулгүй байдлын шалтгааны улмаас гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрх зүйн шалтгаануудыг тодорхойлж өгсөн байдаг.

Монгол улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага

Монгол Улс “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-даа эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтын үүрэг, ач холбогдлыг дараах гурван байдлаар үнэлж байгаагаа тусгасан байна.

Нэгдүгээрт, гадаадын аль нэг орноос орж ирэх хөрөнгө оруулалт нь нийт гадаадын хөрөнгө оруулалтын 1/3-аас багагүй байх бодлого баримталж, гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлан, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулалтаар дамжуулан дотоодын капитал хуримтлалыг нэмэгдүүлж, удирдлагын ур чадвар, технологийг сайжруулснаар дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулна.

Гуравдугаарт, дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулснаар хилийн чанадад хөрөнгө оруулалт, худалдаа хийх дотоодын аж ахуйн нэгжүүдийг бий болгосноор экспортын баримжаатай эдийн засгийн өсөлтийг хангана гэжээ.⁸ Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтын зохистой бодлогыг хэрэгжүүлж чадвал богино болон урт хугацааны хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтой байхаар хөгжлийн бодлого боловсруулагдсан байгааг илтгэнэ.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлогын хувьсал өөрчлөлт нь амар хялбар байгаагүй бөгөөд үе үеийн Засгийн газруудын ГШХО-нд хандах хандлагын илэрхийлэл байв. Өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл нь “нэг туйлаас нөгөө туйл руу савласан” буюу ГШХО-ыг дэмжсэн чиг хандлагаас эрс хязгаарласан чигтэй болж хувирч байлаа. Хөрөнгө оруулалтын хуульд хийгдсэн зарим нэмэлт өөрчлөлт нь ГШХО-ыг дэмжсэн нээлттэй бодлогын чиг баримжаатай зөрчилдсөн, ач холбогдлыг нь бууруулсан тохиолдлууд гарч байв.⁹ Тухайлбал, 1993 онд батлагдсан Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд гадаадын хуулийн этгээд тухайн улсад хөрөнгө оруулалт хийхэд хэд хэдэн шат дамжлага бүхий шалгалтаар орохыг заасан нь хөрөнгө оруулагч нарт хоёрдмол, үл ойлголт үүсгэсэн сөрөг дохио өгч байсан. Хөрөнгө оруулалт хийхэд хатуу, ялгавартай шаардлага тавих арга барил нь цөөн тооны салбар буюу зэвсэг, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом зэрэг үйл ажиллагаанаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээнд ГШХО-ыг нээлттэй оруулдаг албан ёсны либерал үзэл санаатай зөрчилдөж байлаа. Хэдийгээр дээрх шаардлагын хүрээнд хөрөнгө оруулалт хийх хүсэлтэд татгалзсан тохиолдол гараагүй боловч хууль журмаар хязгаарлалт тавих боломжтой байсан нь тодорхой бус байдал бий болгож байв.

2012 оны 5 дугаар сард буюу УИХ-ын сонгуулийн өмнөхөн олон нийтийн дунд үндэсний аюулгүй байдал болоод гадаадын хөрөнгө оруулалтын оролцооны талаар маргаан, мэтгэлцээн өрнөсөн бөгөөд тухайн үед уул уурхайн салбарт хийгдэх гэж байсан гадаадын хөрөнгө оруулалтыг зогсоох үүднээс Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл

⁸ Багийн ахлагч Д.Мөнхцэцэг нар. Монгол улсын эдийн засгийн болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын төлөв байдал. “Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого” судалгааны тайлан. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн. УБ., 2015 он


⁹ <http://documents.worldbank.org/curated/en/158851537431181525/pdf/130036-19-9-2018-17-34-14-MongoliaInvestmentReformMapfinalJuly.pdf>

ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлэлгүй баталсан байдаг. Уг хуульд “стратегийн” (уул уурхай, банк санхүү, харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл) салбаруудад хөрөнгө оруулалт хийх хүсэлтэй хувийн болон төрийн өмчит гадаадын хуулийн этгээд Монгол Улсын Засгийн газраас, мөн тухайн аж ахуйн нэгжийн нийт хувьцааны 49-өөс дээш хувийг гадаадын хуулийн этгээд эзэмшихээр бол УИХ-аас тус тус зөвшөөрөл авахаар тусгагдсан байв.¹⁰

Монгол банкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч Д.Даваадуламын (Д.Даваадулам, 2018) “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүлийн 2018 онд нийтэлсэн “Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинжилгээ” (Зураг 1) өгүүлэлд дурдсанаар Монгол улсад хийгдэж буй ГШХО нь 2012 оноос хойш буурч буй хандлагатай байна. Хөрөнгө оруулалтын төрлүүдийн (Зураг 2) хувьд авч үзвэл уул, уурхайн салбар нь 80%-г эзэлж байгаа нь өнөөдөр манай зах зээл руу өндөр технологийн ноу-хау, мөнгө санхүү, томоохон дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалтын урсгал муу байгаа нь харагддаг. Зам тээвэр, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт татах ажил хангалттай түвшинд хүрэхгүй байна.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, 2024 онд ашиглалтад орох Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг (www.ikon.mn, 2023) 2024 онд ашиглалтад оруулах төслийг “Бодь Интернэшнл” ХХК болон БНХАУ-ын “Пауэрчайна Ресурсэс” ХХК хамтран хэрэгжүүлж байна.

Зураг 1. Монгол улсад орсон ГШХО
Монгол Улсад орсон ГШХО-ын урсгал



Эх сурвалж: Монголбанк

¹⁰ <http://documents.worldbank.org/curated/en/158851537431181525/pdf/130036-19-9-2018-17-34-14-MongoliaInvestmentReformMapfinalJuly.pdf>

Зураг 2. ГШХО-ын төрөл

Монгол Улсад орсон ГШХО-ын орох урсгал (салбараар, сая ам.доллар)

№	Нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017.II	Нийт
1	Барилга	111	93	163	95	124	76	71	37	770
2	Боловсруулах үйлдвэрлэл	24	56	63	45	29	30	24	10	281
3	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	283	653	685	317	293	102	112	34	2,477
4	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	14	27	66	5	5	171	145	18	450
5	Мэдээлэл, холбоо	11	37	19	9	19	31	11	7	143
6	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	14	36	33	27	11	15	12	8	157
7	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	13	142	125	121	117	72	73	40	703
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	18	13	5	5	8	6	7	33	94
9	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5	23	9	14	13	3	4	1	72
10	Уул уурхай, олборлолт	1,160	4,492	3,911	2,507	1,272	790	941	565	15,638
11	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	27	91	97	64	67	79	54	23	502
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	51	61	39	29	18	14	23	8	241
13	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8	8	6	4	12	4	5	2	48
	Бусад	3	14	10	7	4	3	6	5	52
	Нийт	1,741	5,745	5,232	3,246	1,991	1,396	1,486	790	21,629

Эх сурвалж: Монголбанк

Дүгнэлт:

Үндэсний аюулгүй байдлын ойлголт нь нарийн төвөгтэй ба олон талт асуудал байхын зэрэгцээ байнга өөрчлөгдөж байдаг сэдэв юм. Түүнчлэн хамрах хүрээ нь тэлж уламжлалт цэрэг, армийн хэмжээстэй шууд холбоотой байхаас илүүтэй олон нөхцөл байдлыг хамарсан ойлголт болж өргөжсөөр байгаа нь сүүлийн үед дэлхий даяар өрнөж буй үзэгдлүүдээс тодорхой харагддаг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь үндэсний аюулгүй байдлын асуудлын нэг сэдэв болж байна. Уламжлалт аюул заналхийллээс ялгаатай асуудлууд болох эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүч, нөөцийн аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, био-аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал болон бусад талбарт үндэсний аюулгүй байдлын ойлголтын зөрүүг арилгах нь тэдгээрийг хамгаалах тухайлсан арга замуудыг олж тогтоох, салбар хоорондын харилцан хамаарлыг зөв тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг авах боломжийг бүрдүүлдэг. Монгол улсын хувьд ГШХО-ын тайлангаас харахад уул, уурхайн салбар руу чиглэсэн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал гэсэн гол хоёр салбарын асуудал түлхүү яригдаж байна. Эрчим хүч, кибер халдлага, онцгой ач холбогдолтой дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүдэд аюулгүй байдлын үнэлгээг хийх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогын баримт бичиг ба механизмыг боловсруулах бэлтгэл ажил хийх нь стратегийн зорилт болж байна.

Abstract:

The perception of how foreign direct investment will affect national security is complex and multilateral policy issues and should be considered. Today, the terms "national security," "essential security interests," and "public policies" are changing. Nowadays in evoking general considerations of protecting the security of a state, the safety of its citizens and key aspects of its way of life and in their paradigms shift. The threats associated with energy independence,

cyberattacks, and the protection of a particularly important substance are related to security, so the issue of monitoring foreign direct investment in those areas is strategic.

Key words: national security, investment, security interests, fear and threats.

Ашигласан ном, материал

1. Sbrornik, J. (2017). An applied approach to national security: Controlling foreign direct investment on "national security" or related grounds. *Journal of legal studies*, 1-18.
2. WJ MOON, 'Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний аюулгүй байдлын чухал сонирхлууд' (2012) 15:2 Олон Улсын Эдийн Засгийн Хууль Сэтгүүл 481,500
3. Prof. Dr. Carlos Esplugues LLM (Harvard), MSc (Edinburgh), Professor of Private International Law, University of Valencia (Spain)
4. OECD, Security-Related Terms in International Investment Law and in National Security Strategies, May 2009, Paris, OECD 2009, p 3
5. <http://documents.worldbank.org/curated/en/158851537431181525/pdf/130036-19-9-2018-17-34-14-MongoliaInvestmentReformMapfinalJuly.pdf>
6. Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он. 5 дахь тал
7. П.Мөнхтогт. Онц байдал. Онцгой байдлын менежмент (хууд. 79). УБ., 2021 он. Мөнхийн үсэг
8. Д.Даваадулам. Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинжилгээ. УБ., 2018 он. "Мөнгө, санхүү, баялаг", 131-32
9. Багийн ахлагч Д.Мөнхцэцэг нар. Монгол улсын эдийн засгийн болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын төлөв байдал. "Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого" судалгааны тайлан. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн. УБ., 2015 он

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 139-147 дахь тал

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ АСУУДАЛД**

Т.Заяа

ХУИС, ОУХНС-ийн тэнхимийн багш

Хураангуй:

Монгол Улсын (МУ) аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн хэмээн 2011 оны МУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан байдаг. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үүднээс манай улсын төрийн бүх шатны байгууллагууд тэр дундаа Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл (ҮАБЗ) чухал үүрэгтэйгээр оролцдог. Гэвч үндэсний аюулгүй байдлыг хамгаалах асуудалд төрийн гадаад, дотоод бодлогын нэгдмэл, залгамж чанарыг хадгалах, салбар дундын уялдааг хангах, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, үр дүн, үр ашиг, хяналтын тогтолцоог бодитойгоор хэрэгжүүлэх асуудал манай улсад тулгамдаж буй асуудлууд хэвээр байгаа билээ.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд МУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын эрх зүйн орчны хүрээнд нилээд өөрчлөлтийг хийх нь зүйтэй хэмээн дүгнэж, улмаар Үндсэн хууль (1992), Үндэсний аюулгүй байдлын тухай (2001), Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай гэсэн саналыг судлаачийн зүгээс боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны ажилд хууль, эрх зүйн баримт бичгүүдэд шинжилгээ хийх, бусад улсын жишигтэй харьцуулан судлах аргыг хэрэглэсэн болно.

Түлхүүр үгс: язгуур ашиг сонирхол, засаглал, зөвлөл, парламентын засаглал

Удиртгал

МУ-ын Үндэсний аюулгүй байдлын өнөөгийн тогтолцоо бүрэлдэн бий болоход МУ дахь 1990-ээд оны улс төрийн тогтолцооны өөрчлөлт шинэчлэл чухал үүргийг гүйцэтгэсэн. Үүний тод илрэл нь 1992 онд анхны ардчилсан Үндсэн хууль, 1994 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2001 онд Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулиуд батлагдан гарсан явдал юм.

2010 онд улмаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг өөрчлөн шинэчилсэн байдаг. Энэхүү баримт бичиг нь МУ-ын Үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчинг бүрдүүлж буй гол бодлогын баримт бичиг юм. 1994 оны үзэл баримтлалд тусгагдсан “үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийг хангах, хамгаалах зорилгоор Үндэсний аюулгүй байдлын тухай (2001), Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай (1992) тухай хуулиудыг баталж байсан түүхтэй. Гэвч 2010 онд Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ үзэл баримтлал батлагдсан ч дагалдах хуулиудаа УИХ шинэчлэн батлаагүй байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн эрх зүйн байдлыг 1992 онд батлагдсан ҮАБЗ-ийн тухай хуулиар тодорхойлсон байдаг. Тус байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийг МУ-ын УИХ тодорхойлдог бөгөөд МУ-ын Ерөнхийлөгч тэргүүлдэг (МУ-ын Үндсэн хууль, 1992).

Гэвч сүүлийн жилүүдэд МУ-ын эдийн засгийн аюулгүй байдал алдагдаж, нэг улсаас хамааралтай болсон, хуулийн дагуу олгогдсон эрх мэдэл алдагдсан, хариуцлагын тогтолцоо хэрэгждэггүй, улс төрийн намуудын оролцоо их, дурын байгууллага, албан тушаалтан дур зоргоороо шийдвэр гаргадаг, иргэний нийгмийн оролцоо сул, аюулгүй байдлын эрх ашиг орхигдсон, аюулгүй байдал, гадаад бодлогоо нэгдмэл байлгаж чадахгүй байгаа, гадаад

харилцааны яам (ГХЯ)-ны эрх мэдэл хумигдаж бодлогын нэгдсэн байдалд оролцох байдлыг орхигдуулсан, бодлогын баримт бичгүүд болох Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг нягтлахгүй байгаа, хүний нөөцийн чадавхи сул, төрийн байгууллагууд хоорондын уялдаа сул байгаа нь тухайлбал, байгууллага хоорондын ажлын уялдааг хангаж ажиллахыг захирамжилсан акт хэрэгждэггүй, ҮАБЗ-ийн шийдвэр зөвлөмжийн шинжтэй, гадаад харилцааны сайдын захирамжилсан тушаал нийт гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд сул байгаа зэрэгтэй холбоотой юм.

1. МУ-ын ҮАБЗ-ийн эрх зүйн байдал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн эрх зүйн байдлыг 1992 онд батлагдсан ҮАБЗ-ийн тухай хуулиар тодорхойлсон байдаг. Тус байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийг МУ-ын УИХ тодорхойлдог бөгөөд МУ-ын Ерөнхийлөгч тэргүүлдэг (МУ-ын Үндсэн хууль, 1992) тухай өмнө өгүүлсэн билээ (Зураг 2-г үз).

Зураг 2. ҮАБЗ-ийн өнөөгийн бүтэц



МУ-ын хувьд 1992 оны 5 дугаар сарын 29-нд Улсын Бага Хурал МУ-ын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулийг баталж Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг байгуулсан. Зөвлөлийн анхдугаар хуралдаан 1992 оны 8 дугаар сарын 8-нд болж, түүгээр Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай, Зөвлөлийн ажлын дотоод журам болон Зөвлөлийг мэдээллээр хангах журмын төсөл зэрэг асуудлыг хэлэлцэн баталсан байдаг (ҮАБЗ-ийн тухай, 2018). Улмаар 2001 оны 12-р сарын 27-ны өдөр МУ-ын УИХ-аас Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг баталж, уг хуулийн 17.1-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг төрийн нэгдмэл бодлогод нийцүүлэн уялдуулан зохицуулах чиг үүргийг Зөвлөл хэрэгжүүлэх” гэсэн заалт оруулж өгчээ (Үндэсний аюулгүй байдлын тухай, 2001). Ингэснээр ҮАБЗ аюулгүй байдлын нэгдмэл бодлогод хяналт тавих асуудлаар зохих хэмжээний эрх мэдэлтэй болсон байдаг.

ҮАБЗ-ийн талаарх бусад төрийн байгууллагуудын ойлголт, үнэлэмж бага, гадаад бодлого ба аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх эрх зүйн зохицуулалт сул, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын (НБД) мэргэжил, боловсрол, үүрэг гүйцэтгэх хугацаа, нэр хүнд харилцан адилгүй байдаг (ҮАБЗ байгуулагдсан цагаас хойш томилогдон ажиллаж байсан НБД нарын дотор гадаад бодлого, аюулгүй байдлын талаар мэргэшсэн энэ

талын ажлын туршлага хуримтлуулсан мэргэжлийн хүмүүс байсан бол сүүлийн жилүүдэд энэ албан тушаалд мэргэжлийн бус, бизнесмен, эдийн засгийн бүлэглэлүүдтэй ямар нэгэн байдлаар нэр холбогдсон, тодорхой ашиг сонирхлын зөрчилтэй, иймээс олон нийтийн дунд нэр хүнд муу этгээдийг Ерөхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд намын харьяалал болон бусад шалтгаанаар томилдог болсон нь нууц биш) зэргээс үүдэн МУ-ын аюулгүй байдалтай холбоотой гадаад бодлогын шийдвэр гаргалтын нэгдмэл байдал, залгамж чанар алдагдаж буй юм.


“МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, “МУ-ын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам” зэргээс харахад өнөөдөр аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотой чухал шийдвэрийг Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх журам тогтсон (практик дээр хэрэгжиж байгаа эсэх нь эргэлзээтэй). ГХЯ МУ-ын гадаад харилцааны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, гадаад бодлогыг хэрэгжүүлэх эрхээр хангагдсан хэдий ч ЗГ-ын бусад салбарын яамд өөр өөрсдийн чиглэлийн гадаад харилцааг явуулдаг жишиг тогтсон (Мягмардорж, 2019). Ерөхийлөгчийн гадаад харилцаанд гаргаж буй шийдвэрийг Ерөхийлөгчийн Тамгын газар тухайлбал, Ерөхийлөгчийн гадаад бодлого, аюулгүй байдлын зөвлөх боловсруулдаг болсон бол орон нутгийн засаг захиргааны нэгжүүд гадаад харилцааны асуудлаар бие даасан шийдвэр гаргах байдал түгээмэл болоод байна. Шат шатны төрийн байгууллагууд гадаад бодлогын асуудлаар бие даасан шийдвэр гаргах болсон нь гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанар алдагдахад хүрч, улмаар МУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдал ноцтой байдалд орох нөхцөл байдал үүсээд буй юм.

Гадаад харилцааны яам (ГХЯ) нь гадаад харилцааны асуудлаар гарч буй шийдвэрүүдийг уялдуулан зохицуулах, нэгдмэл байдал, залгамж чанарт хяналт тавих зохих ёсны үүргээ гүйцэтгэх боломжоор хомс болсон. Харин Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой аливаа улс төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх буй яам, агентлагийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон.

МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 4.1.3-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгох болгоно” (МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010) хэмээн заасан байдаг хэдий ч УИХ, ЗГ, хүчний байгууллагууд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн эрх үүргийг хязгаарлах явдал байсаар байна (Зураг 3-г үз).

Зураг 3. Тавантолгой болон Төмөр замын асуудлаар шийдвэр гаргах процесс

Тавантолгой төсөл, Төмөр замын бодлого боловсрогдох явц



Эх сурвалж: УИХ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын байнгын хорооноос хийсэн хайгуул судалгааны материал

Дээрхээс үзэхэд, МУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын асуудлаар гарах шийдвэрт УАБЗ-ийн оролцоо сул байгааг стратегийн ач холбогдол бүхий хоёр жишээн дээр харуулсан байна.

2. Үндэсний аюулгүй байдлыг хадгалах чиг үүрэг бүхий бусад улс дахь байгууллагууд

Дэлхий нийтийн жишгийг харахад гадаад харилцааны асуудлаар өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байгууллага нь гадаад харилцаа, дипломат албаны төрийн байгууллага болох ГХЯ байдаг бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой чухал асуудлаар гадаад бодлогын нэгдмэл шийдвэр гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг төрийн үндсэн механизм нь Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл/хороод байдаг аж.

Олон улсын жишгээс харахад төрийн тогтолцоо, засаглалын хэлбэрээр нь авч үзвэл парламентын засаглалтай улс орнуудад Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл нь Засгийн газрын бүтцэд хамаарч байгаа ба байнгын бүтэц бүрэлдэхүүнд нь чиглэлийн яамдуудын сайд нар тухайлбал, үндэсний аюулгүй байдалд шууд хамаарах дараах чиглэлийн яамдын сайд нар багтсан байна. Үүнд:

- Гадаад харилцааны сайд
- Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Батлан хамгаалахын сайд
- Сангийн сайд
- Хөгжлийн бодлого хариуцсан сайд
- Байгаль орчны сайд г.м

Мөн түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нэршил нь зөвлөлөөс гадна газар, хороо гэх мэт нэршилтэй байна. Бүрэлдэхүүний хувьд дунджаар 8-9 хүнтэй байх ба Ерөнхий сайд тус байгууллагыг тэргүүлдэг жишиг байдаг байна (Хавсралт 1-г үз).

МУ-ын хувьд УАБЗ-ийг Ерөнхийлөгч тэргүүлдэг ба тус байгууллагын бүрэлдэхүүнийг УИХ-аас томилдог (МУ-ын Үндсэн хууль, 1992). Бүрэлдэхүүнд

ерөнхийлөгчөөс гадна Ерөнхий сайд, УИХ-ын дарга нар багтдаг. Энэ нь нэг талаар, улсын аюулгүй байдлын асуудлаар төрийн гурван өндөрлөгийн эрх мэдлийг тэгш байдлаар хувиарлаж буй хэрэг боловч нөгөө талаар хууль тогтоох байгууллагын тэргүүнд илүү эрх мэдлийг төвлөрүүлж буй хэрэг юм. УИХ нь Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд улсын дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлдог (Үндсэн хууль, 1992).

Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг ерөнхийлөгч тэргүүлэх нь илүүтэйгээр ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад түгээмэл байдаг практик юм. Үндсэн хуулийн дагуу МУ бол Ерөнхийлөгчийн бус харин парламентын (Үндсэн хууль, 1992) засаглалтай улс юм. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад ҮАБЗ-ийг нь ерөнхийлөгч тэргүүлэх нь зүй ёсны хэрэг билээ.

Дүгнэлт

МУ-ын гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хангахад Засгийн газрын бүтцийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал юм. Иймд нийгмийн салбар тус бүрийн гадаад хамтын ажиллагаа, үндэсний аюулгүй байдлыг хангахад Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл чухал үүрэгтэй оролцох шаардлагатай. Харамсалтай нь, манай улсын хувьд тус байгууллагын гадаад бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоо бага, эрх хэмжээ хангалтгүй, чадавхи сул байгаа зэрэг олон асуудал байна. Асуудлыг мэдэх хүмүүсийн ярьснаар түүний үйл ажиллагаа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга нарын гадаадад хийсэн айлчлалын дүнг хэлэлцэх төдийхнээр хязгаарлагдаж байна. Түүнчлэн, тус байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд зөвлөмж (энэ нь дагаж биелүүлбэл зохих хатуу хэм хэмжээ бус юм) боловсруулдаг зэрэг чадавхийг бууруулж байгаа хүчин зүйлсүүд байна. Иймд дээрх байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчинд өөрчлөх шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

ҮАБЗ-ийн чадавхийг нэмэгдүүлэх, ингэхдээ хийгдэх чухал шинэчлэлт нь тус байгууллагын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэх, чухал салбарын сайдуудыг бүрэлдэхүүнд оруулах, Үндэсний аюулгүй байдалтай шууд хамаарах гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалах асуудлаар бодлого боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, улмаар зөрчигдсөн тохиолдолд хатуу хариуцлага тооцох чиг үүрэг бүхий механизмыг шинээр бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох (үүнийг одоо байгаа ҮАБЗ-ийн бүтцийг шинэчлэн сайжруулах замаар хийх, ҮАБ-ын тухай хуулийг шинэчлэх, зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг боловсронгуй болгох, гарах шийдвэрийг нийтээр дагаж мөрдөх хатуу хэмжээний шинжтэй болгох) шаардлагатай байна.

Тухайлбал, МУ-ын Үндсэн хуулиар олгогдсон ерөнхийлөгчийн ҮАБЗ-г тэргүүлдэг бүрэн эрхийг Засгийн газрын тэргүүнд шилжүүлэх, ҮАБ-ын тухай хуулийг шинэчлэх, тус байгууллагын бүрэн эрх, бүтэц бүрэлдэхүүнийг тусгаж өгөх, үндэсний аюулгүй байдлыг ханган ажиллах үндсэн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах талын зохицуулалт шаардлагатай байна.

Мөн түүнчлэн гадаад харилцааны салбарын бие даасан хуулийн хамрах хүрээнд Гадаад харилцааны асуудлаар Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахад оролцогч бүхий л төрийн байгууллагын албан тушаалтнууд төдийгүй улс төрийн намууд, эрдэмтэд судлаачид, иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулан цаг үеийн, гэнэтийн асуудлаар нэгдмэл шийдвэр гаргах зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг тусгаж өгөх хэрэгтэй.

Abstract:

The Foreign Policy Concept of Mongolia (2011) states that the priority of Foreign Policy is to ensure the security and national interests of Mongolia through political and diplomatic means

within the framework of international law. All government institutions of Mongolia, including the National Security Council (NSC) play an important role in the realization of this goal. However, the matter of protecting national security, maintaining the integrity and continuity of the state's foreign and domestic policies, ensuring inter-sector coordination, and effectively implementing the operation, results, efficiency, and control system of state institutions are still ongoing issues in our country.

It is concluded that significant changes shall be made in the legal framework of the foreign policy and national security of Mongolia. Those changes shall be made to the Constitution of Mongolia (1992), the Laws on National Security (2001), and the Laws on the National Security Council.

"Social unit system methodology" was used to analyze the concept of National Security and the Law on National security of Mongolia. In addition, the role and importance of the National Security Council in the National Security System, its potential in terms of political governance, and the issue of improving the legal status were discussed.

Keywords: national interest, governance, council, parliamentary governance

Ашигласан ном, материал

1. Alexander Martin (21 November 2013). "Japan to Form Own National Security Council". The Wall Street Journal. Retrieved 4 February 2014.
 2. "National Security Committee". directory.gov.au. Department of Finance. 17 June 2019. Retrieved 16 January 2020.
 3. Төмөрчулуун Г., “Гадаад бодлогын шийдвэр гаргах өрнөдийн онол ба МУ”, ШУ-ны /Sc.D / докторын зэрэг горилсон судалгааны ажил, 2006 он
 4. Мягмардорж П., “МУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал”, PhD докторын диссертаци, 2020 он
- Эрх зүйн баримт бичгүүд:
1. МУ-ын Үндсэн хууль, 1992 он
 2. МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он
 3. Дипломат албаны тухай хууль, 2010 он
 4. ЗГ-ын газрын 2013 оны 5-р сарын 11-ний өлрийн 169 тоот тогтоол
 5. Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам, 2013 он
 6. “Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг сайжруулах тухай, 2010 он
 7. МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”,
 8. “МУ-ын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам,
 9. МУ-ын ҮАБЗ-ийн тухай, 2018 он
 10. Үндэсний аюулгүй байдлын тухай, 2001
 11. The National Security Act of Spain, 2013
- Цахим эх сурвалж:
1. МУ-ын ҮАБЗ-ийн албан ёсны вэб хуудас, <https://nsc.gov.mn/mn>
 2. Их Британий ҮАБЗ-ийн албан ёсны вэб хуудас, <https://www.gov.uk/government/groups/national-security-council>
 3. Норвегийн ҮАБЗ-ийн албан ёсны вэб хуудас <https://www.regjeringen.no/en/dep/jd/organisation/underliggende-etater/the-norwegian-national-security-authority-nsm/id426401/>
 4. Энэтхэгийн ЗГ-ын вэб хуудас, <http://www.allgov.com/india/departments/ministry-of-youth-affairs-and-sports/national-security-council?agencyid=7599#:~:text=The%20National%20Security%20Council%20%28NSC%29%20of%20India%20is,services%2C%20advising%20leadership%20on%20intelligence%20and%20security%20issues.>
 5. Канадын ҮАБЗ-ийн албан ёсны вэб хуудас <https://www.canada.ca/en/services/defence/nationalsecurity.html>

6. Финляндын ҮАБЗ-ийн албан ёсны вэб хуудас, <https://um.fi/national-security-authority>
7. Сингапурын ҮАБЗ-ийн албан ёсны вэб хуудас, <https://www.nscs.gov.sg/>

Хавсралт 1. Парламентын засаглал бүхий улсуудын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүн (Судлаачийн өөрийн судалгаа бөгөөд гадаад улсуудын Үндсэн хуулиудыг ашигласан болно)

№	Улсын нэр	Засаглал	Нэршил	Хариуцах ажил, чиг үүрэг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн	Үндэсний аюулгүй байдлын бүтэц, бүрэлдэхүүн
1.	Их Британи	Парламентын/ Үндсэн хуульт хаант	The National Security Council	Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, тагнуулын ү/а-г хариуцах, мөн ОУ-ын харилцаа, гадаад бодлого, ОУ-ын хөгжлийн асуудал, эрчим хүч, байгалийн баялагийн тогтвортой байдлыг хангах	Ерөнхий сайд тэргүүлнэ	9 гишүүнтэй, Хороод, дэд хороод 3Г-ын гишүүд, Яамдууд хоорондын асуудал эрхлэх сайд, Ерөнхий өмгөөлөгч
2.	Сингапур	Парламентын	The National Security Coordination Secretariat	Аюулгүй байдлын эрсдлийг тогтоох, эрсдлийг даван туулах ажлыг зохион байгуулах	Ерөнхий сайдын кабинетэд хамаарах нэгж	Нэгжүүд
3.	Япон	Парламентын/ Үндсэн хуульт	The National Security Council	Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогыг удирдах	Ерөнхий сайд тэргүүлнэ,	9 байнгын гишүүнтэй, ахлах зөвлөхүүд багтана
4.	Норвеги	Парламентын/ Үндсэн хуульт	The Norwegian National Security Authority	Цахим аюулгүй байдлын асуудлыг голчлон хариуцдаг	Батлан хамгаалах яамны харъяа, Хууль зүйн болон Бодлогын яамдуудад ажлаа тайлагнадаг	Нэгж, хэлтэсүүд

5.	Финлянд	Парламентын/Б НУ	The National Security Authority	Мэдээллийн аюулгүй байдалд голчлон анхаардаг	Гадаад харилцааны яамны дэргэдэх нэгж, ТНБД-д ажлаа тайлагнадаг	Нэгжүүд
6.	Испани	Парламентын/ Үндсэн хуульт	The National Security Council	Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын асуудлаар зөвлөх	Ерөнхий сайд тэргүүлнэ	Сайд нар
7.	Канад	Парламентын/ Үндсэн хуульт	The national security advisor	Аюулгүй байдал, тагнуулын асуудал	Төрийн албан хаагч ба Ерөнхий сайдад ажлаа тайлагнадаг	Төрийн албан хаагч 1 хүн
8.	Австрали	Парламентын/ Үндсэн хуульт	The National Security Committee	Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын асуудлаар	Ерөнхий сайд тэргүүлнэ, ЗГ-ын кабинетэд хамаарах	8 гишүүнтэй
9.	Энэтхэг	Парламентын/Б НУ	The National Security Council	Үндэсний аюулгүй байдал, стратегийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар зөвлөх	Ерөнхий сайд	Сайд нар, ЗГ-ын хамаарлын бус зөвлөхүүд
10.	Монгол Улс	Парламентын	The National Security Council	Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага	Ерөнхийлөгч тэргүүлнэ	Гишүүд, НБД

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД
СПОРТЫН ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ ХУВЬ НЭМЭР**

Т.Есүхэй

МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн багш

Ц.Төрболд

МУИС, УТСОУХНУС,
Олон улсын харилцааны тэнхимийн магистрант

Хураангуй:

Монгол улсын гадаад бодлого, олон улсын харилцааг төлөвшүүлэх, улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд нөлөөлөх, ялангуяа олон улсын спортын томоохон арга хэмжээг стратегийн зорилгоор ашиглах замаар спортын дипломатын олон талт үүргийг судлах зорилготой юм. Энэхүү өгүүлэлд кейс судалгаа, улс хоорондын дипломат харилцаан дахь спортын нөлөөллийг шинжлэх замаар дипломат арга хэрэгсэл болох спортын үр нөлөө, түүнийг үнэлэх зорилготой юм. Монгол улсын гадаад улсуудтай харилцах дипломат харилцааг хөгжүүлэх, зөөлөн хүчийг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжихийн тулд спортын арга хэмжээ буюу ОУОХ-ны “Олимпын наадам”, тивийн спортын наадмууд хэрхэн стратегийн хувьд хөшүүрэг болгож байгаа талаар дүгнэлт хийхэд оршино.

Түлхүүр үгс: спортын дипломат харилцаа, үндэсний зочлох өргөө, Олимпын наадам, Олон Улсын Олимпын Хороо (ОУОХ), зөөлөн хүч

Удиртгал:

Эртний грек болон бусад соёл иргэншлүүд “Олимпын наадам” гэх зэрэг спортын наадам, тэмцээн уралдаанууд зохион байгуулж, оролцдог байсан бөгөөд орчин цагт 20-р зуунд буюу дэлхийн II дайны дараачаас зохион байгуулалт нь өргөжин тэлж, улс орнууд онцгой ач холбогдол өгч оролцож ирсэн бөгөөд үүгээр дамжуулан бусад төрт улсуудад өөрийн хүч чадлыг харуулах, энх тайвныг эрхэмлэх, өөр ялгаатай соёл иргэншлүүдийн хоорондын холбоог бий болгох тавцан болж байв¹. Орчин цагт буюу орчин цагийн Олимпын наадмын үндэслэгч Пиер Дэ Кубертины санаачилгаар 1896 оноос эхлэн өнөөдрийг хүртэл зохион байгуулагдаж, илүү өргөн цар хүрээг хамарч, улмаар дэлхийн II дайны дараачаар шинэ дэлхийг сэргээн босгох, хурцадмал асуудалтай улс үндэстнүүдийн хооронд гадаад харилцааны зөөлөн хүчний бодлогын гол цөм болж эхэлсэн бөгөөд өнөөдөр дэлхийн энх тайван, хамтын үнэ цэн, хамтын ажиллагаа, соёлын солилцоо, үндэстний онцлогтой зөөлөн хүчний бодлого, нийгэм эдийн засгийн үр нөлөө зэрэг бусад баталгааг бий болгож байна.

Энэхүү өгүүллийн хүрээнд ОУОХ “Олимпын наадам”-ын үеэр улс орнууд өөрсдийн соёл, ёс заншил, уламжлал болон бусад талуудаар сурталчлан таниулах зорилготой “Үндэсний зочлох өргөө /National House/-г байгуулдаг нь Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн зургаан тулгуур зарчмын “Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого”-той уялдах боломжтой талаар авч үзэж, гадаад бодлогын хэрэгжилтэд оруулах хувь нэмрийг судлан, цаашид Монгол улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглаж болох үндсэн хэрэглүүр болгоход хувь нэмрээ оруулах юм.

¹ <https://olympics.com/ioc/faq/history-and-origin-of-the-games/what-is-the-origin-of-the-olympic-games>

1. Орчин цагийн олон улсын харилцаанд спортын дипломат харилцааны ач холбогдол

Орчин цагийн олон улсын харилцааны хувьд спортын дипломат харилцаа нь спортыг дипломат харилцааны тавцан болгон ашиглах олон төрлийн үйл ажиллагаа, уулзалтууд, тэдгээрээр илэрхийлэх үзэл санаанууд зэрэг стратегийн чухал асуудлуудыг анхаарч үздэг. Олон зуун жилийн туршид спорт нь геополитикийн тэнцвэрт байдлын төв, нэгдсэн хэл болж үндэстэн дамнасан харилцааны зэвсэг болж байсан бөгөөд хамтын үнэ цэнийг бүтээж, дипломат харилцааны зэвсэг болж чадна.² Дэлхийн болон тивийн шинж чанартай спортын арга хэмжээнүүд, спортын холбоод, албаны хүмүүс, тамирчдын солилцоо, хамтарсан санаачилгууд, төсөл хөтөлбөрүүд, спортын салбарын соёлын солилцоогоор дамжуулан улс орнуудын хоорондын харилцаануудыг хамран ойлгоно.

Спортын дипломат ажиллагаа нь энх тайван ба харилцан ойлголцлыг дэмжих, соёлын солилцоо болон зөөлөн хүч, улс үндэстнүүд, соёл иргэншлийн хоорондын хуваагдлыг арилгах холбогч гүүр болох, дипломат ажиллагааны гүүр болох зэрэг нарийн ач холбогдолтой. Спортын дипломат ажиллагаа нь улс орнуудын хооронд гүүр болж, улс төрийн ялгаатай байдлыг үл харгалзан, энх тайвныг дэмждэг бөгөөд энэ нь улс орнууд харилцан ойлголцол, хүндэтгэлийг бий болгож, найрсаг өрсөлдөөн, соёлын солилцоо өрнүүлэх төвийг сахисан нөхцөлүүдийг бий болгож байна.³ ОУОХ болон тивүүдийн салбар хороод, спортын олон улсын холбоодын зохион байгуулж буй спортын арга хэмжээ нь улс үндэстний соёл, уламжлал, үнэт зүйлсээ харуулах боломжийг олгодог бөгөөд, улс орны соёл, үзэл санааны эерэг дүр төрхийг харуулах замаар зөөлөн хүч буюу дэлхийн хэмжээнд нөлөөлөхөд ач холбогдолтой.

Спортын арга хэмжээ нь улс үндэстний соёл, уламжлал, үнэт зүйлсээ харуулах үе шат болдог. Энэ нь улс орны соёл, үзэл санааны эерэг дүр төрхийг харуулах замаар зөөлөн хүчийг буюу дэлхийн хэмжээнд нөлөөлөх, үзэл бодлоо илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд тусалдаг.

Спортын дипломат харилцаа нь улс үндэстнүүдийн холбоог бэхжүүлэх, соёлын солилцоо, онцлогийг таниулах, дэлхийн өнцөг булан бүрд байгаа улс орнуудын дипломат харилцааг хөнгөвчлөхөд ашиглан орчин үеийн олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байна. Жишээ нь: Австрали улсын засгийн газраас “Спортын дипломат 2030”⁴ бодлогыг 2019 онын хоёрдугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ОУ-ын түвшинд австралийн нөлөөг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх, үндэсний эрх ашгийг дээшлүүлэхэд спортыг ашиглахаа тунхагласан. Түүнчлэн АНУ-ын төрийн департментын дэргэдэх, боловсрол, соёлын асуудал эрхэлсэн хороо спортыг дипломат харилцааны гол хэрэгсэл болгодог бөгөөд 2001 оны 9-р сарын 11-нд болсон харамсалтай үйл явдлын дараацаар тус хороонд спортын хэлтсийг байгуулж спортыг хэл, нийгэм соёлын ялгааг даван туулах арга зам болгон ашиглаж, улс орнуудын хоорондын холбогч гүүр болгож чадна гэж үзэж байна.⁵ Мөн АНУ-с НҮБ-д төлөөлж суугаа элчин сайд Самантай Пауэр гадаадад хийх аялал, айлчлалуудын үеэр спортоор дамжуулан, дэлхийн өнцөг булан саад бэрхшээлийг даван туулж, байгаа эмэгтэйчүүд, охидтой харилцахдаа ашиглаж тэдэнд урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгохыг хичээдэг⁶ ажээ.

Спортын дипломат харилцааны эцсийн гол зорилго нь улс төр, соёл, газарзүйн саад бэрхшээл, ялгаатай байдлыг даван туулж, улс хоорондын найрсаг харилцаа, ойлголцол, хамтын ажиллагааг хөнгөвчлөн, төгөлдөржүүлэхийн тулд спортын хүчийг ашиглах явдал юм. Энэ нь улс орнуудын хоорондын харилцаа холбоо тогтоох, өөрсдийгөө эергээр

² Sport diplomacy: A literature review of scholarly and policy sources., Towards an EU sport diplomacy, page 9

³ David Thibodeau, “Sport diplomacy for development and peace” article <https://www.sportanddev.org/latest/news/sport-diplomacy-development-and-peace>

⁴ Sports diplomacy 2030 agenda, Commonwealth of Australia, Department of Health, 2019

⁵ <https://eca.state.gov/sports-diplomacy>

⁶ <https://fj.usembassy.gov/lailanie-burnes-and-samantha-power-promote-women-and-girls-empowerment-through-sport/>

харуулах, ялгаатай соёл, нийгэм эдийн засгийн зорилтуудыг сурталчлах хөшүүрэг болох хэрэгсэл юм.

2. Спортын арга хэмжээгээр дамжуулан Монгол улсын гадаад бодлогын арга хэрэгслүүдийг нэмэх боломж

Монгол Үндэсний Олимпын хороо 1956 оны 2 дугаар сарын 26 өдөр байгуулагдаж 1956 оны 6 дугаар сарын 5-ны өдөр ЗХУ-ын Москва хотод болсон ОУОХ-ны 60 дахь их хурлаар хүлээн зөвшөөрч, ОУОХ-ны гишүүн болсон. Монгол Улсын анхны олимпын 1964 оны “Токиогийн Олимп”-ийн наадамд оролцсоноос хойш 60 орчим жилийн (1984 оны Лос Анжелесийн олимпын наадамд оролцоогүй) олимпын наадмын туршлага, амжилт (30 медаль) бүтээлийн түүхийг бичсээр байна.

Олимпын хөдөлгөөний үндсэн зорилго нь нөхөрлөл, эв нэгдэл, шударга өрсөлдөөний үзэл санаагаар харилцан ойлголцлыг бий болгох, аливаа төрлийн ялгаварлан гадуурхахгүйгээр спортоор хичээллэх замаар энх тайван, сайхан ертөнцийг бий болгоход хувь нэмрээ оруулах явдал гэж үздэг.⁷

Зураг 1. Хятад улсын зочлох өргөөнд албаны төлөөлөгчид айлчилж буй нь



Монгол улсын хувьд Олимпын наадам болоод тивийн спортын наадмуудад оролцох оролцооны хувьд зөвхөн спортын арга хэмжээнээс гадна улс эх орноо сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах боломж нээлттэй болсон. Үүний жишээ нь “Токио-2020” олимпын наадмын үеэр “Үндэсний зочлох өргөө” буюу “Монгол хаус” байгуулах зөвшөөрөл авч Токио цамхагт виртуал зочлох өргөөг байгуулж олимпын наадмын турш зохион байгуулж, ажиллуулсан нь анхны туршлага болсон.

Олимпын наадмын “Үндэсний зочлох өргөө” нь анх Барселона-1992 олимпын наадмын үеэр Голланд улс өөрсдийн “зочлох өргөө”-г буюу “Голланд хэйнекен хаус” байгуулснаас хойш олимпын наадмын уламжлал болсон⁸. Үндэсний зочлох өргөөний гол үзэл санаа нь анхандаа тамирчдын гэр бүл, найз нөхөд, ойр дотны хүмүүсийн цуглах газар хэлбэртэй байсан бөгөөд өргөжин тэлсээр тухайн улсын соёл, уламжлал, олимпын хөдөлгөөний түүхийг таниулах урлаг, соёлын арга хэмжээнүүд зохион байгуулах, музей

⁷ Олимпын үнэт зүйлс, ОУОХ (<https://olympics.com/ioc/olympic-values>)

⁸ <https://www.insidethegames.biz/articles/1086275/holland-heineken-house-details-revealed>

ажиллуулах, соёл, уламжлал таниулах олон төрлийн үйл ажиллагаанууд нэг дор цогцлоон зохион байгуулах, Үндэсний Олимпын хорооны төв штаб, үндэсний спортын холбоодын штаб, хэвлэл мэдээллийн нэгдсэн төв, төрийн албан болон албан бус уулзалтууд зохион байгуулах тавцан болж хөгжсөн. Олимпын наадмын үеэр улс орнуудын төрийн тэргүүн болон улс төрийн албан тушаалтнууд, үндэсний болон олон улсын хэмжээнд эдийн засаг, нийгмийн нөлөө бүхий зочид цуглардаг. Энэ үеэр албан болон албан бус уулзалтуудыг “Олимпын хотхон”-д зохион байгуулах боломж хомс буюу ОУОХ-ны өмч бүхий нэгдсэн аккредитацийн хүрээнд хязгаарлагдмал болдог учир тухайн үйл ажиллагаануудыг гадуур зохион байгуулах шаардлага тулгардаг. Иймд улс орнууд өөрсдийн үндэсний зочлох өргөө нь зарим уулзалтуудыг зохион байгуулах гол хэрэгсэл болох боломжтой.⁹

Пёнчан-2018 өвлийн 23 дахь олимпын наадмын үеэр АНУ, Швед, Швейцар улсууд хамтран “Үндэстнүүдийн тосгон” нэртэйгээр өөрсдийн “үндэсний зочлох өргөөг” зохион байгуулсан. Үндэстнүүдийн тосгоны зураг төсөл, бүтээн байгуулалтын үзэл санаа нь хог хаягдалгүй, дахин боловсруулах боломжтой, эрчим хүчний хэмнэлттэй технологийн шийдлүүдийг ашиглан, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг илтгэсэн архитектурын ирээдүйн өнгө төрхийг дэлхий нийтэд таниулах зорилготой байжээ.

Зураг 2. АНУ, Швед, Швейцар улсуудын хамтарсан “Үндэстнүүдийн тосгон”



Энэхүү судалгааны ажлын хүрээнд спортын дипломат харилцааны хүрээнд МУ Олимпын наадмын хүрээнд зочлох өргөөг зохион байгуулснаар гадаад бодлого болон дотоодын өсөлт хөгжилд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлохын тулд сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд улс орнуудын Олимпын наадмын үеэр зохион байгуулсан “Үндэсний зочлох өргөө”-ний нийтлэг үзэл санаа дээр үндэслэн олон төрлийн арга замуудыг шинжилж үзэхэд дараах хүснэгтэд дурдсанаар нөлөө үзүүлэх боломжтой ажээ. Үүнд:

Хүснэгт 1. “Үндэсний зочлох өргөө”-ний гадаад бодлогод үзүүлэх хувь нэмэр

Соёл ба үндэстний хэв шинжийг сурталчлан таниулах:	Үндэстний соёл, өв уламжлалыг дэлхийн үзэгчдэд харуулах тавцан болж өгдөг. Эдгээр нь тухайн улс орныг олон улсын
---	--

⁹ Wolfgang. M, Andrew. Z, 2012, *International Handbook on the Economics of Mega Sporting Events*, Cheltenham, p143

	хэмжээнд хэрхэн хүлээн авах тухайд нөлөөлөх.
Эдийн засагт үзүүлэх нөлөө:	Аялал жуулчлалыг хөгжүүлж, ажлын байрыг бий болгож, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлнэ. Үндэсний зочлох өргөөнд хүрэлцэн ирэх зочдын урсгалаар дамжуулан шууд болон шууд бус орлого нэмэгдэх, улс орны эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
Дипломат харилцаанд үзүүлэх нөлөө:	Янз бүрийн орны засгийн газар, төрийн албан тушаалтнууд, дипломатчид, бизнесийн төлөөлөл хооронд дипломат харилцаа холбоо тогтоох боломжийг олгоно. Олимпын үеэр албан бус хэлэлцүүлэг, хэлэлцээрүүдийг зохион байгуулж, харилцаа холбоо тогтоох нь цаашдын хамтын ажиллагаа, түншлэлийг өргөтгөх.
Худалдаа, хөрөнгө оруулалтад үзүүлэх нөлөө:	Тухайн улс орны болон санхүүжүүлэгч ОУ-ын компаниудын худалдаа, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнүүдийг сурталчлахад ашиглаж болно. Эдгээр нь боломжит хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч тал, түншүүдэд аж үйлдвэрлэл, бүтээлч үйлдвэрлэл зэрэг эдийн засгийн бодит чадавхыг харуулах платформ болно.
Олон нийтийн оролцоонд үзүүлэх нөлөө:	Үндэсний зочлох өргөөг амжилттай зохион байгуулахад Олимпын наадам хүлээн авагч орон нутгийн иргэд, тухайн орон нутагт оршин сууж байгаа бусад улсын иргэд ихэвчлэн оролцож, тэдний оролцоог бий болгодог. Энэ нь сайн дурын ажил хийх боломж, соёлын солилцоо, олон нийтийн оролцооны эерэг өгөөжийг бүтээж байдаг.
Урт хугацааны нөлөө:	Тухайн улс орны олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх байдал, урт хугацааны эдийн засаг, дипломат харилцаанд эерэг өвийг үлдээж, урт хугацааны нөлөө үзүүлэх боломжтой.

Дүгнэлт

Уг судалгааны ажлын хүрээнд спортын дипломат ажиллагааны Монгол улсын гадаад бодлого болон дотоодын өсөлт хөгжилд үзүүлж болох арга хэрэгслүүдээс “Үндэсний зочлох өргөө”-г онцлон бий болох боломжуудыг эрэлхийлэн дараах дүгнэлтэд хүрлээ.

Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 5 дахь тулгуур зарчмын 25.2 дахь хэсэгт заасан “Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” зорилгын хүрээнд ОУОХ-ны гишүүн байгууллага болох Монголын Үндэсний Олимпын хороотой хамтран урт хугацааны төлөвлөгөө гаргаж зөвхөн Олимпын наадам ч гэлтгүй тивийн хэмжээний спортын наадмуудын үеэр тогтмол зохион байгуулдаг байх нь ямар ач холбогдолтой, улс орны гадаад дипломат харилцаанд бий болох боломжуудын тухай зарим асуудлыг хөндөв.

Улс орны хөгжлийн гол суурь нь гадаад дотоод бодлогын уялдаа холбоо бөгөөд, гадаад бодлого нь тухайн улс орны нүүр царай болохын хувьд хөгжиж буй болон өндөр хөгжилтэй улс орнууд зөөлөн хүчний бодлогыг баримтлах чиг хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй ажиглагдаж байна. Монгол улс гадаад бодлогын хувьд энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан олон тулгуурт бодлого явуулах тухай үзэл баримтлал нь спортын дипломат харилцааг хөгжүүлэх, өргөтгөх суурь боломж байгааг харуулж байна.

Abstract:

The goal of this article is to study the multifaceted role of sports diplomacy in shaping Mongolia's foreign policy including international relations, influencing political, social, and economic relations, especially by using major international sports events for strategic purposes. This article aims to evaluate the effectiveness of sports as a diplomatic tool through case studies and analyzing the impact of sports on diplomatic relations between countries. In order to develop Mongolia's diplomatic relations with foreign countries and support international cooperation, it is necessary to make a conclusion about how sports events, the "Olympic Games" of the IOC, and the continental sports games are strategically leveraged.

Key words: Sports diplomacy, National house, Olympic games, International Olympic Committee (IOC), Soft power

Ашигласан ном, материал

Wolfgang. M, Andrew. Z, 2012, International Handbook on the Economics of Mega Sporting Events, Cheltenham, p143

<https://olympics.com/ioc/faq/history-and-origin-of-the-games/what-is-the-origin-of-the-olympic-games>

Sport diplomacy: A literature review of scholarly and policy sources., Towards an EU sport diplomacy, page 9

David Thibodeau, “Sport diplomacy for development and peace” article

<https://www.sportanddev.org/latest/news/sport-diplomacy-development-and-peace>

Sports diplomacy 2030 agenda, Commonwealth of Australia, Department of Health, 2019

<https://eca.state.gov/sports-diplomacy>

<https://fj.usembassy.gov/lailanie-burnes-and-samantha-power-promote-women-and-girls-empowerment-through-sport/>

Олимпын үнэт зүйлс, ОУОХ (<https://olympics.com/ioc/olympic-values>)

**ТӨРӨӨС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГАД ОЛГОДОГ
САНХҮҮЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Г.Туяагэрэл
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Э.Эрдэнэцэцэг
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Төрийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагад санхүүжилт олгодог бөгөөд энэ санхүүжилт нь тодорхойгүй, ил тод бус байгаа нь дээрх сэдвийг судлах гол үндэслэл болсон. Тус өгүүллээр төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад олгож байгаа санхүүжилтийн төрөл, тэдгээрт шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьсон юм. Энэ хүрээнд Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдал, мөн төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад олгож байгаа санхүүжилтийг 1. Төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгуулдаг “Хамтран ажиллах гэрээ”, 2. Төрийн байгууллагын дэргэдэх хэвлэл мэдээллийн алба, 3. Хэвлэл мэдээллийн байгууллагад төрөөс үзүүлж буй албан ёсны санхүүгийн дэмжлэг гэсэн гурван бүлэг сэдвийн хүрээнд авч үзсэн.

Түлхүүр үгс: Төрийн байгууллага, улс төр, хэвлэл мэдээллийн байгууллага, гэрээ, санхүүжилт.

Удиртгал:

Төр нь улс төрийн амьдралд харьцангуй бие даасан үйл ажиллагаа явуулдаг улс төрийн бодлогын гол субъект юм.¹ Улс төрийн нам нь нийгмийн харилцаанд улс төрийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй оюун санааны түүчээ болсон байгууллага бөгөөд улс төрийн системийн гол бүрдүүлэгч юм.² Эдгээр тодорхойлолтоос төрийг бүрэлдүүлэгч нь улс төрийн нам гэдгийг харж болно. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төрийн институт болгон судалж, улс төрийн оролцогч гэж үздэг. Нөгөө талаас хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрийн бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах чухал үүрэгтэй улс төрийн коммуникацын арга хэрэгсэл. Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төрийн нам, улс төрчид өөрт ашигтай байдлаар ашиглаж, сонгогчидтой харилцаа холбоо үүсгэж, улмаар засгийн эрхэнд гарахдаа ашигладаг. Энэ зорилгоор төрийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагад санхүүжилт олгодог бөгөөд тус санхүүжилт нь тодорхойгүй, ил тод бус байгаа нь дээрх сэдвийг судлах гол үндэслэл юм.

Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад олгож байгаа санхүүжилтийн төрөл, тэдгээрт шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьсон.

Зорилт 1: Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ?

¹ Улс төрийн шинжлэх ухаан. УБ. 2001, 276 дахь тал

² Б.Эрдэнэдалай, Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршилага ба Монгол дахь тулгамдсан асуудал, 2023

Зорилт 2: Төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгуулдаг “Хамтран ажиллах гэрээ-ний зорилго юу вэ?

Зорилт 3: Төрийн байгууллагын дэргэд хэвлэл мэдээллийн алба байх хэрэгтэй юү?

Зорилт 4: Хэвлэл мэдээллийн байгууллагад төрөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэг нь үр дүнтэй байна уу?

Монголын улс төр болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан хамаарлыг судалсан судалгааны бүтээл олон байна. Тухайлбал, Б.Хандсүрэн “Засаглал ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл” УБ. 2014, Т.Номуундарь “Монголын улс төр, хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан хамаарлын эмпирик судалгаа”, УБ. 2015, Л.Туул “Улс төрийн шийдвэрт хэвлэл мэдээллийн үзүүлэх нөлөө” УБ. 2015, Э.Хосбаяр “Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн байдалд анализ хийх нь” УБ. 2022 гэх мэт магистрын зэрэг горилсон судалгааны бүтээл бий. Дээрх судалгааны ажлууд нь өөр өөр байр сууринаас улс төр ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан хамаарлыг судалсан. Тодруулбал, Б.Хандсүрэн Ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл өндөр ач холбогдолтой болохыг онцолсон бол Л.Туул Улс төрийн шийдвэрт хэвлэл мэдээллийн үзүүлэх нөлөөг тодорхойлжээ. Т.Номуундарь Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд улс төрөөс нөлөө үзүүлж, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төрчид өөрт ашигтай байдлаар ашиглах тохиолдол гарч байгааг дурдсан байна. Харин Э.Хосбаяр судалгаандаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчид нь улс төрийн албан тушаалтнууд байгаа, томоохон мэдээллийн байгууллагуудын 70-аас дээш хувийг улс төрийн өндөр албан тушаалтнууд эзэмшиж байгааг өгүүлжээ. Мөн хэвлэл мэдээлэл улс төрчдөөс хараат бус болж эхэлж байгаа ч захиалгын сэтгүүл зүй хөгжих суурь тавигдаад байна хэмээн үзсэн байна. Энэхүү судалгаа нь төрийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд явуулж байгаа бодлогыг бодит баримтад тулгуурлан тайлбарласнаараа шинэлэг байлаа.

Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдал

Монголын хэвлэл мэдээллийн салбарт 1990-ээд оны эхэнд төрийн мэдээллийн хэрэгсэл ноёрхож байсан хэдий ч маш богино хугацаанд зах зээлийн шинэ орчин хөгжиж, хувийн сонин, хэвлэл олноор бий болсон. Ардчилалд шилжсэнээс хойш чөлөөт хэвлэл, чөлөөт сэтгүүл зүй хэмээх нэршил бий болж, улмаар 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль батлагдсан нь Монголын сэтгүүл зүйд томоохон ололт болж, олон хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулах суурь нөхцөлийг бүрдүүлсэн юм. 1999 онд манай улсад 200 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол ажиллаж байна гэсэн тоо гарсан байдаг. Үүнээс хойш тасралтгүй өссөөр Хэвлэлийн хүрээлэнгээс 2022 онд хийсэн судалгаагаар 64 сонин, 50 радио, 135 телевиз, 191 веб сайт, 46 сэтгүүл, нийт 486 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна.³ Тэр дундаа сонин, сэтгүүлийн тоо сүүлийн 23 жилийн хугацаанд хамгийн доод үзүүлэлтэд хүрсэн бол цахим мэдээллийн хэрэгслийн хувьд энэ нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Хэвлэл мэдээллийн салбарт гарч буй энэ өөрчлөлт нь цахимжих хандлага бөгөөд цахим шилжилт эрчимтэй явагдаж байна.

Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллага жил бүр дэлхийн 180 орны хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдалд үнэлгээ хийж, хэвлэлийн эрх чөлөөний индексийг гаргадаг. Манай улс 2013 оноос хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдлаа үнэлүүлж эхэлсэн бөгөөд 2023 онд хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр 88-д орсон.

³Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр, УБ 2022 он, Хэвлэлийн хүрээлэн

Зураг 1. Хэвлэл эрх чөлөөний индекс Монгол Улс.



Эх сурвалж: Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллага

Өмнө нь дурдсанчлан, өдгөө Монголд 486 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Хэвлэл мэдээллийн байгууллага урт хугацаанд, тогтвортой үйл ажиллагаа явуулахад орлогын эх үүсвэр чухал үүрэгтэй. Төрийн байгууллагаас төлдөг зар, сурталчилгааны орлого бол хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүжилтийн бас нэгэн чухал эх үүсвэр болсон. Гэвч энэ талаар тодорхой тоо баримт байдаггүй.⁴

Монголын төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад үзүүлж буй санхүүжилтийг

1. Төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгуулдаг “Хамтран ажиллах гэрээ”,
2. Төрийн байгууллагын дэргэдэх хэвлэл мэдээллийн алба,
3. Хэвлэл мэдээллийн байгууллагад төрөөс үзүүлж буй албан ёсны санхүүгийн дэмжлэг гэсэн гурван үндсэн сэдвийн хүрээнд авч үзлээ.

Төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгуулдаг “Хамтран ажиллах гэрээ”

Төрийн байгууллагууд мэдээлэл, сурталчилгаандаа зориулан жил бүр тодорхой хэмжээний мөнгө төсөвлөдөг. Тухайн мөнгийг хэрхэн зарцуулах талаар ямар нэгэн хууль, дүрэм, журам, зохицуулалт байдаггүй ч бараг бүх төрийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагуудтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулдаг.

Төрийн байгууллагууд нь тухайн оны эхэнд хэвлэл мэдээллийн байгууллагуудаас хамтран ажиллах хүсэлт авч, үүний үндсэн дээр гэрээгээ байгуулдаг. Тухайн оны санхүүжилтээс хамаарч хэдэн хэвлэлтэй, ямар мөнгөн дүнгээр гэрээ байгуулахаа шийддэг бөгөөд хэвлэл мэдээллийн нэг хэрэгсэлтэй багадаа 2 сая, ихдээ 50 сая төгрөгөөр гэрээ байгуулдаг гэх мэдээлэл байна. Төрийн байгууллагаас гэрээ байгуулах хэвлэл мэдээллийн байгууллагыг сонгон шалгаруулах үйл явц ил тод бус, мөн тодорхойгүй байдаг. Зарим тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтны талаарх сөрөг мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэхгүй байх тохироо хийдэг. Үүнийг “Хаалтын гэрээ” гэх нь бий. Энэ нь төлбөртэй сэтгүүл зүйг өөгшүүлж, мэргэжлийн хэм хэмжээг алдагдуулж байна. Гэхдээ гэрээнд ийм агуулга байхгүй ч жижиг хэвлэл мэдээллийн байгууллагад “Хаалтын гэрээ” үйлчилдэг бол томоохон байгууллага нь гэрээгээр албан ёсны мэдээллийг зөвхөн нийтлэх, цахим

⁴[Media ownership monitor Mongolia 2016](#)

хуудастаа түгээх л үүрэг хүлээдэг. Мөн хамтын ажиллагааны гэрээ бүрийг “Хаалтын гэрээ” гэж ойлгож болохгүй юм.

“Захиалагч талын нэр хүндэд харшлах аливаа сөрөг мэдээ мэдээллийг захиалагч талд мэдэгдэх, нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээнэ” гэдэг заалтыг “Хаалтын гэрээ” гэдэг нэр томъёогоор ойлгож болно⁵ гэжээ.

Төрийн байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй Иргэний хууль болон холбогдох бусад хуулийн дагуу гэрээ байгуулдаг. Гэрээний заалтуудаас дурдвал,

- Захиалагч буюу төрийн байгууллагын хувьд мэдээлэл түгээхэд шаардагдах бүх төрлийн мэдээ, мэдээллээр гүйцэтгэгчийг хангах, яаралтай гүйцэтгүүлэх ажил гарвал урьдчилан 1-3 хоногийн өмнө гүйцэтгэгч талд мэдэгдэхээр тусгасан байна.
- Харин гүйцэтгэгч буюу хэвлэл мэдээллийн байгууллага нь гэрээнээс гадуурх үйл ажиллагааны хүрээнд аливаа мэдээ, мэдээллийг түгээхдээ байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагаатай хамааралтай эсэхийг сайтар нягтлан судалсны үндсэн дээр эх сурвалжийг тодорхойлон мэдээлэх үүрэгтэй.
- Мөн гэрээнд заасан үүргийг гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүн, байгууллагын нууцад хамаарах аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно гэжээ.

Шилэн дансны тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар нь таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр зэрэг мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ⁶ гэж заасан байдаг.

Энэ хуулийн дагуу төрийн байгууллага нь цахим хуудасныхаа “Шилэн данс”-нд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээнийхээ үнийн дүнг оруулах үүрэгтэй. Гэвч энэ мэдээллийг олон нийтэд хүргэхээс зайлсхийж зарим төрийн байгууллага таван сая төгрөгөөс доош мөнгөн дүнгээр гүйлгээг хувааж хийдэг байна.

2012 онд Глоб интернэшнл төвөөс Засгийн газрын 10 байгууллагад хэвлэл мэдээлэлд зар цуулсан хөрөнгийн талаар мэдээлэл авах хүсэлт илгээжээ. Зөвхөн 2012 онд УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газар зэрэг 10 байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах мэдээлэл, сурталчилгаанд зориулан 4.1 тэрбум төгрөг төсөвлөжээ. Сангийн яамны мэдээлснээр, УИХ-аас мэдээлэл, сурталчилгаанд 3 тэрбум орчим төгрөг, Засгийн газар 758 сая төгрөг зарцуулсан бол Улаанбаатар хотын захиргаанаас 482 сая төгрөг зарцуулсан байна.

Төрийн байгууллагуудад мэдээлэл сурталчилгааны төсвийг хэрхэн зарцуулах талаар ямар нэгэн журам байхгүй бөгөөд ийм шийдвэрийг ихэвчлэн удирдлага гаргадаг. Төрийн байгууллагын хэвлэлийн ажилтнууд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулахдаа “Хамгийн том мэдээллийн хэрэгсэл байх”, эсвэл хамгийн хямд, эсвэл тухайн байгууллагын удирдлагын танил, хамаарал бүхий мэдээллийн хэрэгслийг сонгодог байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-д Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй гэсэн байдаг. Харин төрийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй гэрээ байгуулж, өөрсдийн хүссэн агуулгаа нийтлүүлэх байдлаар мэдээллийн агуулгад хяналт тогтоож тус хуулийг зөрчиж байна гэж үзэж болохоор байна.

Төрийн байгууллагын дэргэдэх хэвлэл мэдээллийн алба

Төрийн байгууллагууд мэдээллээ олон нийтэд хүргэх зорилгоор хэвлэлийн ажилтантай байдаг байсан бол сүүлийн жилүүдэд хэвлэлийн алба, хэлтэс, газар хэмээх томоохон бүтэц, орон тоотой болсон. Тухайлбал, 1991 онд Улсын Бага Хурлын Тамгын газрын бүтэц, орон тооны хуваарийг батлахад Тамгын газрын Зохион байгуулалтын хэлтэст харьяалагдах Дотоод ажлын хэсэгт Хэвлэл мэдээллийн төлөөлөгч гэсэн нэг л орон тоо батлагдаж байжээ. Улмаар 1992-2000 онд Хэвлэл мэдээллийн алба, 2000 онд Хэвлэл

⁵ Э.Хосбаяр “Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн байдалд анализ хийх нь”, УБ 2022

⁶ Шилэн дансны тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/10497>

мэдээлэл, олон нийттэй харилцах алба, 2001 онд Хэвлэлийн алба, 2003 онд Хэвлэл мэдээллийн алба, 2008 онд Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны хэлтэс, 2009 оноос Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн байна. 2016 оноос УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь Мэдээлэл сурталчилгааны алба, Студи гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй болсон бол 2022 оны гуравдугаар сараас Олон нийттэй харилцах алба шинээр байгуулж, 16 хүний орон тоотойгоор ажиллаж байна. Тус хэлтэс нь УИХ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, УИХ, Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, иргэд, олон нийтийн санал бодлыг хууль тогтоох үйл ажиллагаанд тусгах, хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд парламентын боловсрол олгох, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг эрхлэн гаргах чиг үүргийг гүйцэтгэдэг. Мөн НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь 2022 оноос Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар болон өргөжсөн. Нийслэлийн харьяа нутгийн захиргааны 30 гаруй байгууллага байдаг. Эдгээр нь тус бүр хэвлэлийн ажилтантай, бас төсөвтэй байсан тул зардал хэмнэх үүднээс дээрх газрыг байгуулсан. Харин 2023 оноос эргээд НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс болсон.

Төрийн байгууллагын дэргэдэх хэвлэлийн албаны ач холбогдол болон тус албаны сул талын талаар сэтгүүлч болон хэвлэлийн төлөөлөгч нараас нээлттэйгээр асуухад дараах нийтлэг хариултыг хэлж байлаа.

Төрийн байгууллага дэргэдээ хэвлэлийн албатай байхын ач холбогдол

- Мэдээлэл түргэн, шуурхай олон нийтэд, олон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хүрнэ.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрийн байгууллагын мэдээллийн сенсаций хэсгийг л авч, асуудлын гол хэсгийг орхигдуулах тал ажиглагддаг. Харин хэвлэл мэдээллийн алба нь тэр орхигдсон хэсгийг мэдээлж, мэдээллийг олон хүнд хүргэх нөхцөлийг бүрдүүлдэг.
- Хэвлэл мэдээллийн салбарт ажиллах хүчин дутагдалтай байгаа энэ үед сэтгүүлчдийн цаг, ажлыг хөнгөвчилнө.

Төрийн байгууллага дэргэдээ хэвлэлийн албатай байхын сул тал

- Мэдээллийг зөвхөн төрийн байгууллагын нэг л өнцгөөр хүргэнэ. Энэ нь иргэдэд бодит мэдээлэл хүрэхгүй байх эрсдэлтэй бөгөөд нэг өнцгийн мэдээлэл олон хүнд хүрнэ гэсэн үг.
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хүний нөөцөө “булаалдах” -д хүрдэг.
- Төсвийн мөнгө ажилтнуудын цалин, тоног төхөөрөмж гэх мэтэд зарцуулагдаж, үргүй зардлыг бий болгож байдаг.

Хэвлэл мэдээллийн байгууллагад төрөөс үзүүлж буй албан ёсны санхүүгийн дэмжлэг

МҮОНРТ-д үзүүлэх санхүүгийн дэмжлэг

1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар төрийн эзэмшлийн мэдээллийн хэрэгслийг хориглосон. Мөн 2005 онд Олон нийтийн радио телевизийн тухай хууль батлагдаж, Үндэсний радио, телевизийг олон нийтийнх болгох үйл явц эхэлсэн. Хуулийн дагуу олон нийтийн радио телевизээр арилжааны сурталчилгаа явуулахыг хориглосноор хувийн хэвшлийн телевиз, радиод сурталчилгааны орлого олох орон зайг тодорхой хэмжээгээр чөлөөлж өгсөн. Тус хуулийн 7.1-д Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаагаа явуулахад нь төрөөс санхүү, эдийн засгийн зохих дэмжлэг үзүүлнэ гэж тусгасан бөгөөд энэ талаарх мэдээлэл төдий л тодорхой бус байгаа юм.

МҮОНРТ 2018-2020 онд Үндэсний зөвлөлөөс баталсан орон тооны хязгаарт багтаан 758-763 хүний орон тоотойгоор телевизийн 5, радиогийн 3 сувгаар нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэж байсан бөгөөд Монголын дуу хоолой радио Орос, Хятад, Япон, Англи, MNB world телевизийн суваг англи хэлээр тус тус нэвтрүүлгээ цацсан. Тус байгууллага 2018 онд улсаас 7.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан нь нийт орлогын 40.2 хувь байсан. 2019 онд 9 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд нийт орлогын 43.3 хувийг бүрдүүлж

байв. Харин 2020 онд 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан нь орлогын 27.2 хувийг эзэлж байна. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгээр МҮОНРТ нийт ажиллагсдынхаа цалинг тавьж, нийгмийн даатгал, шимтгэлийг төлдөг. Мөн санхүүжилтийг нь шалтгаангүйгээр хасах гэх мэтээр улс төрийн нөлөө ордог гэдгийг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн даргаар ажиллаж байсан Б.Энхмандах “Өдрийн сонин”-д өгсөн ярилцлагадаа дурдсан байна. Мөн МҮОНРТ нийслэлийн өрхөөс сар бүр 1100 төгрөг, орон нутгийн айлуудаас 600-800 төгрөгийн хураамж авдаг. Дээрх хураамж Монгол Улсын оюуны дархлааг хамгаалах, соёлын өвийг өвлүүлэн үлдээх, үндэстэн ястны давтагдашгүй үнэт зүйлийг авч үлдэхэд зарцуулагддаг хэмээн тус телевизээр мэдээлсэн.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд уг байгууллагад олгох улсын төсвийн дэмжлэгийг хэдий хэмжээгээр, хэрхэн тооцоолохыг тодорхойлж өгөөгүй. Хуулийн дагуу МҮОНРТ-ийн удирдах дээд байгууллага буюу Үндэсний зөвлөл жилийн төсвөө хэлэлцэж, улсын төсөвт тусгах санал гаргана. Түүнчлэн айл өрхөөс хураах хураамжийн хэмжээг Засгийн газраас Үндэсний зөвлөлийн саналд тулгуурлан тогтооно хэмээн ерөнхийлөн хуульчилсан.

МҮОНРТ-ийн редакцын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулсан. Гэвч Глоб интернэшнл төвийн мэдээлснээр, “2006 онд анхны Үндэсний зөвлөлийн гишүүдийг томилсны дараа тус байгууллагын ажилтнууд Түр хороо байгуулж, Үндэсний зөвлөл улс төрийн ашиг сонирхолд хөтлөгдөж, редакцын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж буй, удирдах боловсон хүчнийг хууль бусаар томилж буй зэргийг шүүмжлэн эсэргүүцэж эхэлсэн. Энэхүү тэмцэл нь нээлттэй захидлаас эхлэн суулт хүртэл үргэлжилсэн боловч бодит үр дүнд хүрч чадаагүй юм. Өнөөдрийг хүртэл МҮОНРТ-д улс төрийн нөлөө хүчтэй хэвээр байсаар байна. Энэ нь юун түрүүнд тус байгууллагын удирдах бүтцийн улс төрийн томилгоогоор илэрдэг” гэжээ.

МҮОНРТ өнгөн дээрээ олон нийтийн нэршилтэй боловч үнэндээ улс төрөөс хараат байгаа нь Үндэсний зөвлөлийн гишүүд хийгээд үүнд нэр дэвшигчид болон санхүүжилтийг эх баригч нам, хүчин хүссэндээ үедээ танадгаас харж болно. Тодруулбал, тус зөвлөлийн гишүүнд Ерөнхийлөгч 4, УИХ 7, Засгийн газар 4 хүн нэр дэвшүүлдэг. Мөн тус телевиз төрөөс санхүүжихээс гадна өрх бүрээс сар бүр 600-1100 төгрөгийн хураамж авдаг ч зарцуулалт нь тодорхойгүй, үзэх контентгүй, хуучинсаг гэх шүүмжлэл дагуулсаар байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг

2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталсан. Тус хуулийн зорилт нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасан. Гэвч энэ хууль бичигдсэнээсээ эсрэгээр буюу телевизүүдийг өргөн нэвтрүүлгийн, арилжааны хэмээн ялгаварлаж, шударга өрсөлдөөний зарчмыг зөрчиж, нэг хэсэгт нь л санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа юм.

"Өргөн нэвтрүүлэг" гэдгийг радио, телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэгтгэн харилцаа холбооны сүлжээ, төхөөрөмжөөр нэг цэгээс олон нийтэд нэгэн зэрэг хүргэнэ гэж томьёолсон.

Манайд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлдэг 80 телевиз байгаагаас 18 нь Улаанбаатар хотод, үлдсэн нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. Улаанбаатар хотод өргөн телевизийн үйлчилгээ эрхлэгчид

Зураг 2. Улаанбаатар хотод өргөн телевизийн үйлчилгээ эрхлэгчид

№	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР
1	АЭ энд ЖААГ ХХК	13000005	25-р суваг
2	Улаанбаатар телевиз ХХК	13000006	UBS
3	Гэгээн далай ХХК	13000011	TB 5
4	Алсын гэрэл ХХК	13000018	TM
5	Супер визн медиа групп ХХК	13000019	SBN
6	Суваг ти ви найм ХХК	13000024	TV 8
7	Эм Би Эс ХХК	13000025	C1
8	Медиа холдинг ХХК	13000026	TB9
9	Тэнгэрлэг эх орон ХХК	13000028	Central television
10	Эн Ти Ви Бродкастинг ХХК	13000029	NTV
11	Ийгл Бродкастинг ХХК	13000031	Ийгл нь юс
12	Монгол телевиз ХХК	13000049	Монгол ТВ
13	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	13000093	Стар
14	Про медиа нетворк ХХК	13000092	VTV
15	Имерж медиа ХХК	13000122	ETV
16	Медиа боловсрол суваг ХХК	13000139	Боловсрол суваг телевиз
17	Улс сүлд ХХК	13000159	Сүлд
18	Малчин удмын хийморь ХХК	13000158	Малчин

Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо

Зураг 3, 4. Орон нутагт өргөн телевизийн үйлчилгээ эрхлэгчид

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид Орон нутаг		
ЭЗЭМШИГЧ	ТОДРУУЛА	ХАМРАХ ХҮРЭЭ
1 Ар Би Эн Ти ХХК	AB телевиз	Архангай аймгийн нутаг дэвсгэрт
2 Мичид явас ХХК	Тамир телевиз	Архангай аймгийн нутаг дэвсгэрт
3 Эн Юу Ти 36 ХХК	Саян ТВ	Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт
4 МТД ХХК	Номгон телевиз	Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт
5 Өлгийгийн хийморь өөдөө ХХК	Баянхонгор телевиз	Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт
6 Баянхонгор засагчийн өргөн телевиз ХХК	Мазаалай телевиз	Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт
7 Сайхан Монгол ЭНАК НУТББ	Сайхан Монгол ТВ	Булган аймгийн нутаг дэвсгэрт
8 Хавсигт тайшир ХХК	Миний нутаг телевиз	Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт
9 Ногоон заман эхлэл ХХК	Алтай телевиз	Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт
10 Төх сүмт солонхи ХХК	Залуусан телевиз	Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт
11 Дархан мэдээлэл төв ХХК	DBS телевиз	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт
12 Аа жи би ти нэг ХХК	RGB TV	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт
13 ТВ Дорно ХХК	TV-4	Хиймэл дагуулан сүлжээгээр
14 М. Мөнхбаяр	Од телевиз	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт
15 Ди медиа агентлаг ХХК	DTV	Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт
16 Шинэ зураг ХХК	Нутаг 21	Дорнод аймгийн нутаг дэвсгэрт
17 Алдарт нөмөр ХХК	Дорнод телевиз	Дорнод аймгийн нутаг дэвсгэрт
18 Гэгээн гэгээ ХХК	МБЭЖИ телевиз	Дорнод аймгийн нутаг дэвсгэрт
19 Дорнын хэрлэн тал НУТББ	Дорнын ТВ6	Дорнод аймгийн нутаг дэвсгэрт
20 Тамсаг мэнгэгийн тал ХХК	Талын Анир ТВ	Дорнод аймгийн нутаг дэвсгэрт
21 Буянт чандмань социал медиа ХХК	Маргад телевиз	Дундговь аймгийн нутаг дэвсгэрт
22 Завхан толь сонин ХМХ	AIR-1 телевиз	Завхан аймгийн нутаг дэвсгэрт
23 Жавхлант ширээт ХХК	Шинэ завхан ТВ	Завхан аймгийн нутаг дэвсгэрт

ЭЗЭМШИГЧ	ТОДРУУЛА	ХАМРАХ ХҮРЭЭ
24 Номин Маас ХХК	NBTV (New Broadcasting Television)	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
25 Эрдэнэт тайвс сонин ХМХ	etv телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
26 Очир роуд ХХК	Тусгагс-1 телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
27 Асгатын гол ХХК	Мэдээллийн барх телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
28 Сэтгэлессинг ХХК	MBS телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
29 Ишхлан ХХК	EBS телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
30 БУНАДО ХХК	Тэнгэр TV	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
31 Фило ХХК	TV-24	Хиймэл дагуулан сүлжээгээр
32 Хас Өрнөг ТВ6	Хас телевиз	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
33 Дэлгээн соёлоо ХХК	Соёлоо телевиз	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
34 Төгсдөр-Өв ХХК	Арвайхээр чөлөөт суваг	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
35 Бутан соёл ХХК	Их Монгол	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
36 Гэгээн соёлоо ХХК	GMN телевиз	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
37 Түрдмгийн Бор Интернешнл ХХК	Алтай говь телевиз	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт
38 Ел нуурай ХХК	UCTV	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт
39 Говийн долгион мэдээллийн төв ТВ5	Говийн наран телевиз	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт
40 Моральн ширээ ХХК	SB TV	Хиймэл дагуулан сүлжээгээр
41 Датукон ХХК	BBS телевиз	Хиймэл дагуулан сүлжээгээр
42 МДЛО ХХК	Махдал телевиз	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт
43 Миний Монгол Энтертайвмент ХХК	Миний Монгол	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт
44 Төв явас ХХК	TBS телевиз	Төв аймгийн нутаг дэвсгэрт
45 Очир арвай төв ХХК	T6B Телевиз	Төв аймгийн нутаг дэвсгэрт
46 Сала-Уас ХХК	Уас телевиз	Увс аймгийн нутаг дэвсгэрт
47 Хоса ТВ ХХК	MBC ТВ	Увс аймгийн нутаг дэвсгэрт
48 Хиймэрийн эрчүүдийн хүч ХХК	Увс төв телевиз	Увс аймгийн нутаг дэвсгэрт

ЭЗЭМШИГЧ		ТОДРУУЛГА	ХАМРАХ ХҮРЭЭ
24	Номин Маас ХХК	NMTV /New Broadcasting Television/	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
25	Эрдэнэт таймс сонин ХМХ	etv телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
26	Очир роуд ХХК	Тусгай-1 телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
27	Асгалан гол ХХК	Мэдээллийн барж телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
28	Сэтгэлбэлснэгт ХХК	MBS телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
29	Илхэйн ХХК	EBS телевиз	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
30	БУНАДО ХХК	Тэнгэр TV	Орхон аймгийн нутаг дэвсгэрт
31	Фило ХХК	TV-24	Хийсэл дугуулан сүлжээгээр
32	Хас Өрвөг ТББ	Хас телевиз	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
33	Дэлгээн соёмо ХХК	Соёмо телевиз	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
34	Төгсгөдөр-Он ХХК	Арвайхээр чөлөөт суваг	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
35	Бутан соёл ХХК	Нх Монгол	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
36	Гэгээн соёмо ХХК	GMM телевиз	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт
37	Түдэлгийн Бор Интернешнл ХХК	Алтай говь телевиз	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт
38	Ел нуурай ХХК	UCTV	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт
39	Говийн дэлгээн мэдээллийн төв ТББ	Говийн наран телевиз	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт
40	Морьтын ширээ ХХК	SB TV	Хийсэл дугуулан сүлжээгээр
41	Дигуулан ХХК	BBS телевиз	Хийсэл дугуулан сүлжээгээр
42	МДЦО ХХК	Мандал телевиз	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт
43	Миний Монгол Энтертайммент ХХК	Миний Монгол	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт
44	Төв эмээс ХХК	TBS телевиз	Төв аймгийн нутаг дэвсгэрт
45	Очир арвай төв ХХК	TGB Телевиз	Төв аймгийн нутаг дэвсгэрт
46	Сама-Уас ХХК	Уас телевиз	Увс аймгийн нутаг дэвсгэрт
47	Хоса ТВ ХХК	MBC ТВ	Увс аймгийн нутаг дэвсгэрт
48	Хиймөрлөлг эрүүдийн хүч ХХК	Уас төв телевиз	Увс аймгийн нутаг дэвсгэрт

ЭЗЭМШИГЧ		ТОДРУУЛГА	ХАМРАХ ХҮРЭЭ
49	Уян утсан сүлжээ ХХК	Сүлжээ 3 телевиз	Улаанбаатар Багануур дүүргэ
50	Буян налайв ХХК	Буян телевиз	Улаанбаатар Налайв дүүргэ
51	Огторгуйн асар нийтийн мэдээллийн төв НУТББ	Ховд телевиз	Ховд аймгийн нутаг дэвсгэрт
52	Эко Жаргалант ХХК	Эко телевиз	Ховд аймгийн нутаг дэвсгэрт
53	Некст дэвшил ХХК	Олон ястны телевиз	Ховд аймгийн нутаг дэвсгэрт
54	Хувь хүний мэдээллийн баруун бүсийн институт НУТББ	Гэгээ TV	Ховд аймгийн нутаг дэвсгэрт
55	Обрал телевиз ХХК	Обрал ТВ	Ховд аймгийн нутаг дэвсгэрт
56	Хөвсгөл мэдээллийн төв НУТББ	Далай эхэ ТВ	Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт
57	Үзэгсэлэгт Мөрөн ХХК	Мөрөн ТВ	Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт
58	Өсөл прогресс ХХК	Хөвсгөл телевиз	Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт
59	Лха судан тэнгэр ХХК	Түрэмий ТВ	Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт
60	Өндөрлэн цахил өргөөц ТББ	Өндөрлэн телевиз	Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт
61	Эрчим хурдан хүлэг ХХК	Бүргэд ТВ	Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт
62	Ард контент групп ХХК	Хэнтий зайн ТВ	Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт

End of docum

Activate Windows

Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг дээрх 18 телевиз IPTV буюу олон суваг дамжуулах үйлчилгээгээр дамжуулан контентоо үзэгчдэд хүргэснийхээ төлөө нэг өрхөөс 2500 төгрөгийг “Монголын телевизүүдийн холбоо”-гоор дамжуулан хувааж авдаг.

2022 оны байдлаар Монгол Улсад 941 мянган өрх байгаа бөгөөд олон суваг дамжуулах үйлчилгээг хэрэглэгч 760 мянган өрх байна. Ийн үзвэл сард 1.9 тэрбум төгрөг төвлөрч, 18 телевиз тус бүр 105 сая орчим төгрөгийн санхүүжилт авдаг гэсэн үг. Хуульд энэ мөнгийг өргөн нэвтрүүлгийн бүх телевиз авахаар тусгаж, арилжааны телевизүүд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчтэй харилцан тохиролцохоор тусгасан ч энэ нь биеллээ олохгүй байна. Э.Хосбаяр “Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн байдалд анализ хийх нь” УБ 2022 судалгаандаа “Өргөн нэвтрүүлгийн нэг суваг сар тутам 40-60 сая төгрөгийн тогтмол орлоготой” хэмээжээ.

Зураг 5. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн хэрэглэгчийн тоо

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн хэрэглэгчийн тоо (2022 он)

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Нийт идэвхтэй хэрэглэгчийн тоо 2022 он	Улаанбаатар	АЙМГУУДЫН НИЙЛБЭР дүн
1	Юнивишн ХХК	322,376	232,257	90,119
2	ДДШ ТВ ХХК	288,051	92,963	195,088
3	Скаймедиа ХХК	50,433	43,644	6,789
4	Эн Би Си ХХК	32,153	32,153	
5	Монголсат нэтворкс ХХК	24,229	7,059	17,170
6	Монголын цахилгаан холбоо ХК	8,575	1,093	7,482
7	Шинэ сансар кабель	7,949	7949	
8	Сансар Дижитал ХХК	6,192	6,192	
9	Гал саятан ХХК	3,790		3,790
10	Агаарын суваг ХХК	2,800		2,800
11	ЖСММ БГБХ Нөхөрлөл	2,610		2,610
12	Цацраг трейд ХХК	2,472		2,472
13	Хаан Алтай Ховд ХХК	1,200		1,200
14	Би ти жи ХХК	1,000		1,000
15	Талст эрчим ХХК	820	820	
16	Эм Эм Ди Эс ХХК	700		700
17	Дөрвөн шарга ХХК	695		695
18	Дархан ширхэнцэг ХХК	630		630
19	Лха хөх тэнгэр ХХК	518		518
20	Оптимум нэтворк ХХК	437	437	
21	Ди Би Эс СИ ХХК	400		400
22	Мандал ширхэнцэг ХХК	400		400
23	Наран гурт ХХК	390		390
24	Болор утас	358	358	
25	Мөнх сөрөн чулуу ХХК	350		350
26	Орхон системс ХХК	300		300
27	Өвөр даваат ХХК	300		300
	Нийт	760,028	424,925	335,103

Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо

Мөн өргөн нэвтрүүлгийн телевизүүд тусгай зөвшөөрлийг 5-10 жилийн хугацаатай авч, дараагийн удаа мөн энэ хугацаагаар сунгуулах эрхтэй. Хуульд өргөн нэвтрүүлгийн телевиз тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг тусгаснаас чухам хэзээ, хэрхэн сонгон шалгаруулалт явуулах тухай тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн шинээр телевиз байгуулах гэж байгаа, мөн тусгай зөвшөөрлөө сунгах хүсэлтэй хуулийн этгээдэд зориулсан ерөнхий шаардлага байгаа бөгөөд арилжааны телевизүүд өргөн нэвтрүүлгийн телевизээр үйл ажиллагаа явуулах боломжийг боомилж, зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санхүүгийн илт давуу эрх олгож байна.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд үзэлт багатай Сүлд, ТМ, SBN зэрэг телевиз багтсан нь дээрх телевизүүд шаардлага хангаж байгаа юу гэдэг эргэлзээ үүсгэж буй юм. Товчхондоо, өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд олгож байгаа санхүүжилт нь зарим хэвлэл мэдээллийн байгууллагын толгойг илж, нөгөөг нь боомилсон гэж хэлж болохоор байна.

Ташрамд дурдахад, 2016 оны нэгдүгээр сар хүртэлх хугацаанд сонины борлуулалтыг НӨАТ-аас чөлөөлдөг байжээ. Харин 2015 оны 7 дугаар сарын 9-ны өдөр НӨАТ-ын тухай хуулийг шинэчлэн баталснаар дээрх хөнгөлөлт, чөлөөлөлт үгүй болсон байна.⁷ Одоогийн байдлаар хэвлэл мэдээллийн байгууллага бүр аж ахуйн нэгжийн нэгэн адил 10 хувийн НӨАТ, татвар, нийгмийн даатгал зэргийг төлж байна.

Дүгнэлт

Аливаа улсын ардчиллын хэмжүүр нь хэвлэлийн эрх чөлөө. Монгол Улсад хэвлэл төрийн байгууллага мэдээллийн байгууллагатай уялдаж ажиллах нь түгээмэл ажиглагдаж байна. Нэн ялангуяа, төрийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах замаар эдгээр хоёр субъектийн харилцаа идэвхэждэг. Мөн төрийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй гэрээ байгуулж, өөрсдийн хүссэн агуулгаа нийтлүүлэх байдлаар мэдээллийн агуулгад хяналт тогтоодог. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн байгууллагын харилцаа хамаарал энэ хэвээр үргэлжилбэл олон нийт үнэн, бодит мэдээллээр хангагдах боломж нь хумигдах эрсдэлтэй. Ингэснээр ардчиллыг бэхжүүлэх үйл явц ч удаашрах үр дагаврыг үүсгэж байна. Энэ эрсдэлийг бууруулах гол хүчин зүйл бол хэвлэл мэдээллийн зохицуулалт. ХБНГУ-д төрийн байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллагын харилцааг зохицуулж өгснөөр хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа ил тод үргэлжлэх боломжтой байна. Түүнчлэн аливаа хэвлэл мэдээллийн байгууллагыг улс төрийн ямар субъект эзэмшдэг, эсвэл харилцаа хамааралтай эсэх талаар мэдэх боломжтой байдаг.

Төрийн байгууллагууд мэдээллээ олон нийтэд хүргэх зорилгоор хэвлэлийн алба, хэлтэс, газар хэмээх томоохон бүтэц, орон тоотой болж, хэвлэл мэдээллийн байгууллагын хэмжээний чиг үүрэг, ажлыг гүйцэтгэж байгаа зэрэг нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчиж байна. Тус хуульд Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй, мөн Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно гэсэн байдаг. Гэтэл төрийн байгууллага дэргэдээ хэвлэлийн мэдээллийн байгууллагаас дутахгүй орон тоотой Хэвлэл мэдээллийн алба, хэлтэс, газрыг ажиллуулж, өөрийн хүссэн агуулгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудад түгээж байна.

Мөн төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад үзүүлэх санхүүгийн дэмжлэг ил тод бус, хангалтгүй, нэг хэсэгт нь давуу эрх олгосноос гадна улс төрийн нөлөө хүчтэй хэвээр байна. Тухайлбал, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар МҮОНРТ-д дэмжлэг үзүүлэхээр тусгасан ч олгох улсын төсвийн дэмжлэгийг хэдий хэмжээгээр, хэрхэн тооцоолохыг тодорхойлж өгөөгүй. Мөн МҮОНРТ-ийн редакцын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулсан ч улс төрийн нөлөө хүчтэй байсаар байна. Түүнчлэн өргөн

⁷ Хэвлэлийн хүрээлэн “Media ownership monitor Mongolia 2016”

нэвтрүүлгийн 18 телевизэд олгодог санхүүжилт нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад шударга бус өрсөлдөөнийг үүсгэж, санхүүжилтийн тэгш бус байдлыг бий болгож байгаа юм. Төр зарим хэвлэл мэдээллийн байгууллагад санхүүжилт олгосноор хэвлэл мэдээллийн хэрэгслийн өрсөлдөх чадварыг “боомилж” байна гэж үзэж болохоор байна.

Санал, зөвлөмж

- Төрийн байгууллагатай гэрээ байгуулах хэвлэл мэдээллийн байгууллагыг сонгон шалгаруулах үйл явцыг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, үүнийг тодорхой хууль, журмаар зохицуулах шаардлагатай.
- Төрийн байгууллагын хэвлэлийн алба, хэлтэс, газрын бүтэц, орон тоог цөөлж, зөвхөн тухайн байгууллага сэтгүүлчийг холбох үүрэгтэйгээр ажиллуулах.
- Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад олгодог олон улсын жишгийг судалж, нутагшуулснаар хэвлэл улс төрөөс хараат бус, тэгш боломжоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой.

Abstract:

The government organization provides funding to media organizations. But this funding is ambiguous and non-transparent, which is the main reason for researching the above topic. The article aimed to analyze the types of funding provided by the government to media organizations and determine the current situation.

In this context, the current situation of the media in Mongolia, as well as the funding provided by the government to media organizations, were discussed in the following three groups of topics:

1. Cooperation agreement signed by the government organization with the media;
2. Media department under the government organization,
3. Official financial support provided by the government to media organizations

Keywords: Government organization, politics, media organizations, contracts, financing.

Ашигласан ном, материал

1. Б.Эрдэнэдалай, Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал, 2023;
2. Ж.Төртогтох, С.Мөнхбат, С.Базарпүрэв, Д.Ундрах, Б.Эрдэнэдалай нар, Политологи: Эрдэм шинжилгээний бичиг №21 (571). 2023;
3. Улс төрийн шинжлэх ухаан. УБ. 2001;
4. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр, Хэвлэлийн хүрээлэн, УБ 2022 он;
5. Э.Хосбаяр “Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн байдалд анализ хийх нь”, УБ. 2022;
6. Б.Хандсүрэн “Засаглал ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл”, УБ. 2014,
7. Т.Номуундарь “Монголын улс төр, хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан хамаарлын эмпирик судалгаа”, УБ. 2015
8. Л.Туул “Улс төрийн шийдвэрт хэвлэл мэдээллийн үзүүлэх нөлөө” УБ. 2015,
9. Хэвлэлийн хүрээлэн “Media ownership monitor Mongolia 2016”
10. Шилэн дансны тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/10497>
11. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/15067>
12. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/424>
13. Глоб интернэшнл төвийн албан ёсны вэб сайт <https://www.gic.mn/>
14. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн 2017-2020 оны улсын төсвийн санхүүжилтийн хэрэгжилт, үр нөлөө <https://audit.mn/wp-content/uploads/2022/03/%D0%9C%D2%AE%D0%9E%D0%9D%D0%A0%D0%A2-2018-2020-%D0%A2%D0%90%D0%99%D0%9B%D0%90%D0%9D-20211020-hyrgyysen-1.pdf>

**2019 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ:
ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНОЛ**

Б.Баярбаатар

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн докторант
МАН-ын Хяналтын Ерөнхий Хорооны дарга

Д.Бумдарь

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн профессор

Хураангуй:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-нд Монгол Улсын Их Хурал баталж, 2019 оны 11 дүгээр сарын 26-нд Монгол Улсын Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан. Тус нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийг нэмж оруулсан. Үүнд:

1. Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.
2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.
3. Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, **төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.**” болно.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн заалтын гуравдах хэсэгт “*Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, **санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно***” хэмээн зохицуулсныг хууль тогтоогчийн зүгээс санхүүжилтийг ил тод болгож, намын дотоод ардчиллыг сайжруулж, улсын хэмжээнд бодлого дэвшүүлэн ажиллах, намуудыг төлөвшүүлэх, хариуцлагыг сайжруулахын тулд тус заалт батлагдсан хэмээн тайлбарлаж буй.

Харин тус заалтыг улс төрийн намууд, улс төрчид, эрдэмтэн судлаачид, олон нийтийн байр суурь дэмжсэн болон дэмжээгүй гэсэн хоёр хэсэгт хуваагдаж улс төрийн санхүүжилтийн зохицуулалтыг хийсэн анхдагч хууль батлагдах тухай яригдаж байсан ч улс төрийн намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамаарах зохицуулалтыг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тавдугаар бүлэгт “Улс төрийн намын санхүүжилт” томьёоллоор зохицуулж 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан байна.

Энэхүү өгүүллээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дах заалтын хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар батлагдсан төрийн санхүүжилтийн онолын ойлголт, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хэрхэн зохицуулах, ямар эрх зүйн орчин шаардлагатай, түүний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг судалж зарим улсын жишээг өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Улс төрийн нам, санхүүжилтийн хэлбэр, зохицуулалт, илт тод байдал, хяналт, санхүүжилтийн тайлан

1992 онд ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаар улс төрийн намын талаарх эрх зүйн орчин бүрдэж Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт *“нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;*” хэмээн зааснаар нам байгуулах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг олгож Монгол Улсад олон намын тогтолцоо бүрэлдэн тогтож эхэлжээ.

Нарийвчилсан зохицуулалт бүхий улс төрийн намын тухай хууль анхлан 1990 оны 5 дугаар сарын 10-нд “Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль” хэмээх нэрээр батлагдаж 3 удаа нэмэлт, өөрчлөлт¹ орж дараагаар нь 2005 оны 1 дүгээр сарын 28-нд “Улс төрийн намын тухай хууль”² хэмээн шинэчлэн батлагдсан байдаг. 2005 оны хуулийн шинэчилсэн найруулгаас өмнө улс төрийн намд төрөөс ямар нэгэн санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй байсан бол 2005 оноос хойш тус хуулийн 16-21 дүгээр зүйл, Сонгуулийн тухай хуулийн 40-60 дугаар зүйлээр санхүүжилтийг зохицуулж эхэлсэн. Дээрх хуулиудад нам, нэр дэвшигчид хамааралтай зохицуулалтууд болох санхүүжилтийн эх үүсвэр, зардлын хязгаарлалт, суудлын болон саналын мөнгө, сурталчилгааг дэмжих зохицуулалтууд багтдаг. Харин 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс хойш Улсын Үндсэн хуулийн 19.1 дүгээр зүйлийн 3 дах заалтын хүрээнд “Улс төрийн санхүүжилт” хэмээх ойлголтын шинжлэх ухааны онол, үзэл баримтлалыг тайлбарлах, нэгдсэн ойлголттой байх хэрэгцээ шаардлага үүссэн байна. Улс төрийн санхүүжилт, улс төрийн намын санхүүжилт гэсэн ойлголтууд улс төрийн шинжлэх ухаанд танигдаад нэлээн удсан боловч “улс төрийн санхүүжилт” хэмээх нэр томъёонд багтдаг **“төрийн санхүүжилт \public funding\”** гэх нэр томъёог онол, практикийн түвшинд тайлбарлан судалсан судалгаа ховор байна. Тиймээс энэ өгүүллийн хүрээнд төрийн санхүүжилтийн тухай онол, хандлага, зарчмыг тайлбарлахдаа 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шинэчлэн найруулсан Улс төрийн намын тухай хуульд тусгасан намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн зохицуулалтыг олон улсын сайн жишигтэй харьцуулахыг зорьлоо.

Онолын ойлголт:

Улс төрийн намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг болон нам өөрөө өөрийгөө санхүүжүүлэх арга хэлбэрийг тусгасан хэд хэдэн онол байна. Улс төрийн санхүүжилт нь улс төрийн кампанит ажил, намуудын санхүүжилтийн бүх хэлбэрийг хамарсан өргөн хүрээний онол бөгөөд төрийн санхүүжилт, иргэн болон хуулийн этгээдийн хандив, гишүүдийн татвар, намын хөрөнгө түүнээс олсон орлого зэрэг багтана.

Онолын хувьд “Улс төрийн санхүүжилт (Political Finance)”, “Төрийн санхүүжилт (Public Funding of political parties)”³, “Улс төрийн намын санхүүжилт (Political party funding)” гэх гурван өөр нэр томъёо, ойлголт байна. Эдгээрээс “Улс төрийн санхүүжилт гэх ойлголтод багтах “public funding of political parties - улс төрийн намын төрийн санхүүжилт” хэмээх нэр томъёог хэрэглэж Монгол Улсын хувьд улс төрийн намуудад төрийн санхүүжилт өгөх боломж хуулийн хүрээнд бүрдсэн. Тиймээс судалгааны онолын хэсэгт 1) Улс төрийн

¹ 1995 оны 5-р сарын 10-ны өдөр батлагдсан “Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль”-д 1991 оны 1-р сарын 26, 1996 оны 4-р сарын 26, 2003 оны 5-р сарын 23-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

² Улс төрийн намын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/508>, [Сүүлд үзсэн: 2023/05/10]

³ “Төрийн санхүүжилт” гэх Монгол орчуулгын тухайд IDEA (International Institute for Democracy and Electoral Assistance) олон улсын судалгааны байгууллагаас эрхлэн гаргасан “Funding of Political Parties and Election Campaign” Handbook on Political Finance бүтээлийн Монгол хэлнээ орчуулан гаргасан хувилбарт болох “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлага”-т “Political Finance-Улс төрийн санхүүжилт”, “Public Funding-Төрийн санхүүжилт” гэж хэрэглэсэн байх тул энэ өгүүлэлд мөн адил орчуулгаар хэрэглэв.

санхүүжилт, 2) Төрийн санхүүжилт, 3) Улс төрийн намын санхүүжилт гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг харьцуулан тайлбарлаад үндсэн хэсэгт “Төрийн санхүүжилтийн” хэлбэр, төрөл, зарчим, төлөөлөгчид болон олон улсын судалгаанд үндэслэн зарим улсын жишээг танилцуулъя.

Хүснэгт 3: Улс төрийн санхүүжилт, Төрийн санхүүжилт, Улс төрийн намын санхүүжилтийн тодорхойлолтын харьцуулалт

Political finance [Улс төрийн санхүүжилт]	Public funding of Political Parties [Төрийн санхүүжилт]	Political party funding [Улс төрийн намын санхүүжилт]
Улс төрийн санхүүжилт гэдэг нь улс төрийн зорилгоор цуглуулж буй бүх мөнгийг хамруулан ойлгоно. Үүнд, намын үйл ажиллагаа, тэр дундаа сонгуулийг дэмжих зорилгоор улс төрийн намууд, нэр дэвшигчид, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн эх үүсвэр босгох зорилгоор хөрөнгө босгоход зарцуулж буй арга хэлбэрийг ойлгоно. ⁴ Үүнд хувь хүмүүс, корпорацууд, хуулийн этгээдийн хандив, улс төрийн нам, кампанит ажлыг дэмжих зорилгоор төрөөс олгодог олон нийтийн санхүүжилт, намын хөрөнгийн орлого зэрэг багтаж болно. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг хамтад нь улс төрийн санхүүжилт гэж олон улсад нэрлэдэг. ⁵	Төрийн санхүүжилт гэдэг нь татварын орлого буюу улсын нөөцийг улс төрийн кампанит ажил, улс төрийн намуудыг дэмжихэд ашиглахыг өөрөөр улс төрийн нам болон/эсвэл нэр дэвшигчдэд төр/Засгийн газраас олгож буй хөрөнгө, эх үүсвэрийг хэлнэ. ⁶ АСДҮОУХ ⁷ -с “сонгуулийн сурталчилгаа эсвэл намын ердийн үйл ажиллагаа явуулахад эрх бүхий улс төрийн нам, нэр дэвшигчдэд засгийн газраас олгодог тусламж” гэж тодорхойлсон. Улс төрийн сонгуулийн кампанит ажил, намуудыг төсвөөс санхүүжүүлэх нь улс төрийн үйл явц дахь шударга ёс, тэгш байдлыг дэмжих, улс төр дэх хувийн мөнгөний нөлөөллийг бууруулах арга зам гэж энэ онолын хандлага үздэг.	Улс төрийн намууд үйл ажиллагаагаа явуулах, зорилгодоо хүрэхийн тулд янз бүрийн эх үүсвэрээс авдаг санхүүгийн дэмжлэгийг улс төрийн намын санхүүжилт гэнэ. ⁸ Санхүүжилтийг хувь хүмүүс, корпорацууд, сонирхлын бүлгүүд болон бусад байгууллага зэрэг янз бүрийн эх үүсвэрээс гаргаж болно. Улс төрийн намууд авсан хөрөнгөөрөө сонгуулийн сурталчилгаа, судалгаа шинжилгээ, удирдлага, намын төв байрны засвар үйлчилгээ зэрэг төрөл бүрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

Төрийн санхүүжилт [Public Funding of Political Parties]:

Өмнөх харьцуулалтад дурдсанчлан төрийн санхүүжилт гэдэг нь татварын орлого гэх мэт улсын нөөцийг улс төрийн сонгуулийн кампанит ажил, улс төрийн намуудыг дэмжихэд ашиглахыг буюу улс төрийн нам болон/эсвэл нэр дэвшигчдэд төр/Засгийн газраас олгож буй хөрөнгө, эх үүсвэрийг ойлгоно.⁹ Төрийн санхүүжилтийн зорилго нь улс төрийн үйл

⁴ Jonathan Mendilow and Eric Phélippeau, “Handbook of Political Party Funding”, 2018

⁵ Шилэн нам: Авлигын эсрэг түншлэл, “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээ” судалгааны тайлан, 2018 он, 11 дэх тал

⁶ The Electoral Knowledge Network “Parties and Candidates” article, 2012

⁷ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн - International Institute for Democracy and Electoral Assistance

⁸ Jonathan Mendilow and Eric Phélippeau, “Handbook of Political Party Funding”, 2018

⁹ The Electoral Knowledge Network “Parties and Candidates” article, 2012

явцын шударга, ил тод байдлыг дэмжих, намуудын хэмжээ, нөөц бололцооноос үл хамааран тэгш өрсөлдөөнийг бий болгоход оршино. Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (АСДҮОУХ)-ээс эрхлэн гаргасан “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлага орчуулгын бүтээлд “Төрийн санхүүжилтийн зорилго нь сонгогчдод хүрч ажиллах нөөц бололцоог улс төрийн хүчнүүдэд бий болгож өгснөөрөө олон ургалч үзлийг хөхүүлэн дэмжиж, улмаар улс төрчид бодлогын өргөн сонголтыг сонгогчдод олгоход чиглэдэг. Өөр нэг зорилго нь сонгуульд өрсөлдөгч бүх талд кампанит ажил явуулах санхүүжилт олгосноор эдийн засгийн хувьд давамгайл өрсөлдөгчийн давуу талыг хязгаарлах явдал юм”¹⁰ хэмээн талуудын өрсөлдөөний шударга, ил тод, тэгш байдлыг дэмжих зорилгыг тодорхойлжээ.

Төрийн санхүүжилтийн тухай үзэл санааны хөгжлийг дараах цаг үеүдэд хамруулан үзэх боломжтой. Үүнд:

1. **Хөгжлийн эхний үе буюу XIX зуун:** Улс төрийн кампанит ажилд санхүүжилт олгох нь XIX зуунаас эхлэлтэй бөгөөд 1880-аад онд Германы улс төрийн намуудад төрөөс дэмжлэг үзүүлэх тогтолцоо нэвтэрч дараа нь 1894 онд Францад улс төрийн намуудын санхүүжилтийг тусгасан сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлснээр хөгжил нь эхэлжээ.
2. **XX зууны дунд үе:** Төрийн санхүүжилтийн орчин үеийн онол нь XX зууны дунд үед улс төр дэх мөнгөний үүрэг нэмэгдэж, аливаа зүй бус нөлөөллийн талаар тайлбарлан гарч ирсэн. 1971 онд АНУ-д Холбооны сонгуулийн кампанит ажлын тухай хуулиар¹¹ Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажилд зориулж төрийн санхүүжилтийн тогтолцоог бий болгосон ба төрөөс бага хэмжээний санхүүжилтийг олгож, нэр дэвшигчийн авч болох хувийн хандивын хэмжээг хязгаарласан байдаг. Мөн энэ үеэс улс орнууд улс төрийн хандив, татварын хөнгөлөлт, сонгуулийн үр дүнгээс хамаарч төрийн санхүүжилтийг олгох шинэ арга хэлбэрийг туршиж эхэлсэн.
3. **Орчин үеийн хөгжил:** Сүүлийн жилүүдэд улс орнууд улс төр дэх мөнгөний нөлөөг арилгах, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжихийг эрмэлзэж улс төрийн кампанит ажилд төсвөөс санхүүжилт олгох хандлага нэмэгдэж байна.

Ийнхүү төрийн санхүүжилт нь XIX зуунаас эхлэн хөгжсөн ба орчин үеийн онолыг улс төр судлаач Герберт Александрттай¹² холбон тайлбарладаг. Герберт Александр бол сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, улс төр дэх мөнгөний үүргийн талаар өргөн хүрээнд судалгааны ажил бичсэн Америкийн эрдэмтэн ба сонгуулийн нөхцөлийг тэгшитгэх, чинээлэг хандивлагчид болон ашиг сонирхлын бүлгүүдийн нөлөөллийг бууруулах арга зам болох төрийн санхүүжилтийг ихээхэн дэмжигч байсан бөгөөд 1960-аад онд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Мөн доорх эрдэмтэд төрийн санхүүжилтийн онол, хандлага хөгжихөд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Үүнд:

- **Хууль болон эдийн засгийн салбарын эрдэмтэн Сюзан Роуз-Акерман:**¹³ Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт ба авлига хоёрын хоорондын хамаарлын талаар өргөн хүрээнд судалсан.

¹⁰ Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлага, “Төрийн санхүүжилт” хэсэг, 29-30 дахь тал

¹¹ Britannica. (n.d.). Federal Election Campaign Act, written by Clifford A. Jones, Encyclopedia Britannica. <https://www.britannica.com/topic/Federal-Election-Campaign-Act>
[Сүүлд үзсэн: 2022/09/20]

¹² Герберт Э.Александр (1927-2020) нь Америкийн улс төр судлаач, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мэргэжилтэн. Тэрээр Өмнөд Калифорнийн Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны профессор "Улс төрийг санхүүжүүлэх: мөнгө, сонгууль, улс төрийн шинэчлэл" (1984), "АНУ дахь мөнгө ба улс төр" (1991), "Кампанит ажлын тухай домог" зэрэг хэд хэдэн нөлөө бүхий ном, нийтлэлийн зохиогч юм.

¹³ Jana Kunicova and Susan Rose-Ackerman, "Electoral Rules and Constitutional Structures as Constraints on Corruption," Political Science Quarterly vol. 123, no. 3 (September 2020): 456-472.

- **Улс төр судлаач Томас Гайс:**¹⁴ Улс төрийн өрсөлдөөн, цөөнхийн эрх ашгийг төлөөлөхөд төрийн санхүүжилт хэрхэн нөлөөлж байгааг судалсан.
- **Улс төр судлаач Питер Майр, Ричард Катц:**¹⁵ Улс төрийн намуудын уналт, ардчилсан төлөөллийн үр дагаврын талаар судалж төрийн санхүүжилт ба улс төрийн намын картель хэлбэрийн хамаарлыг тогтоосон.
- **Үндсэн хуулийн эрх зүйч, эрдэмтэн Моника Пинто:** Сонгуулийн үйл явц дахь хариуцлага, ил тод байдлыг дэмжихэд төрийн санхүүжилтийн үүргийг судалсан.

Эдгээр судлаачид нь төрийн санхүүжилт, түүний улс төрийн тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаанд ихээхэн хувь нэмрээ оруулсан байдаг.

Ангиллын хувьд төрийн санхүүжилтийн хэд хэдэн хэлбэрүүд байдагт буцалтгүй тусламж, татаас¹⁶ гэх мэт шууд санхүүгийн дэмжлэг, улс төрийн намуудад татварын хөнгөлөлт үзүүлэх, шуудангийн тарифыг (улсын шууданг үнэгүй ашиглах боломж олгох) бууруулах зэрэг шууд бус дэмжлэг мөн байна. Иймд, төрийн санхүүжилтийг төрийн эх үүсвэрийг ашиглах хэлбэрээс хамааран *төрийн шууд санхүүжилт*, *төрийн шууд бус санхүүжилт* гэж хуваадаг.¹⁷ Төрийн санхүүжилтийн хэлбэрээс үл хамааран 1) хэн санхүүжилт авах эрхтэй бэ? 2) санхүүжилтийг эрх бүхий этгээдэд хэрхэн хуваарилах бэ?¹⁸ гэсэн асуудалд зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Иймд, төрийн шууд болон шууд бус санхүүжилтийг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад хэрхэн хуульчилсныг дараах хэсэгт танилцуулах болно.

1. Төрийн шууд санхүүжилтийг улс төрийн намуудад мөнгөн хэлбэрээр буюу ихэвчлэн банкны шилжүүлэг хэлбэрээр олгодог. Монгол Улсын хувьд 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар бүлэг 27 дугаар зүйлээр “Төрийн санхүүжилт”-ийг тодорхойлоод “27.1.Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид “нийт сонгогч” гэх/-ийн тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилах замаар төрийн санхүүжилт олгоно” хэмээсэн. Цаашлаад хуулийн 27.5, 27.7, 27.11, 27.13 дугаар заалтын хүрээнд Сонгуулийн төв байгууллага санхүүжилтийг олгох, тооцоолох, хуваарилах, зогсоох эрхтэй байх зохицуулалтыг хийсэн байна.
2. Төрийн шууд бус санхүүжилт гэдэг нь улс төрийн намуудад төрөөс олгодог мөнгөн дүнтэй эх үүсвэрийг хэлнэ.¹⁹ Үүнд, татварын хөнгөлөлт, шуудангийн хөнгөлөлт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дэмжих боломж, хэвлэлийн хөнгөлөлт гэх мэт олон төрөл байна. Шинэчилсэн найруулгын 5 дугаар бүлгийн 30-р зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг”-ийг “Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан нам нь сонгуулийн бус жилд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг дараах хэлбэрээр авах эрхтэй” хэмээгээд дараах хоёр төрөлд шууд бус дэмжлэгийг хуульчилсан²⁰ байна. Үүнд:
30.1.1. Намын удирдах байгууллагыг хуралдуулах, гишүүд дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хурлын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах;

¹⁴ Thomas L. Gais and Michael J. Malbin, "Campaign Finance Reform," Society 34, no. 4 (May 1997): 56-61.

¹⁵ Katz.R. S, Mair.P, "Party Politics" Vol.1, No.1, 1995

¹⁶ Татаас гэдэг нь ямар нэгэн аж ахуй нэгжид төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийг ойлгоно. Орос хэлний Дотаций буюу Тэтгэлэг гэх үгийг Монголчилж “татаас” гэж хэрэглэх болсон.

¹⁷ The Electoral Knowledge Network "Parties and Candidates" article, 2012

¹⁸ Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлага, “Төрийн санхүүжилт” хэсэг, 31 дэх тал

¹⁹ "Electoral Systems and Democracy," ACE Encyclopaedia, [2023.10.11] https://aceproject.org/ace-en/topics/pc/pca/pca02/pca02a/pca02a5/mobile_browsing/onePag. [Сүүлд үзсэн:2022/10/01]

²⁰ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2023 он

30.1.2. Намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг олон нийтийн радио, телевизээс гарсан хуваарийн дагуу 30 минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх;

Төрийн санхүүжилтийн зарчмууд:

Улс төрийн санхүүжилтийн нэгэн адил төрийн санхүүжилтэд дараах нийтлэг зарчмууд байна. Үүнд:

- **Шударга байдал, тэгш байдал:** Төрийн санхүүжилт нь улс төрийн намуудын өрсөлдөөний талбарыг тэгшитгэх зорилготой бөгөөд жижиг эсвэл бага санхүүжилттэй намууд илүү том, илүү санхүүждэг намуудтай ижил нөхцөлөөр өрсөлдөх боломжийг олгохыг зорьдог. Үүнд гол анхаарах асуудал нь тодорхой тооны дэмжлэг хүлээсэн нь нотлогдсон намуудад зөвхөн дэмжлэг үзүүлнэ.
- **Ил тод байдал ба хариуцлага:** Төсвийн санхүүжилтэд ихэвчлэн ил тод байх хатуу шаардлага тавигддаг бөгөөд талууд хүлээн авсан мөнгөө хэрхэн ашигласан тухайгаа тайлагнаж байх ёстой. Энэ нь улс төрийн үйл явц дахь ил тод, хариуцлагатай байдлыг дэмжихэд тусалдаг. Тайлан гаргах талуудад “Улс төрийн нам”, “Нэр дэвшигч”, “Туравдагч этгээд”²¹ хамаарах ба санхүүжилтийг тайлагнах нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн ил тод байдлыг хангахад чухал үүрэгтэй.
- **Цөөнхийн ашиг сонирхлыг төлөөлөх:** Олон төрлийн улс төрийн намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлснээр төрийн санхүүжилт нь цөөнхийн ашиг сонирхлыг улс төрийн үйл явцад төлөөлөхөд тусалдаг.
- **Улс төрийн өөр үзэл бодлыг дэмжих:** Төрийн санхүүжилт нь улс төрийн ландшафт дахь олон талт байдлыг дэмжих, шинэ болон өөр улс төрийн хэтийн төлөвийг хөгжүүлэхэд тус дөхөм болно. Тухайлбал, олон талт, олон ургалч улс төрийн дүр төрхийг гаргаж ирэх, тэгш өрсөлдөх боломж олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт.
- **Улс төр дэх мөнгөний нөлөөг бууруулах:** Улс төрийн намуудын хувийн хандиваас хараат байдлыг бууруулснаар төрийн санхүүжилт нь улс төрийн үйл явцад мөнгөний нөлөөллийг багасгахад тусална.

Төрийн санхүүжилтийг хэрхэн хийх вэ?

Улс төрийн намуудад төрийн санхүүжилт олгох үйл явц нь улс орон бүрт харилцан адилгүй бөгөөд улс төр, хууль эрх зүйн нөхцөл байдал, намуудын хэмжээ, олгож буй санхүүжилтийн төрөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Гэсэн хэдий ч төрийн санхүүжилтийг хийхэд хэдэн нийтлэг алхам байна. Үүнд:

- **Сонгох шалгуур:** Улс төрийн нам төрийн санхүүжилт авахын тулд зохих байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн байх, тогтоосон квотод хүрэхүйц гишүүнтэй байх, сонгуульд оролцох зэрэг шалгуурыг хангасан байх ёстой. Мөн “Улс төрийн нам болон сонгуулийн санхүүжилт” судалгаанд төрийн санхүүжилтийг олгох шалгуур буюу төрөөс хэнд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх бэ? гэх асуудалд “босго байхгүй байх; авсан саналын хувь хэмжээ; парламент дахь суудлын тоо; нэр дэвшигчийн тоо”-г хамруулан анхаарах шаардлагатай гэжээ. Манай улсын хувьд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 27.3-т “Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно” гэж заасан нь идэвхтэй үйл ажиллагаатай намуудыг тэгш дэмжих агуулга бүхий байна.
- **Өргөдөл гаргах үйл явц:** Төрийн санхүүжилт авахыг хүссэн улс төрийн намууд хэмжээ, үйл ажиллагаа, санхүүгийн байдлынхаа талаар мэдээлэл өгөхдөө холбогдох байгууллагад хүсэлт гаргах шаардлагатай. Тухайлбал, Улс төрийн намыг Улсын дээд шүүхэд бүртгэхтэй ижил төрлийн өргөдөл хүлээн авах байгууллага байх шаардлагатай гэж олон улсад үздэг. Манай улсын хувьд Улс төрийн намын тухай хуулийн

²¹ Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлага, “Төрийн санхүүжилт” хэсэг, 34-39 дэх тал

шинэчилсэн найруулгын 28 дугаар зүйлээр “Төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах” томъёоллоор санхүүжилт авах хүсэлтийг тухайн жилийн өмнөх жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Сонгуулийн төв байгууллагад гаргахаар²² зохицуулсан.

- **Хяналт, шийдвэр гаргалт:** Төсвийн санхүүжилтийг хариуцах эрх бүхий байгууллагууд өргөдлийг хянаж үзээд аль нам санхүүжилт авах, хэдий хэмжээний санхүүжилт авах талаар шийдвэр гаргана. Манай улсад санхүүжилтийг олгох, хэмжээг тогтоох, хуваарилалт хийх, нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хариуцах байгууллагыг Сонгуулийн төв байгууллага²³ байхаар зохицуулсан.
- **Санхүүгийн зарцуулалт:** Хэрэв улс төрийн намын үйл ажиллагаа төрийн санхүүжилтээр батлагдсан бол уг санхүүжилтийг ихэвчлэн урьдчилан тохиролцсон хуваарийн дагуу эсвэл сонгуулийн сурталчилгаа хийх, намын бусад үйл ажиллагаа явуулах зэрэг тодорхой зорилгоор зарцуулдаг байх ёстой. Тухайлбал, сонгуульд ашиглах уу, эсвэл сонгуулийн бус үед зарцуулах уу? цаашлаад боловсролыг дэмжих зориулалт бүхий байж болно. Шинэчилсэн найруулгын 31 дүгээр зүйлд “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт” хэмээн улс төрийн намаас тайланг хүлээн авах, нэгтгэн тайлагнах үүргийг Сонгуулийн төв байгууллагад хамааруулан зохицуулсан.
- **Тайлан ба хариуцлага:** Төрийн санхүүжилт авч байгаа улс төрийн намууд санхүүжилтээ хэрхэн зарцуулсан тухайгаа тогтмол тайлан гаргаж байх шаардлагатай бөгөөд аудит болон бусад хэлбэрээр хариуцлага тооцдог байх онолын ойлголт байна. Тухайлбал, “АСДҮОУХ-ын “Улс төрийн нам болон сонгуулийн санхүүжилт” бүтээлд тайлангийн давтамжийн хувьд “тогтмол тайлагнах болон сонгуулийн тайлан”, тайлан гаргах талуудын хувьд “улс төрийн нам, нэр дэвшигч, гуравдагч этгээд”, юуг тайлагнах тухайд “орлого, зарцуулалт, өмч хөрөнгө ба өр төлбөр”, ямар мэдээллийг олон нийтэд ил тод болгох тухайд “хүлээн авсан бүх мэдээлэл, тойм мэдээлэл, олон нийтэд мэдээлэхгүй”²⁴ гэх төрөл зохицуулалтыг” онолын хувьд санал болгосон байна. Энэ агуулгын хүрээнд төрийн аудитын байгууллагын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийтэд мэдээлэх, хариуцлага тооцох эрхтэй байх зохицуулалт улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад хийгдсэн²⁵ байна.

Эдгээр нь төрийн санхүүжилтийн үйл явцад хамаарах ерөнхий алхмууд бөгөөд тухайн улс орны онцлог шинж, хууль тогтоомжоос хамаарч өөр өөр байж болно. Хамгийн гол нь төрийн санхүүжилтийн үйл явц ил тод, шударга, хариуцлагатай байх, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах явдал юм. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 27.5 болон 27.6 дахь хэсгүүдэд улс төрийн намд санхүүжилтийг олгох нөхцөл, томъёоллыг тусгасан байна. Тухайлбал, хуулийн 27.5-д заасан томъёоллын дагуу доорх харгалзах утгаар санхүүжилтийг Сонгуулийн төв байгууллага олгохоор байна.

Томъёо нь:

²² “Улс төрийн намын тухай хууль” шинэчилсэн найруулга, 28.1. “Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд төрийн санхүүжилт авах зорилгоор уг санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, санхүүжилт авах тухай хүсэлтээ нам тухайн жилийн өмнөх жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн төв байгууллагад гаргана. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хугацаанд хүсэлт гаргаагүй бол сонгуулийн төв байгууллага энэ тухай сануулж, долоо хоногийн дотор хүсэлт гаргах боломж олгоно.”

²³ Мөн хуулийн 29.1-д “Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн санхүүжилтийн хэмжээг энэ хуульд заасны дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ.”

²⁴ Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлага, “Төрийн санхүүжилт” хэсэг, 39-40 дэх тал

²⁵ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 31.4 дэх заалт

$$H = /C1 \times T1/ + /C2 \times T2/$$

Харгалзах утга нь:

- “Н” – гэж нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;
- “С1” – гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;
- “С2” – гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;
- “Т1” – гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;
- “Т2” – гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг; тус тус ойлгоно хэмээн хуульчлагдсан байна. ²⁶

Төрийн санхүүжилтийн үүрэг:

- Төрийн санхүүжилтийн үүрэг нь улс төрийн нам, нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгаа хийх, судалгаа хийх, арга хэмжээ зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд оршино.
- Төрийн санхүүжилтийн зохицуулалт хийсэн ихэнх улс оронд авлига, чинээлэг хүмүүс, байгууллагын хууль бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн санхүүжилтийг төрөөс зохицуулдаг байна. Тухайлбал, улс төрийн кампанит ажилд хувь хүн, байгууллагын хандивлах мөнгөний хэмжээ хязгаарлагдмал, эсвэл тодорхой улс төрийн кампанит ажлыг хэн санхүүжүүлж байгааг олон нийтэд мэдээлэхийн тулд ил тод болгох шаардлага тавьдаг нь санхүүжилт хязгаарлагдах нөхцөлийг бий болгодог. Харин төрийн санхүүжилтийг идэвхтэй үйл ажиллагааг нь харгалзан намуудад тэгш олгох нь гарааны тэгш боломжоор хангаж буй эхлэл юм.
- Төрийн санхүүжилт нь улс төрийн өрсөлдөөнийг шударга, ардчилсан байлгахад тусалдаг учраас чухал ач холбогдолтой. Төрийн санхүүжилт нь улс төрийн нам, нэр дэвшигчдийг санхүүгийн эх үүсвэрээр хангаснаар сонгогчдоо үр дүнтэй төлөөлөх, сонгуульд өрсөлдөх боломжийг олгодог. Гэвч төрийн санхүүжилт нь зөв зохицуулалтгүй бол авлига, чинээлэг хүмүүс, байгууллагуудын зүй бус нөлөөлд хүргэж, улмаар ардчиллын үйл явцыг алдагдуулж болзошгүй сөрөг талтай.

Иймд, төрийн санхүүжилт нь улс төрийн өрсөлдөөнийг шударга, ардчилсан байлгахад тусалдаг ба улс төрийн намд олгох шалгуур, зарцуулалтын хяналт, тайлан, хариуцлагын асуудлыг улс орнууд хууль тогтоомжоороо сайтар зохицуулж эрх зүйн орчныг бий болгох нь нэн чухал.

АСДҮОУХ-ийн “Улс төрийн санхүүжилтийн мэдээллийн сан” судалгаанд²⁷ бүс нутгийн хувьд улс төрийн санхүүжилтийн зохицуулалтын түвшин дараах байдалтай байна.

Хүснэгт 4: Бүс нутгийн хэмжээнд дэх нэг улсад оногдох улс төрийн санхүүжилтийн зохицуулалтын түвшин²⁸

Зохицуулалтын түвшин	Африк	Америк	Ази	Зүүн Европ ба Төв Ази	Баруун Европ	Англи хэлтэй орнуудад	Дэлхийн түвшинд
Доогуур	22%	11%	55%	0%	38%	17%	22%
Дундаж	53%	28%	5%	28%	33%	33%	38%
Өндөр	24%	61%	40%	72%	29%	50%	40%

Олон улсын зохицуулалт:

²⁶ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 27.5 болон 27.6 дахь заалт

²⁷ Political Finance Database by International Institute for Democracy and Electoral Assistance (International IDEA), [Database result \(question only\) | International IDEA](#) [Сүүлд үзсэн: 2022/09/20]

²⁸ Ibid

Олон улсын хэмжээнд хийгдсэн улс төрийн санхүүжилтийн судалгаанаас үзэхэд дэлхийн 180 орноос улс төрийн намуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлсэн 64 орон (37%), тогтмол ба сонгуулийн үр дүнг хослуулан дэмжлэг олгодог 40 орон (23,1%), зөвхөн сонгуулийн үр дүнгээр санхүүжилт олгодог 14 орон (8,1%)²⁹ байгаа бөгөөд жил ирэх тусам санхүүжилтийг төрөөс ямар аргаар олгож буйг үл хамааран өсөх хандлагатай байна.

Улс төрийн санхүүжилтийг хийхдээ ямар хууль тогтоомжоор зохицуулснаас шалтгаалан улс орнуудыг дараах ангилалд хувааж болно. Үүнд:

1. Сонгуулийн тухай хуулиар төрийн санхүүжилтийг зохицуулсан улс орнууд;
2. Намын тухай хуулиар төрийн санхүүжилтийг зохицуулсан улс орнууд;
3. Улс төрийн санхүүжилтийн тухай анхдагч, бие даасан хуулиар зохицуулсан улс орнууд хэмээн ангилан үзэх боломжтой байна. Хүснэгт 2-т улс орнуудыг хуулийн зохицуулалтаар ангиллаа.

Хүснэгт 5: Улс төрийн санхүүжилтийг зохицуулсан хууль тогтоомжийн ангилал

Сонгуулийн тухай хуулиар төрийн санхүүжилтийг зохицуулсан улс орнууд: ³⁰	Намын тухай хуулиар төрийн санхүүжилтийг зохицуулсан улс орнууд:	Бие даасан хуультай улс орнууд:
Америкийн Нэгдсэн Улс Энэтхэг Улс Канад Улс Их Британи Улс Франц Улс Герман Улс Итали Улс Испани Улс Япон Улс Австрали Улс Бразил Улс Монгол Улс	Финлянд ³¹ Улс Исланд Улс Ирланд Улс Шинэ Зеланд Улс Австрали Улс Өмнөд Солонгос Улс Япон Улс Тайвань Улс Индонез Улс Монгол Улс	Швед Улс Франц Улс Израил Улс Өмнөд Солонгос Улс ³² Япон Улс ³³ Их Британи Улс ³⁴

“АСДҮОУХ-ын “Улс төрийн нам болон сонгуулийн санхүүжилт” улс төрийн санхүүжилтийн гарын авлагын судалгаанд хамрагдсан дэлхийн 180 орноос дээрх улс төрийн санхүүжилтийг зохицуулсан хууль тогтоомжийн ангилалд хамаарсан улс орнуудын хуулийг харахад улс төрийн нам, сонгуулийн кампанит ажлыг төрөөс санхүүжүүлэх асуудлыг сонгуулийн тухай хуулиар зохицуулсан улс орнууд хуульдаа санхүүжилтийн эх үүсвэр, хуваарилалт, ашиглах нөхцөл, хяналт зэргийг тусгасан байна. Эдгээр улс орнууд төрийн санхүүжилтийг хуулиар зохицуулснаа улс төрийн бүх нам, нэр дэвшигч нарт ижил тэгш, нөхцөлийг өгөх, чинээлэг хандивлагчдын улс төрийн явцад үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой хэмээн тайлбарласан. Харин бие даасан төрийн санхүүжилтийн тухай хуультай улс орнуудыг судлахад нам болон нэр дэвшигчийг хэрхэн, хэр хэмжээгээр,

²⁹ Political Finance Database: Are there Provisions for direct public funding to Political Parties? [Are there provisions for direct public funding to political parties? | International IDEA](#), [Сүүлд үзсэн:2022/09/20]

³⁰ Ingrid van Biezen, “Financing political parties and election campaigns – guidelines” by the Venice Commission.

³¹ Act on Political Parties - Финляндын улс төрийн намын тухай хуулийн 8.2, 9.1, 9.3-р зүйл, [Act on Political Parties](#), [Сүүлд үзсэн:2022/08/25]

³² Political Fund Act,- Төрийн санхүүжилтийн хууль: Солонгос [political funds act](#) [Сүүлд үзсэн:2022/08/20]

³³ Political Funds Control Act (1948, last amended in 2014) [Japan:Political Funds Control Act \(1948\)](#) — [Сүүлд үзсэн:2022/08/20]

³⁴ The Political Parties, Elections and Referendums Act 2000 (PPERA), [Political Parties, Elections and Referendums Act 2000](#), [Сүүлд үзсэн:2022/08/20]

ямар хяналт дор санхүүжүүлэх боломжтойг өөрийн улсын нөхцөлд тохируулан өөр өөр зохицуулалт хийсэн байна.

Мөн зарим тохиолдолд Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль болон бие даасан хуулиар хамтад нь зохицуулалт хийсэн улс (Япон) байгааг харж болно.

Мөн Үндсэн хуулиараа төрийн санхүүжилтийн талаар тусгайлан зохицуулсан “Мексик, Бразил, Өмнөд Африк, Энэтхэг, Непал Улс” зэрэг улс орнууд байгаагаас Мексикийн Үндсэн хуулийн³⁵ 41 дүгээр зүйлд Үндэсний сонгуулийн институтыг байгуулж, улс төрийн намууд болон сонгуулийн кампанит ажлыг төрөөс санхүүжүүлэх зарчим, дүрмийг тогтоосон бол Бразил Улсын Үндсэн хуулийн³⁶ 17 дугаар зүйлд намыг бүртгэх шалгуурыг тогтоож, улс төрийн нам, сонгуулийн кампанит ажлыг төрөөс санхүүжүүлэх зохицуулалтыг тусгасан байдаг. Мөн Өмнөд Африкийн Үндсэн хуулийн³⁷ 236-р зүйлд Сонгуулийн хороог байгуулж, үндэсний парламентаас баталсан хуулийн дагуу улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлэхээр тусгасан нь манай улсын одоогийн зохицуулалттай ижил байна.

Дүгнэлт

Улс төр ба мөнгө хэмээх хоёр зүйл нягт холбоотой ба улс төрийн нам, нэр дэвшигчид хэрхэн, яаж, хаанаас санхүүжилтээ бүрдүүлж буй нь ардчилсан улсын сонгууль, түүний үр дүн, улс төрийн тогтолцоонд чухал нөлөөтэй. Улс төрийн тогтолцоонд мөнгийг хэрхэн ашиглахаас хамаарч нэг талаар зөв зохицуулалт бүхий улс төрийн орчин, нөгөө талаар авлига, хээл хахууль эсвэл бизнест баригдсан клиентелист тогтолцоо ч хөгжих боломжтой. Улс төр ба мөнгөний харилцааг зохист түвшинд тодорхойлж улс төрийн тогтолцоонд бодлого боловсруулан гаргаж хэрэгжүүлсэн олон жишиг байдгийн нэг нь “Төрийн санхүүжилт”-д хамаарах ойлголт юм. Төрийн санхүүжилт нь улс төрийн намуудын хэмжээг үл харгалзан идэвхтэй үйл ажиллагаа, сонгогчдын хүсэл эрмэлзэлд үндэслэн гарааны тэгш боломжийг олгож шударга өрсөлдөөнийг бий болгох зориулалттай.

Манай улсын хувьд Сонгуулийн тухай хууль болон Улс төрийн намын тухай хуулиар нам, нэр дэвшигчдэд хамаатай улс төрийн санхүүжилтийн тодорхой зохицуулалтыг хуульчилж (тухайлбал, санхүүжилтийн эх үүсвэр, зардлын хязгаарлалт, дээд хэмжээ, аудит, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага гэх мэт) ирсэн боловч эрх зүйн орчин нь намын санхүүжилттэй холбоотой олон улсын сайн туршлага, удирдамж, зөвлөмжөөс зөрүүтэй, улс төрийн намын санхүүжилтийг хянаж, ил тод байдлыг хангаж буй байдал нь олон улсын стандартаас хоцрогдолтой явж ирсэн. Тиймдээ ч улс төрийн санхүүжилтийг зохицуулж буй өнөөгийн эрх зүйн зохицуулалт ойлгомжгүй, хийдэл ихтэй, үйлчлэлийн механизмууд нь хоёрдмол утгыг агуулсан, тодорхойгүй, тайлбарлагдаагүй байсан зэрэг нь намын төлөвшил, ардчилсан сонгуульд бэрхшээл учруулж буйг судлаачид төдийгүй иргэд сонгогчид ч шүүмжлэх болсон. Иймд төрийн санхүүжилтийг Үндсэн хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлага байсныг баталж Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд “Улс төрийн намын тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар “Улс төрийн намын санхүүжилт”-ийн зохицуулалтыг шинэ бүлгээр хуульчилсан нь сайшаалтай байна. Харин цаашдаа манай улсын хувьд төрийн санхүүжилтийн талаарх хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах, практикт гарах асуудлуудыг хэрхэн зохицуулж өөрийн улс орны улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн нөхцөл байдалд тохирсон загварыг хадгалж төлөвшүүлэх цаашлаад дагнасан судалгааг хөгжүүлэх нь ихээхэн чухал байна.

³⁵ Mexico's Constitution of 1917, [Mexico's Constitution of 1917 with Amendments through 2015](#), [Сүүлд үзсэн: 2022/08/20]

³⁶ Constitution of the Federative republic of Brazil 3rd edition, [CONSTITUTION OF THE FEDERATIVE REPUBLIC OF BRAZIL 3rd Edition](#), [Сүүлд үзсэн: 2022/08/20]

³⁷ The Constitution of the Republic of South Africa, <https://rb.gy/p5qhpa>, [Сүүлд үзсэн: 2022/08/20]

Abstract:

Amendments to the Constitution of Mongolia were approved by the Great Khural of Mongolia on November 14, 2019, and ratified by the President of Mongolia on November 26, 2019. The amendment added the Nineteenth Article 1 to the Constitution.

It includes:

1. The Party shall be established as set out in the paragraph 10 of the Article Sixteen of the Constitution, and shall formulate and conduct nation-wide policy.
2. The Party shall be formed by associating uniting at least one percent of Mongolian citizens, eligible to vote in the election.
3. Internal organization of the party shall be in compliance with the democratic principles, and its capital and revenue sources and spending shall be transparent to public. The Party's organization, operational procedure, funding, and the terms of state funding support shall be determined by law.

In the third part of the provisions of this amendment ***“Internal organization of the party shall be in compliance with the democratic principles, and its capital and revenue sources and spending shall be transparent to public. The Party's organization, operational procedure, funding, and the terms of state funding support shall be determined by law”*** the lawmaker explains that the provision was approved to make the financing transparent, improve the party's internal democracy, propose policies at the national level, shape the parties, and improve accountability. While the provision was divided into two parts, with some parts supported and others not supported by political parties, politicians, academics, and public opinion, the regulations related to financial support from the state to political parties are governed in the fifth chapter of the revised Political Parties Act.

This article will explain the theoretical foundations of state funding as approved in the revised Political Parties Act within the context of Clause 3 of Article Nineteen 1 of the 2019 Constitutional Amendment, examining the regulation of state-provided financial support, the required legal framework, and its significance in comparison to the existing system.

Key words: Political parties, political finance regulations, transparency, control, financing reports

Ашигласан ном, материал

Гадаад эх сурвалжууд:

- Jonathan Mendilow and Eric Phélippeau, “Handbook of Political Party Funding”, 2018
- “Funding of Political Parties and Election Campaigns” A Handbook on Political Finance by IDEA
- The Electoral Knowledge Network “Parties and Candidates” article, 2012
- "Funding of Political Parties and Election Campaigns" by the Venice Commission
- "Money in Politics: A Study of Party Financing Practices in 22 Countries" by Kenneth Janda
- "Political finance and the cartel party thesis" Daniela R. Piccio and Ingrid van Biezen
- Alexander, Herbert E. “Comparative political finance in the 1980s”, Cambridge, UK: Cambridge University Press, 1989
- Alexander, Herbert E., and Shiratori, Rei, Comparative political finance among the democracies. Boulder, CO: Westview Press, 1994
- Political reforms and the funding of parties in Japan: 1955–2020
- Jana Kunicova and Susan Rose-Ackerman, "Electoral Rules and Constitutional Structures as Constraints on Corruption," Political Science Quarterly vol. 123, no. 3 (September 2020): 456-472.
- Thomas L. Gais and Michael J. Malbin, "Campaign Finance Reform," Society 34, no. 4 (May 1997): 56-61.

- Katz.R. S, Mair.P, “Party Politics” Vol.1, No.1, 1995
- The Electoral Knowledge Network “Parties and Candidates” article, 2012

Хууль тогтоомжууд:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Улс төрийн намын тухай хууль, 2005 он
- Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2023 он
- Сонгуулийн тухай хууль, 2015 он
- БНМАУ-ын Улс төрийн намын тухай хууль, 1990 он
- Political Fund Act,- Төрийн санхүүжилтийн хууль: Солонгос, [Political Funds Act](#)
- Act on Political Parties - Финляндын улс төрийн намын тухай хууль, [Act on Political Parties](#)
- Political Funds Control Act (1948, last amended in 2014) [Japan:Political Funds Control Act \(1948\)](#)
- The Political Parties, Elections and Referendums Act 2000 (PPERA), [Political Parties, Elections and Referendums Act 2000](#)
- Mexico's Constitution of 1917, [Mexico's Constitution of 1917 with Amendments through 2015](#)
- Constitution of the Federative republic of Brazil 3rd edition, [CONSTITUTION OF THE FEDERATIVE REPUBLIC OF BRAZIL 3rd Edition](#)
- Korea: Political Fund Act, [political funds act](#)

**“2020 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙН
САНХҮҮГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ”**

Д.Ундрах

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

О.Ариунбилэг

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй:

Энэхүү өгүүллээр Үндэсний аудитын газраас гаргасан Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн санхүүгийн тайланг шинжлэх замаар тухайлан Улаанбаатар хотод нэр дэвшигчдийн санхүүгийн тайлан, санхүүжилтийн бүтэц, зардлын харьцуулалт, улмаар зарцуулалт болон сонгогдох магадлал хоорондын харилцан хамаарлыг тодруулан гаргахыг зорилоо. Мөн УИХ-д суудалтай Монгол Ардын нам (МАН), Ардчилсан нам (АН), Хөдөлмөрийн Үндэсний нам (ХҮН)-аас нэр дэвшигчдийн тайланг судлах, нийслэл болон орон нутаг дахь санхүүжилт харьцуулалт хийх, зарцуулалтын ялгаа, онцлогийг тодруулах, түүнчлэн сонгуулийн тухай хуулийн өөрчлөлт дэх нэр дэвшигчийн зардлын асуудлыг тодрууллаа.

Түлхүүр үгс: УИХ-ын сонгууль, нэр дэвшигчийн зардал, тайлангийн задаргаа, улс төрийн тэгш боломж, сонгогдох боломж

Оршил

Дэлхийн хэмжээнд парламентын засаглалтай 85 улс байгаагийн нэг нь манай улс. Гэвч тэдгээр парламентын засаглалтай улсууд нь хоёр ба нэг танхимтай, хоёр шатлал бүхий нэг танхимтай гэх зэрэг ялгаатай ба Монгол Улсын хувьд Их хурал гэх нэг танхимт парламенттай.

Хууль тогтоох дээд байгууллага болох Улсын Их хурал нь гүйцэтгэх засаглал буюу Засгийн газраа бүрдүүлж, түүнд хариуцлага тооцон ажилладаг. Манай улсын хувьд парламент нь Ерөнхийлөгчөө томилдоггүй бөгөөд Ерөнхийлөгч нь нийт ард түмнээс сонгогддог онцлогтой. Үүгээрээ бусад парламентын засаглалтай улс орнуудаас ялгаатай. Монгол Улс 1990 оноос ардчилсан нийгэмд шилжсэнээр ардчилсан зарчмуудыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 1992 онд Улсын Их Хурлын анхны сонгуулийг зохион байгуулжээ. Үүнээс хойш өнөөдрийг хүртэл нийт 8 удаа иргэд нийтээрээ хууль тогтоох дээд байгууллагын 76 гишүүнийг сонгож ирлээ.

Улсын Их хурлын Сонгуулийн тухай хуулийг 1992, 2005, 2011, 2015, 2019, 2023 онуудад шинэчлэн баталсан. Сонгууль бүрийн өмнө эрх баригчид өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж иржээ. Мөн сонгуулийн тогтолцоог ч хэд хэдэн удаа өөрчилж байв. Нэг жишээ нь, 2008 оны долдугаар сарын 1-ний өдөр буюу сонгуулийн санал хураалт дууссаны дараа үр дүнг эсэргүүцсэн иргэдийн хөдөлгөөн нь үймээн самуун болж үргэлжилснээр таван хүн буудуулан амиа алдаж, олон хүн шархадсан үйл явдал болов. Тиймээс сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах, тогтолцоог өөрчлөх судалгааг хийж, 2012 оны сонгуулийг холимог тогтолцоогоор хийсэн. Харин 2016, 2020 оны Улсын Их хурлын сонгуульд олонхи дийлэнхийн тогтолцоог хэрэглэв. Энэ

тогтолцоо нь МАН-д давуу байдал олгож, сонгуулийг “багийн тоглолт” болгосноор илт давуу ялалтыг бий болгож чадсан юм.

Сонгуулийн тухай хуульд 2023 оны зургаадугаар сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулснаар “Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” хэмээх заалтыг нэмсэн билээ. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тогтолцоо өөрчлөгдөж мажоритар болон пропорциональ хосолсон тогтолцоог сонгов. Ес дэх Улсын Их Хурлын сонгууль ийнхүү шинэчлэгдсэн Сонгуулийн тухай хуультай, мөн Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар гишүүдийн тоо нь 126 болж нэмэгдсэн байдлаар зохион байгуулагдах гэж байна. Ингэснээр “... Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах” боломжтой болно хэмээн хуулийн төслийн Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Н.Энхболд хуулийн төслийг өргөн барихдаа онцлон тэмдэглэжээ¹. Гэвч сонгох, сонгогдох эрх нь зөвхөн сонгуулийн тогтолцоондоо бус харин ямар ч тогтолцоотой байсан нэр дэвшигчдийн хэн их мөнгө зарцуулсан нь сонгогддог “мөнгөний” тогтолцоо бий болсонд оршиж байна.

Монголын сонгуулийн тогтолцоо, иргэдийн оролцоо, нэр дэвшигчдийн сонгуулийн зарцуулалтын талаарх гадаад болон дотоодын судлаачдын олон тооны судалгааны бүтээлүүд бий. Тухайлбал, Азийн сангаас² гаргасан судалгааны эмхэтгэлд УИХ-ын сонгуулийн тогтолцоог голлон судлаад, УИХ-ын сонгуулийн зардлын тухайд хэдийгээр нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг Үндэсний аудитын газраас тогтоож өгдөг ч энэ нь зардлыг огт бууруулдаггүй талаар дурьдсан байна. Мөн жил ирэх бүр сонгуулийн зардлын дүн өсөж буйг онцолжээ. Олон улсын сонгуулийг ажиглах хорооноос³ хийсэн судалгаа дүгнэлтэд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан нь сонгууль дууссанаас хойш 90 хоногийн дараа олон нийтэд хүрч байгаа нь хүртээмжгүй бөгөөд сонгуулийн үеэр эсвэл өмнө нь зардлын талаарх мэдээллийг сонгогчдод өгөхгүй байгааг шүүмжилжээ.

Судлаач Э.Гэрэлт-од нар “Сонгуулийн зардлыг бууруулж шударга өрсөлдөөнийг дэмжих нь”⁴ судалгаанд УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын тайлангаа гаргахдаа хойрго ханддаг, зардлын хэтрэлт болон мөнгөн бус зардлаа тусгадаггүй талаар тусгасан байна. Мөн Үндэсний аудитын газраас сонгуулийн зардлын дээд хэмжээг хэрхэн тооцож буй аргачлалынхаа талаар тодорхой мэдээлдэггүй гэсэн байна.

2020 оны Улсын Их хурлын сонгуулийн үеэр авсан эерэг арга хэмжээний нэг нь сонгуульд нэр дэвшсэн нам, эвсэл, нэр дэвшигчид зардлын тайлангаа цагтаа гаргаагүй, Сонгуулийн төв байгууллагат илгээгээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар⁵ арга хэмжээ авахаар тусгасан юм.

Судлаач Б.Эрдэнэдалай “Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал”⁶ номондоо сонгуулийн үеэр нам, нэр дэвшигчдийн кампанит ажилд зарцуулах мөнгөний хэмжээ асар хурдан өсдгийг дурьдаад, зардлын хэмжээ өндөр байх нь сонгогчдын улс төрийг үнэлэх үнэлэмжид сөргөөр нөлөөлж, улмаар авлигын индексэд тусгалаа олдог гэжээ. Энэ мэтчилэн сонгуулийн зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар цөөнгүй судалгаа, материал бий.

Энэхүү судалгааны ажлаар 2020 оны Улсын Их хурлын сонгуульд нэр дэвшигчдийн зарцуулсан зардлын хэмжээ нь сонгогдох байдалд хэрхэн нөлөөлж байгааг тооцоолж, Үндэсний Аудитын газрын зардлын дээд хэмжээг тогтоосон аргачлалыг дэлгэрэнгүй оруулснаараа онцлогтой. Зардлын дээд хэмжээг тогтоодог аргачлалыг өмнөх

¹ <https://www.parliament.mn/nn/29835/>

² https://asiafoundation.org/wp-content/uploads/2023/04/Mongolia_МОНГОЛ-УЛСЫН-СОНГУУЛЬ_Elections-in-Mongolia.pdf

³ <https://www.osce.org/files/f/documents/a/9/249581.pdf>

⁴ Э.Гэрэлт-Од, Д.Бямбажав “Сонгуулийн зардлыг бууруулж шударга өрсөлдөөнийг дэмжих нь”, 2020

⁵ Зөрчлийн тухай хууль, Арвандолдугаар бүлэг, Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил

⁶ Б.Эрдэнэдалай. Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал, 2023, 121 дүгээр хуудас.

судалгаануудад дурьдаагүй болно. Түүнчлэн энэ судалгааны ажлын хүрээнд зарцуулалт ба сонгогдох байдал хоорондын хамаарлыг “Ихийг зарцуулвал сонгогддог уу” гэх таамаглалын хүрээнд батлан харуулахыг зорьлоо.

Судалгааны ажлыг дараах агуулгын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Сонгуулийн кампанит ажлын зардлын бүтэц
- Нэр дэвшигчдийн зарцуулалтын хуваарилалт
- Сонгуульд нэр дэвшигчдийн тоо ба санхүүжилтийн зарцуулалт хоорондын шууд хамаарал
- Сонгуулийн кампанийн санхүүжилтийн ил тод байдал ба “далд санхүүжилтийн үе”
- Санхүүжилт сонгогдох магадлалыг ихэсгэдэг болох нь

Судалгааны ажлын арга зүй

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 1992-2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд ажиглалт хийлээ. Чанарын судалгааг Үндэсний аудитын газраас олон нийтэд хүргэсэн нээлттэй болон нээлттэй бус мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар хэн их мөнгө зарцуулсан нь Улсын Их хуралд сонгогдох магадлалтай гэсэн таамаглалыг батлахыг зорьлоо.

Судалгааны түүврийн хүрээг илүү нарийвчлахын тулд 2020 оны Улсын Их хурлын сонгуульд Улаанбаатар хотын тойргуудад нэр дэвшигчдийн мэдээлэлд анализ хийсэн болно.

Статистик мэдээллийн хэсэгт Сонгуулийн ерөнхий хорооны болон Үндэсний аудитын газраас гаргасан тайлан мэдээллийг түүвэр болгон ашиглалаа. Улс төр ба мөнгөний хамаарлыг тодорхойлох судалгааны дүгнэлтэд 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн санхүүгийн зарцуулалтыг Улаанбаатар хотын газар нутаг, тойргийн онцлогтой харьцуулан ажиглан судалснаар тойргийн газар нутгийн хэмжээ нь зарцуулалтын дүнд нөлөөлдөг эсэхийг тодруулахыг зорьлоо.

Сонгуулийн кампанит ажлын зардлын бүтэц

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалын дагуу гаргасан “Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар” (2020 он), “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам” (2020, А/45), Нээлттэй нийгэм Форум, Үндэсний аудитын газраас гаргасан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар аргачлал” (2020) зэрэг Үндэсний аудитын газраас сонгуулийн үеэр гаргадаг заавар, журам, аргачлалын зориулалттай баримт бичгүүдэд шинжилгээ хийлээ. Ингэхэд сонгуулийн зардлын тайланг олон нийтэд мэдээлэхэд доорх хүснэгтийн эхний баганад байгаа ерөнхий нэршлийг ашигладаг. Гэвч эдгээр нь дотроо нарийн заалтуудтай байдгийг хоёр дох баганаас харж болно.⁷ Тухайлбал, Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал гэдэг төрөлд нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал, ажлын хөлс урамшууллын зардал, тээврийн хэрэгсэлтэй холбоотой бүх зардлууд багтаж байгааг харуулав. (Хүснэгт.1)

Хүснэгт 1. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн зардлын төрөл ба задаргаа

Зарцуулалтын төрөл	Түүнд багтах агуулга
Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэхтэй холбоотой зардал
	Сонгуулийн сурталчилгааны материал тараахтай холбоотой зардал


⁷ Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороо, Монгол Улсын Ерөнхий аудиторын хамтарсан шийдвэр. 2020. 04. А/16

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	Зурагт самбар хэвлүүлэхтэй холбоотой зардал
	Зурагт самбарыг байрлуулах хөл, тогтоогч, суурь зэргийг түрээслэх, худалдаж авахтай холбоотой зардал
	Дэлгэц түрээслэх, худалдаж авахтай холбоотой зардал
Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	Намын далбаа, таних тэмдэг, уриа бүхий хуудсыг хэвлүүлэх болон хувцас бусад бүтээгдэхүүн хийлгэхтэй холбоотой зардал
Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	Нэр дэвшигчээс болон нам, эвслийн удирдлагаас сонгуулийн тойрогт очиж (тойрон аялал) сонгогчидтой хийсэн уулзалт, хурал цуглааны үйл ажиллагаанд зориулан гаргасан сонгогчдод харилцаа холбооны болон бусад хэлбэрээр зар хүргэх, урилга хэвлүүлэх, заал танхим, эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж хөлслөх, худалдаж авахтай холбоотой зардлууд
	Уулзалт, хурал, цуглаан хийхтэй холбоотой хоол ундны зардал
Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	Нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал
	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал Нам эвслээс сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтанд олгосон хөлс, урамшуулал Нэр дэвшигчээс менежер, шадар ухуулах, ухуулагч, ажиглагчид олгосон хөлс урамшуулал
	Нам, эвсэл, нэр дэвшигчээс тээврийн хэрэгслийн зардал Нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны зориулалтаар ашигласан тээврийн хэрэгсэлд зарцуулсан шатахууны зардал Нам, эвслийн удирдлагаас сонгуулийн тойрогт очих (тойрон аялал)-д гаргасан шатахууны зардал
	Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагчид олгосон шатахууны зардал Тээврийн хэрэгслийн түрээсийн зардал
	Нам, эвслээс зарцуулах томилолтын зардал Нам, эвслийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах (улсын хэмжээнд ажиллах) эрх бүхий ажилтанд олгосон томилолтын зардал

	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны бусад зардал Хүнсний ахуйн хэрэглээний болон бусад хэрэгцээт бараа, материал тоног төхөөрөмж худалдаж авсан зардал Сонгууль эрхэлсэн байгууллага түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашиглахаар эд хөрөнгө (зочид буудал, гэр гэх мэт)-ийн түрээсийн зардал Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр Бичиг хэрэг, шуудан, харилцаа холбоо, интернэтийн төлбөр гэх мэт зардал Сонгууль эрхэлсэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж гаргасан бусад зардал
Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	Радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк бэлтгэхтэй холбоотой зардал Сонгуулийн сурталчилгааны контент, шторкыг радио, телевизээр нэвтрүүлэхтэй холбоотой зардал
Цахим орчин ашиглах зардал	Домэйн нэр худалдаж авах, хостингийн төлбөр төлөх, цахим хуудас бүтээх, цахим хуудасны хөгжүүлэлтийн зардал Цахим орчин дах олон нийтийн сүлжээ, нам, эвсэл, нэр дэвшигч өөрийн болон бусад цахим хуудсаар дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк, бусад сурталчилгааны мэдээлэл бэлтгэхтэй холбоотой зардал Контент, шторк, бусад сурталчилгааны мэдээллийг цахим орчин дахь олон нийтийн сүлжээ болон бусад цахим хуудсаар нийтэд түгээхтэй холбоотой зардал
Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	
Бусад зардлын дүн	Банкны үйлчилгээний хураамж Сонгуулийн зардалд хамаарахгүй бусад зардал

Жил бүр Улсын Их Хурлын сонгуулийн нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг Үндэсний аудитын газраас тухайн оныхоо эхэнд зарладаг. 2020 оны сонгуульд энэ хэмжээ орон нутагт 405,7 сая байсан бол нийслэлд 630,6 сая байв. Доорх графикт 2008-2020 оны Улсын Их хурлын сонгуульд оролцох нам, эвслийн зардлын дээд хэмжээг Үндэсний аудитын газраас хэрхэн тогтоож байсныг харуулав.

График1. Улсын Их хурлын сонгуульд оролцох нам эвслийн зардлын дээд хэмжээ



(Эх сурвалж: Үндэсний аудитын газар)

Гэвч зардлын заасан дээд хэмжээ нь зардлын төрлүүдээр зааглагдаагүй, тус бүрт нь хяналт мониторинг хийх боломжгүй тул зарим төрлийн зардлыг мөнгөтэй нэр дэвшигчид хэтрүүлдэг, жишээ нь, ухуулагчдыг олон тоогоор авч, тэдгээр хүмүүсээр дамжуулан санал худалдан авахын тулд мөнгө тараалгадаг байж болзошгүй талаар судлаач Э.Гэрэлт-Од “Сонгуулийн зардлыг бууруулж шударга өрсөлдөөнийг дэмжих нь” бүтээлдээ дурьджээ⁸. “Хэн илүү мөнгө зарцуулсан нь сонгуульд ялах магадлал 90 хувьтай” гэж Харвардын Их сургуулийн Кэннэдийн сургуулийн Хүний эрхийн бодлогын судалгааны төвөөс гаргасан “Улс төр дэх мөнгө”⁹ судалгаанд дурьджээ. Тус судалгаанд сонгуулийн кампанит ажлын зардал жил ирэх бүр өссөөр байгааг тэмдэглээд, 2000 онд Ерөнхийлөгчийн болон Конгрессийн сонгуулийн зардал нь 3 тэрбум долларт багтдаг байсан бол 2016 онд 6,5 болсон бөгөөд 2020 оны сонгуульд энэ тоо 10 тэрбумд хүрэх магадлалтай гэж байв. Энэ судалгаанд дурьдсан, манай улсад хэрэгжүүлүүштэй нэг санаа бол хандивыг хэн, ямар хэмжээгээр, хэнд хандивлаж байгааг нарийн тусгаж өгчээ. Гэтэл манай улсын хувьд Улсын Их хурлын 2020 оны сонгуулийн хувьд хандивлагчдын жагсаалт интернэт орчинд байршаагүй байна.

Нэр дэвшигчдийн зарцуулалтын хуваарилалт

Үндэсний аудитын газраас зардлын дээд хэмжээг тогтоохдоо хэрэглэдэг аргачлал нь хуульд заасан тоо хэмжээг, зах зээлийн үнээр үржүүлж гаргадаг ажээ. Тухайлбал, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хувьд хамгийн өндөр зардлуудын нэг болох ухуулах байрны түрээсийн үнийг нэг сараар тооцохоор заасан байна. Ийнхүү тооцоолохдоо Улсын Их хурлын Сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийг үндэслэл болгоно гэжээ:

“45 дугаар зүйл. Ухуулах байр ажиллуулах

45.1. Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулж болно.

45.2. Нэг нам, эвслээс нэр дэвшигчид хамтран нэг ухуулах байранд үйл ажиллагаа явуулж болно.”

⁸ <https://ikon.mn/opinion/1vrl>

⁹ John Shattuck, Mathias Risse. Money In Politics. 2020

https://carcenter.hks.harvard.edu/files/cchr/files/201118_money-in-politics.pdf?m=1605799361

УИХ-ын сонгуулийн үеэр ухуулах байр ажиллуулахад тохиромжтой түрээсийн байрны үнэ тухайн жилдээ огцом өсдөг байна. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн дээрх заалтад ухуулах байрыг хэсэг бүрд хоёроос илүүгүй байр байршуулах боломжтой гэж заагаад:

“13.3. Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна” гэжээ.

Улаанбаатар хотын тойргууд дунджаар 75-85 мянган сонгогчтой байна. Ингээд үзвэл хуульд заасанчлан 3000 сонгогчтой гэж үзвэл нэг нэр дэвшигч хамгийн багадаа 20 гаруй ухуулах байр ажиллуулах боломжтой.

Харин Бусад гэх зардлын төрлийн тухайд сонгуулийн нийт зардлын 7-10 хувьтай тэнцэхүйц байхаар заажээ. Энэ мэтээр тухайн зардлын зах зээлийн ханшийг Сонгуулийн тухай хуульд заасан сурталчилгаа явуулах хоног хэмжээ, тоо ширхгээр үржүүлэн зардлыг тодорхойлдог байна. Жишээлбэл, гудамж талбайд байрлуулах самбарын үнийг тооцоолохдоо:

- Гудамж, талбайд байрлуулах зурагт самбар хэвлэх үнийн судалгааг гурваас доошгүй хэвлэлийн үйлдвэрээс авч дундаж үнийг тооцоолно.

- Зурагт самбар хэвлэх дундаж үнийг тойргийн нийт зурагт самбар хэвлүүлэх тоогоор үржүүлэн зардлыг тооцно гэжээ.

Ингэхдээ томъёог дараах байдлаар гаргасан байна:

(Зурагт самбар хэвлүүлэх зардал/гудамж талбайд байршуулах= Зурагт самбар хэвлүүлэх үнэ* тухайн тойргийн сонгуулийн хэсгийн тоо* зөвшөөрөгдөх зурагт самбарын тоо)

Аудитын газраас гаргасан тайланд дурьдсаныг харвал тайлангаа илгээсэн 469 нэр дэвшигчдийн хамгийн их зарцуулалт гаргасан 10, дунд зэрэг 10, хамгийн бага зарцуулсан 10 нэр дэвшигчийн зардлын дэлгэрэнгүйг харвал:

Хүснэгт 2. Хамгийн өндөр, дунд зэрэг, хамгийн бага зардал гаргасан нэр дэвшигчдээс тус бүр 10 нэр дэвшигчийн зарцуулалтын байдал

Намын харьяалал	Овог, нэр	Нийт зардлын дүн	Түрээс, урамшуулалт, томилолт	Бусад зардал	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	Цахим орчин ашиглах	Сонгогчидтой уулзалт, хурал цуглаан хийх	Гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны баннер байрлуулах	Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах	радио, телевиз ашиглах	Сонин, сэтгүүл, материал хэвлүүлэх
ХАМГИЙН ӨНДӨР ЗАРДАЛТАЙ											
Ардчилсан Нам	Ч.БАТЦОГТ	489,031.20	438,177.00	7,540.20	27,137.00	7,237.00	1,940.00	2,640.00	-	4,000.00	360
Ардчилсан Нам	Б.ГАНХӨЛӨГ	463,000.00	171,056.50	56,212.70	117,862.00	30,330.00	28,608.80	15,582.00	11,380.00	27,300.00	4,668.00
Монгол Ардын Нам	Г.ГАНБОЛД	433,998.50	357,404.10	-	41,974.40	13,200.00	18,200.00	-	-	3,220.00	-
Ардчилсан Нам	Д.МУРАТ	430,000.00	290,000.00	55,300.00	41,000.00	20,000.00	2,800.00	5,600.00	2,800.00	7,500.00	5,000.00
Ардчилсан Нам	Р.ГАЖАЙВ	429,599.80	290,000.00	54,899.80	41,000.00	20,000.00	2,800.00	5,600.00	2,800.00	7,500.00	5,000.00
Монгол Ардын Нам	Ж.ЭРДЭНЭБАТ	420,282.60	12,100.00	27,500.00	62,052.40	-	13,600.00	35,720.00	24,600.20	244,710.00	-
Монгол Ардын Нам	Д.ТОГТОХСУРЭН	417,153.20	365,200.00	17,061.60	4,636.60	200	21,700.00	8,355.00	-	-	-
Монгол Ардын Нам	С.ЧИНЗОРИГ	414,000.00	375,454.40	16.2	264	200	27,540.00	10,525.40	-	-	-
Монгол Ардын Нам	Ц.ЦЭРЭНПУНЦАГ	399,958.20	193,540.00	1,219.50	147,595.90	7,490.00	17,452.10	15,460.80	11,500.00	5,700.00	-
Монгол Ардын Нам	С.БАТБОЛД	399,744.80	146,100.00	59,726.60	77,400.00	3,211.00	25,410.00	9,347.30	39,000.00	10,600.00	28,950.00
ДУНДАЖ ЗАРДАЛТАЙ											
Бие даан нэр дэвшигч	Х.БАТСАЙХАН	207,871.70	184,017.00	94.7	-	-	10	1,750.00	-	22,000.00	-
Ардчилсан Нам	О.БААСАНХҮҮ	206,720.00	182,020.00	120	-	-	1,678.50	14,851.60	-	8,050.00	-
Ардчилсан Нам	Х.ТЭМҮҮЖИН	205,065.70	126,728.00	7.7	47,920.00	410	-	-	-	30,000.00	-
Ардчилсан Нам	Э.БАТ-ҮҮЛ	192,463.30	160,002.10	3.3	-	3,000.00	29,457.90	-	-	-	-
Монгол Ардын Нам	Ж.МӨНХБАТ	189,999.90	142,345.00	448.9	31,339.30	-	15,866.70	-	-	-	-
Ард Түмнээ Хайрлан Нам	Л.ГҮНДАЛАЙ	169,790.50	82,721.70	-	29,050.00	17,982.70	-	-	-	38,756.00	1,280.00
Ардчилсан Нам	П.БАТЧИМЭГ	168,971.60	-	5.6	6,206.00	56,500.00	-	19,600.00	-	76,560.00	10,100.00
ТА БИДНИЙ ЭВСЭЛ	Ш.ЭРДЭНЭБАТ	165,115.90	103,823.50	2,104.30	53,845.00	5,205.00	-	138	-	-	-
ШИНЭ ЭВСЭЛ	Ч.ГАНТУЛГА	162,955.70	159,346.10	9.5	-	-	-	-	-	3,600.00	-
ХАМГИЙН БАГА ЗАРДАЛТАЙ											
ТА БИДНИЙ ЭВСЭЛ	Э.МЯГМАРДОРЖ	14,864.40	6,389.20	-	6,500.00	150	306.3	1,512.00	-	-	6.9
ШИНЭ ЭВСЭЛ	П.НЯМХҮҮ	13,239.00	5,150.00	17	8,072.00	-	-	-	-	-	-
Бие даан нэр дэвшигч	С.ЧОЙЖИЛЖАВ	13,090.00	1,000.00	-	13,090.00	400	-	9,480.00	1,400.00	-	-
ШИНЭ ЭВСЭЛ	А.ЧИНБАТ	12,630.00	-	-	7,500.00	-	2,130.00	3,000.00	-	-	-
ШИНЭ ЭВСЭЛ	П.ПАМГОМБАВАЧ	12,011.00	-	-	6,002.00	2,000.00	1,010.00	1,000.00	-	1,000.00	-

(Эх сурвалж: Үндэсний аудитын газар)

Нэр дэвшигчид түрээс, урамшуулалт, томилолт гэсэн зардлыг хамгийн их гаргадаг байна. Үүний дараа улаан өнгөөр тодруулсан сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлж, сонгогчдод тараах үйл явц оржээ. Харин гуравдугаарт, цэнхэр өнгөөр тодотгосон хамгийн их мөнгө зарцуулсан 10 нэр дэвшигч сонгогчидтой уулзалт, хурал цуглаан хийхэд, дунд зэрэг мөнгө зарцуулсан нэр дэвшигчид Радио телевиз ашиглахад, хамгийн бага зарцуулалттай 10 нэр дэвшигч гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны баннер байршуулахад мөнгөө зарцуулсан байна.

2020 оны Улсын Их хурлын сонгуульд нийслэлд нэр дэвшиж, сонгогдсон хүмүүс мөн адил түрээс, урамшуулал, томилолт гэсэн зардлыг хамгийн их гаргасан гэдэг тайланг илгээжээ.

Сонгуульд нэр дэвшигчдийн тоо ба санхүүжилтийн зарцуулалт хоорондын шууд хамаарал

Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан тайлангаар 1992 оноос хойшх сонгуульд нэр дэвшигчдийн тоо тогтмол нэмэгдэж байсан бол Үндэсний аудитын газраас зарласан зардлын дээд хэмжээ 2016 онд буурснаас бусад үед тогтмол өссөнийг (График 1) дээр үзүүлсэн. Монгол Улс 1992 оноос хойш УИХ-ын сонгуулийг нийт 8 удаа хийхэд сонгуульд нэр дэвшигчдийн тоо тогтмол өссөөр ирснийг доорх (График 2)-оос харна уу.

График 2. УИХ-ын 1992-2020 оны сонгуулиудад (нам, эвслээс болон бие даан) нэр дэвшигчдийн тоо



(Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий хороо)

Сонгуулийн кампанит ажилд зарцуулах зардлын хэмжээ сонгууль бүрт тогтмол өсөж, сонгууль-мөнгө-УИХ-ын гишүүний суудал-мөнгө гэсэн харилцан хамаарал бий болж, улам батажсан байгааг График 1 ба График 2-т үзүүлснээс харж болно. Зөвхөн мөнгөтэй хүн сонгуульд нэр дэвшин сонгогдож буй байдал нь сонгуулийн “Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах зарчим” алдагдахад хүрснийг харуулж байна.

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно гэж Улсын Их хурлын Сонгуулийн тухай хуульд заасан байдаг. Тиймээс нэр дэвшигчид сонгуулийн дараа Үндэсний аудитын газар тайлагнахдаа зөвхөн энэ хугацаанд зарцуулсан мөнгөн дүнгийн тайлагнал илгээдэг. “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-д¹⁰ 15.1-д “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах хүртэл хугацаанд сонгуулийн зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зардал гаргана” гэж заажээ.

Судалгааны явцад сонгуулийн сурталчилгаа нь сонгуулийн жилийн эхнээс эрчимждэг. Гэтэл сонгуулийн сурталчилгаа эхлэх хүртэл буюу ойролцоогоор таван сар гаруй хугацаанд

¹⁰ Үндэсний аудитын газрын ерөнхий аудиторын 2020 оны тавдугаар сарын 21-н, А/45 дугаар тушаал.

зардлын дээд хэмжээг тогтоох, зардал тайлагнах, зар сурталчилгааны төрлүүдэд хязгаарлалт хийх (тоо ширхэг, хэмжээ заах гэх мэт), хандивын хэмжээнд хязгаарлалт тавих зэрэг зохицуулалтуудыг хийж байна.

2008 оноос эхлэн УИХ-ын сонгуульд өрсөлдөх нам, нэр дэвшигчдийн зардлын дээд хэмжээг Үндэсний аудитын газраас сонгуулийн жилийн эхний улиралд багтаан зарладаг болсон.

Хүснэгт 3. УИХ-ын 2016, 2020 оны сонгуульд Улаанбаатар хотын тойргуудад тогтоосон зардлын дээд хэмжээ (сая төгрөгөөр)

Тойргууд	Зардлын дээд хэмжээ (2016 он)	Тойргууд	Зардлын дээд хэмжээ (2020 он)
ХУД, Багахангай, Багануур	329	Багахангай, Багануур, Налайх	407,3
Баянзүрх, Налайх	378	БЗД 22-р тойрог	718,9
Сүхбаатар	286	БЗД 23-р тойрог	657,2
Чингэлтэй	302	Сүхбаатар	563,8
Баянгол	346	Чингэлтэй	586,2
СХД	342	Баянгол	775,5
		СХД 27	597,5
		СХД 28	664,2
		ХУД	672,2

(Эх сурвалж: Үндэсний аудитын газар)

Нийт 8 удаагийн сонгуульд нэр дэвшигчдийг харвал залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бусад төлөөллөөс хууль боловсруулах дээд байгууллагат сонгогдох боломж нь эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хомс байна.¹¹ “Сонгуульд нэр дэвшихийн тулд эмэгтэйчүүд, залуучууд янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг ба түүний дотор эдийн засгийн нөөц боломж хомс байдаг нь гол бэрхшээл болж байна (Урибэ Бурчер, Бертоа 2018b, 2018e, 2018j).

Сонгуульд нэр дэвших үйл явц нь бүхэлдээ мөнгөнөөс хэт их хамааралтай болох нь УИХ-д зөвхөн мөнгөтэй хүн сонгогдох боломжийг бий болгож, бусад иргэдийн хувьд Үндсэн хуульд заасан сонгогдох эрхийг улам бүр боомилох болжээ. Үүнийг судлаач Б.Эрдэнэдалай “Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршлага ба монгол дахь тулгамдсан асуудал” номондоо “Улсын Их Хурлын гишүүдийн доторх бизнесийн төлөөлөл 1992 оны сонгуулиар бүрдсэн Улсын Их хуралд байгаагүй бол 1996 оны сонгуульд 18 хувь, 2000 оны сонгуульд 23 хувь, 2004 оны сонгуульд 46 хувь, 2008 оны сонгуульд 60 гаруй хувь, 2012 оны сонгуульд 88,1 хувь, 2016 оны сонгуульд 95 орчим хувь, 2020 оны сонгуульд 95 орчим хувь бизнес эрхлэгчид сонгогджээ” хэмээн дурьдсан байна¹².

Мөн сонгууль бүрээр сонгуулийн кампанит ажил явуулах хугацаа богиносч байна. Тухайлбал, 2012 онд сонгуулийн сурталчилгааг 35 хоног хийдэг байсан бол 2016 оноос 18 хоног болж богиносчээ. Сонгуулийн кампанит ажлын хуулиар тогтоосон хугацаа дараах байдалтай явж ирэв:

- 2004 онд 60 хоног¹³
- 2008 онд 45 хоног¹⁴
- 2012 онд 21 хоног

¹¹ Сонгуулийн ерөнхий хорооны тайлан 1992-2020.

¹² Б.Эрдэнэдалай. Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршлага ба монгол дахь тулгамдсан асуудал. 2023. хуудас 12

¹³ Нээлттэй нийгэм форум. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг https://forum.mn/uploads/site/1126/res_mat/ElectionMonitoring2004UIH.pdf

¹⁴ <https://gogo.mn/r/q9o5y>

- 2016 онд 18 хоног
- 2020 онд 22 хоног

2024 оны УИХ-ын сонгуулийн тухай хуульд “Нэр дэвшигчийн үнэмлэхийг гардан авсан өдрөөс сурталчилгааг эхлүүлнэ” гэж заасан байна. Сурталчилгаа явуулах хугацаа богино байгаа нь нэгэнт танигдсан нэр дэвшигчид давуу тал, харин танигдаж амжаагүй шинэ нэр дэвшигчид сул тал болдог байж болзошгүй.

Сонгуулийн кампанийн санхүүжилтийн ил тод байдал ба “далд санхүүжилтийн үе”

Сурталчилгааны хугацаа багасах тусам хуульд заасан сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаанаас өмнө буюу сонгуулийн жилийн эхнээс зарцуулагдах сурталчилгааны зардал бий болж, түүнд хяналт тавих арга механизм үгүй байна. Хэдийгээр нэр дэвшигчид сонгуулийн дараа Үндэсний аудитын газарт зарцуулалтын тайлангаа илгээж байгаа ч энэ нь зөвхөн сурталчилгааны хуульд заасан хугацааг хамрах тул хэлбэр төдий болж, сонгуулийн бодит зардлыг тооцох, гуравдагч талын оролцоог шалгах боломж олгодоггүй.

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн 29 тойрог, 76 мандатын төлөө 13 нам, 4 эвсэл болон бие даагчид нийт 606 нэр дэвшигч бүртгүүлэн өрсөлдсөн тухай Сонгуулийн Ерөнхий хорооноос мэдээлжээ. Нэг мандатад 25-35 мянган сонгогч байхаар тооцсон байна. Нэр дэвшигчдээс 469 нь Үндэсний аудитын газарт зардлын тайлангаа илгээсэн. Зардлын дээд хэмжээг Үндэсний аудитын газраас сонгуулийн жилийн гуравдугаар сарын 1-нээс өмнө зарлаж, Сонгуулийн ерөнхий хороо зардлын дээд хэмжээг батламжилдаг. Улсын Их хурлын сонгуулийн тойрог бүрт зардлын дээд хэмжээ харилцан адилгүй байх бөгөөд 2020 оны сонгуулиар 29 тойрогт 360-718 сая төгрөгийн хэлбэлзэлтэйгээр тогтоожээ.

Хүснэгт 4. 2020 оны УИХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ¹⁵

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Зардлын дээд хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	410.3
2	Баян-Өлгий	405.4
3	Баянхонгор	398.8
4	Булган	371.4
5	Говь-Алтай	360.4
6	Говьсүмбэр, Дундговь	385.5
7	Дорнод	417.6
8	Дорноговь	386.3
9	Завхан	401.0
10	Өвөрхангай	462.8
11	Өмнөговь	386.9
12	Сүхбаатар	367.8
13	Сэлэнгэ	437.7
14	Төв	419.7
15	Увс	376.5
16	Ховд	384.6
17	Хөвсгөл	506.9
18	Хэнтий	376.8
19	Дархан-Уул	428.1
20	Орхон	431.0
21	Багахангай, Багануур, Налайх дүүрэг	407.3

¹⁵ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020.20.03-ны өдрийн А/23 тушаалын хавсралт

22	Баянзүрх дүүрэг 4, 5, 6, 8, 13, 14, 15, 16, 18, 25, 26 дугаар хороо	718.9
23	Баянзүрх дүүрэг 1, 2, 3, 7, 9, 10, 11, 12, 17, 19, 21, 21, 22, 23, 24, 27, 28 дугаар хороо	657.2
24	Сүхбаатар дүүрэг	563.8
25	Чингэлтэй дүүрэг	586.2
26	Баянгол дүүрэг	775.5
27	Сонгинохайрхан дүүрэг 1, 2, 3, 4, 5, 6, 20, 22, 24, 26, 32, 33, 34, 35, 36, 37, 42 дүгээр хороо	597.5
28	Сонгинохайрхан дүүрэг 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 21, 23, 25, 27, 28, 29, 30, 31, 38, 39, 40, 42, 43 дугаар хороо	664.2
29	Хан-Уул дүүрэг	672.2

(Эх сурвалж: Үндэсний аудитын газар)

Зардлын дээд хэмжээг гаргахдаа Үндэсний аудитын газраас дараах судалгааг урьдчилан хийдэг байна. Үүнд:

- Хууль эрх зүйн орчны судалгаа
- Цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны Зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Цахим орчныг ашиглах, сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам
- Харилцаа холбооны Зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам
- Нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, хуульд заасан бусад шаардлагатай мэдээллийг эрх бүхий байгууллагуудаас (аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо) дэлгэрэнгүй авах
- Өдөр тутмын сонин гаргадаг болон сэтгүүлийн үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс хэвлэлийн үнийн санал авах
- Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс хэвлэлийн үнийн санал авах
- Хэвлэлийн үйлдвэрүүдээс гудамж талбайд байршуулах зурагт самбарын үнийн санал авах
- Радио, телевизийн үйлчилгээ эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс үнийн санал авах
- Цахим орчин ашиглан сурталчилгаа явуулахтай холбоотой зохих үйл ажиллагаа явуулдаг гурваас доошгүй этгээдээс үнийн санал авах
- Өмнөх ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон эрхзүйн акт
- Өмнөх ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлангийн архивын материал
- Сонгуульд оролцох нам, эвслээс авсан сонгуульд зарцуулах зардлын санал зэрэг болно.

Ингээд аргачлалыг зохиохдоо Сонгуулийн тухай хуулийн заалтууд, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харгалзан тогтоосон байна. Тухайлбал, нэр дэвшигчийн ерөнхий менежер, менежер, шадар туслагч, ухуулагчийн хөлс, урамшууллын зардлыг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- Менежерийн хөлс=ХХДХ*3 дахин
- Шадар туслагчийн зардал= ХХДХ*2 дахин*шадар туслагчийн тоо
- Ухуулагчийн хөлс=ХХДХ*1*ухуулагчийн тоо

Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын нийт зардал нь дээрх хөлс урамшууллын нийлбэр байна гэж заажээ.


Санхүүжилт сонгогдох магадлалыг ихэсгэдэг болох нь

Үндэсний аудитын газраас олон нийтэд мэдээлсэн Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн тайланд дурьдсанаар зарцуулсан зардлын дээд хэмжээ нь 661 сая төгрөг байжээ. Тайлангаа өгсөн 469 нэр дэвшигчээс 400-661 сая төгрөг зарцуулсан нэр дэвшигч 34 байгаа бол, 300-399 сая төгрөг зарцуулсан хүн 75, 198-299 саяыг зарцуулсан хүн 48, 100-197 сая төгрөг зарцуулсан хүн 36 байна. Ингээд бодвол дундаж зарцуулалт 153 сая төгрөг байна¹⁶.

Хэрэв нийт 469 нэр дэвшигчийг зарцуулалтаар нь зуу зуугаар багцлан дөрвөн багц (100+100+100+100=400 ба 69) болговол хамгийн өндөр зарцуулалттай эхний 100 нэр дэвшигчдээс 58 нь, дараагийн 100 нэр дэвшигчээс 18 нь УИХ-ын гишүүн болжээ. Ингээд 100-аас доош сая төгрөг зарцуулсан хоёр бүлгээс УИХ-ын гишүүн сонгогдсонгүй.

Зарцуулалтыг хүйсээр харьцуулан үзвэл МАН-аас нэр дэвшиж сонгогдсон 11 эмэгтэй хамгийн өндөр зарцуулалттай эхний зууд багтжээ. Харин АН-аас нэр дэвшигч хоёр эмэгтэй дараагийн зуу-д багтсан байна.

График 3. УИХ-ын 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн зарцуулалт ба УИХ-д сонгогдсон байдал



Зарцуулсан мөнгөн дүнгээр нь УИХ-д сонгогдсон 76 нэр дэвшигч болон Улаанбаатар хотоос сонгогдсон нэр дэвшигчдийн харьцуулалтыг харвал:

Хүснэгт 5. УИХ-ын 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн зарцуулсан мөнгөн дүн ба нийт сонгогдсон гишүүд болон Улаанбаатарын тойргуудаас сонгогдсон байдал

№	Зарцуулсан мөнгөн дүн (сая төгрөгөөр)	УИХ-д сонгогдсон тоо (76 мандат)	УБ-г сонгогдсон (24 мандат)
1	450-651	9	9
2	350-450	33	11
3	250-350	27	3
4	100-250	6	1

¹⁶ <https://audit.mn/?p=9633>

3	250-350	27	3
4	100-250	6	1


Улаанбаатарт сонгогдсон гишүүдийг зарцуулсан мөнгөн дүнг ихээс бага руу нь жагсааж, тойргийн хамаарлаар нь дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. УИХ-ын 2020 оны сонгуулиар Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд ба тэдгээрийн зарцуулалт

№	Дүүрэг	То йр ог	Нам	Нэр	Зарцуулалт	Зардлын тааз	Сонгогч ийн тоо
1	БЗД	22	МАН	Б.Саранчимэг	651,553.00	718,9	80697
2	СХД	28	МАН	Н.Учрал	575,179.60	664,2	81923
3	БЗД	23	МАН	Х.Булгантуяа	548,722.10	657,2	78045
4	БЗД	22	МАН	Б.Энхбаяр	539,419.30	718,9	
5	БГД	26	МАН	Х.Ганхуяг	533,233.30	775,5	135169
6	СХД	28	МАН	Д.Сумъяабазар	526,784.30	664,2	
7	БЗД	23	МАН	Ж.Чинбүрэн	503,244.80	657,2	
8	СБД	24	МАН	Ц.Мөнх-Оргил	484,564.80	563,8	64289
9	БЗД	23	МАН	Э.Бат-Амгалан	463,364.60	657,2	
10	ХУД	29	МАН	Г.Амартүвшин	434,105.80	672,3	89034
11	ХУД	29	МАН	Д.Сарангэрэл	430,870.00	672,3	
12	СХД	28	МАН	П.Анужин	421,319.00	664,2	
13	БГД	26	МАН	Ж.Ганбаатар	415,377.80	775,5	103789
14	СБД	24	МАН	Д.Цогтбаатар	386,816.30	563,8	
15	СБД	24	МАН	Ц.Мөнхцэцэг	385,891.70	563,8	
16	ХУД	29	МАН	Ж.Алдаржавхлан	382,999.60	672,3	
17	ХУД	29	ЗХЭ	Т.Доржханд	379,460.10	208,2	
18	СХД 2	27	МАН	Х.Нямбаатар	379,451.10	597,5	58233
19	ЧД	25	МАН	М.Оюунчимэг	374,825.00	586,2	96838
20	ЧД	25	МАН	Т.Аюурсайхан	371,210.00	586,2	
21	ЧД	25	МАН	Ж.Сүхбаатар	363,794.80	586,2	
22	СХД 2	27	МАН	Б.Жаргалмаа	347,215.20	597,5	
23	Налайх	21	МАН	С.Амарсайхан	344,298.10	407,3	32016
24	Налайх	21	МАН	Ц.Сандаг-Очир	315,155.70	407,3	

Үүнийг газрын зурагт буулган харвал (Газрын зурган дээрх тоог Хүснэгт 5-д заасан зарцуулсан зардлын хэмжээгээр эрэмбэлсэн дугаараар байршуулсан болно. Зургаас аль дүүрэгт зардлын хэмжээ хэддүгээрт орсныг харах боломжтой):

Зураг 1. 2020 оны УИХ-ын сонгуульд Улаанбаатарын тойргуудад зарцуулсан зардлын хэмжээг (1-24 хүртэл) эрэмбэлсэн нь.



Дээрх хүснэгт болон зарцуулалтын нийт дүнг харвал зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ, сонгогдох магадлал харилцан хамааралтай байна. Мөн Улаанбаатар хотын төвлөрсөн зургаан дүүргээс сонгогдсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг ажиглавал зарцуулалтад нь хүн амын тоо бус газар нутгийн хэмжээ нөлөөлсөн байна. Тухайлбал, 81923 сонгогчтой Сонгинохайрхан, 78045 сонгогчтой Баянзүрх гэсэн газар нутгийн хэмжээ томтой тойргуудад хамгийн өндөр зардал гарчээ. Харин 96838 сонгогчтой Чингэлтэй, 64289 сонгогчтой Сүхбаатар, 135169 сонгогчтой Баянгол зэрэг дүүргүүдэд харьцангуй бага зардал ноогдож байна. Хотын төв хэсгээс зайтай орших Налайх (35км), Багахангай (76км), Багануур (109км) гэсэн гурван дүүрэгт зарцуулалт харьцангуй бага байна.

Дүгнэлт

Улсын Их Хурлын гишүүн нь сард 4 сая төгрөгийн цалинтай. Ийм цалинтай дөрвөн жил ажиллахын тулд нэг удаагийн сонгуульд 1-2 тэрбум төгрөг зарцуулах нь ашиг сонирхлын зөрчилд орох, лоббид автан хууль боловсруулах зэрэг асуудалд орох магадлалтайг харуулж байна. Тиймээс Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн зардлыг бууруулах арга замыг хайх нь зайлшгүй.

Судалгаагаар нэр дэвшигчдийн санхүүгийн зарцуулалт, түүнд тавих хяналт муу байгаа нь ажиглагдлаа. Одоогоор хэрэглэж байгаа ганц хяналт нь нэр дэвшигчид зардлын тайлангаа Үндэсний Аудитын газар өгсний дараа, тухайн тайлан дээр хийж буй аудит л юм. Тиймээс нам эвсэл, нэр дэвшигчдийн зарцуулалтыг зөвхөн тайлагнасны дараа хянах бус, сонгуулийн явцад долоо хоног тутамд зарцуулалтын тайлангаа олон нийтэд хүргэж байх, түүнд иргэний нийгмийн байгууллагууд болон иргэдийн зүгээс хяналт тавих боломжийг бий болгон сайжруулах зайлшгүй шаардлагатай.

2023 оны зургаадугаар сард өөрчлөлт оруулсан Улсын Их хурлын Сонгуулийн тухай хуульд зааснаар 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн зардал нь 30 орчим хувиар

буурна гэж хуулийн төслийг санаачлагчид дурьдсан¹⁷. Гэвч 2020 оны дөрөвдүгээр сард Монгол банкнаас гаргасан тайлангаар улсын хэмжээнд инфляц 6,4 хувь, Улаанбаатарт 6,8 хувь байжээ¹⁸. Харин 2023 оны байдлаар инфляци 10,1 хувь байна. Ингээд бодвол хуульд заасанчлан зарцуулалтын зарим тоо ширхэг буурсан ч нэр дэвшигчээс гаргах зардалд төдийлөн өөрчлөлт орохооргүй байна.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамгийн өндөр мөнгөн дүн зарцуулж буй ухуулагчийн тоог хуулиар 50 хувь бууруулж өгсөн бол ухуулах байр болон штаб байрлах байрнуудын түрээсийн үнэ өндөр хэвээр байх бололтой. Энэ тохиолдолд ухуулах байрыг бодитоор байршуулах тоог цөөлж, онлайн орчинд бий болгох боломж, гарц хайх нь зүйтэй. Сонгуулийн сурталчилгааны материалыг нэр дэвшигчид сурталчилгааны эхэнд, дунд, төгсгөлд гэж багадаа гурван удаа тараадаг байна. Энэ тохиолдолд эхний буюу танилцуулга бүхий сэтгүүлийн зардлыг төрөөс санхүүжүүлж, бүх нэр дэвшигчдийг багтаасан байдлаар тойрогт нэг сэтгүүл болгон хэвлүүлж, тэдгээрийг хэсгийн ахлагчаар тараалгах боломж бий гэж харж байна. Ингэснээр хэвлэлтийн болон түгээлтийн зардал хэмнэгдэх боломжтой. Сонгуулийн сурталчилгаа бодит байдал дээр албан бусаар сонгуулийн өмнөх жилийнх нь намраас эхэлж байна. Тиймээс сонгуулийн бус үед сонгуулийн сурталчилгааг хэрхэн хянаж, түүнд зарцуулж буй мөнгөн дүнг хэрхэн тооцож болох вэ гэдэг нь тодорхойгүй хэвээр. Улмаар Улсын Их Хурлын гишүүний сонгуулийн хугацаанд хийсэн ажлаа тайлагнах хуулинд тусгасан үүрэгт ажил нь тэдний хувьд сурталчилгааны давуу талыг бий болгож байгааг ч судлан тооцох шаардлагатай байна.

Abstract:

Within the frame of this article, the authors aimed to clarify the relationship between the financial reports, financing structure, and cost comparison of the candidates in Ulaanbaatar by analyzing the financial reports of the candidates for the 2020 election of the State Great Khural issued by the National Audit Office. Additionally, the study involves analyzing the reports of candidates from the Mongolian People's Party (MPP), Democratic Party (DP), and National Labor Party (NLP) currently serving in Mongolian Parliament. The comparison includes examining public and local funds, elucidating spending differences and characteristics, and clarifying the impact of changes in election laws on candidate costs.

Keywords: Parliamentary Election, election expenses, candidates' financial report, equality, equal opportunity, the right to be elected

¹⁷ <https://www.zindaa.mn/4kio>

¹⁸ (<https://www.mongolbank.mn/file/files/documents/statistic/inflationtuluv/202004.pdf>).

Ашигласан ном, материал

1. Б.Эрдэнэдалай. Улс төрийн санхүүжилт: Олон улсын туршлага ба монгол дахь тулгамдсан асуудал. Улаанбаатар 2023. “Мөнхийн үсэг” ХХК-д хэвлэв.
2. Сонгуулийн ерөнхий хороо. Улсын Их Хурлын сонгууль 1992-2020. “Адмон принт” хэвлэх үйлдвэрт хэвлэв.
3. Нээлттэй нийгэм форум. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг
4. Үндэсний аудитын газар. Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан.
5. Э.Гэрэлт-Од, Д.Бямбажав “Сонгуулийн зардлыг бууруулж шударга өрсөлдөөнийг дэмжих нь”, 2020
6. John Shattuck, Mathias Risse. Money In Politics. 2020
7. Азийн сан. Монгол Улсын сонгууль 1992-202. https://asiafoundation.org/wp-content/uploads/2023/04/Mongolia_МОНГОЛ-УЛСЫН-СОНГУУЛЬ_Elections-in-Mongolia.pdf
8. Олон Улсын сонгуулийг ажиглах хороо. Монгол Улс- Парламентын сонгууль. 2016. <https://www.osce.org/files/f/documents/a/9/249581.pdf>
9. Улсын Их Хурал. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүллээ. 2023. <https://www.parliament.mn/nn/29835/>
10. Зөрчлийн тухай хууль
11. Улсын Их хурлын Сонгуулийн тухай хууль
12. Ш.Адъяамаа. Байр суурь: Томсгосон мажоритар тогтолцооны давуу болон сул тал

АРДЧИЛЛЫГ ЗАЛРУУЛАХУЙ

С.Базарпүрэв

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор

О.Мөнхжаргал

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн багш

Хураангуй:

Ардчиллыг засаглалын жам ёсны хэлбэр хэмээн өргөмжилдөг ч хичээл зүтгэл гаргалгүй жамаараа бий болчихдог тогтолцоо биш юм. Ардчилал бол ард түмний засаглал гэх тогтсон ойлголтоос эхлээд хэвшин тогтсон олон зүйлс түүхэн болон бодит үнэнтэй нийцдэггүй. Ардчилал бол анхнаасаа эдийн засгийн нөөц болон улс төрийн эрх бүхий харьцангуй цөөнхийн засаглал байв. Тэр үедээ хөгжин цэцэглэж байсан ардчилал эрх мэдлийн төлөөх демагогуудын өрсөлдөөнөөр нийгмийн олонхын үндэслэл муутай хүсэл сонирхолд хөтлөгдсөн охлократ засаглал болон хувирснаар мөхсөн түүхтэй. Засаглах эрх мэдлийг эрхшээх хүсэлтэй улс төрийн элитүүд ардчиллыг хөхиүлэн дэмжиж, олон түмнийг итгүүлэх замаар өөрсдийн засаглах боломжийг баталгаажуулсан янз бүрийн хэм хэмжээ, дүрэм журмуудыг ардчилалд шингээсэн. Орчин үед ардчиллын нэр хүндийг унагаж буй олон зүйл эдгээр зохиомол зүйлсээс үүдэлтэйн хувьд тэдгээрийг түүхэн болон учир зүйн үүднээс дахин шинжлэн засаж залруулах цэгийг олж илрүүлэх шаардлагатай юм.

Түлхүүр үгс: ардчилал, демос, демагог, олигарх, элит

Байгальд байдаг хүчтэй нь илүүрхэх дүрэм нийгмийн амьдралд үйлчлэх хэрээр ардчилсан засаглал гэгч нь аяндаа хэрэгждэг жам ёсны хэлбэр биш болох нь тодорно. Энэ байдал нь хүнд оногдуулсан хязгаарлалтын хэмжээгээрээ ялгарах төрөл бүрийн нийгэм-төрийн байгууламжаар хэлбэрждэг. Эсэргүүцэл үзүүлэх чадваргүй олонхыг дарангуйлсан теократ, тиран-дарангуйлагч, монарх-хаант засаглал, импер-эзэнт гүрэн, тоталитаризм, олигарх зэрэг дэглэмийн олон төрлүүд нийгмийн түүхэнд бодитоор оршин байсан.

Байгалийн хууль, нийгмийн жам ёсны бодит байдалд “эргэлт” хийж хүмүүсийн амьдралыг соёлт хэлбэрээр зохион байгуулах гэсэн ардчилсан арга нь ямагт тодорхой эсэргүүцэл, бэрхшээлтэй нүүр тулж байдаг. Ардчилсан хэм хэмжээ орон зайгаа эзэлж, эрэлт хэрэгцээтэй удирдлагын хэлбэр гэдгээ батлахын тулд ихээхэн хүч чармайлт гаргаж байна.

1970-2010 оны хоорондох 40 жилийн хугацаанд тоталитар, авторитар дэглэмээс залхсан олон түмний хүсэл эрмэлзэл амжилт олж дэлхий даяар ардчилсан дэглэм олноор бий болсон. XX зууны эцсээр тусгаар улсуудын 60 хувь нь сонгуулийн ардчилалтай болсон бол XXI зууны эхэнд либерал ардчилал засаглалын хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэр болов (Фукуяма, 2014). Ардчилах үйл явцын амжилт нь ардчилсан хэм хэмжээ, үнэт зүйлстэй, эрх эрх чөлөөтэй, хангалуун амьдралтай нийгэмлэг үүсэн бүрэлдэхэд нөлөөлсөн. Мэдээллээр хангагдсан чөлөөт иргэдээс бүрдсэн нийгэм төлөвшиж байгаа нь ардчилал бэхжихэд үлэмж хувь нэмэртэй ч эдийн засаг, нийгэм, соёлын ялгаа ихэссэн нь ардчилсан дэглэмийн үйл ажиллагаанд шинэ саад бэрхшээлүүдийг учруулж байна. Ардчилсан засаглалын үндсэн нөхцөл нь иргэд өөрсдөө амьдралаа аваад явчих нөхцөлийг бүрдүүлж, эрх ашигтаа үйлчилдэг засаглалыг сонгон үйл ажиллагаанд нь хяналт тавих нөхцөлийг хангах явдал юм (Даль, 2004).

Ардчилж буй дэглэмүүдийн хөгжлийн хэтийн төлөв хүндрэлтэй нөхцөл байдалд байна. Дэвшилт үзэл, рационал институтчилэл, улс төрийн элитийн төлөвшил эхлэл шатандаа яваа, ардчиллын үнэт зүйлс, засаглалд оролцох хэрэгцээ иргэдийн ухамсарт гүйцэд суугаагүй, өмнөх нийгмийн улс төрийн соёл хадгалагдсаар байна. Тиймээс ардчилал засаглагчийн алдаа, хүмүүсийн өмнө тулгамдаад байгаа асуудлыг үр өгөөжтэй шийдвэрлэх чадваргүй улс төрийн систем хэмээн иргэд сөргөөр хүлээж авдаг.

Хэрэв хүмүүс үгийн утга дээр ойлголцож чадвал маргалдах зүйл үгүй болно хэмээн Рене Декарт (1619) тэмдэглэсэн байдаг. Бид олон зүйлийг зөрүү ойлгодог. Хойд Солонгос, БНХАУ-д улс төрийн ганц нам байдаг гэж, АНУ-ын ерөнхийлөгч бүх нийтийн саналаар сонгогддог гэж, Израиль, Балтын тэнгисийн орнуудад бүх нийтийн сонгуулийн эрх хангагдсан гэж, Канад, Австрали улсын тусгаар тогтнол эргэлзээгүй гэж бодон бодит байдлыг анхаарч, анзааралгүй орхидог. Үүнтэй нэгэн адил ардчиллын мөн чанарыг эндүүрэн ойлгох хандлага түгээмэл байна.

Эргэцүүлэн тунгааж үзвэл ардчиллын нэр хүндийг унагаж буй зүйлс голдуу түүний анхны шинжээс гажиж хожим зохиомлоор бий болгосон зүйлстэй холбогдоно. Тэдгээр нь улс төрийн эрх мэдэлтэйн өөртөө ашиг хонжоо олох зорилготой, нийгэмд тулган хүлээлгэсэн үзэл суртал болон хувирсан.

Түүхэн утгыг тодруулахуй

Эртний грекийн "демократ" гэдгийг "ард түмний засаглал" хэмээн зохисгүй ойлгоод удаж байна. Тухайн үеийн грекүүд ард түмнийг "этнос" (орчин цагийн "үндэстэн" гэх ойлголттой ойролцоо), хүн амыг "попүлүс" хэмээн тэмдэглэж байсан бол "демос" гэдэгт зөвхөн улс төрийн эрх бүхий чөлөөт хүмүүсийг багтааж байв. Афины хүн амын ердөө 10-15 хувь нь л демос-т багтаж байснаас (Даль, 2004) үзвэл "демократ" нь ард түмний бус эрх бүхий цөөнхийн засаглал байв. Микений эрин үед хааны ордонд татвар төлдөг тосгоныг дема гэдэг байсан ба тэргүүнээ санал хурааж сонгодог, өөрийгөө мэдэж удирддаг нийгэмлэг буюу өөртөө удирдах ёс анх тэнд бүрэлджээ. Харин томоохон полис үүссэнээр язгуур угсааны ялгаа гарч энгийн ард сонгох, сонгогдох боломжгүй нөхцөл үүссэнээр ардчилал зүсээ хувиргаж эхэлсэн байдаг.

МЭӨ 490 оны үед Эртний Ромд эзлэн авсан нутгуудаас шилжиж суурьшсан нийтийн газар эзэмших эрхгүй, улс төрийн эрх эдэлдэггүй "плебс" буюу жирийн ард гэсэн тодотголтой хүмүүс (хожим патрицаас бусдыг нь тэгж нэрлэж байв) хүн амын чухал бүрэлдэхүүн болж, улмаар тууштай тэмцсэний эцэст улс төрийн эрх эдлэх болсон.

Нийгэмд "кастын" систем бүрэлдэж засаглах эрх цөөн тооны хүний гарт орсон нь эрт үеэс улбаатай. Чухам плебчүүд патрицыг буулган авч, улс төрийн эрхээ эдлэх болсон шиг мэргэн арга ухааныг "нээх" нь ардчилал хэрэгжихэд чухал ач холбогдолтой ажээ.

Аристотель монарх, аристократ, полити гэсэн зохист дэглэмүүдийн зэрэгцээ хаант засаглалыг гажуудуулсан тиран, аристократ засаглалыг эвдсэн олигарх, политиг завхруулсан демократ "засаглал" гэж байдгийг анхааруулсан. Зохистой дэглэм ард түмэнд үйлчилдэг бол гажсан хэлбэр нь засаглагч этгээдүүдэд ашигтай байдаг гэжээ.

Демосууд нийгмийн тулгамдсан асуудлыг шүүн хэлэлцэж, шийдвэрийг шууд гарган хэрэгжүүлдэг байсан. Зарим үйл ажиллагаанд тэд ээлжлэн шодож эсхүл шавга гүйлгэн оролцдог байв. "Шавга орхих нь ардчилсан байгууламж, сонгууль хийж эхлүүлэх нь эсрэгээрээ олигарх юм" гэж Аристотель "Улс төр" гэсэн бүтээлдээ тэмдэглэсэн (Аристотель, 2006).

Периклийн үед цэцэглэж байсан афины ардчилал түүнийг залгамжилсан демагогуудын үед уруудан доройтсон. "Демагог" гэдэг нь нийтийн сайн сайхныг чухалчилсан рационал үг, үйлдлээс илүүтэй өөрсдийн эрх мэдэл, хувийн сонирхолдоо хөтлөгдөж олонхын сэтгэл хөдлөл, айдас, бардамнал, аминч үзлийг өдөөсөн худал мэдэгдэл, уран яриагаар удирддаг хүмүүсийг хэлдэг. Демагогуудын үйлдэл дайн тулаан, эмх замбараагүй байдал, харгис дарангуйлагч, олонхын дарангуйлал зэргийг бий

болгосноор Афины ардчилал мөхсөн түүхтэй. Тиймдээ ч анх "демосын удирдагч" гэх эерэг утгатай байсан "демагог" гэх үг өдгөө эсрэг утгатай болжээ.

Платон, Аристотель нар демократ засаглалыг демагогууд болон ард түмний ухамсаргүй, буруу шийдвэрээр ажилладаг охлосын засаглал хэмээн жигшиж байв. Түүнчлэн Иммануил Кант ардчиллыг "бүгдийн" шийдсэн зүйлтэй санал нэгдээгүй хэсгийг албадан дагуулдаг дарангуйлал (Kant, 1983) хэмээсэн нь бий.

Ардчиллыг бүтэмж муутай хэмээн үзэх хандлага нэн эртнээс байсан ба үр өгөөжтэй эсэх нь олон хүчин зүйлээс хамаардаг.

Нийгэм бүлгүүдэд хуваагдан, үзэл баримтлал ялгаатай болж, хоорондоо өрсөлдөж, нарийн ээдрээтэй эсрэг тэсрэг бодолтой, ижил төрлийн бус бүтэцтэй хүмүүсээс бүрдсэн ч шаардлагатай үед нэгдэж нийлдэг. Үүнийг эв зүйгээр зохицуулах механизмын хэрэгцээ шаардлага ямагт урган гардаг. Аль нэг бүлэглэл бусад бүлэгтэй тэмцэлдэн засгийн эрхийг авч өөрийн үзэл суртал, байр сууриа тулгахдаа түүнийгээ "ард түмний" санаа бодол гэж томьёолдог. 51 хувийн санал авсан бүлэглэл засгийн эрхийг авч "олонхын ардчилал" давамгайлсан хувилбар тогтдог ч 51, 49-н алинд нь хэр олон сайн, муу хүмүүс хамаарч байгаа бол гэсэн асуултыг араасаа дагуулдаг.

Ардчилал дахь цөөнхийн ноёрхол

Засаглах эрхтэйгээ үндэслэх шаардлага бүх л цаг хугацаанд улс төрийн элитийн өмнө тулгарч байсан. Засаглалын асуудал яригдах эхэн үед тэд "шилдэг нь улс орныг удирдах эрхтэй" гэсэн улс төрийн номлол, уриа дэвшүүлсэн. Улмаар шилдгээ тодруулахдаа "сонгогдсон нь удирдах эрхтэй" болсон. Ийнхүү нийгэм улс төрийн тавцанд ардчиллын хэрэгцээ шаардлага элитүүдийн эрх мэдэлд хүрэх, түүнийгээ хадгалах сонирхлоор хөшүүрэгдэн улам идэвхэжсэн.

Энэ явцад жирийн ард олныг хэрсүү ухаантай, мэдрэмжтэй, чадвартай тул засаглагчид тавих шаардлагыг бүрэн хангасан зохистой хүнээ сонгож чадна гэсэн итгэл үнэмшлийг тасралтгүй бадрааж байдаг. Хаалттай кастын системд элит сонгогдох эрхээ хуваарийн дагуу ээлжлэн хүртдэг байсан нь өнөөгийн сонгох, сонгогдох эрхээр бүрэн, тэгш хангагдаж, үндсэн хуулиар хүртэл баталгаажуулсан нийгэмд ч хадгалагдсан хэвээр байна. Материаллаг (мөнгө, санхүүгийн дэмжлэг) болон бусад нөөцөөр давуу нь сонгуульд нэрээ дэвшүүлж, ялалт байгуулах боломжтой болохоос энгийн иргэнд угтаа тэрхүү боломж хаалттай хэвээр байна.

Түүнчлэн орчин үеийн сонгууль нь пиаршикудын дэглэсэн жүжгийн зохиолын уралдаан болж ялалт байгуулах нь үнэмшилтэй тархи угаах чадвараас ихээхэн хамаарах болов. Эдийн засаг, нийгэм улс төрийн нөхцөлийн бодит байдлыг мэдэхгүй олон түмэн сонголт хийхэд нэн бэрх юм. Тэд бэртэгчин улс төрийн хүчний үйлдлүүд, тулгамдаж буй асуудлыг тэр болгон мэдэхгүй, намуудын дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг үнэлэх дүгнэх чадвар хомс байдаг. Улс төрийн мэтгэлцээн хийдэггүй, хийсэн ч мэхлэх гэсэн болхи арга хэрэглэсэн шоутай сонгогч нүүр тулдаг.

Улс төр хийх, түүнд оролцох нь аль ч төвшинд өртөг өндөртэй ажил тул хүн амын хөрөнгөтэй хэсэг л уг ажилд түлхүү оролцдог. Эртний Грект чөлөөт иргэд нь бараг бүгд боол эзэмшигч байсны хувьд ахуйн бэрхшээлд түүртэлгүй хэдэн өдрөөр чуулганд оролцох боломжтой байсан. Эртний Ромын болон хожмын Италийн хотууд дахь Бүгд найрамдах засаглал ч мөн адил газар голдуу хөрөнгө эзэмшигч хязгаарлагдмал хүрээнийхэн л оролцдог засаглал байв (Даль, 2004). Улс төрийн өндөр өртгийг төлөн засгийн эрхэнд гарч нийгмийн нөөцийг хуваарилах эрх мэдэлтэй болсон улс төрийн элит жирийн ардаар хэрхэн засаглахаа заалгаж, тэдэнд хянуулж ажиллахаас илүүтэй өөрийн байр сууриа хадгалж, ашиг хонжоондоо хөтлөгддөг аж. Улс төрийн элитүүд өнөөгийн байр сууриа эцэг эх, ивээгчээсээ (патрон) өвлөн авсан нь түгээмэл бөгөөд дээш гарах гэж ядарч зоволгүйгээр тэнд төрж, бойжсон байдаг. Бохир, жигшүүртэй ажлын дийлэнхийг тэдний дээд үеийнхэн өмнөөс нь хийсэн байх нь ч бий. Тэдний элитар зан суртахуун, онцлог соёл, үйл байдал, хэл яриа нь нийгмийн бусад хүмүүстэй ижилсэх бараг боломжгүйгээр бүрэлдэн тогтсон, өөр ертөнцийн хүмүүс байх нь элбэг.

Олон түмэн элит клубт байнга сөргөж байдаг ч тэд эрх мэдлээс хагацахыг хүсдэггүй. Төрийг эрхшээх, нийгмийн дэг журмыг дэглэх удирдлагын аливаа систем олигарх элитар загвартай. Тиймдээ ч тэд ард түмний "зарц" гэхээсээ илүүтэй ард түмнийг өөрсдийн зорилгодоо бүрэн дүүрэн ашиглахыг боддог. Өнөө үед олигарх цөөнх ардчиллыг дэвшилтэд, тун сайн систем хэмээн магтаж "шууд", "төлөөллийн", "зөвшилцлийн" зэргээр өргөжүүлэхийн зэрэгцээ өөрийн сонгогдох, санасандаа хүрэх боломжуудыг бататган шигтгэж байдаг. Олонх ч түүнд итгэх шинжтэй.

Ардчиллын өлгий гэгдэх улсад сонгогчид нь ерөнхийлөгчөө шууд сонгож чадахгүй төлөөлөгч сонгогчоор дамжуулан сонгох эрхээ эдэлдэг. "Буруу" хүнээ сонгогчхож магадгүй хэмээсэн болгоомжлол уу? Сонгогчид саналаа дэвшүүлсэн төдий, харин тэдгээр төлөөний нөхөд түүнийг нь сонгож ч болдог сонгохгүй ч байж болдог аж. Ийм тохиолдол тухайн улсын түүхэнд нэг бус удаа гарч байсан. Тийм бол энгийн иргэдийн санал, сонголт хийх нь дэмий цаг үрсэн, хий хоосон гэлтэй ажил болж байгаа бус уу. Түүнчлэн улс гүрний сонгуулийн хороо, ялангуяа орон нутгийн хороод "эзэндээ" ээлтэй санал тооллого хийдэг нь нууц биш болоод удаж байна.

"Ард түмний засаглал" гэсэн тунхаглал чихэнд чимэгтэй сайхан сонсогддог ч уг үзэл нэлээдгүй хоосон чанартайг анзаардаггүй хүмүүс түүнд итгэж, ардчиллын зарчимд нийцэн сонгуульд оролцож байгаагаа улс орныг удирдаж байгаатай андуурдаг. Улс орныг удирдахад тусгай эрдэм боловсролтой хүчин хэрэгтэй төдийгүй нийтлэг сайн сайхныг хангахад эрмэлздэг байх шаардлагатай. Ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд дээрх шалгуур хангаагүй нөхөд засаг барилцах жам ёсны эрхтэй хэмээн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдэх нь афины ардчиллыг мөхөөсөн демагогуудын үйлдлийг санагдуулам гамшигт уршиг дагуулах болов. Тухайн дэмийрэл өнөөдөр улс төрийн үзэл санааны том ололт гэгдээд байгаа юм.

Нийгмийн хөгжлийн хувилбарыг ард түмэн тодорхойлж шийддэг хэмээн хөөрөгдөхийн ард олигархын засаглал байх нь элбэг. Олигархууд элдэв янзын эрх, эрх чөлөөний үзэл баримтлал номлон, нийгмийн зөрчил мөргөлдөөн дээр дөрөөлөн улс орны хэтийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх нэрээр тодорхой бүлэг баячуудын хөрөнгийг арвижуулж байдаг. Тэд өөрийн эрх ашигт тохирсон нэг нэр дэвшигчийг сонгон түүний сонгуулийн компанит ажлын хөлсийг төлж, ямар нэгэн асуудлыг шийдвэрлэнэ гэсэн гэнэн итгэл сонгогчдод төрүүлдэг. Итгэл үнэмшил, хүлээлт нь хөсөрдсөн сонгогчид сонголтдоо урам хугарч бухимдлаа гаргахдаа дараагийн санхүүгийн чинээлэг далд бүлэглэлийн төлөөлөлд найдах тавилантай үлддэг. Ийм замаар ардчилсан засгийн эрх баригчид өмч баялаг эзэмшигч олигархуудын гарт орж түүний гаргасан шийдвэрийг даган гүйцэтгэгч болж хувирдаг. Парламентад мэргэжлийн бус хүмүүс суурьшиж, эзнийхээ дохиураар товчлуур дарж дүр эсгэхээс өөрөөр үнэндээ юу ч шийддэггүйг нийгэм гадарлах болсон.

Ардчиллыг дэмжигчид хүн өөрийнхөө хувь заяаны эзэн байх учиртай гэсэн итгэл үнэмшилд захирагддаг. Гэтэл мэдлэггүй, мэргэжлийн бус нөхдийн гаргасан шийдвэр хууль болж бусдын хувь заяаг жолооддогт хамаг учир байна. Охлосууд болон демагогуудын дунд нийгэм бүхэлдээ хохирдог. Олонхын санаа бодол гэсэн тунхаглалаар эрүүл саруул бодолтой цөөнгүй хүнийг хохироох үйл явц өнөөдөр явагдаж байна. Олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг нэрийн доор хүмүүсийн сонирхдоггүй, мэддэггүй, мэдэх албагүй асуудлаар санаа бодлыг нь сонссон нэртэй өөрсдийн санаархлыг халхавчлан гүйцэлдүүлэх хуурмаг зүйл ч олшров. Засаглагч олигарх олон нийтийг аргалахын тулд боловсрол, мэдлэг нимгэн байлгах, бие хүнийг доройтуулах "соёлыг" түгээх сүлжээг бий болгож, эдгээрийн тусламжтайгаар өөрт заналхийлсэн улс төрчид, засгийн газрын нөхдийг намнах хэрэгсэл бүтээсэн.

Эгэл хүмүүс улс төрийн философи яриад суух зав, боломж байдаггүй. Мөнгө олж, гэр бүлээ тэжээх нүсэр хүнд ажилд нухлагддаг. Тэгэхээр "ардчилсан зарчим" нь демагогуудын байнгын нөлөөнд автсан олон түмний ааш авирт тулгуурлан охлократ хэлбэрээр хэрэгжих болдог. Элитүүд олон түмний мэдэлд орж барьцаалагдах сонирхолгүй

тул эсрэгээр олон нийтийн санал бодролыг хянаж, удирдан чиглүүлэх аргачлалыг боловсруулан ашиглахад хөрөнгө хүчээ зардаг. Үүний үр дүнд ард түмний хүсэл сонирхлыг тэд хэлбэржүүлэн тодорхойлж, улмаар ард түмний нэрийг барин өөрсдийн сонирхлоо гүйцэлдүүлэх боломжтой болдог.

Эргэцүүлэх чадвартай хэн ч ардчиллын ард худал хуурмаг зүйлс олон “шигдсэнийг” мэдэх болсон. Гэлээ ч энэхүү эргэлзээг саармагжуулах хүчирхэг хөтөлбөрүүд, сүрдэм дуу хоолойг тасралтгүй ажиллуулж байдаг. Ийм хуурамч ардчиллын цаана олигархуудын тогтоосон тоталитар дэглэм нуугддаг ба ард иргэдийг хүлцэнгүй, дуулгавартай, тэвчээртэй байлгаснаар тэдний ноёлох байр суурь хадгалагдаж байдаг.

Тоглоомын дүрмийг бүтээгч элит сонгуульд ялалт байгуулахад дөхөм байдаг. Ингэхдээ тэд өрсөлдөгч хүчний оюуны чадварыг хомсдолд оруулах, ард олноос бодит мэдээллийг нуун дарагдуулах, төөрөлдүүлэх, тэднийг өөрт ашигтайгаар "гэгээрүүлэх" зэрэг үйлдэл гаргах нь түгээмэл байдаг.

Түүнчлэн засаглагч элитийн хэрэгжүүлдэг нэг ажиллагаа нь иргэдийг нийгмийн хэлтэрхийд хувааж, захиран удирдахад чиглэдэг. Хоорондоо хүч үзэн тэмцэлдээд байдаггүй ч тэдний дунд тулга тойрсон явган хэрүүл маргаан тасардаггүй. Тэдний иймэрхүү үр ашиггүй, утга учиргүй тэмцэл, хуурмаг ялалтыг эрх баригч өөрийн санхүүжүүлж, хянадаг мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлан дэвэргэдэг.

Улс төрийн эрх баригч түүний намд удаа дараа хууртан, хохирсон иргэд сонгуульд эсрэг хүчинд нь саналаа өгч түүнтэй хариуцлага тооцох ганц аргатай. Гэтэл тэрхүү эсрэг хүчин нь эрх баригчтай тохиролцоонд хүрсэн бол сөрөг хүчин болж чадах уу.

Хараат бус, бие даагч нэр дэвшигчдэд итгэл үнэмшил үзүүлэхэд бэрх байдаг. Тэд сонгуулийн ажиллагааны нэг хэсэг болж, жүжгийг сонирхолтой болгон, ардчиллыг амьд байгааг итгүүлэх боломж олгох нь бий. Бие даагчид өөрийнхөө төлөө ажиллаж байгаа мэт боловч эрх баригч улс төрийн хүчийг шүүмжилж, эсэргүүцлээ илэрхийлсэн сонгуулийн саналыг "хулгайлж", засаглагч намын олигарх бүлгийн эрх ашиг сонирхолд үйлчилж, шан харамжаар тэдний төлөө бохир үйлдэл хийх нь түгээмэл.

Зөвхөн манайд ийм журамгүй улс төр, шударга бус улс төрийн сонгууль хийгддэг, бусад улс оронд ардчилал жинхэнэ утгаар хэрэгждэг гэвэл худал. Мэхлэх хэмжээ, хязгаар, улс төрийн технологийн боловсруулалт нь өөр гэхээс үндсэндээ адил юм.

Улс төрийн сайн зохиолоос улс төрийн сайн жүжиг бүтдэг. Олон зууныг дамжин АНУ, Англи зэрэг орнуудад хоорондоо өрсөлдөж буй мэт хоёр намын систем тогтож ирсэн. Эдгээр намуудаас гадна улс төрийн олон нам байдаг. Онолын хувьд тэдгээр намуудаас алин ч засгийн эрх авч болох ч тухайн улсын түүхэнд тийм тохиолдол гараагүй. Дээрх хоёр нам улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн уур амьсгалыг тодорхойлогч улс төрийн эрх баригч олигарх бүлгийн арга ухаанаар бүтээгдсэн. Хоёр намын системийг хуульчлан тогтоох нь эрх мэдлээ алдахгүй байх найдвартай баталгаа болдог.

Улс төрд ард түмнийг оролцох боломжоор хангадаг гэж үздэг ардчилсан "систем" анхнаасаа эрх баригч чинээлэг давхаргаар зохиогдсон ба ард түмний тусад бус элит олигархийн эрх ашигт нийцүүлэн бүтээгдсэнийг дээр дурдсан.

Олон жарныг дамжин засгийн эрхийг эзэгнэхийн төлөө отог, омог, кланы хооронд цус урсгасан ширүүн тэмцэл өрнөж ирсэн, өнөөдөр ч эл дайн үргэлжилсэн хэвээр байна. Засаглагчийн сэнтийд суух сонирхолтой, баялагтай, өрсөлдөх чадвартай хүчний тоо нэмэгдсэн тул тэд засгийн эрхэнд гарах шинэ систем зохиосноо "демократ" хэмээн нэрийдсэн. Өмнөх харгис аргаа засварлаж, хэрцгий хэрэгслээ өөрчлөн засгийн эрхэнд гарах хуучин хэлбэрээ сонгууль нэртэй өөр нэг залиар солин ард олныг түүндээ татан оролцуулж хамтран засаг төрөө байгуулсан мэтээр нийгмийг хуурсан. Засагт гомдоцгоосон иргэдийг өөрсдөө сонгосон гэж тавлаад, дараагийн сонгуулиар зөв, сайн хүнээ сонго, тэр болтол илүү хэрсүүж хэмээн ам тагладаг.

Аристотель албан тушаалыг шүүн, хуваарилахын тулд иргэд нэгнийгээ мэддэг байх хэрэгтэй гэжээ. Охлос эгэл борчуул өөрийнхөн өгсөн саналаар сонгогддог гэсэн гэнэн бодол тээж явдаг. Үнэндээ сонгуульд “санал” өгдөг өөр хүчин зүйл бий. Юуны өмнө олон нийтийн

мэдээллийн хэрэгслээр дамжуулан сонгогчдын тархийг угаасан үзэл суртал, ухуулга мөн хуурамч өгөгдөл, бодит байдлыг дарагдуулсан байдал сонголтод нь нөлөөлсөн байдаг.

Ардчилал хуурах арга хэрэгсэл болдог гэдгийг батлах нэг жишээ нь сул хөгжилтэй орнуудад демократ үйлдлийн систем заримдаа айхтар гацдаг. Түүнээс гарах дотоод нөөц бололцоо байхгүй эсхүл хүрэлцэхгүй тохиолдолд гаднаас дэмжлэг хүсдэг. Ялангуяа бусдын хэрэгт хошуугаа дүрэн ашиг хонжоо олоод амташсан хүчирхэг гүрэн "тусламжийн" гараа харамгүй сунгадаг.

Демократ удирдлагыг арчаагүйд тооцохтой хамт бусад хэлбэрийг түүнээс ч доор гэсэн яриа байдаг. Харин улс төрийн эрх баригчид түүнийг сайн хэмээн үздэг нь тэдний эрх ашигт бүрэн нийцсэн байдагтай холбоотой юм. Тэгэхээр демократ гэдэг цөөнх олонхоо захирах гэсэн эрт үед байсан анхдагч санаагаа огт алдаагүй байна. Засаглал ерөнхийдөө олигарх, тоталитар диктатурт шинжтэй байдаг. Сонгодог диктатур ил тод, ойлгомжтой байдаг бол ардчиллыг хэлбэрдэх үед эрх баригчид муу чанар, далд санаагаа нууцалж нийгэмд илүү хортой хэм хэмжээ, дэглэм болгодог.

Ардчиллын талаар нэг иймэрхүү төсөөлөл, бодит нөхцөл байдал өнөөдөр үүсэн үүнийг засаж, залруулах мөн нийт иргэдийн бодит сонирхолд тохирсон удирдлагын системийг олж тогтоох ажил судлаачдын өмнө тулгараад байна.

Ардчиллыг залруулах асуудал

Демократ үнэт зүйлс дээр тулгуурласан улс төрийн систем нь нийгмийн өмнө тулгамдаад байгаа асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх бололцоотойг тэмдэглэхийн зэрэгцээ ардчиллын боломжийг хэт үнэлэх нь тухайн системийн үнэт зүйлс, улс төрийн байгууламжийг басамжлан эгдүүцэх үр дагаварт хүргэж болзошгүй хортойг анхаарах хэрэгтэй.

Ардчилсан дэглэмийн талаарх төсөөлөл тун энгийн ойлгомжтой, урьдчилан мэдэх боломжтой байдаг. Нийгэм рүү хандан үзүүлэх улс төрийн бодлого нээлттэй, ил тод байдаг нь эдийн засаг, нийгэм ба соёлын хөгжилд зайлшгүй хэрэгтэй улс төрийн тогтвортой нөхцөлийг бүрдүүлдэг.

Ардчилсан институт төлөвшин хөгжих ач холбогдлыг чухалчлан, хүлээн зөвшөөрснөөр уг улс төрийн үзэгдлийг судлахад эрдэм шинжилгээний нийгэмлэг ихээхэн хүч чармайлт гаргаж байна.

Өнөөдөр ардчилал гэдэг нь хүмүүн төрөлхтний хүлээн зөвшөөрсөн цорын ганц загвар хэмээн ойлгож болохгүй юм. Ардчиллаас гадна олон нийтийн зүгээс дэмжлэг авсан улс төрийн систем байсан. Ардчиллын чанар, тогтвортой байдлыг ойлгомжтой, ийм л байх ёстой зүйл гэж үзэх нь алдаатай гэдгийг ардчиллын хөгжил дэвшлийн хувьсал гэрчилсэн.

Орчин үеийн нийгмийн эрэлт хэрэгцээг хангах чадвартай арга хэрэгслийг олж нээсэн цагт ардчилал нийгмийн амьдралыг зохион байгуулах хувьсах чанартай хэлбэр гэдгээ харуулж чадна. Ардчилсан систем өөрийг нь бүрдүүлдэг харилцан шүтэлцээтэй үндсэн элементээс бүтэж, өөрийгөө нөхөн үйлдвэрлэж байдаг харьцангуй хаалттай тогтолцоо бөгөөд өөрийн хил хязгаарыг тогтоож, бүтцээ зохион байгуулдаг.

Өнөө үед улс төрийн системд тавигдах шинэ шаардлага үүсэж түүнийг судлах, хариу барих асуудал судлаачдын өмнө тулгараад байна. Ардчилсан систем үүсэх нөхцөл хэрэгтэй, эсвэл шаардлагагүй гэсэн маргаан судлаачдын дунд байдаг. Өдий хүртэл ардчилсан үйл явцын нэгдсэн хууль бүтээгдээгүй нь эл процесс субьектив шинжтэй гэдгийг баталж байгаа гэлтэй.

Улс төрийн институт нарийн төвөгтэй бүтэцтэй орчин цагийн тасралтгүй өөрчлөгдөж буй нийгмийн нөхцөлд дасан зохицохын тулд бүтэц, үүргээ байнга боловсронгуй болгож, үргэлж хувьсаж байдаг билээ. Институтжих үйл явц ардчиллын дотоод мөн чанарын илрэл. Институт гэдгээр нь тодорхойлогдох явдал чухал ба ардчиллын суурь зарчим болдог онцлогтой.

Нийгмийн эрх ашигт нийцсэн хариуцлагатай улс төрийн бодлого явуулах зорилготой засаглалын институтэд шийдвэрлэх нөлөө үзүүлэх иргэнийг төлөвшүүлэх

ардчилсан институт бол улс төрийн оролцоо юм. Энэ институтийн улс төрийн олон ишт үзэл, эрх зүйт төр улсын тогтолцоо зэрэг нь тухайн институтийн үр ашигтай үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөхцөл болно. Иргэдийн зүгээс гүн гүнзгий, өргөн суурьтай дэмжлэг үзүүлэхээс ардчиллын тогтвортой байдал шууд хамааралтай гэдэгтэй дийлэнх судлаачид санал нэгтэй байдаг. Олонхын зүгээс хүлээн авахгүй байгаа тохиолдолд ардчилал амьгүй л гэсэн үг.

Удаан хугацаанд олон түмний итгэл үнэмшлийг олж чадахгүй тохиолдолд ардчилсан улс төрийн дэглэм дэмжсэн цөөн тооны хүмүүсээ алдах аюултай төдийгүй мөн оршин тогтнох нөхцөлгүй болох талтай. Хүн амын өргөн хэсгийн сонирхлыг илэрхийлж байж л улс төрийн дэглэм ардчилсан гэж нэрлэгдэх учиртай. Улс төрийн элит эрх дархтай цөөнхийн бус нийгмийн олонхын эрх ашигт нийцүүлэн нийгмийг удирдах албатай. Энэ нь хүн бүрийг адил үнэлэхээс эхэлдэг. Тиймээс баян чинээлэг, авьяастай гэдгээс хамаарахгүй бүх иргэдэд амьдрах соёлтой нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө бодлого боловсруулж, улс төрийн шийдвэр гаргах хэрэгтэй.

Иргэний нийгэм нь ардчилал оршин байх таатай орчин. Идэвхтэй, санаачилгатай иргэн байгаа цагт ардчилал үр бүтээлтэй тогтнох баттай суурь болж чадна. Хөгжсөн иргэний нийгэм нь нийгмийн улс төрийн болон иргэний идэвхийн эх сурвалж ч, үр дагавар ч болдог.

Иргэний нийгэм үүсэн бүрэлдэх үйл явц хувь хүн ба цөөнхийн эрхийг хүндэлсэн, улс төрийн хүлээцтэй байдал, нийгмийн хариуцлага зэрэг дээр суурилан тогтсон ардчилсан уламжлал, соёлыг төлөвшүүлэх асуудалтай илүү холбогдох ажээ. Иргэний нийгмийг хаа нэг газраас "зээлж" авчрах бус үндэстний уламжлал, соёлд тулгуурлан эдийн засаг, улс төр хөгжихийн зэрэгцээ, хүн амын амьжиргаа дээшилж, ард түмний ухамсар өссөнөөр бүтээгддэг байгууламж билээ.

Өнөөдөр орчин цагийн ардчиллын хөгжилд хүндрэл учруулах үйл явц шинэ өнгөөр тодрон гарч ирсээр байна. Даяарших процесс улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцон ардчилалд нөлөөлөх том аюул болсоор байна. Дайн, алан хядах ажиллагаа улс орон бүрд түгшүүр авчирч, этносын зөрчил мөргөлдөөн зэрэг нь ардчилсан институтэд дарамт шахалт үзүүлэх болсноор ардчиллаа хамгаалах шаардлага гарч байгаа.

Үүнээс гадна ардчиллын талаарх суурь ойлголтод өөрчлөлт гарах хандлага байгааг түүнд заналхийлж буй аюул гэж үзэх үү гэдэг асуудал үүсээд байна. Ардчиллын үнэт зүйлсийг үндсээр нь эргэн харах эсхүл түүний хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой либерал бүрдэл хэсгийг авч хаях гэсэн зүйл яригдах болов.

Улс төрийн салбарыг ардчилахаас гадна эдийн засаг, нийгэм, соёл зэрэг нийгмийн бусад салбарт ардчилах үйл явц өрнөж байж ардчиллын ирээдүй гэрэл гэгээтэй болох учиртайг судлаачид анхааруулж байна.

Нийгмийн дотоод асуудлыг шийдвэрлэх нь ардчиллын эрхэм зорилго гэдгийг өдөр тутам сануулж, сурталчлах хэрэгцээ байна. Засаглагчийн эрх мэдлийг хязгаарлан улс төрийн үйл явцад идэвхтэй оролцох боломжийг иргэн хүнд хангасан, үнэт зүйлс дээр суурилсан ардчилсан удирдлагын хэлбэр, улс төрийн дэглэм хэрэгтэйг тунхаглах нь ардчилсан үзэл санаа иргэдийн ухамсарт сууж төлөвшин иргэний нийгэм бий болоход нэмэртэй.

Ардчилсан систем хувьсан хөгжих нь тасралтгүй явагдах үйл явц байх учиртай. Ардчиллыг хөгжиж буй динамик үзэгдэл гэж ойлгох хэрэгтэй. Ардчиллын үнэт зүйл төлөвшөөгүй байсан ч түүний институтийн ач холбогдлыг номлож байх хэрэгтэй. Ардчиллыг бүтээж чанаржуулах нь нийгэмд тустай зүйл авчирдаг. Улс төрийн өрсөлдөөн шударга, нээлттэй болдог, улс төрийн процесст нийгэм бүрэн дүүрэн татагдан ордог, хүмүүсийн мэдлэг боловсрол боломж чадвар нэмэгддэг, сонгогдсон томилогдсон засаглагч илүү хариуцлагатай ажиллаж, тайлагнадаг болдог, иргэдийн эрх, эрх чөлөө хамгаалагдах төвшин нэмэгддэг, хууль тэргүүлэх хүчин болж, үр өгөөж нь дээшилж ард иргэдэд найдвартай түшиг тулгуур болдог зэргийг бодолцон нийгэмд ардчиллыг дэмжих хувийг нэмэгдүүлж, давуу талыг бий болгож чадвал үр ашгаа өгөх болно.

Abstract:

Democracy is often hailed as a natural form of government, yet it is not a system that arises effortlessly. Many stereotypes, beginning with the entrenched notion that democracy embodies the rule of the people, do not align with historical and factual realities. Initially, democracy represented the rule of a relative minority possessing economic resources and political power. Athenian democracy, which initially thrived, was ultimately destroyed when it devolved into an ochlocracy driven by the unreasonable interests of the masses, a transformation brought about by the power struggles among demagogues. Political elites seeking to control governance have actively promoted democracy, incorporating various norms and rules into it to ensure their continued authority by persuading the masses. Given that many modern criticisms of democracy stem from these distortions, it is necessary to reevaluate them historically and logically to identify areas for correction.

Key words: democracy, demos, demagogue, oligarch, elite

Ашигласан ном, материал

Kant, I. (1983). *Perpetual Peace and Other Essays*. Hackett Publishing Company, Inc.
Rene Descartes. (1619). *Rules for the Direction of the Mind*. Bobbs-Merrill.
Аристотель. (2006). *Улс төр*.
Даль, Р. (2004). *Ардчиллын тухай*. Эдмон.
Фукуяма, Ф. (2014). *Улс төрийн тогтолцооны сурвалж*. Нэпко.
Улс төрийн тогтолцооны сурвалж. Нэпко.

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ХЭТИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА ¹

О.Хатанболд

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА

Д.Уртнасан

МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн багш

Хураангуй:

Тус өгүүлэл нь монголчуудад шинэ улс төрийн үнэт зүйлс төлөвших үйл явцын нөлөөгөөр буй болсон өнөөгийн улс төрийн соёлын хэв маяг, цаашдаа энэхүү хэв маяг хэрхэн өөрчлөгдөх хандлагатай байгааг тодорхойлохоор зорьсон. Өгүүллийн эхний хэсэгт онол, аргазүй үндсийг тодруулж, шинэ улс төрийн үнэт зүйлс төлөвших үйл явцад он цагийн тайлбар хийж, монголчуудын улс төрийн соёлын хэв маягийн үнэлгээг хийсэн. Дараагийн хэсэгт ардчиллын бэхжилтэд иргэдийн оруулах хувь нэмэр, ардчилсан иргэнийг төлөвшүүлэх нийгэм, улс төрийн нөөц зэргийг тодруулсан хэлцэмж хийсэн.

Түлхүүр үгс: Улс төрийн соёл, ардчилсан шилжилт, ардчиллын бэхжилт, ардчиллыг тээгч институци

Удиртгал:

1980-аад оны сүүлээс өрнөсөн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр ардчилал, хүний эрх, эрх чөлөөнд тэмүүлэх хандлага залуучуудын дунд шинэ дэд соёл бүрдүүлэх гол хүчин зүйлс болсон. 1990 оны улс төрийн тогтолцооны өөрчлөлт нь улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн хэрэгцээ, чөлөөт байдал, ардчиллын практикт суралцах нөхцөлийг бүрдүүлсэн.

Улс төрийн хүрээний асуудал нь нийгмийн нийтлэг үнэт зүйл, эрх мэдэл, ашиг сонирхлыг хөндөж байдаг тул ямагт олон нийтийн анхаарлын төвд оршин байдаг. Нөгөө талаас нийгэм олон төрлийн ашиг сонирхлын нийтлэг болдог, нэг эрх ашгаар нөгөө эрх ашиг хязгаарлагдаж байгаа тул зөрчилтэй харилцааг бий болгох, улс төрийн итгэл буурах, төрийн бодлого, шийдвэрт сэтгэл ханамжгүй болох зэрэг нь засаглалын легитимт чанарыг бууруулах, тогтолцооны хямралд хүргэх зэрэг өргөн хүрээг хамарсан сөрөг нөлөөг үзүүлдэг. Сүүлийн үеийн олон судалгааны дүнд иргэдийн төр засагт итгэх итгэл буурах, улс төрийн зохист бус оролцоо нэмэгдэх, төрийн бодлого шийдвэрийг эсэргүүцэх, улс төрд сонирхолгүй болох зэрэг хандлагатай байна гэж дүгнэж байна. Удаан хугацаанд оршин тогтож буй дэглэмтэй харьцуулахад ардчиллыг шинээр тогтоосон улс орнууд илүү эмзэг байдаг учраас *итгэл буурах, үл итгэх байдал өсөх нь бүр ч их аюултай*. Хувь хүмүүсийн улс төрийн системээ үнэлэх үнэлэмж нь улс төрийн институтүүдэд итгэх итгэл, түүнээс үүдэн гарах улс төрийн үйл байдлаар илэрч байдаг.

Монгол оронд ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэхийн тулд түүнийг сайжруулах, алдааг засах, ардчилалд итгэдэг иргэд хэрэгтэй болж байгааг бидний хийсэн судалгааны дүн илэрхийлж байна.

Онол аргазүйн үндэслэл:

¹ Энэхүү өгүүлэл нь “Монгол Улсын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: институци, харилцаа, үйл явц” сэдэвт судалгааны төслийн хүрээнд хийгдсэн экспертийн тоон болон чанарын судалгаа, олон нийтийн санаа бодлын тоон судалгаанд үндэслэсэн. Монголчуудын улс төрийн уламжлал, соёл, үнэт зүйл, хэм хэмжээ гэсэн дэд сэдвийн зарим үр дүнгүүдэд хийсэн ерөнхий статистик шинжилгээнээс түүвэрлэн оруулсан болно.

Тус өгүүллийн онол, арга зүй нь Роберт А.Далийн боловсруулсан өрсөлдөөн, оролцоо гэсэн хоёр үндсэн хэмжигдэхүүнээр ардчиллыг хэмждэг полярхи ардчиллын онол үзэл санаад суурилна. Монгол орон ардчилсан тогтолцоонд шилжсэнээр улс төрийн аливаа үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр оролцох боломж нээгдэж, өрсөлдөх, сонгох, сонгогдох эрхтэй болсон нь улс төрийн соёлын төлөвшилд шууд нөлөөлсөн.

Ардчиллыг хэмжих, тодорхойлох, ялангуяа төлөөллийн ардчиллын судалгаанд Р.Далийн ардчиллын онолд тулгуурладаг. Учир нь Р.Даль “Иргэд өөрсдийн хүсэл сонирхлоо томъёолж, илэрхийлэх чадвартай байх, төрийн үйл ажиллагаанд тэрхүү давуу талуудыг ижил тэгш хуваарилах “институционал баталгаа” шаардлагатай” (Dahl 1971) байдаг гэж үзсэн. Эдгээр баталгаанд

1. институци байгуулах,
2. нэгдэх эрх чөлөө,
3. үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө,
4. сонгох эрх,
5. төрийн албан тушаалд томилогдох,
6. улс төрийн дэмжлэг авахын төлөө өрсөлдөх эрх,
7. мэдээллийн өөр эх сурвалж,
8. чөлөөт, шударга, хараат бус сонгууль

Ийнхүү иргэдийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх “институционал баталгаа” бүрдэх улс төрийн тогтолцооны суурь нөхцөл, түүнд иргэдийн зүгээс үзүүлж буй нөлөө, үйл байдлыг олон талаас нь судалснаар улс төрийн системийн тогтвортой байдлыг хангах, ардчиллыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Улс төрийн соёлын хэтийн төлөвийг тодорхойлох

Ардчилсан өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсад, монголчуудад шинэ улс төрийн үнэт зүйлс төлөвших, нөгөө талаар ардчиллын үнэт зүйлстэй танилцах нөхцөл бүрдсэн. Тухайлбал.

- *улс төрийн болон нийгмийн оролцоо нь* хүний амьдрал, сайн сайхан байдалд нөлөөлөгч болохыг ухамсарлаж үзэл бодлын илэрхийлэл нь улс төрд анхаарагдах учиртай зүйл гэдгийг илэрхийлсэн дуу хоолойг бусдад сонордуулахад ардчилал нь өөрөө инструментал ач холбогдолтой болсон.
- *ардчиллын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх*, ардчилсан монгол хүнийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн шинэчлэлийг эрэлхийлэгчид бий болсон.
- *үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нээгдэж хаалттай* байсан сэдвүүдээр чөлөөтэй ярьж, бас бичиж эхэлсэн нь нийгмийн оюун санаанд гарсан хувьсгалт-эргэлт бүхий мэдээллийн тэсрэлт гарснаар залуучуудын технологид тэмүүлсэн шинэ дэд соёлын эхлэл тавигдах үндэс болсон.
- *шинэ мэдлэгийн урсгалыг эрэлхийлсэн* бүтээл туурвилын эрх чөлөөний дэд соёл төлөвшиж эхэлсэн. Үүнээс үүдэлтэйгээр үндэсний үзэл санаа, ухамсар, соёл, уламжлалаа сэргээн мандуулахад чиглэгдсэн үндэсний ухамсрын сэргэлт, шинэ цагийн эх оронч хандлага өрнөсөн нь энэ төрлийн дэд соёлыг хурдацтай төлөвшихөд чухлаар нөлөөлсөн.
- *үзэл суртлын төөрөгдлөөс ангид байж* аливаад олон ургальч байдлаар хандах, улмаар нийгмийн өөрчлөлтийн гол эх сурвалж болох хөгжлийн шинэ замыг эрэлхийлсэн.
- *гуравдагч хөршийн бодлогыг эхлүүлсэн* гадаад харилцаагаа өрнөдийн соёл иргэншилтэй хөл нийлүүлэн алхахыг тэмүүлсэн.

1990
оноос:

Коммунист үзэл суртлыг тойрон нягтарч байсан социалист нийгмийн эрхэмлэх зүйлс, хэм хэмжээний ертөнц тулах тулгуур баганагүй болсон явдал нь коммунист үзэл суртал, оюун санааны амьдралыг нэгтгэн нягтруулагч хүч болох чухал үүргээ гүйцэтгэхээ больсон. Энэ нь 1990 оноос эхэлсэн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, зах зээл, чөлөөт өрсөлдөөн зэрэг ардчилсан, чөлөөт нийгмийн үнэт зүйлс нийгэмд улам бүр нэмэгдэж, улмаар төлөвших үйл явц эхэлсэнтэй шууд холбоотой.

2000
оноос:

Ардчиллын үзэл санааг хүлээн авч дэлгэрүүлэх, улмаар улс төрийн шинэ ардчилсан бүтцийг бий болгох замаар ардчиллын хөгжлийг түргэсгэхэд чиглэсэн эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчлах болсон. Учир нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоохын тулд иргэний нийгмийн зохистой төлөвшлийг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа иргэдийн улс төрийн боловсрол, соёлыг төлөвшүүлэх зэрэг цогц үйл ажиллагааг шат дараалалтай, зөв зарчим голдирлын дагуу хийж гүйцэтгэхийг «ардчилсан» шинэчлэгчид, ардчиллыг эрхэмлэх зүйлсээ болгосон шинэ мянганы залуусаас шаардах болсон.

2010
оноос:

Залуучуудын эрхэмлэдэг үнэт зүйлс, төлөв хандлагад дээр дурдсан нөлөөлөл илрэлээ олсон гэж болно. Тухайлбал, улс төрийн үзэл бодол, итгэл үнэмшил орчин үеийн залуу хүний ертөнцийг үзэх үзлийн чухал хэсэг болж (Жнь: амьдарч буй цаг үеийнхээ учир утгын талаарх ойлголт, нийгмийн байгуулал, түүний шинж чанар, ирээдүйн төлөвийн тухай бодол санаа, нийгэмд бодиттой үйлчилж) улмаар улс төрийн үзэл санаанд хандах хандлага, түүнд өгөх үнэлгээ, улс төрийн үйл ажиллагаандаа удирдлага болгож буй бодлого, концепцийн агуулгыг багтаах болсноор илрэх болов.

2020
оноос:


Тогтвортой хөгжлийг хангасан сайн засаглалыг бэхжүүлэхэд хүн бүрийн тэгш, шударга, хариуцлагатай бүтээлч оролцоог нэмэгдүүлэх, бас хөгжүүлэх замаар Ногоон хөгжлийн төлөөх энх тайванч, найрсаг хамтын ажиллагааг бий болгоно. Чингэхдээ *төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн бодит харилцааг хөхиүлэн дэмжих, зарчимд суурилсан хөгжлийн төлөөх түншлэлийг* бий болгох зорилготой шинэ соёлуудыг төлөвшүүлэх явдал нэн чухал гэдэг нь сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд хамарсан үйл явдал, тодорхой үзэгдлүүд харуулсаар байна. Эдгээр нь нийгмийн тэгш бус байдлыг арилгахад талуудын оролцоог хангасан оршин амьдрах тав тухтай, эрүүл аюулгүй, ногоон орчныг бүрдүүлсэн нийгмийн баялгийг бүтээхэд чиглэгддэг.

Улс төрийн соёлын хэтийн төлөвийг тодорхойлохоос өмнө улс төрийн соёлын өнөөгийн байдал, ямар төрлийн улс төрийн соёл давамгайлж буй болон улс төрийн соёлд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь юу болох талаар олон нийтийн санаа бодлын судалгаа, экспертийн анкет судалгаа болон ганцаарчилсан ярилцлагын судалгааны дүнгүүдээс нэгтэн тодруулъя.

1. Олон нийтийн санаа бодлын судалгаагаар монголчуудын улс төрийн соёлын төлөвшилд сэтгэл ханамж ямар байгааг болон өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн дүгнэж байгааг *1-ийн*


тоо «маш муу, сэтгэл хангалуун бус харин 10-ын тоо «маш сайн, сэтгэл хангалуун» гэж 10 хүртэлх шкалаар үнэлэхэд 22.8 хувь нь буюу хамгийн өндөр үнэлгээ тав байсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 69 хувь нь тав болон түүнээс бага үнэлгээ өгчээ.

Зураг 1. Соёлын төлөвшилийн үнэлгээ (ОНСБС)



Экспертийн анкет судалгаагаар монголчуудын улс төрийн соёлын төлөвшилд сэтгэл ханамж ямар байгааг болон өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн дүгнэж байгааг 1-ийн тоо «маш муу, сэтгэл хангалуун бус харин 7-ын тоо «маш сайн, сэтгэл хангалуун» гэж 7 хүртэлх шкалаар үнэлэхэд 43.5 хувь нь буюу хамгийн өндөр үнэлгээ гурав байсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 79.3 хувь нь гурав болон түүнээс бага үнэлгээ өгчээ.

Зураг 2. Соёлын төлөвшилийн үнэлгээ (Экспертийн анкет судалгаа)



Экспертийн ганцаарчилсан ярилцлагын судалгаагаар монголчуудын улс төрийн соёлын төлөвшилийг 7 баллаар үнэлүүлэхэд дундаас доогуур үнэлгээ өгсөн. Гэхдээ тэдний чухал тодруулга бол “массаар нь ингээд дундажлаад харах юм бол гурав байгаа болов уу гэж бодож байна. Харин хотод 3,5 хавьцаа байж магадгүй. Хөдөө орон нутагт арай бага үнэлэгдэх байх. Илүү мэдээлэлд ойрхон байгаа учраас, тэгэхдээ л бас л хэцүү зүйл нь жаахан хотын зах руу гараад ирэхээр бас өөр өөр ялгаатай” байгааг илэрхийлсэн.

Дээрх гурван судалгааны дүнгээс үзэхэд монголчуудын улс төрийн соёлын хөгжил дунджаас доогуур үнэлгээтэй байгаа бөгөөд түүний шалтгааныг экспертүүд дараах хүчин зүйлсээр тайлбарласан.

- Ардчилсан улс төрийн соёл зөв төлөвшиж чадаагүй. Үүнд улс төрийн гол институт болох нам, намын санхүүжилтийн асуудал хамгийн гол шалтгаан болсон.
- Төрийн институциуд чиг үүргээ зөв зүүтэй хэрэгжүүлэхгүй байна. Хууль тогтоох байгууллага зөвхөн сонгогчдод таалагдах явдал гээд ойлгочихсон. Тэдний амьдралыг дээшлүүлэхэд, сайн сайхан байлгахад зорьсон хуулийг нь батлах, хуулийн хэрэгжилтээ хянах ёстой.
- Ардчиллын соёл, ардчиллын уламжлал байхгүй дээрээс нь 80 орчим жил захиргаад алтдад байсан нь ардчилалд суралцах хугацаа шаардаж байна.


- Бидний онцлог нүүдэлчин соёлтой мал аж ахуй, хөдөө аж ахуйн орон байсан тул ардчиллын суурь нөхцөл болох өмч, өмчийн харилцаа, индивидуализм бүрэлдэх аж үйлдвэржүүлэлт бодит утгаар хөгжөөгүй
- Улс төрийн соёл болон улс төрийн боловсролын ялгаа амьдарч буй орчин нөхцөл, мэдээлэл хүртэх боломж зэргээс шалтгаалан харилцан адилгүй байна.
- Ардчилсан үнэлэмжийг төлөвшүүлэх орчин нь удаашралтай байна. Парламент, улс намууд, иргэний нийгэм, засгийн газар, орон нутгийн удирдлага, сонгуулийн хороо зэрэг ардчиллыг тээгч институцийн хөгжил удааширсан.
- Фракцжилт, олон жил энэ улс төрд байсан улсуудын хуучин соёл нь нэг хэвээрээ байгаа нь нөлөөлж байна.
- Амьдралын түвшин доогуур байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагын улс төрийн нөлөө, санхүүжилт, хөрөнгө оруулалт нь үнэн, бодит мэдээлэл түгээхэд саад болж байна.
- Хандлага, итгэл үнэмшил, ардчилсан нийгмийн чиг баримжаа байхгүй байна.

Мөн Монгол дахь улс төрийн соёлын хэлбэрийн талаар экспертээс тодруулахад “**уламжлалт, албатын хэв маяг**” давамгай байгааг олонх экспертүүд илүүтэй хариулсан. Оролцооны хэв маяг их бага байгаа нь иргэний нийгмийн хөгжил сул, иргэдийн оролцоог хангахад бодит байдал онол, үзэл санаа, баримт бичгийн хүрээнд цаасан дээр л байгаа болохоос бодит байдалд хангагдаагүй байна.

Бидний авсан олон нийтийн санаа бодлын судалгаанд шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцооны төлөв байдлыг үнэлсэн зарим асуултад, тухайлбал 0-10 шкалаар “**улс төрчид улсын гол асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх ёстой гэдэгтэй хэр зэрэг санал нийлэх вэ?**” болон “**удирдагч нь аливаа ажлыг амжилттай дуусгахын тулд дүрэм журмыг зөрчсөн байсан ч төрд хүчтэй удирдагч байх нь улсад ашигтай гэдэгтэй хэр зэрэг санал нийлэх вэ?**” гэсэн асуултыг 10-ийн тоо « бүрэн санал нийлж байна », 1-ын тоо « огт санал нийлэхгүй байна », « мэдэхгүй » бол 0 гэсэн сонголтыг сонгох боломжтойгоор үнэлүүлэхэд:

“иргэдийн хувьд одоо хүртэл төрөөс бид хамааралтай гэдгээрээ л харж байна. Нөгөө төрөө дээдэлдэг, зарим талаараа дээдэлдэг гэхээсээ илүү төр бид нарын төлөө ажиллах ёстой гээд мэдээд байна л даа. Тэгэхдээ энэ төр бүхнийг хийнэ гэдэг сэтгэлгээ байгааа байна.”²

Зураг 10. Улс төрчид улсын гол асуудлыг шийдвэрлэх ёстой гэдэгт санал нийлж буй байдал




Улс төрчид улсын гол асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх ёстой гэдэгтэй санал нийлж буй байдал тав болон түүнээс дээш арав хүртэлх шкалаар нийт судалгаанд оролцогчдын 72.1 хувь нь үзсэн бөгөөд түүнээс хамгийн өндөр үзүүлэлт болох арав гэсэн

² Эксперт 5

шкалаар нийт оролцогчдын 21.9 хувь нь үнэлжээ. Харин удирдагч нь аливаа ажлыг амжилттай дуусгахын тулд дүрэм журмыг зөрчсөн байсан ч төрд хүчтэй удирдагч байх нь улсад ашигтай гэж тав болон түүнээс дээш арав хүртэлх шкалаар нийт судалгаанд оролцогчдын 54.7 хувь нь үзсэн бөгөөд түүнээс хамгийн өндөр үзүүлэлт нийт оролцогчдын 20.1 хувь нь тав гэсэн хариултыг сонгожээ. Гэвч ихэнх улс төрчид ард түмнээ боддоггүй гэж тав болон түүнээс дээш арав хүртэлх шкалаар нийт судалгаанд оролцогчдын 74.5 хувь, ихэнх улс төрчид итгэл үнэмшилдээ үнэнч байдаггүй гэж 59.7 хувь нь үзжээ.

Мөн олон нийтийн санаа бодлын судалгаанд эх оронч үзлийн талаарх байр суурийг 1-ийн тоо «Тийм ч хүчтэй биш», 10-ын тоо «Маш хүчтэй», «мэдэхгүй» бол 0 гэсэн сонголтыг сонгох боломжтойгоор үнэлүүлэхэд:

Зураг 11. Эх оронч үзлийн талаарх иргэдийн байр суурь



Иргэд өөрсдийн эх оронч үзэлтэй гэж тав болон түүнээс дээш арав хүртэлх шкалаар нийт судалгаанд оролцогчдын 83.5 хувь нь үзэж байгаа бол УИХ-ын гишүүдийг эх оронч үзэлгүй гэж тав болон түүнээс дээш арав хүртэлх шкалаар нийт судалгаанд оролцогчдын 59.4 хувь нь үзжээ. Мөн УИХ-ын гишүүдийг эх оронч үзэлтэй эсэхийг “мэдэхгүй” гэж 20.6 хувь нь үзжээ.

Монголын зарим зүйл ичгүүртэй байдаг гэдэгтэй санал нийлэх үү? гэсэн асуултад «Зөвшөөрч байна» гэж тав болон түүнээс дээш арав хүртэлх шкалаар нийт судалгаанд оролцогчдын 81.5 хувь нь хариулсан байна.

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт гүйцэтгэсэн “Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлохуй. Шинжээчдийн судалгааны тайланд “улс төрийн соёлтой хүн” гэсэн ойлголтыг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 4. Таны бодлоор ямар хүнийг улс төрийн соёлтой хүн гэх вэ? (хувиар)

	Хүчинтэй хувь	Тохиолдлын хувь	Ач холбогдол өгсөн дэс дараа
Хувийн ашиг сонирхлоос үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэдэг	21.8	61.5	I
Хууль, ёс зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа чандлан баримталдаг	18.2	51.3	II
Улс төр, нийгмийн үйл явцыг бодитой үнэлж, дүгнэх чадвартай	14.5	41.0	III
Эх орон, ард нийтийнхээ сайн сайхны төлөө гэсэн итгэл үнэмшилтэй	12.7	35.9	IV
Хариуцлагатай, хэлсэн үгэндээ байдаг	9.1	25.6	V
Шударга, үнэнч байх	8.2	23.1	VI

Улс төр, эрх зүйн өндөр мэдлэг, боловсролтой	6.4	17.9	VII
Алдаа, дутагдлаа ухамсарлаж, хариуцлага хүлээн, залруулах чадвартай байх	4.5	12.8	VIII
Бусдын санаа бодлыг хүндэтгэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг	1.8	5.1	IX
Нийтгч, бусдыг ялгаварлан гадуурхдаггүй байх	0.9	2.6	X
Сахилга баттай бусдын эрх ашгийг дээдэлдэг	0.9	2.6	XI
Чин сэтгэлээсээ ханддаг	0.9	2.6	XII
Нийт	100	282.1	

Судалгаанд оролцогчдын үзэж буйгаар “улс төрийн соёлтой хүн” гэж хувийн ашиг сонирхлоос үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэдэг, хууль, ёс зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа чандлан баримталдаг, улс төр, нийгмийн үйл явцыг бодитой үнэлж, дүгнэх чадвартай гэсэн үзүүлэлтийг хамгийн ихээр сонгосон байна.

Ардчиллыг бодитоор хэрэгжүүлдэг иргэдийг төлөвшүүлэх:

Иргэдийг оролцуулахгүй байх сонирхол улс төрийн институцид давамгайлсан учраас иргэдийн нийгмийн хөгжилд сөрөг нөлөөтэй. Учир нь улс төрийн бодлого шийдвэр ил тод, иргэдийн ашиг сонирхлыг тусгасан, оролцоог хангасан, харилцан тайлагнадаг, хөндлөнгийн үнэлгээ тогтмол хийгддэг, түүнийгээ мэдээлдэг байх нь иргэдийн ардчилсан тогтолцоондоо итгэх нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл иргэд өөрсдөө мэдээлэлтэй байх, оролцоотой байх тусам улс төрийн итгэл нэмэгдэж байдаг. “Иргэдийн үнэт зүйл болон улс төрийн тогтолцоогоор илэрхийлэгддэг үнэт зүйлсийн хооронд өндөр нийцэж ардчилсан орнуудад хамгийн ардчилсан үзэл баримтлалтай хүмүүсийн дунд итгэл хамгийн өндөр байгаагаар илтгэж болно. Нөгөөтэйгөөр, ардчиллын хэм хэмжээ зөрчигддөг улс орнуудад ардчиллын үнэлэмж өндөртэй хүмүүст улс төрийн итгэл бага байх болно. Ардчиллын үнэт зүйлсийн чиг баримжаа болон улс төрийн итгэлцэл хоорондын хамаарал нь тухайн улсын ардчиллын гүйцэтгэлээс хамаардаг болохыг эмпирик судалгаанууд баталж байна.”³

Мөн тус судалгаагаар “**Гажуудсан ардчилалд** чөлөөт, шударга сонгууль явуулдаг ч засаглалын асуудалтай, улс төрийн оролцоог хязгаарладаг, мөн сонгууль болдог ч тэр бүр чөлөөтэй, шударга байдаггүй тул ардчиллын үнэт зүйлс, улс төрийн итгэлцэл хоорондын уялдаа холбоо сул байдаг.” гэж тодорхойлсон бөгөөд дараах хоёр шалтгаантай.

1. Хувь хүний болон улс төрийн тогтолцооны үнэт зүйлсийн хоорондын үл нийцэх байдал нь хоёр чиглэлд явагдах бөгөөд тухайн улсын ардчиллын түвшин зарим оршин суугчдын хувьд хэт өндөр, заримд нь хэтэрхий доогуур байвал ялгааны дундаж хэмжээс болж ардчиллын үнэт зүйлс болон улс төрийн итгэлцлийн хоорондын холбоо сул эсвэл огт байхгүй болоход хүргэдэг.
2. Шилжилтийн орнууд бусдаас илүү сайн ажиллаж, сайхан орчинд амьдрах зэргээс хамааран оршин суугчдын хүсэл сонирхол, мэдрэмжээс хамааран өөр өөр түвшний сэтгэл ханамжийг бий болгодог.

Иргэд нийгмийн аливаа асуудалд хандахдаа өөрт тогтсон үнэт зүйлс, үнэлэмжийн системээс шалтгаалан дүгнэдэг. Үүнийг “**шүүмжлэгч иргэд - critical citizens**”⁴ гэсэн ойлголтын хүрээнд тайлбарлаж болох бөгөөд дараах гурван хэв шинжээр илэрч болдог.

1. “шүүмжлэгч дэмжигчид - critical trusters” - институцид итгэх итгэлийн янз бүрийн түвшнийг харуулдаг.

³ Mauk M (2019) Disentangling an elusive relationship: How democratic value orientations affect political trust in different regimes. Political Research Quarterly.

⁴ Шүүмжтэй иргэншил нь хүлцэл, олон талт байдал, хүний эрх, ардчилал зэрэг нийтлэг үнэт зүйлсийг сурталчлахад суурилдаг.

2. “гомдол мэдүүлэгчид - compliants,” - институцид итгэдэг ч түүний талаар гомдоллож байдаг.
3. “үл сайшаагч - cynics,”⁵ - бүгдэд итгэдэггүй

Улс төрийн боловсролтой / бүтээлч соёл, улс төр, нийгмийн оролцоог хангахад шаардлагатай ур чадвар эзэмшсэн/, нийгмийн эрх, үүргээ ухамсарлах чадвартай, ардчиллыг бодитоор хэрэгжүүлдэг, өөрсдийгөө улс төрийн үйл явцыг тодорхойлогч гэж үзэж оролцохыг эрмэлздэг иргэнийг төлөвшүүлэх, боломжийг бүрдүүлэх хэрэгцээ гарна. Ийм иргэнийг “шүүмжлэгч дэмжигчид - **critical trusters**” гэж томъёолдог. Эзлэх хувь бүрэн ардчилалтай оронд, гажуудсан ардчилалтай харьцуулахад хамгийн өндөр, харин авторитар дэглэмтэй орнуудад хамгийн бага байдаг. Ардчиллын үнэт зүйлс өндөртэй гэр бүл эсвэл орчинд төрж, өссөн хүмүүс боловсролд илүү их хөрөнгө оруулалт хийх хандлагатай байх, боловсрол эргээд иргэнийг “шүүмжлэгч дэмжигчид - **critical trusters**” байх магадлалыг нэмэгдүүлдэг. Тиймээс ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэхийн тулд түүнийг сайжруулах, алдааг засах, ардчилалд итгэдэг иргэд хэрэгтэй.

Боловсрол итгэл үнэмшил, хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлдог. Тэгэхээр боловсролын нөлөө хөгжилд ямар их үнэ цэнтэй вэ гэдгийг ухамсарлаж, боловсролынхоо концепци хэрэгжилтийг л анхаарах нь зүйтэй. Суурь боловсролын хичээлүүдээс эхлэн ардчиллын мөн чанарыг ойлгуулах заах аргагүйг хэрэгжүүлж болно. Багш бэлтгэдэг бүх сургуулиудаа ардчиллыг заах ёстой. Биеийн тамирын багш байна уу, физикийн багш байна уу хамаагүй бүгд л ардчиллын боловсролтой байх ёстой. Тэд нар чинь зургаан настай хүүхдүүдэд ардчилал гэж юу юм зааж болох бөгөөд биеийн тамирын хичээл дээр шударга ёс гэж юу юм гэдгийг “*Чи энэний урдуур орж болохгүй, сагс тоглохдоо дүрэм зөрчиж болохгүй*” гэх зэргээр ардчиллын боловсролыг олгох боломжтой. Энэ боловсролын концепцээр цаашлаад төр засаг чиний саналаар бий болдог, чи тэрийгээ ингээд хянадаг, хянахын тулд та нар эвлэлдэн нэгдэх хэрэгтэй, тэр нь мөн төр засагт ашигтай гэдгийг тайлбарлаж болно. Ийм боломж бий болгохын тулд хүнээ бэлтгэдэг ба ямар ч салбарыг хөгжүүлбэ гэвэл боловсон хүчин хэрэгтэй. Гэхдээ монголын боловсролын систем ардчилсан иргэн бэлтгэх чиглэлд хангалттай хэмжээнд ажиллаж ирээгүйг экспертүүдийн дүгнэлтэд олон дурдагдсан.

Албан бус боловсролын тал дээр ТББ, их сургуулиуд, академи, улс төр нам иргэдийн соён гэгээрүүлэх, ардчиллын боловсрол олгоход оролцох чухал байна. Иргэдийн өөрсдийнх нь идэвхтэй оролцоог ардчиллын механизм яаж ажилладаг юм, би тэрний хаана нь байна вэ? бид нар олуулаа болбол хүчтэй юм байна, хууль дүрэм дагавал зөв юм байна, татвараа сайн төлбөл надад хэрэгтэй юм байна зэргээр мотивацижуулах чухал байна. Хүмүүсийг илүү их шүүмжлэгч дэмжигчид болгох буюу илүү их либерал ойлголттой, либерал үнэлэмжтэй хүн болох тусам criticism яг шууд хамааралтай шууд корляци нь өндөр байдаг. Үүний тулд олон ургалч үзэл бодлыг хүлээж авдаг, өөрөөс нь бусад хүн үзэл бодлоо илэрхийлэхэд ялгаатай байгаагаар нь хүлээж авах чадавхтай иргэн байх чухал. Ийм байдлаар үнэлэмж, үнэт зүйлс төлөвших процесс өндөр болох юм бол нийгмийн конституалны суурь бэхэжнэ. Хүний итгэл үнэмшил, үнэт зүйлсийн өөрчлөлтийн хэрээр хандлага өөрчлөгддөг, хандлага өөрчлөгдөхөөр дадал зуршил өөрчлөгддөг. Иргэд танин мэдэхийн хэрээр монголд ажиглагдаж буй *идэвхгүй, түр зуурын богино хугацааны улс төрийн оролцооны хэлбэрийг* орхих магадлалтай.

Ардчиллыг тээгч институц төлөвшүүлэх, бэхжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй. Парламент, улс намууд, иргэний нийгэм, засгийн газар, орон нутгийн удирдлагад, сонгуулийн хороо зэрэг институциуд ардчиллыг тээгч байх ёстой байтал тэр үүргээ гүйцэтгэх чадахгүй байна. Монгол Улсын Үндсэн хууль, болон бусад харьяалагдах хуульд тухайн институцийн эрх үүргийн асуудал бүгд тусгагдсан байгаа ч үйл ажиллагаа, түүний хэлбэрийг нь аваад үзвэл асуудал бол гарч ирдэг. Энэ нь тухайн ардчиллыг тээгч

⁵ улс төр, улс төрийн тогтолцоонд сэтгэл дундуур байгаа / Finding critical trusters: A response pattern model of political trust page 2/

институцийн бүтэц зохион байгуулалт болон гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны хооронд асуудал байгааг илэрхийлж байна. Хууль, эрх зүйн орчин байгаа ч хуулийг хэрэгжүүлэхэд тэгш байдал, ил тод байдал зэрэг шаардлагууд нийцсэн үйл ажиллагаа явахгүй байна. Төрийн институцийн дарангуйлал, хүчирхийлэл, хууль үйлдлийг хянан тэнцвэржүүлж чадах, иргэдээс томилогдсон иргэдийн өөрийгөө удирдах байгууллага байгуулагдах эрх зүйн чадавх байгаа ч ялсан намын төлөөлөгчдийн хурал болж эргээд иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэх боломжийг сулруулж байна. Ардчиллын үнэт зүйлсийг үнэгүйдүүлсэн зүйл нь өндөр албан тушаалтнууд, намын бодлого, лидерүүдийн асуудалтай холбоотой байгааг бидний судалгааны дүнгүүд илтгэж байна. Тиймээс улс төрийн нам манлайлан ардчиллыг бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцох хэрэгтэй байна. Улс төрийн нам бол нийгмийн үзэл санааны лидерүүдийн төвлөрөл, өрсөлдөөний талбар байх ёстой. Улс төрийн нам бол манлайллын үзэл санааны итгэл үнэмшлийн, өөрийн гэсэн үнэт зүйлийнхээ төлөө нэгдсэн хүмүүсийн нэгдэл. Тиймээс иргэдийн улс төрийн боловсрол мэдлэг түвшин дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл явц, нийгмийн харилцаанд гол үүрэгтэй институт болж хөгжих цаг иржээ. Ингэснээр ардчилсан тогтолцоогоо бэхжүүлэх, хадгалах үзэл санааг дэлгэрүүлнэ.

Иргэдийн, иргэний нийгмийн хяналтыг шийдвэр гаргагчид өөрсдийнхөө дайсан гэж үзэх хандлагаас татгалзах хэрэгтэй байна. Өнгөрсөн 33 жилийн хугацаанд бодит байдалд төрийн бодлого, шийдвэрт иргэдийг оролцуулахгүй байх сонирхол давамгайлсан байсан учраас иргэний нийгмийн хөгжил удаашралтай байна. Үүний бодит илрэл Төрийн бус байгууллагын хууль 1997 онд батлагдаж нийгмийн хөгжлийн нөлөөгөөр шинэчлэгдэх шаардлагатай болж 2023 оны байдлаар хуулийн хэлэлцүүлгүүд явагдаж байгаа ч хууль, тогтоогчид болон иргэний нийгмийн байгууллагуудын хооронд зөвшилд хүрч чадахгүй байна. Иргэний нийгэм болон төрийн харилцаанд нь ижил түвшинд байх ёстой атал асар том доголдол үүсэж төр эрх мэдлийн хувьд өөрийн давуу байдлыг ашиглан бүх түвшиндээ давамгайл байгаа нь иргэний нийгэм сул чадал муутай, эв нэгдэлгүй болгосон. Гэтэл Үндсэн хуулиас эхлээд иргэдийн оролцоог заавал баталгаажуулах ёстой гэсэн үзэл санаанд үндэслэсэн хуулийн зүүл заалт байгаа ч эрх зүйн чадамжгүй байгааг экспертүүд тодорхойлж байна. Иргэний нийгмийн ач холбогдлыг хувийн хэвшил, төр аль аль нь ухамсарлаж, хүлээж авахгүй байна. Хэрэв хувийн хэвшил иргэний нийгмийг санхүүжүүлэх, инкубатор байгуулах зэргээр дэмжихэд иргэний нийгэм нь хүчтэй болж төрийн эрх мэдлээ хэрэгжүүлэх бюрократ тогтолцоонд хяналт тавих нөхцөл бий болж хувийн хэвшлийнхэн ямар нэгэн байдлаар тэрхүү тогтолцоонд хахуул өгөх шаардлагагүй болдог. Харин төр иргэдийг чимээгүй байлгах, шийдвэр гаргахад оролцуулахгүй байх хандлагатай болохоор ардчиллын механизм нь ажиллахгүй. Манай улсын хувьд иргэний нийгэм гэдэг ойлголтод төрийн бус байгууллагууд хамруулах үзэх хандлага түгээмэл. Гэтэл төрийн бус байгууллагаар дамжуулан шийдвэр гаргах түвшинд оролцох нь намын дэргэдэх төрийн бус байгууллагуудад илүү боломжийг бий болгосон. Улс төрийн намд итгэх итгэл унаж байгаа нь нөгөө талаар энэ чиглэлийн төрийн бус байгууллага, цаашлаад иргэний нийгмийг үнэлэх үнэлэмжид эерэг хамааралтай нөлөөллийг үзүүлж байна. Хяналт байж алдаа дутагдлаас сэргийлнэ гэдэг нь иргэдийн оролцоог шаардсан ардчиллын нэг чухал үнэт зүйл. Гэтэл шийдвэр гаргагчид бодлогын бүх түвшний үнэлгээнд иргэдийн оролцоог хангаж чадахгүй байна. Тухайлбал, мэдээллийн ил тод, нээлттэй бус байдал хангагдаагүй байсаар байгаа олон нийт ч, экспертүүд ч тэр илэрхийлж байснаас гадна судалгаа хийх явцад төрийн мэдээллийн цахим сувгуудыг ашиглахад гарсан мэдээллийн шинэчлэл, мэдээлэл хандалтын сувгийн ажиллагаагүй байдал зэрэг нь илтгэж байна.

“Хүмүүс эдийн засгийн нөхцөл байдлын талаар илүү эерэг төсөөлөлтэй байвал тэд улс төрд итгэх магадлал нь илүү” байдаг. Учир нь хувь хүмүүс эдийн засгийн өнөөгийн болон өмнөх байдлын хоорондын өөрчлөлт, ирээдүйн талаар төсөөлөл зэргээр улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн байдлыг дүгнэдэг. Монгол улсын хувьд ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж эхэлснээр улс төр бизнесийн явцуу бүлэглэлд эрх мэдлийн далд төвлөрөл бий болох үйл явц өрнөснөөр хувь хүмүүсийн улс төрийн

үнэлэмж өөрчлөгдөж, улс төрийн итгэл буурч эхэлсэн. Энэ нь эдийн засгийн рационал байдал чухал бөгөөд эдийн засаг сайн байх нь эрх баригчдад илүү дэмжлэг үзүүлдэг.

Дүгнэлт

Өнөөгийн Монголын улсын төрийн соёлын тухай ойлголтод шинжилгээ хийхэд дараах илэрхийлэмж хамгийн их давтагдаж байв. Эл давтамжит илэрхийлэмжээс үзэхэд, шинжээчид ямар нэгэн тогтсон баригдмал тодорхойлолтоор хязгаарлахгүйгээр танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн төвшинд, мөн үйл ажиллагааны хүрээнд илрэх тэдний бодит хандлагыг багцлан үзвэл, улс төрийн соёлыг олон нийтийн улс төрийн систем, түүний үүрэг, улс төрчдийн үйл ажиллагаатай холбоотой мэдрэмжийг чухалчилж байгаа нь эл шинжилгээгээр нотлогдсон болно. Улс төрийн соёлтой хүмүүс хэмээн үнэлэгдэхийн тулд улс төрийн соёлд нөлөөлж байгаа субъектүүд нийгмийн харилцаанд соёлтой оролцож, иргэний нийгмийн төлөвшлийг бэхжүүлэх нэн чухал болох нь ажиглагдав. Ардчилсан нийгэм хөгжих эсэх нь гагцхүү боловсрол мэдлэгтэй, улс төрийн өндөр соёл, ёс суртахуунтай иргэд, албан хаагчид, улс төрчдөөс шууд хамаарах зэрэг илэрхийлэмжүүд голлож байна.

Abstract:

The article aims to determine the current political culture type, which is influenced by the process of formation of new political values in Mongolians, and how the type tends to change in the future. In the first part of the article, the theoretical and methodological foundations are clarified, a chronological explanation of the process of formation of new political values is made, and the Mongolian political culture type is defined. In the next section, the contribution of citizens to democratic strengthening, and the social and political resources for developing a democratic citizen were discussed.

Key words: Political culture, democratic transition, strengthening democracy, the institution of democracy

Ашигласан ном, материал

1. Философийн хүрээлэн, Улс төр, эрх зүйн салбар. ШУА. Монгол дахь улс төрийн соёл: Уламжлал, орчин үе. УБ., 2020.
2. Философийн хүрээлэн., ШУА. Орос, Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцоо. Хамтын бүтээл. ред. Чулуунбаатар Г. Горшков А.С. «Соёмбо принтинг» ХХК. УБ., 2017
3. ФСЭХ., ШУА. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. II хэвлэл. ред. Чулуунбаатар Г., Даш-Ёндон Б. «Бэмби сан» ХХК. УБ.,
4. ФСЭХ., ШУА. Монголын залуучуудын нийгмийн дүр төрх (XX-XXI зууны зааг дээр). УБ., 2012.
5. Хатанболд О., Хишигдаваа А, Жаргал Ц, Баянмөнх Ц. Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага. Олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан. Улс төр, эрх зүйн салбар. Философийн хүрээлэн., ШУА. УБ
6. Хатанболд О. Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016
7. Хатанболд О. Ардчиллын ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. «Соёмбо принтинг» ХХК. УБ., 2017.
8. Г.Түмэннаст. Нийгмийн социал хүрээний өөрчлөлт, асуудал. In Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/ (pp. 240-271). УБ., 2019. "Адмон принт" ХХК.
9. А.Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2001

10. Сант Марал Сан. Улс төрийн барометр №8-№18. УБ., 2010-2021 Retrieved from <https://mn.santmaral.org/publications> Сант Марал Сан. Улс төрийн барометр №8-№18. УБ., 2010-2021 Retrieved from <https://mn.santmaral.org/publications>
11. Almond A. Gabriel., Powell G. Bingham, Jr. Comparative Politics: System, Process, and Policy. Second Edition, Little, Brown and Company. Boston. 1978.
12. Mauk M (2019) Disentangling an elusive relationship: How democratic value orientations affect political trust in different regimes. Political Research Quarterly. Mauk M (2019) Disentangling an elusive relationship: How democratic value orientations affect political trust in different regimes. Political Research Quarterly.
13. Robert Alan Dahl. Polyarchy: Participation and Opposition. Yale University Press., 1971

ПОЛИТОЛОГИ XXII

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 211-221 дэх тал

**УЛС ТӨРИЙН МӨРГӨЛДӨӨН СУДЛАЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ,
МӨРГӨЛДӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ, ШИЙДВЭРЛЭХ АРГА**

Х.Батхүү
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй:

Улс төрийн мөргөлдөөний мөн чанарыг ойлгохын тулд түүнийг судлах онол, арга зүйн асуудал болон практик ач холбогдлыг авч үзэх нь чухал юм. Улс төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхийн явцад энэхүү ойлголтыг судлах онол, арга зүй бүрэлдэн төлөвшсөн байна. К.Маркс, М.Вебер, Г.Зиммель, Т.Парсонс Р.Дарендорф С.Хантингтон нар уг асуудлыг нарийвчлан судалж, онолын түвшинд хөгжүүлсэн байдаг. Тухайлбал, К.Маркс улс төрийн мөргөлдөөн нь нийгмийн хувьсал хөгжлийн сурвалж болдог гэсэн бол Т.Парсонс мөргөлдөөнийг нийгмийн өвчин гээд түүнийг анагааснаар нийгмийн зөвшилцөл, бүрэн бүтэн байдал хангагдана гэж үзсэн. Мөн мөргөлдөөнийг бүтээгч, бүтээлч шинжтэй болох талаас нь тайлбарласан үзэл баримтлалууд ч цөөнгүй байдаг бөгөөд дээрх судлаачдын судалгааны явцад улс төрийн мөргөлдөөнийг судлах парадигмууд төлөвшин бүрэлджээ. Улс төрийн зөрчил, мөргөлдөөнийг тандан судлах, танин мэдэх, шийдвэрлэх, зохицуулах арга замуудыг судалснаар түүнийг удирдан жолоодоход нөлөөлөх боломжтой юм.

Түлхүүр үгс: Улс төрийн мөргөлдөөн, мөргөлдөөний парадигм, мөргөлдөөний судлах зүйл, үүрэг, мөргөлдөөнийг зохицуулах, шийдвэрлэх арга

Удиртгал:

Улс төрийн үйл явц үргэлж динамик өөрчлөлт дунд оршдогоороо нэн онцлог бөгөөд тэр чанараараа учир начирыг нь олоход төвөгтэй үзэгдлүүдийг ар араас нь төрүүлж байдаг бөгөөд улс төрийн өөрчлөлт, хөгжлийн эх сурвалж нь улс төрийн зөрчил, мөргөлдөөнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл улс төрийн шинжлэх ухааны судлагдахууны нэг бол мөргөлдөөн юм. Мөргөлдөөн гэдэг нь Conflictus санал зөрөлдөх, зөрчилдөх, тэмцэл гэсэн утгатай үг бөгөөд “эсрэг тэсрэг байр суурь бүхий хүчнүүдийн эрх ашиг, зорилгоо хангах явцад үүсч буй зөрчилдөөнийг хэлнэ”¹. Өдгөө мөргөлдөөн судлал нь Конфликтологи (conflictology) гэсэн нийгмийн шинжлэх ухааны бие даасан салбар болон хөгжиж байна. А.Рапподорт мөргөлдөөний дайн, тоглоом, маргаан гэсэн гурван үндсэн хэлбэр байдаг гээд дайн нь талуудын хоорондын хүч хэрэглэх гэх мэт бүхий л арга хэрэгслийг ашиглан эцсээ хүртэл буулт хийлгүйгээр тэмцэх явдал. Тоглоом нь урьд өмнө тохиролцсон тодорхой дүрмийн дагуу мөргөлдөөнийг шийдэх арга бөгөөд эцсийн бүлэгт нэг тал нь нөгөөгөөс давуу байдал олж авах явдал юм. Харин маргаан гэдэг нь мөргөлдөөнийг гагцхүү энхийн аргаар шийдвэрлэх, талууд харилцан зөвшилцөлд хүрэх явдал гэж үзсэн байдаг².

Мөргөлдөөнийг судлах онол арга зүйн үүсэл, хөгжил

Судлаачид мөргөлдөөн судлалын үүсэл, онолын концепци, арга зүйн гол хандлагууд гурван үе шатыг дамжин бүрэлдэн төлөвшжээ гэж үзсэн байдаг. Үүнд:

Нэгдүгээр үе. XIX зууны дунд үеэс XX зууны дунд хүртэлх үеийг хамрах бөгөөд К.Маркс, М.Вебер, Г.Зиммель, В.Парето, Г.Моска, Ж.Сорел, Ф.Оппенгеймер нарын бүтээлд мөргөлдөөний тухай түлхүү тусчээ. Тухайлбал, К.Маркс нийгмийн янз бүрийн

¹ МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2014, 456х

² МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2014, 457х

ангиудын эдийн засаг, нийгэм, улс төрийн эрх ашгийн зөрчил тэмцэл нь нийгмийн мөргөлдөөний болон хувьсал хөгжлийн эх сурвалж болдог³ гэж үзсэн бол, М.Вебер мөргөлдөөн бол социологийн шинжлэх ухааны үндсэн ойлголт мөн бөгөөд тэр нь нийгэм соёлын амьдралын салшгүй үзэгдэл мөн гэсэн бол Г.Зиммель мөргөлдөөн нь эерэг ба сөрөг талтай үзэгдэл⁴ гэсэн байна. Энэ үед дараах санаанууд дэвшигдэн тавигджээ:

- Нийгмийн жам ёсны хэвийн үзэгдлүүдийн нэг нь мөргөлдөөн бөгөөд хүн ба нийгмийн уг шинжид мөргөлдөөнийг төрүүлэн бий болгодог биологи, сэтгэл зүйн ба нийгэм соёлын янз бүрийн шинж чанар, хүчин зүйлс байдаг
- Мөргөлдөөн нь нийгэмд хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, тэрээр нийгмийн дэвшил хөгжлийг хангаж, нийгмийн нэгдэл, нийтлэг хэм хэмжээ үнэт зүйлийг бататгаж бэхжүүлэхэд нэмэр болдог байна.
- Нийгмийн хөгжлийн мөргөлдөөнтэй төлөв байдал ба түүнийг үүсгэж байдаг нийгмийн бүтцийн хэв маягийн хоорондын хэлхээ холбоо, харилцан нөлөөллийг танин мэдэж ойлгоход мөргөлдөөн чухал үүрэгтэй.
- Засаглан захирч бу цөөнхи ба түүнд захирагдан удирдуулж буй олонхийн хоорондын эсрэг тэсрэг байдал зөрчил, мөргөлдөөн нь түүхэн, зайлшгүй мөнхийн үзэгдэл байдаг.
- Мөргөлдөөн үүсч шийдвэрлэгдсэнээр нийгмийн анги бүлгүүдийн ялгаатай, зөрчилтэй эрх ашиг тодорхой хэмжээгээр харилцан тэнцвэрждэг гэсэн байна.

Хоёрдугаар үе. XX зууны дунд үеэс 1990-ээд он хүртэлх үеийг хамрах бөгөөд бүтэц, үүргийн онол арга зүйн хандлага давамгайлдаг. Энэ чиглэлийн онол нь мөргөлдөөнийг нийгмийн өвчин гэж үзэж, түүнийг анагааснаар нийгмийн зөвшилцөл, бүрэн бүтэн байдал хангагдана гэж үзсэн. Тухайлбал, Т.Парсонс нийгэм тогтвортой, хэвийн байх функционал нөхцөлүүдийг дараах байдлаар нэрлэсэн байна⁵:

- Нийгмийн гишүүдийн мэдэгдэхүйц хэсгийн биологийн ба сэтгэл зүйн үндсэн хэрэгцээнүүдийг хангах
- Нийгмийн хяналтын байгууллагууд хувь хүмүүсийг тухайн нийгэмд хэвшин тогтсон хэм хэмжээ, үнэт зүйлсийн дагуу хүмүүжүүлэх талаар үр нөлөөтэй ажиллах
- Хүмүүсийн хувийн амьдрал, үйл ажиллагааны сэдэл нь нийгмийн чиг баримжаатай нийцэж тохирсон байх, хувь хүмүүс нийгмээс тогтоосон үүрэг зорилтуудыг биелүүлдэг байх явдал юм гэжээ.

Энэ үеийн гол төлөөлөгчид болох Э.Мейо орчин үеийн аж үйлдвэржсэн нийгэм нь зохицол, нийгмийн зөвшилцлийг эрхэмлэн тэмүүлэх хэрэгтэй бөгөөд эдгээр нь нийгмийн жам ёсны төлөв байдал мөн. Харин мөргөлдөөн бол “нийгмийн өвчин” юм гэжээ. Харин Л.Козер “мөргөлдөөнт харилцаагүй социал бүлэг гэж байхгүй бөгөөд мөргөлдөөнүүд нь нийгмийн тогтолцооны ажиллагаа, тэдгээрийн халаа сэлгээнд эерэг ач холбогдолтой байдаг”⁶ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл мөргөлдөөний үзүүлэх эерэг нөлөөг тодруулах гэж эрмэлзсэн байдаг. Тэрээр “Мөргөлдөөн гэж үнэт зүйлс, нийгмийн тодорхой статус, засаглал болон бүгдэд нэгэн зэрэг үл хүрэлцэх материаллаг ба оюуны баялагийн төлөөх өрсөлдөгчиддөө хохирол учруулах буюу ялах, устгах зорилго бүхий тэмцэл”⁷ гэж үзжээ. Харин К.Дойч мөргөлдөөнийг бүтээлч, эвдэгч гэж ангилсан бөгөөд хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг нь системчилсэн байна.

Мөргөлдөөний тухай үзэл баримтлал онолын хөгжилд Р.Дарендорф чухал хувь нэмэр оруулсан байдаг. Тэрээр мөргөлдөөн нь нийгмийн амьдралд байх байнгын төлөв зүйл гээд мөргөлдөөн байх нь бус, харин харин байхгүй бол хэвийн бус үзэгдэл өрнөж байна гэж

³ К.Маркс, Ф.Энгельс “Сочинение” М., 1961

⁴ А.В.Дмитриев “Конфликтология” М., 1998 /стр-343/

⁵ А.Я.Анцупов, А.И.Шпилов “Конфликтология” М., 2000

⁶ Lewis A.Coser “The Functions of Social Conflict”, 1956

⁷ “Государство и право” М., 1995/ 9 стр-9

үзсэн. Мөн хэн мөргөлдөөнийг удирдаж чадна, тэр түүхийн үйл явцыг хянаж чадна гэсэн. Түүний гол дүгнэлт бол “нийгэм нь зөвшилцлийн болон мөргөлдөөний шинжтэй ба энэ нь харилцан нэг нэгнийгээ үгүйсгэх бус харин харилцан нэг нэгнийгээ нөхөн гүйцээх шинжтэй”⁸ гэж үзсэн байдаг. Английн судлаач Ж.Бартон “Олон улсын харилцаан дахь анархизм нь нийтлэг үнэт зүйлсийн учир шалтгаанаар хязгаарлагдаж байдаг учир мөргөлдөөнүүдийг зохицуулаад зогсохгүй харин бүр мөргөлдөгч талуудын хамтын ажиллагаа болгон хувиргаж болно”⁹ гэсэн байдаг.

Гуравдугаар үе. 1990-ээд оноос хойш үеийг хамарна. Энэ үед мөргөлдөөн судлал хоёр асуудалд анхаарал хандуулж авч үзэх болсон бөгөөд нэг дэх чиглэл нь мөргөлдөөнийг өөрийг нь илүү чухалчилж судлах болсон. Өөрөөр хэлбэл, “Хэрэв энхийг хүсвэл дайныг судалж танин мэд” гэсэн зарчмыг баримталсан байдаг. Хоёр дахь чиглэл нь мөргөлдөөнийг бус энх тайван тогтвортой байдал, зөвшилцөл, зохицолыг гол асуудал болгон авч судлах болсон. Мөн энэ үед гарч ирсэн нэгэн шинэ хандлага бол соёл иргэншлийн мөргөлдөөний тухай асуудал юм. Тухайлбал, С.Хантингтон “Соёл иргэншлүүдийн мөргөлдөөн ба дэлхийн шинэ дэг журам” (1996) бүтээлээ гаргасан. Түүний үзэж буйгаар өнөөгийн дэлхийн хамгийн нөлөөтэй соёл иргэншил нь Индуизм, Исламын, Японы, Үнэн алдартны, Хятадын болон Өрнөдийн гэсэн зургаан соёл иргэншил байна гэжээ¹⁰. Энэ зургаагаас гадна Африкийн болон Латин америкийн соёл иргэншил нилээд өргөн тархсаныг бас хүлээн зөвшөөрсөн байна. Ирээдүйд эдгээр соёл иргэншлүүдийн хооронд мөргөлдөөн явагдах бололтой гэж үзсэн.

Конфликт буюу мөргөлдөөний судлах зүйл гэдэгт мөргөлдөгч талууд хоорондоо сөргөлдөж мөргөлдөхөд гарч буй зайлшгүй шийдвэрлэвэл зохих тодорхой бодит эсвэл оюун санааны хийсвэр асуудал түүнтэй холбоотой гол зөрчил байдаг.¹¹ Мөргөлдөөнийг илрэн гарах хүрээгээр нь эдийн засгийн, социал хүрээний, шашны, улс төрийн, соёл иргэншлийн, үндэстэн угсаатан хоорондын, олон улсын гэж ангилдаг бол мөргөлдөөний субъект нь бие хүн, нийгмийн бүлэг, анги давхраа, хамт олон, байгууллага, үндэстэн угсаатан, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, төр, улсууд байдаг байна.

Мөргөлдөөний парадигмууд

Парадигмын тухай ойлголтыг анх Америкийн судлаач Томас Кун авч хэрэглэсэн байдаг. Тэрээр “парадигм бол аль нэгэн шинжлэх ухааны нийгэмлэгийн хүлээн зөвшөөрч баримталсан итгэл үнэмшил, үнэт зүйл болон арга хэрэгслийн нийлбэр мөн”¹² гэж тодорхойлсон. Судлаачид түрэмгийлэл, хүчирхийлэл үүсэхийг хоёр шалтгаантай холбон тайлбарласан.¹³ Нэгдүгээрт, хүний төрөлхийн мөн чанараас үүдэлтэй түрэмгийлэл (нийгэм биологийн парадигм), хоёрдугаарт, нийгмийн хүчин зүйлсээс хамаарсан хүчирхийлэл (ангийн, диалектик, бүтэц үүргийн парадигм) зэрэг болно. Үүнд:

1. Нийгэм биологийн парадигм: Энд гол тайлбарыг түрэмгийлэл гэсэн ойлголтоор тайлбарладаг бөгөөд зөрчил тэмцэл гэдэг нь бүх амьтанд байдаг шиг хүнд ч гэсэн төрөлхийн шингэсэн байдаг зүйл гэж үздэг. Түрэмгийлэл гэдэг нь хүний зан төлвийг тодорхойлдог нөхцөлдсөн зөн совингийн үзэгдэл бөгөөд ийм зан төлөв нь түрэмгий харьцаа, шууд тулалдаанаар илрэх ба бүлэг доторх гол хүний түрэмгий байдал нь араатан амьтны байр сууриа бэхжүүлэх оролдлоготой ижил гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Ч.Дарвины “Байгалийн шалгаралын онол”-ийн хүрээнд авч үздэг байна. Тухалбал, судлаач Шерер түрэмгийлэл гэдэг үзэгдэлд гурван хандлага байж болохыг тодорхойлсон¹⁴. Үүнд:

- Түрэмгийлэл нь төрөлхийн шинж ба төрөлхийн хүч байдаг
- Сэтгэл хөдлөлийн огцом өргөлт

⁸ Р.Дарендорф “Современный социальный конфликт” иностранная журнал., 1990 №5

⁹ П.А.Цыганков “Гаролди” М.,2002 стр-349

¹⁰ МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ.,2014, 469х

¹¹ Ж.Т. Тощенко “Политическая социология” М., 1999

¹² МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ.,2014, 87х

¹³ А.Д.Здравомыслов “Социология конфликта” М.,1996

¹⁴ А.Д.Здравомыслов “Социология конфликта” М.,1996

- Сургалтын явцаар дамжсан түрэмгий зан төлөвийн чиг хандлага зэрэг юм.

2. Ангийн парадигм: Энэ онол мөргөлдөөн нь зайлшгүй нийгэм улс төрийн шинжийг агуулдаг, эсрэг тэсрэг байр сууриар илэрхийлэгдэж, улс төрийн мөргөлдөөний үндэс суурь нь ангийн тэмцэл байдаг гэж үздэг. Тухайлбал, К.Маркс “Мөргөлдөөн нь нийгмийн өөрийнх нь үндэс суурьт шингэсэн байдаг бөгөөд хүмүүсийн эдийн засгийн системд эзэлж байгаа байр сууриас нь шалтгаалан янз бүрийн ангид хуваагдсанаас үүсэн гардаг олон бүлгүүдэд хуваагдаж, үнэт зүйл ба ашиг сонирхлоороо зөрчилдөн, дайсагналцаж ангийн тэмцэл үүсгэнэ. Ангийн тэмцэл нь ихэнхи улс төрийн мөргөлдөөнүүдийн эх үүсвэр болдог ба ийм мөргөлдөөнүүд нь улс төрийн тогтвортой байдлыг алдагдуулж, эцэстээ улс төрийн зорилготой хувьсгалд хүргэдэг байна. Энэхүү хувьсгал нь түүхийн хурдасгагч болдог”¹⁵ гэж үзсэн байна.

3. Бүтэц үүргийн парадигм: Мөргөлдөөн нь нийгмийн байгуулал ба нийгмийг зохион байгуулахад гарсан гажуудал бөгөөд энэхүү хандлага тодорхой хэмжээгээр, нийгмийн тодорхой нөхцөлд бүрэлдэж байдаг. Ингэснээр нийгмийн тогтвортой байдал алдагдаж улмаар мөргөлдөөнд хүргэдэг байна.

4. Диалектик бүтээн байгуулагч парадигм: Энэ нь мөргөлдөөнийг заавал сүйтгэгч хүчин зүйл байх албагүй, харин бүтээгч, бүтээлч шинжтэй болох талаас нь тайлбарладаг. Өөрөөр хэлбэл мөргөлдөөн нь өөрчлөн байгуулах хэлбэр бөгөөд нийгмийн байгууллын хөгжилд түүний оруулах хувь нэмэр хэмжиж баршгүй их байдаг. Нийгэм нь мөргөлдөөнгүйгээр цаашид хөгжих боломжгүй, мөргөлдөөн гарч буй нь харин ч эрүүл үзэгдэл гэж үздэг.

Улс төрийн мөргөлдөөний судлах зүйл юу вэ?

Мөргөлдөөний нэг гол талбар бол улс төрийн ертөнц байдаг. Нийгмийн бүлгүүдийн аж амьдралыг хангахтай холбоотой нөөцийг хуваарилах, хүртэх, ашиглахтай холбоотойгоор нийгмийн мөргөлдөөн үүсдэг бол улс төрийн мөргөлдөөн нь эрх ашиг, зорилго, үнэт зүйл, байр суурь, статустай холбоотойгоор улс төрийн хүрээнд үүсч, явагддаг байна. Улс төрийн янз бүрийн хүчнүүд, улс төрийн бодлогын субъектүүд засгийн эрхийг гартаа авч хэрэгжүүлэх, өөрсдийнхөө улс төрийн статус, байр суурийг өөртөө ашигтайгаар өөрчлөх, эрх ашиг, үзэл бодол, үнэт зүйлсээ хамгаалж хэрэгжүүлэхийн төлөө тэмцэх явцад үүсдэг мөргөлдөөн, тэмцлийг улс төрийн мөргөлдөөн гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл улс төрийн мөргөлдөөн нь улс төрийн зөрчлийн жам ёсны хэвийн үзэгдэл, илрэл болдог байна.

Улс төрийн мөргөлдөөний судлах зүйл нь мөргөлдөгч талуудын аль аль нь өөртөө ашигтайгаар шийдвэрлэх хүсэл, сонирхолтой байгаа улс төрийн ямар нэг асуудал, зорилт мөн¹⁶ гэж тодорхойлсон байдаг бөгөөд түүнийг нарийвчлан судлахын тулд дараах зүйлсийг дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай байдаг. Үүнд:

1. Эх сурвалж, шалтгаан. Энэ нь улс төрийн институтууд үзэл бодол, соёл, үнэт зүйлсээрээ хоорондоо ижилсэх эсвэл ялгарах үйл явцын зөрчилтэй холбоотой байдгаараа онцлог. Улс төрийн мөргөлдөөний эх сурвалж нь мөргөлдөөн үүсч гарах гүнзгий үндэс суурь, эх үүсвэр нь болдог бол шалтгаан, шалтаг, хүчин зүйл нь өдөөгч нь болдогоороо ялгаатай байдаг.

2. Субъект, объект ба бусад оролцогчид. Эсрэг тэсрэг талуудыг бүрдүүлж улс төрийн мөргөлдөөнд оролцож байгаа оролцогчидыг ялгаатай авч үзэх шаардлагатай. Үүнд:

- Субъект: Мөргөлдөөний эсрэг тэсрэг хоёр талыг бүрдүүлж, улс төрийн мөргөлдөөнд идэвхитэй оролцож байгаа этгээдийг хэлнэ.
- Объект: засаглалын нөөцөд эрх мэдлээр дамжуулж хяналт тавих явдал¹⁷

¹⁵ К.Маркс, Ф.Энгельс “Сочинение” М., 1961

¹⁶ А.В. Дмитриев “Конфликтология” Учебное пособие М., 2000

¹⁷ А.В. Дмитриев “Конфликтология” Учебное пособие М., 2000

- Хөндлөнгийн өдөөн хатгагч, турхирагч: Улс төрийн мөргөлдөөнд шууд, ил тод идэвхитэй оролцохгүй боловч хоёр талыг хооронд нь турхирч, хүчийг нь сулруулах замаар байдлыг өөртөө ашигтайгаар эргүүлэх сонирхолтой этгээдийг хэлнэ.
- Талуудын хань, хамсаатан: Мөргөлдөөнд шууд оролцохгүй хирнээ мөргөлдөөн үүсгэх ашиг сонирхолтой, талуудад зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх зэргээр оролцогч этгээдийг ойлгоно.
- Зохион байгуулагч: Улс төрийн мөргөлдөөнийг тодорхой зорилгоор урьдаас төлөвлөн зохион байгуулж, түүний өрнөл, шийдэл, төгсгөлийн үйл явцыг өөртөө ашигтайгаар эргүүлж, хянахыг хичээдэг хүч юм.
- Зуучлагч: Мөргөлдөгч талуудыг хооронд нь зөвшилцүүлэх, мөргөлдөөнийг хохирол багатайгаар шийдвэрлэх, зохицуулах сонирхолтой хөндлөнгийн гуравдагч этгээд байдаг. Тэрээр талуудын байр суурийг хооронд нь дамжуулж зуучилдаг байна.

3. Арга хэрэгсэл, технологи. Мөргөлдөөнийг үүсгэж буй талууд өөр өөрийн онцлог бүхий зорилготой байдаг бөгөөд өөртөө ашигтайгаар шийдвэрлэхийн тулд түүндээ нийцсэн арга хэрэгсэл (үзэл суртал, мэдээллийн хэрэгслүүд, сүрдүүлэг, заналхийлэл, хүчирхийлэл, хууран мэхлэх, санхүү, хөрөнгө мөнгөний гэх мэт), технологитой (цэвэр ба бохир) байдаг.

4. Үе шат. Улс төрийн мөргөлдөөн нь тодорхой үе шатуудтай байх ба үүнийг дараах таван үе шатыг дамждаг гэж судлаачид тодорхойлсон байдаг¹⁸. Тэдгээрт:

- Нөхцөл байдал бүрэлдэх үе. Энэ үед мөргөлдөөнт нөхцөл байдал аажмаар бэлтгэгдэж бүрэлддэг. Мөргөлдөөнт нөхцөл байдал гэдэг нь хоёр болон түүнээс дээш субъектүүдийн эрх ашгийг адилхан хөндсөн зөрчилтэй төлөв байдлыг хэлнэ. Энэ нөхцөл байдлыг талууд хэрхэн үнэлж, дүгнэхээс мөргөлдөөний эхлэл шалтгаалдаг байна.
- Нуугдмал үе. Нэгэнт бий болсон мөргөлдөөнт нөхцөл байдлыг талууд олж харах, мөргөлдөөнд бэлтгэх, хүч нөөц бололцоо, арга хэрэгсэл, стратегия боловсруулах бэлтгэл шат бүхий мөргөлдөөн нуугдмал байх
- Эхлэл үе. Мөргөлдөөн ил тод илэрч, албан ёсоор эхлэх шат нь дараах үйлдэл, үйл явдал болдог. Үүнд: нэгдүгээрт, сөргөлдөгч талуудын нэг нь нөгөө талын эрх ашиг, байр суурь, статус, үзэл санаа, үнэт зүйлд нь эсрэг чиглэсэн бодит үйлдэл, алхам хийнэ. Хоёрдугаарт, нөгөө тал нь тэр үйлдэл, алхмыг өөрийнх нь эсрэг чиглэгдсэн ноцтой үйлдэл, эрх ашгийг нь шууд хөндөж, хохирооход чиглэгдсэн үйлдэл, үйл ажиллагаа гэж эмзэг байдлаар хүлээн авч зохих хариу үйлдэл, эсэргүүцэл үзүүлнэ.
- Өрнөл, хурцадмал үе. Дээрх үе шатуудыг дараа мөргөлдөөн ид өрнөж, талууд өөртөө байгаа нөөц, боломж, арга хэрэгслээ бүрэн дайчлан ашигладаг. Улмаар мөргөлдөөний хүрээ хязгаар, нөлөө, оролцогчдын тоо хэмжээ нэмэгдэх эсвэл хумигддаг байна. Үүний үр дүнд талуудын аль нь ялах, ялагдах нь тодорхой болдог.
- Төгсгөл буюу зохицуулалт, шийдвэрлэгдэх үе. Мөргөлдөгч талууд хоорондоо зөвшилцөх, харилцан буулт хийх эсвэл нэг тал нь нөгөөдөө ялагдах, бууж өгөх, устгагдах, гуравдагч этгээдийн оролцоо, зуучлалаар мөргөлдөөн зогсох зэргээр төгсгөл болдог байна.

5.Төрөл ангилал. Улс төрийн мөргөлдөөнийг мөн чанар, бүтэц, гол шинж чанаруудаар нь нь базаж нэгтгэн дүгнэсэн байдалтайгаар ангилж үзсэн байдаг¹⁹. Эдгээр шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн ангилалын талаар товч дурьдая. Үүнд:

- Орон зайгаар нь улс орны доторхи, улс орны хэмжээний, бүс нутгийн, орон нутгийн чанартай улс төрийн мөргөлдөөн

¹⁸ А.Д.Здравомыслов “Социалогия конфликта” М., 1996

¹⁹ А.В.Дмитриев “Конфликтология” М., 2000

- Үргэлжлэх цаг хугацаагаар нь богино, дунд, урт хугацааны мөргөлдөөн
- Хууль эрх зүйгээр зохицуулагдаж болох эсэхээр нь институтчилагдсан болон институтчилагдаагүй гэсэн төрөл хэлбэртэй байж болно
- Чанарын шинж чанараар нь гүнзгий буюу эвлэршгүй, гүнзгий биш буюу эвлэрүүлж болох улс төрийн мөргөлдөөн
- Үйл явцынх нь эрч хүчээр хүчтэй хурц нөгөөтэйгүүр хүч сул аажим шинжтэй гэж ангилж болно
- Ил тод байдлаар нь нээлттэй эсвэл далд
- Явагдах чиг шугам, бүтцээр нь засаг захиргааны янз бүрийн түвшингийн субъектуудын хооронд эсвэл төв засгийн газар ба орон нутгийн засаг захиргааны хооронд босоо чиг шугамаар, улс төрийн субъектүүд, улс төрийн хүчнүүдийн хооронд хэвтээ чиг шугамаар явагддаг мөргөлдөөн
- Улс төрийн мөргөлдөөн нь систем болохын хувьд үүсч гарсан эх сурвалжаараа өөрийнхөө системийн доторхи ба гадаад мөргөлдөөн
- Хэрэглэгдсэн арга, хэрэгсэл, нөөц тэдгээрийн шинж чанараараа зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн үзэл суртал, үнэт зүйлсийн мөргөлдөөн

6. Мөргөлдөөний стратеги ба тактик. Улс төрийн мөргөлдөөнд хамтран ажиллаж асуудлыг шийдэх, өрсөлдөх гэсэн үндсэн хоёр стратеги байх бөгөөд хослуулан хэрэглэдэг боловч ихэнхидээ аль нэг нь давамгайлдаг байна. Өрсөлдөгч ямар стратеги ашиглаж байгаа нь тун чухал ач холбогдолтой. Тухайлбал, Хоёр тал хоёулаа өрсөлдөх стратеги баримталбал хэлэлцээр мухардалд ордог бол харин нэг нь өрсөлдөх нөгөө нь ажиллах стратеги баримтлахад ер нь талаас илүү хувьд нь өрсөлдөх стратеги ялдаг байна. Харин тухайн зорилгод хүрэх арга замыг нь тактик гэж үзэж болно. Нэг тактик хэд хэдэн стратегид ашиглагдаж болдог. Улс төрийн мөргөлдөөний талуудын стратеги нь дараах байдалтай байдаг²⁰ байна. Үүнд:

- Мөргөлдөөнийг улам хурцатгаж даамжруулахад чиглэгдсэн, нөгөө талдаа өөрийнхөө эрх ашгаа тулган хүлээлгэсэн хэлбэртэй
- Маргаантай асуудлыг хоёр тал харилцан ашигтай шийдвэрлэхэд чиглэгдсэн конструктив шинжтэй
- Нөгөө талд буулт хийсэн маягтай
- Мөргөлдөөнөөс дайжиж зугтах, гарахыг хичээсэн
- Хамгаалж, хориглосон байдалтай
- Дайрч давшсан шинж чанартай байдаг.

7. Нийгэмд гүйцэтгэх үүрэг. Улс төрийн мөргөлдөөнийг жам ёсны үзэгдэл гэж үзэн эерэг талыг нь харах эсвэл сөрөг, гаж үзэгдэл талаас нь хандахаас хамаарч түүний нийгэмд гүйцэтгэх үүргийг тодорхойлж болно. Тухайлбал, Мертон 1957 онд улс төрийн мөргөлдөөний үүргийн гурван гол ангилалыг хийсэн²¹ байдаг. Тэдгээрт:

- Тунхаглаж байгаа үүрэг: Нийгмийн системд нөлөөлөх үйл ажиллагааны зориудын бодит нөхцөл байдал юм.
- Нуугдмал үүрэг: Нийгмийн үйл ажиллагаагаар зохион байгуулагдсан бодит бус өөрөөр хэлбэл бодит нөхцөл байдалд нөлөөлдөггүй
- Хувьсах үүрэг: Нийгмийн үйлчлэлийн бодит нөхцөл байдлаар илрэх бөгөөд нийгмийн системд дасах байдалд саад болдог байна гэж үзсэн.

²⁰ А.В.Дмитриев “Конфликтология” М., 2000

²¹ А.Д.Здравомыслов “Социалогия конфликта” М., 1996

Судлаачид улс төрийн мөргөлдөөний нийгэмд гүйцэтгэх үүргийг янз бүр тэмдэглэсэн байдаг боловч дараах ерөнхий хэдэн үүргийг дурьдах нь зүйтэй. Үүнд:

- Мэдээлэл танин мэдэхгүйн үүрэг: Улс төрийн мөргөлдөөн үүснэ гэдэг бол нийгэмд ямар нэгэн асуудал, зөрчил байна түүнийг зүй зохистойгоор шийдвэрлэх хэрэгтэй гэдгийг санаалж, дохио, мэдээлэл өгч байгаа хэрэг юм.
- Нийгмийг нэгтгэж нягтруулах, сөргөлдөгч талуудыг хооронд нь зөвшилцүүлэх үүрэг: Улс төрийн мөргөлдөөн нь нийгэм дэх бүлгүүд, хүчнүүдийн хоорондын харилцааг тэнцвэржүүлдэг байна.
- Нийгэм дэх анги, бүлгүүдийн байр суурийн ялгарал, зөрчлийг ил тод болгож тэдгээрийг танин мэдэх, эрх баригчид нийгмийн ялгаатай эрх ашгуудыг ханган хэрэгжүүлэх боломж олгодог
- Дасан зохицохуйн үүрэг: Мөргөлдөгч талуудад сургамж, туршлага өгч, тэд өөрчлөгдөж буй шинэ нөхцөл орчинд дасан зохицох, өрсөлдөгч хүчнүүдтэйгээ хэвийн байдлаар, эрх зүйн хүрээнд зэрэгцэн орших нь чухал гэдгийг ойлгуулдаг
- Улс төрийн мөргөлдөөн нь нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт, хөгжил дэвшлийн дотоод эх сурвалж, түлхэц хүч болж өгдөг байна
- Сөрөг, хор хохиролтой үүрэг: Сөрөг үүргүүдийг нь ерөнхийд нь дараах байдлаар нэгтгэн дүгнэж болох юм. Үүнд: нэгдүгээрт, улс төрийн тогтвортой байдлыг алдагдуулдаг, хоёрдугаарт, хүч их хэрэглэдэг, хууль бус арга хэрэгслийг ихээр ашигладаг, гуравдугаарт, нийгмийг талцан хуваагдуул, хагаралдуулдаг, дөрөвдүгээрт, зөрчил тэмцлийг улс төрийн гүнрүү шигдүүлж, тодорхой хугацааны дараа дахин мөргөлдөөн үүсэх хөрс суурь бий болгодог байна.

Улс төрийн мөргөлдөөнийг зохицуулах, шийдвэрлэх арга

Улс төрийн мөргөлдөөн бол нийгмийн оршин тогтнол, хөгжил дэвшлийн хэрэгцээ шаардлага, шийдвэрлэвэл зохих асуудал, хэрэгжүүлэх ёстой зорилго, тодорхой зорилтуудтай нөхцөлдөн уялдаж гарч ирдэг үзэгдэл учраас түүнд сөрөг байдлаар хандах, мөргөлдөөнөөс зайлсхийх, зохиомлоор нууж хаах мэтээр хөнгөн хийсвэр хандаж болохгүй асуудал юм. Тодорхой шалтгаан, нөхцөл байдлын эрхээр улс төрийн мөргөлдөөн нэгэнт үүссэн бол түүнд анхаарал хандуулж судлан таньж мэдэх, зүй зохистойгоор зохицуулах, шийдвэрлэх зайлшгүй шаардлага үүсдэг. Тиймээс улс төрийн мөргөлдөөний тухай асуудлын хүрээнд түүнийг зохицуулах, шийдвэрлэх зорилгоор хэрэглэх арга, хэрэгслийн тухай асуудлыг судлах нь чухлаар тавигддаг байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн мөргөлдөөнийг зохицуулах арга зам, мөргөлдөөнийг шийдвэрлэх асуудлыг тусад нь ялгамжтайгаар авч үзэх ёстой.

Улс төрийн мөргөлдөөнийг зохицуулах арга зам. Мөргөлдөөнийг зохицуулах, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх олон янзын аргууд байдаг. Тэдгээрийн дотроос илүү үр дүнтэй, илүү их хэрэглэгддэг нь улс төрийн аргууд байдаг бөгөөд тэдгээрийг дотор нь уламжлалт ба институционал гэж ангилдаг.

1. Уламжлалт аргууд. Улс төрийн мөргөлдөөнийг зохицуулах хамгийн өргөн дэлгэрсэн арга бол гуравдагч этгээдийн оролцоо, зуучлалын тусламжтайгаар хэлэлцээр хийх, эвлэрэх зэрэг аргууд байдаг. Гуравдагч этгээд гэдэг нь зөвшилцөлд хүрэх эрмэлзэл бүхий мөргөлдөөнөөс гадуурх этгээдийг хэлдэг. Зуучлагч гэдэг нь тухайн онцлогт тохирсон туршлага, мэдлэгээ ашиглаж асуудлыг зөв зүйтэй ойлгоход нь сөргөлдөгч талуудад тусалдаг туслагч бөгөөд харин эцсийн шийдвэрийг мөргөлдөгч талууд өөрсдөө гаргадаг байна. Гуравдагч этгээд нь улс төрийн мөргөлдөөнийг шийдэх явцад олон үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эдгээрийг дурьдвал нэгдүгээрт, мөргөлдөгч талуудын төлөөлөгчдийн хооронд харилцаа холбоо тогтоох, хоёрдугаарт, талуудаар бие биеэ хэлэлцээрт орох эрхтэй гэж хүлээн зөвшөөрүүлэх, гуравдугаарт, хэлэлцээрийн үйл явцыг зохион байгуулах, дөрөвдүгээрт, мөргөлдөгч талуудын үл хамаарах экспертүүд, шийдвэр гаргах этгээдүүдийг олох, цаг хугацаа сунгаж өгөх зэрэг нөөцийг хуваарилах, тавдугаарт, асуудлыг судлан шинжлэх, зургаадугаарт,

мөргөлдөөнийг бодитой, зүй зохистой шийдвэрлэхэд туслах зэргийг багтаадаг. М.Мерль хэлэхдээ “эрх зүйн хэм хэмжээг дагах шаардлагагүйгээр мөргөлдөөнийг зохицуулах бүх арга замын үндэс нь бүх талууд сайн дурын үндсэн дээр байх ёстой”²² гэсэн байна. Өөрөөр хэлбэл мөргөлдөөнийг энхийн аргаар шийдвэрлэхэд сөргөлдөгч талуудын хүсэл зорилгоос бүх зүйл хамаарна гэсэн үг юм. Энэ нь улс төрийн мөргөлдөөнийг уламжлалт аргаар зохицуулах нь хязгаарлагдмал шинж чанартай байдгийн үндсэн шалгаан болдог билээ.

- Хэлэлцээрийн арга. Энэ нь мөргөлдөгч талуудын хүсэж буй зүйлийнхээ зарим хэсгийг олж авч, тохиролцоонд хүргэдэг бөгөөд дараах нөхцлүүд бүрдсэн үед хэлэлцээр үүсэх боломжтой гэж үздэг. Үүнд: нэгдүгээрт, талууд мөргөлдөөнт ашиг сонирхлоос гадна ач холбогдол бүхий нийтлэг эрх ашигтай байх, хоёрдугаарт, бусад хувилбаруудаас тодорхой харилцан ойлголцсон шийдвэр илүү боломжтой гэж хоёр тал үзсэн, гуравдугаарт, тэд харилцан хүлээн зөвшөөрөх шийдвэр олох гэж хэлэлцэж эхэлсэн байх зэргийг багтаадаг. Гэвч энэ аргыг мөргөлдөгч талууд дуртай хүлээж авдаггүй бөгөөд тэд ихэвчлэн өөрсдөө асуудлаа шийдвэрлэх сонирхолтой байдаг байна.
- Эвлэрэлийн арга. Маргааны элементийг гуравдагч этгээдээр удирдуулсан комисс авч үзээд талуудын харилцан мөргөлдөөний шийдлийг гаргаж өгдөгөөрөө энэ арга онцлогтой. Эвлэхүүлэх комиссыг эртнээс байгуулж чадсан үед л энэхүү арга илүү үр дүнтэй байдаг.

2. Институционал арга. Энэ арга нь улс төрийн мөргөлдөөнийг зохицуулахад тодорхой институт, эрх зүйн хэм хэмжээг ашиглах явдал байдаг. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллага гэсэн институт бий болсноор улс төрийн мөргөлдөөн, олон улсын мөргөлдөөнийг зохицуулах асуудлыг урагшлуулсан алхам болсон юм. Эдүгээ уг институт гуравдагч этгээд сөргөлдөгчдийг салгах биш, харин Засгийн газар хоорондын байгууллага, судалгааны комисс байгуулах, өөрийн нөхцлүүдийг дэвшүүлэн тавих зуучлагчыг томилох буюу эвлэрүүлэх үүргийг өөртөө хүлээх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Жишээлбэл, 1948-1949 оны Палестины асуудлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас томилсон зуучлагч шийдсэн байдаг. Мөн 1970 онд Израйл, Арабын улсуудын хооронд үүссэн асуудлыг уг институтээс эвлэрүүлэх комисс томилж шийдвэрлэсэн байдаг. Гэвч сүүлийн үед улсуудын хооронд үүссэн мөргөлдөөн, эсвэл их гүрнүүдийн үүсгэсэн улс төрийн мөргөлдөөнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын зүгээс явуулах арга хэмжээ хүчин мөхөсдөх эсвэл аргагүйн эрхэнд байр суурь илэрхийлэх, нүдээ аниад өнгөрөх зэрэг нь түүний үүрэг хязгаарлагдмал байдалд орсныг харуулж байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүй, олон улсын байгууллагуудыг үл хайхран өөрийн эрх ашгаа дээгүүрт тавих асуудал байсаар байгаа нь институционал аргыг хүчгүйдүүлж байна.

Улс төрийн мөргөлдөөнийг шийдвэрлэх арга. Улс төрийн мөргөлдөөн нь олон янз, харилцан адилгүй байдагтай холбоотойгоор түүнийг шийдвэрлэх шалгарсан арга гэж байдаггүй. Улс төрийн мөргөлдөөнийг шийднэ гэдэг нь оролцогчид маргаантай асуудлаараа тохиролцоонд хүрнэ гэсэн үг. Ийм тохиролцоог судлаачид гурван төрөл болгон ангилдаг.²³ Нэгдүгээрт, мөргөлдөгч талууд санал нийлэх, хоёрдугаарт, нэг тал нь шахалтанд автах, гуравдугаарт, гадаад хүчний, хууль ёсны буюу ёс суртахууны хүсэл зорилготой нийцүүлэх зэрэг багтдаг бөгөөд нэг ба гуравдугаар тохиолдолд хоёр тал хоёулаа идэвхитэй оролцдог байна. Хүчтэй тал нь нөгөө талдаа ашиг сонирхлоо тулган хүлээлгэж улс төрийн мөргөлдөөнийг хүч түрэн шийдэж болохгүй, хэрэв ийм тохиолдолд тодорхой цаг хугацааны дараа мөргөлдөөн дахин сэргэх магадлал асар өндөр байдаг. Судлаачид онолын болон практик туршлагад үндэслэн тулгуурлаж, бэрхшээлийг шийдэх талаар зарим дүгнэлтүүдийг хийсэн байна. Үүнийг дурьдвал:

²² А.В.Дмитриев “Конфликтология” М., 2000

²³ А.В.Дмитриев “Конфликтология” М., 2000

1. Объектив шалтгаануудыг арилгах арга. Улс төрийн мөргөлдөөнийг шийдвэрлэх хамгийн гол арга зам бол мөргөлдөөний нөхцөл байдлыг төрүүлсэн объектив шалтгаануудыг арилгахад оршино. Зарим мөргөлдөөнүүд гадаад нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байдаг.

2. Субъектүүдийн ашиг сонирхлын зөрчилдөөнийг арилгах арга. Судлаачдын үзэж буйгаар улс төрийн мөргөлдөөний үндэс нь субъектүүдийн ашиг сонирхлын зөрчилдөөн байдаг аж. Иймд энэхүү зөрчилдөөнийг арилгах нь хамгийн үр дүнтэй байдаг гээд мөргөлдөөний үндэс болж буй шалтаг, ашиг сонирхлын зөрчилдөөнийг арилгах аргуудыг томъёолсон байдаг.²⁴ Үүнд:

- Мөргөлдөөний объектыг алга болгох
- Мөргөлдөөний объектыг талуудад хуваах
- Ээлж дараа тогтоох буюу хоёр тал объектыг хоёулаа ашиглах, дүрэм тогтоох
- Объектыг нөгөө талд шилжүүлж, нөхөн төлбөр авах
- Мөргөлдөгч талуудын харилцааг нийтлэг сонирхол төрүүлэхүйц шинэ салбарт шилжүүлэх зэрэг юм.

Дүгнэлт

Улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн нэг бол мөргөлдөөн бөгөөд Конфликтологи гэсэн салбар шинжлэх ухаан ч үүсчээ. Ерөнхийдөө мөргөлдөөнийг судлахдаа түүний нийгмийг салан бутаргахад чиглэгдэж байна уу эсвэл нэгтгэн нягтруулахад чиглэгдэж байна уу гэдгээс нь хамааруулж үзэж болно. Мөргөлдөөнийг судлахдаа онол арга зүйн үндэслэл, мөргөлдөөний парадигм, судлах зүйл, эх сурвалж, объект, субъект, оролцогчид болон төрөл ангилал, арга хэрэгсэл технологи, стратеги тактикийг тодорхойлж түүнийг шийдвэрлэх, зохицуулах арга замуудыг эрэлхийлэх нь чухал байдаг. Улмаар улс төрийн мөргөлдөөнийг зохицуулах, шийдвэрлэх арга замыг олсноор түүнийг удирдан чиглүүлэх боломжтой.

Манай улсын хувьд улс төрийн мөргөлдөөн судлалын асуудалд анхаарал хандуулах нь ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл нийгмийн тогтвортой, тайван байдлыг судалж танин мэдэх, амьдрал практикт хэрэгжүүлэхийн тулд түүний эсрэг үзэгдэл болох мөргөлдөөнийг судлах хэрэгцээ тулгарч байна. Энэ нь “хэрэв энхийг хүсвэл дайныг судалж танин мэд” гэсэн зарчим юм. Нидерландын судлаач Ванханен 1999 онд 183 улсын талаар харьцуулсан судалгаа хийсэн бөгөөд Монгол улсыг туйлын амгалан орон гэж тодорхойлсон байдаг. Тэрээр мөргөлдөөнийг угсаатны хүчин зүйлд нь тулгуурлан улс орнуудад 0-100 хүртэл оноогоор үнэлгээ өгч судалсан байдаг²⁵. Үүнд:

- 0 оноо. Томоохон угаатны байгууллага байхгүй, улс төрд угсаатны нөлөөллийг төдийлөн ач холбогдолтойд авч үздэггүй
- 5 оноо. Угсаатны намууд Парламент эсвэл Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын арваас багагүй хувийг эзэлдэг, улс төрд угсаатны нөлөөлөл үүсч байгаа, зарим нэг угсаатны бүлгүүд өөр хоорондоо зөрчилдөх байдалд орсон
- 10 оноо. Угсаатны бүлгүүд хүн амын 10-14 хувийг эзэлдэг, угсаатны байгууллагуудад ихээхэн ач холбогдол өгч дэмждэг, улс төрд угсаатны нөлөөлөл өсөх хандлагатай, угсаатны хуваагдал бий болсон
- 20 оноо. Хүн амын дотор угсаатны эзлэх хувь хэмжээ 15-29 хувьд хүрсэн, улс төрд угсаатны нөлөөлөл онцгой өссөн, угсаатны хуваагдал онцгой хурц хэлбэрээр өрнөдөг
- 40 оноо. Угсаатны бүлгийн эзлэх хэмжээ хүн амын 30-49 хувийг бүрдүүлж, угсаатны ашиг сонирхлын мөргөлдөөн нийгмийн амьдралыг тодорхойлдог, улс төрл угсаатны

²⁴ А.Я. Анцупов, А.И.Шипилов “Конфликтология” М., 2000

²⁵ А.В.Дмитриев “Конфликтология” М., 2000

бүлэг, байгууллагууд онцгоы их ач холбогдолтой, төр засгийн түвшинд угсаа гарвалаараа талцах явдал ихэссэн, томоохон угсаатны бүлгүүдэд хүн ам хуваагддаг

- 60 оноо. Хүн амын 50-69 хувь нь угсаатны зөрчилд идэгдсэн, томоохон сонирхлын байгууллагууд угсаатны ялгарал дээр суурилдаг, угсаатны зөрчил мөргөлдөөн, мөргөлдөөний бусад хэв шинжээс давамгай байдалтай байдаг, засгийн газрын байгууллагад угсаатны бүлгийн эзлэх хувь хэмжээ өндөрсөн
- 80 оноо. Бүх сонирхлын байгууллагууд угсаатны шугамаар бий болдог, хүн амын 70-89 хувь нь угсаатны зөрчилд идэгдсэн, улс төрийн хүрээнд угсаатны нэг нам ноёрхох байдалтай, угсаатны мөргөлдөөн онцгой хурц хэлбэрээр өрнөдөг
- 100 оноо. Хүн амын 90-100 хувь нь угсаатны зөрчилд идэгдсэн, томоохон сонирхлын байгууллагууд нь угсаатны шугамаар бий болдог, сонирхлын бүлгүүдийн хоорондох зөрчил мөргөлдөөн нь угсаатны шугамаас үүдэн бий болдог

Хэдийгээр энэ судалгаагаар Монгол угсаатны асуудалгүй, улс төрийн мөргөлдөөн туйлын бага орон гэж нэрлэгдэж байгаа ч манай улсад улс төрийн мөргөлдөөн үүсч болох гадаад болон дотоод нөхцөл байдлыг анхааран үзэх нь чухал. Үүнийг дараах байдлаар авч үзэж болох юм. Үүнд:

1. Гадаад нөхцөл байдал. Хүйтэн дайн төгсгөл болж, өрнө дорнын хоорондох түгшүүрт байдал намжсан нь дэлхийн тавцанд цоо шинэ нөхцөл байдал бүрдүүлж олон улсын харилцаанд олон субъектүүд бие даан оролцох болсон. Мөн удаан хугацаанд далд байсан үндэстний, угсаатны, шашны, эдийн засгийн, соёл иргэншлийн, улс орнуудын доторхи улс төрийн мөргөлдөөнүүдийг ил болгож улмаар эдгээр нь олон улсын харилцаанд нөлөөлөхүйц болсон байна. Дэлхий нийтээрээ глобалчилалд орж аль нэг улс орон эндээс өөрийгөө тусгаарлан авч үлдэж чадахааргүй болсон. Энэ нь улс орны дотоод асуудал болон олон улсын харилцаанд маш хүчтэй нөлөөлж байна. Ийм нөхцөлд олон улсын болон бүс нутгийг хамарсан улс төрийн мөргөлдөөн, түүний нөлөө манай улсыг тойрон өнгөрөхгүй нь ойлгомжтой.
2. Дотоод нөхцөл байдал. Хэдийгээр манайд угсаатны, шашны зэрэг томоохон асуудлууд байхгүй гэж үзэж байгаа боловч Монголын улс төрийн системд намуудаас гадна, төрийн бус байгууллагууд, иргэний хөдөлгөөн зэрэг ашиг сонирхлын бүлгүүд идэвхитэйгээр оролцож байгаа явдал зэрэг нь дотоод нөхцөл байдлыг бүрдүүлж болох юм.

Abstract:

In order to aware the nature of political conflict, it is essential to study its theoretical and methodological aspects and practical significances. In the course of the development of political thoughts, theoretical and methodological basis of this concept were formed. K. Marx, M. Weber, G. Simmel, T. Parsons, R. Dahrendorf and S. Huntington studied the concept in detail and developed it theoretically. Particularly, K. Marx concepted that the political conflict is a source of social revolution and development, while T. Parsons believed that by treating the conflict as a social disease, social consensus and integrity are ensured. Also, there are numerous concepts that explain the conflict from the point of view of its creativeness, and the paradigm for the study of the political conflict has been formed during the studies of the above researchers. Studying the ways to investigate, recognize, resolve and moderate such political conflicts allows the people to manage them properly.

Keywords: Political conflict, Paradigm of conflict, Study of conflict, Role of the state, Methods of managing and resolving conflict

Ашигласан ном, материал

1. МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” сурах бичиг УБ., 2014
2. Lewis A.Coser “The Functions of Social Conflict” 1956
3. А.В.Дмитриев “Конфликтология” Учебное пособие М.,2000
4. К.Маркс, Ф.Энгельс “Сочинение” М.,1961
5. А.Я.Анцупов, А.И.Шипилов “Конфликтология” М.,2000
6. “Государство и право” М., 1995
7. Р.Дарендорф “Современный социальный конфликт” иностранная журнал., 1990 №5
8. П.А.Цыганков “Гаролдки” М., 2002
9. Ж.Т. Тощенко “Политическая социология” М., 1999
10. А.Д. Здравомыслов “Социология конфликта” М., 1996

ҮНДЭСНИЙ АДИЛСАЛ

М.Мөнхзул

ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургууль,
Нийгмийн ухааны тэнхимийн дэд профессор

Г.Уянга

ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургууль,
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд орчин үеийн улс төр судлалын судалгааны ажлын хүрээнд “адилсал”, “үндэсний адилсал” гэсэн ойлголтуудыг авч үзэх болно. Эдгээр ойлголтуудыг бүрдүүлэгч хэсгүүд болон тэдгээрийн шинж чанаруудыг тодруулав.

Түлхүүр үгс: үндэстэн, адилсал, үндэсний адилсал.

Үндэсний адилсал буюу үндэсний өөрийн ухамсар нь үндэсний болон угсаатны шинжийг бүрэлдүүлдэг онцлогтой нь холбоотой тухайн хүний өвөрмөц байдал юм. Хэдийгээр үндэсний адилсал хэмээх ойлголт нь “иргэншил”, “үндэстэн” гэсэн ойлголтууд ойролцоо боловч түүнийг бүрдүүлэгч хүчин зүйлсүүд нь өөр юм. Юуны өмнө “адилсал”, “үндэсний адилсал” гэсэн ойлголтуудыг авч үзэх хэрэгтэй. Үүний тулд:

- Identity хэмээх нэр томъёоны тодорхойлтуудыг авч үзэх
- Үндэсний адилсал хэмээх ойлголтын мөн чанарыг авч үзэх

Үндэсний адилсал нь тухайн үндэстний уламжлал, соёл, хэлээр илэрхийлэгддэг цогц ойлголт юм¹. Үндэсний адилсал нь хүний иргэний харъяалалаас үл хамааран бүлэг хүмүүстэй хуваалцдаг үндэсний мэдрэмж байж болно. Үндэсний адилсал нь “тэд”, “бид”, “ялгаатай байдлаа мэдрэх” зэрэг сэтгэл зүйн онцлог юм².

Сүүлийн үед судлаачид энэ асуудалд анхаарлаа хандуулж байгаа бөгөөд үүнийг хэд хэдэн нөхцөл байдалтай холбон тайлбарлаж болно. Адилсалын асуудал нь даяаршлын нөхцөлд хоёрдмол утгатай, зөрчилдөөнтэй, шинж чанараараа огт өөр утгатай болж байна. Энэ ойлголтыг тайлбарладаг аргууд ч өөрчлөгдсөн. Энэхүү асуудлыг судалснаар соёл иргэншлийн онцлог, шинж чанарыг тодорхойлох боломжтой болох бөгөөд энэ нь адилсал үүсэх нөхцлийг бүрдүүлдэг. Шинжлэх ухааны судалгааны бүтээлүүдээс үзэхэд адилсалын тухай олон тодорхойлолт байдаг. Эртний Грекийн үеэс эхлээд өнөөгийн өрнөдийн философийн бүтээлд “адилсал” хэмээх нэр томъёог хэрэглэж ирсэн байна. Identity нь латин хэлний “таних” гэсэн үгнээс гаралтай. Сэтгэл судлаачид адилсалыг субъект нь өөрийгөө өөр субъектүүдэд хамааруулан үзэхийг хэлнэ гэж томъёолдог. С.Хантингтон адилсал нь хувь хүн юмуу бүлэг нь өөрийгөө ухамсарлахуй гэж үзсэн³. Харин психоанализмын хүрээнд З.Фрейд адилсалыг “эго буюу би” гэж үзсэн. Адилсах үйл явц нь хувь хүний төлөвшил бөгөөд хувь хүн өөр субъектүүдтэй өөрийгөө адилтган үзэх туршлага юм⁴.

¹ . Искусство и цивилизационная идентичность. Н.А.Хренов. «История мировой культуры». М.,2007. Стр. 603

² Definition of National Identity in English Oxford Dictionary.

³ Хантингтон С. Кто мы? Вызовы американской национальной идентичности. М.2004. Стр. 635

⁴ Фрейд З. Психология масс и анализ человеческого “Я” [Электронный ресурс]

<http://www.magister.msk.ru/library/philos/freud001.htm>.
19.02.2020.

Э.Эриксон адилсалыг хувь хүний өөрийгөө танин мэдэх үйл явцын түүхэн удамшил гэж үздэг⁵. Э.Эриксоны үзлээр адилсал нь хоёр түвшинд илэрдэг. Эхний түвшин нь хувь хүн өөрийгөө бүлэгтэй ижилсүүлэх цаг хугацаа, орон зайны тасралтгүй үргэлжлэх оршихуй. Хоёр дахь түвшин нь бусдад хүлээн зөвшөөрөгдөх явдал. Дээрх хоёр түвшний эерэг тал нь хүн нийгмийн орчинд ямар байр суурьтай байхыг онцолсон, сөрөг тал нь хүн ямар байх ёсгүйг хэт хатуу баримталсан байдаг. Хэрвээ нийгэм дэвшилттэй хөгжилтэй бол эерэг тал нь давамгайлах боломжтой. Адилсах үйл явц нь үнэлэмжийн төлөвшилттэй ижил гэж Э.Эриксон үзсэн байна. Ижилсэх хэрэгцээ дууссан үед өөрийгөө таниулах хэрэгцээ эхэлдэг. Энэ нь хүн хүүхэд насандаа ижилсэх хэлбэрийг өөртөө шингээснээс үүсэх бөгөөд цаашлаад хувь хүн нийгэмд таниулах хэн болох ёстойгоо мэдэх үйл явцаас эхэлдэг. Э.Эриксоноос өмнө Ж.Г.Мид “Би”-гийн хоёр үе шатны (хувь хүн ба бусдын өөртөө хандах хандлага) хоорондын эмпирик харилцааг илрүүлэхийг оролдсон⁶. Түүний энэхүү санааг Ю.Габермас цааш нь үргэлжүүлсэн. Хувь хүний бусадтай харилцах нь түгээмэл шинжтэй⁷.

“Адилсал” гэдэг ойлголтын талаар Английн социологич А.Гидденсийн боловсруулсан хоёр туйлт тайлбар байдаг. Нэг талаас дасан зохицох үнэмлэхүй чадвар, нөгөө талаас өөрийгөө бусдаас тусгаарлах чадвар юм. Түүний үзлээр өөрийгөө таних чадвар нь хүний сэтгэл зүйн давхаргад суурилсан байх ёстой⁸.

Үндэсний адилсалын тухай асуудал судалгааны олон бүтээлд дурдагддаг. В.Кочетков “Орчин үе дэх үндэсний болон угсаатны адилсал” хэмээх бүтээлдээ үндэсний адилсалыг психоанализмын үүднээс авч үзсэн байдаг. Үүндээ орчин үеийн нийгмийн бүрдүүлж хөгжүүлэхэд адилсалын ач холбогдлыг үнэлсэн байна. Тэрээр үндэсний адилсалыг хувь хүний өөрийн үндэстэн, үндэсний төртэй харилцах харилцааны хариу үйлдлийг тусгасан соёлын хэмжээ гэж тодорхойлсон⁹.

Түүнчлэн Ю.А.Кожевников “Даяаршиж буй ертөнц дэх үндэсний адилсалын хямрал” бүтээлдээ үндэсний адилсалыг янз бүрийн “хэмжээ” болон “шинж чанар”-ын хослолоор авч үзсэн. Үндэсний адилсал нь цогц, олон талт, нийгмийн үзэгдэл гэж толорхойлогддог. Үндэсний адилсал нь сэтгэл зүй, соёл, түүх, нутаг дэвсгэр, улс төрөөр дамжин бэлгэдлийн үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээрээ өөрийн гэсэн үндэсний соёл, ёс суртахуун, нийгмийн үнэт зүйлс, соёлын хэм хэмжээ, үзэл санааг бий болгох үндэсний нийгэмлэг болдог. Үндэсний адилсал нь бодит байдал дээр янз бүрийн нөлөө, өөрчлөлтөнд өртөж байдаг. Мөн цааш үндэсний адилсал нь тухайн үндэстэнд харъяалагддаг хүмүүсийн хооронд байдаг “чухал шинж чанаруудын нэгдэл” гэж тэмдэглэжээ¹⁰.

Үндэсний эрх ашгаа дээдлэх энэхүү үндэсний үзлээс үндэсний адилсалаа тодорхойлох эх сурвалж бий болно. Үндэсний адилсалыг хөндлөнгөөс нь тогтоохдоо хэл, соёл, гадна төрх зэрэг байдал дээр үндэслэдэг хэдий ч хамгийн чухал нь дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар тогтносон үндэстэн байх явдал юм. Учир нь үндэсний адилсал нь хувь хүн аль нэг үндэстэнд харъяалагдах гол хүчин зүйл бөгөөд өөрийгөө адилтгах явдал юм. Үндэсний өөрийн ухамсрын улс төрийн шинж нь хүмүүсийн хувийн чанар, тухайн үндэстэн-ястны, үндэстэн-угсаатны, улс төрийн хамаарлаа ухамсарлах үндэсний адилсалд суурилдаг байна. Үндэсний адилсал, угсаатны адилсал, угсаатны гарал үүсэл зэрэг нь XX зууны дунд үеэс шинжлэх ухаанд нэвтэрсэн цоо шинэ ойлголтууд юм.

Үндэсний адилсал нь улс төрийн онцлог, эзэнт гүрэн, улс төрийн соёл, иргэншил, эх оронч үзэл зэргийг хэсэгчлэн хамарсан олон хэмжээст түүхэн ойлголт юм. Үүнийг ойлгохын тулд үндэстэн өөрийгөө танин мэдэх хэрэгтэй. Үндэсний адилсал нь нийгмийн

⁵ Эриксон Э. Идентичность: юность и кризис. М. 1996. Стр. 344

⁶ Мид Дж. Дух, самисть и суспильство з точки зору социального бихевиориста. – К.: Украинский центр духовное культуры, 2000. Стр 123-127.

⁷ Габермас Ю. Философский дискурс Модерну. – К.: Четверта хвиля, 2001. Стр 290

⁸ Giddens A. Modernity and Self – Identity / A/ Giddens. – Stanford, 1991. – P. 47.

⁹ Кочетков В. В. Национальная и этническая идентичность в современном мире. М. 2012. Стр. 214-227.

¹⁰ Кожевникова Ю.А. Кризис национальной идентичности в глобализирующемся мире. М., 2012. –Стр. 22

бүрэн бүтэн байдал, төрийн оршихуйн асуудалтай шууд холбоотой. Хүмүүсийг нийтлэг соёл, түүх, газар нутаг, хуувь тогтоомжууд нэгтгэдэг. Эдгээр нь хүмүүсийн бэлгэдлийг бэхжүүлдэг. Аливаа улс үндэстний хүмүүс бүгд бие биенийгээ танихгүй, магадгүй бүх газар нутгаараа явж үзээгүй ч гэсэн бэлгэдлээрээ төр улсынхаа дүр төрхийг төсөөлдөг.

Үндэсний адилсал нь хүүхэд байх үеэс сэтгэцийн хөгжлийн үе шаттай уялдан хэд хэдэн шатыг дамжин үүсэж хөгждөг. Пиаже үндэстэнд хамаарагдах хүүхдийн ухамсрыг (хүүхдийн үндэсний өөрийн ухамсрыг) хөгжүүлэх үзэл баримтлалыг дэвшүүлсэн хүмүүсийн нэг юм. Пиаже хүүхдэд угсаатны онцлог нь хөгжих 3 үе шатыг тодорхойлсон байдаг. 6-7 насандаа хүүхэд өөрийн үндэс, угсааны талаарх анхны, хэсэгчилсэн, системгүй мэдлэгийг олж авдаг. 8-9 насанд хүүхэд өөрийгөө угсаатны бүлэгтэйгээ ижил хэмжээнд тодорхойлдог. 10-11 насанд угсаатны адилсал нь бүрэн бүрэлдэн тогтож¹¹ цаашдаа өдөр тутмын соёлын онцлогоосоо шалтгаалаад үндэсний адилсал нь хөгждөг байна.

Үндэсний адилсал нь хэн болохоо танихаас гадна түүний үнэлгээ, гишүүнчлэлийн ач холбогдлыг илэрхийлдэг бол харин “айдас, нэр төр, бардамнал, дургүйцэл нь угсаатнуудын хоорондын шалгуур юм”¹². “Эдгээр мэдрэмжүүд нь тухайн угсаатны сэтгэл хөдлөл, ёс суртахуунтай нь гүнзгий холбоотой бөгөөд хувь хүн төлөвших явцад үүсэн бий болдог байна”¹³. Үндэсний адилсал нь үндэсний өөрийн ухамсарт чухал үүрэгт гүйцэтгэдэг. Тухайлбал, “хүн төрөлхтний түүхийн эртний үед үүссэн өөрсдийнхөө гарал үүслийг ямар нэгэн амьтантай зүйрлэдэг сэтгэл зүйгээс эхлэн өөрийгөө ухамсарлах ухамсар бий болсон байна”¹⁴.

Үндэсний адилсал нь зан үйлийн онцлогийг илэрхийлсэн нийгмийн шинж юм. Тэр нь дотроо өөрийн үндэстний онцлогийг илэрхийлсэн ухамсрын талаарх мэдлэг, өөрийн үндэстнийг үнэлэх гишүүнчлэлийн ач холбогдол гэсэн танин мэдэхүйн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Үндэсний адилсал хүний амьдралын туршид ихэвчлэн өөрчлөгддөггүй, хөдөлгөөнгүй хэвээр хадгалагддаг ба ямар ч насны хүн өөрийгөө ухамсарлахад түлхэц болж өгдөг. Зарим угсаатны сэтгэл судлаачид “үндэсний адилсалыг үндэстний хамгийн чухал шинж тэмдэг хэмээн онцолдог байна”¹⁵. Угсаатны адилсалын эерэг хандлага нь угсаатны мэдрэмжид тулгуурласан сэтгэл ханамж, хүсэл бахархал, амжилт бүтээлээр илэрдэг. Харин сөрөг хандлага нь өөрийн угсаатны онцлогийг буруушаах, мэдрэмжийг үгүйсгэх, доромжлох, бусад угсаатан, ард түмнийг илүүд үзэх шинжээр илэрдэг. Үндэсний адилсалын гол шинж нь үндэстэн өөрийгөө үнэлэх үнэлэмжээс өөрийгөө ухамсарлах ухамсар билээ. Мөн эцэст нь “хувь хүний өөрийнх нь чадвар, угсаатны үүргийг үнэлэх байдал, бусад ард түмнүүдийн дунд үндэстнийхээ ач холбогдлыг үнэлэх үнэлэмж маш чухал”¹⁶.

Орчин үед “адилсал”-д дүн шинжилгээ хийж, шинжлэх ухааны судалгаанд өргөн ашиглаж байна. Энэ нь ч санамсаргүй зүйл биш. “Даяаршлын эрин үе дэх улс төр, эдийн засаг, соёлын өөрчлөлтөөс шалтгаалж хүний амьдрал, үйл ажиллагааг олон талаас нь судалдаг судлаачид тэднийг дагасан олон үзэл баримтлалтай холбоотой”¹⁷. Судлаачдын гаргасан ажлын агуулгатай танилцаж түүнд дүн шинжилгээ хийхэд “үндэсний адилсал”, “үндэсний өөрийн ухамсар”-ийн тухай ойлголтуудыг янз бүрээр илэрхийлсэн байдаг. Тухайлбал, В.Ю.Хотинец үзлээр “угсаатны адилсалыг угсаатны өөрийн ухамсрын өндөр түвшний үзүүлэлт гэж үзэх хэрэгтэй”¹⁸ болж байна. Тэгвэл эсрэгээрээ “угсаатны өөрийн

¹¹ Вальцев С. В. Факторы формирования национальной психологии // Проблемы современной науки и образования. 2012. № 2 (2). Стр. 20-22.

¹² Солдатова.Г.У. Психология межэтнической напряженности. М.,1998. Стр 75

¹³ Мөн тэнд. Стр 49

¹⁴ Поршнев Б. Ф. Социальная психология и история. М., 1979. Стр. 83.

¹⁵ Бромлей Ю. В. Очерки теории этноса. М., 1983, Стр. 45-48.

¹⁶ Крысько В. Г. Этнопсихология и межнациональные отношения. Курс лекций. – М., 2002, Стр.109

¹⁷ Бауман.З. Идентичность в глобализирующемся мире // Бауман, З. Индивидуализи/ рованное общество : пер. с англ. М.,2002. Логос. Стр.390

¹⁸ Хотинец.В.Ю. Этническое самосознание. СПб. : Алетейя.,2000. Стр.240

ухамсрын гол шинж үзүүлэлт нь угсаатны адилсал бөгөөд тэр нь илүү өргөн ойлголт”¹⁹ гэж үзэх хандлага бий. Т.Г.Стефаненко угсаатны адилсал нь тухайн хүний нийгмийн танин мэдэхүйн салшгүй нэгэн хэсэг болохынхоо хувьд тухайн угсаатны төлөөлөгчийн хувьд сэтгэл хөдлөл, өөрийгөө ухамсарлах үйл явцын үр дүн гэж үздэг. В.Н.Павленко үүнтэй төстэй байр суурийг баримталж угсаатны адилсал нь тодорхой нийгэмд гишүүнчлэлтэй байх явдал бөгөөд зөвхөн сэтгэл хөдлөлийн ухамсар төдий биш юм. “Ер нь энэ бол нэлээн төвөгтэй үзэгдэл бөгөөд үүнд танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлөөс гадна зан үйл ч орно”²⁰. Хувь хүн өдөр тутмын амьдралдаа соёл, дадал зуршлаас гадна тухайн угсаатны гишүүн болохоо байнга батлан харуулж байдаг.

Үндэсний адилсал нь нийгэм, улс төрийн бодлогыг тодорхойлж, үндэстэн өөрийгөө танин мэдэх зорилгыг бий болгож байх ёстой. Үндэсний адилсалын шинж чанарын бүрдэл нь дараах агуулгыг илэрхийлдэг.

1. Нийгэм-үндэсний (хэл, соёл, эдийн засаг, өдөр тутмын үйл ажиллагаа)
2. Улс төрийн-үндэсний (төрийн эрх мэдэл, төрийн байгууллагууд, хил, арми, төрийн тэргүүн, төрийн харяалал, сүр сүлд)

Дээрх хоёр бүрэлдэхүүн нь үндэсний адилсалыг тодорхойлдог байна.

Үндэсний адилсал бол зөвхөн архив, уламжлал, нутагшилт төдийгүй олон түмнийг орчин үеийн ертөнцөд нэгтгэх арга хэрэгсэл юм. Тийм учраас үндэсний адилсалыг шинжилж, үнэлэх, цаашлаад даяаршлын үйл явц дахь үндэсний адилсалыг судлах шаардлагатай байгаа. Даяаршлын нөхцөлд үндэсний адилсал үүсэх нь нэг талаас тусгаар тогтнол, бусад үндэстэн-угсаатнуудаас хол байх, үндэсний нэгдмэл “Би”-гээ хайх, нөгөө талаас даяаршсан нийгэмд өөрийн байр сууриа илэрхийлэх өрсөлдөөнд оролцох замаар тодорхойлогддог.

Орчин үед үндэсний адилсал нь үндэстэн болж байна. Хэдий тийм боловч үндэсний адилсалыг тодорхойлдог хэлбэрүүд нь холбоотой байсаар байна. Тиймээс даяаршлын нөхцөлд үндэсний адилсал нь субъектив хүчин зүйлсийн ялгарал, хуваагдал, нэгдлийн системтэй үйл явц болдог. Үндэсний адилсалын үйл явц дахь нарийн төвөгтэй байдал нь соёлын олон талт байдал, бэлгэдэл нийгэм, улс төрийг бодит байдалд нийцүүлэхэд оршино. Тиймээс өнөөгийн даяаршсан ертөнцөд үндэсний адилсалыг судлах нь нийгэм-танин мэдэхүйн болоод онол арга зүйн ач холбогдолтой. Учир нь үүнийг социологийн бие даасан томоохон судалгаа, хэлэлцүүлэгтэй адил томъёолж болно.

Үндэсний адилсал нь олон талт шинж чанартай бөгөөд үүнийг хэзээ ч нэг бүрдэл хэсэгт оруулж үзэж болдоггүй. Үндэсний адилсалыг бий болгож бүрдүүлэх үйл явц нь мөн чанарын хувьд субъектив тул цаг хугацааны явцад байнга өөрчлөгдөн хувьсаж байдаг. Орчин үеийн шинжлэх ухаан болон олон нийтийн цахим ертөнцөд “үндэсний асуудлууд” дахин сөхөгдөж байна. Энэ нь дэлхийн интеграцилах үйл явцтай холбоотой. Дэлхийн соёл, эдийн засгийн нөлөөн дор үндэстнүүд бүрмөсөн алга болох, эсвэл өөр шинэ шинж чанаруудыг олж авч байгаа өнөөгийн нөхцөлд үндэсний төр улсыг ойлгох зөрчилтэй үзлүүд ч мөн бий болж байна.

Дүгнэлт

Үндэсний адилсал нь нийгмийн харилцаанд хамгийн их хэрэглэгддэг зүйл юм. “Адилсал” хэмээх нэр томъёо нь XX зууны төгсгөлд улс төрийн философийн хүрээнд анх ашиглагдсан байна. Үндэсний адилсал үндэсний залгамж чанар, тогтвортой байдал, үндэс угсаа, үндэстэн өөрийгөө танин мэдэх, ухамсарлах гэсэн ойлголтуудтай холбоотой бөгөөд тодорхой хэмжээгээр дээрх шинж чанаруудыг агуулсан байдаг. Үүнийг хувь хүний хил хязгаараас давж нийгэмд өөрийгөө тодорхойлох гэж ойлгож болно.

¹⁹ Стефаненко, Т.Г. Этнопсихология : учебник для вузов. М, 2004. Аспект Пресс. Стр. 368

²⁰ Павленко, В.Н., Таглин, С.А. Общая и прикладная этнопсихология. М., 2005. Товарище/ство науч. изд. КМК. Стр. 483

Резюме

Национальная идентичность — наиболее часто используемая категория в анализе общественного взаимодействия, социальной коммуникации. Данный термин окончательно закрепился в социально-философском дискурсе в конце XX в. Национальная идентичность ассоциируется с понятиями самобытности, преемственности, устойчивости, отождествления и осознания своей этнической и национальной принадлежности и характеризуется качественной определенностью. Ее сущность выходит за границы отдельной личности и затрагивает самоидентичность социальной системы.

Abstract. National identity may refer to the subjective feeling individual shares with a group of people about a nation.

Keywords: national, identity, nation state

Ашигласан ном, материал

1. Искусство и цивилизационная идентичность. М. 2007.
2. Кожевникова Ю.А. Кризис национальной идентичности в глобализирующемся мире. М., 2012.
3. Кочетков В. В. Национальная и этническая идентичность в современном мире. М., 2012
4. Фрейд З. Психология масс и анализ человеческого “Я” [Электрон ном] <http://www.magister.msk.ru/library/philos/freud001.htm>.
5. Хантингтон С. Кто мы? Вызовы американской национальной идентичности. М. 2004.
6. Эриксон Э. Идентичность: юность и кризис. М. 1996.
7. Габермас Ю. Философский дискурс Модерну. М., 2001.
8. Мід Дж. Дух, самість і суспільство з точки зору соціального біхевіориста. – К.: Український центр духовної культури, 2000.
9. Definition of National Identity in English Oxford Dictionary [Электрон ном]. – https://www.lexico.com/en/definition/national_identity.
10. Giddens A. Modernity and Self – Identity / A/ Giddens. – Stanford, 1991.

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 227-234 дэх тал

**УЛС ТӨРИЙН ПАТРОНАЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ИНСТИТУЦИОНАЛ
ХАНДЛАГА**

Н.Отгонбаяр

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн докторант

Л.Билгүүнтөгс

Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийн докторант

Хураангуй:

Ардчилсан улс төрийн тогтолцоо бүрэлдэн бий болоход төрийн алба томоохон үүрэг гүйцэтгэдэг байна. Үүнтэй холбоотойгоор төрийн албаны мэргэшсэн байдлыг хангахад тулгарч буй томоохон сорилтын нэг нь улс төрийн патронаж юм. Өгүүллийн хүрээнд судлаачид улс төрийн патронаж, түүний институционал хандлагын талаар цэгцтэй ойлголт өгөхийг оролдсон болно.

Түлхүүр үгс: Улс төрийн патронаж, төрийн албаны томилгоо, клиентелизм, патрон-клиэнтийн харилцаа.

I. Оршил

Аливаа улс орон хөгжих, уруудан доройтох үйл явц юуны түрүүнд, төрийн албаны үйл ажиллагаатай нягт холбоотой байдаг. Энэ ч утгаараа дэлхийн улс орнуудад төрийн мэргэшсэн албыг бүрдүүлэх зорилгоор өөрчлөлт, шинэтгэлийн үйл явцыг өргөн хүрээнд авч хэрэгжүүлж буй дүр зураг ажиглагдаж байна. Монгол улсын хувьд төрийн мэргэшсэн албыг төлөвшүүлэх зорилго бүхий шинэтгэл 1990 оноос эхэлсэн гэж үздэг ба өнөөг хүртэлх хугацаанд хэд хэдэн үе шаттай хэрэгжиж иржээ (Ц. Самбалхүндэв, Д. Байгал, 2009). Харамсалтай нь, үр дүн хангалтгүй, хэрэгжилт муу байна. 2009-2019 оны хооронд төрийн нийт албан хаагчдын тоо 34%-иар нэмэгдсэн хэрнээ мэдлэг, чадвараар уралдаант сонгон шалгаруулалт (ерөнхий болон тусгай)-ад орж, өндөр оноо авсан иргэд төрийн албанд томилогдох механизм бүрэн төлөвшиж чадахгүй байгааг Дэлхийн банкны судалгааны тайланд дурджээ (Дэлхийн Банк, 2020).

Төрийн мэргэшсэн албыг төлөвшүүлэх чиглэлд онцгой ач холбогдол өгч буй өнөө үед судлаачдын анхаарлын гадна байж боломгүй асуудлын нэг нь улс төрийн патронаж юм. Улс төрийн патронаж харилцаа Монгол улсын төрийн албанд бодит үзэгдэл болсон. Тухайлбал, 1996 оны сонгуулийн дараа “баг бүрдүүлэх”, 2000 оны сонгуулийн дараа “бүтцийн өөрчлөлт хийх”, 2004 оны сонгуулийн дараа “зөвшилцөл хийх”, 2012 оны сонгуулийн дараа төрийн өмчит болон төсөвт үйлдвэрийн газар олноор байгуулж, мэргэшсэн албан хаагчдыг шилжүүлэн байршуулах, тэрчлэн “үүрэг гүйцэтгэгч” нэрийн дор улс төрийн зорилгоор халаа сэлгээ хийх, албан тушаал хуваарилах үйл явц эрчимжсэн (Удирдлагын Академи, 2014). Төрийн албаны зөвлөлөөс жил тутам гаргадаг албан ёсны тайланд дурдсанаар, 2007 онд төрийн нийт албан хаагчдын 5.2% хууль бус халаа, сэлгээнд өртөж байсан бол 2012 онд уг тоо 9.3%, 2013 онд 11.52%, 2014 онд 13.09%, 2015 онд 13.35%, 2016 онд 14.23%, 2017 онд 15.5% болж тус тус өсчээ. 2019 он гэхэд төрийн захиргааны албан хаагчдын 22.3% нь хууль зөрчсөн халаа, сэлгээнд өртсөн байна (Дэлхийн Банк, 2020). Ерөнхий бүтцийг судлан үзвэл, өөрийн хүсэлтээр, өөр байгууллагад шилжсэн, бүтцийн өөрчлөлт гэх үндэслэлээр шилжилт хөдөлгөөнд орох явдал их байгаа нь улс төрийн патронажийн харилцааны илрэл юм.

Хэдийгээр гадны улс орнуудад уг асуудлаар олон тооны өгүүлэл, нэг сэдэвт бүтээл нийтлэгдэж буй боловч Монгол улсын төрийн албаны зохион байгуулалт дахь улс төрийн патронаж харилцаа, шалтгаан, үр дагавар, институционал хандлагын талаар хийгдсэн судалгаа бага, энэ чиглэлд судалгаа хийх хэрэгцээ, шаардлага байгааг дурдах байна. Энэ талаар судлаач Д. Оюунсүрэн, Ж. Диркес, Л. Бямбаханд (Oyunsuren, Dierkes, and Byambakhand) нарын зүгээс “Монгол бол улс төрийн патронажийн нэлээд сонирхолтой тохиолдол болно. /.../ Монгол хэлнээ патронажийн чиглэлээр судалгааны бүтээлүүд гараагүй гэдэг нь уг үзэгдэл байхгүй гэсэн үг огтоос биш юм” (Oyunsuren, Dierkes, & Byambakhand, 2023, pp. 121, 122) хэмээн бичсэнтэй санал нэг байна.

Өгүүллийн хүрээнд төрийн албаны зохион байгуулалт дахь улс төрийн патронаж, үндсэн ойлголт, институционал хандлагыг гадна, дотны судлаачдын бүтээлд тулгуурлан тоймлон гаргахыг оролдсон болно.

II. Онолын судалгааны үр дүн

Үндсэн ойлголт, тодорхойлолт

Аливаа үзэгдэл, үйл явцыг танин мэдэхийн тулд тухайн судлах гэж буй үзэгдлийг илэрхийлсэн ойлголтыг тодорхой болгох хэрэгцээ, шаардлага үүснэ.

Манай улсад судлаачдын нэг сэдэвт болон орчуулгын бүтээлүүдэд улс төрийн патронаж (political patronage), клиентелизм (clientelism) гэх ойлголтуудыг ижил утгаар хэрэглэж буй хандлага байна. Ялангуяа Михал Клима (Klima)-гийн бүтээл (Клима, 2017) Монгол хэлнээ орчуулагдан гарсны дараа нэлээд хүчтэй болсон. Гэвч улс төрийн патронаж, клиентелизм нь үгзүйн гарвал болон утга зүйн хувьд харилцан ялгаатай ойлголт гэдгийг дурдах байна.

Судалгааны бүтээлүүдэд клиентелизм гэдгийг үйлчлүүлэгчдийн (их төлөв эдгээрийг клиент гэж нэрлэдэг) зүгээс үнэнч байдлыг чухалчлах, хариуд нь ивээгчийн (ихэвчлэн эдгээрийг патрон гэж нэрлэдэг) зүгээс зан үйл, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчин тэдэнд байгууллагын нөөцөд нэвтрэх, өмгөөлөл, хамгаалал хүртэх боломж олгодог далд хэлбэрийн босоо харилцаа бүхий удирдлага-зохион байгуулалтын үзэгдэл мөн гэж үзсэн байдаг (Харитонов, 2013). Улс төрийн патронажийг бодвол клиентелизм илүү өргөн хүрээтэй, илүү нийгэм рүү чиглэсэн, хамгийн гол нь, төрийн бараа, ажил, үйлчилгээг солилцох зорилготой юм (Petr Kopecký, Peter Mair, Maria Spirova, 2012). Харин улс төрийн патронажийн хувьд мэргэжлийн толь бичиг болон судлаачдын зүгээс харилцан адилгүй байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, Америкийн Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбооноос эрхлэн 2011 онд хэвлүүлсэн «Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь»-д Айсэнгүл Комсуоглу (Komsuogly) “... дэмжлэг, тусалцаа үзүүлсэнийх нь төлөө ивээн тэтгэгчийн зүгээс үйлчлүүлэгч этгээдэд төрийн нөөцийг ашиглан үйлчилгээ үзүүлэх юм уу, ажлын байр санал болгох практик ...” мөн гэж патронажийг тодорхойлоод “патронаж, клиентелизмийг адилтган” үзэх явдал байдаг ч тусдаа ойлголт болохыг дурджээ (Aysegül Komsuogly, 2011, p. 1199).

Оксфордын Их Сургуулиас эрхлэн 2022 онд хэвлүүлсэн «Төрийн захиргааны Оксфордын тайлбар толь»-д Франческо Пэницца, Гай Питэрс, Конрадо Р. Ларрабүрү (Panizza, Peters, & Larraburu) нар улс төрийн патронажийг засаглалыг “...бий болгох, дэмжиж, тэтгэх зорилгоор улс төрчдийн зүгээс ашиглах арга хэрэгсэл мөн” гэж үзээд “төрийн албаны сонгуульт бус албан тушаалд өөрт үнэнч хүмүүсийг томилох улс төрийн тоглогчдын онцгой эрх...” (Francisco Panizza, B. Guy Peters, & Conrado Ramos Larraburu, 2022) хэмээн тодорхойлжээ.

Конрад Аденауэр Сангийн хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2022 онд хэвлэгдсэн «Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь»-д судлаач Я. Төгөлдөр (2022) улс төрийн “... патронаж нь төрийн албан тушаалд өөрийн аялдан дагагчид болон намын гишүүдийг томилох үйл явцыг хэлнэ. (...) Ийм үзэгдэл ихэнхдээ аж үйлдвэр сул хөгжсөн, уламжлалт соёлтой, иргэний нийгэм болон улс төрийн байгууллагууд нь инстүүцийн төлөвшилийг хангаагүй үед ажиглагддаг байна. (...) төрийн албаны хүний нөөцийн

бүрдүүлэлтэд нөлөөлж, мерит зарчим, шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчмууд алдагдах, төрийн удирдлагын тогтворгүй байдлыг бий болгох сөрөг үр дагавартай үзэгдэл” мөн (Төгөлдөр, 2022) гэж тайлбарласан.

Мэргэжлийн дээрх толь бичгүүдээс гадна судлаачид улс төрийн патронажийн талаар янз бүрийн тодорхойлолт гаргасан байна. Үүнийг дараах байдлаар нэгтгэсэн болно /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Патронажийн талаарх судлаачдын тодорхойлолтууд

№	Судлаачид, он	Тодорхойлолт
1	Лэйдэн Их Сургуулийн профессор Ханс Дальдэр /Daalder, 1966/	Улсын юм уу хагас улсын салбарт улс төрийн намууд “нэвтрэх үйл явц” мөн
2	Корнэлл Их Сургуулийн профессор Мартин А. Шефтэр /Shefter, 1977/	Улс төрийн дэмжлэг үзүүлсэнийх нь хариуд улс төрчдийн зүгээс сонгогчид, дэмжигчид болон өөрийн намын гишүүдэд хуваарилж өгөх олон янзын ашиг тус
3	Флорэнц дахь Европын Их Сургуулийн профессор Жан Блондэл /Blondel, 2000/	Улс төрийн ашиг тус үзүүлсэнийх нь төлөө улс төрийн нам, засгийн газрын зүгээс тодорхой этгээдэд хүндэтгэл, ажлын байр, гэрээ хэлэлцээр буюу улсын захиалга нийлүүлэх ажил зэрэг янз бүрийн бараа, бүтээгдэхүүн санал болгох үйл явц мөн
4	Сан-Францискогийн Улсын Их Сургуулийн профессор Кэй Лоусон /Lawson, 1980/	Сонгуулийн явцад санал өгсөнийх нь хариуд тодорхой сувгаар дамжуулан хариу үйлдэл үзүүлэх улс төрийн намуудын үйл ажиллагаа мөн.
5	Принстоны Их Сургуулийн профессор Алекс Уэйнгрод /Weingrod, 1968/	Улс төрийн дэмжлэг, туслалцааны хариуд улс төрчдийн зүгээс нийтийн баялагийг юм уу төрийн албаны албан тушаал хуваарилах үйл явц мөн
6	Принстоны Их Сургуулийн профессор Алекс Уэйнгрод /Weingrod, 1968/	Өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд эрх ашиг, түншлэлээр холбогдсон харилцан адилгүй эрх мэдэл бүхий хүмүүсийн хоорон дахь харилцаа мөн
7	Харвардын Их Сургуулийн профессор Шмул Н. Эйзэнштадт, Флоридагийн Их Сургуулийн профессор Ренэ Лэмаршан /Eisenstadt, Lemarchand, 1981/	Эрх мэдэл бүхий ивгээгчийн зүгээс бусдаас өөрт шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ авсны хариуд клиент нарт бараа, үйлчилгээ, өмгөөлөл, хамгаалал хүртээх явдал мөн
8	Абэрдин Их Сургуулийн профессор Фрэнк У. Били /Bealey, 2000/	Томилогдож буй этгээдийн мэдлэг чадвар буюу гавьяа зүтгэл дээр бус, бие хүний ашиг сонирхолд нийцүүлэн засгийн газрын зүгээс хийх томилгоо мөн
9	Сьюзэн Беджэр тэргүүтэй судлаачдын эрхлэн хэвлүүлсэн бүтээлд /Badger et al., 1998/	Намд үнэнч байсных нь төлөө төрийн нөөцийн ашиглан шагнаж урамшуулах тогтолцоо; Мэдлэг чадвараар бус, эрх баригч намын эдийн болон эдийн бус ашигт нийцүүлж төрийн албанд томилох, дэвшүүлэх үйл явц мөн.
10	Нотинхэйм Их Сургуулийн профессор Жан-Хинрик Мейер-Сахлинг /Meyer-Sahling, 2006/	Улс төрийн хэмжүүрт тулгуурлан улсын салбарын албан тушаалд хүн томилох үйл явц мөн.

11	Пэтр Копэцки, Питэр Мэйр /Korescky, Mair, 2006/	Улсын салбарын юм уу хагас улсын салбарын албан тушаалд хүн томилох улс төрийн намын эрх мэдэл.
12	Лондон дахь Хатан хааны коллежийн профессор Анна Звезда /Gwiazda, 2008/	Улсын салбарын юм уу хагас улсын салбарын янз бүрийн албан тушаалд эрх баригч намын зүгээс гишүүн, дэмжигчдээ томилох замаар төрд улс төрийн нам нэвтрэх үйл явц мөн.
13	Вильнюсийн Их Сургуулийн профессор Виталис Накросис, Лютаурас Гүдзинскас /Nakrošis, Gudžinskas, 2013/	Улсын салбарын хүрээн дэх албан тушаалд хүн томилох улс төрийн намуудын бүрэн эрх
14	Венийн Их Сургуулийн профессор Вольфганг С. Мүллэр /Muller, 2005/	Намын улс төрчид болон клиентүүдийн хооронд явагдах шууд болон шууд бус солилцоонд төрийн нөөцийг ашиглах үйл явдал мөн.
15	Лондонгийн Эдийн Засаг, Улс Төрийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн профессор Эллиот Грин (Elliott Green, 2011)	Улс төрийн дэмжлэгийн хариуд иргэдийн зорилтот бүлэгт улс төрийн удирдагчдын зүгээс биет баялаг хуваарилах нийтлэг шинтэй улс төрийн бодлогыг патронаж гэнэ.
16	Вильнюсийн Их Сургуулийн профессор Виталис Накросис /Nakrošis, 2014/	Төрийн байгууллагын албан тушаалд итгэгдсэн юм уу намын гишүүдээ томилох, тэрчлэн албан тушаалаас чөлөөлөх улс төрийн намуудын эрх мэдэл
17	Лондонгийн Эдийн Засаг, Улс Төрийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн профессор Клара Волинтиру /Volintiru, 2014/	Улсын салбарын удирдлагын байгууллага дахь ивээлийн буюу улс төржсөн томилгоо.
18	ШУТИС-ийн профессор Я. Төгөлдөр (Tuguldur, 2022)	Улс төрийн патронаж нь төрийн албан тушаалд өөрийн аялдан дагагчид болон намын гишүүдийг томилох үйл явцыг хэлнэ.
19	Франческо Пэницца, Б. Гай Питэрс, Конрада Рамос Ларрабүрү / (Francisco Panizza, B. Guy Peters, and Conrada Ramos Larraburu, 2022)	Шийдвэр хууль ёсны мөн, бишээс үл хамааран улсын салбарын хүрээнд сонгуульт бус албан тушаалд өөрийн үзэмжээр хүн томилох улс төрийн тоглогчдын эрхийг хэлнэ
20	Б. Гай Питэрс, Колин Нокс, Бюон Сок Ким /B. Guy Peters, Colin Knox, Byeong Seob Kim, 2023/	Улс төрийн тоглогчид улсын салбарын удирдлагын голлох албанд өөрийн үзэмжээр томилгоо хийх эрхийг хэлнэ.

Эх сурвалж: Ауримас Зарэмбагийн бүтээлд (Zaremba, 2016) тулгуурлан боловсруулав.

Энэ мэтчлэн судлаачид харилцан адилгүй байр суурь баримтлах ч улс төрийн патронажийг нийтлэг шинжид тулгуурлан дараах байдлаар тодорхойлж болох байна. Улс төрийн патронаж нь клиентелизмын нэг хэлбэр бөгөөд хуульд нийцсэн, үгүйгээс үл хамааран эрх баригч нам, улс төрчдийн зүгээс гишүүн, дэмжигчдээ мэдлэг чадвар, мэргэшил, туршлага шаардах төрийн албан тушаалд үнэнч байдлыг шалгуур болгон томилох, юм уу уг шалгуурыг удирдлага болгон төрийн албан хаагчдыг албан тушаалаас халах, чөлөөлөх үйл явцтай хамаарал бүхий патрон, клиентийн хоёр талт харилцаа мөн (Төмөр & Отгонбаяр, 2023).

Институционал хандлага

Төрийн албаны зохион байгуулалтад улс төрийн патронаж илрэх үйл явц, түүний шалтгаан, мөн чанарыг ойлгож, танин мэдэхэд институционал хандлага суурь нөлөө

үзүүлсэн. “Улс төрийн шинжлэх ухааны зориулалт нь улс төрийн үйл явцыг мөн чанарын төдийгүй илрэн гарах тодорхой хэлбэрийн хувьд судлан гаргахад оршино. Эндээс шинжлэх ухааны судалгааны хоёр түвшин буюу чиглэл байгааг харж болох байна. Эхний түвшинд их төлөв онолын асуудлыг авч үзэх улс төр судлаачид багтдаг бол хоёр дахь чиглэл нь улс төрийн тодорхой үйл явцыг задлан шинжилж, улс төрийн шийдвэр гаргахад зөвлөмж боловсруулах судлаачдын үйл ажиллагаатай холбогдоно” (Семенова, 2022, хууд. 11). Нийгмийн үзэгдэл, үйл явцад улс төрийн институтуудын зүгээс гүйцэтгэх үүрэг, түүний байр суурийг судлахад институционал хандлагын мөн чанар оршино. Үг зүйн хувьд “институционализм” гэх ойлголтыг анхлан Америкийн эрдэмтэн Уилтон Х. Хамилтон (Hamilton) 1919 онд нийтлүүлсэн «Эдийн засгийн онолын институционал хандлага» нэрт нэг сэдэвт бүтээлдээ хэрэглэж, шинжлэх ухааны хүрээнд нэвтрүүлсэн (Hodgson, 2005, pp. 233-244).

Институционал хандлага улс төрийн үзэл, сургаалын нэн эрт үед бүрэлдэн бий болсон түүхтэй. Тухайлбал, эртний Грекийн улс төрийн онолч Платон (Plato), Аристотель (Aristotle) нар төр, улсын бүтэц, зохион байгуулалт, зохистой хэлбэрийн тухай сургасан байна. Үүнээс гадна, хожмын нөлөө бүхий судлаачид болох Н. Макиавелли (Machiavelli), Ж. Бодэн (Bodin), Т. Хоббс (Hobbes), Ж. Локк (Locke), Ж. Ж. Руссо (Rousseau), В. Ф. Хегэл (Hegel) нарын хүмүүс тодорхой түвшинд авч үзсэн байдаг (Гаджиев, 2015, р. 134). Гэхдээ улс төр, захиргааг тусгаарлах үзэл санаа, төрийн зохион байгуулалтын зохист хэлбэртэй холбоотойгоор Ш. Л. Монтескье (Montesquieu), Ш. Ж. Боннин (Bonnin), Ш. Дюпэн (Dupin), Э. Лабула (Laboulaye), Л. А. Макаре́ль (Macarel), А. Ф. Вивьен (Vivien), К. И. Блунчли (Bluntschli), Вильсон (Wilson), М. Вэбер (Weber), Э. Дүркхейм (Durkheim), Т. Парсонс (Parsons), Р. Мертон (Merton), П. Бэргер, Т. Лукман (Berger, & Luckmann) нарын бүтээлд институционал хандлага тусгагдсан байдаг (Отгонбаяр & Төмөр, 2022, хуудсд. 64, 65; Weber, 1978; Durkheim, 1993; Parsons, 1949; Мертон, 1966; Питер Бергер, Томас Лукман, 1995). Хэдийгээр дээрх эрдэмтэд “улс төрийн патронаж” гэх ойлголтыг хэрэглээгүй боловч уг үзэгдэлд шууд хамаарал бүхий үзэл баримтлалыг дэвшүүлсэн.

Улс төр, захиргааны зохист харилцааны талаарх анхны үзэл санааг Вильсон хөгжүүлсэн гэж үздэг боловч үүнийг нотлох баримт олддоггүй. Өөрөө ч энэ талаар дараах санааг уламжилжээ. Энэ “(...) шинжлэх ухааныг хөгжүүлэхэд Америкийн эрдэмтдийн оролцоо огтоос байсангүй. Үүнийг Европын эрдэмтэд хөгжүүлсэн юм. (...) Америк юм уу Английн зарчимтай үл холбогдох гадны шинжлэх ухаан гэж хэлж болно” (Wilson, 1887, pp. 201, 202) гэжээ.

Францын эрдэмтэн, улс төрийн бодлоготон Александ Ф. Вивьен (Vivien) нийгмийн хөгжлийг түргэтгэх, улс төрийн тогтолцоог төлөвшүүлэхэд төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх явдал чухал бөгөөд улс төрийн хүрээ санаачлага, шийдвэр гаргах бол захиргаа уг шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх үүрэгтэй гэжээ. Ингэхдээ улс төрийн тогтолцоонд ямар ч өөрчлөлт бий болсон төрийн албан хаагчид мэдлэг чадварын үндсэн дээр сонгон шалгаруулалтын үр дүнгээр томилогдож, тогтвортой ажилладаг байх ёстой гэжээ. Өөрөөр хэлбэл, мэргэшсэн, тогтвортой ажиллах төрийн албан хаагч улс төрийн аливаа хэлбэрийн дарангуйлал оршин тогтнох үндсийг үгүй хийдэг байна. Энэ үүднээс Монтескьегийн эрх мэдэл хуваарилах онолд нөхвөр санааг тусгаж, мэргэшсэн төрийн албан хаагчдын харилцааг зохицуулах захиргааны эрх мэдэл байх ёстойг онцолсон (Vivien, 1852).

Швейцарийн эрдэмтэн, Цюрих Их Сургуулийн профессор Каспар И. Блунчли (Bluntschli) улс төр, захиргааг тусгаарлах нь ихээхэн ач холбогдолтойг дурдсан. Гэхдээ улс төрийн хүрээ бодлого, шийдвэр боловсруулах үүрэгтэй бол захиргаа түүнийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлнэ. Үүний үндэс нь төрийн албан хаагчид хувь улс төрчдөөс ангид, мэдлэг чадварын үндсэн дээр сонгон шалгаруулалтын үр дүнгээр томилогддог байх ёстой гэжээ (Блунчли, 1867).

Принстоны Их Сургуулийн профессор Вудро Вильсон (Wilson) төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх гэдгийг үйл ажиллагааны үр ашигт байдалтай холбон тайлбарласан. Энэ талаар тэрээр улс төр, захиргааг тусгаарлах нь “(...) зарчмын ач

холбогдолтой юм. Германы томоохон эрдэмтэд уг асуудлыг анхлан тодорхойлсон. Тухайлбал, Блюнчли төрийн захиргааг улс төр болон эрх зүйгээс зааглан авч үзжээ. Түүний үзсэнээр, улс төр – төрийн үйл ажиллагааны ерөнхий, нийтлэг хүрээг хамардаг бол захиргаа – тодорхой, хязгаарлагдмал үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйлдэл болно. Улс төр – төрийн зүтгэлтний, захиргаа – шийдвэр хэрэгжүүлэгчийн хүчин чармайлгын үр дүнд биелэлээ олдог. Улс төр захиргааны дэмжлэггүйгээр оршин тогтнох боломжгүй” гэжээ. Мөн тэрээр “Захиргааны хүрээ болбоос үйл ажиллагааны хүрээ мөн. Энэ утгаараа улс төрийн тэмцлээс ангид байдаг. Захиргаа өөрөө улс төрийн хүрээний гадна оршино. Захиргааны асуудал – улс төрийн асуудал огтоос биш юм. Хэдийгээр улс төр захиргааны зорилтыг тодорхойлох ч энэ нь түүний үйл ажиллагаанд улс төр хутгалдан оролцоно гэсэн үг огтоос биш болно” (Wilson, 1887, хуудсд. 211, 212) гэсэн байна.

Институционал хандлагын хүрээнд боловсруулагдсан дараагийн нэг томоохон үзэл баримтлал нь М. Вэбер (Weber)-ийн бюрократийн онол юм. Улс орны үр дүнтэй хөгжлийн үйл явц юуны түрүүнд, мэргэшсэн, тогтвортой, цомхон, чадварлаг төрийн албанаас ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх нь хөгжлийн суурь нөхцөл мөн гэсэн санааг гаргажээ. Үүнтэй холбоотойгоор Вэбер рационал бюрократийн тухай ойлголтыг хөгжүүлсэн. “/.../ капиталист нийгэм хүртэлх өмнөх үед патримонал буюу өв залгамжилсан уламжлалт бюрократи” оршиж байсан бол “капиталист нийгэм үүсэж, томоохон аж үйлдвэр, нарийн бүтэц, зохион байгуулалттай аж ахуйн нэгж, салбарууд бий болсноор” төрийн алба ч хувьсан өөрчлөгдөж зүй зохист буюу рационал шинжийг олсон талаар бүтээлдээ дурджээ.

Албан хаагчид нь мэргэшсэн, тогтвортой, улс төрийн аливаа оролцооноос ангид байх төрийн албаны зохион байгуулалтын бүтцийг рационал буюу зохист гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, өөрөө өөрийгөө зохицуулах, зохион байгуулах албан ёсны дүрэм журам бүхий тогтолцоо хамгийн нийцтэй бөгөөд нийгэм-эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг талаар онцолсон байна. Энэ тохиолдолд төрийн албаны зохион байгуулалтад улс төрийн патронаж илрэх нь үр ашиггүй, тогтсон хэм хэмжээ, зохион байгуулалтыг эвдсэн нийгмийн зүй бус үзэгдэлд тооцогддог байна (Weber, 1978).

Веберийн хөгжүүлсэн рационал бюрократийн үзэл баримтлалын санаа Францын эрдэмтэн, Парижийн Их Сургуулийн профессор Дэвид Э. Дүркхэйм (Durkheim)-ийн нийгмийн аноми байдлын онолд тодорхой хэмжээгээр тусгагдсан байдаг (Харитонов, 2013, хууд. 36). Бие хүний зан үйл нийгмийн тодорхой байдлаас шууд хамаарна. Хэрэв нийгэм хямралд орвол тухайн нийгмийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээ өөрөө утга учраа алддаг жамтай. Дүркхэйм үүнийг аноми байдал хэмээн нэрлэжээ. Үзэл санааны ертөнц хямарч, суурь үнэт зүйл, ёс суртахууны хэм хэмжээ сулрахын зэрэгцээ хууль ёсны болон хууль бус байдал ялгагдахаа болихыг аноми гэнэ (Durkheim, 1993). Энэ талаас авч үзвэл төрийн албанд улс төрийн патронаж бий болох нь тухайн нийгэм бүхэлдээ, тэрчлэн түүнийг бүрдүүлэгч элемент бүр ёс суртахуун, зан үйлийн хямралд автаж, тунхагласан алсын хараа, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хоёрын дунд зөрчил үүсэж байгаагийн илрэл юм.

Нийгмийн аноми байдлын онолыг шинэ шатанд гаргаж хөгжүүлсэн хүн бол Америкийн эрдэмтэн, Колумбын Их Сургуулийн профессор Р. Мертон (Merton) болно. Хүний хүрээлэн буй орчны тодорхой нөхцөл үүсэхэд нэг талаас, нийгмийн, нөгөө талаас, соёлын бүтэц суурь шалтгаан нь болдог. Мертоны үзсэнээр, аноми байдал нь “соёлын” болон “нийгмийн бүтцийн” дунд үүсэх зөрчлөөс үүдэлтэй. Нийгмийн бүтцийн олон тооны элемент дотроос түүний мөн чанарыг тодорхойлж байдаг хоёр элемент туйлын чухал юм. Нэгдгээрх нь “тодорхой нийгмийн юм уу түүнийг бүрдүүлэгч анги давхаргуудын эцсийн зорилго болж байдаг ашиг сонирхол, үзэл бодол, соёлоос бүрддэг” бол хоёрдугаарх нь “дээрх зорилгод хүрэх арга хэрэгслийг тодорхойлж, хянаж, зохицуулдаг” байна. “Ямар ч тохиолдолд соёлын зорилгод хүрэх арга хэрэгслийн сонголт институционал хэм хэмжээгээр хязгаарлагдана” (Мертон 1992, 118,119).

Соёлын зорилго, түүнд хүрэх институционал арга хэрэгсэлийн хооронд үл нийцэл бий болсноор аноми байдал үүснэ. Аноми байдлыг хоёр зүйлээр хэмжиж болно. *Нэгдүгээрт*, оршин буй итгэл үнэмшил, зан үйлийн хэм хэмжээ суларсан, юм уу хуваагдсан, эсвэл утсан нийгмийн төлөв байдлаар тодорхойлогдоно. *Хоёрдугаарт*, хувь хүн нийгмийн чиг баримжаагүй болж, өмнөө тавьсан зорилгодоо хуульд нийцсэн аргаар хүрэх боломжгүй болсноор тодорхойлогдоно. Аноми байдлын шууд үр дагавар болж зан үйлийн гажуу хэлбэрүүд үүснэ (Мертон, 1992, 110). Үүний тодорхой жишээ нь төрийн албан дахь улс төрийн патронаж юм.

Институционал хандлага нь төрийн албаны зохион байгуулалт дахь улс төрийн патронажийг нийгэм-улс төрийн тогтолцооны хэм хэмжээ, ёс суртахууны үндсийг сулруулж, хямрал, эмх цэгцгүй байдалд хүргэх сөрөг үзэгдэл болохыг онцолдог байна.

III. Дүгнэлт

Судлаачдын зүгээс гадна, дотны судлаачдын бүтээлд дүн шинжилгээ хийсний эцэст дараах санааг өгүүллийн дүгнэлт болгон гаргаж байна. Үүнд:

- **Нэгт**, улс төрийн судалгаанд клиентелизм /clientelism/ болон улс төрийн патронаж /political patronage/ гэх ойлголтуудыг харилцан адилгүй байдлаар авч үзэж буй хандлага нийтлэг байна. Судлаачдын үзэж буйгаар, клиентелизм гэдэг нь үйлчлүүлэгчдийн (их төлөв эдгээрийг клиент гэж нэрлэдэг) зүгээс үнэнч байдлыг чухалчлах, хариуд нь ивгээгчийн (ихэвчлэн эдгээрийг патрон гэж нэрлэдэг) зүгээс зан үйл, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчин тэдэнд байгууллагын нөөцөд нэвтрэх, өмгөөлөл, хамгаалал хүртэх боломж олгодог далд хэлбэрийн босоо харилцаа бүхий удирдлага-зохион байгуулалтыг хэлдэг байна. Харин улс төрийн патронаж гэдэг нь клиентелизмын нэг хэлбэр бөгөөд хуульд нийцсэн, үгүйгээс үл хамааран эрх баригч нам, улс төрчдийн зүгээс гишүүн, дэмжигчдээ мэдлэг чадвар, мэргэшил, туршлага шаардах төрийн албан тушаалд үнэнч байдлыг шалгуур болгон томилох, юм уу уг шалгуурыг удирдлага болгон төрийн албан хаагчдыг албан тушаалаас халах, чөлөөлөх үйл явцтай хамаарал бүхий патрон, клиентийн хоёр талт харилцаа юм.
- **Хоёрт**, улс төрийн патронажийн институционал хандлагад тухайн үзэгдлийг нийгмийн тогтсон хэм хэмжээ, итгэл үнэмшлийг эвдэх зорилго бүхий сөрөг үйл явц гэсэн ойлголт түгээмэл байдаг.
- **Гуравт**, хэдийгээр гадны улс орнуудад улс төрийн патронажийн чиглэлээр судалгааны ажил харьцангуй сайн хийгдэж байгаа ч Монгол улсын тухайд сайн судлагдаагүй төдийгүй нэр томьёо, ойлголтын хувьд нэгдсэн байр суурь төлөвшиж чадаагүй байна.

Abstract:

Civil service plays an important role in the formation of a democratic political system. However, one of the serious problems in ensuring the professionalism of the civil service is political patronage. In the context of the article, the researchers tried to give a systemic idea of political patronage and its institutional approach.

Keywords: Political patronage, public appointments, clientelism, and patron-client relation.

Ашигласан ном, материал

Aysegul Komsuogly. (2011). Patronage. George Thomas Kurian (Хян.)-Д, *The Encyclopedia of Political Science: Volume 1-5* (хууд. 1199). Washington, D.C.: CQ Press.

Durkheim, E. (1993). *Ethics And The Sociology Of Morals*. (Robert T. Hall, Орч.) Buffalo, New York: Prometheus Books.

Francisco Panizza, B. Guy Peters, & Conrado Ramos Larraburu. (2022). Patronage and Public Administration. B. Guy Peters, & Ian Thynne (Хянд.)-Д, *The Oxford Encyclopedia of Public Administration*. Oxford: Oxford University Press.

Hodgson, G. (2005). 'Institution' by Walton H. Hamilton. *Journal of Institutional Economics*, Vol. 1(Issue 2).

Oyunsuren, D., Dierkes, J., & Byambakhand, L. (2023). Patronage in Mongolia. B. Peters, C. Knox, & B. Kim (Хянд.)-Д, *Political patronage in Asian Bureaucracies* (хуудсд. 121-154). Cambridge: Cambridge University Press.

Parsons, T. (1949). *The Structure of Social Action; a study in social theory with special reference to a group of recent European writers*. Glencoe, Illinois: The Free Press.

Petr Kopecký, Peter Mair, Maria Spirova. (2012). *Party Patronage and Party Government in European Democracies*. Oxford: Oxford University Press.

Vivien, A. (1852). *Études administratives*. Paris: Guillaumin Libraire.

Weber, M. (1978). *Economy and Society: An Outline of Interpretive Sociology*. (Guenther Roth, & Clauss Wittich, Хянд.) Berkeley, Los Angeles, London: University of California Press.

Wilson, W. (1887). The Study of Administration. *Political Science Quarterly*, Vol. 2(No 2).

Zaremba, A. (2016). Partinio patronažo konceptualizavimas. *Public Policy and Administration*, Vol. 15(No 3), 462.

Блунчли, И. (1867). *Антропологические очерки учений о правъ и государствъ*. Санкт-Петербургъ: Типографія А. Головачова.

Гаджиев, Х. (2015). Политические институты: Институциональный и неоинституциональный подход. *Власть*, 07.

Дэлхийн Банк. (2020). *Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж*. Улаанбаатар хот.

Клима, М. (2017). *Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу: Далд бизнес улс төрийн намуудыг хувьчлан колоничилсон нь*. (Р. Батсайхан, П. Цэнгүүн, Д. Амартүвшин, Хян., & Ж. Сайханзаяа, Орч.) Улаанбаатар хот: Сэлэнгэ Пресс.

Мертон, Р. (1966). Социальная структура и аномия. *Социология преступности (Современные буржуазные теории)* (хуудсд. 299-313).-Д Москва: Издательство «Прогресс».

Отгонбаяр, Н., & Төмөр, Т. (2022). Харьцуулсан болон хөгжлийн захиргаа: Онол, үзэл баримтлалын тойм. *Нийгмийн хөгжил: Асуудал, шийдэл*, №1.

Питер Бергер, Томас Лукман. (1995). *Социальное конструирование реальности*. Москва: МЕДИУМ.

Семенова, В. (Хян.). (2022). *Политический анализ и прогнозирование* (2-е издание хян.). Москва: Юрайт.

Төгөлдөр, Я. (2022). Патронаж/ Ивээлд авах үзэл (Patronage). Конрад- Аденауэр Сан, Ш. Батсүх, Н. Бурмаа, Я. Долгоржав, & С. Ганзаяа (Хянд.)-Д, *Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь* (хууд. 237). Анхны хэвлэл, Улаанбаатар хот.

Төмөр, Т., & Отгонбаяр, Н. (2023). Патронаж томилгооны талаарх ойлголт, онолын хандлагууд. *Төрийн удирдлага онол, арга зүйн сэтгүүл*, №22, 65-76.

Удирдлагын Академи. (2014). *Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн явц, үр дүн, хандлага: Судалгааны тайлан*. Улаанбаатар хот: Соёмбо Принтинг ХХК.

Харитонов, В. Н. (2013). *Клиентелизм в государственной службе: причины и пути ограничения*. Диссертация на соискание ученой степени кандидата социологических наук, Москва: Московский Государственный Университет имени М. В. Ломоносова.

Ц. Самбаллхүндэв, Д. Байгал. (2009). Төрийн албаны шинэтгэл ба манлайлал. *Шинэ толь сэтгүүл*, №66.

ПОЛИТОЛОГИ ХХП

Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 235-247 дахь тал

АЛБАН БУС УЛС ТӨР: КЛИЕНТЕЛИЗМ, ТӨР БОЛОН НАМЫГ БАРЬЦААЛАХ
ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Д.Бадамдаш

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн багш

Б.Сарантуяа

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Д.Бумдарь

МУИС, УТСОУХНУС,

Улс төр судлалын тэнхимийн профессор

Хураангуй:

Энэхүү өгүүллээр 1989 оноос хойших үеийн коммунизмаас ардчилсан тогтолцоонд шилжсэн орнуудын улс төрийн хөгжлийг ойлгоход нэн чухал ач холбогдолтой улс төрийн нам-эдийн засгийн албан бус хамаарлын тухай шинэ өнцгийг өгүүлж далд сүлжээ, далд улс төрийн бүтэц бүхий клиентелизм, авлига, патрон ёсны тухай ойлголтыг улс төрийн намын судлагдахуунд нэгтгэх зорилго бүхий албан бус сүлжээ, албан бус солилцоо, албан бус улс төр, албан бус пост-коммунист номенклатур¹, албан бус намын хувьчлал ба колоничлол, албан бус “үйлчлүүлэгч-үйлчлүүлэгчийн” загвар, далд улс төрийн урсгал, далд хэлбэрээр нам, төрийг барьцаалах зэрэг нэр томъёог ашиглаж тайлбарласан Чехийн улс төр судлаач Михал Климагийн “Пост-Коммунист Европ дахь албан бус улс төр: улс төрийн нам, клиентелизм ба төрийг барьцаалах” номд анализ хийж дээрх хэсэгт өгүүлсэн нэр томъёоны тайлбарыг нэгтгэн хүргүүлэхийн чацуу “клиентелизм, намыг барьцаалах болон төрийг барьцаалах” гэх ойлголтуудыг тодорхойлон дүгнэхэд төвлөрч дүгнэлт хэсгээр дамжуулан Михал Климагийн бүтээлд анализ хийснээ танилцуулах болно.

Түлхүүр үгс: Албан бус улс төр, клиентелизм, авлига, колоничлол, нам болон төрийг барьцаалах

1980-1990-ээд оны зааг дээр Зөвлөлтийн коммунист тоталитар тогтолцоо задран унаснаар олон улс дарангуйллын тогтолцооноос чөлөөлөгдсөн. Үүнийг Фрэнсис Фукуяама (1989) **ардчилал ялж, түүхийн төгсгөл** ирсэн хэмээн тодорхойлсон. Самуэль Хантингтон (1991) Евро-Азийн бүс нутаг дахь энэхүү өөрчлөлт нь 1970-аад оноос өмнөд Европт эхэлж, аажмаар Латин Америк, Африк, Азид тархсан **ардчиллын гурав дахь давлагаа** хэмээн тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл Коммунизм, ЗХУ задран унаснаас хойш 30 жилийн дараа Төв болон Зүүн Европын бүс нутаг намын хөгжил, улс төрийн дэглэмийн динамик, ардчиллын чанарыг харьцуулан судлах лаборатори мэт болж энэ нь ардчилал төрийн байгуулалт, зах зээлийн эдийн засгийн нэвтрэлт, улс төрийн манлайллын бюрократизац² зэрэг маш богино хугацаанд өрнөсөн нүсэр том трансформацийн нэгдэлд суурилжээ. “Улсын нөөцийг асар их хэмжээгээр шунан мөлжих “нээлттэй цонх” буюу нэг төрлийн

¹ Коммунист дэглэм нуран унасны дараа намаас томилогдсон эрх мэдэл бүхий хүмүүс.

² Улс төрийн албан тушаалууд төрийн удирдлагын зохион байгуулалтад шилжиж, бүтцэд орж, хатуу зохион байгуулалттай болох үйл явцыг хэлнэ.

"Клондайкийн алтны халуурал" нь энэхүү коммунизмын дараах эмх замбараагүй нийгмийн түүхэн мөч байв" хэмээн Михал Клима онцлон тэмдэглээд 1989 оноос хойших улс төрийн хөгжлийг ойлгоход нэн чухал ач холбогдолтой улс төрийн нам - эдийн засгийн албан бус хамаарлын тухай шинэ өнцгийг гарган тайлбарлажээ. Коммунист дэглэмийн дараах улс төрийн тогтолцооны өвөрмөц байдалд дүн шинжилгээ хийх харьцуулсан улс төрийн альтернатив хүрээг баримталсан ба Судлаач Хэйлийн тайлбарласнаар (2015) пост-коммунизм нь 1990-ээд онд ардчилсан шинэ дэглэм бий болоход албан бус сүлжээ, албан бус улс төрийн чиг хандлагын үүрэг гүйцэтгэсэн гэдэг талаасаа "дахин давтагдашгүй улс төрийн тогтолцоо" юм. Энэ хүрээнд намуудын фирмийн холбоо, гүйлгээний далд хэв маягийг тухайлсан сонирхлыг төлөөлөх, дэмжих албан бус улс төрийн тогтолцоо гэж үздэг. Өөрөөр хэлбэл эдгээр нь албаны институт болон объектив сувгаар дамжуулан хувь хүн, бүлгийн хэрэгцээг хангах ашиг сонирхлын улс төрийн арга замыг хэрэглэдэг. Ингэснээр энэ төрлийн тухайлсан ашиг сонирхлыг хангах нэмэлт болон паралел суваг бүхий **сонгомол харилцаа, стратегийн нэмэлт хүрээ** бүрэлддэг (Piattoni, 2001) хэмээжээ. Коммунизмын дараах клиентелизм нь **бүтцийн авлига, бүтэцлэг патрон ёсыг** (Sajó, 2002) хамарсан нийгмийн зохион байгуулалтын тухайлсан хэлбэрийг бүрдүүлдэг бөгөөд ингэснээр **улс төрийн намыг барьцаалах, түүнчлэн төрийг барьцаалах процессыг** бий болгодог гэж үзжээ. Тиймд энэ өгүүллийн онолын эхний хэсэгт 1) **Клиентелизм**, 2) **Албан бус улс төр**, 3) **Бюрократизац**, 4) **Албан бус посткоммунист номенклатур**, хэмээх нэр томьёонуудыг тайлбарлахын чацуу **"клиентелизм, намыг булаан авах болон төрийг булаан авах"** гэх ойлголтуудыг тодорхойлоход төвлөрөх болно.

Онолын ойлголт:

Юун түрүүнд 1) **Клиентелизм**, 2) **Албан бус улс төр**, 3) **Бюрократизац**, 4)

Албан бус посткоммунист номенклатур хэмээх нэр томьёонуудыг тайлбарлая.

1. Клиентелизм

Үгийн утга тайлбарын хувьд клиентелизм гэдэг нь англи хэлний clientelism, латин хэлний clientēla гэсэн үгээс гаралтай түүхийн хувьд Ромын үед анх үүссэн нэг талаас дэмжлэг, туслалцаа шаардлагатай, эрх бүхий чинээлэг язгууртнууд нөгөө талаас эд материалын сонирхол дутагдал бүхий язгууртанд дэмжлэг үзүүлэх чадвартай ядуу иргэдийн хооронд хийгдэх харилцан ашигтай үйл ажиллагаа болж хөгжжээ. Мөн клиентелист үйл ажиллагааг Венийн их сургуулийн профессор Вольфганг С. Мүллер "намаас сонгуульд нэр дэвшсэн улс төрч, түүнийг дэмжигчдийн хооронд төрийн эрх мэдэлд дулдуйдан хийгдэх албан тушаалын томилгоо, материаллаг нөөцийн солилцоо мөн"³ гэж тодорхойлжээ. Харин Михал Климагийн "Пост-Коммунист Европ дахь албан бус улс төр: улс төрийн нам, клиентелизм ба төрийг барьцаалах" нь бүтээлээс "Улс төр, эдийн засгийн ил тод бус зах зээлийн өргөн хүрээг хамарсан нийгэм, улс төрийн цогц үзэгдэл юм; иймд төрийн бүхий л шийдвэр гаргалт клиентелист гүйлгээний боломжит хэрэгсэлд тооцогдоно" хэмээн энэ өгүүллийн судлаачид Монгол хэлнээ буулгасан бол Михал Климагийн "Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу: далд бизнес улс төрийн намуудыг хувьчлан колоничилсон нь" хэмээн орчуулгын бүтээлд "Клиентелизм нь хоёр болон олон хүнийг хамарсан найз нөхөд, хамаатан садангийн онцгой харилцаа, холбоо бөгөөд голдуу тодорхой зорилгод чиглэсэн байх ба нийгэм, эдийн засгийн (эсвэл улс төрийн) хувьд дээгүүр зиндааны нэг этгээд (патрон, ивээн тэтгэгч) нь доогуур зиндааны нөгөөдөө (клиент, дэмжигч) өөрийн нэр нөлөө, боломж бололцоог ашиглан хангамж, хамгаалалт үзүүлж байхад клиент нь мөн хариуд нь ивээн тэтгэгчдээ өөрийн биеэр үйлчлэх зэргээр ерөнхий дэмжлэг, туслалцаа үзүүлдэг үзэгдэл юм. Тэтгэгч, дэмжигчдийн холбоо нь олон хүнийг хамарч, тэдгээр нь хэд хэдэн шат дамжлага үүсгэж улмаар нэгэн пирамид болж "нийгмийн

³ Müller, Wolfgang C. "Party Patronage and Party Colonialization of the State." In Handbook of Party Politics, edited by Richard S. Katz and William Crotty, 189. London: Sage, 2006.

солилцооны сүлжээг” улмаар “нийгмийн солилцооны авлигалыг” бий болгодог”⁴ хэмээн тайлбарласан байна. Цаашлаад Клиентелист болон авлигын үйл ажиллагааг субьектив ба объектив гэсэн хоёр үндсэн аргаар ажиглаж, хэмжиж болно.⁵ Энэ нь бизнест идэгдсэн засгийн газар, бизнест идэгдсэн улс төрийн нам хоорондын хамаарлаас урган гарч буй давуу эрхээ урвуулан ашиглах явдалд гол анхаарлаа хандуулдаг. Үүнд, ялангуяа нам доторх зөрчилдөөн, засгийн газрын хямрал маягаар илэрдэг улс төрийн дээд түвшний элитүүдийн авлигын дуулиан багтдаг. Үүний зэрэгцээ цагдаа, прокурорын байгууллага, шүүх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон улс төрийн тогтолцооны бусад элементүүдийн бие даасан байдал, үйл ажиллагааг хязгаарлах зорилготой оролдлогуудтай холбогдоно.

2. Албан бус улс төр

“Албан улс төрийг “дүрэм ба институци”-ийн хүрээнд улс төрийн оролцоо гэж тодорхойлдог бол албан бус улс төр нь эрх мэдэл, давуу эрх олж авахын тулд хувийн харилцааг ашиглах явдал юм. Албан бус улс төр хэмээх ойлголтод хамаатан садан, ивээл, эх оронч үзэл, улс төрийн зуучлал, ивээн тэтгэгч-үйлчлүүлэгчийн харилцаа зэрэг олон нэр томьёо багтдаг” хэмээн “2004–2005 оны Макаогийн засаг захиргааны онцгой бүсийн сонгуулийн албан ба албан бус улс төр”⁶ бүтээлдээ профессор Эйло Вин-ят Ю⁷ дурджээ. Харин Михал Климагийн бүтээлд “клиентелизм нь албан бус сүлжээ, албан бус улс төрийн шаталсан бүтцийг бага багаар агуулдаг” гэж судлаач Зилонка, Хэйл⁸ нар үзсэн. Цаашлаад албан бус улс төр, клиентелист сүлжээ нь улс төрийн намуудыг эзэрхийлж, улмаар зэрэмдэглэж хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг гажуудуулж болзошгүй нөхцөл үүссэн гэдгийг тодорхойлох хэрэгтэй болдог. Нөгөө талаас албан бус улс төрийг зарчмын хувьд биш юмаа гэхэд ядаж албан ёсны улс төртэй эн зэрэгцэхүйц түвшинд авч үздэг хандлага байна. Энэ талаар “засгийн газрын хэд хэдэн удаагийн хямрал, улс төрийн эргэлтийн шалтгааныг ойлгох оюун санааны орон зай тэлснээр “илүү ардчилсан, илүү автократ нөхцөл байдлуудын хооронд” чөлөөтэй шилжих хэв маяг нээгдсэн” гэж судлаач Хэйл⁹ тэмдэглээд албан бус улс төр нь улс төрийг ерөнхийд нь авч үзэх нь пост-коммунист тогтолцооны эмзэг байдлыг ойлгох боломжийг олгодог хэмээжээ.

3. Бюрократизац

Михал Климагийн “Пост-Коммунист Европ дахь албан бус улс төр: улс төрийн нам, клиентелизм ба төрийг барьцаалах” бүтээлд тодорхойлсноор “Улс төрийн албан тушаалууд төрийн удирдлагын зохион байгуулалтад шилжиж, бүтцэд орж, хатуу зохион байгуулалттай болох үйл явцыг”¹⁰ хэлнэ. Цаашлаад Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичигт тайлбарласнаар “Бюрократ гэдэг бол захиргааны хүчинд тулгуурласан, маш нарийн шаталсан зохион байгуулалт бүхий дэглэмтэй удирдлагын тогтолцооны тухай ерөнхий ойлголт юм”¹¹ хэмээн тайлбарласан байна.

⁴ Михал Клима “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу: далд бизнес улс төрийн намуудыг хувьчлан колоничилсон нь” орчуулгын бүтээл, “Мизэс Монгол” ТББ, 2017 он, 7 дахь тал

⁵ Kostadinova, Tatiana. 2012. Political Corruption in Eastern Europe: Politics After Communism. Boulder, CO: Lynne Rienner Publishers.

⁶ Yu, Eilo Wing-Yat. "Formal and Informal Politics in Macao Special Administrative Region Elections 2004–2005, London, Routledge, <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/10670560701314248?needAccess=true> [2023.11.01]

⁷ Эйло Вин-ят Ю нь Макаогийн их сургуулийн Засгийн газар, төрийн удирдлагын тэнхимийн туслах профессор бөгөөд ардчилал, сонгууль, улс төрийн намууд, Хонг Конг, Макао, Тайваний улс төрд анхаарч судалдаг улс төр судлаач болно.

⁸ Hale, Henry E. (2015). Patronal Politics: Eurasian Regime Dynamics in Comparative Perspective. Cambridge: Cambridge University Press.

⁹ Hale, Henry E. (2015). Patronal Politics: Eurasian Regime Dynamics in Comparative Perspective. Cambridge: Cambridge University Press.

¹⁰ Michal Klima (2020) “Informal politics in post-communist europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.

¹¹ МУИС-ШУС-Улс төр судлалын тэнхим “Улс төрийн нэвтэрхий толь бичиг” 2020 он, УБ, 165 дахь тал

4. Албан бус посткоммунист номенклатур

Албан бус посткоммунист номенклатур нь коммунист систем задран унасны дараа посткоммунист нийгэмд бий болсон албан бус практик, бүтцийг хэлдэг.¹² Энэ нь практикт албан ёсны институцийн сул тал, улс төр, хэвлэл мэдээлэл, өдөр тутмын амьдрал зэрэг янз бүрийн салбаруудын нэгдлээс үүдэлтэй байдаг ба улс орнуудад коммунист дэглэм задран унасны дараа нийгэм-эдийн засаг, улс төрийн шинэ элит бий болсон утгыг мөн илэрхийлдэг. Михал Клима номенклатур гэдгийг “коммунист дэглэм нуран унасны дараа намаас томилогдсон эрх мэдэл бүхий хүмүүс”¹³ хэмээн тодорхойлсон. Үзэл баримтлалын хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, дарангуйлагч улс төрийн тогтолцооноос зах зээлийн баримжаатай эдийн засаг, ардчилсан засаглалын хэлбэрт шилжсэнтэй шууд холбоотой. Нэр томьёоны хувьд 20-р зууны сүүлээр Зүүн Европ болон хуучин ЗХУ-ын орнуудад коммунист дэглэмүүд задран унасан нөхцөлд эхэлжээ.

I. Клиентелизм

Өмнөх хэсэгт тайлбарласан нэр томьёоны хүрээнд 1980-1990-ээд оны зааг дээр Зөвлөлтийн коммунист тоталитар тогтолцоо задран унаснаар олон улс дарангуйллын тогтолцооноос чөлөөлөгдөж коммунизмын уналтын үеэс улбаалан клиентелизм бий болоход нэн таатай хүчин зүйлс үүсэн бий болжээ. Үүнд:

- a) Улс төрийн хүрээнд эрх мэдлийн зааг ялгаа, хяналт тэнцвэрийн тогтолцоо устаж алга болсон;
- b) Улс төр, ялангуяа хуучин коммунист намын төрийн захиргааны үйл ажиллагаанд хэт хөндлөнгөөс оролцох болсон;
- c) Улс төр, эдийн засгийн салбар хоорондын ер бусын хамаарал бий болсон;
- d) Төрийн болон хувийн хэвшлийн хэт их уялдаа холбоо бий болсон;
- e) Улс төрийн эрх мэдлийг хянагч хүчтэй иргэний нийгэм, дундаж давхарга устсанаар нийгмийн гишүүд хоорондын харилцаа холбоо, тогтвортой улс төрийн соёл алдагдсан зэрэг шалтгаанууд нь улс төр, эдийн засгийн шилжилтийн клиентелист чиг хандлагыг урьдчилан тодорхойлж эхэлжээ.

Энэхүү эхлэлд Климагийн тодорхойлсноор дараах хүчин зүйлс нэмэгдэж клиентелизмын хүрээг тэлсэн байна. Үүнд:

- a) Улс төр, эдийн засаг, нийгмийн трансформацын өвөрмөц цар хүрээ, ялангуяа өмч хувьчлалын урьд өмнө байгаагүй тэлэлт нь улс төрийн намуудыг түрээсийн хандлагад тулгуурласан стратегийг хэрэгжүүлэхэд хүргэсэн;
- b) төрийн захиргааны байгууллагыг улс төржилтөөс ангижруулах ажил удааширсан;
- c) “уламжлалт капиталын сүлжээ”-г өөрчлөх үйл явцын эхэнд давуу эрх эдэлж байсан махчин, шимэгч бүлгүүдийн дархлаагүй байдал, өөрөөр хэлбэл хуучин коммунист нууц цагдаагийн бүтэцтэй холбоотой нийгэм, санхүүгийн капиталыг эзэмшсэн явдал бий болсон. Үүнийг судлаач Мунгиу-Пиппиди тайлбарлахдаа “энэхүү үзэл нь нийгэм-улс төрийн универсализм ба партикуларизм гэх хоёр хандлагатай нийцдэг. Универсализм нь төр болон хувийн хэвшил хоорондын ялгаа тодорхой зааглагдсан, эрх мэдэл хуваарилагдсан орчин үеийн улс орнуудад түгээмэл ажиглагддаг. Ийм нийгмийн орчинд М.Веберийн тайлбарласан бюрократ тогтолцооны хамгийн тохиромжтой хэлбэрийг ашиглах боломжтой ба “хөдөлмөр хуваарилалтын босоо тогтолцоо төлөвших, тодорхой дүрэм журмаар удирдуулах, дүрмүүд нь албан журмаар хэрэгждэг, бүтэн цагаар ажилладаг мэргэжилтнээр хангагдсан, аль ч талаараа төрийн захиргааны арга хэрэгслийг эзэмшдэггүй хүмүүсээр хүрээлүүлсэн, ажлын гүйцэтгэлээс шууд олсон орлогоос илүү цалингаараа амьдардаг хүмүүстэй” хэмээх үндсэн шинж чанарууд илэрдэг” хэмээжээ.

¹² Smilova, Ruzha, and Daniel Smilov.” Informal Politics and Formal Media Structures,” chapter 13, pg.197-213

¹³ Michal Klíma (2020) “Informal politics in post-communist Europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.

Ийнхүү тоталитаризмыг ардчилсан сонгуулийг нэвтрүүлэх, институци байгуулах клиентелист дэглэмд суурилсан нийгмээр сольсон ба клиентелизмыг тодорхой ашиг сонирхлыг төлөөлөх, дэмжих тогтолцоо, эсвэл албан ёсны байгууллагууд албан бус сувгаар хувь хүн эсвэл хамтын хэрэгцээг хангах сонирхлын улс төр гэж ерөнхийд авч үзэх болжээ. Тухайлбал, сонгодог жишээ болж судлагдсан БНЧУ-д хөгжсөн шинэ төрлийн клиентелизмын гол цөм нь хүчирхэг төлөөлөгч болон эрх мэдэлгүй төлөөлөл, ивээн тэтгэгч, үйлчлүүлэгч хоорондын уламжлалт харилцаа, солилцоо байх боломжгүй гэдэг нь тогтоогдсон¹⁴ байна. Өнөөдрийг хүртэл судлагдсан ихэнх судалгаануудад “хувь хүн болон бүлэг хоорондын шаталсан **"ивээн тэтгэгч-үйлчлүүлэгч"** гэх босоо харилцаа” хэмээн тодорхойлсон байдаг ч судлаач Пиаттони¹⁵ клиентелизмд “соёл, хөгжил, эдийн засгийн” гэсэн гурван хандлагаар анализ хийснийг энэ хэсэгт дурдах нь зүйтэй. Тухайлбал, соёлын хандлага нь “гэр бүл, овог аймаг, угсаатны бүлэг, уламжлалт хэв маяг” зэрэг үзэгдлүүдтэй холбоотой хүмүүс хоорондын харилцаанд анхаарлаа хандуулдаг ба тухайлсан нийгмийн өвөрмөц соёлыг илэрхийлдэг. Энэ утгаараа клиентелизмыг **соёлын эмгэг** гэж үздэг. Хөгжлийн хандлага клиентелизмыг “өгөгдсөн улс төрийн тогтолцооны гажуудал буюу бүрэн бус хөгжлийн үр дагавар” гэж тайлбарладаг. Харин эцэст нь, хүмүүс хоорондын харилцааг “үр ашгийг дээд зэргээр нэмэгдүүлэх эдийн засгийн зорилго” удирддаг учраас клиентелизмын тухай ойлголт нь эдийн засгийн шинж чанартай¹⁶ байдаг (Piattoni, 2001). Эдгээр гурван хандлага нь пост-коммунист орчин дахь клиентелизмыг судлахад хэрэг гэж үзсэн нь клиентелизмыг тайлбарлах энэ хэсэгт дурдагдах зүйтэй судлагдахуун байна.

"Үйлчлүүлэгч-үйлчлүүлэгч"-ийн харилцаанд голчлон анхаардаг хандлага нь орчин үеийн клиентелизмын шинж чанаруудыг бий болгосон хувьсамтгай нөхцөл байдалд илүү нийцдэг. Эдгээр өөрчлөлтийг Китшелт, Вилкинсон¹⁷ нар дараах байдлаар хэсэгчлэн тайлбарлажээ:

*Ардчилсан институцийн нөхцөлд клиентелизм нь нэг шугаманд тасалдсан хэв маягтай өрнөх ба рационал арга хэрэгслийг (нормыг үл хэрэгсэх) гол болгосон брокер зуучлалын харилцаа (нүүр нүүрээ харж солилцоо хийхгүй) болж хувирсан байдаг.*¹⁸

Пост-коммунист нөхцөл байдлын хүрээнд клиентелизмыг шинээр тодорхойлох боломжтой. Орчин үеийн үзэл баримтлал нь ихэвчлэн Латин Америкт хэрэглэгддэг учраас клиентелизмыг модернизацийн гажуудсан үйл явцын нөхцөл дэх ивээн тэтгэгч-үйлчлүүлэгчийн харилцаа гэх хөгжлийн хандлагаар дараах байдлаар тайлбарлагдана. Үүнд:

- зах зээлийн харилцаа,
- ардчилсан шийдвэр гаргалт,
- төрийн бюрократ тогтолцооны мэргэшсэн байдлын эсрэг ажиллах замаар ивээн тэтгэгчдээ үнэнч байдаг нийгмийн харилцаа¹⁹ юм.

Цаашлаад, Сажо (Sajó, 2002) барууны уламжлалтай пост-коммунист улс орнууд дахь клиентелизмыг үнэлэх хялбарчилсан хувилбарыг танилцуулахад клиентелизмыг нийгмийн зохион байгуулалтын нэг хэлбэр гэдгийг онцолж, дараах аксиомуудыг²⁰ дэвшүүлсэн. Үүнд:

¹⁴ Michal Klíma (2020) “Informal politics in post-communist europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.

¹⁵ Piattoni, Simona. (2001), “Clientelism, Interests, and Democratic Representation: The European Experience in Historical and Comparative Perspective”. Cambridge: Cambridge University Press.

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ Kitschelt, Herbert, Steven I. Wilkinson, eds. Patrons, Clients and Policies: Patterns of Democratic Accountability and Political Competition. Duke University, North Carolina.

¹⁸ Michal Klíma (2020) “Informal politics in post-communist europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.

¹⁹ Michal Klíma (2020) “Informal politics in post-communist europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.

²⁰ Sajó, András. (2002), “Clientelism and Extortion: Corruption in Transition.” Pp. 1–21 in Stephen Kotkin and András Sajó (eds.) Political Corruption in Transition: A Skeptic’s Handbook. Budapest: Central European University Press.

- a) Посткоммунист клиентелизм нь авлигын суурь нөхцөлийг бүрдүүлж, шинээр үүсгэж байна гэдэг нь авлига өөрөө тухайн улс орон, бүс нутгийн нийгмийн бүтцийн тулгуур болсон гэдэгтэй утга дүйнэ.
- b) Клиентелист авлига нь бүтцийн авлигын нэг хэлбэр учраас үүнийг индивидуал авлигаас ялгах ёстой.
- c) Зүүн Европ дахь клиентелист бүтэц нь хуучны коммунист нэршилтэй холбоотой хэдий ч тухайн бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн явцад төр төвтэй (хуучин дэглэмээс ялгаатай нь) клиентелист тогтолцоо үүссэн. (Sajó, 2002)

Посткоммунист клиентелизмын оргил үед ивээн тэтгэгч ба үйлчлүүлэгчийн үүргийн ялгаа бүдгэрсэн буюу бүгд харилцан үйлчлүүлэгчид гэх утгыг агуулдаг болжээ. “Үйлчлүүлэгч-үйлчлүүлэгч” гэх томъёоллоор бий болсон энэхүү уян хатан загвар нь далд улс төр, эдийн засгийн зах зээлийн сүүдэрт үйлчлүүлэгчид хоорондоо хэлцлийг хийдэг гэж үздэг. Хэт даварсан хувилбар талаасаа улс төрчид зөвхөн эрх мэдэл гэлтгүй бизнес, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ч гартаа төвлөрүүлж болно. Ийм төрлийн бүрэн эрх, чиг үүрэгтэй улс төрчид эрх мэдлийн наймаач, улс төрийн алт хайгч болон хувирдаг буюу “улс төрд гарсан бизнесмен”-д тооцогдоно. Эсрэгээрээ эдийн засгийн эрх мэдэлтэй бизнесменүүд ажлын байр, бараа таваарыг улс төрийн эрх мэдлээр наймаалцаж болно.²¹ Тиймээс тэд өмчлөл, пүүс, төртэй тогтоосон харилцаа, ажиллах хүчний хяналт, орон нутгийн нийгэмд үзүүлэх эдийн засгийн нөлөө зэрэг олон хүчин зүйлээс бүрдсэн эдийн засгийн хүч чадлаа ашигладаг (Daniel Kaufmann, 2001). Ийнхүү төр төвтэй клиентелизмын посткоммунист тодорхойлолт²² нь сонгодог ойлголтоосоо дараах байдлаар ялгагдаж гарч ирэх ба энэ нь нэгдсэн тодорхойлолтыг хийдэг тустай ажээ. Үүнд:

- a) Клиентелизм нь улс төр, эдийн засгийн ил тод бус зах зээлийн өргөн хүрээг хамарсан нийгэм, улс төрийн цогц үзэгдэл юм. Иймд төрийн бүхий л шийдвэр гаргалт клиентелист гүйлгээний боломжит хэрэгсэлд тооцогдоно.
- b) Улс төр - бизнесийн харилцан үйлчлэл, өөрөөр хэлбэл нам, пүүсийн харилцаа нь ивээн тэтгэгч-үйлчлүүлэгчийн шаталсан загварт суурилдаггүй, харин илүү уян хатан "үйлчлүүлэгч-үйлчлүүлэгч" гэх харилцаа, солилцоонд суурилдаг. Иймд аль аль тал нь бизнес эрхлэгч байдаг.
- c) Түрээс хайх стратеги нь харилцан дундын ашиг сонирхлын хүрээнд төрийн өмчийн баялгийг солилцох, хүүлэх хэлбэрээр илэрдэг. Энэ нь тэдний “нөхөрсөг” улс төрийн эрх мэдлээ зуурч үлддэг шалтгаан юм.
- d) Сонгуульт үзэл баримтлал гэх улс төрийн намын стратеги нь намын хатуу дэмжигчид дээр тулгуурладаг учраас гол шинж чанар биш.

Дээрх эрдэмтдийн ялгамжтай тодорхойлолтоос олон талт клиентелизмын ухагдахууныг посткоммунист өвөрмөц трансформацийг тайлбарлахад ашиглаж дараах өргөн хүрээний тодорхойлолтыг дэвшүүлж болно хэмээжээ.

Посткоммунист төр төвтэй клиентелизм нь нийгмийн зохион байгуулалтын тодорхой хэлбэр талаасаа бүхнийг хамарсан, нэвтрэх үзэгдэл буюу улс төр, эдийн засгийн эрх мэдлийг агуулсан албан тушаалыг албан бус, хууль бус, хагас хууль бусаар ашиглах явдлаар илэрдэг. Энэхүү эрх мэдэл нь эрх баригч намууд, ил тод бус бизнес эрхлэгчид болон тэдгээрийн холбоотнуудын хувь хүн, бүлэгт ажлын байр, бараа бүтээгдэхүүн, төрийн болон хувийн хэвшлийн бусад ишигдвэрийг хуваарилах үндсэн мөлжлөгийн стратегид тулгуурладаг. Энэ нь эцсийн дүндээ төрийн зардлаар харилцан баяжих нэг л зорилготой. Тийм учраас клиентелизм нь бүтцийн авлига, бүтцийн патрон ёсонд автдаг. Энэ нь хамгийн дээд шатандаа "намыг барьцаалах" үйл явцыг бий болгодог бөгөөд яваандаа эдийн

²¹ Kaufmann, Daniel, Aart Kraay, and Massimo Mastruzzi. (2010), “The Worldwide Governance Indicators, Methodology and Analytical Issues.” Policy Research Paper, No. 5430, (September) World Bank.

²² Michal Klíma (2020) “Informal politics in post-communist europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.

засгийн зорилгоор "төрийг барьцаалах", улс төрийн зорилгоор "клиентелист ардчилал" гэх үзэгдлийг бий болгодог.

Ийнхүү дээрх тодорхойлолтод дурдсанчлан клиентелизмын хамгийн дээд шат нь намыг барьцаалах” үйл явцыг бий болгох бөгөөд яваандаа эдийн засгийн зорилгоор “төрийн барьцаалах”, улс төрийн зорилгоор “клиентелист ардчилал” гэх үзэгдлийг бий болгодог болохыг дахин энд онцлог тэмдэглээд дараагийн хэсэгт “намыг булаах болон төрийг булаан авах үзэгдлийг” тайлбарлая.

II. Намыг болон төрийг барьцаалах үзэгдэл

Өгүүллийн энэ хэсэгт “**State capture and party capture**” хэмээх үгээр эх бүтээлдээ тайлбарлагдсан “төрийг барьцаалах болон намыг барьцаалах” хэмээх үзэгдлийг тайлбарлая.

Юун түрүүнд “state capture-төрийг барьцаалах” агуулгын хүрээнд дэлхийн банкны эдийн засагчид болох судлаач Хеллман, Кауфман нар 1990-ээд оны сүүлээр пост-коммунист орнуудад зах зээлийн эдийн засаг, либерал ардчилал нэвтрүүлсэн эхний 10 жилд тохиолдсон асуудлуудыг ажигласны үндсэн дээр төр барьцаалах үзэл санааг боловсруулсан²³ байна. Тодруулбал, судлаач Хеллман, Кауфман нар пост-коммунист шилжилтийн үеийн эдийн засагт тохиолдох нэг үзэгдлийг төр барьцаалах гэж үзсэн ба гол цөм нь нэг талаас хүчирхэг пүүсүүд, нөгөө талаас хүнд сурталтай улс төрчид хоорондын "хуйвалдаан" хэмээн тайлбарласан. Ийм хамтарсан байдлаар тэд хувийн ашиг хонжоо олох бодлого боловсруулж, зах зээл дээрх тоглоомын дүрмийг зохиодог. Хууль ёсны том авлигын энэ хэлбэр нь засаглалын сул дорой байдлыг ашиглан эдийн засаг, улс төрийн тогтолцооны ноцтой доголдлыг үүсгэдэг. Үүнд оролцогч талууд нь нэг бол эдийн засаг, институцийн шинэчлэлийг хэрэгжүүлэх боломжгүй эсвэл огт хүсэхгүй байгаа гэж хуваагддаг байна. Цаашлаад үүний гол үүргийг шинээр байгуулагдсан жижиг корпорац, төрийн өмчит болон хагас өмчит компаниудын төлөөлөгч пүүсийн эзэд гүйцэтгэдэг. Тэд парламентын гишүүн, засгийн газрын албан тушаалтан, шүүгч, төв банкны гишүүн, улс төрийн намуудад хахуул өгч, нөлөөлөх онцгой байр суурьтай байдаг. Үүнээс дүгнэн харахад судлаач Хеллман, Кауфман нарын хувьд төр барьцаалах гэдэг нь “цөөн хэдэн пүүс бусад бүх пүүсүүдийн зардлаар аюулгүй байдал, өрсөлдөх давуу талтай бүсүүдийг бий болгох стратеги” болсон гэж үзсэн.

Пост-коммунист клиентелизмыг төр барьцаалах эдийн засгийн хувилбартай нь харьцуулж үзвэл хэд хэдэн чухал ялгаатайг харж болно. Энэхүү ялгаа нь төр барьцаалах тухай ойлголтыг анх нээсэн Дэлхийн банкны эдийн засагчдын тайлбартай холбогддог. Иймд төр барьцаалах хэлбэр нь системийн клиентелизмээс дараах үзүүлэлтээр ялгаатай:

- a) Гол өрсөлдөөний талбар нь монопол буюу олигополын бүтэц цэцэглэн хөгжиж, ялан дийлсэн шилжилтийн үеийн гажуудсан зах зээлийн эдийн засаг байна.
- b) Төв пүүс – төр хооронд тогтоосон харилцааны хүрээнд барьцаалагч пүүсүүд тус ажиллагааны гол санаачлагч байдаг учраас идэвхтэй субъектэд тооцогддог; тэдний объект нь төр, төрийн алба байна. Пүүсүүд эрх мэдлээ “пүүсийн хэмжээ, өмч эзэмшил, төртэй тогтоосон харилцаа, ажиллах хүчний хяналт, орон нутгийн нийгэмд үзүүлэх эдийн засгийн нөлөө”²⁴ зэрэг хүчин зүйлээс авдаг (Daniel Kaufmann, 2001).
- c) Сонгогдсон улстөрч, карьер хөөж буй төрийн албан хаагчид нь төрд орсон жүжигчид болох нь тогтоогдоно. Эдгээрт зөвхөн парламентын гишүүд, ерөнхийлөгчөөс гадна Төв банк, шүүх, улс төрийн намууд зэрэг институцийн оролцогчид багтана.
- d) Нэг талаас барьцаалагч пүүсүүд, нөгөө талаас улс төрчдөд зориулсан хувийн болон бүлгийн ашиг тусыг ялгаж салгасан. Барьцаалагч пүүсүүд түрээсийн хууль, дүрэм журмын (гэрээний эрх, өмчийн аюулгүй байдлын эрх) тусламжтайгаар зах зээл дэх давуу байр суурийг эзэлж, эдийн засгийн онцгой ашиг олдог. Үүний хажуугаар улс төрчид саналын хэлбэрээр улс төрийн давуу талыг олж авдаг.

²³ Kaufmann, Daniel, Aart Kraay, and Massimo Mastruzzi. 2010. “The Worldwide Governance Indicators, Methodology and Analytical Issues.”, Policy Research Paper, No. 5430, (September) World Bank.

²⁴ Мөн тэнд.

- е) Төрийг барьцаалах үзэгдэл нь “пүүс – төр” хоорондын харилцан үйлчлэлийн хүрээнд байдаг хэдий ч пост-коммунист клиентелизм нь “нам – пүүс”-ийн хэв маягт гол анхаарлаа хандуулж, ингэх явцдаа төрийг улс төрийн намаас ялгаж авч үзсэн.

Төрийг барьцаалах хэмээх энэ агуулгын хүрээнд судлаач Грзимала-Буссе, Иннес²⁵ нар болон Стуббс, Зриншчак²⁶ нар өөр өөрийн санал боловсруулалтыг танилцуулсан байдаг. Тухайлбал, Грзимала-Буссе, Иннес нар “төрийг барьцаалах тухай илүү боловсронгуй, шинэ үзэл санааг боловсруулан танилцуулж, улс төрийн системийн бүрдлийг төр барьцаалах үзэгдэл судлагдахуунтай нэг шугаманд байршуулсан. Судлаач Грзимала-Буссе төрийн өмчийг улс төрийн элит олборлох замаар төрийг барьцаалах олон талт стратеги нь тухайлсан улс төрийн институци, түүний чадавхад хэрхэн нөлөөлж, бүрдүүлдэг болохыг судлах аргачлалыг баримталсан бол Судлаач Иннес корпорац төрийг барьцаалах, улс төрийн нам төрийг барьцаалах гэсэн хоёр төрлийн төр барьцаалахуй байна” гэж үзсэн бол Стуббс, Зриншчак нар “клиентелист хэлбэрийн барьцаалахуйг судалсан. Тухайлбал, Хорват улсад өрнөж буй нөхцөл байдлын хүрээнд тэд клиентелист барьцаалахуйн тухай ойлголтыг өргөн утгаар илэрхийлж, үүнд холбогдох улс төрийн элитүүдийн идэвхтэй үүргийг онцолсон. Тэд клиентелизмыг засаглалын гажуудсан хэлбэр, нөөцийн тэгш бус дахин хуваарилалтаас бүрдсэн цогц бүтэц гэж тодорхойлсон. Энэ талаасаа “улс төр, эдийн засаг, нийгмийн бодлогын бүтцийн хүчийг” клиентелизмын үзэл баримтлалд нэгтгэсэн (Zrinščak, 2015). Тэд тус судалгаандаа “клиентелист дэглэм” гэх нэр томъёог ашигласан. Уг нэр томъёог хоёр тайлбарын хүрээнд задалжээ. Үүнд, (i) клиентелист дэглэмийг нийгэм, улс төрийн бүхий л системийг хамардаг гэх талаас нь, (ii) ‘корпорац’ болон ‘нам’ төр барьцаалах хувилбаруудыг нэгтгэх замаар клиентелист төр барьцаалахуйн хүрээлэлд багтах бүхий л клиентелист зохицуулалтыг авч үзнэ” хэмээх байр суурийг илэрхийлсэн. Үүнээс пост-коммунист клиентелизм нь нам төрийг барьцаалах, корпорац төрийг барьцаалах тухай асуудлын аль алиныг нь хамардаг учраас ‘давхар’ эсвэл ‘хоёр дахин их’ хүчээр төрийг гартаа авдаг хэмээх дүгнэлтэд хүрчээ.


Хоёрдугаарт, “party capture-намыг барьцаалах” хэмээх томъёоллын хүрээнд Михал Климагийн “Пост-Коммунист Европ дахь албан бус улс төр: улс төрийн нам, клиентелизм ба төрийг барьцаалах” бүтээлд хэрхэн тайлбарласан болохыг авч үзвэл: бүтээлд *намыг барьцаалах хоёр талт үйл явцыг* клиентелизмын гол элемент болгон танилцуулсан ба бизнесийн хөндлөнгийн оролцоог хоёр талт байдлаар шинжилсэн байна. Үүнд:

- 1) “Доороос” гэж нэрлэсэн намын хувьчлал буюу бүс нутгийн дарга нараар удирдуулсан орон нутгийн болон бүс нутгийн бизнес;
- 2) “Дээрээс” гэж нэрлэсэн намын колоничлол буюу үндэсний хэмжээний дарга нар эсвэл олигархуудын удирддаг аварга корпорацын конгломератууд талаас нь шинжилсэн үр дүнгүүд байна. энэхүү хоёр агуулгыг хялбархан тайлбарлах үүднээс зураг 1 болон 2-ын тус тусын тайлбарыг анхаарна уу.

²⁵ Grzymala-Busse, Anna M. (2002), *Redeeming the Communist Past. The Regeneration of Communist Parties in East Central Europe*. Cambridge: Cambridge University Press.


²⁶ Stubbs, Paul, and Siniša Zrinščak. (2015), “Citizenship and Social Welfare in Croatia: Clientelism and the Limits of Europeanisation.” *European Politics and Society* 16 (3): 395–410.

Зураг 1. Пүүс-нам-пүүс загварт суурилсан намыг барьцаалах үзэгдэл



Зураг 1-т үзүүлсэн эхний үе шатанд далд бизнесийн оролцогч талууд ихэвчлэн улс төрийн нам руу хоёр талаас нь нэвтэрч, эзлэн авахыг эрмэлздэг болохыг дүрсэлсэн.

Зураг 2. Барьцаалагдсан нам клиентелист төрийг барьцаалахаар эрмэлзэж буй нь



Зураг 2-т үзүүлсэн хоёр дахь үе шатанд аль хэдийн барьцаалагдсан намууд махчин субъект, клиентелист нам болон хувирч, ил тод бус улс төр-бизнесийн механизмд чухал үүрэг гүйцэтгэж, төрийн эрхийг барьж дуусах (Судлаач Грзимала-Буссе төрийн өмчийг улс төрийн элит олборлох замаар төрийг барьцаалах олон талт стратеги нь тухайлсан улс төрийн институци, түүний чадавхад хэрхэн нөлөөлж, бүрдүүлдэг болохыг судлах аргачлалыг баримталсан ба тус хүрээндээ клиентелизм, махчин дайралт, уусан нэгдэх, мөлжих гэсэн дөрвөн өөр хэлбэрийг заагласан²⁷) хүртлээ тухайн пүүсүүдийн мөлжлөгийн

²⁷ Grzymala-Busse, Anna M. (2008a). "Beyond Clientelism: Incumbent State Capture and State Formation." Comparative Political Studies 41 (4-5): 638–673.

төлөө ажилладаг болохыг дүрсэлсэн. Товчхондоо, эхний зорилт нь холбогдох улс төрийн намууд, хоёр дахь нь улс төрийн тогтолцоо, түүний элементүүдийг барьцаалах зорилготой ба эхний зорилт нь хоёр дахь зорилт биелэгдэх алхмыг нээж өгдөг.

Дүгнэлт:

Чехийн улс төр судлаач Михал Климагийн 2020 онд англи хэлээр хэвлэгдсэн “Пост-Коммунист Европ дахь албан бус улс төр: улс төрийн нам, клиентелизм ба төрийг булаан эзлэх нь” бүтээлд дүн шинжилгээ хийж үзлээ.

Уг бүтээлд Төв болон Зүүн Европын орнууд тэр дундаа БНЧУ-ын улс төрийн түүхэнд ардчиллыг гажуудуулж буй үйл явцын дотоод үйл явцыг задлан шинжилгээ хийж өгсөн. Энэ нь гадаад болон дотоод олон нөхцөл байдлын харилцан үйлчлэлийн үр нөлөөгөөр бий болсныг харуулжээ.

Дотоод хүчин зүйлийн тэргүүн эгнээнд хуучин коммунист дэглэм тогтож байсан орнуудад албан бус сүлжээ нь коммунизмын үед “тэсэж үлдэх” стратеги байж байгаад тогтолцооны өөрчлөлтийн үед мөн “тэсэж үлдэх” цаашлаад тогтолцоонд давуу тал олох, ноёрхох байр сууринд хүрэх тэргүүлэх стратеги болсныг харуулсан юм. Өөрөөр хэлбэл, бүх үзэл санааг хатуу хяналтад байлгаад тоталитар дэглэмд улс төрийн тоглогчид, нам, бүлгүүд албан ёсны үзэл сурталд нийцэх “албан” дүр төрхөөс гадна, тогтолцоонд “тэсэж үлдэх”, бүлэг хоорондын өрсөлдөөнд “амжилттай байх”, зорилгодоо хүрэх далд, албан бус бүтэц, сүлжээнд тулгуурлаж байдаг аж. Патрон-клиент буюу ивээгч эзэн-үйлчлэгчийн харилцаа сүлжээ нь нэлээд эрт үеэс угшилтай бөгөөд феодалын нийгмийн үед өргөн дэлгэр үйлчилж, албан харилцааг бүрдүүлж иржээ²⁸. Бүр эртний Ромын эзэнт улсын үеэс эхтэйгээс гадна хамжлагын нийгэмд, хувь хүмүүсийн эрх чөлөө хумигдмал, газрын эздийн хязгааргүй ноёрхлоос үүдэлтэйгээр хамгийн чухал эрх мэдлийн харилцаа байж ирсэн гэж болох юм. Харин хатуу хяналттай, тоталитар нийгэмд нь энэхүү уламжлалт харилцааны аргыг хатуу тогтолцооны үед “тэсэж үлдэх”, “амжилт гаргах” нэг арга хэрэгсэл болгон далд байдлаар ашиглаж ирсэн байдаг. Энэ харилцаа нь бүлгийн дотоод ёс суртахуун, харилцан туслах, үйлчлэх гэсэн бичигдээгүй дүрэмд суурилсан шинж чанартай байдаг. Ялангуяа албан харилцаанд иргэдийн олонх үйл ажиллагаа хориотой, хязгаартай үед далд байдлаар хэрэглэдэг гэж үзэх боломжтой. Энэ сүлжээ бүтэц нь коммунизмаас ардчилалд шилжих үед хэвээр хадгалагдах төдийгүй, хүний эрх, эрх чөлөө хүлээн зөвшөөрөгдөх хэрээр илүү илэрхий хэрэглэгдэх болсон байна.

Дээрхээс гадна төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед хийгдсэн улсын өмчийг их хэмжээгээр хувьчлах үйл явцад энэ бүтцийг ашиглах, улмаар энэ албан бус бүтэц нь илүү батжин бэхжих нөхцөл болж өгсөн нь дотоодын хүчин зүйл болсон байна. Мөн Чехийн нөхцөл байдлаас үзвэл Европын холбооноос өгсөн элдэв дэмжлэг туслалцаа мөн нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх хүрээнд орон нутгийн засаг захиргаанд өгсөн эрх мэдэл нь орон нутгийн улс төрд ийм боломжийг талбиун тавьж өгчээ.

Гадаад хүчин зүйлийн хувьд 1980-аад оноос Рейган, Тетчерийн эдийн засгийн неолиберал бодлогын үр нөлөөгөөр ОУВС, Дэлхийн банк зэрэг байгууллагууд шинээр эдийн засгийн шилжилт хийж байгаа болон тусламж, хөнгөлөлттэй зээл авах орнуудад үнийг либералчлах, төрийн оролцоог бууруулах, өмч хувьчлалын бодлого баримтлахыг бодлогын болзол нөхцөл болгон хэлэлцэж байсан нь нөлөөлсөн юм.

Үүнээс гадна Климагийн үзэж буйгаар дэлхий даяар өрнөж байсан нийгэм эдийн засгийн томоохон өөрчлөлт бол намын үндсэн дэмжигч болж байсан томоохон ангиудын хүчин чадал суларч, анги дагасан гишүүнчлэл, намын дэмжлэг суларч ирснээр намуудын санхүүжилт тодорхой болсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл, намын гишүүнчлэл дэлхий даяар суларснаар намын санхүүжилтийг төрөөс даах, төрөөс татаас үзүүлэх хандлага

²⁸ “Clientelism social science” <https://www.britannica.com/topic/clientelism> [2023.11.18]

Баруун Европт гарч тэр чинээгээрээ нам төртэй ойрхон байх болсныг дурдсан. Ийм нийтлэг чиг хандлага ч мөн шилжилтийн орнуудад нөлөөлсөн байна. Энэ нь Баруун Европын орнуудад Намуудын картель тогтолцоо үүсэхэд, Төв болон Зүүн Европын орнуудад намын клиентелист тогтолцоо, Зүүн Европын болон Хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан зарим орнуудад олигарх тогтолцоо үүсэхэд мөн нөлөөлөх хүчин зүйл болжээ.

Чех улсын улс төрийн тогтолцоонд гарч буй эдгээр чиг хандлага нь Монгол улсын хувьд ч гэсэн төсөөтэй байгаа бөгөөд цаашид илүү сайн судлах, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх шаардлагатай юм.

Клиентелизм орчин үеийн ардчилсан шилжилтэд хүчтэй илэрч байгаа энэ үзэгдлийн гол сөрөг үр дагавар нь иргэний нийгмийн сонирхлыг улс төрийн тогтолцоонд төлөөлөх, илэрхийлэх ёстой улс төрийн намууд тэдгээр үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй, явцуу эдийн засгийн бүлэглэлийн хяналт, эрхшээлд орсноор нь намууд нь барьцаалагдаж, улмаар улс төрийн тогтолцоо нь бүхэлдээ гажуудахад хүрдэг байна.

Ийнхүү ардчилал гажуудаж, намын тогтолцоонд итгэх итгэл хөсөрдөн унаснаар хүн ардын улс төрийн оролцоо, идэвх эрс буурч, намуудын төлөөлөх ёстой байсан нийгэм эдийн засгийн суурь хуваагдал (зүүний болон барууны, нийгмийн баримжаат болон чөлөөт зах зээлийн) намын тогтолцооны гол хэмжүүр байхаа больж, оронд нь уламжлалт намууд ба тэдний эсрэг, шинээр гарч ирж буй намууд гэсэн гол хуваагдал бий болж сонгуульд нөлөөлж буйг дурдаж байна. Өөрөөр хэлбэл, албан бус сүлжээнд, нөлөөлөлд автсан намуудад итгэхийн оронд шинээр гарч ирсэн, уламжлалт намуудыг бүгдийг нь эсэргүүцдэг, авлигын эсрэг уриа дэвшүүлсэн шинэ нам, шинэ улс төрчдөд дэмжлэг ихээр очих нийгмийн давлагаа үүсдэг нь Чехийн 2010, 2013, 2017 оны сонгуулиас харагджээ. Монголд ч гэсэн үүний жижиг илрэл нь 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд “цагаан сонголт” хэмээх аль ч нэр дэвшигчийн дугуйлаагүй саналын тоо 100 орчим мянга өгснөөс анзаарч болох юм. Залуусын улс төрийн оролцоо суларч, хүнийссэн, бүх улс төрчдийг авлига, гэмт хэрэг гэх зэргээр хар бараанаар төсөөлөн ойлгох хандлага хүчтэй байна.

Хэдий гажуудсан боловч ардчиллын үндсэн механизм болох чөлөөт шударга сонгууль ажиллаж байгаагийн илрэл нь иргэний нийгмийн бухимдал сонгуулиар эсэргүүцлийн сонголт болж чадаж байгаа явдал юм. Чех сонгогчдын хувьд иргэний нийгмийн ийм цохилт нь тогтолцооны хувьд нэлээд өөрчлөлт, хөдөлгөөнийг бий болгож, уламжлалт том намуудаас гадна шинэ нам, улс төрчид гарч ирэх боломжийг бий болгож байгаа юм.

Эдгээр шинэ намуудыг иргэний нийгэм нь хүчтэй дэмжих, эдгээр намууд амжилттай төлөвшин бэхжиж чадах нь тогтолцооны нам болох “хуучин намуудын” орон зайг эзлэхэд чухал нөлөөтэй байх юм.

Мөн эрх барьж буй улс төрийн хүчнүүд ийм томоохон сонгуулийн “эргэлт” гарах урьдчилан тооцоог сайн хийж чадвал, түүнээс урьдчилан сэргийлэх, намын дотооддоо “авлигачидтай” хийх тэмцлээ сайжруулах, намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн нам, сонгуулийн хууль, улс төрийн санхүүжилтийн хууль тогтоомжоо сайжруулах замаар улс төрийн хүсэл зориг гаргаж чадах нь “зөөлөн газар”-дахад чухал нөлөөтэй юм.

Хэдий энэхүү бүтээл нь Чехийн улс төрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн ч олон талаараа Монголын нөхцөл байдалд “нялзааж” хэрэглэж болохуйц ойролцоо, нийтлэг хэв шинжийг олж илрүүлсэн нь чухал ач холбогдолтой юм. Нэг талаас пост-коммунист цаг үе, шилжилтийн өвөрмөц шинж байдалд тохирсон арга, аргачлал дэвшүүлсэн нь маш оновчтой бөгөөд бодитой дүн шинжилгээ хийх нөхцөл юм. Нөгөө талаас, тогтолцооны шилжилтэд өмнөх тогтолцооноос үлдэх сэтгэлгээний болоод бусад “өв”-ийг харгалзаж үзэх зайлшгүй шаардлагатайг нотолж өгчээ.

Abstract:

This article aims to elucidate the distinct political development in post-communist countries after 1989, focusing on the deviations from democratic governance. Drawing upon the insightful analysis provided by Czech political scientist Michal Klima in his work titled "Informal

Politics in Post-Communist Europe: Political Parties, Clientelism and State Capture", this review article aims to synthesize and present key findings related to clientelism, the challenges of countering the state, and the strategies employed in managing the state. The analysis encompasses elements such as clientelism, corruption, and the patronage system, highlighting the nuanced perspectives on these issues within the framework of the post-communist political landscape.

The overarching goal is to contribute to a comprehensive understanding of the post-communist political dynamics, encompassing diverse elements such as clientelism, state governance, and the intricate interplay of political forces.

In conclusion, the analysis serves as a precursor to further exploration and understanding of the post-communist political landscape, offering valuable insights into the complex nature of state governance, clientelism, and other challenges to revive the civil society to counter these defective elements of the democratic regime.

Key words: Informal politics, clientelism, corruption, colonialism, state and party capture

Ашигласан ном, материал

Монгол хэлээр:

- Михал Клима “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу: далд бизнес улс төрийн намуудыг хувьчлан колоничилсон нь” орчуулгын бүтээл, “Мизэс Монгол” ТББ, 2017 он,
- МУИС-ШУС-Улс төр судлалын тэнхим “Улс төрийн нэвтэрхий толь бичиг” УБ, 2020 он

Англи хэлээр:

- Kostadinova, Tatiana. 2012. Political Corruption in Eastern Europe: Politics After Communism. Boulder, CO: Lynne Rienner Publishers.
- Müller, Wolfgang C. "Party Patronage and Party Colonialization of the State." In Handbook of Party Politics, edited by Richard S. Katz and William Crotty, 189. London: Sage, 2006.
- Yu, Eilo Wing-Yat. "Formal and Informal Politics in Macao Special Administrative Region Elections 2004–2005," London, Routledge, <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/10670560701314248?needAccess=true> [2023.11.01]
- “Clientelism social science” <https://www.britannica.com/topic/clientelism> [2023.11.18]
- Michal Klíma (2020) “Informal politics in post-communist europe: political parties, clientelism and state capture” English version, London, Routledge.
- Piattoni, Simona. (2001), “Clientelism, Interests, and Democratic Representation: The European Experience in Historical and Comparative Perspective”. Cambridge: Cambridge University Press.
- Kitschelt, Herbert, Steven I. Wilkinson, eds. Patrons, Clients and Policies: Patterns of Democratic Accountability and Political Competition. Duke University, North Carolina.
- Sajó, András. (2002), “Clientelism and Extortion: Corruption in Transition.” Pp. 1–21 in Stephen Kotkin and András Sajó (eds.) Political Corruption in Transition: A Skeptic’s Handbook. [online]. Budapest: Central European University Press.
- Kaufmann, Daniel, Aart Kraay, and Massimo Mastruzzi. (2010), “The Worldwide Governance Indicators, Methodology and Analytical Issues.” Policy Research Paper, No. 5430, (September) World Bank.
- Grzymala-Busse, Anna M. (2002), Redeeming the Communist Past. The Regeneration of Communist Parties in East Central Europe. Cambridge: Cambridge University Press.
- Grzymala-Busse, Anna M. (2008a). “Beyond Clientelism: Incumbent State Capture and State Formation.” Comparative Political Studies 41 (4-5): 638–673.

- Stubbs, Paul, and Siniša Zrinščak. (2015), “Citizenship and Social Welfare in Croatia: Clientelism and the Limits of Europeanisation.” *European Politics and Society* 16 (3): 395–410.

ЗОХИОГЧИД

Зохиогчийн нэр	Ажил, албан тушаал	E-mail
Ж.Төртогтох	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор	turo@num.edu.mn
Г.Туяагэрэл	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	tuyagerel.g@num.edu.mn
Б.Уянга	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	uyanga.batbuyan04@gmail.com
Д.Сүхболд	Улаанбаатар Эрдэм их сургуулийн профессор	Sukheemodun@yahoo.com
Г.Золзаяа	Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүй олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч	zolzaya@otgontenger.edu.mn
Б.Эрдэнэдалай	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	erdenedalai@num.edu.mn
Ю.Ариунзаяа	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	ariunzayay@gmail.com
С.Мөнхбат	МУИС, УТСОУХНУС-ийн захирал	munkhbat.s@num.edu.mn
Д.Ундрах	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	poli_und@num.edu.mn
Б.Анхзаяа	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	baterdene.ankhzaya@gmail.com
Б.Болор-Эрдэнэ	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	bolorerdenebayar11@gmail.com
У.Батцэрэн	Удирдлагын академи, Төрийн албаны сургууль, Сургалтын менежер, Дэд профессор	battseren@naog.gov.mn
Д.Алтанхуяг	Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургууль	adongoobor@gmail.com
Н.Мягмарцоож	МУБИС, Дэд профессор	myagmartsooj@msue.edu.mn
Д.Түмэнжаргал	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	tumeed@num.edu.mn
А.Отгонням	Жилин их сургуулийн Зүүн хойд Ази судлалын хүрээлэнгийн докторант	avarzadotgoo77@gmail.com
Sebule	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	Sebule0818@gmail.com
Ш.Эвсанаа	ДХИС, ЭЗНУС, Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, ахмад	sambaaevsanaa3@gmail.com
Т.Заяа	ХУИС, ОУХНС-ийн тэнхимийн багш	zaya.t@humanities.mn
Т.Есүхэй	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн багш	tyesukhei@num.edu.mn

Ц.Төрболд	МУИС, УТСОУХНУС, Олон улсын харилцааны тэнхимийн магистрант	turboldts@gmail.com
Э.Эрдэнэцэцэг	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	erdenecceg88@gmail.com
Б.Баярбаатар	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	B_bayar8888@yahoo.com
Д.Бумдарь	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн профессор	bumdari@num.edu.mn
О.Ариунбилэг	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	ariunbilegt2014@gmail.com
С.Базарпүрэв	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор	bazarpurev@num.edu.mn
О.Мөнхжаргал	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн багш	munkhjargal.o@num.edu.mn
О.Хатанболд	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА	khatanboldo@gmail.com
Д.Уртнасан	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн багш	urtnasan_d@num.edu.mn
Х.Батхүү	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	batkhuukhurelbaatar@gmail.com
М.Мөнхзул	ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургууль, Нийгмийн ухааны тэнхим	munkhzul@mul.s.edu.mn
Г.Уянга	ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургууль, Нийгмийн ухааны тэнхим	uyanga@mul.s.edu.mn
Н.Отгонбаяр	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант	otgonbayarnyamaa.n@gmail.com
Л.Билгүүнтөгс	ХУИС-ийн докторант	bilguuntugsluvsandorj@gmail.com
Д.Бадамдаш	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн багш	badamdash@num.edu.mn
Б.Сарантуяа	МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн магистрант	sarantuyabtr@gmail.com

CONTRIBUTORS

Author	Affiliation	E-mail
Turtogtokh Janar	Professor, Chairman, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	turo@num.edu.mn
Tuyagerel Ganbat	Senior lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	tuyagerel.g@num.edu.mn
Uyanga Batbuyan	Graduate Student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	uyanga.batbuyan04@gmail.com
Sukhbold Dorjderem	Professor, Ulaanbaatar Erdem University	Sukheemodun@yahoo.com
Zolzaya Gankhuyag	Head, Journalism, International Relations Department, Otgontenger University	Zolzaya@otgontenger.edu.mn
Erdenedalai Bat-Ulzii	Associate Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	erdedenalai@num.edu.mn
Ariunzaya Yura	Graduate Student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	ariunzayay@gmail.com
Munkhbat Sonomdarjaa	Director, SPSIRPA, National University of Mongolia	munkhbat.s@num.edu.mn
Undrakh Davaadorj	Associate Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	poli_und@num.edu.mn
Ankhzaya Bat-Erdene	Graduate Student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	baterdene.ankhzaya@gmail.com
Bolor-Erdene Bayaraa	Graduate Student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	bolorerdenebayar11@gmail.com
Battseren Urtnasan	Associate Professor, Training Manager, School of Civil Service, National Academy of Governance	battseren@naog.gov.mn
Altankhuyag Dongoobor	Graduate Student, School of Management, National Academy of Governance	adongoobor@gmail.com
Myagmartsooj Natsag	Associate Professor, Mongolian State University of Education	myagmartsooj@msue.edu.mn
Tumenjargal Davaaadorj	Senior Lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	tumeed@num.edu.mn
Otgonnyam Avarzad	Graduate Student, Jilin University	avarzadotgoo77@gmail.com
Sebule	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	Sebule0818@gmail.com

Evsanaa Shambaa	Senior lecturer, Department of Social Science, University of Internal Affairs, Mongolia	sambaaevsanaa3@gmail.com
Zaya Tumurchuluun	Lecturer, Department of International Relations and Social Sciences, University of the Humanities	zaya.t@humanities.mn
Yesukhei Tumurbaatar	Lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	tyesukhei@num.edu.mn
Turbold Tsiiregzen	Graduate student, Department of International Relations, SPSIRPA, National University of Mongolia	turboldts@gmail.com
Erdenetsetseg Erdenetsogt	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	erdenececeg88@gmail.com
Bayarbaatar Bayarmagnai	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	B_bayar8888@yahoo.com
Bumdari Dagva-Ochir	Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	bumdari@num.edu.mn
Ariunbileg Oyunbilegt	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	ariunbilegt2014@gmail.com
Bazarpurev Sambuu	Advisory Professor, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	bazarpurev@num.edu.mn
Munkhjargal Otgonbayar	Lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	munkhjargal.o@num.edu.mn
Khatanbold Oidov	Leading Academic Researcher, Head of Department of Political Science & Legal Studies, Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences	khatanboldo@gmail.com
Urtnasan Dagiidamba	Lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	urtnasan_d@num.edu.mn
Batkhuu Khurelbaatar	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	batkhuukhurelbaatar@gmail.com
Munkhzul Myagmarsuren	Associate professor, Department of Social Science, School of Economy and Business, Mongolian University of Life Science	munkhzul@mul.edu.mn
Uyanga Gansukh	Senior lecturer, Department of Social Science, School of Economy and Business, Mongolian University of Life Science	uyanga@mul.edu.mn

Otgonbayar Nyamaa	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	otgonbayarnyamaa.n@gmail.com
Bilguuntugs Luvsandorj	Graduate student, University of Humanities	bilguuntugsluvsandorj@gmail.com
Badamdash Dashdavaa	Lecturer, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	badamdash@num.edu.mn
Sarantuya Baatar	Graduate student, Department of Political Science, SPSIRPA, National University of Mongolia	sarantuyabtr@gmail.com